

Жагсаагийн БЯМБА



ЭНЭРЭЛГҮЙ

ХОРВОО



Ж.Бямба

Энэрэлгүй хорвоо

Уут нь цоорхой ч

Ёроол нь өвөртөө

1971 онд ном хэвлэгдэн гарсны дараа “Уут нь цоорхой ч ёроол нь өвөртөө” шүүмжийг бичин гаргасан боловч дарагдаад 1991 онд “Зохист аялгуу” сонин (5.24 №10)-д хэвлэснийг энд эмхэтгэн харууллаа.

Энэ шүүмжийг бичсэнээр миний бие тухайн үедээ нилээд шүүмжлэл хүртээд авсан.

Уншмагц зохиогч нь хэзээ ч сүүл барьсангүй дээ гэж хэлмээр, аль ч үед уншигчийн бүтээлч идэвхийг сэргээж чадах “хуучин ном” тааралддаг. Тийм ном нэг талын өрөөсгөл үнэлгээнд өртөж “шуугианаар” дарагддаг боловч үзэл бодлын хувьд “харш” гэгдэх хоч талаас нь эргэн ярилцах боломж байх юм.

“Хүний нэгэн насанд хорвоогийн бүх явдал хувьсан өөрчлөгдөхийг үзлээ” гэж амьдрал хэмээн “их савны” дотор юу эс багтахыг хэлэх зоримог баатрууд гарч ирсэн романы нэг бол Ж. Бямбын “Энэрэлгүй хорвоо”, “Хорвоогийн өнгө”, “Үнэний хорвоо” хэмээх гурвал юм. Энэ роман гуч гаруй (1971) жилийн өмнөөс нэг бус удаа хэвлэгдэж, уншигчид гар дамжуулан үздэг зохиолын тоонд хэвээрээ явна. Зохиолд өрнөсөн амьдрал хэмээх “их савнаас” өөр өөрийн уутны хэмжээгээр цуврал романы баатрууд авч байна.

Амьдралын өөрчлөгдөн хувирах жамыг эмэгтэй хүний хувьд өөрийн гэх нуруутай, чиг зорилготой залж, аж төрлөө гэр зуурын орчноос холтголгүйгээр хийдэг учиртайг үзүүлж чадсан нь эр хүний нөмөр нөөлгөнд илт ивээгдэх арчаагаа алдсан “жаргалд” хууртагдагчдад сургамж өгч байна.

Нийгмийн олон давхаргыг төлөөлсөн дүрүүдийн хувьд олон ургальч ухаарал дотор “... үнэн дотносгоор далан дээр нь алгадагч”-аараа ялгарч буй баатрууд үзсэн дуулснаараа сэхээрч, тэтгүүлж ивээлгэснээрээ баяждаг бол “Бар бамбарыг” алгасч мэдэх хошин аяс давхар бий.

Бие, хэл, сэтгэлийн өнгөнд тогтдог уран үгийн цуваанд уяаны морьд шиг оролцсон баатруудын амьдрал нь “идэр залуу настай, исгэлэн халуун биетэйдээ өөрийгөө сайн зүгт дайчилж амжвал муу юм орогнох хоосон зай үлдэхгүй”-г өгүүлсэн зөн совингийн мэдрэмжтэй байгаа нь “Улс төрийн тавьгар” дагасан хэрэг биш байна.

Хүний үл танигдах чанарыг дуулиан шуугианы үзүүлбэр болгож өнгөлөх бичлэгээс ялгарсныг “... Урангоо бүсгүйн гунигтай яриа”-нд үл сэжиглэх Билгүүн лүгээ ойлгохын тус оршсон сэтгэл зүйн шүүмжид таныг урилаа.

МЗЭ-ийн гишүүн, утга зохиолын судлаач

Д. Хүү

Нэгдүгээр бүлэг

Хонгор бүсгүй

Үзүсгэлэн гоо төрнө гэдэг

Үзсэн бүхний нүдний чимэг

Болор мэт тув тунгалаг тэнгэрийн зүүн хаяанаас нүд гялбуулсан түмэн өнгийн солонгын ёацрал татуулсаар наран мандлаа. Ургах нарны шижир туяа хангай хөвчийн сарьдаг уулсын мөнгөн цагаан магнайд хөлс дааварлуулж, хөнгөн цайвар манан хөшиглөн суунаглах голын хөндий, нуга талыг гийгүүлэв. Үнэгэн шогшоо салхины аясаар намилзах навч цэцэгнээ хуран хоносон шүүдрийн дусал сувд адил солонгорон гялбалзана.

Алсын бараа харагдахуйц сэргэлэн дэнжид буусан хоёр гэрийн хонь бэлчээрлэн идээшилсээр баруун хөндий хүрч явна. Зэлэн дээр үхэр тугал мөөрөлдөнө. Хаврын нарны илч, үржилт хөрсний шим хоёрт ааглан ургасан хээнцэр яргуй шиг турьхан бүсгүй гандаж хорчийсон навч шиг үрчлээт нүүртэй бөгцгөр эмгэн хоёр үнээ сааж байна.

Хотын зүүн талын гэрээс алх дөшний дуу тасралтгүй сонсдох нь хэн нэгэн хүн өглөө эртлэн үйл бүтээж суугаа бололтой. Баруун гэрийн хоймор дээл нөмрөн завилан сууж, цэцгэн хуартай далбин амсартай гангар шаазанд шар хойг болсон өтгөн цай мэлтэлзүүлэн хийгээд амтархан оочилж байгаа ахимаг эрийг гүзээ Намсрай гэдэг. Гэдэс нь өмднийхээ захыг даван шалхайн унжиж, дэнхэр толгой, эргэлсэн дух, хянган хамар нь аягатай цайнд бүдэгхэн тусах төдий.

Түмэн сүүдэр хээтэй зургаан том авдар эгнүүлэн тавьж зүүн талын эрээн нүүртэй орон дээр улаан цэмбээр хөвөөлсөн олон эсгий гудас давхарлаж дээр нь хивс дэвсжээ. Авдар бүрт олон өргөстэй цоож зүүснийг үзэхүл үнэт эд агуурс агуулсан бололтой. Айргийн хөхүүр, бүрхээр, тогоо сэлтийг баруун талаараа дэс дэсээр нь тавьсан ажээ.

Гэрийн эзэн “Охин минь эх шигээ сайхан цай чанадаг болж шүү. Өнчин өссөн юм болохоор гэр орны ажилд шаггүй болох нь дээ. Ажил үйл сайтай байвал өөрт нь л хэрэгтэй сэн. Охин минь одоо аавдаа хань болжээ. Хөөрхий минь, нялх юм даа” гэж бодон нээлттэй үүдээр үхрийн зэл рүү нүдний хараа бэлчээнэ. Үнээгээ тун ч яаруу сааж байгаагий нь ажаад, “Аргагүй дээ, хот хүрээ үзсэн юм биш. Одоо охин минь юм үзэж нүд тайлах цаг боллоо. Алийн болгон гэрийн мухар сахиж суух вэ. Миний охин шиг бүсгүй хүүхдүүд энд тэндгүй явах л юм. Охин минь эхгүйдээ л тулга тогоотой зууралдсаар оронгоос ч гарч чадахгүй юм” гэж бодов. Намсрай адуу туусан хүн ирж явааг хараад, том гуулин данхныхаа тагийг авч зайлан аяга руугаа хийж цайгий нь шимэн шаарья нь зажилж тургиад сая сэтгэл ханан цэрдийсэн гэдсээ дааж ядсан янзтай ширдэг тулан янцаглан босов. Тэгээд бүсээ сулхан ороож захнаас товруутай мөнгөн хазаар авч гадаа ирж байгаа адууг тосон очив. Адуу хураах чимээнээр зүүн гэрээс сүлжмэл буурал гээгнийхээ үзүүрээс нарийн сур зүүсэн янхигар өвгөн барим хирийн цоог цагаан сахлаа шувтран завдсаар гарч ирсэн нь дархан Сүх байлаа.

- Ямар морь бариулах вэ? гэж адуу хурааж ирсэн тэнхээлэг байрын хархүүг асуухад Намсрай

- Юмжирдуламын халиуныг... гэвэл залуу эр бугуйлаа эвхэн мориндоо гэнэт ташуур өгч, түрүүнээс хойш адуу захлан цойлох янзтай тогтож ядан байсан бие багатай халиун морь руу ухасхийв. Залуугийн уургач бор морь адуу руу дайран ороход халиун ч нөгөө тийшээ зүтгэж сүргийн дундуур хага яран цойлон гарав. Бугуйл сур адуудын толгой дээгүүр агаар зүсэн исгэрч халиун морины толгойд шавхийн орлоо. Халиун морь нэгэнтээ цовхроод цааш зүтгэтэл залуу эр мориныхоо хондлой дээр унан алдан татахад халиун морь шадван эргэж урд хоёр хөл дээрээ цахдан зогслоо. Үнээгээ ивэлгэж байсан Юмжирдулам бугуйлч залууг харан алмайрч түүний бугуйлаас чангаалцаж байгаа мэт хувингийнхаа сэнжийг тас атгачихсан зогсож байв. Түүнийг хараад эмгэн

- Охин минь, тугал чинь хөхчихлөө гэж уулгадан хэлэхэд бүсгүй сандран тугалаа татахдаа эмгэнээс ичиж нүүр нь час улайжээ.

Намсрай морио оосорлож өвгөний дэргэд хөтөлж ирээд

- Дархаан, танай хүүг адууны толгой алдаж байхыг би ер үзсэнгүй. Сайхан эрдэм юмаа даа гэж бахдан дуугарав. Үе залган мөнгө урласан өвгөн Сүхийг нутгийнхан нь голцуу “Дархан” гэж эрхэмлэн дуудаж заншсан ажээ.

- Намайг дуурайж алх дөш нийлүүлж сурахгүй нь бололтой. Адуундаа бол ч гайгүй л юм биз гэж өвгөн дурамжхан хэлэв.

- Базарыг чамлалт байхгүй шүү дархан минь! Манай энэ хавьд адуунд эрэмгий байна гэдэг эр хүний бахархал, эмнэг хангал бол ч бүр яана! Манай энэ хавьд танай хүүгийн энд хүрэх эр байхгүй гэж би боддог. Өнгөрсөн намар баян Долдынх пүүсэнд өгөх адуугаа Базараар хүргүүлсэн шүү дээ. Тэгэхэд баянтан нутгийн олон уургач эрсэд зар тараачихаад адуугаа хураалаа. Дал наяд эмнэг барьсан даа. Тэгэхэд танай хүү “Хүн уургалаад өгмөгц л чихдэж авч ганцхан тонгорч унагаачихаад л сүүлнээс нь хэсгийг сугалæ авч хөлийã нь богочиж хаячихаад яваад байсан. Богочсон адуу чинь тэндээ эргэлдэж цовхчоод холдож ч чадахгүй юм. Тэгээд адуугий нь туулгасан хойноо өйөөх богочоогий нь тас тас огтчоод ганцхан хашгираад л элдээд явчихсан шүү. Ёстой нэг бахтай харагдсан. Эр хүн тийм байхад яах вэ! гэж Намсрай яриад морио хөтлөн уяа руугаа алхав. Дархан Сүх, унаагаа юүлэхээр морь бугуйлдаж буй хүүгээ эцэг хүний хэмжээлшгүй хайр, бахархал шингэсэн нүдээр харан сахлаа илбэн зогсохдоо “Нээрээ ч амтай бүгд л миний хүүг адуунд сайн гэж магтах болж дээ. Энэ ч эр хүнд бас л нэг эрдэм шүү” гэж бодлоо.

Намсрай морио бөхлөөд гэрт орж баруун хоймортоо авдрын шөргүүд мод унуулан тавьсан алаг хивсэн гөлөмтэй, мөнгөн хяртай, бүсгүй хүний жижигхэн эмээлийг хайчтай авч гарав. Халиун морины дэлийг засаж эмээллээд, богинохон яргай ташуур бүүргэнд нь өлгөж хантайран эргэхэд охин нь хоёр хувин сүү барьсаар гэр рүүгээ яаран ирэв.

- Аав аа, үнүэгээ саачихлаа. Одоо явах уу? гэж охин сэтгэл догдлон асуугаад “Хурдхан очих юмсан. Хожимдох бий дээ. Цагтай, нартай юм гэсэн” хэмээн битүүдээ их л яарч байлаа. Эцэг нь гал дээр байгаа хонин тогоотой сүү рүү өнгийж хараад “Яасан дундхан юм бэ дээ. Энэ хүүхдийн хөлд нь хий орчихоод хэдэн үнээгээ ганц ганц шувтарсан болоод орхиж дээ” гэж бодон хөмсөг атируулснаа “За за яах вэ. Хэдэн тугал нь сүүгээр гулгиг. Балга сүүний төлөө

охиноо гомдоож юу хийнэ. Баярлаж яарсандаа тэр биз. Ямар бага байж үзээгүй биш. Нэг юманд явах сураг сонсчихоор өдөр шөнө өнгөрөхөө больчихдог юм чинь” гэж санамагцаа сэтгэл нь хоромхон зуур цэлмэж охиноо энхрийлэх эцэг хүний хайр зүрхэнд нь бялхаад иржээ.

- Охин минь, түргэлж үз дээ. Аав нь сүүгээ хөөрүүлчихье гээд Намсрай зууханд түлээ хийж гал асаах нь тун ч сурмаг дадмагийг ажихад үхсэнээс үлдэж хоцроод гэрт эм болж, гадаа эр болж удсаны аж.

Юмжирдулам охин нарт хорвоод дуугаа сонсоод арван долоо дахь зунтайгаа золгож байгаа авч ааль ааш нь хүүхдэрхүү, эрх танхи хэвээр. Хүрээ орж цам үзэх болсондоо баярлаж хөөрсөн бүсгүй гөрмөл мөнгөн утсанд хэлхэж бүснээсээ зүүсэн олон түлхүүр гарган энэ ч авдрыг ухасхийн нээж нэгийг үзэж, тэр ч авдар руу гүйж дэгдэн нөгөөг авч янз янзын дээл хувцас шилж сонжин, гоёж гоодох нь сэргэлэн цовоо, хөнгөн шалмаг агаад хар багаас өөрийн мэдэлтэй, дур зоргоор өссөн нь илт үзэгдэнэ. Юмжирдулам хормойгий нь тойруулан хоргойгоор хошмоглоон эмжиж, тууз, алтан саа хадсан мөнгөн товчтой цэнхэр торгон тэрлэгээ өмсөж

- Ааваа, охиныхоо бүсийг бүсэлж өгөөч гэж эрхлэнгүй хэлээд эцгийнхээ өмнө инээмсэглэн очив. Намсрай шар бажгар дурдан бүсийг охиныхоо туяхан нарийн бэлхүүсээр цэмбийтэл ороож өгөхдөө “Эрд гарах шахсан байтлаа даанч эрх юм даа. Өнчин юмыг яая гэх вэ. Одоохондоо дураараа л байхаас даа” гэж бодсоноо

- Охин минь, хэзээ томоожино доо. Ийм том хүн байж ааваараа бүсээ бүслүүлнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ. Хүн харвал юу гэх бол! Аягүй бол шоолох байх даа гэж өхөөрдөнгүй хэлж инээгээд охиныхоо духан дээр үнсэв.

- Гоё бүслэх гэсэн юм л даа... гэж охин нь мишээгээд модон жаазтай толь авч бэлхүүсээрээ нахилзан туялзан тольдож, дээлийн хуниасыг засч, товч шилбээ үзэж, зургаан талтай, угалз шагласан, хүрэн сампинтай дэгжин тоорцгийг баруун тийш нь нэг хэлтийлгэж, зүүн тийш нь нэг хазайлган тавьж гэдэгнэж годгонон байх нь аальгүй ч юм уу гэмээр. Царайлаг төрсөн охиноо энэрэл хайрын нүдээр харж сэтгэл хөдлөн суугаа Намсрай “Эх нь аргагүй л уран хүн байсан юм даа, хөөрхий. Бурхан болооч минь энэ тоорцгийг өвөл нь хийгээд ганц ч өмсөж чадсангүйсэн. Үртэй хүн сайхан юм. Охин минь эдлэх боллоо. Олон жил хадгаллаа. Сайхан зохиж байна шүү” гэж бодон зуухандаа түлээ нэмж байлаа.

- Аав аа, та хараач! Ямар байна? гээд охин жижигхэн цагаан шүд яралзуулан инээж, эцгийнхээ урд очоод нааш цааш эргэлдэв.

- Гоё байна, гоё байна, охин минь! Магтах үг олдохгүй байна гээд Намсрай охиныхоо ширүүн гар хүргэх аргагүй булбарай хацрыг том алгаараа илээд

- Охин минь, манай эндээс зөндөө хүн явж байгаа. Тэдэнтэй замдаа нийлээд яваарай! Олон хөлийн газар морь малаа алдуузай. Сайн бөхөлж, харж хандаж байгаарай! гэж захиад охиноо дагуулан гарахад “Хэдий газар нь ойр ч гэсэн хүрээ хийдэд очиж үзээгүй болохоор энэ тэрийг харж алмайрч байгаад унаагаа алдчихгүй бол дажгүй дээ. Нас нь бага ч гэсэн өнчин

өссөн болохоор санаа нь хэрсүү юм даг. Алзахгүй байгаа” гэж эргэцүүлж нэг бодлоо.

Юмжирдуламыг морины уяа руу явахад сайхан хар гээгнийх нь мөнгөн оосор гутлынх нь өсгийг цохилон хангир жингэр дуугарна. Энэ зуур Базар уян дээр ирж буугаад бүсгүйтэй хэдэн үг солиотохсон гэж бодовч эцгээс нь зовж эв аяа олж ядахдаа дэмий л морио уяж хондлойгий нь арчсан болж цаг нөгцөөн, цохон дээрээ нийлэх шахсан өтгөн хар хөмсөгтэй, цогтой хар нүдээр ирж яваа бүсгүйг сэм сэм харан байтал Намсрай

- Алив, хүү минь! Охины моринд мордоод цочоогий нь гаргаадахгүй юу. Номхон ч гэсэн уналгүй удсан болохоор яаж мэдэх вэ гэсэнд тун ч таатай далим гарав. Базар халиун морийг уяанаас тайлж аваад мордож хэсэгхэн газар хатируулснаа эргэж ирээд уяанаас холхон буусан нь эцэгт нь мэдэгдэлгүйгээр, бүсгүйн чихнээ хэдэн үг шивхийгээд орхих арга сүйхээлж амжсаных ажээ. Юмжирдуламыг баясгалантайяа мишээсээр дэргэдээ ирэхэд Базар цулбууры нь атгуулаад мордохыг завдан жолоогоо хумхин барих агшинд нь

- Орой чамайг тосно шүү гэж аяархан хэлэв. Бүсгүй эцгээ дуулчихаагүй байгаа даа гэж ичингүйрч царай нь улайн тонгойход ган дөрөөний нь гялалзсан тавган дээр улбар туяа татах шиг болжээ. Юмжирдулам “За тэгээрэй” гэсэн санаагаа илтгэсэн эрэвгэр алаг нүдээрээ залуугийн өөдөөс нэгэнтээ ирмээд найман угалз гурван сарьст шар угалзтай хар булигаар гутлынхаа ээтэн хушуугаар нарийхан цагаан дөрөөг сурмаг дөрөөлж, мориндоо шавхийтэл мордов.

- Охин минь, битгий оройтоорой. Харанхуй болохоос өмнө ирээрэй гэж эцгээ хэлэхэд

- За аав аа! гээд бүсгүй хормойгоо жимбийтэл шууж эмээл дээрээ цэмцийн суугаад өвсөн толгойг өрвөлзтөл, өндөр довыг торолзтол, дээлийн хормойг дэрвэлзтэл хатируулан одов.

Гоо бүсгүй сэтгэл булаам зуны байгалийн үлэмжийн сайхныг харан баясч явахдаа өөрөө тэр үзэсгэлэнт орчинтой хоршин, үзсэн бүхний хайр татах өнгө жавхаа төгс байгаагаа үл мэднэ. Тэртээд сүрлэг цавчим хадат Цэцэн уул униартан дүнхийж, жигнүүрийн таваг шиг Цэгээн нуур цэлийн цэнхэртэнэ. Өглөө эрт ч гэсэн хоёр сүрэг адуу нууранд ороод зогссон харагдах нь халуун өдөр болох шинжтэй. Хөндий талд хот айлууд ярайгаад, энд тэндгүй хонин сүрэг цайран бэлчээрлэнэ. Ургамал цэцэгсийн анхилуун үнэр сэнгэнэсэн зөөлөн салхи, бүсгүйн гэрэлтэж туяарсан улаахан хацрыг илбэж санчгий нь эрүүлзүүлэн наадна. Үүнийг ч үзэж баясан, түүнийг ч харж шохоорхон буй өтгөн хөмсөгтэй, дугариг хар нүднээс нь орь залуу насны баяр баясгалан гэрэлтэнэ.

“Хүрээ гэдэг яасан гоё газар бол! Хүмүүс шагшин магтаад хэлэх үгээ олж яддаг юм билээ. Цам, майдар гэж юу байдаг бол? Бодвол бас л учиргүй сайхан юм болдог биз. Аав минь намайг үнэнхүү гайхалтай юм үзүүлэхээр явууллаа шүү. Уг нь бага балчир байна гээд найр наадамд явуулдаггүйсэн. Одоо намайг том боллоо гэж бодож байгаа юм болов уу? Би ч алийн болгон хүүхэд байх вэ. Хүнд хайр сэтгэлтэй болсон бүсгүй хүн шүү дээ... Ганцаараа чинь нэг л эвгүй юм уу даа. Базартайгаа ингээд явбал яасан сайхан байх бол?” гэж бүсгүй бодоод хайртай залуугаа хойноосоо хүрээд ирэх болов уу гэж горилсон бололтой эргэн харвал эцэг нь гэрийнхээ үүдэн дээр зогссон хэвээр. Ондоо хэн ч үл үзэгдэнэ.

“Өчигдөр орой уулзахдаа л хамт Хүрээ оръё гэж хэлдэг байж. Хэлье гэж бодсоноо ичээд чадаагүй юм. Хэрэв хэлчихсэн бол цуг явах байсан болов уу. За хаанаас, орой угтана гэсэн юм чинь... Хүрээд ирвэл яах вэ?... Өдөр царайгий нь харахаас нүүр халуу оргиод байсан юм чинь бас ч яаж явах билээ. Тэгээд ч амьтан шоолбол яана!” гэж бодон яваа энхрий бүсгүйн хонгор сэтгэлийн угт амрагийн нууцхан мөрөөдөл эргэлдэж ичих баясах хосолно.

Охиноо холдон холдтол харан зогсч байсан Намсрай “Миний ганц охин хүний зэрэгт хүрчээ. Эхээсээ өнчирч хоцрох үед охиныг минь ийм болох юм гэж хэн санах вэ. Эхтэйгээ мөн адилхан аа! Үгүй, тэр нуруу туруугий нь... ! Эх нь ийм л бүсгүй байсансан. Эхийгээ бүрэн өвчиж шүү. Надтай төстэй юм бий гэж үү. Эх нь охиноо өөртэйгээ ийм адилхан гэж бодож байсан болов уу? Хорвоо гэгч нүүр тал хардаггүй яасан ч хатуу юм бэ? Нялх багаас нь эх, үрийг хагацаах юм. Хөөрхий хань минь хувьгүй хүн юм даа. Ийм сайхан охиноо харж байж чаддаггүй...” гэж бодтол хамрынх нь уг руу янгинаж, хоолой нь зангирч нүдэнд нь нулимс хуран охиных нь бараа бүрэлзэн торолзов.

Юмжирдулам арван настайдаа эхээсээ өнчирсөн юм байжээ. Эцгийн өвөрт арван тав хүртлээ унтаж эрх хонгор өсөв. Намсрай гоонь эрийн зовлон эдэлж өнчин үрийн ая аялж ганц охиноо хошуу цорвойлгон өхөөрдөн эрхлүүлж, бал бурамнаас эхлээд юу хүссэн бүхний нь алган дээр нь тавьж, зүггүйтэж дураар аашлахад нь гар хүрэх нь байтугай нэг ч удаа хөмсөг зангидан ширүүн дуугарч үзээгүй билээ. Охиноо хүний дайтай болгоход нь олон жил нэг нутаг, ихэр буудалтай явсан дархан Сүхийнх өгүүлж баршгүй тус дэм болжээ. Эцгийнхээ эзгүйд Юмжирдулам дархныхаас салахгүй, хоёр хөгшнийг “өвөө, эмээ” гэж дуудан, нэгэн гэр шигээ эрхэлж наадан өнждөг байлаа. Тэр хоёр ч өнчин охиныг төрсөн үрээсээ ялгалгүй энхрийлэн өсгөлцсөн ажээ. Намсрай нүдэндээ гүйлгэнэсэн нулимсаа арчаад, санаа алдаж “Долоон жил өнгөрчээ. “Ид насандаа эмээсээ сал, эзгүй хээр унаанаасаа сал” гэдэг яасан хатуу үг вэ? Сайн ханиа алдахад хорвоо дээр гишгэх газар олдомгүй байсан. Тэгэвч амьд хүн аргатай гэгчээр муу охиноороо сэтгэлээ тэжээж өдий хүрлээ. Эр хүн шиг найр наадам, зугаа цэнгэл ч үзсэнгүй. Охиноо хойт эхийн гар харуулалгүй халуунд халааж, хүйтэнд хөргөлгүй өсгөлөө. Одоо л Намсрайн охин гээд баян, хоосонгүй шаагиж эхлэх нь дээ. Охин минь аавдаа аз жаргал хайрлах байх. Санаанд таарсан боломжийн хүнтэй ханилуулбал болох нь тэр. Тэгвэл Намсрай хэдэн жил сэтгэл амар гэлдрэхсэн” гэж элдвийг бодон уймран зогсоход түүний царайд гуниг баясал хоёр ээлжлэн тодорч байлаа.

Жороо бор морь унасан гандмал даалимбан тэрлэгтэй өвөгжөөр хүн тэлгүүлсээр Сүх дархны уяан дээр ирж буув. Эмээлийнх нь зэс зоос хадсан улаан цэмбэн оломцог нь халцарч цоорсон харагдана. Дархных руу мойтгонон алхаж яваа тэр хүний малгай дээрх цийлэн цэнхэр жинсийг хармагц Намсрайн үрээ бахдан баясч байсан сайхан сэтгэл хаврын тэнгэр мэт гэнэт харанхуйлан, царай нь барайгаад явчихав. “Энэ улаан амласан нохой нэг муу чулуу хадчихаад тайж гэж түрээ бариад юу шалих вэ. Угаас байхын тавилангүй амьтан чинь хүний юм луйвардаж аваад ч өөдлөхгүй юм даа” гэж Намсрай тэр тайжид атаархан хорсов.

Намсрайн эхнэрийг насан худаг болохоос өмнөхөн нэгэн хэрэг мандаж, түүнээс өдөгдөн нутаг усныхаа тэр тайжтай түнжин дагарч “жинс гэдэг чулуу боловч хэрэгтэй эд. Дээдсийн зиндаанд багтдаг болохоороо тэдний нүдэнд бүлээн үзэгдэж их юмны ам хаадаг байна шүү” гэсэн бодол Намсрайн сэтгэлд хадагдан үлдсэн билээ. Намсрай дориун явдалтай болж

магадгүй гэж горьдож байсан нэг бор шүдлэнгээ алдаж эрж суран байсаар гурван жил өнгөрсний хойно сая сураг сонсож арайхийн олоход сайхан жороо морь болсон байжээ. Гэтэл тэр тайж Намсрайн олж ирсэн жороо борыг өөрийнхөө морь гэж булаалдав. Тайж тэр үеэр тааруухан сайварладаг бор морио алдчихсан юмсанжээ. Тэдний маргаан даамжирч тамгын газар заалдахаас аргагүй болов. Тамгын түшмэлүүд тохой нь цоорсон чигчүү дээлтэй хохь тайжийн малгай дээрх чулууг үзчихээд “Тайжтан өөдөө морил” гэж хоймор өөд занган ялдам зан гаргаж нахилзах мөртөө тарган морь унаж, торгон дээл өмссөн баян Намсрайг огтхон ч тоохгүй, харин хялбалзан харж “Тийшээ суу!” гэж ширүүн зандарч хатавч руу дохижээ. Бор морь үйлийн үргүй Намсрайнх байтал тамгынхан тайжид сүрхий тал өгөөд байхаар нь

- Чаа гэх ямаагүй, туу гэх нохойгүй тайж яаж малын зүс таних вэ? Энүүнд хонины унаанаас дээр юм яаж байх вэ гэж Намсрай шарандаа хэлж орхисонд түшмэлүүд уурсаж

- Ариун цагаан тайж хүнийг ам хэлээр дайрч давшиллаа. Баянаараа түрээ барьсан барлаг ард даварч далимдуулж байна. Энэ морь тайжийнх мөн. Тайж хүн хэдий ядуу ч худал хэлэх учиргүй гэж тайжаа өмөөрч Намсрайг гэмтэн болгоод жороо бор морины нь цулбуурыг тайжийн гар дээр тавьжээ. Тайж бор морий нь хазаарлаж байхдаа Намсрайг дийлсэндээ илтэд бардамнаж

- Чам шиг муу харц боол үе залгамжилсан тайж угсаатны дэргэд юу ч биш. Хорхой шавьж гэж мэд! хэмээн агсарчээ. Намсрайн уур омог бадарч, хөрөнгө хогшилдоо эрдэн сагаж яваа баян хүн гэсэндээ бас ч шил зааж

- Та нар түшмэд язгуураа татаж тайжтайгаа хуйвалдаж харц ардын хөрөнгийг булааж авлаа. Энэ муу хохь тайж чинь та нарыг очиход алаад өгчих бөгтөр ирэг байтугай царигтай төлөг ч байхгүй. Юунд нь зулгуйдсан юм бэ гэж хэлчихээд газар нулимж дэвслээд мордох гэтэл тамгын тэргүүн түшмэд ихэд хилэгнэж

- Тэнгэр язгуурт тайж хүнтэй тэрсэлсэн танхай ардыг тавь банзад! гэж хахир дуугаар бархирсанд хэдэн тахар, хиа Намсрайн тал талаас ноцон барьж авсан билээ. Түүнээс хойш Намсрай угийн дуу цөөнтэйн дээр бүр ч дуугаа хурааж, сар болоход гэрийнхэнтэйгээ тоотойхон дуугарсан ажээ. Тэгээд язгууртан дээдэстэй зиндаархах санаа төрж, уйгагүй нухан байж монгол бичиг халт мулт сураад занги, мээрэн мэт зэрэг жинстэн болох гэж санаархан цаагуур наагуур нилээд гүйсэн авч бүтэлдэж өгсөнгүй. Тэгэхээр нь Богдын хүрээ орж өргөл барьцаар хахуулдан жинс зэрэг олж авах гэсэн боловч өнгө тал хардаг хорвоод өглөг, танил хоёр нь багадаад хоосон буцахдаа “Ойр дотнын нэг л донир юм уу, сойвонтойсон болж гэм. Богд эзэнтэнд дорхиноо бараалхаж, сугсалзсан отго, гялалзсан жинстэй буцах байсан даа. Дээш нь татах хүчтэйхэн ганц гар л байхад суга үсрэхэд уг нь амархан юмсанж. Шүүрээд зүүгдчих тийм гаргүйдээ би авчирсан жаахнаа дэмий үрээд гуяа ганзгалж харих боллоо. Надад нэг муу хорголын чинээ чулуу хайрлах ачтан дээдэс байдаггүй яасан өчүүхэн хувь заяатай амьтан бэ!” гэж өөртөө гомдож цөхрөн үлдсэн билээ.

Одоо ч Намсрай урьдын тэр нэгэн явдлаа нэхэн санаж бодлогоширон зогсож байлаа. Түүний нүдэнд хорсол занал гялалзана. “Сайн муу ч нэг чулуутай бол санасандаа хүрэхсэн. Би юмтай бол юмтай, номтой бол номтой. Тэгэхэд тэр жинс чөдрийн ганц унаатай амьтны уранхай малгай дээр байснаас миний энүүн дээр байсан бол ядаж өнгөтэй харагдахсан” гэж бодсон

Намсрай хоргойгоор хөвөөлж, саагаар эмжиж, орой дээр нь булганы сүүл, өмнө талд нь улаан шүр хадсан цагаан эсгий тоорцгоо авч үзээд “Би ядахдаа тайжийн охинтой сууж тавнан болох минь ч яав даа. Залуу насанд энэ язгуур угсаагий чинь даанч ухаарах сөгөөгүй явж дээ. Ямар нэг угсаа удамтайсан бол над шиг баян хүн ноён болоход ч амархан санж дээ” гэж харц язгууртай төрсөндөө харамсан гасалжээ.

Хоёрдугаар бүлэг

Тэргүүн туслагч

Эрх ямбандаа омойтох аваас

Энэ биенд халтай буюу

Халхад цууд гарсан Цэцэн Сарт-Уулын хошууны гол хүрээ ер бишийн хөл хөгжөөнтэй аж. Өглөөнөөс эхлэн хүрээний дөрвөн зүг найман зовхисоос сайхан хүлэг морюу унасан баян гангачууд, холын нүүдэлд аяншиж борлосон тэрэг ачаатай мөргөлчид, хавчиг үүргэвчтэй мод тулсан бадарчин, дулдуйчин, ноорхой дээлтэй цоорхой гуталтай гуйлгын хар хүүдий үүрсэн үгээгүе ядуус уван цуван ирсээр байлаа. Хүрээний хаяа дэрлүүлэн барьсан өнгө өнгийн том жижиг майхны үүднээс утаа май суунаглана. Хүрээний гудамжаар магнаг торгон дээлтэй ихэс дээдэс, лам хуврагууд намс намс алхацгаана. Хэдэн үе эдэлсэн мэт хир даг болсон дээлтэй ядуус тэднээс дөлсхийн тоос манаруулан пир пар явцгаана. Хийд сахисан борчуулын сайран хөлтэй нүцгэн жаалууд элдвийг сониучирхан хар нүдээ бүлтэлзүүлэн цаагуур наагуур гуйлдэнэ. Олз олборт хэзээнэе сүйхээтэй худалдаачин хятадууд ч сагстай боов чихэр дамнан өөд сөөргөө холхиж, мохоо сурсан монгол хэлээр тахиа мэт хоолой шахан орилолдоно. Мөргөлчид сүм дуганын үүдээр сунан мөргөж, хүрд эргүүлэн маань мэгзэм уншиж чөлөө завгүй хөлхөцгөөнө.

Бага үд болоход цам үзэж, майдарт мөргөх гэсэн сүсэгтэн олон биесийн урд гарах гэж ярган зүтгэж, нааш цааш түлхэлцэн сэтгэл яаран зогсоно. Тэдний царайд хишиг буян горилон хүлээсэн байдал илэрхий. Намсрайн охин хүрээн дээр эрт ирсэн учир нүүрэн талд байр эзэлж, энэ тэрийг ихэд сонирхон харж заримыг учрыг олж ядан гайхаж, алаг нүд нь тормолзон зүрх догдлон байна. Юмжирдулам гэрээс гарч үзээгүйн харгайгаар хүрээ хийдэд эргэл мөргөл үйлдэхийн учрыг мэдэхгүй болохоор бусад мөргөлчдийн адил юм бүхнийг санасанчлан гүйцэлдүүлэх гэж үүгээр түүгээр сэлгүүцэн дэмий цаг нөгцөөсөнгүй.

- Алив таминь шахцалдаж түлхэлцэлгүй байж үзээч! гэж хижээл эхнэрийг мөрөн дээгүүрээ эргэн харж үглэхэд ард нь байсан намхан эр

- Наад дээлийн чинь түнтгэр мөр намайг хаачихаад юм харуулахгүй байна. Авгай хүний дээл гэдэг ийм газар өмсмөөргүй хувцас байна гэж учир өгүүлэв.

- Халууцаж ядаж байхад мөрөн дээр гараа битгий тавиач! гэж нэг хар хүн унтууцав.

- Гээгэн дээр даралгүй байж үзээч! Хуу татах нь байна шүү гэж нэг хүүхэн гонгиноход

- Амьтан шахаад байхад эмээ нь яах вэ дээ гэж хүний мөрөн дээгүүр буурал толгойгоо цухалзуулан юм харчих санаатай зүтгэж байгаа эмгэн дуугарав.

- Далимдуулахаа болиоч! Бурхан харж байгаа шүү гэж нэг дэгжин хүүхэн дэргэдээ зогсож байгаа хархүүг ширэв татан хараад, гары нь цааш түлхлээ.

- Чимээгүй! Догшин сахиус залрах гэж байна.

- Хэрэлдээд байхаар бурхандаа залбираач, таминь! гэж хоёр хүн хэлэв.

Бүрээ бишгүүр тэргүүтний дуу хангинаж, бүжгийн цоглог сүртэй ая эгшиглэхэд зүйл зүйлийн аймаар, гайхмаар баг өмссөн хүмүүс уван цуван гарч ирээд тэрхүү уянгат хөгжмийн аялгуу айзамд нийцүүлэн үсэрч харайн, дэгдэж цовхрон жавхлантай бүжнэ.

- Сүх дархны хийсэн хоёр бишгүүрийн дуу тасхийтэл уянгалаад онцгой байна шүү.

- Ховорхон төрөх уран хүн дээ.

- Ийм сайхан бишгүүрийн дуунд бурхан хүртэл баясдаг байх даа гэж хүмүүс айлынх нь өвгөн дархныг магтан ярилцахыг сонсоход Юмжирдуламд сайхан санагджээ. Цамын сүрлэг дэг, аялгууг улайран сонирхож, сүслэн биширсэн мөргөлчид урагш улам шахцалдан түрсээр байв. Өгөршиж муудсан хайс шажигнан яйжигнах аж. Юмжирдулам хайс, мөргөлчид хоёрын завсарт хавчуулагдан бие өвдөж, цээж бачимдавч сонин сайхныг үзэхийн эрхээр аргагүй тэсч байв.

- Алив тэр хүн доошоо болооч!

- Толгойгоо битгий хоёр тийш нь бөндөгнүүлээд бай!

- Миний өмнө тэмээ шиг олигор амьтан зогсчихож!

- Нүгэл таминь, дуугай байж үз!

- Бурхан хилэгнэвэл яана! гэж ам амандаа шуугилдавч нэмэр болсон юмгүй, харин ч үймэн шуугих нь ихэдсээр байлаа. Гэтэл аймаар багтай, эрээн цоохор хувцастай, барын сүүл барьсан хоёр хүн гарч ирээд мөргөлчдийг хайр найргүй нанчихад

- Яадаг билээ, азар!

- Хойшоо болоорой, ах дүү нар минь!

- Яах вэ, яах вэ, хэд гуядуулчих. Бузар чинь арилна.

- Бузартсандаа чи л нүдүүлэхгүй юу гэгцгээн бөөн дуу шуу боллоцов. Айж мэгдсэн сүсэгтэнүүд гэдрэг ухрах гэж чихцэлдэхэд арынх нь зодуулахыг юухан чинээ бодохгүй урагш тэмүүлэн тэдний байрыг эзэлж байлаа. Олон хүн гэгч юм руу хушуураад дайрахаараа шуурганд уруудсан хонийг эргүүлэх гэж хичнээн шилбүүрдэвч дийлддэггүйн адил ажээ. Азрын нэг нь хамгийн урд зогссон Намсрайн охиныг зориуд янз үзсэн бололтой сүр бадруулан ороолгоход айж балмагдсан турьхан бүсгүй “Аав аа!” гэж дуу алдан гараараа нүүрээ дарж, орох байх газраа олж ядан дэмий л ганц алхам ч атугай ухрахыг оролдовч хүч мөхөстжээ.

Дуганын үүдэнд тусгайлан засч хивсэн олбог тавьсан вандан дээр хошуу ноён, түшмэд,

мяндаг тушаалтан лам нар ямбалан суужээ. Тэдний гол дунд луун хээтэй магнаг дээлэн дээр ёслолын хар хүрэм өмсөж, тогосын отго бүхий улаан жинстэй малгай тавьсан арван хэдэн насны шаравгар царайтай хөвгүүн суух нь хошууны үе залгамжилсан агь ноён болой. Ёс ёмбогор, төр төмбөгөр гэдэгт баригдсан агь ноён ямбаны хувцсандаа түүртсэн янзтай сууна. Өөрийн дураар үүгээр түүгээр хэсэн гүйж тоглож наадан яваа хүүхдүүд түүнд атаархам санагдах ажээ. Агь ноён хүүхдийн эмээх, гайхах хосолсон сониучхан нүдээр цамын бүжгийг харан алмайрч сууна. Ноёны баруун гаь талд улаан орой бүхий хар хилэн малгайтай хүрэн хамбан дээлтэй, улаан хамартай, ёлтолзсон ширүүн харцтай дөчөөд насны хар хүн, дугуй хээтэй шар торгон дээл дээр улаан чисчүү орхимж ороосон амандаа ном уншин баруун гараа хааяа өмнөө өргөн наманчилж нүдээ хагас анисхийн суугаа амгалан дүртэй бие жижигтэй, туранхай ламтай зэрэгцэн суусан нь хошууны тэргүүн туслагч Сэр-Од, түүний сүслэн биширдэг дүвчин ламтан Агваанлуvsан хоёр байлаа. Сэр-Од туслагч, эсрэг талдаа зогсоод юм үзэж байгаа Юмжирдуламыг цам эхлэхийн өмнөөс нүд салгалгүй ширтэж “Ямар сайхан амьтан бэ! Манай хошууных л байх даа. Мөргөлчин дагаж ирээ биз. Энэ удам хошуу нутагт хичнээн ийм цэврүү шиг бүсгүйчүүд миний нүднээс далд өнгөрдөг бол? Хаа буусный нь мэдэх арга олдохгүй байх даа” гэж хэрхэхээ эргэцүүлэн байснаа дэргэдэх лам руугаа тонгойж

- Та тэр бүсгүйг хараач! Лусын дагина шиг цэвэрхэн төржээ гэж эрх алдан үг унагахад ламтан

- Аа тэр үү? гэж хайхрамжгүйхэн дуугараад амандаа номын үг гүнгэнэж эрихээ гүйлгэснээ сая Сэр-Од руу харж

- Та мэддэггүй юм уу! Энэ чинь гүзээ Намсрайн ганц амин сүнс нь шүү дээ. Дээдсийн нүдэнд өртөх л охин байгаа юм гээд залирхгаар инээмсэглэв.

- Та таньдаг юм шив дээ?

- Тиймээ

- Нэрийй нь хэн гэдэг вэ?

- Юмжирдулам.

- Аа мөн мөн гэж туслагч амандаа гунганаад “Захын сум отог ч биш юмсанж. Миний өвөрт өсөж байгаагаас ялгаа алга. Тэгэхэд мэдэхгүй сууж байдаг яав даа. Өвгөрөхийн дохио гэхээс яах вэ. Надаас олигтой амьтан бол аль хэдийнээ...” гэж өөрийгөө голон цухалдав. Туслагчийнхаа хүүхэмсэг зантайг мэдэх ламтан тал засах ая шалтаг гарсныг юун эс андах вэ.

- Эр хүн шохоорхох бүсгүй шүү гээд лам өрөөсөн нүдээ доогтойхон анисхийв.

- Та түүнийг таньдаг юм бол цам тарахаар хүрэн дэх хашаандаа дагуулаад очоорой.

- Жа гээд лам хоолойгоо засав. Туслагч ойр байгаа нэг хиаг гараар занган дэргэдээ авчраад

- Тэр азарт зодуулаад байгаа баян Намсрайн охиныг аваад ир! Эндээс цам үзэг! гэж ихэмсэг ёсорхуу хэлбэл түүний харцнаас цаад санаагий нь мэдсэн хиа “Цам үзүүлнэ” гэдэг ч манж үг

дээ. Саваагүй зантай амьтан шүү. Энэ олон ихэс дээдсээс зовж нэрэлхэх нь яана аа” гэж бодоод өөрөө ч олны дундуур тийш шахалдан зүтгэхээс тээршааж

- Дээдсийн дунд эмс охид чирч ирлээ гэж ноён надад хилэгнэхгүй байгаа даа гэвэл туслагч үг ч хэлсэнгүй, би мэдэж байна гэсэн ширүүн харцаар нэвт сүлбэжээ. Туслагчийнхаа догшин харц зангаас сүнсээ зайлтал айдаг хиа ум хумгүй арилахдаа “Ноёныг элэг бариад дураараа загнаж сурсан хүн дээ. Энэ хошууны нүдэнд үзэгдсэн олигтой охидыг сорчилж гүйцээлээ. Түшмэл хүн гэхэд олиггүй амьтан” гэж амандаа үглэн хараал тавьсаар явлаа. Дээдсийнхээ элдэв паянг доод хүмүүс нь нэгд нэгэнгүй мэдэвч өөр хоорондоо дэмий л амны зугаа гарган хов жив болгон ярихаас биш, тэнгэр рүү харж байгаад тэр тэглээ гэж хашгирчих зүрхтэй хүн үгүй билээ.

- Чамайг туслагч хүрээд ир гэж байна хэмээн хиаг хэлэхэд Юмжирдулам архайж дархайн суусан хошууны ихсийн дэргэд очно гэхээс цөсөө хальтал айж мэгдэн

- Үгүй үгүй. Та бушуухан явж үз! гэж хоолой чичрүүлэн хэлэхэд өөрөө ухаангүй айчихсан хиа хожмын зэмээс мултрахыг хичээхдээ хүүхний айсныг огтхон ч тоохгүй харин ч

- Дээдэс таалснаас хойш оч оч! гээд гараас нь угзчин олны дундаас гулд татан авч гарлаа. Юмжирдулам туслагчийн хөлд сөгдөн iөргөвөл Сэр-Од түүний тохойноос найрсаар дэмнэн босгов.

- Азарт зодуулаад өвдөв үү? гээд туслагч бүсгүйг айлгаж үргээчихэлгүй, аятай харагдахыг хичээн инээмсэглэхэд Юмжирдулам эмээж сүрдсэндээ дуугарч ч чадсангүй.

- Аавын чинь бие тэнхээ сайн байна уу?

- Сайн бай... гаа...

- Айж зоволтгүй эндээс үзвэл чамд илүүтэй сайхан харагдана шүү гэж Сэр-Од их л найрсаг хэлэв.

- Намсрайн ганц охин азтай байна. Чамайг манай хошууны тэргүүн туслагчтан таалж байна гэж Агваанлуvsан дүвчин үл мэдэгч царай гарган өгүүлэв. Туслагчийг яасан сайхан зантай хүн бэ гэж санасан цайлган сэтгэлт бүсгүй тэр үгийн цаад санааг ухаарсангүй. Царайлаг төрсөн бүсгүй хүн ихэс дээдсийн харцанд бүхнээс түрүүнд өртөж зовох, завших хоёрыг хослон үздэг нэгэн нууцхан жам байдгийг бие цогц, сэтгэл санаа нь төлжиж гүйцээгүй энэ жаалхан бүсгүй хэдийнээ сэнхрэх билээ дээ.

- Чи цам үзэж байсан уу? гэж туслагч асуув.

- Огт үзээгүй. Одоо л...

- Эднийг хашин хааны хүүхэд гэдэг юм гээд туслагч инээсэн марзан багтай хүүхдүүдийг зааж. Тэр үхэр толгойтой нь Чойжоо бурхан. Бас тэр мял бурхан заларч яваа гэж цамд гарч байгаа бүхний учрыг тайлан ярихад бүсгүй ахимаг түшмэлд үнэн санаанаасаа баярлаж суув.

Олон унжлага шажигнуулан санжуулсан, ижилхэн гоё хувцастай хорин нэгэн дар эхийн бүжих нь Юмжирдуламд гоц сайхан санагдана.

Туслагч цам бүжихийг сонирхогч дүр үзүүлэх авч Юмжирдуламын бүсэлхийгээр тэврэн бие рүүгээ шахаж, түүний царай руу өлбөлзөн ширтэж сархдын донтой хүн лонхтой юмны бараа харчихсан мэт байн байн шүлсээ залгин санааширч байгааг уран бүжиг, уянгат хөгжим хоёрт татагдаж алмайрсан бүсгүй огтхон ч анзаарсангүй. Харин нярваан дүр үзүүлэн уруул нь үл мэдэг хөдлөн суугаа нойрмог нүдэлсэн Агваанлуvsан туслагчаа ажчихаад, “Сархад, бүсгүй хүн хоёр мөн ч их шидтэй юм даа. Ямар ч хүнийг толгой мэдүүлэлгүй эрхэндээ оруулдаг байна шүү. Энэ хоёрт шунасан хүн эрээгээ ч алдах юм. Хошуу хүрээний цам гарч байхад ноёны оронд ноён болсон тэргүүн туслагч түмний нүдэн дээр ингэж ч суух гэж дээ. Энэ туслагчийн хийсэн нүгэл дээд язгуурынхаа нэрэнд хучигдаад өнгөрөх юм” гэж зүвүүрхэн байтал туслагч өөдөөс нь санаандгүй харчихсанд ярвайж байсан нүүрнийх нь үрчлээ тавигдаад хуурмагаар инээмсэглэж хөхүүлэн таашаасан янзтай мэхэсхийжээ. Бүсгүйн халуун илч сүвээнээс нь төөнөхөд туслагчийн хамаг сэрэл нь хөдөлж улам чанга тэвэрч байлаа. “Өвгөн ноёнд боогдож залуу насаа завшаан багатай өнгөрөөсөн юмсан. Одоо намайг ингэж суухад хэн ч өөдөөс ам ангайж чадахгүй юм чинь. Ядаж хөндлөнгөөс хошуу амаа билүүдэх хатангүй нь яамай... Бүхэл хошуу Сэр-Одын амаар хөдөлж байна. Санаснаа гүйцээхэд хориг саад болох юмгүй нь сайхан. Агь ноён яах вэ дээ, одоохондоо эрхлэхээс өөр юу ч мэдэхгүй дээрээ байна. Төрийн хэрэг мэдэх ухаан гүйцлээ ч нэг хэсэгтээ миний санаагаар явах нь зайлшгүй. Би ч бас ноёныхоо толгойд өөрийнхөө ухааныг шингээхээ дөнгөх байлгүй. Ноён биш атлаа ноёны амаар дуугарч байна гэдэг мөн ч их заяа шүү” гэж Сэр-Од өөрийн эрх мэдлийн ихийг бахдан бодохдоо сэтгэл өег байлаа. Хамаг бие нь хөшиж, амьсгал нь давхцах шиг болоход Юмжирдулам түшмэлийн тэвэрснийг гэнэт ухаарсан авч сүрнээс нь айн айсаар гарыа нь зугуухан түлхэхэд түшмэл тавьсангүй. “Бурхан минь, ихэс дээдсийн дунд яаж байгаа нь энэ вэ. Ээ, бурхан минь, яасан хачин харах юм бэ. Хайрлаж энхрийлсэн ах хүний харц арай биш дэг. Нэг л аймаар түшмэл байна шүү. Одоо яана аа” гэж бүсгүй ийш тийш эмээнгүй харвал анзаарч ажсан хүн ер үгүй. Ганцхүү түүнийг анх авчирсан залуухан хиа л шохоорхож сонжсон янзтай харж байснаа харц тулгармагц цаанаа л нэг тохуутай жуумалзаад дэргэдэх хүнийхээ чихэнд нэг юм шивнэхэд нөгөөх нь инээж байв. Бүсгүйн хамаг бие халуу төөнөж, хасын цагаан царай нь час улайлаа. Нэг л жирийн биш хэрэг болох нь гэдгийг Юмжирдулам бүсгүй хүний зөнгөөр гадарлажээ.

- Би морио хараатбая гээд бүсгүйг булт үсрэн ухасхийхэд гэнэгүй байсан туслагч түүнийг ханцуйн дээрээс нь шүүрэн тогтоож

- Зүсийа нь хэлчих. Би хиа зараад харуулчихъя. Ер нь манайхны морьдтой нийлүүлчих гэж хэлье. Эндээ юм үзэх нь чамд таатай бус уу? гээд хиагаа хайн харуулдав. Юмжирдулам түшмэлийг бүр салахгүй болох нь гэж санахаас айдас нь хүрч хэрхэх ухаанаа олохгүй мунгинаж, дуугарч ч чадахгүй ээрэн зогстол гэнэт нэг сайхан бодол сэтгэлд нь харван орлоо.

- Үгүй ээ... унаж яваа морь биш ээ гэж сандарсандаа түгдчин хэлээд дороо хавчигнасанд туслагч

- Аа, за за. Хурдхан яваад эргэж ирээрэй! Одоо улам гоё юм гарна шүү гээд түүнийг тавив. Юмжирдулам хавхнаас тасдуулсан зээр шиг түшмэлийн дэргэдээс огло үсрэн холдож бөөн

хүний дундуур зүсэн орж алга болов. Тэгээд нэг газар хяран зогсч олон хүний хоорондуур тохь муутайхан цам үзжээ. Туслагч түүнийг хүлээж ядсан бололтой тал тал тийш харуулдан өндөлзөж сууснаа нөгөө хиагаа дуудан үг хэлж явуулав. Хиа нь нэлээд удсаны хойно эргэж очиж туслагчдаа нэг юм хэлэхэд туслагчийн царай хувьсхийж, нүд нь гялалзаад уур омог нь хөөр÷ аймшигтай догшин ширүүн болох шиг бүсгүйд санагджээ.

Цам дэгэлж гүйцэхэд сүнсийã нь авчих шахсан эрхэмсэг түшмэлээс зайлж амжсандаа айхын аюулгүй болж сэтгэл амарсан Юмжирдулам хүрээний гоёмсог сүм дуган, түүн доторхи айдас хүрэм догшин сахиус бурхад хээнцэр чамин тахил тавил, их дуганд зээглэн суугаад хурал хурж, ном ягнан хэнгэрэг цангийн дуу нижигнэж байгаа олон лам нарын сүрдэм байдал, орон барилгын бишрэм сайхан ур хийц, хээ хуарыг нүд хужирлан сонирхов. Хүрээний гудамжаар явж байхад сүмийн гуулин хонхнуудын жингэнэх, болжморын жиргээнтэй хослон түмэн хөг аялга үүсгэн хангинан цуурайтах нь бүсгүйд сонсовч ханашгүй сонин санагдсан учир үе үе зогсож чагнан чагнан, ахин дахин сэтгэл баяссаар явлаа. Тэгээд эцгийнхээ өгсөн хэдэн янчаанаар багынхаа дуртай мөсөн чихэр, бурам танзуур авах далимаар хэдэн пүүсээр оров. Түүний анхны орсон пүүсний эзэн нүдэндээ дугуй чулуун шил зүүсэн намалзсан шар луухаан маасайтлаа инээмсэглэж

- Юм юмаа байна шүү. Юу авна аа? гээд элдэв янзын эд агуурс авчирч дэлгэхэд санаа зовсон бүсгүй.

- Үгүй үгүй. Би юм авахгүй гэсэнд луухаан шигтгээтэй алтан ээмэг авч бүсгүйн чихнээ баригч болон далимдуулж хацрыã нь хальт илбэж нэг үзээд

- Ийм хөөрхөн хүүхэн ийм гоё ээмэг авахгүй яах аа. Хямдхан өгнө шүү. Дараа манайд ирвэл зүгээр өгсөн ч яах аа гээд олон үг муруй хазгай хэлж урсгахад нь Юмжирдулам

- Хэг, хүүхэн байхдаа яах вү дээ гэгчхээд шурхийн гарлаа. Гэрээсээ холдож хүний амьдралын шалдар булдар үгсийг дуулж яваагүй, тэр тусмаа таних мэдэх ах зах хүмүүс нь түүнийг “Охин минь” гэсээр дасчихсан болохоор “Хүүхэн” гэдэг үг түүний чихэнд тун ч нийцгүй сонсогджээ. “Хүүхэн гэдэг чинь том хүн байлгүй яах вэ. Намайг хүүхэн гэхдээ ичих нь яана аа” гэж бүсгүй ихэд зэвүүрхсээр боовны мухлагт очлоо.

- Ёстой сайхан боовоо бий шүү. Үзваа, үзваа гэсээр ид дунд насны тарган хятад алцаганан босч ирэв.

- Үзэхгүй, үзэхгүй. Танзуур гурван жин, бурам ганц жин, мөсөн чихэр хоёр жинг боогоод өгөөрэй!

- За за, одоохон гээд хятад сурмаг гэгч нь жигнэж өглөө.

- Маатан авахгүй лаа?

- Түүнд чинь би дургүй. Шүд сугалчих шахдаг юм.

- Манай маатан тийм ч муу биш шүү. Чи амс ваа. Их сайхаан гээд хятад маатангийн хагархай

авчирч алган дээр нь тавихдаа өөдөөс нь учиргүй шуналтай гөлийн ширтэж, нэг алгаараа түүний тоссон гарынх нь доороос илээд орхисонд бүсгүйн эгдүү хөдөлж маатангий нь өөдөөс нь шидчихээд гарсанд хятад “Ха яа!” гэж дуун алдаад хоцорчээ.

Юмжирдуламыг морь руугаа дөхөж явтал дэгжин хувцасласан халамцуу байрын өндөр хархүү замы нь тосон хөндөлсөж

- Сайн байна уу? гэхэд нь бүсгүй булга тусч мэндийн хариу хэлээд явах гэтэл хархүү өмнүүр нь хэрж

- Чи чинь Намсрай гуайн хүүхэн шив дээ гэхээр нь

- Яршиг даа, хүүхэнсээд байхдаа яах вэ дээ гэсэнд

- Чи алийн болгон хүүхэд байх гэсэн юм бэ?... юундаа яарах вэ. Би чамд гологдохооргүй баян айлын хүү шүү. Манай нэг түншийнд хоёблаа очиж жаахан наргия. Маргааш яв л даа гэж ээрээд саламгүй болохоор нь Юмжирдулам айж

- Аав загнана гэж уйлагнан хэлбэл халамцуу эр өмнөө чичрэн зогсч буй бүсгүйн нүдэнд цийлэгнэсэн нулимсыг ажиглаад

- Үхсэн хойноо хүүхэн бол доо гэж нулимчихаад яваад өгөв. Юмжирдулам дахиад бас юу нь хүрээд ирдэг бол хэмээн сэтгэл зовж, мориндоо шогшиж хүрээд авсан юмаа хурдхан ганзагаараа даруулаад мордохдоо “Ээ Балданлхам минь! Хүрээ гэдэг чинь хүн явах аргагүй яасан аймшигтай газар вэ. Дахиад ирэмгүй юм байна” гэж бодоод тэндээс бушуухан холдохын хүслэн болжээ.

Гуравдугаар бүлэг

Азтай учрал

Ухваргүй нэгэн хэргээс

Удаах мянга нь үүсмой

Сэр-Од туслагч ноёноо бараа бологсдынх нь хамт зуслангийнх нь өргөө рүү явуулаад өөрөө Агваанлувсан ламын хамт хүрээн дээрх хашаанд нь очжээ. Ганц жангийн дүнзэн байшингийн хоймрын ширээний хажууд лам түшмэл хоёр өөд өөдөөсөө харан сууна.

Юмжирдуламыг алдчихсандаа туслагч баргар царайлан байн байн хөмсөг зангидан тун ч тавгүй байгааг ламтан мэдэж байлаа. Туслагчийн сэтгэлийг засаж тал олохоо Агваанлувсан дөнгөх хүн. Тиймээс ч хиадаа уурсан дэмий л бухимдаж байсан туслагчийг дагуулан иржээ.

- Туслагч та сархад зоогло гээд мөнгөн хундагатай архи хоёр гардан бариад

- Тэр бүсгүйн явсныг харсан хүн алга. Хүрээн дээр хонох биз. Би нэг бандийг аль өмнөөс хашаан дээр харуулд суулгачихсан. Тэр лав хэлнэ гэж туслагчийг тайвшруулж байв. Дүвчин ламынхаа үгэнд сэтгэл сэргэсэн туслагч “Энэ лам ч хэцүү санаатай хүн дээ. Тэр хүүхний энд байгааг мэрэг төлгөөрөө ч мэдчихсэн юм бил үү. Сэтгэл санаагий нь над руу эргүүлэн зассан ч чадах лам даа. Тэр хүүхэн хүрээн дээр л хоноосой билээ. Тэгвэл ч миний амнаас гарахгүй л дээ” гэж Сэр-Од бодон сэтгэл ялихгүй уужирч ламын хундгалсан сархдыг цааргалалгүй тогтоосоор байлаа. Тэгтэл нэг дэлдгэр бор банди гүйн ирж хаалгаар шагайн

- Багш аа, халиун морьтой бага шиг бүсгүй хүн хойшоогоо явчихлаа. Тэр биш байгаа даа гэж хашгиртал Сэр-Од хундагатай архиа ширээн дээр шидчихээд босон харайв.

- Туслагч та суузна. Сандраад яах вэ. Ондоо ч хүн байж болно. Юу ч гэсэн би урьдаар хараатхая гээд Агваанлувсан хоргоноос дуран авч орхимжоо чирсээр гарав. Хэдэн хормын дараа аахилсаар орж ирээд

- Мөн. Үйлийн үргүй мөн гэж амьсгаадан хэлэхэд туслагч ламын жижиг байшингаас харайн гарч уяатай морио санд мэнд тайлж аваад явуут дунд нь мордон, булчин мах нь хөвчрөн зангирсан бүдүүн гуянд нь ташуур өгч тэртээ хойт дөрөлжийн наад хавтгайд яваа морьтой хүний араас давхив. Сэр-Од архинаас зовхи нь улайж манантсан сүүмгэр нүдээ жартайлган өмнөх морьтноо ширтэн гүйцэхгүй хоцорчих бий дээ гэхээс улам адгаж, морио сэлгээгүй ташуурдана. Түүний малгайн хос залаа хойш дэрвэн хийснэ.

Тэнхээ мэдэн харайлгаж байгаа мориныхоо явдал дунд “Ээ золиг гэж. Ламбугайг харуул тавьж тус болоогүй бол би түүнийг хүрээн дээр хонох юм гэж санаад аажуу уужуу учры нь олох гэж байгаад алдчих байж шүү. Түүнийг ганцаарангий нь хэрэггүй явуулав байна. Хиагаа л дагуулдаг байж. Тэгсэн бол Дүвчин ламынд дагуулж оччихсон өдийд ёстой нэг наргиж суухгүй юу... Хамар дороо ийм хөөрхөн амьтан өсчихөөд байгааг мэдэхгүй суудаг тун тоогүй. Хар ус залгисаар байгаад энэ муу хоёр ногоон чинь юм үзэхээ болио юу? Тэгэх ч ёсон үгүй дээ. Тийм нүд булаам амьтан байх гэж. Тэнгэр бурхан манай хошуунд сайхан дагинаасаа

гомдоохооргүй хайрлах юмсанж. Хошуу хотлоо байг гэхэд ойрын сум отгоо ялихгүй ч гэсэн хэргээр эргэж тойрч явах нь тустай бус уу?” гэж туслагч бодохын сацуу

- Энэ муу адсага чинь газар хороохоо больчихоо юу даа гэж морио зүхэж толгой руу нь нэг удаа ороолгоод авлаа. Туслагч “чүү, чүү” гэж морио давьчиж ташуурдан өөрөө ч урагш өхөлзөн зүтгэж явахдаа “Эв нь таарвал хатнаа болгоё гээд үзвэл яадаг бол? Даанч бага юм уу? Хошууны тэргүүн туслагч ямар ч хүнийг шилж таалъя гэвэл дур шүү дээ. Түүний өмнө хориг тавих хүн байх биш. Болохгүй бол богтлоод ч авах ёс байна. Язгууртан хүнд охиноо өгөхгүй гэх тэнэг толгой бий гэж үү? Яггүй сүрхий санаатай эцэг эх царайлаг төрсөн охиноо ихэс дээдсийн гар дээр эв аяы нь олж байгаад л тавьчихыг боддог биш үү. Тэгснээрээ ч тэд энэ хорвоогоос хожих юмаа хождог. Намсрай чухам ямар хүн бол? Нэг үе ч дээдсийн зиндаа руу тэмүүлээд үзсэн шүү. Намсрай охиноо надад өгвөл өөрөө л өөдөлнө. Хошууны бүх мэдэл миний гарт байгаа цагт Намсрай шиг эрийг сайн, муу аль замаар явуулах нь миний дур... Төрхөмдөө буцсан тэр муу мондийг дагуулахгүй ганган хатантай болчихсон сууж байхсан” гэж бодохдоо түүний архи, халуун хоёрт минчийж хүрэнтсэн царайд өнгөц инээмсэглэл зурсхийв.

Дөрөлжийн өврөөс хоёр хүн цувран өгсөн явах үед араас нь нэг хүн яаралгүйхэн гарч ирсэн нь Базар байлаа. Тэр залуу ойртон ирж яваа Юмжирдуламыг таниад хойноос нь унаагаа хайрлахгүй давхиж яваа хүнийг гайхан таньж ядахдаа урьд шар дурангаа сунган харж тэргүүн туслагч Сэр-Од болохыг танимагц царай нь хувьсхийв. “Чи муу зөнөг түшмэл ингэж явдаг вий. Чиний санаа чонын санаа хоёр ив ижил” гэж Базар бодоод модон дунд морио бөхлөөд түшмэлийн яахыг хүлээн нуугдав.

Юмжирдулам дөрөлж дээр гарч ирээд хүрээний барааг эргэж нэг харлаа. Цэмцгэр бүсгүйн том хар нүдэнд Түдэвтэй уулын мөнх цасан дуулга хөх цэнхэр тэнгэрийн доогуур цайвалзан үзэгдэнэ. Уулын арыг хучсан өтгөн ногоон ой, Галуутайн голын зах хүртэл хөглөрөн үргэлжилнэ. Голын хөвөөнд байгаа их хүрээний сүм дуган гоёмсог сайхнаараа бүсгүйн харцыг булааж алтан ганжрууд нь оройн нарнаа шаргалтан гялалзана. Өдрийн үзсэн цамын сонин сайхан дэг ая, хорин нэгэн дар эхийн уян налархай бүжгийг санаандаа дүрслэн бодож сэтгэл сэргэн баясч “Базар минь тийм сайхан юм байдгийг үзсэн болов уу. Түүндээ бушуухан ярих юмсан. Хоёулаа ч үзсэн болоосой. Тэгсэн бол тэр түшмэл гуай яаж ч чадахгүй дээ” гэж бодож байтал урдхан талд нь малгайн орой шоволзсоор нэг морьтой хүн цогиулан гарч ирэв.

Туслагч, бүсгүйг цааш явчихсан гэж санаж явснаа ийнхүү цавхийтэл тулгарсанд хирдхийг цочиж, тэрхэн зуур ялимгүй эвгүйрхэж, хэрхэхээ бодон мориныхоо амыг татлаа. Хүнд ташуурын эрхэнд автай элсэрхэг өгсүүр газар тэнхээ тамираа шавхан хар хөлсөө цувуулсаар гарч ирсэн хөөрхий адгуус хүч алдран зогсов. Хоёр бөөр нь түнхэлзэж, хамар нь сарталзан жавьжаар нь цагаан хөөс сахарч, хөх мах нь чивчигнэнэ. Туслагч өөрөө ч явган гүйчихсэн юм шиг морин дээрээ цээж түхэлзэн амьсгаадаж байлаа.

Юмжирдулам мориныхоо амыг эргүүлэн ухасхийх гэснээ туслагчийн яарч мэгдсэн царай, дөрвөн хөл дээрээ арай ядан тогтож байгаа усан хулгана болсон морийг нь ажаад, түүнийг яаруу албаар явахад нь саад болуужин хэмээн сэтгэж хажуу тийш болон зам тавиад, ёсыг бодон мориноосоо бууж, хүндлэн өнгөрүүлэхээр мэхийв. Гэтэл Сэр-Од шууд дэргэд нь ирж буув. Бүсгүй сүрдсэндээ дэмий л хойш ухрав. Сэр-Од тэрхэн зуур ярих юмаа олж ядан

бүсгүйг дэргэдээ суу гэж дохиод даалингаасаа сүйжин хөөрөг гарган тамхилжээ. Яах гэж буйн учрыг мэдэхгүй балмагдаж хоцорсон бүсгүй сөхрөн суугаад түүний хөөргийг хоёр гардан авахдаа гар нь чичирч байв. Сэр-Од бодол болон дүнсийж тамхиа шунаг татаж морь үргэмээр чанга чанга найтаалгав.

- Чи яагаад эргэж ирсэнгүй явчихав? гэж туслагч эелдэгхэн асуугаад түүнийг нүд цавчилгүй ширтэв. Юмжирдулам гэмт хүн мэт айж юу ч хэлж чадахгүй газар ширтэн зогсоно.

- Чи багадаа нэг муу годгор охин байсан даа. Одоо хэний ч хараа булаам дориун хүүхэн болжээ гэж туслагчийг хэлэхэд Юмжирдулам ичих эмээх зэрэгцэж хацар нь туслагчийн хөөргөний улаан шүрэн толгой шиг болжээ. “Аав шиг хүн байтлаа яасан хачин юм хэлнэ вэ? Шал согтуу ч юм уу” гэж бүсгүй бодлоо. Эзгүй хээр таарсан энхрий бүсгүйг элэг барьж, яасан ч яах вэ гэж санасандаа Сэр-Од ийнхүү эрээ цээргүй илэн далангүй ярих гэсэн юмсанжээ. Ламынд уусан хэдэн хундага хар архи аргиж яваа зүрх зоригийг нь чангалаад орхижээ.

- Юмжирдулам аа! гэж туслагч цаанаа нухацтай дуудаад, түүнд ойртой сууж,

- Чи надаас айж зовох хэрэггүй. Хоёулаа сайхан ярилцъя. Би хошууны чинь тэргүүн туслагч шүү дээ. Чи одоо манайхаар орж биеийнхээ алжааг гаргахгүй юу. Манайд саатсан гэдгийг би маргааш эцэгт чинь дуулгая гэж өгүүлэв. Туслагч их л шүлэнгэтсэн янзтай юм ярьж Юмжирдулам руу дөхөж суугаад байгааг далдаас нүд цавчлахгүй ажиж байгаа Базар арай ядан биеэ барьж зогсоно.

Бүсгүйн сэрвийсэн сормуустай мойл хар нүд, төмсний цэцэг шиг ягаан урбóл, булбарай зөөлөн хацрыг харах бүрийд Сэр-Одын зүрхний цохилт хурдасч бие сэтгэл нь муу зүгийн хоронд автаж, зүүгээр хатгавч мэдэхгүй болтлоо мансуурчээ.

- Туслагч гуай, би оройн саамнаас наана харихаас тун болохгүй гэж бүсгүй дуулдах төдий хэлээд мэхэсхийв. Шунал тачаалдаа ухаан солиорох шахсан түшмэл эрээ цээрээ алдаж “Энэ муутай ёсорхож сүйд болж цаг нөхцөөгөөд яах вэ. Тэртээ тэргүй муусайн харц боолууд ёс мэдэх биш. Барлагтай нь барлагийн ёсоор уулзвал барав” гэж санаа эрсдэн.

- Чи хорвоогийн жамыг мэдэхгүй байна. Чам шиг царайлаг төрсөн бүсгүй хүн хонины хорголон дунд өнхөрч байдаг юм биш. Ноёд түшмэдийн баян тансаг өргөөнд очиж цэнгэж жаргахаас илүү заяа тавилан байхгүй гэж хэлэв. Юмжирдулам түүний буцаж няцах янзгүй эрс байдлыг мэдээд салахгүй бол яана даа хэмээн айхдаа царай нь хувхай цайж, хамаг бие нь чичирч байлаа. Тэгээд хүн гэсэндээ түүний гараас мултрах арга бодож олоод

- Туслагч гуай, та намайг өршөөж хайрла! Аав минь надад зовж байгаа. Би хожим аавд худал хэлээд хүрээ орох нэрээр гэрээсээ гарч ирье. Тэр цагт та намайг таалалдаа багтаахгүй юу” гэж учирлан хэлээд, “Базар минь ячихав аа? Арай ирэхээ больчихсон юм биш байгаа. Эсвэл Хүрээ рүү очоод зөрчихөв үү? Одоо би яана” гэж бодон ийш тийш горьдож хүлээсэн нүдээр гүйлгэн харснаа мориндоо мордохыг завдав. Бусдыг мэхэлж сураагүй бүсгүйн гэнэн царайд худал хэлсэн нь илхэн байгааг ажсан хашир түшмэл “Үгээ нууж чадахгүй байж намайг хуурах юм гэнэ ээ” гэж бодоод

- Чи өөрийн үзэсгэлэн гоо царайгаар дээдсийн дунд зугаацан наргих ерөөлтэй төржээ. Тэр сайхан хувь заяанаас зугатвал эцэст гэмшивч баршгүй болно гэж хэлээд тэвчээр алдан бүсгүйн жижигхэн цагаан гарыг шүүрч авав. Түүний тачаангуй харцнаас айсан Юмжирдулам

- Аав аа! гэж мод хаданд цуурайттал огцом чанга хашгираад гараа угз татан авч мориндоо мордох гэж оролдоход Сэр-Од цулбуурыа нь шувт татан авч “Чоно өтлөвч хургандаа, цорж өтлөвч балиндаа зөв. Эзгүй хээр ингээд алдвал амаараа орсон хишгийг хэлээрээ түлхэнэ гэгч болно. Миний урдóр улаан хөлтэй юм тийм ч амархан гардаггүйсэн” гэж бодон бүсгүйн гоолиг бэлхүүсээр тэврэн авч мориноос нь холтгов.

- Таминь ээ, яадаг билээ! гэж бүсгүйн цурхиран орилох дууг ойн цуурай хангинатал давгав. Базар хайрт бүсгүйгээ туслагчийн гараас салгахаар модны араас дөхтөл халиун морь зулран алдуулаад дөрөлжийн замаар уруудав. Эмээл, хазаарыа нь эвдүүлчихгүйг хичээж морийа нь барьж авахаар амьа нь тостол номхон халиун ч хэд шогшсоноо ижил сүргийхээ морийг хараад зогтусан үүрсжээ.

Туслагч, бүсгүй хоёр дээр дороо орон ноцолдоно. Архинд хөлчүүрхсөн туслагчид айсан бүсгүй тийм ч амархан дийлдсэнгүй. Юмжирдулам туслагчийн хавьтсан газар нь хазаж базаж, нүүр нүд рүү нь хичнээн дэлсэвч цаадхи нь огтхон ч тоохгүй улам махран ноцож байлаа. Сэр-Од хэдий согтуу ч эр хүн болохоороо тэнхээ тамир дулимаг бүсгүй хүнийг эздийлэн дарж унав. Түшмэлийн амнаас ханхлах архи, тамхины нялуун үмхий үнэрт бүсгүйн ой гугаж дотор нь харанхуйлна. Юмжирдулам хүчинд авгаж аргаа барахдаа Сэр-Одын нүүр рүү нулимж уйлан бахиран тийчлэв.

Морио барьж бөхөлж амжсан Базар “Чамайг би нэг болгоод өгье! Хавьтсан бүхнээ бузарлах хүсэлтэй түшмэлд үзээгүй шүүлтгийа нь үзүүлье!” гэж занасаар харайж хүрэхэд доод ертөнцийн нүгэлт хоронд давхар согтсон туслагч юуг ч анзаарахгүй болтлоо улангасчээ. Нэгэн хүчит гар Сэр-Одын далан дээрээс дээлтэй махтай нь умартал базаж, ховх татахад энгэр заамных нь товч шилбэ ханзарч, арьс мах нь хуурчих шиг болов. Өөрийн биенд ийнхүү аймшиггүй халддаг ямар амьтан бэ хэмээн уурсан үзвэл, нүд нь хорсолтойёо гялалзаж, хөмхийгөө тас зуусан өндөр залуу зогсч байв. Базар түүний хоолойг шахан мод руу түрж

- Дэүд язгууртан байтлаа малнаас доор аашлана бий! Чамайг цааш нь харуулчихвал бурхан таална гээд том хутгаа сугалан дүрэх гэтэл

- Ээ, дүү минь өршөө! гэж туслагч хоёр гараа наминчлан муухай орилж

- Туслагч гуай нь сархдаа хэтрүүлээд ухаан алджээ гэж бувтнав. Базарыгаа хүн алах нь гэж үнэмшсэн Юмжирдулам ч айсандаа түүний хутгатай гараас зуурч

- Ээ Балданлхам минь! Яаж болдог юм бэ гэж дуу алдан уйлагнахад залуу хутгаа хуйнд нь хийгээд Сэр-Одыг нуруугаар нь мод мөргүүлэв. Түүний амнаас цус амтагдан ухаан нь балартжээ. Сэр-Одын ухаан санаа сэргэн нүдээ нээхэд Базар түүний урд хэзээ хэзээгүй дайран сүлбэх гэж байгаа хүрдсэн бух шиг хялайн харж зогсоно. “Үүний гараас амьтае голтой сална гэж үү. Амьтан хүн хүрээд ирэх бий дээ. Улаан зам газар дэмий юм боллоо” гэсэн бодол туслагчийн толгойд орж ирэв. Сульдсан морь нь толгойгоо унжуулан зогссон хэвээр.

Оройн сэрүүн салхинд модны навчис үл мэдэг сэрчигнэхээс өөр өчүүхэн ч аниргүй. Юмжирдулам дээлийнхээ шороо тоосыг гүвж, бүсээ засан бүсэлж байлаа.

- Тэр малгай аваад аль! гэж Базар, туслагчийн хөсөр унасан малгайг Юмжирдуламаар авахуулав.

- Бүсгүй хүн, ертөнцийн тоос хоёртой хутгалдаж байснаас ариухан салхинд байвал дээр гээд залуу туслагчийн малгайг модны орой өөд шидчихсэнд малгай нь модны мөчирт өлгөгдөв. Сэр-Од айгаад юу ч хэлсэнгүй. Энэ хэрэг яаж шувтрахыг бүү мэд. Түрүүхэнд нь хүн үзэгдэх бий гэхээс ичиж байсан бол одоо “Нэг хүн хүрээд ирдэггүй юм байх даа. Тэгвэл энэ гайхлын гараас мултрахсан. Эзгүй хээр хошуу туслагчаа барьж зодсон гээд ялд унагахад юухан байх вэ. Тааралдсан хүнд хэдэн лан хаяхад л туслагчийн хишиг гэж чимээгүйхэн хүртчихээд миний хэл гэснийг л хэлнэ шүү дээ” гэж бодов.

- Ноёны нэр барьж олон хүний мах идсэн түшмэл дээ, чи! Одоо тэр олон гэмгүй хүнээс зулгаасан махныхаа хэсгийг ч болтугай буцааж өгөх ээлж болж дээ гэж Базарыг шүд зуун хэлэхэд туслагч “Энэний гарт амь үрэгдэх хэрэг болжээ. Хаашдаа өнгөрлөө” гэж цөхрөн бодов. Тэгтэл түүний нүүрэн дээр анхны нударга буув.

Сэтгэлтэй бүсгүйгээ өмөөрч хилэн хорсолдоо ухаан алдах шахсан залуу эр аргиж яваа түшмэлд хүчит нударганыхаа амтыг ханатал үзүүлж, хэдэнтээ мод мөргүүлээд тавихад Сэр-Од газар саван ойчлоо. Залуу эрийн өшөө хорсол үүгээр тайлагдсангүй. Түшмэлийн морийг сул тавьж хөөлөө. Тэгээд хоёул морьд руугаа алхав.

Сэр-Од сэргэж нүдээ нээлээ. Моддын мөчир гишүү бүүдэртэн бараантаж, түүний чөлөөгөөр тугалган бараан тэнгэр мэлтийнэ. Хавь орчин нь эл хуль дүнсийнэ. Туслагч үдшийн бүрий болтол ухаангүй хэвтэж хувцсанд нь чийг даасан байлаа. Босох гэтэл бүх бие нь хөндүүрлэнэ. Нэг зовхи нь булуу болтлоо хавдаж нүдий нь таглажээ. Нүүрээ илэхэд гарт нь цус наалдаж байгааг бодоход ямар нэг газраа шалбарсан бололтой. Арай ядан өндийхөд цээжнээс нь цус амтагдав. Хоолойгоо засаад нулимахад бөөн нөж уналаа. Туслагч хөл гараа хөдөлгөн босч морио хартал морь нь алга.

Модонд өлгөөстэй малгайгаа авахаар эцтэлээ оролдоод чадсангүй, амьсгаадан суув. Түшмэл хүн амьсгын сүнс болсон отго жинстэй малгайгаа эзгүй хээр хаяад явах аргагүй. Олны явдаг харгүй замын дэргэдээс туслагчийн малгайг хэн нэг нь олбол ямархан шуугиан дэгдэх билээ. Ингэж суутал гай болоод хүн амьтан дайралдах бий гэж туслагч санаа зовно. Тиймээс байн байн чимээ чагнан хүн явбал модны араар нуугдан өнгөрөөхөд бэлэн байлаа. Малгайгаа авах гэж модтой ноцолдсоор байтал харанхуй болж од түгж эхлэв. Сэр-Од модонд авирах гэж дэмий оролдож дээлээ ч урж, давирхай болгожээ. Түвэг удалгүй малгайгаа авчих арга байсныг дэндүү оройтсон хойно оллоо. Нэг чулуу олж бүснийхээ үзүүрт уяд ахин дахин шидэж байж малгай өлгөгдсөн мөчрийг оосорлож хугалжээ. Туслагч малгайгаа авсандаа учиргүй баярлаж дээд тэнгэрт залбирснаа өөрөө ч мэдсэнгүй.

Морио эрээд олдохгүй болохоор нь “Малгайтайгаа байхад морь зэрэг ч яамай. Юу ч гэж хэлээд нэр цэвэр хоцорч болно” гэж тайвшраад өргөөнийхээ зүг алхаж гарав. Саахалтын газар ч явган явж үзээгүй ямбатай түшмэл хээр хонохгүйн эрхэнд хөлсөө цувуулан амьсгаадан

алхана. Архи нь гарч хамаг бие нь сулбайн тамирдана.

Оройныхоо явдлыг эргэцүүлэн бодох тусам уур нь хүрч цухалдана. Харц ядуусыг аливаа ялд унаган ясанд нь хүртэл балбаж байснаас биш, өөрийнх нь биенд салхинаас өөр юм хүрч байгаагүй болохоор тийнхүү жанчуулсан нь зүүдэнд оромгүй явдал болжээ. “Сүхийн тэр олигор хар хүн алахаас ч буцахгүй дэг шүү. Би жаахан ширүүлсэн бол нухчихаад явах байсан даа. Хошуу туслагчдаа гар хүрэхийг огтхон ч цээрлэхгүй байна гүэч. Ноёд дээдсийнхээ өөдөөс архирвал ямар байдгийг чамд мэдүүлээд өгье. Харц боолууд ухаарч аваг! Толгойгий нь өндийлгөхгүй дарж байхгүй бол муусайн боолууд яаж ч мэднэ. Сүх хэзээний лам, түшмэл хоёрт тоомжиргүй байдаг золиг. Нохой бүрийн санаа адил гэгчээр хүү нь бас ижилхэн бодолтой байгаа. Ноёноо нохой шиг бодвол яадгийг чамд үзүүлэх цаг бий” гэж Сэр-Од занал хорсолдоо автан хор шар нь буцалж шүдээ тас зуугаад уурандаа хурдан хурдан алхаж явлаа.

Туслагчийн морийг сүрэгтээ очиход адуучид ухаан алдан сандарч өргөөн дээр давхиж иржээ. Тэгээд хэдэн хиа нижгээд морь хөтлөн хүрээний зам дагуу гарав. Тэдний нэг нь харанхуй дунд сүүдэгнэн явж байсан туслагчаа олов. Туслагч уурандаа морины цулбуурыг үг дуугүй шувт татан авч мордон давхихад хиа зодуулаагүйгээ аз гэж бодон хоцорчээ. Санаа зовон хүлээцгээж байсан өргөөнийхэн туслагчийн эсэн мэнд ирсэнд баярлаж юу болсныг шалгаахад

- Муу адсага чинь санаандгүй явгал булгиж би нүүрээрээ харуулдаж унаад үхэх шахлаа гэж Сэр-Од муугаа мориндоо чихээд гэртээ орлоо.

- Хиа нараасаа авч явахгүй дээ гэж нэг түшмэлийн харамсангүй хэлэхэд нөгөө нь туслагчийн урагдаж салбараад давирхайн үнэр ханхалж байгаа дээлийг ихэд гайхаж харж

- Та мориндоо чиргүүлээ юу? гэж туслагчийнхаа хэлсэн шалтагт хүмүүсийг эргэлзүүлэх үг цухуйлгахад хэрэг явдлыг нууцлан үлдээх гэсэн Сэр-Одын уур гэнэт дүрсхийж

- Гарцгаа! Мориноос унасан хүн үзээгүй юу? гэж зандарсанд мээрэн, занги, хиа, бичээч нар чимээгүйхэн гарч одоо.

Хошуу туслагч бодолд автан сэтгэл гонсгор сууна. Булангий нь гуулиар бөгжилж, зүмбэрдсэн хээтэй авдрын нүүр лааны гэрэлд шаргалтана. Хуучиатар нүүртэй өргөн палигар орны хөл, толгой хоёрт алтан саа, хоргой, мөнгө, туушин сэлтээр эрээн мяраан болтол урлан чимсэн дэр нижгээдийг тавьжээ. Түшмэлийн зан, орны намба төрх хоёрыг харваас мөн ч их юм элээсэн байх гэж санагдана. Түшмэл үнэхээр хань ижил тогтоодоггүй хүн санжээ. Ёс төртэй авсан дөрвөн сайхан хатад туслагчтай олон цөөн жилээр дэр нэгтгэжээ. Тэднийг үе залгамжлах үр төрүүлж өгсөнгүй гэж төрхөмд нь буцаасан билээ. Хүмүүс тэр гологдсон хатангуудыг туслагчийн буян эдлэх хувьгүй хөндий хэвэлтэй эмс гэж ад үздэг байлаа. Гэтэл тэд нутгийн өөр харчуултай ханилж хүүхэд төрүүлсэн учир олны санаа эргэж “Манай туслагч өөрөө эрх мэдэл, эд хөрөнгийн буянтай болохоос үрийн заяагүй хүн” гэж сэм ярих болжээ.

Өндөрхөн нуруутай, залуухан хүүхэн дөнгөж босго алхуут зогсч, туслагчийн нүүр рүү халыт хараад мэхэсхийв. Түүний давхраалаг нүдэнд нь сэтгэлийн арилшгүй гуниг шингэжээ. Залуугаараа нуруу нь бөгтийсхийж, нүдний нь доод зовхинд хэдэн үрчлээ тогтжээ. Энэ

насандaa инээж баясч үзээгүй болов уу гэмээр гутуу гундуу, уруу дорой царайтай аж.

- Явган таварсаар хамаг бие буларч гүйцлээ гээд туслагч орон дээрээ хажуулах зуур хяламхийн харахад хүүхэн навгасхийв. Туслагчийнхаа зан муутай байгааг түүний аяыг андахгүй болсон шивэгчин хүүхэн мэдээд яаран цай чанаж, амттай зоог барих гэж орон гаран бөндөгнөнө. Сэр-Од мөнгөн аягатай буцлам халуун цай оочлох зуураа шивэгчийн хөдлөвч бүрийг дагуулан ажиж “Бөгс нь бяцарчихсан хорхой шиг хөдөлж цөхөөд байхаар түргэлээсэй” гэж бухимдаж байвч

- Пагма аа, сайхан хоол хийж үз. Шургаж унах нь байна шүү гэж аядуухан дуугарах нь шивэгчинээ тайвшруулсангүй, харин ч сэтгэл хирдхийлгэм сонсдов.

Туслагчийн хүйтэн зэвүүн царай хэдхэн хормын дараа ийг хувирч ялдам нигүүлсэнгүй аястай болох нь сайны үр биш гэдгийг шивэгчин дор нь ухаарч гүн санаа алджээ. Эзэн хүн зөв харж зөөлөн дуугарвал зарц барлагийн сэтгэл өег, харц дээгүүр байдаг. Гэтэл хүүхний царай урьдахиаас улам гунигтай болсон нь юуных билээ.

Пагма хар нялхаасаа өнчирч нэгэн баян айлын зарц болжээ. Хатуу сэтгэлтэй эзний хар бор ажилд борви бохисхийлгүй зүтгэсээр жаргал гэдгийг үзэлгүй өсөв. Сэр-Од туслагч тэр баяныд нэг удаа дайлуулахдаа зарц бүсгүйгийн нь харчихаад “Олон газрын ихэс дээдэс ирдэг болохоор өргөөний газар зүс царай сайтай аягачин шивэгчин байвал хошууны нэрд тустай” гэж Пагмыг аягачнаар авсан билээ. Зовлон үзсэн ядуу бүсгүй зан сайтай түшмэл дагаж жаргана гэсэн гэнэн бодолтой Сэр-Одын ирэв. Түшмэлийн өнгөний аашинд хууртсан залуу бүсгүй ач тусыг нь бодохдоо биеэ харамлаж зүрхлээгүй ажээ. Тэгэвч нэгэнт хожимдсон байлаа. Хүн зуусан хойно нохойгоо хорихтой адил болов. Арга сүр ихтэй хашир түшмэл номхон хүлцэнгүй хөөрхий бүсгүйг хаашаа ч хөдөлж чадахгүй болтол нь атгандаа оруулж авчээ. Шивэгчин хүүхэн туслагчийн сүүлчийн хатанд тархиа хага цохиулсан ч удаа бий. Гэтэл туслагч өмгөөлсөн нь үгүй. Харин шивэгчинтэйгээ ямар ч хамаагүй гэдгээ хатандаа үзүүлэх гэж хуурмаг зан гарган догшин ширүүн авирлаж Пагмыг давхар зовоосон билээ. Тэр хатнаа буцаасны дараа шивэгчиндээ эргээд өнгөний элэгсүү зөөлөн зан гаргаж, хааяа хувцас хий гэж хямдхан торго ч өгөх болжээ. Дээдсийн гараас мултрах аргагүй болохоор Пагма түшмэлийн аяыг дуртай ч, дургүй ч дагасан ажээ.

Туслагч, шивэгчин хоёрын гэмийг мэдэх зарц шивэгчин нар түүнийг хушуу өргөдөг гэж дэмий хардан үерхэж дотносохын оронд дөлж хөндийрэн санаанд оршгүй хатуу үгээр сүлбэн сэтгэлийн зовлонг нэмнэ. Зарим нь атаа жөтөөндөө автаж хорон муу санаагаар ховын үг чулуудах нь байж суухад нэн ч бэрхтэй. Сэтгэлийн түмэн зовиурыг эдлэвч түүнийг гэтлэн давах хүчгүй ядуу бүсгүй амьд ангайж, мэнд мэлтийж суухаас өөрөөр яах билээ.

“Өнөөдөр мөн ч урагшгүй юм боллоо. Дөч шахтлаа ийм азгүй явж үзсэнгүй. Тэгэхдээ тийм хөөрхөн амьтныг шүү. Сүхийн олигор хар харц доодост золбин үг тарааж, нэр бузарлах бий дээ. Олиггүй яриа гаараад ирвэл ихэс дээдсээ гүжирдэн нэрийн нь гутаасан хэрэгт унагана даа” гэж туслагч хөмхий зуун унь ширтэн хэвтэнэ. Өөрийнх нь олхиогүй явдлын тухай дэл сул яриа нэгэнт даамжирсаар алс зайдуу нутгийн сортоотойхон хүний чихэнд ч хүрчихээд байхад туслагч ингэж нэрээ хайрласаар байдаг нь инээдтэй бөгөөд хөөрхийлөлтэй. Хүнийг газар доогуур ортол муулах мөртөө өөрийнх нь нүүрэн дээр гэмгүй царайлж өнгөрдөг нь энэ

хорвоогийн нэгэн согог буюу.

- Та хоолоо зооглоно уу? гэж шивэгчин хүүхэн ширээн дээр тавагтай банш тавиад, туслагчийг дурамжхан босож ирэхэд нь мөнгөн аяга, зааны ясан савх барилаа. Оройнхоо явдлыг бодохоос харамсан халаглаж байгаа туслагчид хоол идэх ч дур хүрсэнгүй. Сэр-Од “Яасан амтгүй юм бэ? гэж бодон хэдэн банш савхдаж аягандаа хийгээд тамшаалан идэж байв.

Зуухны амаар улалзаж байгаа галын дөл ширтэн хувь заяаныхаа тухай бодолд умбан суугаа Пагма туслагчийн хоолоо голонгуй байгааг мэдээд юу гэж загнах бол гэхээс яс нь хавталзан байна. “Хүний царай харж нэг насыг яаж барах вэ. Ядуу зүдүү ч гэсэн хань ижилтэй хүн зовлон жаргалаа хуваалцаад ямар ч гэсэн надаас жаргалтай байгаа. Санаандаа таарсан хайртай хүнтэй байна гэдэг яасан сайхан юм бэ! Түүнтэйгээ учрах мөч охорхон ч гэсэн насан туршид үзсэн зовлонгоо мартах шиг болох юм. Хүний дайтай амь зууж нэг үзэхсэн. Туслагч гуай хүрээн дээрээ хонохгүй хүрээд ирдэг нь ч юу вэ. Оршихтойгоо учран суувал наддаа жаргал. Тэр минь хүлээж байгаа даа. Туслагчийн ирснийг мэдсэн болов уу” гэж санаашран суугаа бүсгүйг

- Зүгээр банш байна шүү. Би ч боллоо. Чи идээч! гэх түшмэлийн дуу давхийтэл цочоожээ. Туслагч тавагтайгаа өөрөөсөө холдуулан түлхэж, шивэгчнээ эелдэгхнээр харж мишээв. Түшмэлийн өнгөц сайхан зан нэг л муу ёр зөгнөсөн шинж болохыг шивэгчин хүүхэн андахгүй тааварлах учир зүрх нь түг түг цохилно. “Амнаасаа унагачих шахан жалир жалир идсэн хэрнээ сайхан гэнэ шүү. Одоо ч гарцаагүй боллоо. Яана даа” гэж шивэгчин санаа зовно. Сэр-Од зассан оронд тухлан хэвгээд сэтгэлээ тайтгаруулахаар хундага архи авчруулан залгилав. Пагма аяга тавгаа янзлаад болзоот хүндээ очихоод бушуухан гарахаар үүд рүү алхтал

- Пагма аа! Нааш ир! гэж түшмэл аяархан хэлсэн нь түүний хоёр хөлийг тушжээ. “Намайг өмгөөлөх хүн байдаг ч болоосой. Гүйгээд хүрэхсэн. Тийм ч хүн бий л дээ. Оршиход минь намайгаа гэсэн сэтгэл хичнээн байвч түшмэл гуайн өөдөөс яах вэ дээ. Хурууных нь чилээг гаргахгүй шүү дээ, хөөрхий. Нэг удаа өөр хүнтэй болсныг туслагч мэдчихээд өргөөнийхээ газар харц доодостой шалиглав гэж сүйдлэх шахаж билээ. Бурхан минь, одоо бас мэдчих бий дээ. Ховч эмс л хэлчихгүй бол яамай... Ийм л үйлтэйгээс хойш өчүүхэн би хаачих вэ дээ” гэж торонд орсон болжмор шиг эрх мэдэлгүй хөөрхий хүүхэн бодсоор туслагчийн орны дэргэд очиж сүүмэлзэн байгаа лааны дөлийг гөлрөн зогсов. Өвдөгнийх нь чичрэх тоолонгоор дээлийнх нь хормой хөдөлнө. Нулимс бүрхсэн гунигт нүдэнд нь лааны дөл өнгө өнгийн туяа татуулан солонгорно.

Туслагч өөрийнхээ өмнө гэмтэн мэт хөдлөх ч үгүй зогсч байгаа шивэгчнээ харж “Манайд анх ирэхдээ ноёны өргөө хавья толгой цохих хүүхэн байсансан. Хэдхэн жил юун ч амархан царай алдах юм билээ. Манайхаас идсэн уусан нь хаагуураа ордог юм бол. Муу нохойн гэдсэнд шар тос зохидоггүй гэдэг ч энэ биз. Угийн заяа муутай төрөө байлгүй” гэж гайхжээ. Пагма хорин хэдхэн настай боловч зарц хүний хатуу амьдралыг туулж, бие сэтгэлийн гуниг зовлонд идэр залуугийн гоо үзэсгэлэн, цог залиа алдсаныг эргэцүүлэн бодох ухаан туслагчид байсангүй. Хүүхний сэтгэл санааных нь хамаг шим шүүсийг цэцгэнд суусан зөгий мэт сорж ийнхүү гуниг цөхрөлийн туйёд хүргэсэнээ эргэн боддоггүй нь юутай мунхаг вэ? Үгээгүй хүний түмэн зовлонгийн хагасын нь ч болтугай сэхээрэх ухаан дээдэст заяагаагүй нь нэн ч гаслантай.

Өдрөөс хойш оволзож бадарсан хор шараа тайлаа гэсэн туслагч энэхэн үед Юмжирдуламыг бүрнээ мартаж,

- Бид хоёр мөн зовлонтой хоёр шүү... Мэдэхгүй юм шиг ангайж зогсоод яах вэ дээ гэж өнгөц инээмсэглээд хурууныхаа өндгийг норгож лааны голыг чимхэхдээ “Хорвоо ингэ гэснээс цааш яах вэ. Очиж очиж шивэгчинтэйгээ шүү... За за царайлаг аягачин шивэгчнээ оролддоггүй ихэс дээдэс байдаг гэж үү. Миний іэдэхээс би л ганцаараа биш юм даг” гэж өөрийгээ цагаатган санаа амарчээ. Олиггүй муу явдал харахад ариун мэт санагдах дээдсийн хучилган дор ийнхүү өнгөрдөг ажээ.

Лааны гол шажигнан харанхуй айёа Пагмын хоёр хацрыг дагаж нулимс бөмбөрнө. “Сэтгэлтэй хүндээ яваад очих мэдэлгүй би яасан үйлтэй вэ. Орших минь намайг ирсэнгүй гэж гомдох байх даа. Үхсэн ч, сэхсэн ч тэнэж яваад азаа үзэх юмсан. Орших минь ганц хөгшин эхтэй болохоор түүнээсээ холдож чадахгүй байх. Энэ сэтгэлийн тамаас ангижрах хувь надад байдаг болов уу?” гэж шивэгчин хүүхэн сэтгэл шимшрүн бодож гашуун нулимсаа арчина.

Өргөөний өмнөх арын модонд нэг хүн тэсэж ядсан байртай холхиж, айлуудаас нүд салгахгүй ширтэх нь Пагмын хүсэл болсон Орших гэдэг нутгийн залуу байжээ. Туслагчийн гэрийн тооноор улалзаж байсан бүүдгэр шар гэрэл бөхөхөд тэр залуу “Одоо л нэг ажил нь дуусав бололтой. Яасан их яарч байгаа бол! Гүйгээд ирж яваа байх даа” гэж бодоод мод түшин харанхуй руу нүд бүлтийлгэн харна. Хэдэн мөч өнгөрсөн боловч нүдэнд өртөх бараагүй, чихэнд сонсдох чимээгүй байлаа. Хүлээсээр байтал шөнө дунд болов.

Хайртай бүсгүйгээ ирсэнгүй “Юу болов? Хийсэн юм нь туслагчийнх нь сэтгэлд таарахгүй болоод зодуулчихав уу” гэж санаа нь зовон эргэлзэж байсан залуу эр шивэгчний суудаг гэрт очиж үзэхээр модноос бууж нилээд явснаа нохой хуцахад зогсоод “Ээ дээ, горьгүй байх. Харц хүн тэр рүү шөнө байтугай өдөр ч дураар очих биш. Хоёр биеэ ял зэмд унагаж магадгүй” гэж бодоод зориг мохон гэдрэг буцаж уяатай морио аваад шогшуулан оджээ.

Дөрөвдүгээр бүлэг

Хар ухаан

Амьдралыг тунгаан бясалгаваас

Аминдаа зөв ухаан суумой

Тулганы баруун талыг эзлэнхэн суусан дархан Сүх хуучин гоёл чимгийн эрсгэр сарсгар мөнгийг үнсээр чигжсэн том халбаган дээр овоолж бадамлан асаж байгаа дэнгийн галд бариад завсарлахгүй нэгэн жигдээр үлээнэ. Улаавтар, шаргал, цайвад, хөхөлбий өнгийн дөлний халуун илчинд цайвартаж байснаа улайсан улайссаар гадна талаасаа хөлрөх мэт бурзайсаар хайлан урсч байгаа мөнгөнөөс өвгөний нүд үл сална. Насан турш тосон дэнгийн галд шарагдсаар хүрэн бор болсон өвгөний хөндлөн дагуу олон үрчлээ тогтсон духан дээгүүр хөлс дааварлана. Өвгөний дээд талд нарёйн багаж сэлтээр дүүргэсэн хэд хэдэн нүдтэй дархны хайрцаг, доод этгээдэд нь алх дөш, мөнгө цутгах хэв байна.

Тулганы зүүнтээ суугаа Доржпалам эмгэн гар дахь эрихээ гүйлгэн мөнгө хайлж байгаа өвгөн, буцлах гэж байгаа тогоотой цай хоёрыг ээлжлэн харж “Зарим улс, өвгөнийг минь хөгширч гарын нь тамир тэнхээ муудаж байгааг бодож зөөлөн цагаан мөнгө өгөх нь яана даа. Хэрэг нь өнгөрсөн муусайн юмаа эвлүүлж авах гэж гарьяа нь барах юм. Хуучин мөнгөний хатууг хэлээд яах вэ” айуэ насан өндөр болсон ханиа хайрлан өрөвдөж сууна. Дархан хазайсан тийшээгээ урсчихаар мэлтэгнэн байгаа улаан хайлмал мөнгөө хажуу тийш тавиад, хямсаагаа авч дэнгийнхээ зэрэгцээ гурван бүдүүн голыг тосонд нь шигтгэж бөхөөгөөд хэдэнтээ гүнзгий амьсгалав.

“Вг”ний тамирдсан царайг эмгэн ажаад,

- Өвгөөн! Та энэ хэрийн мөнгийг тун хурдан хайлдаг байж билээ. Одоо баахан уддаг болжээ гээд дэвэрч байгаа цайгаа самрав.

- Больж л яваагийнх биз дээ. Амьсгалын тамир хүрэхээ байх нь ээ.

- Та нэг сайхан хөөрөг хийж аваач. Тэгвэл биенд чинь амар байхгүй юу.

- Тэгэхсэн гэж санах л юм.

- Одоо ямар залуу байсантайгаа адил биш. Амьтны юм хийлгүй санаа амар суувал зүгээрсэн. Хар нүд хуу татаад л дэнгийн галд шарагдаж, нүдээ хөхөртөл юм шагайсаар өдрийг барахад бие чинь яаж гүйцэх вэ гэж эмгэн санаа зовонгуй хэлэв.

- Амьтан ах дүүс гуйхаар чинь үнэрхэж тунирхсан болох биз гэж бодоод үгүй гэж чадахгүй юм. Тэгээд ч хонь алах цээжэнд илхэн байна гэгчээр мөнгө дархлах ч бас түвэггүй мэт санагдаад байх юм гээд өвгөн эмгэн өөдөө инээмсэглэн харав.

- Өвгөн минь! Танд одоо санаа л үлдээд байна шүү дээ гэж эмгэн дуугарав. Сүх хайлсан цул мөнгийг дөшин дээрээ тавиад давтаж эхлэхэд том алхны өргөх тоолонгоор гарынх нь булчин

зангирч байлаа.

Сүхийн эцэг угаас ядуу татуу хүн учир хүүдээ өвлүүлэх хогшил хомстой байжээ. Тэгээд ч ужиг өвчинд нэрвэгдэж амин тэжээлийнхээ хэдийг өргөл барьцанд барьж билээ. Харин хүү нь багаасаа авхаалжтай сэргэлэн учир шанаганы иш хадах, данхны цорго гагнахаас эхлэн оролдож оролдсоор мөнгө дархалж сурснаар барахгүй бас цахиур буу үүрч уул хад хэсэн ан гөрөө хийсээр хэний ч дор орохгүй амь зуулгатай болжээ. Нутгийн өвгөд ч Сүхийг идэр залуу явахад нь юм юманд сортоо самбаатай сүрхий хүн гэж ам нийлэн ярьдаг байлаа.

Дархан Сүх арван хурууныхаа үзүүрээр амь зуусаар нас гуч гарахын алдад ухаан нь ид цэцэглэж гүйцэж хийсэн хэт хутга, хазаар, мөнгөн аяга, бүсгүй дүний гоёл, бурхан тахилын хэрэглэл нь газар сайгүй гайхагдаж, хошуу даяар цуутай дархан болов. Хол ойрын баячууд хосгүй уран чамин эдлэл хийлгэж өөр хоорондоо гайхуулах хүсэлд хөтлөгдөн бие биесээс өрсөн дархан Сүхийг урин залах болжээ. Хошуу ноён ч түүнийг аваачиж юм хийлгэдэг байв. Ийнхүү түүнийг санаа амар суулгахаа больсон учир дарх хийхээр ийш тийшээ олон хоног сараар явах нь зөндөө байлаа. Харин насан өндөр болсон хойно сая гэр зуур байх боловч бас л зүгээр суух нь ховор.

- Өвгөн минь, урьдаар цайгаа уу! Наадахиа азнаач дээ! гээд эмгэн багавтар мөнгөн хуланд цай хийж барив.

Хоёр хөгшнийг цайгаа ууж хууч хөөрөн суутал айлынх нь бүсгүй Юмжирдулам орж ирлээ. Бүсгүй өвгөний дэргэд суугаад хагас дутуу хийж тавьсан янз янзын юмсыг өөрийн хүн мэт нэгд нэггүй үзэж сонирхсоноо

- Өвөө, та миний ээгийг дууссан уу? гэж асуув.

- Өдрийн хэд гүйж орж ирээд салахгүй нь ээ. Өвөө нь мөддөө завдахгүй байхаа даа гэж цаашлуулан инээмсэглэхэд Юмжирдулам

- Өвөө тэгээд л тоглоом хийгээд байх юм гээд нүдээ эрвэлзүүлэн харав.

- Бага байхад гоёхын л дон болдогсон. Ээмгий нь бушуухан хийж өгөөд санаагий нь амраагаатахаач гэж эмгэнийхээ хэлэхэд сүх багажныхаа хайрцгийг онгойлгон гоёмсог ээмэг гаргаад нүдэндээ нэг ойртуулж, нэг холдуулан өө сэв, өнгө хийцийг нь нарийн шинжиж энд тэнд нь багажны үзүүр хүргэх төдий янзалснаа

- За май! Зүүгээд үз дээ, охин минь! гээд өглөө.

Юмжирдулам түүний эвэршсэн баравгар том алган дээрээс уран гоё хийцтэй ээгийг савхан цаган хуруугаараа чимхэн авч шохоорхон үзэж урамшин баясна. Бүсгүй хорол толгойтой шар ундром шигтгээтэй, тус бүр зургаан салаа мөнгөн утсан унжилгатай ээмгийг чихэндээ зүүж, авдран дээрээс толь авч тольдон, толгойгоо намбатай эвлэг хөдөлгөж нүдээ тормолзуулан хөөр баяр болно. Ээмэгний чулуун шигтгээ нь гялалзаж мөнгөн утас нь шажигнана. Өвгөний хийсэн олон ээмэгнээс өөрийнх нь гойд илүү сайхан болсон шиг санагдав. “Ёстой гоё болж шүү. Базартаа хайртай болохоор нь ингэсэн юм биш байгаа даа. Арай мэдмээргүй юм” гэж

бодтол хоёр хөгшин түүний бодлыг таачихаад байгаа юм шиг санагдсанд нүүр рүү нь халуу оргив. Юмжирдулам хацраа алгаараа нэг илснээ

- Буурай! Ямар байна? гээд эмгэн рүү харж, толгойгоо үл мэдэг займчуулахад ээмэгнийх нь мөнгөн утаснууд цэцэг мэт намиран савлана.

- Алив охин минь, хажуу тийшээ хар даа! За одоо наашаагаа! Ай даа, сайхан зохиж дээ. Аав чинь охиноо гоёулах гэж аргагүй л мэрийжээ. Өвгөн ч гараа гаргажээ гээд эмгэн дуу алдан шагширч түүнийг улам ч баясуулжээ.

Намсрай охиноо багаас нь алт, сувд, торго дурдмаар гоёх гэж баярхан саахалзахад нь дархан Сүх “Чиний буянг охин чинь эдлэх хэзээ ч оройтохгүй. Битгий яар! Багаас нь хүүхдийг үнэт эдээр туйлуулбал санаа сэтгэлд нь харшгай, зөв ухаан суухад нь садаатай байдаг” гэж сурган хориглоход Намсрай ганц охиндоо юу ч эдлүүлсэн миний дур гэж хааяа мугуйдлан боддог ч гэсэн охиноо өсгөх, орон гэрээ авч явахдаа хоёр хөгшний гарыг ямагт харахын сацуу тэр хоёр ч охинд нь амин голоос хайртай учир зөрж эс түвдсээр өдий хүрчээ. Харин саяхны нэг өдөр Намсрай дархныд таван цэн алт авч ороод бас л юу гэх бол доо гэж тээнэгэлзсэн бололтой Сүхийн царай руу харж сууснаа

- Охин минь өслөө. Одоо юм эдлэх цаг нь болоо биз дээ. Нэг сайхан ээмэг хийж өгөөч! гэхэд нь хажуунаас нь эмгэн

- Намсрай минь яах болох вэ. Бүсгүй хүн гурван цэнгээс илүү алт эдэлбэл насанд цөвгэй гэдэг юм. Охин чинь хүүхдээрээ байна шүү дээ. Мөнгөөр сайхан ээмэг хийлгэчих. Алтаа дараа бол! гэж хэлсэнд өвгөн ч битүүдээ зөвшиж байгаа бололтой юу ч хэлсэнгүй. Тэгээд эл мөнгөн ээмгийг хийлгэхээс аргагүй болжээ.

“Хөөрхөн ааштай охин шүү. Бид хоёрыг эцэг эх шигээ л боддог юм. Хүүд минь хань болоосой билээ. Өнчин өссөн болоод өр нимгэнтэй юмсан” гэж бодсоор эмгэн дэрийнхээ авдар руу бөгцөгнөн очиж мөсөн чихэр атгаж ирээд бүсгүйн хацарт хүрэх гэж хэрээрээ өлийж байж шовхийтэл үнсээд

- Охиныхоо гоё ээмгийг мялаая гээд чихрээ өгөхөд Юмжирдулам хоёр гараараа эвлэгхэн тосон авч хүүхэд мэт хохин баясч, баярласнаа сайхан харц, уяхан мишээлээр илтгэнэ.

- Өвгөөн! Энэ ээмгийг та ийм сайхан хийснийг бодоход нүд чинь муудаагүй байна шүү. Намайг залуу байхад л ийм ээмэг хийж өгдөгсөн. Хүн юм байлгах биш дээ. Чи дархан ханьтай хүн дахиад хийлгэчих гээд л мултлаад авчихдаг байж билээ. Тэгсээр эцэст нь юу ч үгүй хоцрох шив дээ гэж эмгэнээ өгүүлэхэд өвгөн “Нээрээ л тийм дээ. Юм хийдэг хүнд олигтой юм тогтох биш. Ханьдаа хийж өгсөн аль сайхан юмаар энэ хавийг авгайчуул гоёсныг хэлж яаж барах вэ” гэж бодон дуугайхан мушилзав.

Эмгэн уруулаа умгануулан маань уншиж эрихээ түргэн түргэн гүйлгэж “Өвгөний минь хэдэн хуруу эвдэрч монийгоод дарх хийнэ гэхэд эвлэхийн аргагүй болж дээ. Хичнээн лан мөнгө балбасныг хэн мэдэх вэ. Тэгээд бодохоор хүний гар өөдтэй ч байх арга алга. Сурсандаа л болдог юм байх даа” хэмээн бодол болон нойрмоглосон мэт сууснаа мөсөн чихэр амтархан

хүлхэж байгаа Юмжирдулам руу харж

- Охин минь! Өглөөгүүр танайд хэн буугаад мордов? гэж асуув.

- Гомбо гуай гэж бүсгүйг хэлэхэд өвгөн

- Гомбынд чинь тийм хулагч гүү байдаггүй байх аа. Хэзээ авсан юм бол? гэж гүнгэнэв.

- Өвөө! Гомбо гуайг урьд шөнө Хүрэн хадны энгэрт явахад нь чөтгөр дуугарч гэнэ ээ. Тэгээд ааг амьсгаагүй зугтаж морио бүгштэл давхисаар Агваанлуvsан дүвчин гуайнд очиж айлтгажээ. Дүвчин гуай мэргэлж үзээд “Чиний шарга моринд чөтгөр шүглэсэн байна. Морьтойгоо харивал гэр оронд чинь л лай ланчиг учирна. Морио зарж арга засал хийлгэвэл гэмгүй өнгөрнө” гэж айлдсан гэнэ. Гомбо гуай айхдаа сайвар шаргаа дүвчин гуайд барьж амь насаа даатгаад тэднийхээс тэр хулагч гүүг гуйж унаад буцаж яваа юм гэнэ үэ гэж бүсгүй тэр хүний эцэгтээ ярьсныг хүүрнэв.

- Ий яадаг билээ! Балданлхам минь! Хорлол болоогүй нь овоо доо гэж эмгэн уулгадан залбирч бурхан руугаа очиж адис аваад зул өргөж арц унгасгав.

- Гомбо аймхай хүн дээ. Тэгээд л айсан хүний нүдэнд аргал хөдөлнө гэгч болоо биз дээ гэж өвгөнийг тоомжиргүй хэлэхэд эмгэн

- Хүрэн хадыг чинь хэзээний гүйцтэй гэж ярьдаг юм. Дүвчин гуай ч олон амьтныг гай зовлонгоос гэтэлгэж байгаа хувраг даа, хөөрхий. Тэр чигээрээ амьд бурхан байхгүй юу гэж бишрэлтэйеэ ярихад

- За тэгээд хэрэгтэй хэрэггүй юм донгосоод бай! Муусайн мухар толгойтнууд бурхан болохдоо яадаг юм. Агваанлуvsанг амьд бурхан гэж чамд хэн хэлээ вэ гэж Сүх дархан эмгэн рүүгээ ширвэлзэв.

- Чи ч яах вэ, буруу номын амьтан гэж эмгэн гомдонгүй дуугарав.

Сүх шашин бурхан гэж сүжиглэж сүйд болдоггүй, гүдэс хар хүн билээ. Намрын жасаа уншуулж даллага авах болоход өглөө эртлэн цайгаа ууж, хээр хийх юмаа авч хонь хариулан оддог ажээ. Тэгээд жасаа дуусч лам нар тарснаас нилээд хожуу гэрийн бараа хардаг. Өөрсдийгээ тоодоггүй болохоор лам нар түүнд муугаар үл барам. “Сүх бол лам бурхандаа сүжиглэхийг мэдэхгүй угийн тэнэг амьтан. Хөндлөн хөх төмөр үүрч хөдөө хээрийг хэсч нүгэл хилэнц хийсэн нь тоймгүй. Өөдтэй явах учир байхгүй. Бурхан түүнийг хэзээ нэг цагт хатуу гэсгээн цээрлүүлнэ” гэж ярьсаар ирсэн боловч дархан Сүх тэгш дүүрэн аж төрсөөр ирсэн билээ.

- Өвөө! Чөтгөр гэж юу байдаг юм бэ? гэж Юмжирдуламыг асуухад эмгэн

- Балданлхам минь! Дахиад бүү дурс! Гай болно. Бурхандаа залбир, охин минь! гэж өвгөнөөсөө урьтан сургамж айлдлаа.

- Охин минь буг чөтгөр гэж юу байх вэ. Мухар толгойтнууд л хүний юмыг салгах гэж хуурч

залилж байгаа юм. Лам нар чинь үнэндээ арга мэхээр л хүний тархи толгойг эргүүлж зовлон дайрсан улсыг завшин юмжиж байдаг муухай амьтад шүү дээ... гэж өвгөнийг ярихад эмгэн тэсэлгүй дундуур нь орж

- Нүгэл гэм! Хүний ганц охины заяаг төөрүүлж бурхан шашнаас нь салгах гээ юу. Намсрай чинь чам шиг лам багшаа мартчихсан хүн биш. Охин минь, буруу зөнөсөн энэ өвгөний үгийг бүү ойшоо! Лам багшдаа сайн сүсэглэж бай! Бурхан багшаас хүчтэй юм энэ орчлонд байхгүй гэж үглэв.

- Хөөш эмгээн! гэж Сүхийг ярих гэтэл эсгий үүд сэвхийн сөхөгдөж Базар орж ирлээ.

- Миний хүү нимгэн хувцастай явсан юмсан, даарав уу? За суу. Ундаа уугаарай. Үүр цүүрээр хоосон явсан өлсөө байлгүй... Ядаж нойроо бүтэн авч болдоггүй юм байх даа гэж эх нь олон үг урсгаж, шар тосонд багсарсан арвайн гурил аяганд хийж өгөв.

- Антай явав уу, хүү минь! гэж эцгийн асуухад хүү

- Ганцхан гуртай.. гэж хариу өчив.

- Хангайн хишгийг чамлах юм биш, хүү минь! гэж эмгэн хэлэв.

- Чи сая намайг нүгэлтэй үг хэллээ гэж загнаад байсан чинь одоо хүүгийн хийсэн нүгэлд олзуурхаж байх шив. Та нар ч нэрэн дээрээ бурхан ном, буян хишиг гэж баахан юм үглэчихээд нидэр дээрээ өөрсдөө ч нүгэл хийгээд, өрөөл бусдын хийсэн нүглийг ч хуваалцаад байдаг улс даа. Агваанлуvsан та хоёр ч ийм л буян хийнэ дээ гэж өвгөн эмгэнийхээ амыг асууж маг маг инээхэд

- Цөг, цаашаа! гэхээс өөр үг эмгэнд олдсонгүй. Юмжирдулам Базарыг үзмэгцээ ичингүйрч, дуугайхан босож гарахыг завдтал

- Охин минь, суу суу. Ангийн мах ид гээд эмгэн

- Миний хүү хурдхан өвчиж янзал! Намсрай гуайндаа хувь өгөөрэй! гэж хэлэв.

- Нүгэл хилэнц байдаг бол ч нэг насаар хөвчид тэнэж амьтан хядсан би л хамгийн түрүүнд өнхөрмөөр байтал жар гарчихаад гэлдэрч явна. Нэг насаар буян хийж байна гэж сайрхадгаараа бол ч лам нар мөнхөрмөөр юм. Гэтэл маниас ялгаагүй шив. Манайхны шүтээд сүжрээд сүйд болдог Агваанлуvsан чинь чөрийчихээд, амь сүнс нь хаанаа явдаг бол гэмээр харагдах юм. Миний насыг наслах болов уу даа гэж өвгөнийг өгүүлэхэд

- Үгүй, та дуугай шиг урдахиа хийгээч! Таны ярьж байгаа чинь хүүхдүүдэд гай болно гэж эмгэн уцаарлаад, “Манай энэ нэг насаар лам багшаа ад үзсээр дуусах нь гээч. Насаа ахихаар, үгүй дээ лам багшаас адис авдаг болох болов уу гэж санасан чинь бас байдаггүй. Ямар учиртай төрсөн хүн юм бол доо хөөрхий минь... Гэлээ ч айлын чинээ л айл явна. Муу юм л учирсангүй, ум ма ни бадь ми хум” гэж сүслэн наманчлав.

Сүх эмгэнийхээ үглэхийг үл тоон ийн хуучилсан нь

- Хүүхдүүд минь, энэ мэргэн түргэн гэж биеэ магтдаг мухар толгойтнуудад их учир бий. Намайг арван хэдтэй байхад эцэг минь өвдлөө. Хэдэн сар хэвтэрт байсан. Манайх олон лам залж гүрэм дором хийлгэсэн боловч эцгийн бие сайжралыг олсонгүй. Манай нутагт нэг лут баян гүртэн лам байлаа. Тэр гүртэн манайд хэдэн удаа ирж аавыг сэхээх арга чарга хийж байна гэж ном айлдсан юм. Өвөл болсон хойно нэг ирэхдээ гурилаар лүд хийж галын захад тавьчихаад баахан ном уншиж сүйд боллоо. Уяаёгүй гурилан хүний нүднээс нулимс гоожиход гүртэн гуай чамайг уйлсан ч гаргана, уйлаагүй ч гаргана гээд номоо чанга чанга уншиж хонх дамраа сүртэй нижигнүүлж байлаа. Ээж, айлын авгай хоёр “Гүртэн гуайн уншлага мөн ч хүчтэй юм, сахиус минь өршөө гээд л залгайр байв. Тэр лүдийг надаар хаяулсан юм. Би багынхаа сувьдаг элээ шиг саваагүй зантай амьтан болохоор яагаад уйлдаг юм бол гэж сонирхон нөгөө лүдийг гадаа авч гарсан хойноо хагалаад үзсэн чинь толгой дотор нь нүднийх нь тус газар мөс хийчихсэн байхгүй юу.

Энэ яриаг сонсоод Базар инээд алдав. Юмжирдулам биеэ займчин нүднээсээ нулимс гартал хөхрөв.

- Лам багшаа шоолдоггүй юм. Алдас болно. Галзуурах чинь энэ үү!? Үэж эмгэн нүүрээ үрчийлгэн нүдээ гурвалжлуулан, хөмсгөө зангидан бүсгүйг муухай харан зандраад,

- Битгий худал хөөрөөд бай, зөнөг минь! Хувилгаан багшаараа доог хийсэн чам шиг нүгэлт амьтан энэ орчлонд байхгүй гэж өвгөндөө уурлаж тулганыхаа захад тунтганан сууна.

- Өвөө, энэ чинь үнэн юм уу? гэж Юмжирдулам нулимсаа арчин инээдээ барьж ядан жуумганан асуухад эмгэн нүднийхээ булангаар хялайн харав.

- Нээрээ шүү. Лам нар чинь тэгж л хүн хуурч, юмыа нь салгадаг улс. Агваанлуvsан гэдэг чинь тиём л амьтан гэж өвгөнийг хэлэхэд уурлаад ч нэмэргүйгээ мэдсэн эмгэн

- Өвгөн минь, та өөрөө буруу зөнөх мөрөөрөө зөнөхгүй хүүхэд бүү уруу тат! Дүвчин гуай мэдчихвэл хараал хийнэ шүү гэж эмээсэн янзтай хэлэв.

- Түүний хараах чинийхтэй адил биз. Чи намайг бурхан номдоо буруу санасан амьтан гээд өдрийн хэд харааж яншдагтай чинь ив ижилхэн биз гэж Сүх хэнэггүй хэлээд инээмсэглэв. Эмгэн уурлаж гуйж ядаад аргаа барахдаа

- Наад зөнөгийхээ үгийг бүү үнэмш, хүүхэд минь! Дуулаагүй юм шиг байцгаа! Аан уун гээд инээлдэхээр чинь улам гаарч байгаа юм. Хүүхдүүд минь, бурханд сүжигтэй явбал энэ насны үйлсээр барахгүй, хойт насандаа сайн төрлийг олж төрдөг гэж лам багш сургадаг. Лам бурхнаараа даажин тохуу хийвэл энэ яваа насаар барахгүй хойт насанд халтай гэдэг юм... Манай энэ ч эцгийгээ дуурайсан амьтан болно доо. Энэний чих рүү ус хийсэн ч ижил, алт хийсэн ч ижил. Намайг ямар ч сайхан үг хэлэхэд хайхардаггүй амьтан гэж эмгэн хүү рүүгээ занган хялмалзсанаа

- Охин минь, чи маань, мэгзэм их уншиж, бурхандаа сайн залбирч байгаарай! Надаар ч заалга! Чи ахар жолоотой бүсгүй хүн шүү дээ. Лам бурхан л чиний хувь заяаг зааж өгнө гэж Юмжирдуламыг сургав.

- Ээж ээ, аав яалаа гэж худлаа ярих вэ дээ. Аав лам нарыг тоосонгүй гээд манайх муудсан юм алга. Таныг өдөр бүхэн бурхандаа мөргөлөө гээд ч бусдаас илүү гарсан юм алга гэж хүүгээ тохуутай инээмсэглэхэд эх нь уурлаж

- Тат! Зөнөгтэйгээ нийлж эхийгээ дооглох чинь дугав уу! гээд хуянгаа нухдаг матигар модоо шүүрч хүүгийгээ нуруу руу буулгаад авчээ.

- Өвөө, аав тань тэгээд зүгээр болсон уу? гэж сониуч зан нь хөдөлсөн бүсгүй тэссэнгүй асуув.

- “Гүртэн гуай манай аавд шүглэсэн ад зэтгэрийг уйлуулаад хөөсөн. Одоо зүгээр болно” гээд л ээж маань ирсэн хүн бүрт сайрхан ярьдаг боллоо. Би нэг өдөр ээжийг түүнээ ярьж суухад нь “Тэр гурилан хүний чинь нүдэнд мөс хийчихсэн байна билээ. Тэр нь л хайлааа гёжсон юм” гэж хэлчихээд зодуулсан. Ээж минь аавыг сэхнэ гэж баярлахдаа тэр гүртэнд хүнд өгөхийн аргагүй хоёр сүүтэй хайнагёён үнээгээ барьчихсан. Аав минь ч засралгүй байсаар өнгөрсөн гэж өвгөн ярив.

- Өвөө! Агваанлуvsан дүвчин гуай манай жасааг уншихдаа лам нарт таныг “Бурхан сахиусаа умартсан буруу зүгийн чаралба байгаа юм. Арван найман тамын адгийн халуун тамд унана” гээд л яриад байсан гэж бүсгүй хэлэв.

- За тэр дээ. Хэлэх юм биш, базарваань хом пад... Лам багш нар дургүй хүндээ далдуур хараал ширээл хийж сүйдэлнэ шүү, өвгөн минь! Та бодолтойхон байж үзээдэй гэж эмгэнийг санаа зовнингуй хэлэхэд Сүх,

- За за, юун яасан хараал гэж уцаарласанд

- Өвгөн минь! Өтөлсөн хойноо муугаа үзэх бий дээ. Зовлонгүй шиг нүд аних юмсан гэж хэлэхдээ эмгэний хоолой зангирч дөт их сүсэг бишрэлийн улмаас айж эмээсэндээ нулимс нь мэлмэрээд ирэхэд мойног хуруугаараа арчиж, яаж ч чадахгүй арга тасарсандаа санаа алджээ.

- Манай эндхийн мухар толгойтнууд цөм өвөөгий чинь харааж зүхдэг юм. Өвөө нь ч тэднийг үзэхгүй явсаар нэг насыг барж байна. Аавыг өвчтэй байхад манайх хэдэн малаа лам нарт барьж өгсөөр ганц муу тугалтай үнээтэй үлдсэн. Манай нэг ухаан сайтай сүрхий авга ах байсан юм. Авга маань “Сүсэгтэй хүнд бурхан байдаг, сүсэггүй хүнд бурхан гэж юу ч байхгүй. Чөтгөр бий гэж санавал хаа ч чөтгөр дайралдаж болно. Чөтгөр байхгүй гэж санаад айхгүй явбал чөтгөртэй гэж ярьдаг газраас ч чөтгөр олохгүй. Аль алин нь хүний хоосон санааных юм шү. Бурханд хэт сүсэглэвэл хөл нь тушаатай, гар нь хүлүүтэй, нүд нь харалган болж хоосрох зовохын туйлыг хэзээ нэг цагт үзнэ” гэж бидэнд ярьдаг байсан. Намайг эцэг эх шигээ хоосон чанарын юманд шүтсэнээс амь зуух арга ухаан сур гэж захидагсан. Авга маань “Хэнгэрэг цангийн дуунд өвчтэй хүн эдгэх учир байхгүй. Амь зуулганаасаа дэмий салахын нэмэр. Харин тэгснээс тун эм олж увал дээр” гэж аав ээж хоёрыг хорьдог байсан. Тэгэвч эцэг эх маань лам бурханд дуйлгүй сүсэглэдэг болохоор өвчтэй зовлонтой цагт аяаь нь дагахаас өөр арга байгаагүй.

Аавыг нас нөгцсөний дараа авга маань гүрэмдүүлсэн хүн чинь эдгээгүйн учир юмаа эргүүлж авна гээд нэх! гэж надад үг зааж манай амь зуулганы голыг салгасан өнөөх гүртэн ламынä

очуулсан юм. Би малаа нэхээд өгөхгүй болохоор нь бэлчээрээс нь тасдаж хөөгөөд ирсэн. Түүнээс болоод лам нар намайг ад үзэх болсон. Харин сүүлдээ “Сүх дархан өөдлөхгүй. Удахгүй догшин сахиусын хорлол болно. Та нар Сүх шиг явбал энэ хорвоод сайныг үзэхгүй” гэж нутгийн ах дүүст муулаад байхаар нь уур хүрээд болдог юм биш. Залуу ч байсан, зүрх зоригтой юунаас ч буцдаггүй дээрээ байсан үе. Нэг өдөр нөгөө гүртэй толгойтой олон лам нар айлд цуглаад хурал хурж байгааг сонслоо. Халамцуу явсныг ч хэлэх үү, нэг сайн айлгая гэж бодоод давхиад хүрлээ шүү. Эсгий үүдийн нь гэр дээр нь хаячихаад бугаа шийрлээ,

- Хүн мөрөөрөө явахад та нар дандаа үхнэ, хатна, өөдлөхгүй гэж харааж зүхдэг. Муусайн мухар толгойтнуудыг бүгдийг чинь гөрөөс намнаж байгаа юм шиг тонилгоно. Тэгээд та нарын хараал хүрдэг, үгүй хоёрыг үзнэ гээд нэг хий буудаад орхив. Тэгсэн чинь лам нар ч бужигналдаад явчиблээ. Миний үеийн нэг залуу намайг бариад авлаа. Тэр хооронд өнөөх лам нар чинь тал тал тийшээ арилж өгч билээ. Түүнээс хойш манай эндхийн мухар толгойтнууд намайг харахаараа сүнсээ зайлтал айдаг болсон юм. Зарим нь намайг харын бөөгийн сүнс болоод юунд ч дийлдэхгүй байна гэж донгосдог гэнэ билээ. Тэдний хараадгаар бол би өдийд гозойж явах учиргүй. Тэгэхээр лам нар чинь хоосон чанарын юмаар хүнийг айлгаж сүрдүүлдэг нь үнэн байх гэж санадаг юм гэж... дархан Сүх ярихад нүүрээ байдгаар нь үрчийлгэж тун ч дурамжхан чагнаж суусан эмгэн нь үгийг нь тасалж

- Энэ ёдоороо бол чи хойт насандаа яаж зовох бол доо гэж үг хаяв.

- Хүүхэд минь, лам бурхан, буг чөтгөр, гай барцад гэж айж эмээж явбал нэг ч удаа сэтгэл амрахгүй хөрөнгө хогшилтой ч явж чадахгүй. Өнчин ишиг үхчихсэн ч юуны гай бол гэж мухар толгойтнууд руу гүйсээр жаахан юмаа тэдний зууш болгож, өөрсдөө хоосон хонодог болно. Би хөрөнгө, хогшил сайтай айлууд ч гүрэм хийлгэсээр юмаа барж, хүнээ үхүүлээд гуйлга гуйж, баячуудад зарагдаж амь зогоож байхыг цөөнгүй үзлээ шүү дээ. Болж л өгвөл мухар толгойтнуудаас холхон явахад гэмгүй, хүүхдүүд минь! гэж сургамжлан ярьжээ.

Өвгөний яриаг чагнаж ихэд гайхан бодлогоширсон Юмжирдулам,

- Өвөө! Лам нар тийм муу юм бол та яах гэж сайхан дуутай бишгүүр хийж өгсөн юм бэ? Зун намайг цам үзэхэд мөргөлчид таныг шагшиж магтаад л сайхан гэхэд Сүх

- Хөлс шангий нь авчихаад юмын нь муу хийж болохгүй шүү дээ, охин минь! Олон ард дуугий нь сонсоод баясахдаа Сүх дархан хүний нүд хуурсангүй гэж бодож байвал болох нь тэр. Надаар лам нар бишгүйдээ л мөнгө хийлгэсэн. Тэдний юмыг ч би муу хийе гэж санаж байгаагүй. Хүн сайхан сэтгэлээр над руу ирж байхад би юмын нь хуурамч хийж сэтгэлд нь сэв үлдээж болохгүй. Хүнд муу санаж явбал нүгэл тэр. Сайн санаж явбал буян нь тэр гэв. “Үнэнээ хэллээ, хөөрхий өвгөн минь. Нэг ч хүний юмыг гарын үзүүрээр дөмнөөд орхиж байгаагүй юм. Баян хоосон, дээр дор гэж ялгахгүй аль ч хүний юмыг мэрийж хийдэг юм даа. Хүнийг баярлуулж байвал сая санаа нь амардаг сонин хүн шүү. Хүний өөрийн хошууны эр эм, лам хар хичнээн ч амьтныг баярлуулсан бол доо. Өвгөнд минь гомдсон хүн лав байхгүй дэг. Манайхаас хийлгэсэн юмаа авахдаа сэтгэл дундхан гарч байсан хүнийг би л үзээгүй. Бурханд сүжиггүй ч олон амьтнү сэтгэлэйг засч баясгаж байсандаа л өвгөний минь үйлс үртэй нь бүтэж явдаг биз” гэж эмгэн сэтгэл дүүрэн бодоод, түрүүхэнд нь гомдож, уурлаж байснаа умартаж өвгөнөө ч ханийн халуун дотно харцаар харан мишээжээ.

- Юмжирдулам аа, чи надад өвчүү түшиж өгөөч! гээд Базар бүсгүйг дагуулан гарч гураа өвчив. Тэр хоёр бие биеэ хайрын нүдээр баясан харж хүүрнэнэ.

- Базар аа! Чи чөтгөр үзсэн үү?

- Үгүй, байхгүй юмыг чинь юугий нь үзэх вэ.

- Чөтгөр байдаг байх аа. Олон хүн чөтгөдтэй тааралдсан гээд л аймаар юм ярьдаг шүү дээ.

- Эсгүй хээр айж явахад янз бүрийн юм дуугарахаар чөтгөр гэж санаад улам айдаг байлгүй дээ.

- Би чөтгөд бий гэж санадаг. Хонь малд явахад чөтгөр дайралдвал яана. Ямар аймшигтай вэ!

- Чөтгөр байхгүй ээ. Би ч бас бага шиг байхдаа чөтгөрөөс айдаг л байсан. Хээр гараад оройтчихоороо дандаа хулмалзаж бие ширвэтэж, энд тэнд шар шурхийх шиг санагддаг байсныг яана. Аавыг чөтгөр байхгүй гэж ярихаар нь ердөө үнэмшдэггүй байлаа. Шар шорооны үзүүрт нэг ламыг тавьснаас хойш бугтай болчихсон гээд л шуугидаг боллоо. Аав намайг нэг шөнө дагуулж очлоо. Би ч учиргүй айж аавд наалдаад л суучихсан. Тэгсэн чинь хэнгэрэг цан балбаад л сүйд болж байна. Миний айсан гэдэг ч тоймгүй. “Миний хүү битгий айгаарай. Аавтайгаа яваа эр хүн чинь юунаас ч айдаггүй юм. Муу эр л аймхай хулчгар байдаг юм” гэж аавыг хэлэхээр нь айхгүй байя гэж бодсон ч болдоггүй. Мадъяаа өглөө нь нөгөө дуугараад байсан юмаа үзлээ. Тэгсэн чинь далны яс, маанийн үсэг бичсэн мод, сумны зэв, төмөр сэлтийг холбож харгананд өлгөчихсөн нь салхинд хавиралдан шажигнаад их чимээ гаргаж байх юм. Салхи ширүүсэхээр бүр ч сүртэй дуугарахыг яана. Дараа нь нэг шөнө хэргээр очиж чагнасан чинь өнөөх маань дуугарч байсан. Тэгэхээр нь аваад хаячихсан. Түүнээс хойш тэнд чөтгөр дуугарлаа гэж ярихаа больсон. Айсан хүнд тийм л юм чөтгөр болчихдог юм билээ. Тэгээд л би буг чөтгөрөөс айдаггүй болсон. Ямар ч харанхуй шөнө хаа ч явсан айдаггүй. Одоо хөдөө гадаа унтсан ч хулчийхгүй гэж Базарыг ярихад амаа ангайн чагнаж байсан бүсгүй

- Ямар аймаар юм ярина вэ гэв.

- Чи надтай яв л даа. Би чамд чөтгөртэй гэж ярьдаг газрыг үзүүлье. Юу ч дуугардаггүй юм.

- Хүүе больё. Би л айна даг. Үнхэлцэг хагарчихвал яах юм бэ гэж Юмжирдулам түүний өөдөөс айсан нүдээр дүрлийтэл ширтэн харав.

Тавдугаар бүлэг

Шөнийн гийчин

Хэргэм зэргийн хүслэн

Хэтийн явдалд халтай

Хүрээ татсан ёлтгор наран шингэн алдаж, уулын сүүдэр хүүшлэн үдшийн жавар сэнгэнэж эхлэв. Өндөр уулын энгэр дэх ханан хадны нөмрийн нууцгайхан өтөг дээр өвөлжиж буй хоёр гэрийн хэдэн талаас орж ирсэн чийр замаар сайн бэлчээрт гэдэс гарсан хонь мал хааяа нэг өвс хаялан яаралгүйхэн дөхнө. Хотны захаар бут сондуул шинжлэн гүйж явсан бүдүүн халтар нохой айсуй яваа хоньчны бараагаар хоёр гурав хөв хөв хуцсанаа таньсан бололтой тосон шогшив. Зүүн гэрээс бөгтгөр эмгэн гарч ирээд жаргах наран доогуур саравчлан харснаа түлээ тэврэн орсны дараахан гэрийн тооноор утаа суунаглаж уур нүдүүрийн чимээ сонсдох нь хонины хүнээ халуун ундтай угтах гэж яарсан бололтой. Гэрийнхээ гадаа охинтойгоо түлээ хөрөөдөж байсан Намсрай чулуун хашааны хаалга дэлгэж хонио хотлоход бэлэн болгов.

Уулын өвөлжөөг төдөлгүй шөнийн харанхуй нөмөрч од түглээ. Хонин сүрэг хашаа дүүрэн налайж, бод мал нь өтгийн хаяа бүрхэн энд тэндгүй архайж дархайн хэвтэж тавтайхан хивөгээх нь зутарч бээрээгүй, өнтэй тарган орж байгаа нь илхэн. Хот айлын анир чимээгүйг нохойн дуу эвдэв. Холоос гарч зүтгүүлсэн бололтой цан хүүрэг цохисон хоёр морьтой хүн Намсраинд буужээ. Гийчдийг гэрт орсны дараахан дахин зурвас гэрэл гялсхийн хаалга онгойж нэгэн бүсгүй хүн гарч нөгөө гэр рүү хэд алхсанаа морьд аргамжсан бололтой бууцны бэлээс сүүтэгнэн ирж яваа хүнийг тонгойн харснаа таньж

- Базар аа! гэж аяархан дуудаад угтан очсон нь Юмжирдулам байлаа. Залуу хүү бүсгүйн дэргэд ирж нүд рүү нь ширтэн инээмсэглэн асууруун

- Танайд юун улс ирэв?

- Нэг нь тамгын тахар шиг байна. Нөгөөгий нь танихгүй юм.

- Чи айлын бүсгүй хүн байж унд усаа хийхээ бодохгүй юунд гарч гүйгээ вэ? Эсвэл манайхаас юм авах гээ юу?

- Ганцаарантай чинь уулзах хэрэгтэй гэж тахар гуайг хэлэхээр нь аав намайг танайд оч гэлээ.

- Тахар болсон хойно хэрэг зарга л гэж яваа биз.

Хоёр залуу хашаа түшин зогсч, хайр энэрлийн дулаан харцаа харилцан илгээж, сэтгэлийн угт баясна. Базар одот тэнгэрийг өлийн харснаа

- Яасан намуухан шөнө вэ... Хоёулхнаа байх шиг сайхан цаг ер үгүй юм гэхэд

- Надад ч бас тийм л санагддаг юм гээд бүсгүй жаахан санаашрав.

- Бид хоёр дандаа хамт байгаа юм шиг хэрнээ яг хоёрхон биеэрээ таарах нь тун ховор юм даа гээд залуу ширүүхэн хүрвэл хагарчихмаар эмзэг юманд хүрч байгаа мэт хонгор бүсгүйнхээ булбарай хацрыг аяархан илэв.

- Гэнэт хүн гарч ирээд харчихвал яах нь вэ гээд Юмжирдулам инээвхийлж түүнийг налсхийн малгайнх нь бүчийг имэрч зогсоно.

- Хүний ёсон мөн сонин юмаа. Чи бид хоёр хар нялхаасаа хамт өссөн. Жаахан байхдаа чи намайг “Ах аа” гээд дагаж гүйдэг байсансан. Гэтэл хоёр биедээ сэтгэлтэй болчихсон байдаг. Бага байхад хоёр гэрийнхээ алинд ч хамаагүй өвөртөө унтдаг байж билээ. Одоо болохоор аав ээж нарынхаа дэргэд нүүр нүүрээ ч эгцэлж харахаас санаа зовох юм гэж залууг өгүүлэхэд бүсгүй

- Яагаад ийм болчихов доо гэж гайхмаар санагддаг... Танайд өдөрт олон орохоосоо ч эвгүйцэх юм гэв. Базар бүсгүйнхээ хацрыг илж таалж хүйтэнд жиндсэн хацарт нь хошуугаа хүргэхэд Юмжирдулам шөнийн харанхуйд ч гэсэн ичиж зовоо юм болов уу нүдээ анивалзав.

- Чи бага байхдаа муухай шогч амьтан байсан шүү. Нэг өвөл миний хүзүү рүү цас чихээд уйлуулж аавдаа зодуулж билээ. Намайг чи мөн ч их шоглодог байсан. Түүгээр бол ч би чамд хайртай байх учиргүй л дээ гэж бүсгүйг шивгэнэн ярихад

- Хүүхэд ахуйдаа зодолдож нүдэлдэж явсандаа өширхдөг хүн байдаг гэж үү. Хүн болж төрөөд хамгийн сайхан санаатай явдаг үе нь тэр байх гэж Базар хэлээд амраг бүсгүйнхээ гарыг дааруулчих бий гэж шилүүсэн нударга дотроо илж байснаа түүний хуруун дахь бэлзгийг тэмтэрч үзээд

- Хэзээ чи ийм бэлзэгтэй болоо вэ? гэж асуув. Юмжирдулам цаанаа юу ч бодож санасан юмгүй

- Намар туслагч гуай аавыг аваачиж цайлсан юм. Тэгээд охины чинь хувь гэж энэ бэлзгийг чихэр боовгой өгсөн байна билээ гээд ядам хуруундаа зүүсэн хоёр талдаа хажилгатай, очид алмас шигтгээтэй алтан бэлзгээ гарган үзүүлэхэд эрдэнийн шигтгээ нь харанхуйн дунд оч мэт гялсхийв.

- Туслагч юу болёоо гэж чамд ийм их үнэтэй цайтай юмаа бэлэглэдэг билээ? гэж Базар цаанаа л нэг зуунги хэлэхэд түүний дуунд уурлаж зэвүүрхсэн өнгө илрүхийг бүсгүй гадарлаад баахан санаа зовсон мэт дуугайхан байснаа,

- Мэдэхгүй л дээ. Аавыа авчраад өгөхөөр нь цаана наана юм ч бодсонгүй хуруундаа л хийчихсэн гэв.

- Чи дэндүү гэнэн юм. Учрыа нь мэдээгүй байж яах нь вэ. Цаад чоно чинь ямар ч бодолтой өгсөн юм билээ.

- Зуныхаа шившгийг тараачихна гэж айгаад түүнээ цагаатгах гэсэн байж магадгүй л юм. Туслагч гуай ер нь харц надаар оролдмооргүй юм. Сархдаа дэндүүлэн ухаан алдчихсандаа л

тэгсэн байх. Надаас олон ах хүн шүү дээ. Тэгээд эрүүл болсон хойноо сэтгэл нь зовоод аавыг цайлсан ч байж мэдэх юм гэж Юмжирдулам энэхэн зуур ахархан ухааныхаа хэрээр тунгаан бодоод ийн учирлав.

- Ганц энэ биш... Ер нь тэр золиг чинь ноёны нэр барьж дураараа дургиж манай хошууг баллаж байгаа хүн. Хээл хахуулд шунаж хичнээн гэмгүй хүнийг зэмд унагадаг гэж санана! Хүнгүй газар цусгүй цааш нь харуулчихмаар амьтан гэж Базарыг шазуур зуухад

- Базар минь! Туслагч гуайг зун ухаангүй хоцроход нь үхчих бий дээ гэж би их айж байсан. Чамд минь гай тарилгүй шиг өнгөрөв бололтой. Тэр хүнд дахиад бүү гэм хүргээрэй. Чамайг барьж аваад хар гэрт хийж есөн эрүү гэдэг аюултай юманд унагавал яана! Би чамгүйгээр яаж явах юм бэ гэж бүсгүйг хэлэхэд Базар зөөлөрч

- Би түүнд гар хүрэхгүй л дээ гэж санаагий нь засаад

- Танайд орчихоод ирье. Тэд юу ярьж байгаа бол? Чи эндээ хүлээж байгаарай! гээд явав.

Базарыг ороход тэд мал сүрэг, нутаг усны тухай ярьж суухад нь миний хөлийн чимээнээр өөр юм ярив уу гэж сэжиг төржээ. Их гал өрдсөн учир гэрт халуун бүгчим байв. Гэрийн эзэн тавагтай халуун банш ширээн дээр тавиад лонхтой хар архи гарган гийчдээ дайлж байлаа. Тахар, өвгөжөөр хүн хоёр халуун хоол, хатуу дарсаар дайлуулсаар бээрээ нь гарч царай нь минчийчихсэн сууна. “Хоол ундаа ч охиноороо хийлгээгүйг бодоход эд яггүй нууц юм яаруу ярьсан баймаар. Энэ халуунд дээл хувцсаа ч тайлахгүй хөлсөө цувуулан суугааг бодоход хонохгүй бололтой” гэж бодсон Базар тэднийг ганц нэг үг асуухад нь хариу хэлж хөвстэй түлээний дэргэд хэдэн мөч зогсов. Намсрай түүнийг хялам хялам харж тун дурамжхан янзтай байхаар нь залуу удсан ч үгүй гараад хүлээж ядан байгаа Юмжирдулам руу очив.

- За юу ярьцгааж байна?

- Хэрэгтэй хэрэггүй л юм бурж байна. Аав чинь ч намайг орсонд дургүй байх шиг байна.

- Чиний дэргэд ярих байтлаа намайг гаргах уу даа.

- Дэмий орлоо. Гаднаас нь чагнавал яах бол?

- Хүүш, болохгүй! Аав мэдчихвэл уурлаж сүйд хийнэ. Тэгээд ч тэд юугаа ярих нь чи бид хоёрт хамаатай биш гэж бүсгүй сандран хэлээд Базарын гараас атгаж авав.

Гэрээс тахар гарч ирээд хоолойгоо засч, хэн нэг хүн яриа чагнаж болзошгүй гэж харлахсан янзтай ойр зуур алхан тонголзон харснаа буцаж оров. Тахар гэрт ороод өвгөжөөр хүн рүүгээ нүд ирмэв.

Туслагч Сэр-Одын садангийн өвгөжөөр хүн зорьсон хэргээ хэлж түвдэхгүй хулгаж суусан бол сархдын увьдсанд зүрх орж орог буурал толгойгоо хэд илээд малгайгаа өмсөж суудлаа засч төв түвшин болоод ийн хэлжээ.

- За, Намсрай минь! Эрсэн эрдэнэ, сурсан сувд танайд байна гэж бид зорьж ирлээ дээ гээд

хөөргөө гаргагч барьж,

- Буга намнаач нь манайд, булга зүүгээч нь танайд байна гэж үг нэмлээ.

Санаандгүй ийм үг сонссондоо Намсрай яах ч учраа олохгүй бантчихав. Сэр-Од туслагч Намсрайг очиход “Чи охиноо язгууртан дээдэс шиг зөв сайхан өсгөсөн байна шүү. Хэн ч танай охиныг их заяатай хүн гэж хэлнэ дээ” гэж ярьж байсан нь гэнэт санаанд нь оров. Охиныг минь хатан болгох гэсэн алсын санаатай байжээ. Ингэб юм гэж аанч санасангүй. Одоо яах билээ би? Тэнгэрийн зарлиг шиг яасан хэцүү үг вэ? Энгийн нэг хүнсэн бол ч нүүр өгөхгүй зад загнаад буцаахсан. Эд нарт ширүүлчихвэл туслагч хилэгнэж муугаар хаяалж мэднэ. Юутай ч гэсэн энэ удаа тамхийа нь татаж орхихоос доо” гэж Намсрай хаширлаж,

- Бодож байж больё доо гэж дурамжхан дуугараад тамхийа нь авч үнэрлэхчээн болжээ.

Хэзээний дуу цөөтэй Намсрай бүр ч дуугаа хурааж, аяганд цай хийж аваад ганц нэг оочигч болон хөнхийгээд суучихсанд гэрийн дотор амьтаё юм үгүй мэт болов. “Эрдэнэ мэт ганц охиноо очиж очиж хөгшин түшмэлийн өвөрт хийгээд яах ч юм билээ... Уул нь ч дөч хүрч яваа ид дунд насны л хүн дээ. Дээд язгуур угсааны тийм эрх мэдэлтэй түшмэл хүн харц ардын охиныг таалахад болохгүй газаргүй ч юм болов уу. Ямар ч гэсэн энэ насандаа л дуулаагүй юм байна. Гэтэл хэн хүнд тохиолдохгүй нэн ховор хувь заяа охин бид хоёрт таарах нь энэ үү? Ай мэдэхгүй” гэж гэрийн эзэн бодлогоширно. “Манай Сэр-Одыг хөгшин гэж голоод охиноо өгөхгүй юм биш байгаа. Эцэг хүний санааны дур шүү дээ. Язгууртан хүн харцын охиноор яах вэ, аз заяанд нь муу болно гэж хэлбэл амаа таглуулаад буцахаас өөр үггүй” гэж өвгөжөөр хүн бодож хүүхний эцгийн ам ангайхыг хүлээж ядахдаа гэдсээ цүрийтэл цай ууж суулаа.

Нөгөө тахар нь Намсрайг дуугарах янзгүй байхаар нь зэвүүрхэж “Энэ муу боол хошууны тэргүүн туслагчаас охиноо харамлах нь уу даа. Шивэгчин болгох гээгүйгий нь яамай даа гэж бодохгүй яах нь вэ. Сэхүүн зан гаргах гээд байвал чамайг мөглөнд цоожилж байгаад ганц охиныг чинь авсан ч дур юм чинь” гэж бодон түүнийг хялайн харна. Намсрай тахрын харцтай тулгараад гөлсхийн санаа алдав. Энэ тахар харгис хэрцгийгээрээ хошууныхаа харц олны зүрхэнд хүрсэн учир түүнийг “Догшин Пэрэнлэй” гэдэг билээ. “Хэлгүй юм шиг суусаар байгаад бид хоёрыг явуулчих санаа байна уу, чамд! Над шиг эзнийхээ хайрыг хүлээсэн тахар хүн энэ муутай яаж ч ярьсан яадаг юм бэ. Чамайг юу гэхийа чинь үзэж байж сална даа” гэж өөртөө эрдсэн тахар,

- Бие биеэ харж сууснаас ний нуугүй ярьчихвал хэн хэнд маань амар биш үү. Хошууны тэргүүн туслагч танай охиныг таалж байгаа нь миний хувьд баярлалтай санагдах юм. Намрын л танайд дуулгая гэж ярилцсан боловч туслагч өөрөө сэтгэл зовсхийн завдалгүй байсаар өдий хүрээ. Өндөр дээд язгуурт түшүүштэй сайн хүн шүү. Сайн бод доо Намсрай минь! гэж хэлэхэд,

- Харин нь ээ гээд Намсрай уруу харан таг болчихов. “Үнэрхэж тунирхсан дүр үзүүлбэл бэрд үнэ хүндтэй байдагсан. Боож дургүйцвэл ноёд түшмэд нь уурсах болов уу. Энэ Пэрэнлэйн царайг харахад сүрдүүлэх янзтай. Ёс төр бодож гуйсан дүр үзүүлээд болохгүй бол яана ч гэж ярилцсан юм билээ. Би яаж мэдэх вэ. Яавал эдний дур. Охиноо бэрдэлж байгаад амаараа шороо үмхэж юу юу ч үгүй хоцорвол яана! Харамлаагүй хүн болоод тэг тэг гэж уриалган

дуугарья гэхээр эрх танхи охин минь хөөрхий болно. Би гэдэг хүн яана даа. Ямар ч гэсэн нэг юм хэлж эднийг аргацаан явуулахаас өөр арга алга уу даа” гэж уймран суусан Намсрай

- Дээд язгуурт хошуу туслагчтан охиныг минь хатан болгохоор таалж байгаад өчүүхэн боол би баярлавч баршгүй. Гэсэн ч эрхэм дээдсийн буян хишиг харц гаралтай охинд минь хүнддэх бий дээ гэж эмээж байна. Заяа төөрөг нь нийлэх тавилангүй бол миний охин яах вэ гэхэд, эрхэмсэг туслагчийг гай зовлон дайрах бий дээ гэж санаа туйлун их зовниж байна. Ямар ч атугай лам багшаасаа жил сүүдрийн нь асууж байж болох уу даа. Хувь заяа нь таарч тохирдог юм бол төрсөн охиноо хошууныхаа тэргүүн туслагчийн хатан болгоход баяртай байлгүй яах вэ гэж зулгуйдан өгүүлэхэд “Чи ингэж хэлэхгүй хаашаа гарах вэ. Тэгэхгүй бол ам руугаа алгадуулах байсан юм чинь” гэж бодсон тахрын хөргөр бараан царайд эрдэж бардсан хүний хүйтэн инээмсэглэл тодров.

- Хүүхний сүйд тавин лангийн бөгтөр ембүү тав, морь арав, тугалтай үнээ тав, хонь тавь, дээлийн өнгө хорийг амалж байгаа даа. Дараа ярьж байж тохирно биз гэж өвгөжөөр хүн хэлээд “Пэрэнлэй ч зоримог түрэмгий сүрхий хүн юм даа. Баян хоосонгүй айдаг нь ч аргагүй юм байна. Пэрэнлэйтэй ирээгүй бол ч би Намсрайн амыг харсаар хэд хонож ч мэдэх нь гээч хэмээн өвгөжөөр хүн нь хамт ирсэн тахартаа тун ч их баярлажээ.

Тэднийг явахаар завдахад Намсрай,

- Морь, биеэ амрааж хоноод өглөө мордохгүй юу. Шөнийн хүйтэнд хол газар яаж явах вэ гэж тал өгсөн боловч тэд яаран мордов. Сэр-Од хөндлөнгийн хүний нүдэнд өртөхгүйн учир харанхуй болсон хойно хүрч, шөнөө багтаж буцаж ир гэсэн юм байжээ. Замдаа даарахгүй гэж ахиухан архи уусан халамцуу тахар мориндоо мордсон хойноо бөхийж Намсрайн мөрөн дээр алгадаад

- Сэ туслагч ноёнтонд айлтгаж байгаад чамайг залан болгох юм гэнэ билээ. Хошуу ноён хүүхэд болохоор хамаг хэргийг тэргүүн туслагчдаа даатгадаг юм. Тэгэхээр түүний санаснаар болох биз. Манай туслагч хэзээний чамд сайн шүү дээ. Энэ хошууны олон бичигтэн дотроос чамайг шилж байгааг бодооч! Сэ туслагч шиг хүргэнтэй хүн чинь өөрөө залан болчихоор зарц зараад хөл жийж суухаас өөр яах вэ. Өтөлсөн хойноо жаргажээ. Намсрай минь! гэж шивгэнээд эмээл дээрээ цэх болж

- Чи ч мөн азтай хүн юмаа гээд баргиа хахир дугаар ха ха ха гэж чанга инээжээ

“Залан гэдэг ганц үг Намсрайн чихнээ тун ч аятайхан сонсдож хөх жинс нүдэнд нь үзэгдэх шиг болж түүний сэтгэлд эрхгүй нэгийг бодуулав. Пэрэнлэй ч түүний инээмсэглэхийг мэдээд, туслагчийнхаа зааж өгсөн эгзэгтэй үгэнд өөрөө хачир нэмээд цагий нь олж хэлж чадсандаа ихэд сайрхан буцлаа. Мөнгө дайвал дутна, үг дайвал илүүднэ гэдэг энэ ажээ.

“Манай залан өөд болсоор удлаа. Хошуу тамгын алаа ч хийдэгдэх нь байна. Даруйдаа нэг хүн олохгүй бол горьгүй нь дээ” гэж туслагчийн ярьж байсан нь Намсрайн дотор тогхийгээд явчив. Хошуу туслагч өөрөөр нь бичиг бичүүлж үзээд хичээлтэй сүрхий хүн юм гэж магтаж байсан нь ч санагджээ. Намсрай тодоос тод цахилзан гялалзаж байгаа оддын доогуур дүнхийн харлах тэртээ уулын оройг ширтэж “Бүхэл бүтэн хошуу захирч, амьтны юмыг тонож

хагартлаа баяжсан туслагч байж ямар ч нарийн юм бэ? Амлаж байгаа сүйгий нь хараач! Ичмээр юм. За тэр сүй мүй нь ч яах вэ, хоосон хонох гэж байгаа биш. Харин тэр жинс гэдэг чинь ёстой эрдэнэ шүү. Туслагчийн тааллаар болно гэдэг яриангүй үнэн. Залан болчихдог юм бол ч... Сэр-Од охинд минь ахдаад юу базаах вэ. Над шиг өтөлсөн биш. Эрх охинд минь нас нь тогтсон хүн дээр. Юу ч гэсэн дүвчин багшаас асууя. Миний ганц охин түшмэлийн хатан болох учиртай төрсөн ч юм билүү. Бурхнаас заяасан бол яах вэ. Охин минь Намсрайн үр үндсийг залгамжилна. Тэгэхээр охиноо ноён язгуурын хүнтэй суулгавал сайн үр төрүүлж, Намсрайн удам язгуур угсаатан болно. Ач гуч минь намайг дурсахдаа сайн заяа дагуулсанд минь буян санаж явах болí” гэж бодон зогсоход хоёр морьтны бараа тасарч, алслан холдож байгаа морин түвэргээний чимээ бүдэг бадагхан сонсоно. Гүн бодолд дарагдсан энэ хүн чихнийхээ даарахыг ч анзаарсангүй. Чихээ часхийхэд “Ээ золиг” гэж хараагаад давхийн нударгаараа үрж

- Гуйгаад олддоггүй тэр муу жинс чинь цагаа болохоор өөрөө хүрээд ирдэг байна шүү гэж амандаа бувтнаад гэр рүүгээ орох гэтэл хашааны дэргэд хүн шивнэлдэхийг сонссод тэр зүг сэртхийн ажиж чимээ чагнав.

- Юмжирдулам аа! гэж эцэг нь дуудав.

- За, аав аа гэсэүд охин нь гүйж ирэхэд нэг хүн цаашаа сүүтэгнэн явчихыг Намсрай хараад “Базартай зогсож байж шүү. Хэрэв охиноí Сэр-Одтой суулгах болбол энэ ороолон чинь гай тээг болж мэднэ. Сүх дархан лам ноёдод хэгжүүрхдэг бүдүүн хүзүүтэй хүн. Энэ хүү ч гэсэн зангий нь хуулсан байлгүй гэж бодоод гэртээ оров.

- Чи Сүх гуайнд орохгүй гадаа зогсож байгаа юу? гэж эцгийнхээ асуухад Үмжирдулам юу ч хэлсэнгүй ширдэг ширтэн сууж эцгээсээ зовоходоо ухасхийн зуух руугаа түлээ чихсэнд

- Чи энэ халуунā гал өрдөж яах нь вэ гэхээр нь аргаа барахдаа аяга шүүрч цай хийж аваад, ичиж самгардсандаа халууныā нь ч мэдсэнгүй балгаж сандраад буцааж тургихаас айгаад залгиж орхисонд хоолойны нь арьс зумраад явчих шиг болж нүднээс нь нулимс бөмбөрөв.

- Охин минь, чи хэрээ мэдэж хүн төрхтэй шиг байвал дээр шүү. Өдий багаасаа битгий задрах гээд байгаарай! гэж эцэг нь битүүхэн зэмлэжээ.

Зургадугаар бүлэг

Осол цалгарын гай

Харц ядуус хоосон ч

Халуун сэтгэлээр баян

Алба гувчуурт төлөх хөрөнгөгүй гэж заалдсан хэдэн ардын хэргийг шүүлгэсээр өдрийн тэнг авсан хошуу туслагч ердийнхөөрөө нилээд аажуу гэртээ ирэхдээ отго жинстэй малгайгаа авч авдран дээрээ чулуудаад янцаглан суухад нь Пагма түүний ууртай байгааг мэдэж, эртнээс бэлдэж тавьсан зоогий нь шалмаг гэгч барьжээ. Туслагч өөр рүү нь хяламхийж ч харахгүй ихэд өлсөж ундаассан янзтай зоогийн махнаас том том огтлон ховдоглон үмхэлж байхыг Пагма харан суухдаа “Ямбатай улс өл даадаггүй юм уу даа. Өглөө бишгүй л идэж аваад явсан. Үдийн хугархай болоход хаанаас ингэтлээ өлсөв гэж. Хїосон хүний жилдээ олддоггүй хоолыг ганцхан удаад залгиж орхих юм. Тэгэхэд ядуу хүнд ийм мах цагаан сараар л нэг олдож магадгүй дээ” гэж бодон цайгаа хурдхан зооглоод яваасай гэж хүлээнэ. Гэтэл туслагчийг тун ч тухлуу байхаар нь түүний сэтгэл улам яаран донголзоно.

Улин исгэрэх шуурганы чимээ чагнан тоононы шилэн дээр цайран унах цасан ширхгийг харахаас Пагмад даарах шиг санагдана.

“Туслагчдан оройтоод намайг хүлээлгэчихлээ. Бушуухан яваасай! Аягүй бол хэвтээд өгөх байх. Гараад явчихвал уурлах болов уу. Орших минь хувцас хунар муутай юмсан. Энэ хар хүйтэнд гадаа зогсоор осгох шахаж байгаа даа” гэж санаа зовно. Сэр-Од гэдэс аарсан хойноо “Хэдэн задарсан боолоос болж турж үхэх шахав байна. та нарыг даа, би одоохоон шүүслээд өгье. Байхгүйгээрээ шалтаглаад мултарна гэж бодож байгаа бий” гэж бодон тэр хэдтэйгээ дахин уралцахаар, хайргүй хаясан малгайгаа авч энд тэнд нь нясалж, үснийх нь сорыг хэд үлээгээд өмсчээ. Хүн гадаа гарамгүй цасан шуурганд зориглон явахыг бодоход туслагч тэр заргыг даруй нэг тийш болгон сэтгэл амрах гэж яарсан нь илт. Тэгээд ч тэр нь бусадтай бус өөртэй нь холбоотой юмсанжээ.

Туслагчийг явмагц Пагма гадаахь байшинд ухасхийн орж жаахан гурил будаа хүүдийд хийж өөрийнхөө байдаг гэдээс баадан авч боогоод гартал хашааны хаалган дээр өөрийг нь эргүүлдээд байдаг саримгар шар царайтай залуухан хиатай халз мөргөлдөв.

- Туслагчтан бий юу? гэж хиа инээмсэглэн асуух нь түүний явахыг харуулдаж байгаад ирсэн бололтой.

- Бий бий. Өргөөндөө байгаа. Та морилогтун гэж Пагмыг хэлээд цааш явах гэтэл хиа гараас нь шүүрч,

- Чи энэ хар шуурганаар хаачих гээ бэ? Хоёулаа орьё. Намайг бас хуурах санаатай юу. Би чамтай уулзах гэсэн юм гээд хашаа руу чангаахад Пагма уурлаж,

- Шивэгчин хүнээр оролдож байдаг яасан ичгүүргүй амьтан бэ. Туслагчтанд хэлнэ шүү гээд

бие багатай доожоогүй хиаг түлхчихсэнд хаалганы ёроолын хонгарласан цасан дээр тэрийн унаад хоцров.

Гудамжаар цасан хуй манаран эргэлдэж байлаа. Шуурга хүрээний амьд бүхний хөлийг хорьсон бололтой. Хүн байтугай газар сайгүй хоол эрж шинжлэн шогшиж явдаг нохдын бараа ч үл үзэгдэнэ.

Пагма цасан шуурга сөрөн болзоот амрагтаа яаран хунгарт бүдчин бүдчин явахдаа араасаа хүн дагасныг мэдсэнгүй. Пагмыг хэдэн сар ээрүүлдээд санаандаа хүрч чадаагүй сайхь хиа цасанд хутгалдтал түлхүүлсэндээ хорсож, түүний хаа хүрдгийг мэдэхээр гудамж, хашааны булан тойроход нь алдахгүй мөшгиж байлаа. Тэгтэл Пагма хүрээний захын гудамжны доголд морио тушчихаад хоёр ханцуйдаа гараа шургуулан нааш цааш холхин байсан хүн дээр очихыг хиа хараад нуугдаж хэрхэхийг хүлээв. Эцэнхий хээр морь шуурга уруудан толгой унжуулж, дөрвөн хөлөө хумьсхийн зогсжээ. Пагма нөхөөстэй хуучин өнгө нэхий дээлтэй, үс нь халцарч хуйх болох шахсан үнэгэн лоовууз өмссөн Оршихын гарыг атгаж үзсэнээ

- Чи минь баахан даарав уу? гэхэд хүйтэн шуургыг төдийлэн тоосон янзгүй зогсож байгаа бөлцөндүү зовхитой, онигордуу нүдтэй залуу

- Энэ зэргийн шуурганд юу алзах вэ гээд инээмсэглэв.

- Би чамайг осгох гэж байгаа байх гэж сэтгэл зовсон шүү. Чи ч харин өлчир юм байна... Үүнийг ам руугаа хийчих гээд Пагма аягын чинээ цагаан тос өглөө.

- Өмсөх юмгүй хүйийг өлчир гэдэг юм. Өгөх юмгүй хүнийг өрд ороолгон гэдэг юм гээд Орших хар бор ажилд нухлагдаж эвэр ургасан том гараараа тосноос хэлтэлж ам руугаа хийгээд

- Ээждээ аваачиж өгье гээд үлдсэнийг ий өвөртлөх гэхэд нь Пагма,

- Энүүнтэй нийлүүлээд ганзагалчих гээд авчирсан гурил будаагаа өгөхөд залуу

- Уулзах бүртээ шахам л юм авчрах юм. Чи өөрөө болоод байгаа юм уу? Аль эсвэл хөлс хүч авдаг хэрэг үү? Үгж асуув.

- Надад юуных нь хөлс хүч байх вэ. Туслагчийн л юмнаас хумсалсан юм.

- Пагма минь, тэгвэл больсон нь дээр. Хумсалсаар хумсалсаар хулгайч гэгч болох вий. Мэдэгдэж хэрэгт орвол яана.

- Санаагаа бүү зов. Аяга тавгаар байтугай уут саваар нь авсан ч мэдэхийн аргагүй их юм бий. Хичнээн баян гэж санана гэж Пагма нүдээ бүлтийлгэн дуу алдав.

Хашааны булангаар толгой цухуйлган харж байсан хиа “Чи муу шивэгчин ноёны хиаг тоохгүй дээгүүр зантай мөртөө харц барлагтай хашаа хорооны мухарт ингэж явдаг бий вий! Намайг түрүүн ааг омогтой түлхэж байл уу. Надтай гэмгүй байсан бол чамд л өлзийтэй байх байсан” гэж шивэгчинд гологдсондоо өширхөж алтан хошуу өргөхөөр гүйж одов.

Уулзалгүй удсан Орших Пагма хоёр үүгээр түүгээр хүн явахгүйд нь олзуурхаж даарах бээрэхийг үл тоон ярилцсаар байлаа. Намрын сэрүүн унаж нутаг холдсоноос хойш баян айлын зарц Оршиход хүрээ орж сэтгэлтэй бүсгүйтэйгээ учрах зав хэрхэн олдох билээ. Баяны өвөлжөө бууцуй засаж, өвн хужир, мод түлээгий нь буулгах давхар давхар хүчир ажилд зүтгэсээр намрыг ардаа хийж, өвөлтэй золгов. Баяных өвөлжөөндөө буусны дараахан цаг өнтэйн учир Орших лам багшдаа мөргөх нэрээр хүрээ орох болжээ.

- Чамайг харуулдан хүлээж суух хэцүү юм даа. Чи намайг ямар уйтгартай байдаг гэж санана! Мөн ч удаж байж нэг ирэх юм даа чи минь. Бараагий чинь харахаар сэтгэл амрах юм. Ойрхон ойрхон ирж байгаач дээ! гээд Пагма Оршихын хацарт хацраа нааж санаа алдлаа.

- Хүний эрхэнд байгаа надад тэгж дураараа явах арга даанч алга даа.

- Чи минь намайгаа бодвол морь унаж мод тохоод хээр гадаа явчихдаг эр хүн шүү дээ. Над шиг нэг түшмэлийн царай ширтэж хаяагий нь сахиад хэвтэж байгаа биш дээ. Миний хаа яваад хэзээ ирэхийг баян андахгүй. Аяуй нь дагаж л байхгүй бол аяга хоолноосоо сална.

- Хүний эрхэнд нэг насыг барна гэдэг юутай гашуун зовлон бэ. Өөрийн эрхээр ганц хоног ч байтугай явж үзэхсэн. Хайран сайхан залуу нас минь аз жаргалгүй өнгөрөх гэж үү. Орших минь чи эр хүн шүү дээ. Эр хүн арван гурван мэхтэй гэдэг. Түүнийгээ хэрэглэхэд чи минь намайг энэ дөнгөнөөс салгаж чадах биш үү. Хорвоо дээр хоног өнгөрөөнө гэдэг надад тун ч бэрх байна гээд Пагма нулимс асгаруулан уйлав. Энгэрийн нь даган бөмбөрч байгаа нулимсанд цасан ширхэг шаван хөлдөж байв. Хайрлан дурласан хичнээн хос залуу хувь тавилангийнхаа хатуу хуулинд хүлэгдэж уйтгар гунигийн нулимсан далайнд хөвж зол завшаангүй өнгөрч байсныг хэрхэн өгүүлж барах билээ.

Хүний уй гашууй уран гоё үгээр ч атугай засах чадалгүй төрсөн дуугүй номой Орших хүүхний гасланг сэтгэл зүрхэндээ хуваалцан шаналж нулимсыг нь арчиж тайтгаруулахыг оролдохоос үл хэтэрнэ. Зовлонгийн түмэн харанхуйгаас хагацаж, аз жаргалын гэгээн наран өөд тэмүүлсэн хөөрхий бүсгүйн хүсэл мөрөөдлийг оч адил гийгүүлэх эрс зоримог үг Оршихын амнаас эс гарав. Хорвоод учрах хатуу бэрх болгонд өмнө номхон хүлцэнгүйгээр сөхөрч аялдан дагана гэдэг хувь зохиолынхоо үүд хаалгыг өөрийн гараар түгжиж байгаа хэрэг.

- Пагма минь бодоод бодоод бодуй шийр дөрөв гэдгээс хэтрэхгүй юм даа гэж Орших цөхөрсөн янзтай хэлэв.

- Чи минь яв даа. Муу унаатай хүнд хүрэх газар чинь хол... Би ахар жолоот хүн яах вэ. Чамайгаа бодоод анхирай сууж байхаас гэж хүүхэн эхэр татан өгүүлэв.

- Баяны ажлын барагддаггүйг чи мэднэ шүү дээ. Зун болж нутаг ойртохоос нааш уулзаж завдахгүй байх... Сайн сууж байгаарай! гээд Орших хүүхнийг үнсэхэд

- За гэж Пагма дөнгөж дуугараад мэгшин уйлж нулимсаа арчсаар байв.

Орших мориныхоо тушааг тайлаад хүүхний нулимсыг арчиж

- Битгий уйл даа, Пагма минь! Амар мэнд суувал зун болох маргааштай адилхан шүү дээ гээд мордохыг завдтал гэнэт морин туурай тачигнаж тахар Пэрэнлэй давхин ирлээ.

- Задарсан боол чи ингэж явдаг бий! гэж Пэрэнлэй хашгираад Оршихын нуруун дундуур хүнд ташуураа буулгаж Пагмыг ороолгоод хоёулангий нь тамгын газар руу хөөж одов.

Тэр хоёрын тухай хиагаас сонссон Сэр-Од сүүлийн үес Пагмын өөртөө илт дургүйцэх болсны учрыг сая мэдэж ухаад уурсан, сэтгэлтэй хоёрыг хүнд ялā унаган дахин ойртуулахгүй байхаар яг таг бодлоо. Тэгэхдээ доод түшмэлийнхээ гараар могой бариулаад өөрөө ард нь хоцорч шивэгчиндээ нэр цэвэр үлдэх ов гаргажээ. Нэгэн занги тэр хоёрыг өргөөний газар самуурч, туслагчийн сангаас хулгайлан завшсан гэж залхаав. Туслагчийнхаа хэлснээр Пагмыг айлган сүрдүүлж зангаад, Оршихын хоёр хацрыг хорь хорь шаахайдан цээрлүүлэв. Загнах зодох хоёрт айж хэлмэгдэн ухаан алдах шахсан Орших өргөө рүү хэзээ ч дахин ирэхгүй гэж ам өгч түмэнтээ мөргөж байхад Пагма яавал яаг ч гэсэн янзтай үг дуу ч үгүй гөлийж, занги, тахар хоёрыг хорсолтойёо харж харин хайрт хүнийхээ тийнхүү андгай өргөж арчаагүй байгаад голоосоо гомдохдоо “Энэ чинь надтай уулзаж байхаа бүр болино гэнэ үү. Өнөөх хайр сэтгэл нь шаахайны амт үзэхтэйгээ зэрэг хийсээд явчив гэж үү. Ээ чааваас, ийм ч эр заяах гэж! Эдний өөдөөс часхийсэн хэдэн үг хэлчихээд миний гараас хөтлөөд гарах аавын хүү байсан ч болоосой. Миний заяа дутсанаас л энэ. Туслагчийн хүйтэн өврөөс өөр юм олдох тавилангүй төрсөн амьтан байж дээ би” гэж гутран бодож суулаа. Сэр-Од тэнд орж ирээд

- Энэ хоёр залуу улс болохоор нэгэн удаад осолдоо биз. Ял зэмлэлэйг үүгээр дуусга! Дахин чингэвэл хүндээр цээрлүүлнэ. Одоо эндээс дадбó зайл! гэж сүртэй дуугарахад Орших түүний өлмийд сөгдөж

- Өршөө, туслагчтан! гэж бөхөлзөн мөргөөд гар гэж ам ангайсан дээр нь зайлах гэсэн бололтой шурхийн босож цус шүүрсэн хацраа алгаараа даран үзсээр Пагма руу нүдний булангаар ч болтугай харж зүрхэлсэнгүй ум хумгүй босго даван одов. Түүнээс хайр энэрэлийн дулаан харц горилж байсан Пагма тэсэлгүй нулимс урсгасаар хоцорлоо. Сэр-Од туслагч шивэгчин рүүгээ зэрвэс харснаа дууныхаа өнгийг өөрчлөн

- Чамайг өргөөнд удсан болохоор чинь өршөөж ял оноосонгүй. Зүй нь хөөх байсан юм гэвэл

- Одоо хөөгөөд аль! Надад энэ тамын оронд чинь байх хүсэл алга. Түүнтэйгээ хамт явна гэж цурхиран орилж ухасхийн гарах гэхэд нь тахар Пэрэнлэй түлхэж унагав.

- Чи ноёны өргөө, хошуу хүрээг тамын орон гэнэ ээ! Чамайг тэгж галзуурвал хүсээд байгаа тамын оронд чинь түвэггүй хүргээд өгнө шүү гэж түүнийг шүүсэн занги хөмсөг зангидан зандрав. Пагма амархан аюул заналд унахаа гадарлан амаа хамхиад хүртээмжтэйгээр нь нулимсаа баахан асгаруулжээ.

Оршихыг хүрээнээс гарахад цасан шуурга намжсан байлаа. Залуу эр улаан нялга болсон хоёр хацраа өрөөсөн ханцуйгаараа ээлжлэн хаацалж жавар сөрөн шогшуулж явлаа. “Мөрөөрөө гэлдэрч явсан хирнээ ямар аймшигтай ялд унав аа, би! Хүрээ рүү яах зүглэнэ вэ? Арга бий гэж үү? Очихгүй гэхээр Пагмыгаа би яах хүн бэ? Намайг явснаас хойш түүнийг минь яаж зовоогоо бол? Х°нг°н л өнгөрөх болтугай” гэж Орших залбираад “Хаашдаа хоёр хацаргүй

боллоо. Юу ч үгүй хөлдөх байх. Шаахай гэдэг чинь ямар аймшигтай зодуур вэ” гэж бодно.

Үнэг, хярсны арьс сагсалзтал ганзагаалаад хүрээ орохоор явж байсан Базартай Орших замд тааралдав. Базар уулзсан хүнийхээ хацрыг хармагц тамганд шүүлгээд буцаж яваагий нь мэдсэн боловч түүнийг хэрэг хиймгүй юм гэж гайхахдаа

- Яагаад хоёр хацраа уруулчихаа вэ? Дориун эр нэг гарч ирэх нь энэ үү? Ёж асуувал Орших нэг юм хэлэх гэж уруулаа хөдөлгөснөө дуугарсангүй.

- Татвар түрээсээ төлж чадалгүй махаа зулгаалгаа юу?

- Хэдэн лан оноосныа нь аргалаад төлчихсөн.

- Тэгээд?... Хулгай зэлгийд холбогдоо юу? Баяныхаа хониноос шөл уучихсөн уу? гээд Базар дооглонгуй инээмсэглэв.

- Үгүй, яалаа гэж.

- Тэгвэл зүгээр хүнийг яалаа гэж зодож байгаа махчингууд вэ? гээд Базар хөмсгөө атируулав. Баахан ичингүйрч үнэнээ нууж өнгөрөх гэж хулмаганаж байсан Орших “Дархныг лам ноёдод дургүй гэлцдэг. Миний зодуулсныг үзээд зэвүүцэхийг бодоход хүү нь бас адил байх” гэж гэнэт бодоод хар багаасаа нэг нутаг, ихэр буудалтай явж, тоглож наадаж өссөн үе тэнгийн залуудаа учраа яривал арга ухаан зааж тус болж юун магад гэсэн санаа төрөв.

- Би өргөөний нэг хүүхэнтэй сайн байдаг юм. Түүнтэйгээ уулзаж байж баригдаад тамганд хүргэгдэж хоёр хацрынхаа махыг өгч саллаа гэв.

- Чи чинь ноёд түшмэдэйн хатад эргүүлж явдаг болоо юу? гэж Базар тоглоом болгон инээхэд Орших,

- Хатнаа алд. Туслагчийн шивэгчин гэж санаа зовонгуй дуугарав.

- Яггүй хүнтэй учирч дээ. Туслагчийн гараас тэр хүүхнийг салгана гэдэг амаргүй.

- Яах ч ухаанаа олохгүй байна. Уулзахад ч хэцүү боллоо.

- Амьд хүн аргатай. Яваандаа эвийа нь олж болох биз... Чи яаж ингэж харих вэ. Хоёр хацар чинь юу ч үгүй хөлдөнө. Май, үүгээр ороогоод харь гээд Базар ганзагнаасаа нэг үнэгний арьс авч өглөө.

- Би удаахгүй аваачаад өгчихнө өө гэж Оршихыг хэлэхэд

- Яах вэ хө, хэдэн аяга будаанаас өгөөд шөлөнд хийгээд уучихаарай! Хангай надаас хишгээ харамлах биш гээд Базар

- Ээжийн чинь тэнхээ сайн байгаа юу? гэж асуулаа.

- Ээж яах вэ, овоо байна. Ядуу зүдүү, идэж уухаар гачигдуу байхаар чинь настай хүн алсаасаа өөдлөхгүй юм байна шүү гэж Орших өгүүлэв.

- Чи надтай хааяа зээрэнд явж бай л даа.

- Би чинь угаасаа анд дургүй хүн шүү дээ.

- Зээр эргүүлээд байж дөнгөнө биз. Би чамайг дагуулаад явж байя гэж Базарыг хэлэхэд Орших түүний тусархуу зантайд нь сэтгэлийн гүнд баясжээ.

Долоодугаар бүлэг

Хувь заяаны дэнс

Шооны нүх, хаашаа бол

Хүний заяа тийшээ

Гэрийн дотор нам гүм, бүлээн дулаан. Арц хүжний анхилуун үнэр ханхлах нь сэтгэлд тааламжтай. Өвч хивс дэвсэж, том жижиг зурмал, дэлгэмэл, гуулин бурхад, тахилын хэрэглэл, баринтагтай ном судар оржээ. Намхан модон орны өмнөх эрээн олбог дээр Агваанлуvsан завилж суугаад урьдахи ширээнээ дэлгэн тавьсан зузаан судрын хуудсыг эргүүлэн уруулаа дорволзуулан амандаа уншиж байснаа хааяа номноос нүдээ салган нарийхан хүзүүгээ сунган тооно өөд өлийн ширтэж хоёр гараа өргөн залбирна. Түүний эцэнхий царай зэрмийж цайсныг үзэхдүл сэрүү унаснаас хойш тоотойхон гадаалдаг болсных аж.

Намсрай орж ирмэгцээ дүвчингийн амрыг эрээд үсэнд нь цан тогтсон малгайгаа шалавхан авч түүний өвдөгт сөхрөн толгой бөхийн адис хүртэв. Агваанлуvsан урьдахи номоо хамхин хажуу тийш тавив. Намсрай багшдаа авчирсан хөлдөөсөн сүү, лонхтой архиа барив. Ламын шавь дэлдэн банди орж ирээд Намсрайд цай идээ бариад багшийгаа дохимогц гарлаа.

- Намсрай минь, хөхөө өвөл холоос зүтгэж ирснийг бодоход онц хэрэг гараа юу? Охины чинь бие сайн биз?

- Багш таны авралаар бид цөм мэнд сайн байна аа гэж Намсрай мэхийн өчөөд

- Багш минь, манай охиныг хошуу туслагчид гуйж ирлээ. Гэгээн багш таныхаа тааллаар болохоос биш, өчүүхэн би юугаа мэдэх билээ. Та нэг болгооё айлдаач! гээд соном хадаг дээр шоргоолжин ембүү тавьж барилаа. Агваанлуvsан чөргөр урт гараа тосож барьцыг сурмаг авахдаа “Туслагч Сэр-Од зун нэр нүүрээ барахаасаа ч буцахгүй шохоорхоод байсан юм. Тэгж таарна. Эрх мэдэлтэй хүн санаснаараа зүтгэхэд түүний өмнүүр хориг тавих хүн бий гэж үү” хэмээн бодлоо. Намсрай, дүвчингийн нүүр өөд бишрэлтэйеэ ширтэн юу айлдахыг нь яаран хүлээнэ. Дүвчингийн гарт эргэлдэж байсан зургаан талдаа түвд үсэгтэй хүрэн шоо бяцхан модон хайрцагны таг дээр торхийн унав. Зүүрмэглэсэн мэт чацавхийж ч хөдлөхгүй байсан дүвчин сая шоо унах чимээнээр нүдээ нээн шоо руу харснаа үл мэдэг цочин давхийхийг Намсрай ажаад дотор нь сэртхийжээ. Дүвчин “дээд тэнгэрийн язгууртай хүний хувь заяа яалаа гэж ийм муу ёр зөгнөсөн байх билээ” гэж бодоод шоогоо удаанаар шившин хоёр дахин орхиод санаа алдахад Намсрай “Багш минь юм асуухад ингэж удаггүйсэн. Гуряа орхичихоод санаа алддаг нь юу вэ? Учрал ерөөл нь таарахгүй байгаа юм байж дээ. Царамд ургасан вансэмбэрүү шиг ариухан төрсөн охин минь тэргүүн туслагчийн хатан болох хувьгүй байна гэдэг мөн хачин аа... Тэгвэл ч өнөөх залан, жинс хоёр чинь цаашаа буцчих байх даа. Намсрайн удам угсаа язгууртан болно гэж хүссэн минь өнгөрчээ” гэж гомдолтойёо бодон уруу царайлж дүвчинг юу гэж айлдах бол гэхээс зүрх нь түг түг цохилно.

Агваанлуvsан чшоогоо атган “Бууснаар нь айлчихвал яадаг бол? Намсрайтай хуйвалдан

худал хэлж охинтой нь суулгахгүй байна гэж бодвол яана! Сэр-Од туслагч дургүйгээ хүрсэн хүнийг яаж ч мэднэ... Ийм хоёр хүний хувь тавилан заавал таарах ёстой доо. Энэ шоонд учир ургалаа. Энэ золигийн банди намайг эзгүй хойгуур бохир гараа шоонд хүргэж бузартуулчихсан юм биш байгаа даа” гэж бодоод хэрхэхээ мэдэхгүй алмайрч сэтгэл түгшин сууна.

Агваанлуvsан баян айлын ганц хүү ажээ. Эцэг нь хүүгээ буянтай сайн лам болгох гэж найман настайд нь Галуутайн хүрээнд нэгэн гавьжид шавь оруулав. Түүний дөнгөж өсөн төлжиж байсан оюун санаа гавьжийн айлдсан бурхны сургаалын мананд бүрнээ төөрч, эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусыг бодон ном бясалгахаас өөр юухныг ч мэддэггүй хүн болов. Агваанлуvsан төрөлхийн ухаан мулгуугийн харгайгаар хүүгээ гавьжийн дамжаа барихад нь хүрээний лам нарыг хүйгээр нь цатгана гэж сайрхан баян тарганаараа бардамнаж явсан эцгийнхээ санаанд дүецэхүйцээр бурхан номд боловсорч мяндаг тушаалтай лам болж чадсангүй. Эцгийнх нь бардам амыг сонссон Агваанлуvsангийн үеийн танил лам нар ч хэзээ гавьжийн дамжаа барьж бид нар гэдэс гарах болж байна, түргэлж үзээч гэж даажин тохуу хийдэг байлаа. Гэсэн ч Агваанлуvsан нутаг усандаа нэртэй дүвчин лам болов. Эцгийгээ насан эцэслэхэд гучин настай үлдсэн Агваанлуvsан хүрээнээс гарч арвин хөрөнгө зорийа нь өвлөж хөдөөлөн суужээ. Үе залган баян чинээлэг яваагаа, үнэн санаанаасаа бурханд сүсэглэж буян үйлдэж буйн ач гэж итгэдэг сайхь дүвчин эцгийнхээ үр удмыг өөрийн биеэр тасалæ, хурааж хуримтлуулсан өв хөрөнгөө үлдээх үргүй болсноо эс ухаарсан нь нэн ч өрөвдөлтэй!

Агваанлуvsан шүүрэн тагтай гуулин шанланд арц уугёоёæ сангийн жижигхэн судар гаргаж ирээд дүнгэнэтэл уншиж гарахад Намсрай ч залбиран сүсэглэж байлаа. Дүвчин сангаа тавьж арцны суунаглах угаанд шоогоо ариутган дуусаад дахин мэргэлэв. Зандан шоо дүвчингийн хүсэж горьдсон талаар унахад сэтгэлийнх нь бөглөөс сая онгойи шавийнхаа өөдөөс нүүр бардам харлаа. Багшийнхаа нүүр, шоо хоёроос нүдний хараа салгахгүй бүэтгэнэж суусан Намсрай түүний мишээнгүй царайг ажаад санаа амрав. Агваанлуvsан шоогоо ариулснаас тийнхүү зөв уналаа гэж санаад,

- Туслагч, танай охин хоёр бурхнаас заяасан ерөөлтэй хоёр юм даа. Туслагч хонин жилтэй нь бүр ч ээлтэй. Танай охин заяаных нь хань юм байна. Туслагчтан заяаныхаа ханийг олохгүй төөрч мунгинасаар өдий хүрчээ... гээд нүдээ аньсхийн хэсэгхэн дуугүй байснаа,

- Намсрай чамайг ч гэсэн охиноос чинь дутуугүй хувь зохиол хүлээж байна гэж туслагчаас дуулснаа өгүүлэв. Багшийхаа айлдварийг чих тавин сонсож суусан Намсрай энэ үгэнд урамшиж “Намайг залан болгох гэсэн түшмэлийн санааг хүртэл багш минь номын хүчээр мэдчихжээ” гэж бодоод дүвчин ламын “Мэргэнд” улам биширч,

- Багш минь, тэгээд харшлахын аливаа шалтгаангүй, үр үйлс нь дэлгэрч явах нь уу? гэж лавлав.

Дүвчин нүдээ аньж шоогоо дахин үлээж шившихэд “Гоочийа нь гартал сайн үзэх нь дээ. Мөн ч мэргэн түргэн лам шү. Би ховор сайн багштай хүн юм” гэж Намсрай бодоод дүвчинг бахархан харна. Агваанлуvsан шоогоо орхиод үзтэл туслагчийн гэрлэхэд ямар нэг саад тотгор байх шиг санагдахад нь “Туслагчид саад болох юу ч баймгүйсэн. Аа байз, тэр охин чинь бага хүн. Нааш цааш гүйдэг залуу хүн бий биз. Ондоо юу байх билээ” гэж гайхан бодлогоширч

байснаа,

- Яггүй тотгор байна даа. Түүнийг арилгачихвал тун сайн санж гэв.

“Базар гайхал байж таарна. Тэр л охиныг минь эргүүлдэж хувь заяанд нь цөв суулгаж магадгүй. Сүх гуай ч багад нь сүй тавьснаараа саад болж мэднэ” гэж Намсрай санамагц багшдаа айлтгаж мөн эсэхийг нь тодруулахыг хүсэхийн учир,

- Юу юм бол?... манай айлын Сүх гуайн банди биш байгаа даа гэж асуухад,

- Тэр чинь мөн дөө гэж дүвчин үгний нь аясыг дагуулав. Намсрай “Миний таамаг багшийн мэргэтэй яг нийлж байна. Чам муу гуйлгачинг миний охинд дахиад ойртвол уу...” гэж дотроо зүхэж,

- Тэгвэл би очоод салж нүүнэ гэж хэлэв. Залан болж байвал замд нь юу ч хийхээсээ Намсрай буцахгүй болжээ. “Сүхийн тэр банди хошууны тэргүүн туслагчтай эм булаалдана гэдэг ч санаанд багтамгүй хэрэг байх аа. Хэрэв тэгвэл тэнгэрийн лууны өөдөөс архирсантай адил болж сүүлнийх нь үзүүрт гуядуулна” гэж дүвчин бодоод,

- Сүр болж айл аймгийнхаа улстай харгалдаж муудаад яах вэ. Тэр тотгорыг би арилгая. Чи дуугүй байж л бай. Охиныхоо тухайд ч гэсэн туслагчийн хатан болгох гэж байгаагаа хэнд ч сэдэв авахуулахгүй байвал охины чинь заяанд нийлэмжтэй сайн болох нь ээ гэж айлдсанд Намсрай,

- Жа, багш минь! Таны ариун сургаалаас яалаа гэж гажих вэ. Охин бид хоёрын хувь заяаг энэ насан туршид сахиусандаа багтааж яваа эрхэм багш таны өлмий баг орших болтугай! гэж бөхөлзөн залбирав.

- Өлзий хишгийг тэгш хураасан сайн сэтгэлт шавь чиний ганц охины хувь тавиланг намайг соёрх гэж бурхнаас зарлиг болгосон болохоор өчүүхөн хувраг миний бие түмэн олон шавь нарынхаа төлөө буян үйлдэхээс яахин зайлсхийх билээ гэж Агваанлуvsсан хүлцэнгүй айлдахад Намсрай, багш ламынхаа гараас дүнхэр толгойдоо адис хүртээд

- Багшийн минь лагшин тунгалаг байх болтугай! гэж ерөөл тавиад мэхэлзэн ухарсаар гэрээс гарлаа.

Магнай тэнийм баяртай буцаж яваа Намсрай шовгор малгайныхаа сампинг барилан үзэж “Энэ мууг чинь жинсээр солино доо. Залан болоод хошууны санг эрхэлж хагартлаа баяжина. Сангийн нярав хавилдуу баймаар гүзээ шүү” гэж гэдсээ илэн ганцаараа инээмсэглэж “Багшийгаа ингэж айлдаж байхад охиноо туслагчид өгөлгүй яах вэ. Бурхнаас заасан заяагийг нь төөрүүлж болохгүй. Охин үртэй хүн сайхан юм даа. Охиноо өсгөх гэж олон жил зүдэрснийх одоо жаргахгүй бол хэзээ жаргах вэ. Намсрайн ураг удамд жинс зүүх нь бүү хэл, гартаа ч барьж үзсэн хүн үгүй. Миний үе дээр бараг ноён болох нь гээч. Намсрай залан гээд улс амьтан нахилзана. Тэгэхэд нударгаараа шилбүүрдэж толгойгоо ихэмсэг дохиж өнгөрөх юм шүү. Нөгөө хувхай тайжийг уу, чамайг ялихгүй шалтгаар өөтүүлж байгаад бөгсий чинь салбартал банздахгүй бол юуны хүү болîð áîё. Тэр зэргийн хохь тайжаас залан хүчтэй, нөөлөг

ихгэй байхгүй яах вэ. Тэргүүн туслагч хүргэн маань болчихоороо миний үгнээс зөрөхгүй биз. Хүний юм гүжрээр авсны чинь гор өтөлсөн хойно нь гарах нь ээ дээ. Намсрай залан уу, яггүй залан гарна даа” гэж таатайхан бодлоор сэтгэлээ зугаацуулан ергүүлж явлаа.

Наймдугаар бүлэг

Алс замд

Үнэн цагаан сэтгэлийн толь

Гэнэн хонгор нас хөөрхий

Юмжирдулам хонио орхиод уул өөд мацан мацсаар нэгэн том цохион дээр гарч “Ёо ёо, халууцчихлаа” гээд хөлсөө арчиж амьсгаадан шилбүүрээ тулан зогсов. Тэнгэрийн хаяа цайвар манан татан суунаглаж алсын цагаан уулс сүүмэлзэх төдий үзэгдэнэ. Чанх баруунаа зах нь үл үзэгдэх элсэн манхан их далайн давалгаа мэт давхралдан долгиотон үзэгдэнэ. Галуутайн голын мөс цэнхэртэн гялалзаж, энд тэнд уур манан савсан суунаглана. Халиуран шаргалтах өвсөн толгой цас бүрхсэн хөндий талын хүйтэн өнгийг дарсан нь нүдэнд дулаан, сэтгэлд таатай. Өндөр газраа ч хацар хайрах жаваргүй, байгаль дэлхий гойд налгар тайван байгаад сэтгэл байсан бүсгүй гэнэт дуулмаар санагдахад амьсгалаа гүнзгий аваад

“Оломгүй далай нь

Онгоцоо дүүрээд мэлмэрнэ дээ хө

Орчлонгийн хүмүүс нь

Эйдэлгүй юундаа жаргах вэ дээ хө

Үнэгэн зоотой морийг

Үнэлээд унах нь бэрх үү дээ хө

Үнэн санаатай хүнийг

Олоод ханилах нь хэцүү дээ хө

гэж уртын сайхан дууг цээжний гүнээс улам улмаар түрэн ундрах уужим тавиун хоолойгоор хангинатал дуулахад уулнаас ууланд уянгалан цуурайтна. Бэлд байгаа хонин сүрэг, орхисон шагай шиг хөдөлгөөнгүй шахам идэшлэх нь тэр дууны уянга төгс цээлхэн аялгуунаа уяран бүүвэйлэгдэх мэт.

Нэгэн бараан морьтой хүн цас манаруулан давхин айсуйг бүсгүй хармагц тамгын газар дуудагдсан Базарыгаа юу болсон бол гэж гэнэт санан сэтгэл нь сэртхийжээ. “Базарт минь өнөөх есөн эрүү гэгчээ тулгаад одоо намайг аваачиж ялд унагаах гэж байгаа юм биш үү? Тиймгүй бол над руу хэн ингэж давхих вэ. Тамгын тахар ирж байж мэднэ” гэж бүсгүй бодон учиргүй айж хадны араар нуугдаад сэм сэм харна. Морьдныг дөхөж ирэхэд нь Юмжирдулам таньж үнэ маань юунд ингэтлээ давхина вэ! Зуны өнөөхийн хяхуу гарч дээ. Хэрэг бишидвэл зугатна гэж сайн морио унаж явсан шүү. Тэр нь яг оносон байх” гэж бодон сэтгэл зовниж хурдан уулзаж учрыг сонсохын хүслэн болж хад чулуу дамжин дэгдэн дүүлэн уулнаас бууж угтан очвол Базарын морь хөлөрч битүү цан хүүрэг болсон байлаа. Залуугийн баярлаж

хөөрсөн царайг хараад бүсгүйн сэтгэл тайвширч,

- Юу болов? Гэмгүй өнгөрөв үү? гэж яаран асуув.

- Туслагч хүний ариун лагшинд гар хүрсэн гэж надад шийтгэл оноох байх гэж бодоод би их л айж байлаа. Гэтэл тэр тухай юу ч дурссангүй. Туслагч өөрөө ч надтай тааралдсан. Огт танихгүй юм шиг байна билээ.

- Ухаан алдчихсан явж л дээ. Тэгээд юу хийснээ ч мэдэхгүй байсан хэрэг байх. За яамай, би тэр хэргийг хэзээ нэг цагт босож ирнэ гэж дандаа айдаг байсан юм гээд Юмжирдулам санаа амарсан бололтой гүн амьсгалав.

- Надтай ноён уулзах гэсэн юм байна. Би чинь ноёндоо бараалхаад ирлээ.

- Хошуу ноён чамаар яах гээ вэ? Манай ноён чинь хүүхэд гээ биз дээ.

- Арван хэдтэй хөөрхөн хүүхэд байна. Ноён гэхээрээ сүртэй юм. Эмээсхийж л суулаа.

- Чи юу болсноо бушуухан яриач!

- Манай хошуу ноён надад төрийн чухал хэрэг найдаж байгаа юм гэнэ. Агваанлуvsан дүвчин цагаан сараар Богд гэгээнд мөргөхөөр удахгүй Да хүрээ орох юм байна. Хошууны ноён ч Богд хаанд өргөх бэлгээ дүвчингээр өгчилгөх болжээ. Намайг дүвчин гуайд бараа болж яваад Да хүрээ орж үзээд ир гэлээ. “Чамайг энэ хавьдаа бянтай, томоотой болохоор чинь хошуу засаг найдаж энэ чухал хэргийг зарлиг болгож байгаа юм” гэж ноён хэллээ.

Миний унаа хөсөг, хоол ундыг хошууны сангаас гаргах гэнэ. Да хүрээ үзнэ гэдэг ямар их аз вэ! гэж Базар баяр хөөр болов ярив.

Агь ноён алсын санаатай туслагч Сэр-одын амаар дуугарч байгааг Базар үл мэднэ. Туслагч, агь ноёныхоо гэнэн балчирхныг далимдуулж уг хэргээ хошууны нэрээр хийж байгаагаар итгүүлж чадсан билээ. Тусархуу цайлган сэтгэлт залуу эр Базар туслагчийн олон нүүдлийн цаанаас бодож олсон давхар маданд ийнхүү оржээ.

- Хоёулаа явдаг ч болоосой! Да хүрээ гэдэг их хол болов уу?

- Хоёр сар илүү болоод ирнэ... гэснээ Базар өврөө уудалж боодолтой юм гарган

- Ноёнтон надад хэдэн янчаан, чихэр боов өгсөн шүү гээд Юмжирдуламд үзүүлж атга дүүрэн чихэр өглөө.

- Ямар их удах юм бэ? Чамайг иртэл уйдаx байх даа гээд бүсгүй санаа алдаж ганц чихэр амандаа хийв.

- Да хүрээнд хүний хар нүднээс бусад цөм бий гэнэ. Чи надад юу захих вэ? гээд Базар өнөөдөр явчих гэж байгаа юм шиг яаран тэмүүлж мориндоо ташуур өгөхийг завдана. Санаанд оромгүй сонин юм сонсож сэтгэл хөөрсөн залуу хүн ийнхүү тогтож ядсан догдлонгуй

сэтгэлтэй байдаг билээ. Алс хол зорих болсон тухай сонин сайхан үг сонсгосон хэрнээ өөртэй нь тухтайхан ярилцах ч үгүй яаран дэгдэлзэж байгаад нь бүсгүй гоморхож,

- Надтай жаахан байж болохгүй бол явж л байхгүй юу гэж тунирхан хонь руугаа алхав. Базар түүнтэй зэрэгцэн очиж мориноос буув. Бүсгүйн нүд доголлон íóëèìñòàé байхыг залуу ажиглаад,

- Юунд айлгаа вэ? Би ямар өнөөдөр явчих гэж байгаа биш гээд хурууныхаа өндгөөр нулимсыг нь арчлаа.

- Чи л өөрөө надтай ганц хоёр үг солихын оронд юу захиx вэ, юу захиx вэ гэж шалж мэгдээд байх юм.

- Чамдаа дуртай юмыг чинь олж ирэх л гэж тэр шүү дээ.

- Юугаа захиx вэ дээ.

- Юу ч байсан хэлээч!

- Явахад чинь болох уу даа.

- Одоо хэл л дээ.

- Чи янзын хүн шүү гээд бүсгүй Базарын нүүр өөд харан инээвхийлж

- Чи надад хоёр гоё улаан хув олж ирээрэй! Гэзгэндээ даруулга хийлгэе гээд бүдүүн хар гэзгээ шувтрахад нь “Яасан хөгтэй юм захина вэ” гэж чамласан Базар

- Ердөө л энэ үү? гэв.

- За яах вэ тэгвэл Да хүрээний мөсөн чихэр авчраарай! Ямар амттайгий нь үзье.

- Тэгнэ ээ. Одоо ээж аавдаа хурдхан дуулгая гээд залуу, бүсгүйн хацрыг энхрийлэн илчихээд мориндоо үсрэн мордож гэрийн зүг хийсгэн одов.

Хүүгээ өтгийн бэл хүртэл өгсүүд өөд цогиулсаар ирэхийг үхрийн хэвтэр цэвэрлэж байсан эх нь хараад

- Чи чинь галзуураа юу? Хариг хатуу цагт наад унаа чинь яаж тэсэх вэ гэж загнав.

- Ээжээ! Би Да хүрээ орох болсон...

- Ухай, чи тэгүүд л эхээрээ тохуу хийгээд байгаарай!

- Нээрээ шүү, ээжээ гээд хүү нь учрыг ярихад эх нь баярлахдаа хөлдүүс хамж байсан савраа хаячихаад тэврэн үнсэв.

- Яасан буянтай үр вэ, чи минь. Бурхан багшдаа залбирч яахаар ийм л байдаг юм. Да хүрээ чинь бурхны орон. Дүвчин багштай явсны хэрэг юу билээ, Богд гэгээний мутрын адис хүртэхийг бодоорой! Тун болохгүй бол сунтагийнх нь ч яах вэ. Амьд бурхнаас адис авсан хүн нэг насаар ажрахгүй. Дүвчин ламтнаар оройн дээд Очирдарийн хувилгаан Богд Жавзандамба гэгээний тариедсан утлага заавал авахуулаарай!! Ээж чинь тэр бурхан хүний мутар хүрсэн утлагыг үнэрлээд үхвэл амьд явсны хэрэг бүтнэ. Жар дөхсөн намайг Да хүрээ орж чадаагүй байхад хүү минь явж байдаг аль төрөлдөө хийсэн буяны ач бол! гэж эх нь дээр дээрээс нь давхцуулан яриад энэ баярт мэдээг өвгөндөө дуулгахаар ихэд яарч хүүгийнхээ гараас хөтлөн майжигнан алхав. Эмгэн дөнгөж үүд сөймөгц л

- Өвгөөн! “Урьд ургасан чихнээс хойно ургасан эвэр урт” гэдэг үнэн юм гээч хэмээн өгүүлсээр гэртээ орлоо.

Туслагч Сэр-Одын хар санааны тухай ямар ч ажиг сэжиг аваагүй дархан Сүх хүүгээ багаасаа газар үзэж нүд тайлах болсонд баярлаж өвлийн дунд сарын хуучаар алс замд мордуулжээ.

Есдүгээр бүлэг

Сэжиг таавар

Төрийн нэр барьж зоргоор загнаваас

Түмэн олонд зовлон хураамой

Зүйл зүйлийн амтат зууш, нарийн хíол, архи дарсны үнэр гэр дүүрэн ханхийнэ. Дархан Сүхийн өмнөх зандан ширээн дээр тавагтай, дийзтэй идээ будааг зай завсаргүй өрж, хэдэн янзын сархдыг задлан тавьжээ. Хошууны тэргүүн туслагч Сэр-Од өөрөө өвгөний өөдөөс эгц харан суусан нь нэн их хүндэтгэж, эн сацуугийн маяг үзүүлсэн шинжтэй. Туслагч сархад хундагалан өвгөнā барьж,

- Та тавтай сууж зооглогтун! Би нэрэлхсэн хүнд гомдчихдог юм шүү гэж найр тавин инээмсэглэж архины хоронд бэрсүүжиж улайсан нүүрээ хааяа илж малилзана.

- Гялайлаа, туслагчтан! гээд Сүх хундагатай архинд уруул хүргээд тавилаа.

Ноёд түшмэд мөнгөн эдлэл хийлгэх гэж дархан Сүхийг дуудуулж байснаас биш ийнхүү суудал зэрэгцэн хүндёун дайлж байсан нь үгүй. Тийм болохоор дархан Сүх хошууны тэргүүн туслагчийнд эрхэмсэг гийчин болсондоо хөөрч сүйд болсонгүй. Тэргүүн туслагч түүний нэр цууд гарч ид гялалзаж явах үед нь тоогоогүй атал үеэ өнгөрөөсөн хойно нь мартсанаа санасан мэт сүйд майд болон залсан нь хал үзэж хашир таньсан өвгөнд тийм ч таатай санагдсангүй. Өвгөн дархан зуушнаас хааяа нэг савхдаж, хатуу хар дарснаас ганц хоёр шимж, туслагчийн амнаас ямар үг гарахыг хүлээсэн янзтай яриа хөөрөө ч үгүй дүмбийж сууна. Туслагч Сэр-Од, настай хүн, хүүхэд хоёр баярлаж хөөрөх нь хялбархан байдгийг санаж ноёдын өргөөний ёс төгөлдөр биежүү дайллагаар өвгөний сэтгэлийг засан гэнэт хөл алдуулах гэж бодсон юмсанжээ.

Үзүүр төгсгөл нь үл мэдэгдэх далд битүү хэрэг үүсгэн эцсийн эцэст энгийн ардыг гэнэгүй байтал нь зангад унагадаг засаа ноёдын занг мэдэх өвгөн Сүх хүүгий нь алс газар явуулсныхаа дараа өөрийā нь ийнхүү залсанд хар санаж үгээ цэнэн хянуур болгоомжтой байгаагийн учир энэ ажээ.

- Тань шиг уран хүн манай хошуунд байхгүй. Тэр жил танаар хийлгэж билээ энэ хундагыг. Үүн шиг сайхан хийцтэй хундага надад огт дайралдаагүй шүү. Би ч бас хэрдээ олон газар явсан хүн... гэж туслагч урьдах мөнгөн хундагаа авч эргүүлэн тойруулан үзэв. Хундаганы амсрыг нимгэн хурц ирмэг гарган цэвэрхэн эргүүлж доод хэсгийг нарийн угалзаар цоолборлон чимж, хос хажлагатай сийлмэл хээтэй цомбогор ёроол хийжээ. Ёроолд нь тааруулсан жижигхэн шилээр шагайхад олон гоёмсог цагаан суварга сүмбэрлэн харагдах аж. Түүнийг өрөөсөн нүдээ анин харж байсан туслагч

- Юмыг урлана урлана гэхэд ингэж урладаг ямар гойд ухаан бэ! Дархан хүн бурхан ухаантай гэдэг л энэ байх. Энэ суваргыг яаж хийв ээ! гээд дуу алдан тагнай ташин шагширч байв. Тэгэхэд Сүх “Түшмэл хүн зулгуйч гэдэг үнэн юм даа. Энэ зэргийн аяга хийх дархан халхад

хаа мундах вэ. Бид хоёр хэзээ тэгтэл сүйд болж байлаа даа. Гэнэт ингэх гэдэг өөдтэй юмны зөй яагаад ч биш. Яах л гээд байгаа бол? гэж бодно. Сэр-Одын зулгуйдахыг харах тусам өвгөний сэтгэлийн гүн дэх битүү сэжиг улам лавширч нууц санаагий нь мэдэхсэн гэж яарна.

- Бид танаар мөн ч их мөнгө хийлгэсэн шүү. Тэгсэн хэрнээ таныг хүндлэн цайлж байсан удаа үгүй шахам. Би өнөөдөр хошууныхаа толгой дархантай ганц удаа ч аугай наргия гэж бодсон юм. Танд зориулж зэхсэн энэ идээг бага гэлгүй зоогло л доо гээд туслагч хундагатайгаа хөнтөрч өвгөнийг ид, уу гэж шахсаар байв. Сэр-Од хиа заран дууч, хуурчдаа авчирч өвгөнд ая бариулав. Ардын дууны аялгуу сайхан эгшгэнд Сүх өвгөний сэтгэл уярч зүрх нь баяр хөөрөөр булгилавч биеэ барин дүнсийн сууна.

Хошууны ихэс дээдсийн наргиан цэнгээн дээр юм уу, эсвэл харь хошуунаас ирсэн ноёд түшмэдийг хүндлэхдээ ая дуу барьдаг байтал тэргүүн туслагч харц ардтайгаа язгууртны зиндаанд наргиж суух нь Сүхийн хувьд бодох нь бүү хэл, зүүдэнд ч оромгүй хачин санагджээ. Дархан Сүх үг дуу ч үгүй дүмбийж, архинд ам хүргэхээ болиод, зуушнаас хааяа нэгхэн чимхэлж тамшаална. Өвгөн хэнэггүй царайлан өөрийнх нь дайллагыг үл ойшоосон янзтай хөндий зөнгөр байгаа нь туслагчийн сэтгэлд эс нийцэв. “Өөх өгөвч ө°риймсдөггүй, маб өгөвч манайхшдаггүй чи тийм сүрхий хүн гээ! Чамд дээдсийн хишиг хүртэб хүсэл алга бол таарч тохирох юмыг чинь хүртээнэ дээ” гэж зэвүүрхсэн туслагч,

- Дэмий гонгинолдохоос өөр юу ч чадахгүй хоолны савнууд! Нүднээс далд ор! гэж ширүүн зандарч дууч, хуурчдаа хөөн явуулж Сүхэд уурласан уураа тэдэнд гаргажээ. Туслагч өөрийг нь залж авчирсан тухай учраа шууд хэлэхгүй сүрхий цэнэж үгний эгзэг хүлээн хойш тавиад байгааг Сүх мэдээд, сайны үр дагуулмааргүй санагдаад байгаа тэр үгийг сонсолгүй явсан нь өлзийтэй хэмээн бодоод сэтгэлд нь тохирох аятайхан үг хэлээд салахыг хичээв.

- Эрхэм дээдэс минь! Таны хишгийг хүртсэндээ насан өндөр болсон өвгөн би хязгааргүй гялайлаа гээд бослоо. Туслагчийн царай хувьсхийж “Хөгшин чөтгөр гэдэг чи ёстой мөн дөө. Хар санаархаад байгаагий нь. Ширүүлснээс уран аргаар гартаа хийвэл түвэггүйсэн” гэж бодоод

- Дархан минь, та настай тохитой хүн байж суугаач дээ! Миний чадах ядахаараа зассан идээг чамлалгүй зооглох нь яагаа вэ гэв. Өөрийнх нь санаснаар байгаагүйд уурласан туслагчийн дууны егөөтэй хүйтэн өнгийг олж таньсан дархан Сүх

- Өвгөн болсон надад хүнддэхгүй бол таны хишигнээс ихийг хүртлээ гээд гараа элгэндээ аван мэхийхэд туслагчийн уур хүрэвч санасан хүсэл ихийн эрхэнд боогдож

- Тийм бол яая гэх вэ хэмээн аргагүйн эрхэнд дуугараад “Одооноос үнэрч нохой шиг шиншлээд байгаа энэ гайхалд үнэн үгний үнэрийа нь ч авахуулж болохгүй нь. Хар санаад байгаагий нь яана” гэж бодлоо.

- Пагма аа! Дарханд бэлэг сэлт бэлдээрэй! гэж Сэр-Од шивэгчиндээ хэлээд Сүхийг ширээний ард суухыг гар дэлгэн урив. Өвгөн дархан хэт яарч босон харайж өөрийгээ туслагчийн аманд хэмлүүлснээ ухаарч “Хөгшин толгой яахыа нь хүлээгээд дуугүй сууж л байхгүй. Миний энэ түргэн зан уу” гэж санасаар суудлаа эзлэв.

- Хошуундаа ийм уран дархантайгийн хэрэг юу билээ, би танаар эр хүний сайхан мөнгөн эдлэл хийлгэхсэн гэж бодсон юм. Да хүрээ орохдоо ч манай хошууны дархны хийсэн юмыг үзэцгээ, та нарт ийм уран хүн байна уу? гэж бардаж гайхуулах гэсэн юм. Хошуугаа л нэрд гаргах гэсэн давхар ухаан зарсныг минь яана! Ноёд түшмэд чинь нэг газар цуглрᠠхаараа хошуу нутгийнхаа өнгөтэй өөдтэй, сайн сайхан юмнаас эхлээд өмссөн зүүснээрээ их бардалцдаг юм. Тэр баяд ноёдын дунд олиг муутайхан байвал өөрийнхээ нүүрийг шарж хошууныхаа нэрийг түймэрдэж орхидог юм даа гээд Сэр-Од ямар ч хар санаа агуулаагүй хүн болох гэж амаа ангайн наг наг инээв. “Тийм бол ч өөр хэрэг. Ээ дээ, юу л бол доо. Эд нар надаар юм хийлгэхдээ хэзээ ингэж хүндэлж мэндэлж сүйд болдог байлаа даа. Гэнэт ийм дайллага болдог ч жирийн хэрэг лав биш. Яалаа ч гэсэн эвлэрэнгүй янзтай байж санаагий нь гүйцэд мэдье” гэж санасан Сүх нэг хундага сархад тогтоогоод тухлуу гэгч нь сууж, тамхи татдаггүй боловч янжуур асааж

- Хошууныхаа эрхэм дээдэс та бүхний хүслийг ёсоор болгоход өчүүхэн боол би энэ зовлогоо юунд хайрлах билээ. Гагцхүү нас өндөр болжээ. Чадал тэнхээ хүрдэг юм бол таны нүүрийг бодож сайхан эдлэл хийхийг хичээлгүй яах вэ гэж уриалган хэллээ.

- Би өөртөө мөнгөн хазаар, эмээлийн хэрэглэл, хэт хутга хийлгэе... Ноёны хувьд өөр. Манай ноён одоо арван тавтай. Гурван жилийн дараа хатан таалах болно. Тэгэхээр ноёны сүй тавьсан хатагтайд бүрэн гоёл нэгийг хийлгэмээр байна. Эртнээс бодолтой байхгүй бол цагаа тулахаар сайн дархан байтугай муу нь ч олодохгүй тэвдэнэ. Ноён, хатан хоёрын насан туршдаа бахдаж явах сайхан гоёл хийж өгөөрэй! гэж Сэр-Од ярьсанд өвгөний сэтгэлд дахин хар буулаа. Сайхан санаатай гүдэс өвгөний итгэл алдрав. Өргөөний ямар ч нууц “Хүнд битгий хэлээрэй” гэсэн нэгэн хэвийн оршилтойгоор хамгийн дотно хүмүүсийн ам дамжин сунасаар илэрхий болдог тэр л жамаар тэргүүн туслагчийн хатан таалах гэсэн яриа Базарыг Да хүрээ рүү явсны дараахнаас бусдын чихийг дэлссэн ажээ.

“Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий” гэгчээр агь ноёны хүүхдээрээ байхад авах хатанд нь гоёл төхөөрнө гэдэг тун жигтэй юм. Намсрайн охиныг гуйлаа гэж сураг сонсогдсон. Тэр ортой дог шүү. Энэ түшмэл надаар хэнд юу хийлгэх гээд байгаа бол” гэж бодохоос өвгөн дархны сэтгэл чилээрхэж таг дуугүй нилээд суулаа. Туслагч хатан таалах бүртээ Сүх дархныг дуудуулан хамаг гоёл чимгээ хийлгэж, залхаадгаар үл барам түүнээс болж муудалцаж байсан удаа ч бий болохоор өвгөний сэжиг таавар улам лавшрав. Тиймээс ч туслагчийн гараас мултрах арга сүвэгчлэх нь түүнд илүүтэй чухал санагджээ.

- Таны хийлгэх мөнгө дэндүү их байна. Иймэрхүү гоёлыг нэг хүний гараар хийлгэвэл эв зохицол нь тун сайхан болдог юм. Би яагаад ч барахгүй. Та ондоо хүнээр хийлгээрэй! Нас дээр гарчихаар чинь ухаан мулгуу болохоор барахгүй нүд муудаж, хуруу моонийчихоод нарийн юм хийе гэхэд салгалж чичрээд эвлэхгүй болж шүү гэж Сүхийг хэлэхэд Сэр-Од

- Та өөрийн уран авьяасыг ингэж дараад юугаа хийнэ вэ, хүн мэдэхгүй биш. Бид таныхаа тэнхэл ямар байгааг ч мэдэлгүй яах вэ. Ноднин жил баян Балживын авгайд хийсэн толгойн чимгийг үзсэн. Нүд хужирлам сайхан эд байдаг шүү. Баян хүн сайн ч хөлс өгсөн байлгүй. Түүгээр бодоход ганц жилд таны нүд муудлаа гээд юу базаах вэ. Хэвээрээ байгаа биз. Ноёны хатан болох хүнд тэр дайны хийхэд болно. Харин хөлсний тухайд таныг гомдоохгүй. Хошуу захирсан ноён, туслагч хоёр юу боллоо гэж гар татах билээ гэж өвгөний амыг яах ч аргагүй

болтол таглаад, авдраа уудлан хэдэн гулууз мөнгө гаргаж дархны өмнө чулуудав. Сүх баахан мухардаж, зайлах шалтаг олохгүй байгаагаа мэдсэн хэдий ч

- Эр чадалтай, ид залуу явсан бол ноён та хоёртоо хийж өгөлгүй яах вэ. Талийгаач өвгөн ноён та хоёр чамлахааргүй мөнгө хийлгэсэн дээ. Одоо би санаанаас цаашгүй болжээ. Сайн сайн залуу дархчууд олон байна. Тэд нараар хийлгэ! Хөгшин намайг зовоогоод нэмэр алга гэж аргацаахыг оролдов. Туслагч “Хөгшин толгой чи ингэсхийгээд намайг хуурчихна гэж бодоо бий. Амархан салахгүй байх аа. Түшмэл хүн санасандаа заавал хүрдгийг үзүүлье ээ, чамд” гэж бодоод

- Та харьяат ноёндoo гарынхаа урыг гаргахаас юундаа тэгтэл цааргалаа вэ. Хошуу засгаа сурсан эрдмээрээ боож байгаа чинь ноёны сонирт хүрвэл муу юм болох байх шүү. Настай хүн та юу эс андах аж. Манай ноёныг хүүхэд гэж санаж болохооргүй сүрхий хэцүү санаатайг яана! Тэгэхээр хойтох урдахаа бодож, эв түнжин санаж ноёны таалалд нийлүүлбэл өөрт чинь дээр биш үү! гэхэд нь Сүх “Ноёны нэр барьж сүр далайлгаж байгаагий нь хараач хөөе. Элбэг зочлолт, сайхан ааш хоёрынх нь зэс одоо л цухуйж байна. Энэ түшмэлийн хүслийг хязгаарлах эрхтэн дархтан манай хошуунд байх биш. Дээрээ даруулгагүй. “Дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэж” сурсан түшмэл дээ. Ноёны нэр зүүсэн тэр муу хүүхэд, сэтэртэй хонь хоёрт ялгаа бий гэж үү. Би гэдэг хүн одоо яадаг билээ. Хөгшин намайг яая гэвэл Сэр-Одын дур юм чинь” хэмээн зүрхшин эмээхийн сацуу нэгэнт арга мухардсан учир

- Дархан мундсан биш, та очиж очиж зөнөсөн намайг шалж зовоогоод юу хийнэ. Тулгаж байгаад хийлгэлээ ч тэнхэл алдарсан хөгшин хүн хамаг мөнгөөр чинь тоглож орхиод авья авч болохгүй, хаяу хаяж болохгүй юм болно. Дээдсийнхээ буянг дэмий үрэн хилэнц хураахаа больё! гэж эрс хэлэв.

- Мөнгөөр нааддаг хүн нь та биш гэдгийг би мэднэ. Хошуу ноён найрсаг ялдам угтахаар та хэдэрлэж гэдийвэл хилэгнэж юу магад. Хэл үггүй хийчихвэл хэн хэнд маань хожим хойно зовлонгүй өнгөрөхсөн. Хаврын эхэн сардаа багтаагаад хийчихээрэй! гэж Сэр-Од захирангуй хэлэхэд нэртэйгээр нь зарлиг буулгаад хийлгэчих чинь яагаа вэ гэж санахаас Сүхийн эгдүү хүрч “Олон хүнийг өвдөй дороо сөгтгөж сурчихаад намайг бас гарынхаа дор боол мэт байлгах гээ юу чи?! Өтөлсөн хойноо чиний өмнө бөхөлзөж нахилзаж явдаг ч зовлон байгаа даа” гэж бодмогц дархны уур хүрээд явчихав. Зүгээр зогсож байгаа морийг хэдгэнэ хатгаад авахад цовхчидог шиг өвгөн Сүхийн зоримог зан гэнэт хөдөлж “Чам шиг түшмэл над шиг хөгшин хүнээр оролдоод юу олж долоох юм бэ” гэж бодоод

- Эрхэм туслагч та намайг тэрэгний илжиг шиг зүтгүүлэх гээгүй биз. Гурван жилийн цаана гэрлэдийн төлөө өдөр сар болзох хэрэггүй байх аа. Хэзээ ч хийсэн яадаг юм бэ гэж хэгжүүн үг хэллээ.

Нэгээхэн ч харц ард өөрийнх нь өөдөөс ийм аймшиггүйгээр сөргөн мэтгэлцэж байхыг үзээгүй Сэр-Од туслахын уур нь хүрч чинэрч хүрлийсэн хацар нь уурандаа татвалзаж байлаа. “Чамайг нэхий шиг үеяүэ зөөлрүүлж байгаад хийлгэхсэн. Элдүүрийн ариг даах болоод миний урдаас бураасай. Чамаар юмаа сайхан хийлгэх гэсэндээ би зөөлөн байгааг энэ тэнэг боол ухаарах нь яана вэ? Банз, шаахайн амт үзэх гэж чиний таван махбод чинь харшаад байна даа. Хүссэн юм хүзүүгээр гэгч болчих бий дээ. Гэхдээ энэ удаад тэсээд өнгөрье. Оройтохгүй

гэж туслагч араандаа зууж

- Таны саяны хорон үг чинь өөрийгээ зовоохоос намайг зовоохгүй. Хошуу засаг танд тун өршөөлтэй байгааг санаж явахад илүүдэхгүй. Энэ мөнгөө аваачиж миний хэлсэн ёсоор хийнэ биз. Өөр яриа алга даа, уран гарт өвгөн минь! гэж егөөдөв. Сэр-Одын догшин харц, уурандаа таталдаж байгаа хацар, дууных нь зэвүүн хахир өнгийг олж ажсан өвгөн дархан хичнээн шөргөөцөлдөөд нэмэргүй, харин ч дэндвэл түүний аманд унаж өгөхөө мэдээд, “Яйар гартайгаа чамаар хэлүүлэхдээ хүрээгүй. Миний гараас юу авахаа чи үзнэ бий” гэж сэтгэлийн гүндээ занаад, хэдэн гулууз мөнгийг нь авч ган дуугүй үүд саван гарчээ.

Дархан Сүх тэрхүү дайллаганы тухай эмгэндээ юу ч ярьсангүй, мөнгийг нь авдрын ёроол руу хаячихаад таг чиг болов. Харин өөрөө туслагчийн нууцгай санаа юу болохыг мэдэж, хор шүүгийг нь тунгаах гэж ихэд бодох болжээ. Өвгөнийхээ ямагт бодлогошрон, толгой салаавчлан унь ширтэн үе үе санаа алдаж хэвтэх болсныг эмгэн нь мэдээд,

- Өвгөөн! Та нэг л янз болчихож. Бие чинь өвдөөгүй биз гэж асуухад,

- Зүгээр зүгээр гэж хайхрамжгүй дуугарахаас ондоо үг эс хэлнү.

- Та хүүгээ санаад байна уу? Ариун дагшин бурхны оронд явсан хүүгийн хойноос зовоод яах вэ. Богд гэгээний сахиус өршөөгөөд амар мэнд яваад ирнэ дээ гэж гайхаж хоцорсон эмгэн хэлдэг байлаа.

Айлынх нь Намсрайн ааш зан урьдынхаасаа нэг л ондоо, өөрсдийг нь үл тоомсорлох аястай болсныг Сүх ажиглав. Намсрай хэзээний орхисон бичиг номоо сая ухаан орсон мэт дахин сөхөж, шөнө дөл болтол дэн барин уншин сууж, аг ангайвал ноёд, түшмэд гэж ярих дуртай болсон байлаа. Гэтэл удалгүй Намсрайг залан болгох гэнэ гэсэн цуу бас таржээ. Эл бүхнийг сонсож мэдсэн өвгөн дархан эсэн бусыг эргэцүүлэн бодож сэтгэл тун ч шаналгаатай байхад эмгэн нь мааниа уншиж хүүгийн явсан зүг цайныхаа дээжийг өргөн санаа амар хүлээж байв.

Сэр-Од Намсрайг залан болгож охиныг нь хатан болгож таалах гэж буйгаас гарцаагүй мэт өвгөн Сүхэд санагджээ. Найсрай туслагчтай сүлбэлдэн Юмжирдуламаас хүүгийг нь холдуулахаар тийнхүү алс газар одуулсан байх гэж бодохоос хүүгээ гэнэ алдан явуулсандаа гашуудаж байлаа. Тэгээд дархан Сүх хүүгээ эргэж иртэл туслагчийн мөнгийг хийлгүй аргацаан хүлээх болжээ.

Тэрхүү айлчлалаас хойш сар хагас өнгөрөхөд Сэр-Од, тахар Пэрэнлэйг хоёр удаа зарж ирүүлсэнд дархан эхнийхэд нь “бие өвдөөд хариугүй байна” гээд, дараачийхад нь “Саянаас оролдож байна” гэж өөр хүнд хийж байгаа юм үзүүлэн хуурч буцаав. Тэргүүн туслагч Сүхийг юу ч хийхгүй байгааг Намсрайгаас лавлан мэдээд ихэд хилэгнэж нэгэн өдөр Пэрэнлэйг дахин ирүүлэв. Туслагчаа ямар бол тэр зангаар нь байж сурсан тахар өвгөнд ширүүн авирлаж,

- Сар шахам болоход гараас чинь гарсан юу байна, түүнээ өг! гэж зандарч

- Арай амжаагүй байна. Хэд хоноод ир гэж өвгөнийг хэлэхэд үл хайхран

- Хошуу засгаа хуурч мэхэлсний чинь шанг хүртээнэ гэж зодож жанчих шахам гуд гуд татан хувцас хунарыг нь өмсгөн тамгын газар руу хөөж аваачсан билээ.

Сэр-Од туслагч юмыа нь хийхгүй арга саам хэрэглэж байгаа дархан Сүхийг сүр хүчээр далайлган гартаа оруулахаар яг таг товолжээ. Өвгөн дархныг тамгын их өргөөнд орж ирэхэд эгнэн суусан хошууны хэдэн түшмэлийн гол дунд нь тэргүүн туслагч сууж үзэн ядсан ууртай догшин харцаар ширвэлээ. Хэдэн хиа өвгөнийг баруун хатавчинд нь нуга даран сөхрүүлж суулгаад хоёр гарыа нь ард нь хүлэхэд өвгөн мөчөөгөө өгөхгүй зэвүүрхэж,

- Дургүй чавганцад дарж байж сахил хүртээнэ гэгч болох нь шив дээ гээд зориуд инээв. Өвгөний хөх инээдийг харсан туслагч “Хоёр чонын хэн нь хэнийгээ химлэхээ үзүүлнэ дээ. Төр барьсан тэргүүн туслагчийг төрхгүй төрсөн муу боол яах вэ. Ямаа туйлаад янгиа эвдэхгүй гэгч болж дээ. Гуйсан толгой байтугай гуйгаагүй толгойг туушандаад өгдөг юм чинь! Махаа хорсохоор, хийхгүй гэхийг чинь харья! гэж зангаад

- Тэрслүү зөнөг чи ноёны зарлигийг дагадаггүй санаагаа хэл! гэж хахирган дуугаар хашгирав.

- Ноён надад зарлиг болгоогүй. Тийм бол зарлиг буулгасан ноёнттойгоо уулзана. Насанд дарагдсан хүнийг дээрэлхэж бай гэж ноён чинь айлдсан уу? гээд Сүх хөмхий зуун босож ирлээ.

- Сөхрүүл, наадахаа! Арав шаахайд! гэж Сэр-Одыг омогтой хэлэхэд Пэрэнлэй нэгэн тахрын хамт Сүхийг буцаан сөхрүүлж дахин босгохгүйн тулд тахиман дээр нь хөндлөн мод тавьж дарлаа. Пэрэнлэйг ширмэл шаахай авч өвгөн дархны хоёр хацар дээр тав тав буулгав.

- Та нар яахаараа гэмгүй номхон ардын зовлогыг зулгааж байна вэ? гэж Сүх хашгираад ухасхийн зүтгэж байлаа.

- Түрүүчийнх нь багадаж! Дахиад арав! Задарсан амыа нь хамхитал цохь! гэж туслагчийг өндөлзөн зандрахад Сүх дархны хоёр хацарт шаахай тас нясхийн буусаар байлаа.

- Ноёны зарлигийг нугаладаа болих уу, чи? Хэлэхгүй, хийхгүй бол хумсных нь завсраар хулс шаа! гэж туслагч бахираад шовх үзүүртэй арваад хулс ширүүн дээр цацав. Пэрэнлэй хүнийг алчехаасаа ч буцахгүй эр учир хулсыг хамж аваад дархны хумсны завсраар шаах гэтэл уурандаа багтрах шааж байсан туслагч тэрхэн зуур “Амиа үрэхээс буцахгүй тэнэг боолыг хараач! Хулс шаалгах нь гээч! Тэгвэл юмаа хийлгэх аргагүй болно” гэж бодож амжаад

- Боль! гэж Пэрэнлэйг хориглов. Өвгөн дархан ч туслагчийн санааг гадарлаж

- Та нар энэ хулснүүдээ миний хумсанд шаа л даа. Тэгээд би гэртээ санаа амар хэвтэж байя гэсэнд Сэр-Од

- Чиний амаар болдог юм уу! Хийе гэтэл нь цохиод бай! Хэзээ “За” гэсэн цагт нь л боль! гэж байж ядан хашгирч байв. Дархан Сүх хөмхий зууж туслагчийн өөдөөс нүд цавчилгүй, хорсолтойгоор ширтэнэ. Шаахайдахын тоолонгоор толгой нь хоёр тийшээ гилжис гилжис хийн ганхана.

Аравдугаар бүлэг

Алтан бурханы хэрэг

Авилгач санаатны башир заль

Алт мөнгөтэй цусан төрөл

Энэ жил хаврын урь гойд эрт орлоо. Цагаан сар гармагц л Да хүрээний гудамж, хол ойр сүлжсэн сүйх тэрэгний зам, явган хүний муруй сарий зөргийн цас хайлан нүлайж, амьтны хөлөөр олон жил тээрэмдүүлсэн үхмэл хар шороотой хутгалдан газар сайгүй шавар шавхай болжээ. Шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт эзэн хаан түмэн наст, наран гэрэлт богд Жавзандамба хутагтын өвлийн ордны дэргэд үй түмэн хүн өглөөнөөс эхлэн шавааралдан үймж нааш цааш түлхэлцэн өмнүүрээ ээрэн зогсож байгаа лам нарыг ягуухан түрж, ордны хана руу лам ойртон шахцалдах авч нэгээхэн ч удаа бие биеэ дээрэлхэн загнахгүй, ганц ч хүний амнаас хараал зүхлийн үг цухуйхгүй байгаа нь цөм л амьд бурхан хэмээгч Богд ламтны сунтгийн адис хүртэх гэж сэтгэл догдлон бурхан лам хоёроос өөр юу ч бодохгүй гүн бишрэлтэй, нэн тэвчээртэй хүлээж буйнх ажээ. Тэдний дунд ноорхой дээлтэй, шавхайд будагдсан маажгий гуталтай, өвчин эмгэгт шаналсан өрөвдөлт ядуус, торгон дээлтэй, булган малгайтай баян тарган тайж түшмэл, элдвийн хүмүүс байх нь Богд гэгээнтний сунтгийн адис гэгч олж хүртэхэд амаргүйнх бололтой. Ордноос зайдуу хөллөгөө тэрэг, унаширч гэдсээ татсан тэмээ, морьд бөөн бөөнөөр үзэгдэх нь газрын холоос цагийн хайрууд зүтгэн явж ирээд бас л Богдын адис тавихыг хонон өнжин хүлээж байгаа мөргөлчдөйн уналга хөсөг байлаа.

Үд хэвийх үед Богдын ордны тагтнаас нэгэн лам аргамж мэт урт оосор хөвүүлсээр гарч ирэхэд хүмүүс

- Богдын минь сунтаг залраад ирлээ гэж шивэр авир хийж, амандаа ямар нэгэн юм хэдгэнэ мэт дүнгэнэтэл уншицгаан нэг нэгээсээ урьтаж сунтгийн адис хүртэх гэж урагш чихэлдэн тэмүүлцгээнэ. Тэр олны дунд Базар зогсож байлаа. Түүнд “Ум ма ни бааь ми хуй” гэдэг маанийн зургаан үсгээс өөр энэ насандаа тогтоосон ганц шад мэгзэм ч үгүй, бусдын адил хөл алдам сүжгийн сэтгэлээр хомс болохоор ийш тийш харан алмайрна.

Базар Агваанлуvsанг дагаж өвлийн адаг сарын хорин есний нүргээн ихтэй хурлын өдөр Да хүрээнд орж ирсэн билээ. Цагаан сараар залуу эр дүвчингийн хамт түүний танил лам нарынхаар хэсэхдээ үрээнийхнийг тун ч хөлтэй шинэлдэг юм байна гэж боджээ. Тэгэвч хүрээний хаяа сахисан борчуудын гэрт цагаан сар ямархуу тарчиг ядмаг өнгөрснийг үл мэднэ. Агваанлуvsанг дагаж Богд хааныг үзнэ гэж их л баяртай байтал “Жил сар гараад бараалхах ихэс дээдэс олон учир Богд эзэн бидний мэтийн хүнд мутрûн адис хүртээх завгүй гэнэ. Бид хошуу ноёны нэрийг барьж арай гэж бараалхлаа. Чамайг хамт авч орох гэж гуйж ядав. Харин маргааш Богд хаан сунтгийнхаа адис хүртээнэ” гэж дүвчин лам залуу хүүг хуураад явуулчихжээ. Гэвч Базарын сониуч хүсэл мөхсөнгүй, амьд бурхан ямар байдгийг холоос ч атугай харья гэж бодов. Нөгөө лам чирч ирсэн оосрынхоо үзүүрийн хадганд боодолтой бондгор юмаар сүсэгтэн олны толгой дээр түншин адис өгч эхлэв.

- Одоо Богд хаан удахгүй заларч ирэх болов уу? гэж Базар нэгэн өвгөнөөс асуухад

- Богд ламтан сунтгийн адис хайрлахдаа гарч ирдэггүй юм гэхэд нь залуугийн урам хугарч

- Өө тийм үү... Энэ аргамжны чинь нөгөө үзүүр нь ордон дотор уяатай байдаг юм уу? гэвэл

- Яалаа гэж. Энэ сунтагны чинь нэг үзүүрийг Богд ламтан бариад сууж байгаа юм. Богд эзний гараар л дамжиж байгаа болохоор мутар, сунтгийн адис адилхан. Тэр ч байтугай чамайг гэртээ сууж байхад чинь Богд ламтан дотроо чамайг гэж бодоод гараа ганц дохичихсон ч ялгаагүй чамд өршөөл хишгээ хайрлаж байгаа нь тэр гэж өвгөн өгүүлэв. “Үнэн л байгаа даа. Энэ шороон дээр түмэн амьтныг адьсалж дуустал Богд хаан сунтгийнхаа үзүүрийг бариад сууж байх гэж үү. Юу л бол доо” гэж Базарыг бодон зогсоход сүсэгтнүүд адис хүртэх гэж өрсөлдөн түлхэлцэх нь бүр ч их болсонд тэгж байх нь түвэгтэй санагдаад орхин одлоо.

Түүнийг хүрээний зах зээл дээр очиход ойн хүрэн шоргоолжны үүр шиг амьтан хүн бужигнаж байлаа. Малгайчин, гуталчин, боовчин, дулдуйчин, их хөлийн панзчин хөлхөлдөн өөр өөрийн юмсаа тэнгэрт тултал магтан сайрхаж үнэ хаялцан шуугилдана. Буйд зэлүүд хөдөө нутгийн залууд монгол иргэн, түвд, орос есөн хэлийн хүний өмссөн зүүсэн хэлэлцэх үгс, хөдлөх аяглах нь тус тус өмнөө, хараад баймаар сонин санагджээ. Гэтэл зах дээр хөлхөх хүн бүрийн өмнө хоёр гараа сарвайн алга тосон бөхөлзөх гуйлгачин ядуус туйлын өрөвдөлтэй, харахаас нүд дэльдрам аж. Тарган сайхан морь унасан ганган эрс, бүсгүйчүүд, сүйх тэрэгтэй ихэмсэг яравгар ямбаган дээдэс тэр зовлонт хүмүүсийн гар дээр ганц зоос хаяхын оронд ер хүн байна гэж санасан янзгүй дайрчих шахан өнгөрч зарим нь, ташуур далайн замаасаа зайлуулахыг Базар үзээд “Харваас ийм баян цатгалан атал яасан хүний нүнжиггүй улс вэ! Зодолгүй өнгөрснөө буян болно гэж хэлэх нь холгүй байх шив. Хүн яахаараа ийи мөсгүй болно вэ” гэж хэрдхийн гайхлаа. Тийн явтал хүрэн тэрмэн дээлтэй булган малгай духдуулсан нэгэн дэгжин хархүүг бор морины нуруун дээр хөндлөн суучихсан, амандаа дуу аялан олны дундуур зүсэн орж ирэхэд хүмүүс булт булт үсрэн зам тавьж байхдаа зарим нь,

- Богдын сойвонгийн дүү гэлцэх нь хүрээнд их л зартай хүн бололтой. Уранхай хөдсөн дээлтэй бөгтгөр эмгэн гар тоссоор түүний өөдөөс шууд очиход морь нь үргэж булга тусав.

- Замаас зайлахад яадаг гуйлгачин бэ! гээд хархүү тэнзэн ташуураа мөрөн дундуур нь буулгасанд эмгэн,

- Ёо ёо ёо! Юм хайрлахын оронд ташуур хайрладаг байна шүү. Сохор амьтныг зодож байдаг яасан өлөн гэдэс нь ороолдмор вэ! гэж муухай хараасанд хар хүүгийн царай барсхийж,

- Чам муу гуйлгачинг зодох нь байтугай алчихсан ч миний дур! Чи надаас юу олж долоох вэ! гэж агсран ташуураа далайхад нь Базар ухагхийн шүүрч аваад дугтарсанд хархүү мориноосоо уначихав.

- Чи дөнгөө ядсан хөгшнийг зодож байдаг ичих нүүрэндээ элэг наасан новш вэ. Ийм эхээс гараагүй юу, чи! гэж Базарыг хэлбэл хархүү

- Хүрээний хогийн чавганцыг өмөөрдөг яасан сүрхий гуйлгачин гарч ирээ вэ?! гээд заамдан авахад нь түлхэж орхисонд гэдрэг харан ойчиж тэрмэн дээл нь түйий хөлийн шавхай болов.

- Ганц боллоо! Хүн бүрт дээрэлхэж явдаг юм.
- Энэ тулдаа Богдын сойвонгийн дүү болоогүй
- Аагий нь дараад өгдөг овоо аавын хүү юм даа.
- Энүүнд хавьтах хүн олдоогүй болохоор сагаад байгаа юм.
- Тэлээ ишигний бяргүй нохой шив! гэж хүмүүс шуугилдлаа. Хархүү босоод дээлийнхээ шороог ч гүвсэнгүй шалавхан тордож,
- Гайгүй ээ! Чам муу гуйлгачинг болгоод өгөх цаа бий” гэж загнаад эргэн эргэн харж явахад нь
- Өнөөх омог шар чинь яалаа!
- Айж байх шив. Сүүлээ хавчаад зугтаж байна гэж захынхны зарим нь хашгиралдав. Гэрээсээ алс газар явж үзээгүйн учир ганц сар гаруй болоход эх эцгээ санаж байсан Базарт тэр сохор эмгэн эхтэй нь адилхан санагдсанд дамнуурга үүрсэн иргэнээс хэдэн боов авч өглөө. Нөгөө хархүүг адгийн муу үгээр харааж байсан эмгэн
- Зуу насалж, зургаадай таяг тулж, өглөг буян чинь өндөр уул шиг арвин, өгөөмөр сайхан сэтгэл чинь өргөн түмнээ баярлуулж яваарай, хүү минь! гэж Базарыг ерөөгөөд явлаа.

Базар олон хүн бөөгнөж хуурын эгшиг хангинаж байгаа нэг газар сониучирхан очиж харвал, хоёр хөлгүй хижээл хар хүн хуурдаж сууна. Өглөг хайрласан хүнийг сайхан үгээр магтан ерөөж байлаа. Тэр хүнийг баян айлын зарц байгаад хоньтой нь шуурганд уруудан хээр огож хоёр хөлнөөсөө салсан юм байх, тэгээд баяных нь хөлгүй болчихоор нь хөөсөн юм гэнэ гэж хүмүүс ярилцахыг Базар чих тавин сонсоод хуурчийг хайрлах сэтгэл өөрийн эрхгүй төрж урагш давшин хэдэн зоос өгсөнд

- Хүрээнийхэнд ийм өглөгч хүн үгүйсэн. Аль нутгийн хүү вэ? гэж хуурч асуув.
- Засагт хан аймаг, Цэцэн Сарт-Уулын хошуу гэж хариулав. Хуурч цогтой хар нүдээрээ түүний нүүр рүү ширтэж, хуураа хөрөөдөн, чихийа нь мушгиж бодлогошрон байснаа хоолойгоо засаад ийн шүлэглэв.

Ховдог баяны мал дагаж

Хоёр хөлнөөсөө салчихаад

Өтлөх насны босгон дээр

Орох оронгүй хөөгдсөн чиг

Хурдан морины сүүлээр

Хуур хийгээд амь зууж байгаа

Хувьгүй төрсөн Балжир гуайд нь

Холбож хэлэх үг байна аа!

Мэргэд сэцдийн намтар нь

Монгол улсдаа түгсэн

Цэцэн Сарт-Уулын хошууны

Цэлмэг саруул ухаантай

Ханхар өргөн цээжтэй

Хүрэн зандан царайтай

Харах нүдэнд дулаахан

Хайр хүрэм залуу байна.

Соргог хурц харцанд нь

Шонхрын зориг илэрсэн

Сайхан төрсөн биенд нь

Баатрын шинж бүрүёясэн

Арслан барын тэнхээтэй ч

Амгалан хунгийн ааштай

Ард зондоо хайрлагдмаар

Авхаалжтай сэргэлэн хархүү байна.

Арван тавны сар шиг

Атар талын цэцэг шиг

Цэвэрхэн төрсөн хүүхнүүдийн

Зүрхний галыг асаамаар

Зэрэгцэн суугаад ярилцах

Чин хүслийа нь бадраамаар

Үеийн олон залуусаас

Үнэхээр содон эр байна...

гэж аялгуулан ерөөж эхэлсэнд тэрхүү магтаалын үгэнд ичиж, бас тал талаас нь хүн ажиглаад ч байх шиг санагдсан учир дуусахыг нь хүлээж чадалгүй бушуухан холдлоо. Тэгэвч хүн хүний царай ширтэн нүдээ бүлтэлзүүлэн “Буянтан, юм хайрла” гэж ам хамхилгүй дуугарах авч сохор зоос ч өгөх хүн тэр болгон тааралдахгүй хоосон алга дэлгэсэн хэвээр байгаа гуйлгачдыг харсаар атал юу ч өгөлгүй явчих нь хүний үнэргүй зан шиг бодогдов. Базар “Бурханд мөргөж маань уншсанаас ядарсан хүнд тус хүргэвэл энэ насны чинь буян тэр” гэж эцгийнхээ сургадгийг бодоод мөнгө байхад өлсгөлөн ноход шиг хөдлөх бүрийд дагуулан өлбөлзөн харж байгаа ядуусаас харамлаж байгаа юм шиг эвгүй санагдаж, хормой дүүрэн боов аваад захын гуйлгачдад тараав.

- Өглөгийн эзэн зуу насла!

- Ховорхон учрах буянтан ирж ингэж гялайлгах гэж!

- Ямар бурхны бүрэлбаа заларч ирэв ээ, та минь?!

- Ийм олон амьтсыг гялайлгаж байгаа хүн чинь бурхан биш юу байх юм бэ?

- Богдын хүрээнд ийм буянтан түм байдаг болоосой! гэж тэд шуугилдан түүнийг тойрч шавлаа. Базар боовоо өгсөөр тэдний талд нь ч хүрэлгүй дуусахад

- Ээ заяагүй толгой!

- Зүтгэсээр байгаад хүрч чадсангүй!

- Ийм өглөгч амьтнаас үмх боов хүртэх заяагүй болохоор өлбөрч үхэхдээ таарсан толгой! гэж хоосон хоцрогсдын зарим нь өөрийнхээ хувь заяаг зүхэн гаслалдав. Базар яах ч учраа олохгүй гайхан зогстол хашир догь байрын нэг хүн түүнийг хажуу тийш аваачаад

- Дүү минь! Чи Богдын хүрээний гуйлгачдыг цагтах гэвэл хөрөнгөө бүгдийа нь хайрлаад ч дийлэхгүй. Эдэнд чинь өглөг өгөх сайн санаатай хүн байх нь байдаг юм. Гэлээ ч гуйлгачин нь даанч олон. Харин чи эдэнд овоо юм хайрлалаа. Залуу хүн гэхэд овоо шүү. Чамд лав буян болно. Чи хүрээний явдлыг мэдэхгүй алс хошууны хүн бололтой. Одоо хэр тааруу дээрээ эндээс явж үз! Цаадуул чинь чамайг нүцгэрэхээс нааш салахгүй гэж түс тас хэлэв. Тэр хүн гол алдалгүй үнэнийг хэлсэн санагдах учир Базар захаас гарч “Эд нар яагаад ингэж үгүйрч гүйцэв ээ? Эднийг энэрч тэнхрүүлэх улс хүрээнд байдаггүй юм болов уу? Богд хаан хүрээндээ ийм олон гуйлгачин байгааг мэддэг л баймаар юм. Тийм бол эдэнд өршөөл хишгээ хайрламаарсан. Агваанлуvsан гуай Богд хааныг манай Монгол улсын хамаг амьтны амь нас, хувь заяаг дааж байгаа бүхнийг тольдон мэдэгч амьд бурхан, далдыг хардаг далай ламын зарлигаар заларч ирсэн их хутагт гэж ярьсныг бодоход хүрээнийхээ захаар орсон ч эс орсон ч

энэ гуйлгачдыг мэдмээр юм. Тэгвэл эд нарт яагаад тусыг үзүүлдэггүй байна? Эсвэл хүн бүр ноён, түшмэл, лам, баян, зарц, гуйлгачин болæ төрдөг хувь тавилан байдаг гэж бурхан багш сургасан тухай дүвчин ламтны айлддаг үнэн юм болов уу?” гэж өчүүхэн ухааныхаа хэрээр учрыг тунгаа᠔᠒᠑ мэрийн газар шагайн Гандангийн дэнж өөд сажилж явлаа.

Энэ үед Гандантэгчлэн хийдийн ойролцоох нэгэн хашаанд байгаа дөрвөн ханатай жижиг гэрт Агваанлуvsан, мариалаг бүдүүн лам хоёр урд урдаасаа харан толгойгоо нийлүүлэх шахам суугаад аяархан ярилцах нь их л нууцгайлсан төлөвтэй. Агваанлуvsан Базарыг гүжир хэрэгт үг нэгсэн унагах тухай ярихад хамартаа тамхи чихэн дуугайхан чагнаж байсан бүдүүн лам

- Дүвчин минь! Ам алдахад амаргүй хэрэг бололтой. Хожим өөрт гай болохгүй байгаа гээд Агваанлуvsангийн °өдөөс болгоомжтой харцаар ширтэв.

- Танд бүр нарийн учры᠗ нь хэлье. Надтай яваа энэ хархүүгийн эцэг нь нэг насаар шашин төртэй тэрсэлсээр яваа хүн. Базарт хошуунд хийсэн хэрэг багагүй. Тэнд барья гэхээр хошууны хар гэр шийртэй эрийг тогтоож чадахааргүй олиг муутай. Тэгээд нааш нь хуурч авчраад бат саванд оруулах гэж байгаа юм л даа. Тэндхийн хэргийн талаар хошуу засгаас нугалбар бичиж тавин лангийн ембүүний хамт надаар ирүүлсэн. Би түүнийг хошууныхаа тэргүүн туслагчийн захисан Шүүх яамны түшмэлд нь өглөө өргөчихсөн. Тэгэхээр зөвхөн эхий᠗ нь гаргахад л таны дэм хэрэг болоод байна. Шашин төрийг бататгах ариун үйлсийг чинь санаанаасаа сүсэлж энэ хэрэгт үнэнхүү сэтгэлээс тус хүргэхийг хичээсэн хүний гарыг цайлгаарай гэж хошууны тэргүүн туслагч хайрласан юм гээд дүвчин жижгэвтэр алтан бурхан гаргаж барилаа. Алтан шаргал өнгөөр гялалзан туяарах бурхныг хар᠑агцаа бүдүүн ламын малигар нүүрэнд инээмсэглэл тодорч, хоёр гардан авч зулайдаа хүргэн адис авахад Агваанлуvsан “Энэ лам ч одоо миний амнаас гарахгүй боллоо. Алт гэгч хүний аминд хүрэхэд амархан эд дээ” гэж боджээ.

- Одоо хоёулаа танай гэрийн юмыг сандааж орхиё. Базарыг ирэхэд та дуугүйхэн гараад арван тавны цагдааг олоод ир! Тэгээд л тэдний гарт хийчихье. Зовлонгүй бүтчихнэ гэж дүвчинг ятгахад бүдүүн лам толгой дохиод, янцаглан босч гэрийн доторхио урвуулж хөрвүүлчихээд хүлээж байтал Базар ч орж ирлээ. Хамаг юмаа онгичин суугаа ламыг хараад Базар юу болчихсон юм бол гэж гайхаж ядан суулаа. Бүдүүн лам нилээд ууртай янзтай дүвчин, Базар хоёрыг муухай муухай харсаар дуугүй гарч одов.

- Энэ ламын нэг алтан бурхан алга болчихож гэнэ ээ. Эднийд байснаар нь бид хоёрыг сэрдэх байх даа. Өчигдөр уржигдрын л буцдаг байж. Одоо яана вэ гэж Агваанлуvsан санаа зовсон байдал гаргаж хэлэхэд Базар

- Аваагүйгээс цааш айх юу байсан юм бэ гэж жишим ч үгүй байхад нь “Энэ хүн ч ингэж хэлэх нь арга᠗᠑ байх аа, чи! Одоо туслагч хатан таалахад харшлах юмгүй боллоо” гэж дүвчин бодож, хүнийг хилс хэрэгт хийх гэж байгаадаа огтхон ч сэтгэл түгшсэн янзгүй суух нь нэн аймшигтай. Бүдүүн лам энгэр дээрээ соёмбо тэмдэг бүхий хантааз өмссөн арван тавны хоёр цагдаагийн хамт аахилж уухилсаар орж ирлээ.

- Би ийм хоёр бурхантай байсан юм. Нэг нь алга болчихсон байна. Энэ лам, залуу хоёроос өөр хүн манайд байгаагүй. Хувраг хүн арай ч ийм хилэнцтэй юм хийхгүй. Энэ залууг авсан гэж

бодож байна гэж бүдүүн лам амьсгаадан яриад дүвчингийн өгсөн бурхныг цагдаад үзүүлэв. Хоёр цагдаа Базарыг авч явах гэхэд

- Би энэ дүвчингийн бараа болж яваа хүн. Эцгийн буянд сиймхий самбай, сэтэрхий тэвнэ ч нуувраар авч үзээгүй. Энэ ламтан эндүүрч байгаа биз гээд хөдөлсөнгүй. Цагдаа нар Базарыг барихыг санаархсанд нааш цааш түүдэг шиг түлхчихээд биедээ хавьтуулахгүй байхаар нь Агваанлуvsан хэрхэхийг бодон сууснаа Базарыг дагуулж гараад

- Хүн гэгч ямар муухай санаатай вэ. Бид хоёрыг хулгайд хардаж байгааг харав уу? Миний хуучин танил лам шүү дээ. Гомдоход гол харлаж байна. Дүү минь, хоёулаа эд нартай явж тэр яам тамгынх нь газар очиж нэрээ цэвэрлэж авъя. Чи битгий эсэргүүц! Цагдаа нарыг нь зодвол ялихгүй юмнаас ямааны гарз гэгч болно. Чи эндээ хүлээж бай! Би ч энэ ламын нүүрэн дээр хоёр цагдаад учрыг ярья гээд эргэн оров.

- Би цаад хүнийг чинь явуулах арга оллоо. Надтай яваа энэ залуу нутагтаа байхын хуруу урттай гэгддэг юм. Энэнээс ондоо авах хүн ер үгүй гэж хэллээ. Ингээд тэд явцгаав. Хаа очиж байгааг Базар мэдэхгүй учир Да хүрээний шоронгийн хашаанд ормогц түүнийг хэдэн хуяг буу зэмсгээр далайлган барьж хорилоо.

Базар алтан бурхны хэрэгт шүүгдэж хоёр хонгоо уруулж хэд хоноод байлаа. Агваанлуvsан сураггүй болчихоор нь хүний газар хаяад явж дээ гэж бодож ихэд гомдсон билээ. Гэтэл нэг өдөр Агваанлуvsан шөл цайтай ирж тун ч тухтай уулзаад,

- Дүү минь, унаа мал маань хэцүүдлээ. Би буцахаас болохгүй нь. Дүвчин гуай нь түнш ламтайгаа муудалцаж Шүүх Яам хүртэл гомдол зарга мэдүүллээ. Чамайг тэр алтан бурхныг аваагүй гэдгийг хэлж суллахыг гуйж хэдэн том түшмэлд хахуул шургууллаа. Алтан бурхан хулгайлсан эзэн ч олдож магадгүй бололтой. Чамайг удахгүй гаргах байх. За тэгээд сайн яваад нутагтаа очоорой!... Би гэдэг хүн эцэгт чинь, хошуу ноёнд юу гэж хэлнэ. Намайг л шоронд хийлгэчихээд ирлээ гэж бодох байх даа. Ийм муухай юм болох гэж. Яаж нутгийнхныхаа нүүрийг харна. Болдогсон бол эндээс явамгүй байна. Миний танил, лам хүн байж мухар гүжирө чамайг унагадаг даанч яав даа. Ингэхийг нь мэдсэн бол өөр айлд буух минь ч яалаа гэж сэтгэл маш зовууртай байгаа царай гарган яриад босохдоо “Нэг насаар энэ харанхуй савандаа суух болтугай. Эндээс сугаран зайлж бидэнд гай тарих нүх сүвийг бурхан хаах болтугай” гэж амандаа шившин залбираад эргэж харалгүй гарчээ.

Хонгор сайхан сэтгэлтэй залуу эр нутгийнхаа дүвчингийн шилийг харж хоцрохдоо “Энэ хүн мөн ч их санаа зовж байна шүү. Миний өмнөөс хахуул хүртэл өгөхийг бодоход намайг салгаж аваад хамт буцъя гэж үнэхээр бодож дээ. Тэр муухай ламаас ганц боллоо. Түүнтэйгээ бас муудалцаж шүү. Эндээс гарсан цагтаа нэрий минь хөөдсөн тэр цэндгэр ламтай заавал нэгийгээ үзье ээ, би! гэж бодлоо.

Арслангийн зулзага тэнхээтэй ч торонд орохын цагт хичнээн хүрхрэн дүүлэвч тусыг олохгүйн адил хүний үр хэдий ухаантай ч цоожтой хаалганы цаана суугаа болохоор дэмий л хорсон бухимдахаас өөр хэрхэх билээ дээ.

Арван нэгдүгээр бүлэг

Хорслын туйл

Хүнлэг сэтгэлийн нарыг хааваас

Хүлцэшгүй хилэнгийн дөл бадармой

Хошуундаа алдартай уран дархнаар хийлгэсэн гоёл чимгийн гайхам сайхнаар бүсгүй хүний шохоорхонтгой сэтгэлийг бишрүүлэн татах гэсэн хүсэл, Агваанлуvsан дүвчинг буцаж ирэхэд хуримлах ёслол хийх гэсэн болзоо хоёрт шаагдсан тэргүүн туслагчийн хамаг хэрэг санасанчлан бүтээгүй учир хууль цааз барьсандаа эрдэж, дархныг талхидаж байгаад мөнгөө хийлгэб гэж тамгын газрын дэргэд гэр бариулан суулгав. Өөрийн биеэр өдрийн хэд эргэж сэтгэлдээ таараагүй юмыг санаатайгаар муухай хиев гэж хэдэн удаа сүрхий жанчиж, хоюу засагт мөчөөрхсөн хорон санаагаа хэл! гэж байцаав. Сүх зодуураас болж хамаг бие шархиран хөндүүрлэн гар салгаёе, нүд бүрэлзээд юу ч хийж чадахгүй байна гэж шалтаглан хэвтсэн боловч Сэр-Одын сэтгэл зөөлөрсөнгүй баширлав гэж харин ч нэрмэн зодож байлаа. Хүчинд автсан өвгөн дархан хэрэг явдал хаашаа эргэж юугаар төгсөхийг харан байж болохоор шийдэж туслагчийн мөнгийг хийхээс аргагүй болов.

Дархныг юм хийгээд байхаар Сэр-Од нэг өдөр орж ирээд энэхэн тэрхнийг сонирхои сууж байснаа,

- Таныг ингээд л хэл үггүй хийгээд байвал би яалаа гэж ширүүлэх вэ. Төрийн түшмэл хүн заавал ч ширүүн дориун байх учиргүй. Харц ард ямар байна, түшмэл тийм л байдаг. Та ч гэсэн миний оронд хошууны тэргүүн туслагч байгаа бол мөн л тийм байхаас аргагүй... Таныг гарынхаа урыг гаргаад байвал би ч таныг аятай тавтай байлгахад мэдлээ гаргалгүй яах вэ. Юмны учир иймэрхүү байдаг биз. Та юу эс андах вэ гэж түрүүчийн зодсоноо цагаатган өвгөний сэтгэлийг засч хуурах гэж ядахдаа нялуун үг урсган инээхэд түүний дотор санааг андахгүй мэдэж байгаа дархан ихэд зэвүүрхжээ. Харин дархны гар хөдөлж байгаа болохоор биеийн нь сайн байлгаж ажлаа түргэн бүтээхийг Сэр-Од хичээхийн учир хамгийн сайн хоол унд өгүүлж дуртай цагтаа балгаж бай гэж хоёр гурван янзын хятад архи хүртэл гэрт нь тавиулсан нь түүнтэй зөөлөн аргаар үзэж санасандаа хүрэх гэснийг өвгөн ч бас мэдэж байлаа. Сүх туслагчийн юмыг хийж байгаа ч гэсэн “Миний хүүг яагаад Агваанлуvsантай явуулав? “Итгэлтэй, томоотой хүн” гүдэг дөвийлг°с°н нэр юунд өгөв? Эдэнд шарвалзуур сүүл олон байсаар байхад заавал хүүгий минь онцолдгийн учир юу вэ? Намсрай яагаад залан болов? Хүүгий минь Намсрайн охинтой гэмгүй байдгийг мэдээд ямар нэг будлиан самуун гарахаас сэрэмжлэн холдуулаа юу? Тэгээд араар нь Юмжирдуламтай хуримлах гэж байгаа юм аиш үү? Хаврын дунд сар талдаа орчихоод байхад тэд яагаад ирэхгүй байна вэ? Агваанлуvsан хүрээнд удах хэрэгтэй юм гэж үү? гэсэн хариу нэхсэн олон сэжигтэй бодол түүний сэтгэлд эргэлдэнэ. Дархан туслагчийн юмыг хойш тавилаа ч гэсэн зодуур нүдүүрт дахин өртөхөөс эмээхийн эрхэнд хазаар, хэт хутгыа нь хийж дууслаа. Сэр-Од хийцийн нь ихэд голж,

- Дуугүй байхаар нүд хуурах хэрэггүй. Дахин ингэвэл өөрт чинь л муу болно гэдгийг хашир хүн эрх биш гадарлаж байгаа биз гэж цаанаа л нэг заналтай хэлээд ёозгүй хүйтэн нүдээр харахад дархны яс янгинах шиг болжээ.

Биеийн шаналгаа, сэтгэлийн зовиур хоёрт нэрвэгдсэн өвгөн яльгүй турж, царай нь цонхийжээ. Өвгөн дархан аливааг бодлогоширсон уйтгартай нүдээр удаан ширтдэг болов. Нэг өдөр дархныг бүсгүй хүний толгойн чимгэнд угалз урлаж суухад Пагма домботой цай, уур савссан халуун мах барьсаар орж ирэхдээ урьдын адил царайгий нь ажиглав. Ямар ч гэм зэмгүй тэр хүний зовж байгааг шивэгчин хүүхэн мэдэх учир биеийн нь муудчих бий гэж санаа тавин хоол ундаар нь тордохыг хичээдэг ажээ.

- Цаадах чинь мажийгаад өгвөл би хоосон хоцорно. Миний юмыг хийж дуустал юу хүссэний нь өгч бай гэж Сэр-Одын хэлснээр Пагма ийнхүү олигтой өөдтэй бүхнийг шилж сонгон санаанд нь тааруулахыг мэрийх учир дархан ч ядуу бүсгүйг хайрладаг байлаа. Сүх дархан мөнгөний өөдөс илүүчилж хийсэн нарийхан боловч ганган бэлзгийг Пагмад өгч

- Хүү минь, хүнд ачтай тустай яваарай! Сайн санааны үзүүрт тос гэж үг бий. Үйлс чинь бүтэж явах болтугай! гэж ерөөв. Пагма бүсгүй хүн болж төрсөөр ийм сайхан бэлзэг зүүж үзээгүй учир бэлзгийг хуруундаа нэг хийж, нэг авч ахин дахин үзэж машид баярлав.

“Ямар сайн хүн бэ! Ийм хүнийг яагаад эрүүдэж зовоодог байна вэ?... Энэ бэлзгийг туслагчийн мөнгөнөөс аваад хийчихсэн байх аа. Тэгэхээр туслагч мэдэж бас л зодох юм биш байгаа даа. Ядаж байхад нь гай болбол ямар сайн байх вэ” гэж Пагма бодоод,

- Сүх гуай! Туслагч өөрийнхөө мөнгөнөөс тонож надад бэлзэг хийлээ гэж сүйд болохгүй байгаа даа... гэж эмээсэн янзтай хэлэхэд,

- Зүгээр, хүү минь! Дуугүй л зүүж бай! гэж Сүх түүний сэтгэлийг заслаа. Дархныг завилан суугаад мах огтолж, цай уун тавлаж байхад шанаагийн нь даган хөлс урсана. “Эвий хөөрхий. Орон гэрээсээ хол, хөгшин хүн ямар өөдтэй байх вэ. Би мэрийгээд мэрийгээд эмгэнийх нь цай шиг цай хаанаас чанав гэж. Харин ч бие сайтай хүн юм. Энэ зэрэгтэй байгаа нь яамай” гэж Пагма бодож өвгөнийг өрөвдөн харж сууснаа,

- Сүх гуай! би танд нэг магнай тэниймээр үг хэлэх үү? гэв.

- Ухай, юу вэ хүү минь!

- Танай хүү одоо гэртээ ирчихсэн байх аа...

- Яаж байна?

- Дүвчин ламтан сая туслагчийнд ирлээ.

- Өө тэгэв үү? гээд Сүх аягатай цайгаа тавьж дээлээ нөмрөөд сэвхийтэл босож гарахдаа “Юутай ч гэсэн хүү минь мэнд яваад ирдэг нь ашгүй. Хойшдоо яаж ч манарсан дүүрчээ” гэж бодсоор Сэр-Одын орлоо. Туслагч дүвчин хоёр ярьж байснаа дархныг ороод очихтой зэрэг таг дуугүй болов.

Агваанлуvsан өвгөнийг хармагцаа харц нь мятарч түүний нүүр өөд эгц харж чадахгүй сүү долоосон гөлөг мэт гөлөлзөж байлаа. Дүвчингийн эмээнгүй царайг ажаад дархны сэтгэл

сэртхийж “Яахаараа энэ мухар толгойт гэм хийчихсэн юм шиг миний нүүрийг харж чаддаггүй билээ? Хүү минь яагаа бол?” гэсэн муу ёрын бодол орж ирэв.

- Сайн явсан уу? Хүү минь гэртээ харьсан уу? гэж Сүх яаран асуув

- Сайн явах нь сайн явлаа... гэж дүвчин сунжруу дуугараад хэсэгхэн зуур хэлэх үгээ олж ядсан бололтой гөлрөн байснаа

- Та суу л даа. Ярих юм байна гэхэд нь Сүх дүвчинд дөхөсхийн суув.

- Танай хүүд хошуу засаг их найдсан. Би ч сайн хүү гэж санаж явлаа. Гэтэл Да хүрээнд орсон хойноо хошууны нэр гутаасан олиггүй хэрэг хийсэн. Даанч тусгүй гэж дүвчинг хэлэхэд Сүх,

- Яасан юм бэ? гэж гар занган давшлан өндөлзөв.

- Бид хоёр миний танил ламын буулаа. Танай Базар тэр ламын алтан бурхныг хулгайлсан. Тэгээд тэр хэрэгтээ хар гэрт хоригдсон. Би дээгүүр доогуур таньдаг хүнээс гуйж, байгаа жаахнаасаа хахуул цуггаж үзээд ч суллуулж чадсангүй. Да хүрээний нэртэй мэргэн ламаар заяа төөргийн нь үзүүлэхэд төрөхийн санаа буруутай, сувдаг сэтгэлийн тулам болсон хүн байна гэж айлдсан. Түүний хойноос сэтгэл тавивал өөрийн чинь биенд цөвтэй гэхээр нь би ч айгаад орхиж наашаа гарлаа. Танай хүүгээс болоод оройтож ирлээ шүү дээ гэж дүвчин яриад амандаа ном уншин тооно өөд гөлрөв.

- Элэнцгийн чинь мэргэн лам! Миний хүү хүн болсоор учигтай зүү хулгайлж үзээгүй. Чи л миний хүүг хэрэгт хийснээс зайлахгүй. Мухар толгойлсон хатмал лүд чи хүүгийн минь толгойг залгичихаад ирсэн үү?! гэж өвгөн дархан хашгираад ганц ухасхийн дүвчинг заамдан авч багаёзуурийн нь шахав. Агваанлуvsангийн цэрай хувхай цагаан болж ам нь ангалзан нүд нь бүлтгэнэв.

- Дархаан! Та яаж байгаа чинь энэ вэ! Хувраг хүнийг... гэж Сэр-Одыг бостол өвгөн үгийг нь тасалж

- Хувраг болохоо алд! Цадахаа мэдэхгүй хувалз! Амьд явж амьтан хүнд гай чирж байснаас танилбол барав! гээд хөвхтэй хагалсан модноос нэгийг шүүрч дүвчингийн толгой руу буулгах гэтэл Сэр-Од амжиж гараас нь булааж авав. Гэтэл тэгээд ч нэмэр болсонгүй. Насаараа мөнгө балбасан өвгөний балт шиг хатуу гар ламын жижигхэн толгой дээр гялсхийн буулаа. Дүвчин лантуугаар цохиулсан юм шиг ширдэг дээр ойчиж нүд нь цэхийгээд явчихав. “Дархан ингэж санадаг нь аргагүй! Харин би юмаа л хийлгээд авчих юмсан. Бас дүвчинг сэмхэн муулчихсан ч яах вэ. Дархныг хуураад араар нь тавивал боллоо” гэж Сэр-Од бодоод өвгөнийг тайвшруулах санаатай оролдож

- Та сэтгэлүү барьж тайвшир! гээд архи хундагалахад нь

- Та нарын бузар гараас гашуун ус уухгүй гээд дархан амьсгаадан суулаа. Дүвчинг арай ядан сэргэж өндийж ирэхэд дархан дахин заамдаж хоолойгий нь шахав. “Ингэдийг нь мэдсэн бол энэ чаралбыг гартал үхсэн мэт хэвтгээд байдаг байж. Энэний гарт амь үрэгдэх нь ээ” гэж

бодоод дүвчин туслагч руу өршөөл эрсэн нүдээр гөлөгнөн харлаа.

- Чамтай амиа солино доо гээд Сүх дүвчинг үүд рүү гуд татан чирэв. Сэр-Од хиа дуудаж сүр болсонгүй, харин ч энэ тохиолдлыг аятайхан далимдуулж түүнд нүүр олох гэж санаархан тэр хоёрыг салган дүвчин рүү нүд ирмэн дохисонд Агваанлуvsан гарч одов.

- Сүх гуай! Танай хүүг би хулгай хийсэн гэж яагаад ч санахгүй байна. Ямар будлиан болсныг одоо мэдэхийн арга алга. Тэгэхээр би Да хүрээ рүү буухиагаар бичиг илгээе. Та миний юмыг хурдан хийж дуусгаад хойноос нь яв! гэж Сэр-Одыг зулгуйдан ярихад дархан Сүх “Чи намайг малгай өмссөн мал гэж бодно уу? Агваанлуvsангийн гараар могой бариулчихаад одоо болохоор өөрөө мултарч надад гэмгүй хүн болж мэхлэх санаатай юу! гэж бодоод үг хэлэлгүй гарч дарх хийж байгаа гэртээ орж толгой салаавчлан гэдрэг харан хэвтэв.

Олон хоногоор санаа зовон хүлээсэн хүүгийнхээ тухай ийм аймшигт мэдээ сонссон өвгөн элдвийг бодон сэтгэл үймэрч зүрх шимшрэн гасалж байлаа. “Хүү минь хэдий сэргэлэн ч тийм хэрэг яагаад ч хийхгүй. Юунаас болж эндэх нь энэ вэ? Хүнд итгэмтгий гэнэн цагаанаасаа болчихлоо. Хүүгий минь явах үед ямар ч хов жив сойсогдоогүй болохоор түшмэлийн холын бодолтой хар санааг мэдсэнгүй. Намсрайн охиныг богтлох гэснээс гарцаагүй боллоо. Хүү охин хоёроо том болохоор нь ханилуулна гэж багад нь сүй тавьснаа Намсрай яагаад умартав?! Амаа буцах болохоороо тэр нууцаа туслагчид хэлж хүүгий минь цөлсөн юм биш үү? Эд хүний санаанд оромгүй яасан муухай юм бодож олно вэ! Та нараас би ингэж дөнгүүлснийхээ өшөөг яаж авах вэ? Энэ олон чонын өөдөөс ганц би яах вэ. Хүү минь амьд мэнд л байгаасай!” гэж элэг эмтрэн бодоход хоёр шанаагийн нь даган нулимс бөмбөрч байлаа.

Сүх тогтож сууж чадахгүй болж харихаар шийдээд эмээл хазаараа авч гарав. Гэтэл цээжинд нь хорсол хилэн багтаж ядан оволзож, туслагчийг зүгээр орхиод явахын аргагүй мэт санагдав. “Би одоо яах вэ? Ямар ч гэсэн чамайг нэг удаа дөнгөж байж л эндээс зайлна байгаа. Тэгээд хүүжийдээ хойноос явъя” гэж бодоод өвгөн дархан явахыгаа түр хойшуулав. Сэтгэл санаа нь уйман шаналсан Сүх тэр өдрөө юу ч хийлгүй өнжив. Шөнө нь ч нойр муутай хоножээ. Гэхдээ туслагчийг нэгмөсөн чадах арга олсондоо урамшиж үүр цүүрээр босоод дарсны мөнгөн гүц урлаж эхлэв. “Сүх дархнаар миний юм хийлгэдэг ч өнгөрөв бололтой. Одоо нэг л гэдийвэл яаж ч зодоод нэмэр байхгүй. Юу ч хийлгүй хэвтэж байгаад үхэхээ юман чинээнд бодохгүй айхтар золиг” гэж санаа зовнин өөр ямар дархныг гуйя даа гэж хошууныхаа дөнгүүр шиг дархчуудыг хуруу даран нэрлэж, шилж сонжиж байсан туслагч Сэр”Од дархны гэрээс алх дөшний дуу гарахыг сонсоод ямар ч атугай надад хонзогносонгүй гэж сэтгэл тайвшрав.

Дархан хоёр хоног толгой өөд татахгүй суусаар мөнгөн гүцээ дуусгав. Пагма өглөө эрт хоол цай оруулж ирэхдээ дархны царай цэлхэрч, нүд бүлцийснийг үзүүд өрөвдөн хайрлажээ.

- Таны нүүр хавантай байна уу даа? Хэд хоног юм хийхээ больж биеэ сувилуулбал яана?... Үгүй бол туслагчтанд хэлээд гэртээ хариад ирэхгүй юу гэж Пагмыг хэлэхэд өөрийг нь өрөвдөж байгаа хар элгийн ядуу бүсгүйд өвгөн баярласан хэдий ч

- Гайгүй биз дээ, хүү минь! Надад зовоод яах вэ. Харин туслагчийг ирж уулзаач! гэж хэлээтэхгүй юу гээд явууллаа. Удсан ч үгүй Сэр-Од туслагчийг орж ирэхэд дархан

- Миний хүүг ялнаас салгахад таныгаа тусаа үзүүлэх байх гэж бодоод ийм юм хийчихлээ гээд гүцээ өгөхөд туслагч
- Тэгэлгүй яах вэ. Ерөөсөө дүвчингийн бүтэлгүйгээс ийм хэрэг болж байгаа юм. Би ч уурлаж дүвчинг бишгүйдээ нэг загнасан. Хошууныхаа ганц дархны хүүг хилс ялд уначихаад байхад бид хөөцөлдөхгүй яах вэ. Би дөнгөж өчигдөр айлтгал бичээд Да хүрээнд явууллаа гэж бэлэн зэлэн урсгахад Сүх төдий л итгэсэнгүй. Сэр-Од гоёмсог гүцийг шохоорхон үзэж байснаа
- Гоё гоё гэхэд дэндүү гоё байна шүү гээд дархны өөдөөс үнэнхүү биширсэн нүдээр харж инээмсэглэв.
- Та тэгээд надад өгч байгаа юм уу? гэж ихэд шунангүй асуулаа.
- Тандаа барихгүй бол хэндээ гэж хийх вэ.
- Гялайлаа... Түрүүчийн юмсыг ингэж хийсэн ч болоосой. Тэгсэнсэн бол хаа ч явж, хэнд ч үзүүлэхэд нүүр бардам байхсан.
- Таныг хөлсөн дээрээ гар татах байх гэж бодоод би төдий л их хичээхгүй байна. Та намайг идэрхэн байхад гурван мөнгөн аяга хийлгээд амласнаа өгөөгүй шүү дээ.
- За тэр өнгөрсөн юмыг дурсаад яах вэ... Одоо яасан ч тэгэхгүй. Тэр үед би залуу байсан болохоор юмны учир мэдэхгүй байжээ. Одоо яалаа гэж тийм хуншгүй зан гаргах билээ. Хошуу туслагчдаа бүү муу сана! Сэтгэлдээ тохирсон хөлсөө аваарай! Авна гэснийг чинь өгнө.
- Нээрээ юу?
- Нээрээ байлгүй яах вэ. Сүх гуай минь! Та яасан их хар санаатай хүн бэ? Ийм хүнд чинь юу ч гэж хэлэх вэ дээ гээд туслагч худлаа инээв. Сүх туслагчийн сэтгэлд хар буулгахгүй гэхдээ
- Уг нь тэгмээрсэн дээ. Хошуу захирсан баян туслагч нарийлбал ичмээр юм бололгүй яах вэ гээд мишилзэн инээв.
- Ёстой хэлдэг үгээ хө.
- Таны нэг л юманд би шохоорхож байна. Түүнийг хөлсөндөө оруулж өгдөг юм бол ч...
- Тэг тэг. Юу вэ? Хэлээч!
- Танд олон жороо морь бий. Надад жороо халтраа л өгчих! гэж өвгөнийг хэлэхэд туслагч эргэлзэнгүй янзтай сууснаа “Ганц сорьд нь сугалах гэж байгаагийн нь хөөе. Намайг боож байгаа ухаантай юм биз дээ. Гэсэн ч бас юмаа хийлгээд авч байвал өгөх эсэх нь миний дур юм чинь” гэж бодоод
- Түрүүний хэлэх чинь яагаа вэ. Миний юмыг сайхан хийдэг юм бол ч ганц жороо морь хамаагүй шүү

- Та хожим буцах юм биш биз?

- Хаанаас даа. Би чинь хэлсэндээ хүрдэг хүн шүү. Өгөхгүй гэвэл адуунаас ийн бариад аваарай! гэж хэлээд Сэр-Од “Туслагчийнхаа морийг барьж авбал ч хонгоныхоо махыг барж байж л сална бий” гэж бодохоос хөх инээд нь хүрэв.

- За тэгвэл өгөө аваа таарлаа шүү дээ. Би хүүгээ ганц сайн унаатай болгоё гэж бодсон юм л даа... Таны юмыг түргэн хийж дуусгаад хүүгийхээ хойноос явъя. Та хүүгий минь хэргээс суллуулахыг бодож үзээрэй! Тэгвэл таны ачийг хэзээ ч мартахгүй.

- Та бүгд санаа зов! Би танд түрүүн хэллээ шүү дээ. За гэвэл ёогүй хүн шүү би гэж хэлээд хуурамчаар инээмсэглэж мөнгөн гүцийн нь бариад гарахдаа туслагч зөнөж яваа өвгөний амыг дагуулаад ганц сайхан дөнгөлөө гэж боджээ.

Дархан Сүх уран аргаар туслагчийн хүсэл шуналыг хөдөлгөж байгаад ямар ч сэжиггүй болтол нь сэтгэлийг нь засаж чадсан учир санаснаа хийхээр гулуузнаас мөнгө тас цавчин хайллаа. Тэгээд их юм эдэлж нүд тайлсан хэн ч болов шохоорхон үзэхээр маш сайхан мөнгөн баавар хийж өгсөнд Сэр-Од ухаан алдах шахам баярлаж “Жороо халтраа хоосон амлаж байгаад муу дархныхаа гарыг гаргуулж ганц дөнгөлөө. Надаас тэр морийг хаашаа харж байгаад авах бол доо” гэж бодож инээдээ барьж ядан жуумалзаж байв.

- Бодоод байхад таны жороо халтрыг авна гэдэг миний мулгуу бодол байж. Харин би таны тэр сайхан хүлэгт дүйцэх эмээлийн хэрэглэл хийе гэж саналаа гэж дархан хэлэв. Эрх сүрээрээ далайлгаад жороо халтраа өгөхгүй байж чадах боловч Сүх авах гэж булаалдан бөөн шуугиан дэгдээнэ дээ гэж санаа зовсхийж байсан туслагч санаандгүй ийм үг сонссондоо нэгэн хэсэг алмайрч орхиод “Моринд ч санаархсан бус, хүүгээ л ял янхнаас мултлах гэсэндээ надад саймсарсан хэрэг байх нь. Танай хүү ч хар гэрээс хоёр хөлөөрөө гардаг нь өнгөрсөн байх аа” гэж бодсон хэдий ч өвгөний сэтгэлд өөд^{оо} энэ хэрэгт оролцсон гэдэг хар үлдээхгүйн тулд анх дайлсан шигээ дайлж хөлснөөсөө гадна ялихгүй бэлэй сэлт өгч зусрын сайхан үгээр шүршиж явуулсан билээ.

Сэр-Од туслагч Сүх дархнаар хийлгэсэн мөнгөн хэрэглэлээ гойд их шохоорхож түүгээрээ гоёж гайхуулахын дон шүглээд байсан учир яаран шинэ эмээл төхөөрүүлжээ. Түүний очсон газар бүхэнд хүн шавж эмээлийн нь сонирхож байхыг хараад туслагч тун ч бардам сэхүүн явдаг байлаа. Шинэ хатандаа дээл хийх сайн торго авахаар Улиастай ороход худалдаа наймааны баячууд бололтой хэсэг хүмүүс түүний морин дээр шавчихсан шивэр авир хийн инээлдэж байснаа туслагчийг ойртож ирмэгц инээдээ тэвчиж ядан холджээ. Тэгэхэд нь эд яасан бол гэж харалхсан туслагч морио тойрч үзээд,

- Яав, та нар? Юундаа инээгээ вэ? гэж араас нь зандрахад нэг нь,

- Бид яагаа ч үгүй. Сайхан эмээл байхаар нь сонирхоод л... гэхэд нь Сэр-Од ихэмсэг царайлан мордож одоход өнөөдүүл нь инээлдсээр хоцорчээ. “Юм үзээгүй муусайн юмнууд” гэж туслагч зэвүүрхэн хараав.

Туслагч Сэр-Одыг залгаа хошууны Цогтоо ван ноёнд бараалхаж хоёр хошууны хоорондын

нэгэн хэргийг нийлээд буцахад нь вантан түүнийг үдэж мордуулахдаа эмээлийг нь шохоорхож үзэж байснаа,

- Тун яггүй хийжээ гээд ёжтойхон инээмсэглэхэд нь Сэр-Од бардам зангаасаа болоод анзааралгүй,

- Тун ховорхон эд дээ гэж хэлэхэд ван мөн л амыг нь дагуулан,

- Хаа ч байхгүй байх аа... Хаанахын дархан хийсэн юм бол доо, хөөрхий? гэж асуужээ.

- Манай хошууны уран Сүх гэдэг хүн хийсэн юм.

- Тэр чинь яггүй дархан дуулддаг юм гэж ванг хэлэхэд Сэр-Од түүнийг давах санаа төрж

- Таны хошуунд ийм юм хийх дархан байхгүй байх аа гэж бардамнав.

- Тэр үнээн. Манай хошуунд ийм юм хийх дархан байхгүй гэж ван егөөтэй хэлээд Сэр-Одын сагсуурсанд нь зэвүүцээд өөрийн ажсан юмаа хэлэлгүй явуулжээ.

Нэгэн удаа Сэр-Одыг тамган дээрээ их албатай суусаар түр гадаалахаар гарч иртэл харц барлаг арваад хүн морийг нь тойрон элэг мэдгүй инээлдэн шуугиж,

- Ийм эмээлтэй хүнд эхнэр яаж тогтох вэ.

- Боддог санадаг нь энэ юм байх даа гэлцэн инээлдэх сонсдов. Туслагч “Энэ муусайн барлагууд хэний тухай юу ярив?” гэж бодоод тэднийг байцаахаар дуудахад эргэж харах нь байтугай улам хурдлан гудамжны булан тойрч алга болов. “Хаа газар миний эмээлийг үзсэн хүмүүс инээлдээд байдгийн учир юу билээ” гэсэн сэжигтэй бодол түүнд төрөв.

Эмээлээ очиж үзэхэд ер буруу гажуу юм алга байлаа. “Нээрээ эртэд Цогтоо ван нэг л ёжуун инээгээд байсан. Энэ эмээлд нэг л гоохой байх шиг” гэж бодсон туслагч тамгынхаа өргөөнд буцаж орсон ч үгүй гэртээ харьж эмээлээ авч ороод юм юмы нь нэгд нэггүй нягтлан үзлээ. Мөнгөн баавар дээр нь нэг хачин арзайсан амьтны дүрс харагдахаар нь, үгүй энэ чинь юу вэ гэж дуу алдан эргүүлж тойруулан үзвэл, хүн инээгээд байдгийн учир тайлагдаж ирэх ньтэр. Залгалдсан хоёр нохойн хөлийг дээш нь харуулаад товойлгон цохичихсон нь энгийн нэг харахад махиралдаж тахиралдсан угалз хээ мэт харагдах ажээ. Туслагчийн уур шатаад явчихав. Босон харайж бахь олж ирэнгүүтээ эмээлийнхээ мөнгөн баавруудыг хэмх хэмх хөшин суга татаж хаялав. Туслагч хоёр гараа зангидан шүдээ тас зуугаад хойроо дэвхцэн

- Чи намайг ингэж шившиглэсэн бий! Чамайг даа, би...! гэж хашгичиж байтал Пагма домботой цай барьчихсан орж ирээд түүний минчийж хүрэнтсэн царай, яахаас ч буцахгүй догшин харцыг үзээд айсандаа босгоны тус газар хөшсөн мэт зогсов.

- Чи тахар Пэрэнлэйг одоохон олоод ир! гэж хашгирахад нь Пагма домботой цайгаа бушуухан тавиад шурхийн гарав. “За яамай, надад л уурлаагүй юм байга” гэж залбирав. Пагма айсандаа хахаж цацан гүйсээр тахарыг олж ирэв. Пэрэнлэй мөнгөн бааврыг нь ховх татаж хаясан шинэ эмээлийг нь таниад хэрэгт дурлан,

- Туслагчтан, юу болоо вэ? гэж асуучихсан чинь

- Та нар л үүгүй байсан бий! Хэлэлгүй өдий хүрснээ яах гээ вэ? гэж загнахад Пэрэнлэй бүр ч гайхаж хоцроод өөдөөс нь мэлтийгэл ширтэв.

- Тэрслүү боол Сүхийг одоохон очоод аваад ир! гэж зандрахад нь Пэрэнлэй годхийн гарчээ.

- Энэ эмээлийг гарга! гэж туслагч Пагма руу зандраад өөрөө хэдэн баавраа хамж аваад,

- Намайг шившиглэнэ гэхэд даанч ингэж шившиг болгох гэж! Өөрийнх^{оо}р барахгүй харийн хошууныхны доог болгоно гэнэ ээ! Улиастайд очиход тэр нэг хэдэн юм инээлдээд байсан, үүнийг үзээ байна шүү. Одоо Улиастайгаар нэг миний тухай шившигтэй яриа тарж гүйцсэн дээ. Дахин Улиастай орох нүүргүй болжээ. Цогтоо вантай дараа яаж уулзана? Хэрэв Да хүрээ орсон бол Монголд багтахгүй шившиг болох байж гээч... Би сайханд нь хууртаад ажсангүй. Манай тамгынхан мэдсэн хэрнээ хэлэхгүй, зэвүүн золигууд. Та нарыг даа!... Холын муу санаа шүглэж гүйцсэн хөгшин боол чиний голыг чинь гогодно доо. Ноёд дээдсээ нохойгоор шившиглэсэн боол өөрөө нохойн үхлээр үхэх ёстой” гэж хөмхий зуун занасаар байлаа.

Тэр шөнө тахар Пэрэнлэй, дархан Сүхийг хөөн ирж хар гэрт хонуулаад өглөө нь тамган дээр авчирлаа. Дархныг мэхлэх гэж муу санаа өвөрлөсөөр өөрөө чадагдсандаа уурлаж хилэгнэсэн Сэр-Од шүдээ хавиран

- Дээдэстэйгээ тэрсэлдэг тийм сүрхий балмад боол гээ чи! Чамайг хярамцаг болгоод орхиёо!... Наадахаа нэвсэртэл нь цохь! гэж дэвсэлнэ. Сүхийн хүлгийг тайлж түрүүлэг нь харуулан хэвтүүлж хөл цээж хоёр дээр нь нижгээд хүн дарж суув. Торомны гуя шиг туригар гуянд нь банз тас нясхийн буув.

- Ёо ёо болиоч та минь! Надад хийсэн хэрэг алга гэж өвгөний орилоход Сэр-Од өврөөсөө мөнгөн бааврууд гаргаж,

- Энэ чинь юу вэ? Муу боол чи мэдэх үү? Юу сийлснээ үз, чи! Энэ чинь надад биш, хошуу засагтаа тэрсэлсэн хэрэг! Эзэн ноёндоо ээлгүй эргүү боолыг бүү хайрла! гэж хашгирахад өвгөнийг дахиад банздаж гарлаа. Нэг хиа газар хэвтэж байгаа бааарыг авч үзтэл туслагч,

- Чи юун хэрэгт дуртай новш вэ? Цөмийн нь нааш нь өгөөтөх! гэж зандран өвөртлөхөд тамгынхны зарим нь гэмгүй царайлан бие бие өөдөө нүд ирмэн инээдээ барих гэж уруулаа хазах нь мөнгөн бааарын нууцыг хэдийнээ мэдчихсэн бололтой.

- Засгаар түрээ барьсан зальхай түшмэл чи даадаг л юм бол миний зовлогыг зулгаа! Хүүгий минь залгиад цадсангүй юу, чи! Миний зовлого чинийхээс цэвэр. Цадталаа ид! Цусал! гэж өвгөн хашгирлаа.

- Омгийн нь дарагдтал цохиод өгөөч, малнууд аа! Хүн зодож сураагүй адгууй уу, та нар чинь!... би заагаад өгье гээд Сэр-Од тэсэлгүй харайн очиж тахар Пэрэнлэйн хацрыг халуу оргитол алгадаад гараас нь бааарыг шүүрэн авч,

- Одоо дуугараагах! Дахиад амаа ангайлгаач! гэж хашгиран Сүхийг галзуу юм шиг тэнхээ мэдэн балбав. “Би тэртээ тэргүй энэ түшмэлийн гараас гарах өнгөрлөө. Ямар ч атугай хэлдгээ хэлж аваад үхье. Долоон булчирхайгий нь уудлаад өгөх минь” гэж зориг шулуудсан өвгөн дархан

- Өөрийн чинь төрх жингэрийн нохойноос ялгаагүй болохоор эмээлийн чинь баавар дээр дүрсэлж манай туслагч иймэрхүү хүн гэдгийг олонд үзүүлсэн юм. Чам шиг ноёныхоо нэр барьсан нохойноос дор амьтан энэ хорвоод байхгүй. Хошууны нэр бузарласан энэ туслагчаа дагаж хүний мах иддэгээ больцгоо! гэж дайрыа нь маажиж, шүд зуун оуһауёуһууд байв. Олны нүүрэн дээр ингэж адгийн муухайгаар дайруулсан удаа Сэр-Од туслагчид нэгээхэн ч үгүй билээ. Ичих, уурлах хоёрт ухаан алдсан туслагч сүүлдээ хээгээ барж өвгөний хонгон дээр цохихоо болиод хаа дайралдсан газар нь нүдэж бас өшиглөж байв. Өөрөө хүн зодож хууль нугалж байгаа туслагчийн өмнөөс үг хэлчих хүн нэг ч байсангүй. Сүхийн гуяны мах салбарч, цус нь туслагчийн хувцсанд бялдаж банзны үзүүрт цохигдсон нүүр, толгой нь хэгзсэрч цус гоожно. Сүх ухаан алдаж дуугарахгүй боллоо. Сэр-Од “Хүү ÷инь ноднин зун намайг ийм л болгосон доо. Өөртөө гай болсон ǰд хүүхдэдээ гомд! Чи яасан их аагтай новш вэ! Дахиад дуугардаг юм бол чиний бодийг чинь хөтлөөд өгнө” гэж занаж хүн зодсондоо тамирдаа уухилж аахилсаар ширээний ард суулаа.

- Юугаа харж алмайрсан ноход вэ, та нар! Ус хийж сэргээгээд цохиоч! гэж туслагчийн дуу хадахад Пэрэнлэй гүйн гарч хувинтэй ус авчран Сүхийн толгой цээж рүү цутгав. Хагас дутуу ухаан орсон өвгөн дархан “Махчин, улаан махчин! гэж занан хүндээр зовёурлан байлаа.

Хошууны бүх мэдэл гарт минь байхад өөдөөс цорволзож байдаг ямар оуһууа боол вэ, чи! Муусайн харц боолуудын хувь зохиол миний гарт. Ухаантай нь намайг дагаж номхон боолын ёсоор явна. Тэнэг нь ингэж л хохимой толгойгоо хага цохиулна. Үнэнийг хэлж байгаа нь энэ гэж дээдсийн согогоор оролдвол өчиггүй нидрүүлнэ. Хэдхэн цөөн этгээд хичнээн цорволзоод хошуу засгийг яах юм бэ? Түрүүний бөөс толгойд гэгчээр боолууд толгой руу асах ёсгүй” гэж Сэр-Од бодон өөртэйгээ эрслэн тулсан дархан Сүхийг адгийн тэнэг амьтан гэж гайхаж байлаа.

Нутгийнхандаа хүндтэй, шулуун шударга зантай өвгөн дархныг энэрэн хайрлах хүн тамгынхны дотор ч байжээ. Тэргүүн туслагч Сэр-Одод дургүйцсэн нэгэн хиа гэмгүй хүнийг хилсээр махчилсан тухай ноёндoo айлтгаж өршөөл гуйсан юмсанжээ. Агь ноёныг арваад настай байхад эцэг ноён нь Сүхийг өргөөний газар авчран хүүдээ эмээл хазаар, хэт хутга, мөнгөн аяга хийлгэсэн ажээ. Зуны нарлаг өдөр Сүх дархан ноёны өргөөнд дайлуулж халамцуухан гарахдаа агь ноёны толгойг илж үнэрлээд морджээ. Цагаан чисчүү тэрлэгтэй дархан Сүх эцгийнх нь юм хийлгэсний шан болгож өгсөн бүрэн хэрэглэлтэй сартай хүрэн морь унаад сайварлуулан ганхуулсаар магнаг цэнхэр тэнгэр, манант ногоон талын савсалгад сүүмэлзэн сүүмэлзсээр бараа тасрахыг сониучирбан сэтгэлээр нүд алдалгүй харсаар хоцорсон тэр нэгэн хөрөг агь ноёны сэтгэлд одоо ч хэвээр ажээ. Сүхийн хийсэн уран гоё эдлэлийг хэрэглэж өссөн агь ноён сэтгэлд нь мартагдашгүй дурдатгал үлдээсэн тэр хүнээ гамшигт учирсныг зүрх шимшрэн сонссон аж. Тиймээс агь ноён өвгөнийг хэлмэгдүүлсэнд уурлаж туслагчийгаа дуудан

- Та Сүх дархныг яах гэж шүүж байгаа юм бэ? Хэн түүнийг шүү гэсэн юм бэ? гэж сүрхий

шаанги зэмлэв. Агь ноёныг хүүхэд гэж тоомжиргүй байдаг Сэр-Од энэ үгийг сонсоод хиртхийн зовж,

- Ноёнтон минь, танд хэлээгүй минь түмэн буруу, өршөөгтүн! Хожим алгасалгүй дагая. Тэгэвч эцгийн тань гэрээс ёсоор засаг заслалын хэргийг би танд судгах ёстой билээ. Таны эцэг эрхэм дээд ноёнтныг таалал төгссөнөөс хойш харц доодос ноёнтон таныг бага балчир гэж басамжлан элэг барьж толгой маажих гээд байна. Доодост зөөлөн байж хэрхэвч болохгүй. Тэгвэл таны суудал ганхана. Ноёнтны ширээг бат бэх орших болтугай гэсэн чин санаанаас дархан Сүхийг цээрлүүлсэн минь үнэн. Нэг барлагийг залхаавал мянган барлагийн амыг тагладаг жамтай билээ! гэж нахилзаж бөхөлзөн өчив. Сүх ноёнттой нүүр учрах хувьгүй болохоор Сэр-Одын энэ айлтгал агь ноён, дархан хоёрын завсарт даахгүй хэрэм боллоо. Түшмэд нь ноёндоо урьтан ам нээдэг учраас ноён ч тэр үгийг нь сүсэглэн дагахаас аргагүй болдог аж. Ойрын шадар хүний амаар ойворгон хэрэг хичнээн гардгийг хэн эс мэднэ. Сүхийн үгийг сонсдогсон бол ноён нэгийг бодохсон бизээ.

Арван хоёрдугаар бүлэг

Уран арга

Зол баяргүй уйтан тамд ч

Зул мэт ухааны оч гялбана

Чийгт гяндангийн цоожтой хаалга тар нярхийн онгойж

- Гарцгаа! гэх захирангуй дуу сонсогдоход Базар өндийв. Түүний дэргэд байгаа хууз хар хүн хүзүүндээ угласан том дөнгөө данхалзуулан бослоо. Гараа гавлуулж, хөлдөө тушаа хийлгэсэн Базар дэгсээр гадаа гарав.

Тэнгэр цэлмэг, салхигүй, наран ээсэн залхуу хүрэм өдөр байлаа. Хашаа байшингийн нөмөр дагаж нялх ногоо цухуйжээ. “Ай хөөрхий хавар болж дээ. Эцэг эх, нутаг орон минь яасан их санагдана вэ. Одоо Цэгээн нуурт усны шувуу чуулаад юутай сайхан байгаа бол. Шувуу шиг нисээд харьчихдаг ч болоосой!” гэж Базар бодсоор нэгтээ очиж шороон дээр суулаа. Нар салхины бараа харалгүй хоёр сар шахам гянданд сууснаас түүний царай цонхийж цайгаад алтан бурхны хэрэг хүлээлгэх гэж эрүү шүүлт тулгаснаас нилээд турж тамирдсан байлаа. Хонгоных нь зодуурын шарх эмзэглээд сууж боломгүй байхаар нь хажуулав. Базар дүвчин ламтны хэлснээр нэг л өдөр гаргаад тавьчих юм шиг бодих тэвчин хүлээсэн боловч суллах нь байтугай харин ч хэрэг хүлээлгэх гэж хатуу чанд залхаах болжээ. Залуу эр удаан тэсвэрлэсэнгүй нэг удаа гэнэт уур хилэн нь бадарч,

- Хулгай хийгээгүйгээ хэлсээр байтал чихгүй юм шиг өнгөрөөгөөд тамлан зовоодог чинь юу вэ гэж омогдон байцааж байсан түшмэлийн тархийг янтайгаар нь хага цохисон учир түүнийг ихэд сэжиглэн гавлаж гинжлээд маш чандаар хорих болжээ.

Хууз хар хүн түүний дэргэд ирж наран сөрөг харж бодол болон зогссоноо шүүрс алдаж,

- Хавар болж хамаг амьтан сэргэж байхад харанхуй нүхэнд хэвтэж байдаг ийм ч хийморьгүй юм байх гэж хэмээн дуу алдлаа.

- Намбаа гуай! Та Алтайн нурууны хүн мэдэхийн аргагүй газар орогнож байсан юм бол яагаад баригдчихаа вэ? Байгаа газрыг чинь үзсэн хүн ховлочихоо юу? гэж Базар асуув.

- Миний оромжийг мэдэх хэдэн хүнд олиггүй амьтан байхгүй. Өөрийнхээ мууд л тэр. Би дотор газрын жинчдээс тэмээний тэнгийн торго шүүрдэг байлаа. Надад нэг сайхан өндөр улаан морь бий. Түүнтэйгээ Цонжоос Ховдын пүүсэнд бараа хүргэж гэсэн иргэн жинчинг отлоо. Тэднийг буучихаад байхад нь дөхөж очоод мориндоо ташуур өгч дайраад орохдоо нэг баглаатай торго шүүрээд авсан чинь татагдаж гэдэргээ унаад хоцрох нь тэр. Тэгсэн чинь шушмаануудын муу санаатайг хэлэх үү, шүүрдэг хүн байдгийг дуулчихаад ачаагаа буулгахаараа хоёр тэнгээ холбочихсон байхгүй юу. Тэгээд шушмаануудад зодуулж арай чамай амь голтой Ховдын шоронд ирж, тэндээсээ Да хүрээнд хүргэгдэв ээ чи минь. “Бөх хүн бүдүүн өвсөнд” гэгч шиг л юм болсон. Эрх дураараа явах хоногийнх нь тоо гүйцсэн юм

байлгүй дээ гэж Намбаа яриад Базарын өөдөөс харж инээмсэглэсэнд харцанд нь нууцгайхан гуниг илрэхийг залуу эр ажиглав. Өдөр шөнийг нэн зовууртай өнгөрөөж байсан Базарын сэтгэл Намбааг ирснээс хойш сэргэжээ. Тэр хоёр арваад хонохдоо хэн хэндээ хань болж зүрх сэтгэлээ нээн ярилцах болжээ. Урианхайн урт гарт, унтаа Намбаа гэж Ховдын хязгаарт алдаршсан энэ хүн Базараас хорь гаруй ах, амьдралын зовлон багагүй үзсэн хашир догь эр ажээ. Базар түүний нэр яагаад ийм урт гуншинтайн учрыг сонирхоход Намбаа,

- Ихэвчлэн Урианхайн хязгаараас адуу хөөдөг болохоор Урианхайн урт гарт гэсэн юм болов уу даа. Би хүнтэй унтаагаараа ярьчихдаг, унаан дээрээ унтсан чигтээ хаа ч хүрчихдэг юм. Тэгээд унтаа гэсэн байх гэхэд нь ихэд гайхсан билээ.

Намхан давжаа биетэй, харахаа аоожоогүй байрын хижээл эрийг анх орж ирэхэд Базар “Энэ хөөрхий амьтан хэрэг хийгээд байхдаа яах вэ. Бас л над шиг гүжирт унаа биз. Ийм хүнээр ч яах юм билээ” гэж ихэд голж тоосонгүй өнгөрчээ. Гэтэл тэр хүн нь тун ч нүүрэмгий, яриа хөөрөө гэж ус цас шиг хүн байлаа. Намбаа Монголоос дотор газар руу хонь тууж яваа хятадуудыг шөнө унтаж байхад нь ганцаархнаа хэриээ толгой дээр нь очиж суугаад хоолойгоо хэд засаж бүдүүн модны бараа харуулчихаад жаахан байзнаж байгаад сэмхэн босож хониноос нь таслан авч туугаад явчихдаг байншаа, залуудаа Ховд, Улиастайн манж амбаны сүргээс шилдэг морьд хөөж байсан тухайгаа үлгэр шиг юм ярихад нь Базар аман дээр нь чихээ тавих шахан сонсдог хэрнээ “Сайхан худал ярьж сурсан сэргэлэн эр юм. Энэ бид хоёрын тэгэх ч гайгүй биз. Харин сайн эр болох гэж бурж байж амнаасаа сэжиглэгдэн хэрэгт холбогдсоноос зайлбаргүй” гэж бодож байсан удаа бий. Тэгээд дотно танилцсан хойноо Намбааг юу гэж басамжилж байснаа санахаас ичиж өөрийгээ битүүхэн зэмлэвч хүнийг гаднаас нь сонжиж болдоггүй, эрийн шандас гэж нэг дийлдэшгүй нууц увдис яснаасаа заяасан байдгийг ухаарснаа машид олзуурхжээ.

Хаврын нарны өгөөмөр ил÷ бүлээцүүлэх нь тун тааламжтай. Базарын залхуу хүрч зүүрмэглэтэл хуяг тэр хоёрыг хөөж орууллаа.

- Энэ үмхий нүхний мухарт ясаа тавих юм биш байгаа даа гэж Базар хаалганы цаана цоож ханхийхийг чагнан ууртай дуугарав. Суллагдах өдрөө хүлээсээр нэгэнт цөхөрсөн боловч сэтгэлийн гүнд горьдлын өчүүхэн оч улалзсаар байгаа ажээ.

- Чи гарна гэж арай бодоод байгаа юм биш биз?

- Хулгай хийгээгүй хүнийг тавихгүй яах юм бэ? Тэгээд ч дүвчин лам маань мэдэлтүй түшмэлүүдэд нь мөнгөн хахуул өглөө гэсэн юм. Тэд нь ч намайг гаргана гэж амласан юм гэдэг шүү. Хүний мөнгийг худал хэлж авахгүй биз дээ.

- Чи тэр дүвчингээ хахуул өгснийг яаж мэдэж байгаа юм бэ?

- Яах юу байх вэ, өөрөө надад ярьсан юм чинь.

- Чамайг хуурсан байвал яах вэ?

- Надад худал хэлэх учиргүй. Би тэр дүвчинд гэм хийсэн биш.

- Би чиний ярьсныг хэдэн өдөр эргэцүүлж бодлоо. Танай хошууны ихэс дээдэс чамайг мэхлээд байгаа юм биш үү? Чамайг алтан бурхны гүжирт унагаах нэг хэрэг тэдэнд байж л дээ. Түүнээс биш цаадуул чинь ашиггүй тоглоомоор нааддаг улс биш. Да хүрээнд чамайг хуурч авчирснаас зайлахгүй. Таны дүвчин хахуул өгсөн гэдэг ч худал. Эд чинь мөнгийг нь авбал чамайг эргэлзээгүй гаргана. Чи эндээс амьд гарахгүй болсон байх. Надад тэгж л санагдах юм. Ноёд түшмэд гэдэг чинь чиний зэргийн үс нь гуужиж гүйцээгүй мөндөл шиг хархүүг байтугай долоо шархдаж дол цохисон чоно шиг хашир эрийн толгойг өөрт нь мэдэгдэлгүй эргүүлээд тавьчихна шүү. Ингэхэд чи л хошууныхаа дээдсийн дургүйг хүргэх яггүй хэрэг сандаасан байх аа даа. Тэгээгүй бол чамаар оролдох учиргүй баймаарсан гэж Намбаа ярив. Сэр-Од туслагч, дүвчин лам хоёр сүлбэлдэн өөрийг нь ялд унагаж байгаа гэхэд Базарт үнэмшимгүй санагдав.

- Би хошууныхаа дээдсийн сэтгэлд хумсын толион чинээ ч муу юм хийгээгүй дээ гээд Базар бодлогошрон хэвтэн байснаа,

- Намайг эндээс тавихгүй гэдгийг та яаж мэдэж байгаа юм вэ? гэж асуусанд Намбаа

- Бодоод байхад надад тэгж л санагдаад байна. Түүнээс биш чамайг энд хадгалж элэнцгээ хийх юм бэ гэв.

- Тэгвэл намайг байцаадаг түшмэл алтан бурхан аваагүй гэдгийг мэдээгүй хэрэг үү?

- Тэр чинь чамайг бурхан хулгайлчихаад хүлээхгүй байна л гэж бодож байгаа. Харин Шүүх Яамны дээгүүр зиндààнi түшмэл чиний хэргийн гохыг атгаад сууж байж мэдэх л юм.

- Тэгдэг л юм байх даа. Тун хачин юм гээд Базар гайхашран санаа алдав. Тэгээд орой болтол элдвийг бодон улам ч урам зориг нь хугарчээ. “Сэр-Од туслагч ноднин зун зодуулсныхаа өшөөг далдуур авч байгаа юм байж дээ. Эсвэл удах тусмаа өөрийнхээ шившгийг олонд тараана гэж сэрэмжлэв үү. Нэг бол намайг хошууныхаа дээдэст халтай хүн болох нь гэж муу санаалаад эртнээс холтгож байгаа юм болов уу” гэж бодоод туслагчийг зодсон тухайгаа ярихад Намбаа

- Тийм байж болно. Гэхдээ тэрүүхний төл°ө ийм хүнд ялд унагамгүй юмаа. Өөрсдөө хонгьгай чинь зулгаагаад тавьчихсан ч дөнгөнө шүү дээ. Өөр нэмэр хамжаа бий болов уу гэж хэллээ. Тэр хоёрын хэн хэн нь дуугарахгүй байх нь хоёулаа л гүн бодолд дарагдсан бололтой.

Давчуу тасалгаан дотор хоёр хүн бие биеэ үзэхээргүй харанхуй болж буй нь нар шингэсний тэмдэг ажээ.

- Намбаа гуай гэж Базарын дуу харанхуйн дундаас огцом сонсдоход дэмий ярьж залуу хүний сэтгэлийг үймрүүлж орхив уу даа гэж санаа зовсхийж байсан Намбаа

- Юу гээ вэ? гээд дөхөж очив.

- Та намайг эндээс хэзээ ч гаргахгүй гэж лав бодож байна уу?

- Магадгүй л байх гэж Намбаа сунжруулсхийн хэллээ.

- Тэгвэл оргоно доо гэж залуугийн зоримог дуугарахад Намбаа

- Эр хүний бодол мөн хө гээд “Най бага ч эрийн хуйх юм хө. Сэтгэлээр унаад амьдаараа үхчих эр биш байна” гэж бахдах сэтгэл төрөв.

- Буутай манаа, цоожтой хаалганы цаанаас гавгай гинжтэй хоёр хүн оргоно гэдэг ч зүүднээс ялгаагүй хэрэг ээ?

- Арга ухаан зарвал ч мултарч чадна. Яадаг бол гээд бодчихвол гэрийнхээ босгыг ч давж чадалгүй байсаар өнгөрнө дөө.

- Хоёрын хоёр толгой байна, эндээс салах арга заавал олъё. Та ч бод! Би ч бодно гэж Базар шийдэмгий хэлэв.

Тэр хоёр хэдэн өдрийн турш тархиа гашилтал оргох арга сүвэгчилсэн авч хэн хэнийхээ сэдсэнийг шүүн тунгаан няцаасаар сэтгэлдээ яв цав тохирсон найдвартай сайн арга нэгийг ч олсонгүй. Нэгэн шөнө Базар бодолд дарагдсаар нойр нь хулжиж эргэн хөрвөн хэвтэж байснаа гэнэт ухасхийн өндийж

- Хөөш, хөөш! гэж Намбааг угзчив.

- Яав аа, юу болов? гэж Намбааг нойрмоглон асуухад

- Би ёстой нэг уран арга оллоо гэж хаалганы цаадах хуяг дуулчих бий гэсэн мэт чихэнд нь шивэгнэв. Энэ үгийг сонсмогц Намбаагийн нойр сэргэж,

- Ухайс даа, яриач! гэж уриалган хэлээд харанхуйд инээмсэглэх шиг болохыг Базар мэдлээ.

- Хуягийг алт өгнө гэж хууръя.

- Ай даа, чи мөн гоомой юм бодов оо. Шоронд хэвтэж байгаа бид хоёрт алт бий гэж хэн үнэмших юм бэ? Нялх хүүхэд л магадгүй... Унт, унт! гэж Намбаа дурамжхан дуугараад эргэж хэвтэх шиг болоход Базарын урам хугарсан боловч

- Намбаа гуай! Та аан гэж бай л даа гээд түүнийг чангаасаар босгон өөрийн бодсоноо нэг нэггүй ярив.

- Энэ чинь ёстой эр хүний санаа байна. Болдог хэрэг гэж Намбаа баяртай хэлэв. Маргаашнаас нь эхлээд Базар үхлүүт өвдсөн хүн болж наранд ч гаралгүй хоёр хоног хэвтээд гурав дахь өдөртөө хоол ч идсэнгүй, хуягийг асуухад нь хэзээ хэзээгүй амьсгаагаа хураах гэж байгаа хүн шиг үгээ зөөж тавин аман дотроо дуулдахтай үгүйтэй бувтнажээ.

- Энэ залуу өнөө шөнөөс буюдбайж байх аа гэж Намбааг нарлаж суухдаа хэлэхэд хуяг зөвшин толгой дохих нь түүнтэй санал нийлж буй бололтой.

- Алтан бурхнаа шингээж чадалгүй өөд болох нь ээ. Цаад лам нь хараал хийсэн байх гэж Наибааг өгүүлэхэд хуяг бас л толгой дохилоо.

Шөнө дундын хэрд Базар хаалгаа аяархан тогшлоо. Хуягийн хөлийг чимээ хаалганд дөхөж ирэв.

- Яах гээ вэ? гэж хуяг асуув.

- Би тэсэхгүй нь ээ... Та буян санаж надад тус болооч! гэж Базар их л дорой дуугаар хэлэв.

- Юу гээд байгаа юм бэ, чи!

- Энэ хүн ухаангүй унтаж байна. Надад олон юм ярих тэнхэл ч алга. Та хаалгаа онгойлгохгүй юу. Би танд нэг л юм хэлье.

- Наанаасаа хэлчих. Үг чинь дуулдаж байна

- Надад хэдэн цэн алт байна. Та намайг үхэхээс өмнө үүнийг аваад нэг laid хойтохыг минь даатгаж өгөөч! Би бас алтан бурхан нуусан газраа зааж өгнө шүү. Тэр бурхныг та аваарай! Түүнээс болж би үхэх үйлтэй амьтан байж л дээ гээд Базар уйлагнав.

- Чамд яаж алт байх юм. Бүү донгос! Солиороо юу, чи!

- Бий бий... Дээлийнхээ хаваасанд нуучихсан юм. Үхэхийн хооронд танд худал хэлээд яах вэ. Та орж ирээд ав л даа. Би өөрөө гаргаад өгчих тамиргүй болжээ гэж Базарыг үгээн зөөн учирлахад хуяг “Үхэх хүнд үг хэрэггүй гэгчээр энэ одоо намайг хуураад яах билээ. Үнэн байх шүү. Хаалга сахиж байгаад алттай болж баяжих юм биш байгаа даа... Харин цаад хүн нь мэдчих бий дээ” гэж бодоод

- Цаад хүн чинь бөх унтаж байна уу? гэж асуув.

- Түрүүнээс хойш л хурхираад байна шүү дээ. Та хаалгаа аяархан онгойлгоорой! гэж Базарыг хэлэхэд хашир хуяг гаднаас нь чимээ чагнан удаан зогсов. Нэг нь жигдхэн хурхирч нөгөөх нь үхэх гэж амь тэмцэж байгаа бололтой огцом огцгii амьсгалæ байгаа нь сонсдов. Хуяг хаалгаа чимээгүйхэн онгойлгож цээжээ оруулаад хар санасандаа бас л дахин чих тавихад нөгөө залуу нь “Бур... хан минь... бур хан минь” гэж дуулдах төдий тасалдангуй үглэхийг сонсоод түргэн завдахгүй бол энэ чинь амь тавих нь гэж бодiiä алтыг нь бушуухан салгаж авах шуналын гал нь дүрэлзээд иржээ. Хуяг түргэн орж хаалгаа хаагаад,

- Алив, тэр алт чинь? äж асуугаад Базарын дээрээс тонгойход,

- Миний өвөр рүү гараа шургуулаад үз гэв. Хуяг энгэрийг нь тэмтчиж

- Өнгө дотор хоёрын завсар байгаа энэ бөөрөнхий юм мөн үү? гэж баярлан дуу алдав.

- Мөн мөн. Нэг тийш нь гүйлгээд сугалæ авна уу, ураад авна уу, өөрөө мэд! Тэртэй тэргүй үхэх гэж байгаа хүн дээлээр яах вэ. Наад алтаараа та миний хойноос буян хийлгээрэй! Би

таны ачийн хариуд өнөөх хулгайлсан алтан бурхныг хаана нууснаа ч бас хэлнэ гэж Базарыг хэлэхэд хуяг нэг үгээ юун ч олон улиглах юм бэ гэж дотроо уцаарласан боловч үхэх гэж ухаан нь орж гарч байгаа амьтан арга ч үгүй биз гэж бодоод

- Тэгээрэй, тэгээрэй... Үгүй тэгээд тэр бурхан чинь хаана байгаа юм бэ? гэж тэвдэнгүй асуув.

- Наадахиа бушуухан аваатах! Дараа нь хэлье гэж Базар амьсгаадан хэллээ. Залуугийн амьсгал улам давхцахад хэрэв үгээ гүйцээж чадалгүй амьсгаа хураачихвал алтан бурхангүй хоцорно гэж айх, яарах давхцсан хуяг

- Би чамайг сайн ламд даатгаж диваажингийн оронд төрүүлнэ. Чи алтан бурхнаа л самууралгүй амархан олохоор сайн зааж өгөөрэй!... Одоо хэл хэл! Би энэ алтыг чинь авчихаж амжина гэж хэлээд Базарын дээлийн өнгийг ураг гэж улайран байтал Намбаа түүний тархин дундуур хүнд дөнгөөрөө татсанд үхэтхийн унав. Тэр хоёр хуягийн түлхүүрийг авч гав гинж, дөнгөнөөсөө яаран саллаа. Намбаа хуягийн аманд даавуу чихэж гарт нь гав хийгүүд бүсээр нь ягштал хүлж байхдаа,

- Эр хүн олзанд, эрвээхэй зуланд гэгч энэ дээ. Шунаад байгаа алт нь бөөрөнхий чулуу шүү дээ гэж инээн хэллээ. Намбаа, Базар хоёр хуягийг өөрсдийнх^{оо} оронд цоожлоод гарч явлаа. Одоо нэг газраас унаа залгаад жилийж өгнө дөө гэж Намбааг хэлэхэд Базар

- Урьдаар намайг гүтгэсэн бүдүүн ламынд очно.

- Хүн олонтой газар руу явж хэрэггүй. Сэжиг авна.

- Хашаандаа ганц гэр. Яагаад намайг хулгайд сэрдсэнийг нь мэдье. Бас таны тааврын үнэн эсэх нь ч тодорно гэж Базар зүтгэсээр Гандангийн дэнж өөд гарч ламыг хашааг давж, хаалганы түгжээг мултлан гэрт нь сэм оров.

- Бос! гэж хэн нэгэн хүн зандран хучлагыг нь хуу татахад нам унтсан лам цочин сэргэж янцаглан өндийж, дэргэдээ зогсож байгаа хоёр хүнийг гайхан харснаа Базарыг таниад царай нь хувхай цайлаа.

- Та намайг алтан бурхны гүжир хэрэгт унагасан байх аа! Би тантай эрлэг хаанд очиж нүглээ шүүлгэхээр ирлээ гэж Базарыг хэлэхэд лам түүнийг суллагдаад ирлээ гэж санаад айсандаа

- Үнэхээр миний нэг алтан бурхан алга болох нь болсон. Чухам чамайг авсан, үгүй хоёрыг би мэдээгүй л дээ. Хууль цаазаа барьсан түшмэл нь буруу ташаа болсныг нь мэдээд чамайг тавьсан бол яамай. Ухаантан мэргэд үнэнийг ололгүй яах вэ. Ах лам нь хилс болсныг хожуу ухаарч очиж нүглээ наманчилж хэлсэн шүү... За хүү минь, тийшээ суу! Хоол цай зэхье. Ядарсан байлгүй яах вэ гэж хууран аргацаан өнгөрөөхийг боджээ. Гэтэл Базар хуягаас авсан хутгаа гарган ламын зузаан харвинд хүргэж,

- Би оргож явна. Үнэнээ хэлэхгүй бол дүрлээ шүү. Намайг ямар санаатай хулгайд гөрдсөнөө хэл! Дахин мэхлэх гээд байвал амины чинь хохь! гэж шүд зуун хэллээ. Хутганы үзүүр харвин руу нь ороод байх шиг санагдахын сацуу лам тэр залуугийн царайг ажиглах эзгүй хашаанд

алчихаад явахаасаа буцахгүй шинжтэй харагдав. Үнэнээ тоочиж, бүх хэргийг Агваанлуvsсанд чихэж амиа авч үлдэхээс өөр арга үгүй болсныг лам ухаарчээ. Тэгээд лам хуйвалдааныхаа тухай нэгд нэггүй яриад,

- Ах ламыгаа өршөө! Дүв⁺-инг гуйгаад байхаар нь аргагүйн эрхэнд амьа нь дагасан юм. Ийм муухай нүгэлтэй чивэлтэй юм байх уу, гэж залбирна.

- Аминд тулсан цагт нууц гэгч байхгүй болсон амьтад шив. Нэгийгээ барьж идэхээс буцна гэж үү хэмээн Намбаа зэвүүцэн хэлэв.

- За тийм бол намайг гүтгэснийхээ шанд авсан алтан бурхнаа аваад аль! гэж Базар тулгахад лам “Нэгэнт ийм юманд ороолдож нэрээ хөөдсөн^o өс хойш тэр бурхныг өгнө гэж ярихгүй. Зовлонгүй орж ирсэн тийм алтыг яалаа гэж тавиад туучих вэ. Нэгэнт өштөн эзнийа нь заагаад өгсөн байхад алтан бурхны төлөө аминд арай ч хүрэхгүй биз. Ядаж өөрийнх нь юм биш шүү дээ” гэж лам бодоод,

- Ламтан нь түүнийг чинь инжаанд наймаалчихсан гэвэл

- Та бол түүнийг яаран зарахдаа тулсан ядарсан хүн биш. Түүнийг би мэднэ. Алтан бурхандаа хайртай юу, аминдаа хайртай юу? гээд Базар чичээд орхитол хутганы үзүүр ламын зузаан харвинг халцлан цус шүүрэв.

- Ээ бурхан инь! Ёо ёо, аллаа! гэж лам дуу алдаад, “Энэ чинь тэр чигээрээ ландрам биш үү” гэж бодонгуут,

- Одоохон одоохон гээд уухилан босож авдраа уудлан далдын далд хийсэн алтан бурхнаа авч өгөхдөө “Хайран юм, хайран ч юм, шингээж чадсангүй” гэж амандаа үглэжээ.

- Та гэрийн ард байгаа пүнзнээс эмээл хазаар олж ав! Би энэ ламыг хүлээтхье гэж Намбаад хэллээ. Базар бүдүүн ламыг дарж унахад амь л гарч байвал хүлүүлэх ч яамай гэж санасан бололтой өчүүхэн ч эсэргүүцсэнгүй. Базарыг гэрээс гарч ирэхэд Намбаа,

- Нэг дориун эмээл, мөнгөн хазаар хоёроос өөр юу ч алга байна гэв.

- Сур, дээс байвал авна шүү. Замдаа морь бугуйлдана. Алтан бурхан байхад эмээл хазаар байгаатай адил гээд Базар юмыа нь онгичиж эвхээстэй татлаганы дээс олж авлаа. Тэр хоёрыг ламынхаа явахад од шуугдаж Богд хан уулын зүүн ташлан дээгүүр цолмон тодоос тод гялалзана.

- Богдын хүрээний хонхроос гарч амжаагүй байтал нар гарах нь уу даа гэж Базарыг санаа зовнингүй өгүүлэхэд,

- Бид хоёрыг унаажаад талийж өгсөн гэж бодоцгооно. Хоёулаа Богд хан уулынхаа аглаг ойд бүгж өнжье. Тэгээд шөнө болохоор айван тайван сайн унаа олж аваад хөдөлье гэж Намбаа хэлээд өмнө зүгт хөглийн бараантах их уулыг чиглэн шуудхан алхав.

- Олон жилийн үхсэн чийг бам дүүрч амьд амьтан байхын эцэсгүй болсон шоронгийн мухарт

нэг насаар хадагдсан гэж санан үе үе гутрал цөхрөлийн туйлд хүрэн алдаж байсан анд хоёрын сэтгэл тэнгэр мэт тэнүүн, баяр баясгалан дүүрэн явлаа.

Арван гуравдугаар бүлэг

Дархны бодол

Ховорхон тохиох авьяасыг үл энэрэгч

Хотол түмний аранга нь болой

Гэрийн баруун талын орон дээр царай нь хохийж цайсан дархан Сүх хэвтэнэ. Түүний нүүрэнд усан хаван гүйж цэлхийгээд нүд нь онийж үрчлээ атриа нь тэнийсэн мэт харагдана. Нилээд амьсгаадангуй байх нь дотуур хаван ихийнх бололтой.

Хэвтэрт орсоор сар дөхөж байгаа аж. Туслагч Сэр-Од түүнийг хярамбаг болтол жанчиж өшөө хорслоо тайлаад гадаа гарган хаяжээ. Ухаангүй хэвтэж байсан өвгөнийг Пагма арайхийн гэрт оруулж цус нөжнөөс нь салгаад шөнө сэм явж эмгэнд нь хэл хүргэсэн аж. Намсрайг хамт явалцахыг өвдөг сөгдөх шахам гуйгаад бүтсэнгүйд эмгэн арга буюу ганцаараа хүрээ оров. Эмгэн үхлүүт хэвтэж байгаа ханиа үзээд тамгынхны зарим нэг уян сэтгэлтэйнх нь зүрхийг шимширтэл уйлжээ. Эмгэний уй гашууг сонссон Сэр-Од “Цаад шулмын чавганцаа нүдэнд үзэгдэж чихэнд сонсдохгүй газар зайлуул!” гэж агсрав. Бядал муутай эмгэн өвгөнөө арайхийж гэрийнх нь бараа харууллаа.

Өвгөн арваад хоног шархны халуун болж хааяа ухаан балайран дэмийрэхдээ хүүгээ ярьж, Сэр-Одыг харааж зүхдэг байв. Түүний бие нэг үе сайжрах төлөвийг олсон боловч бүрнээ сайжирч гүйцэх өдий байлаа. Хүнд шүүлтэд тэнхэл алдан туйлдсан хөгшин хүнийг үрээ санагалзах сэтгэлийн зовлон давхар нэрмэж байв. Эмгэн үзсэн, сонссон арга засал бүхнээ хэрэглэж хичнээн оролдовч Сүхийн бие илаарших нь бүү хэл, өдөр ирэх бүр дордсоор байлаа. Арга тасарсан эмгэн өвчтэй ханийнхаа сэтгэлийг сэвтээхгүйг хичээн лам нарт нуувраар өргөл барьц базаан ном уншуулж хүрээний дацанд хурал хуруулавч тус болсон нь үгүй.

Гэрт орохоор өвчтэй ханийн царай харж, гадаа гарахаар сураг тасарсан хүүгийн барааг горьдон харгуй замын алсыг ширтсээр хаврын сарыг барж байгаа эмгэний царай харлаж, орог саарал үс нь энэхэн зуур цав цагаан болов. Өвгөнийхээ эдгэрэхгүй байгааг түүний бурханд сүжиггүйгээс болов гэж эмгэн бодож байлаа. Тэгээд өвгөнөө ятган үгэндээ оруулж чадвал бүх юм сайнаар эргэнэ гэж итгэх учир нэгэн өдөр

- Өвгөн минь, чи дээдэст тэрсэлсээр ийм хагацашгүй зовлонд уналаа. Аягүй бол Агваанлуvsан дүвчин хараал хийсэн ч байж болно. Хэдэн сайн лам залж гүрэм хийлгэе. Чи минь лам бурхандаа сайн сүсэглэ! Тэгвэл лха таван тэнгэр өршөөн нигүүлсэж гай барцадаас салах байх. Минийхээ үгэнд орооч дээ, өвгөн минь гэж уйлагнан гуйхад өвгөн,

- Эмгэн минь, ус уухын хувь гүйцээгүй бол ингэж байгаад босно биз. Би нүгэл хилэнцтэйдээ биш, Сэр-Одын зодуураас л болж доройтлоо. Мухар толгойтнууд юугаа мэдэх вэ дээ. Тэд чинь зовлонтой газар улай үзсэн хэрээ шиг шавчихдаг улс. Тэдэнд юмаа дэмий гарздах хэрэггүй. Намайг хадан гэртээ очлоо ч гэсэн та хоёр хэдэн малтайгаа үлдсэн чинь дээр гэж Сүх хэлэв. Өвгөний гүдэс шулуун занг ямар ч зовлон гуниг нугалж чадсангүй. Өвгөнийхээ эргэшгүй эрс шууд үгэнд эмгэн гомдож “Хөөрхий өвгөнд минь ханиад ч бараг хүрдэггүй юмсан. Одоо юу

болох нь энэ вэ. Ганц удаа ч гэсэн бурхан багшдаа залбирах нь яана даа. Тэгвэл мөн ч их зовлон хагасрахсан. Өвгөнийг минь муу зүгийн юм хорлосон болоод чигээрээ дуусаж байна уу даа. Миний үйлийн үр ийм юм биз” гэж бодон бодон уйлна.

Сүх эмгэнээ гиншин уйлаад байхаар элэг эмтрэн өрөвдөж

- Эмгээн! Үхэх, төрөх хоёроос өөр үнэн юм энэ хорвоод үгүй. Хүн гэдэг төрөхдөө заяасан эцэг эхээ баярлуулж, үхэхдээ төрөл төрөгсдийнх^{оо} нус нулимсыг бардаг нь хорвоогийн жам шүү дээ. Намайгаа өнгөрлөө ч гэсэн уйлаад яах вэ. Мөрөн мэт нулимс асгаруулавч үхсэн амьтан босох биш. Тэгэхээр сэтгэлээ хатамжилж сууя даа гээд хаван гүйсэн монцгор хуруугаараа эмгэнийхээ нулимсыг арчаад

- Харин хүүтэйгээ амьд уулзахын учир байдаг юм уу, үгүй юу гээд санаа алдав.

- Хүүгээс минь сураг чимээ сонсогддог ч болоосой. Тэр зүгээс нисээд ирж яваа шувуу ч гэсэн сайхан харагдах юм. Хүү минь яаж яваа бол доо. Дүвчин ламтнаар мэргэлүүлэх юмсан гэж эмгэнээ өгүүлэхэд Сүх,

- Хүүгийг минь ирүүлэх байтлаа хар гүжирт унагаад орхив гэж үү? Тийм чонын гөлгийг чи юундаа шүтнэ вэ? гэхэд эмгэн нь дуугарсангүй, харин “Ламтанг яаж тэгж хэлж болох вэ. Ай бурхан минь өршөөгөөрэй! Тандаа хар буруу санаагүй шүү” гээд залбирчээ.

- Хүүгийхээ хойноос явдаг ч болоосой. Зовлогоо дааж босч чадахгүй хүн чинь яах билээ. Хүү минь овоо золбоотой юмсан. Нэгэнт хилс ташаа хэрэгт орсноо ухаарсан бол ч мултрах арга олдоно доо. Тэгэвч хичнээн ухаан сийлээд ч гарч чадахааргүй юманд хийчихсэн байвал яах вэ. Сэр-Од тийм гоомой юм хийхгүй. Хүнийг ястай нь хатаах л юм бодож олох хүн. Би ч хичнээн удав гэж. Харин чи минь л үйлээ үзэх байх. Чамайгаа цор ганцаар орхиод явна гэхэд утсан чинээ улаан гол минь тасрахгүй зовоох байх даа гэж Сүхийг хэлэхэд эмгэн нь эхэр татан,

- Өвгөн минь билэг дэмбэрэлгүй юм битгий ярь даа гэв.

- Танайх хониндоо явахгүй яачихаа вэ. Хонь газрын мухарт хүрлээ гэсээр Намсрай орж ирэхдээ “Муусайн гуйлгачингууд” гэж аман дотроо хараахыг Сүх сонсжээ. Намсрай залан болмогцоо Сүхийнхнийг тоохоо больж, охиноо Сэр-Одын хатан болгоход Базарыг тотгор болно гэж бодох учир Сүхийнхийг хүний сайн сайханд гай болсон хар овоохой гэж зүхдэг болжээ.

- Наад толгой дээрх чинь чамд гай болох нь ээ гэж Сүхийг хэлэхэд Намсрай яачихсан юм бол гэж бодон өвгөний нүүр рүү гайхан харснаа малгайгаа авч эргүүлж тойруулан үзээд өмнөх нь инээдэмтэй.

- Чиний энэ эрх зэрэгт бэт шунадаг чинь чамайг юунд хүргэдэг бол д’ю. Ямар их гай чирэх бол? Түрүүч нь цухалзаж л байна. Эрх ямба ер нь хүнийг эвддэг юм шүү. Чи ингэж явж хүн дүрсээ алдав даа гэж Сүхийг хэлэхэд,

- Бүү галзуур! Миний яаж явах нь чамд падгүй. Намайг зэрэг жинстэй болсонд чи бүү атаарх! Харц язгууртай төрсөн өөрсдийнхээ заяанд гомд! гэж Намсрай омгорхон загнаад гарав.

- Харж байна уу, энэ золигийг... Манайхыг бараадаж ганц охиноо хүн болгосноо мартжээ. Ухаанд нь ухна үхсэн мондийг доо... гэж Сүхийг уурсахад эмгэн нь “Тусаа бүү дурс, тусыг бүү март!” гэсэн үг байдаг биз дээ. Үхэх хүний зан нь хувирдаг гэдэг ч бас үнэн байх. Өвгөн минь хүн рүү үсчиж загнадаггүй сэн. Одоо шал өөр болчихож. Яана даа. Балданлхам минь” гэж бодон буруу харж ханцуйгаараа нулимсаа арчаад гарч уяатай тэмээ авч хониндоо мордов.

Наран ээж, найртай салхи үлээсэн дулаан сайхан өдөр байлаа. Гуу жалга, бэл хөндийд яргой цэнхэртэх нь үзэх нүднээ чимэгтэй. Хааяагүй нялх ногоо урган агь нүдэлжээ. Нуур мөрнөө мөрөөдсөн усны шувууд цэлмэг тэнгэрт зэл татан ганганан гунганан ниснэ. Урин цагийн сэтгэлд зохист эл байдал хөөрхий эмгэний гунихралыг хагалсангүй. Эмгэн яргой хөөж одсон хонио гүйцэн эргүүлээд тэмээний алхаанд бүүвэйлэгдэн гүн бодолд дарагдаж явна. Ганц хүү нь алс газар сураг ажиггүй болж насных нь хань өвчинд нэрвэгдэн шаналж буйг санахад өөрөөс нь илүү зовлонг хүн энэ хорвоод үгүй мэт. Гайцхүү зовлонг тэвч гэсэн лам багшийн сургаалыг сүслэн дагасандаа л сэтгэлээ чанга барьж яваа аж.

“Аль насанд хийсэн үйлийн үрээр би ингэж өтөлсөн хойноо сэтгэлийн там эдэлнэ вэ. Бурхан багшийн сургаалыг алгасалгүй дагасаар өдий хүрсэн бус уу? Гэвч хүн нүглээ мэддэггүй юм гэсэн... Үхэхийн завсар үрээс минь салгаж зовоохын учир юу вэ? Өвгөн минь, дүвчин багшид хар санах юм. Буяны мөд хөөсөн лам багш минь яалаа ч гэж тийм хилэнцтэй үйлийг хийх вэ дээ. Балданлхам минь, хэлэх ч юм биш” гэж эмгэн бодно. Эцэг хүү хоёрын тухай олны ам дамжсан элдэв яриа эмгэний сэтгэлийг илүүтэй зовооно.

- Дархан Сүх нэг насаар бурхантай тамцаглаж явсныхаа лайг одоо эдэлж байгаа юм. Түүнийг үхэхэд ганц хүүгээр нь толгойгий нь түшүүлэхгүй гэж бурхан залхаасан юм байх.

- Дархны хүү чинь төрөлхийн хулгайч шинжийн хүн юм гэнэ ээ. Тиймдээ бурхны оронд очоод бурхан хулгайлсан юм гэнэ шүү.

- Нутагтаа байвал Базар энэ хошууныханд амар заяа үзүүлэхгүй юм гэнэ дээ. Тэгээд дүвчин ламтан түмэн олныг зовлонгоос гэтэлгэх гэсэндээ түүний энд хийх хэргийг нь тэнд хийлгэжээ. Чадалтай эрдэмтэй лам гэдэг холын юмыг хардаг байна шүү.

- Бурханд харш санаатай хүнийг илрүүлсэн гэж Агваанлуvsан дүвчинг Богд гэгээн хөхүүлэн шагнасан гэнэ.

- Бурхан шашиндаа сүслэхгүй бол энэ ба хойт насандаа өөдлөхгүй гэдэг чинь яг үнэн юм байна. Лам бурхандаа залбирч явахыг үе удамдаа хэлж сургамаар юм.

- Сүхийнтэй ойртвол хаяа хавиргандаа гай болно гэж лам хуврагууд айлдсан гэнэ гэж хэний амнаас гарсан нь үл мэдэгдэх дам яриа хошуу нутгаар нэг тархжээ.

Бурханд туйлаас сүсэглэдэг эмгэн ийм яриад сонсоод яахин сэтгэл амгалан байх билээ. Дөрвөн цагийн эргэлтэд хүүгийнхээ хойноос зовниж бурханд залбиран сууна. Өдөржин

шөнөжин эрих татан маань уншиж бурхандаа зул хүж өргөвч хүүгээс нь сураг үл дуулдана. Сэтгэл санааны ийм өвчинд мэрүүлсээр бие эрүүл ч нойр хоолондоо муу болжээ. Эмгэн хамаг амьтан амилан сэргэж өсөн төлжиж байгаа хаврын байгалийг таашаан шохоорховч бие сэтгэл тэнийсэнгүй, түмэн зүйлийн гунигт бодолд автан толгой гудайлган уруу царайлж явна.

Эмгэнийг хонинд явсан хойгуур Юмжирдулам Сүхийнд орж гал түлж, цай ундыа нь хийж өгч байлаа. Намсрай охиноо Сүхийнд оруулах тун ч дургүй, харин ч гэр орныхоо ажлыг хийсэнгүй гэж зэмлэхэд бүсгүй үг дуугүй өнгөрөөгөөд зав чөлөө гарвал өвгөний рүү гүйдэг байжээ. Хоёр хөгшний сэтгэлийн гунихралыг хуваалцаж байгаа ганц хүн нь Юмжирдулам юм. Бүсгүй гал түлж цай чанаж суухдаа

- Өвөө, хүүгээс чинь сураг алга уу? гэж өөрөө ч тэсгэлгүй хүсэн хүлээж, эх эцэг хоёроос нь дутуугүй санаа зовж байгаа хүнийхээ тухай асуув.

- Өвөл өнгөрөөд хаврын сар шувтрах гэж байхад сураг гарвал гарах болсоон. Одоо ч горьдлогогүй шив дээ гэж Сүх арайхийн хэлэв. Түүний хоолой зангирч, нүдид нь нулимс нь өөрийн эрхгүй бөмбөрөв.

- Пээ, яасан гашуун май вэ! гээд утаанд нүд нь хорсогч болон хайч аван галаа төнхөх зуур нулимсаа арчиж амжав. Тэгээд босож өвгөнийг түшин өндийлгэж аягатай цай өгөв. Өвгөн цай оочих зуураа “Энэ нэг хүний үр бас л бид хоёртой адил хүүгийн минь хойноос сэтгэлээр унаж гүйцлээ. Бие биедээ сайн л хоёр байж дээ. Ханилах заяагүй юм байлгүй” гэж бодолхийлж бүсгүйг харан харан өрөвдөнө. Тэгээд Юмжирдуламтай энгүүн юм ярьж байгаад ухаан санаа авахуйц хэдэн үг хэлье үү гэж бодож суутал нь Намсрай охиноо дуудах сонсдов.

- Гялайлаа, охин минь! Аав чинь дуудаад байна. Явахаас биш дээ гэв.

Сүх дархан хажуулдан хэвтээд элдвийг бодно. Эзгүй гэрт түүний бодолд саад болох юм нэгээхэн ч үгүй.

“Тэнэмэл нохой шиг нүдүүлчихээд ингэж ч хэвтэх гэж дээ. Ноёд түшмэд намайг хүн гэж үзэж явсан юм гэж үү? Тэдний сурсан нь зусар зан, чаддаг нь башир арга болохоор хоосон сайсарч миний гарын ялихгүй жаахан урыг завшиж л байжээ. Энд тэндхийн ихэс дээдэстэй эдэлж хэрэглэж байгаа юмаараа харгалдаж сайрхах гэсэндээ л надад бие биеэсээ илүү сайн хүн болох гэж өрсөлдөж байсан биш үү? Тэгснээс ч намайг өдийд энэрэх сэтгэлгүй ийм болгоод хаяж байгаа юм. Би ч яах вэ, нэг их сүрхий уран хүн биш. Гайхалтай, гайхалтай урчууд нохой шиг шогшиж яваад үхлээ. Галуутайн хүрээний гол шүтээн Балданлхам бурхны залран ирж байгааг их дуганын хананы хэмжээгээр зурсан “Уран бийрт” гэж нэршсэн зураач Билэгт яалаа. Нэг насаар хүрээ хийд, лам хар айлын бурхан бүтээсэн бус уу? Дөчөөдхөн настай байхдаа саа гариг дайрч салга болсон. Тэгээд гуйлга гуйж яваад Галуутайн хүрээний хог дээр өлбөрч үхлээ. Хамаг бурхнаа бүтээлгэсэн хүрээний ихэс лам нар түүнийг хайхарч үзсэн үү? Үгүй... Ямранз дархан гэж алдартай уран хүн байлаа. Түүний мөнгөөр урлаж байгаад баралгүй орхисон Сэцэн Сарт-Уулын хошууны хүрээ цамын байдал ай даа мөн ч гайхамшигтай сан! Нэг товхыг дарахаар бүх оролцогсод нь дор бүрнээ толгой гар, хөлөө савчуулаад бүждэгсэн. Өөр нэг товх дарахаар хөгжим нь дуугардаг болно гэж Ямранз гуай

өөрөө ярьж байж билээ. Гэтэл өвчлөөд түүнээ дугуу чигээр нь орхисон. Тэр гайхам сайхан юмыг дуусгасан бол өдийд үзсэн харсан нүд хичнээн бахтай байх вэ! Авьяас билэг, ур ухааныг хайрлан дээдэлж байгаа ихэс дээдсийг би ер үзсэнгүй. Авьяаст хүмүүнийг дээдээ байг гэхэд доод зэндааны түшмэлийн дайтай үзэх нь яана даа. Ноёд түшмэд нас элэгдэхэд ухаантай нь ч, мулгуу нь ч, нэг нь залгамжилж, авдаг алба гувчуураа аваад л зодох хүнээ зодоод л байж байх юм. Тэгвэл уран ухаантны бодож сэдсэнийг хэн ч гүйцээж үл чадна. Хошууны ноёд түшмэд ялихгүй хуучтай болмогцоо л Да хүрээ, цаашлаад аль дуртай газраа л тонилж өгөх юм. Тэд маниас гувчуурдсан хошуу сангийн мөнгөөр л тэгж туйлж байна. Нэг түшмэлийн оронд Ямранз гуайг явуулж сувилуулсан бол нэгэн сайхан юм бидний гар дээр хоцрох байлаа. Их, бага ямар ч түшмэлийг нэг газар очиход хөл алдаж сүйд болох мөртөө гартаа уртай, тархиндаа ухаантай хүнийг үл тоодог нь юутай харамсалтай вэ. Харц ардууд уран ухаантан хүнээ гойд хайрлах юм. Гэтэл ноёд түшмэд хайхрахгүй нь хачин. Түшмэл нь түшмэлдээ хэрэгтэй болохоор тэр үү? Эсвэл ахар ухаантай нь түшмэл болчихдог байна уу? Бас ч мэргэн ухаантай ноёд түшмэд байгаа л дуулддаг. Юутай ч гэсэн ноёд түшмэдийн мунхаг, арга зальтай нь олої дог. Тиймдээ ч ухаантайгаа өөд нар харуулдаггүй байх. Тэгээд л ухаантай доодос нь дээдэх мунхаг түшмэдийнхээ санаанд тааруулахгүй бол амаараа шороо үмхдэг байх. Манай хошууны ноёа түшмэл нараар жишээд бодоход яг л тийм бололтой. Өөрийн санаа зөв байтал түүнээ чөдөрлүүлж тушуулна гэдэг бас амаргүй еэ!

За за, “Төрийн төлөө оготно боож үхэв” гэгчээр энэ хошууны ихэс дээдсийн олиггүй мууг түүж бодож гүйцэх биш. Миний санаа зовсноор сайн сайхан болчих биш.. Гэлээ ч “Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө хатдаггүй” гэсэн мэргэн үг байдгийг бодоход эрхбиш сайхан цаг ирмээр юм даа” гэж өвгөн Сүх бодон тооноор тунаран цэнхэртэх тэнгэрийг харан хэвтэнэ. “Гадаа гардагсан бол мөн ч дулаахан сайхан өдөр болж байгаа юмаа даа. Тэнгэр цэлмэг, салхи хөдлөхгүй байхыг бодоход мөн ч сайхан байгаа даа. Үүдээр толгойгоо цухуйлгачих тэнхэлтэй ч болоосой. Тэгвэл эргүү юм шиг бодол болж байхгүй сэн. Хүн өвчтэй юм уу, хийх юмаа олж ядсан үедээ л хэрэгтэй хэрэггүй юм их боддог байх. Өдөржин ингээд хэвтэхэд есөн шидийн юм санаанд орохыг яана! Ер нь өвчтэй хүн сайхан юм боддог гэж үү! Болж л өгвөл дэмий юм бодож сэтгэлээ зовоохгүй байх юмсан” гэж бодоод санаа алдсанаа тоононоос мултарч ядан байгаа нарны сүүлчийн бацрагийг хараад, эмгэн минь ирэх болж дээ гэж санан чих тавьж чимээ чагнасхийнэ. Эмгэнээ гадагшаа удаахан явах хооронд биеэ гэнэт муудах бий дээ гэж нэгэнт дор орчихсон энэ өвгөн санаа зовдог юмсанжээ.

Арван дөрөвдүгээр бүлэг

Эцгийн сургамж

Төрсөн эцгийн нас элж өнчрөн хоцрох нь

Тэнгэр ниргээж газар еврэх лүгээ адил буюу

Шөнө нилээд орой болсон хэр нь Сүх эмгэн хоёр унтаагүй л байлаа. Эмгэн өвчтэй өвгөнийхээ нойрсохыг хүлээзнэн тулганы зүүн талаар бүхэл хажуулаад эрихээ гүйлгэж элдвийг бодолхийлэн байхдаа хааяа өндийж өвгөнийхээ чичивгэнэн хөдөлж байгаа зовхийг ажиж унтаагүй байгаагийг нь мэдээд эргэж хэвтэнэ. “Ай хөөрхий, энэ хорвоо яасан ч хатуу юм билээ дээ. Муу өвгөн минь шөнө хонох тусам дордоод л байх юм. Хүү минь хүрээд ирдэгсэн бол зовлон нимгэрэхсэн. Манайд яагаад ийм их зовлон нүүрлэв ээ? Өвгөн бид хоёр амьтан ах дүүд хар буруу санаж яваагүйсэн. Надад хийсэн нүгэл хилэнц гэж даанч баймгүйсэн. Гэтэл өвгөн, хүү хоёрыг минь ийм болгочих гэж. Бүсгүй төрөлтөн болоод ч тэр үү, амьд бүхэнд зөөлөн сэтгэл гаргаж явлаа. Хорхой шавьж явахыг үзсэн ч тойроод гардаг байсан биш үү. Бага байхдаа ч эцэг эхийн үгийг дагаж шувууны өндөг ч хагалж явсангүй. Цаг ямагт, энэ болоод хойт насаа бодож буян санасаар өдий хүрлээ. Тэгэхэд миний энэ бодь сэтгэлийг бурхан багш олж хараагүй юм байх даа, Балданлхам минь, бурхан багшдаа муу санаж алдас болох нь ертөнцийн хамаг амьтны заяа төөргийг харж суугаа бурхан багш минь өчүүхэн шавь намайгаа яалаа гэж мартаж вэ... Буянт амьтны дэргэд миний буян юугаа базаах вэ. Санаанаас цаашгүй биз. Тиймдээ л ийм гай зовлон дайрч байгаа байх... Эсгүүл өвгөний минь хийж явсан ан ав нүгэл хилэнц хураагаа юу? Ай бурхан минь, өвгөндөө яаж муу санаж болох билээ. Энэ хүний хүчинд айлын чинээ айл болж явсаар нэгэн насыг элээв. Хөөрхий минь, заяа нь гомдчихно” гэж бодсоноо эмгэн энэ бодлоо өвгөнөө мэдчих бий гэсэн шиг түргэхэн өндийж царай руу нь харав.

Сүх гал нь буурсан гийлгэр нүдээр зулын сүүмгэр гэрэлд сүүдэртэн бараантах унь ширтэж бодол болон хэвтэхдүе өдрөө хүлээсэн өвчтэй хүний адилаар хувь заяандаа гаслан эчнээ уйлсангүй, харин ч төрөлхийн эрс шууд зан, үзэн ядах ухаан хоёроосоо болоод сэтгэл нь нэн ч чанга байлаа. Үнэн цагаанаараа явтал нь ийнхүү хилдүүлж үхлийн босгонд тулгасны учир хошуу туслагчийг амьсгал хураан хураатлаа хорсон занахаар болжээ.

- Энэ хорвоог нартай гэрэлтэй юм шиг бодож явсан гэж үү, би! Хүн өөрийн эр чадалд найдаж, болж бүтэж байна гэж санаж яваа цагтаа хорвоогийн үнэнийг хагас ухаардаг бололтой. Хүн энэ хорвоогийн бурангуй зовлонд нухлагдсан цагтаа түүний жинхэнэ нүүр царайгийг нь сая олж хардаг байх. Хорвоогийн муу бүхэн гагц мухар толгойтнуудаас ч болдог бус, отго жинстэнгүүд нь ч манийгаа зайдагнаж суудаг байна. Биднийгээ хэнийг нь хажуу хавирганаас шөргөөх нь вэ гэж жинстэй малгайн дороос отон харж, хэрэв хэн нэг нь хөдөлбөл залгихад бэлэн амаа ангайн хүлээдэг байна шүү.

Энэ хорвоод үнэн ч юм алга, энэрэхүй сэтгэл ч алга. Зөвхөн хүний сэтгэлийг илбэдэх чөтгөрийн гал шиг сүүмгэр гэгээтэй юм. Тэр гэгээнд нь хүмүүс хууртаж түүний цаана байгаа харанхуй тамыг олж хардаггүй байна.

Миний гэрт өчүүхэн хүмүүс хорвоогийн энэ үнэнийг түмэнтээ сэхээрэвч худлыг нь үнэн, харанхуйгийг нь гэрэлтэй болгох ухаан хүрэхгүйгээс цааш яах ч юм билээ дээ...

Хүү минь амьд байхад нүүр учирдаг ч болоосой. Нас бага, цус шингэний харгайгаар хорвоогийн үнэнийг ухаараагүй яваа хүүдээ л энэ бүхнийг хэлэх юмсан. Хойч үе маань ухаарч байвал бурангуй ёс ноёрхсон энэ харанхуй хорвоод гэгээ оруулах сүвийг нь нээх ухаан сийлж юуны магад вэ” гэж дархан Сүх бодол тавин хэвтэнэ.

Эмгэн өндийж мөлхсөөр дэрийн авдрынхаа урд хүрч тагийг нь авч гараа шургуулан ухаж ухаж нэг боодолтой юм гаргаж задлахад дотроос нь хадганд ороосон хүүхдийн даахь гарав. Эмгэн даахийг хэд үнэрлэсэнээ “Хүүгийг минь даахь...” гэж бувтнаад уйлагнав. Эмгэн даахиа нүүрэндээ нааж хэсэг зуур чимээгүйхэн уйлаад өвгөнөө мэдээтэх вий гэсэн бололтой хялам хялам харж нулимсаа арчин тайтгарав. Тэгээд өвгөнийхээ дэргэд очиж

- Хүүгийн минь даахь! гээд даахиа өгч

- Хүүгийнхээ даахийг авч байх үед бид хоёр мөн ч залуу сайхан явжээ гэж бувтнав. Өвгөн хүүгийнхээ даахийг үнэртсэнээ гүн санаа алдав. Нүдэнд нь нулимс мэлмэрснээ ганц дусал нулимс өрөөсөн шанаагийг нь дагаж зулын гэрэлд од харвах шиг гялсхийн буурал санчиг руу нь орчихов.

- Эмгэн нэгийг сонссон бололтой сэртхийн өндийж чимээ чагнаснаа

- Уяан дээр дөрөө дуугарах чинь. Өдийд хэн манайд ирэх билээ. Өнөө гайхал Пэрэнлэй чинь биш байгаа... гэж хэлээд даахиа далд хийв.

- Миний зовлогыг халуунаар нь зулгаах л гээгүй бол Пэрэнлэй өөр юугаа шиншилж ирэх вэ гэж өвгөн ууртай дуугараад үүд рүүгээ хяламхийн харав.

- Хүүш өвгөөн! Хоолойгоо засах нь хүүтэй минь юу адилхан юм бэ! Хүү минь биш байгаа даа! гээд эмгэнийг шимтэн чагнахад өвгөн,

- Хаанаас даа, дэмий юмаар сэтгэлээ хуурч яах нь вэ гэв. Үүдэнд хүн ирээд хөлөө хооронд нь хавиран цохиход эмгэн

- За тэр! Эс хэл лүү! Хүүгээс минь өөр ингэж гутлынхаа шороог гүвдэг хүн манай энд байхгүй гээд ухасхийтэл эсгий үүд сэвхийн Базар орж ирлээ.

- Балданлхам минь өршөө! Үр минь! гээд эмгэн мэнд ус ч үгүй хүүгээ зуурч аваад санаа зовж асар удаан хүлээсэн сэтгэлийн гунигаа тайлж нус нулимсаараа будаж гарлаа. Эцэг нь хүүгээ хараад ядаж өндийгөөд суучихья гэж санаад хэд хүчлэн зүтгэсэн боловч чадсангүй.

- Ээ, чааваас! гэж өвгөн гаслантай дуугараад тамирдан амьсгаадав. Эцгээ өндийх гэж цөхрөнгөө барж байгааг харсан хүү нь нэг сугандаа эхийгүү тэвэрсээр дэргэд нь хүрч амрыг эрэн золгов. Эцэг, хүүгийхээ хоёр хацрыг үнсээд, ядарч гандсан хүрэн царайгийг нь удаан харж баясгалантай инээмсэглээд,

- Миний хүү тийм сүрхий занганаас мултраад ирэхийг бодоход эр хүн болжээ гэж бахархан өгүүлээд эмгэндээ
- Хүүгээ эсэн мэнд ирчихээд байхад чи юундаа усан нүдлээ вэ! Унд цайгаа бушуу хийгээч! гэв. Эмгэн ч овоо тайтгарч хүүгээ арайхийн тавьж, хамт ирсэн хүнтэй нь золгоод өрхөө татаж галаа яаран асаалаа.
- Та нар минь сайн байцгаав уу? гэж хүүгээ лавлахад
- Билэгтэй юм гэж сайн гэхээс дээ гэж эмгэн дурамжхан дуугараад,
- Хүү минь турж эцээд нүднээс гарчихаж. Орон гэрийнхээ барааг амар мэнд харсан нь яамай даа гэж баяртай өгүүлэв. Базар нутгийн зах руу орж ирмэгцээ эцгийнхээ юу болсныг нэгэнт сонссон учир тэр тухай шалгаахыг бодсонгүй.
- Аав, таны бие одоо ямар байна?
- Сайжрах горьдлогогүй л юм шиг санагдах боллоо... гээд
- Хүү минь, чи тэр бэрх гүжир ялнаас яаж салав даа? гэж асуув. Базар хар гэрт танилцсан сайн андынхаа тухай, тэндээс гарсан арга ухаанаа ярихад эх нь бишрэн залбирч, эцэг нь бахдан сонсов. Хүүтэйгээ амьд уулзахгүй нь гэж эргэшгүй бодож байсан өвгөний элэг дэвтэж сэтгэл нь тэнийгээд, хүүгээрээ өргүүлэн байж өндийн суугаад хол ойрын сониныг ярьцаалаа.
- Буянтай гэгддэг улс нь л бузар хэрэг үйлддэг юм биш үү гэж хүүгээ хэлэхэд эцэг нь
- Яг үнэн, хүү минь! Миний хүү аргагүй л юмны наад цаадыг ухаж мэдэхтэй болж байгаа юм байна гэж баясав.
- Ээж Агваанлуvsан дүвчинг амьд бурхан гээд л байдагсан. Гэтэл амьд бурхны маань арга заль, гэмгүй хүнд учруулж байгаа гай зовлонг харж байгаа биз дээ гэж Базарыг ярихад сүсэг бишрэлтэй эх нь
- Хүү минь, бид л энэ насандаа ийм зовлон үзэх зураг тавилантай болоод тэр биз. Бурхан биднийг нигүүлсээд л бид чинь одоо ингэж халуун амь, бүлээн зүсээрээ уулзлаа шүү дээ гэж хэллээ.
- Харин Да хүрээг бурхан, лам хоёроос олон юмгүйгээр нь бурхны орон гэж хэлж болох юм. Тэгсэн хэр нь тэд чинь зовсон түм олонд тус болох санаагаар тун ч бага юм. Гуйлгачи ядуус нь тоолж баршгүй олон юм. Яахаараа ч тийм болон болчихдог юм бүү мэд.
- Лам, бурхан олшрохоороо тэгдэг юм. Миний хүү нүдээ нээж ертөнцийн явдлыг сайн ажиглаж, яагаад ийм байна вэ гэдгийг тунгааж явдаг юм шүү гэж эцэг нь хэлэв.

Базар Намбаа хоёр айргийн тос самарсан амтат шаргал цайнаас ганц ганц аягыг уумагцаа л хамаг биеийнх нь хөлс ус мэт урсах нь хүнд эрүү шүүлтэд тамираа барж, алс замд довтолгон

алжааж зүдэрснийх ажээ. Эмгэн өвгөндөө шинэ шөл уулгах гэж өчигдөрхөн төхөөрсөн хонины шинэ махнаас эвдэж гал дээр үйлээ.

- Муу хүү минь сарьсалж гүйцжээ гээд эмгэн толгойгий нь илэв.

- Та хоёр чинь гуравхан хоног яваад ирлээ гэж үү? Яаж унааждаг байна? гэж Сүхийг сонирхон асуухад эмгэн

- Шувуу шиг хурдан явжээ гээд гайхан шогшров.

- Унаа залгах шиг амархан юм хаа байх вэ... Танай хүү бугуйлд үнэхээр сайн юм. Шөнө адуун дотор ороод явуут дундаа сайн морийа нь шилж олоод бугуйл шидэхдээ тун ч алдахгүй юм аа. Тэгээд бугуйлаараа хөтлөөд явчихаар чинь хүний мөр хар үлдэхгүй. Эзэн нь ч барагтайд сэжиг авахгүй шүү гэж Намбаа хүүгий нь магтав.

- Шөнө адуу хөөцөлдөж явсан биш дээ. Яаж чаддаг юм бол оо гэж өвгөн толгой сэгсрэв.

- Бид хоёр замдаа удаагүй хэрнээсээ өнөө өглөө үүрээр зүүн нуруунд ирээд модон дотор бүгж өнжлөө шүү дээ. Өдрөөр наашаа явбал нутаг нь болохоор Базарыг захаас аван андахгүй. Тэгээд л хэрэг бишдэнэ гэж хаширлахаас аргагүй боллоо. Өв÷тэй эцэг дээрээ өөрийн дураар давхиад ирчихүж болдоггүй мөн ч бэрх цаг шүү гэж Намбааг ярихад эмгэн

- Үйл лай гэж ÷ тэнгэрээс хийсээд ирж байгаа юм даа гэж үг нэмэн залбирч

- Энүүгээрээ л дуусах болтугай! гээд босож амандаа маани уншин хүрд эргүүллээ.

- Үй ёай гэж ч тэнгэрээс хийсээд ирж байгаа юм биш дээ. Ноёд түшмэдийн л балгаар мань мэт нь зовлон зүдгүүр үзэж байгаа юм гэж Намбааг хэлэхэд өвгөн,

- Тун үнэн үг... Мухар толгойтнууд ч бас ялгаагүй гэхэд,

- Эд наргүй бол ч ёстой жаргах байх аа гэж бүсээ тайлан нөмгөлж байсан Базарыг дуугарахад эмгэн

- Яаж тэгж хэлж болох вэ, хүү минь! Ихэс дээдэсгүй бол бид чинь толгойгүй хөл болно шүү дээ гэв.

- Миний хүү зөв л бодож... Энэ хорвоод ганц бид биш, үй түмэн амьтан өөр өөрийнхээ оногдсон зовлонг эдэлж байна. Жаргалдаа ташуурсан цөөхөн лам ноёд манийгаа эвлэж ховлож эвхэж түрийлж сурчихсан нь хачин шүү. Тэгээд бүр дандаа дийлнэ гээч. Энгийн номхон ард нь буулганд даруулсан шар шиг л хорвоогийн зовлон зүдгүүрийг тэвчээртэй өнгөрөөж сурчихсан нь гайхалтай. Ингэж байх тавиланг бурхан багшаас заяасан юм гэж мухар толгойтнуудын донгосдог нь үнэн байх учиргүй баймаар. Бурхан багш гэж юу ч байдаг юм бүү мэд. Хаа байдаг юм гэж мухар толгойтнуудаас асуухаар тэнгэрт байдаг юм гэж хэлдэг. Тэнгэрт байдаг юм бол маньдаа яаж ч сургаал айлдах билээ. Хар ухаанаараа бодоход сэтгэлд багтдаггүй юм даа. Шороон түмэн харц доодсууд муусайн лам ноёдыг сэгсрээд хаячихад юухан байх вэ дээ. Гэтэл хонины морь шиг ноолуулаад л байх юм. Яавал зохихыг би

нэг насаар бодоод олсонгүй. Миний охорхон ухаан ийм юманд яаж ч хүрэх билээ. Харин та хоёр залуу улс, сайн бодож явахад гэмгүй шүү гэж дархан Сүхийг өгүүлэхэд Намбаа “Одоо тавь шахаж байж миний залуусах ч өнгөрчээ” гээд санаа алдав. Намбаа ноёдод өширхөхдөө адуу малынх нь сорыг таслан хошуу алгасан хөөж хорслоо тайлж байснаас биш, өвгөний ярьсан шиг ийм нухацтай юмыг бодох нь байтугай сонсож ч яваагүй болохоор харанхуй цээжинд нь од харвах шиг болов. Базар аягатай цай руугаа гөлрөн бодол болжээ.

Нэгэн гэрийн халуун ам бүл учран золгож өнгөрсөн хэдэн сард амссан зовлонгоо уудлан ярьж сэтгэл тэнүүн эл шөнийг өнгөрөөсөн нь харанхуй шөнө наран гийгүүлсэн лүүгээ адил болжээ. Үүр хаяарах дөхөхөд Базар

- Бид одоо ийн байж яавч таарахгүй. Хар гэрээс оргосон бид нууцгай байхгүй бол баригдаж юу магад. Намайг тийм хүнд ялā унагаж орхисон болохоор манай хошууны түшмэдүүд намайг ийм амархан гараад ирсэн гэж яавч итгэхгүй гэж өгүүлэхэд эцэг нь тосон авч,

- Дахин тэдний гарт орохгүйг бодохоос өөр аргагүй. Одоо тэгээд яах билээ. Би гэж нэг амьдаас цаашгүй амьтан байдаг нь даанч тоогүй гэж өөртөө гомдсон янзтай хэлэвч түүний харц хүүгээсээ салахгүй байхыг хүсэх мэт.

- Аав минь, би өдөр нь ууланд бүгээд шөнө нь ирж байя. Намбаа гуай манайд байна. Намбаа гуайг энд таних хүнгүй болохоор сэжиг санах нь гайгүй биз гээд Базарыг гарахад эх нь

- Хүний үр орондоо байж болдоггүй ийм хэцүү юм байх гэж хэмээн нулимсаа унаган хоцров. Базар Юмжирдуламд сэм хэл хүргэж хонио хариулах нэрээр уулзах газрыг Намбаад захиад мордов. Маргааш өглөө нь хайрт хүнийхээ ирсэн тухай сонссон Юмжирдулам урьд урьдаасаа нэг л хөнгөн сэргэлэн болчихоод эцгийгээ хонь руу мордох гэхэд нь заавал өөрөө үвах гэж зөрсөөр болиулжээ. Юмжирдуламыг хониндоо хүрээд цааш явсаар уулын мод руу шууд яваад орчихыг харсан Наисрайд сэжигтэй бодол төрсөн учир гэртээ сууж тэсэлгүй хойноос нь мордлоо.

Нэг насны хань болохоо бодох байтугай амьд уулзана гэдэгтээ эргэлзэж байсан амраг хоёр хэмжээлшгүй баяртай учрав. Юмжирдулам уяхан хорвоогийн ариухан нулимсаараа Базарын энгэрийг мялаажээ. Тэр хоёр харавч ханашгүй янагийн хайр шингэсэн нүдээр бие биеэ харан харан баясан ярилцаж, удаан хүлээж их санасандаа байн байн санаа алдана. Тэглээ ч анхаарал сэрэмжээ алдаагүй байсан Базар бэлээс өгсөн яваа хүнийг харснаар барахгүй Намсрай мөнийг танилаа.

- Чи аавдаа сэжиг авахуулж дээ... Манай руу орой болсноос хойш битгий зүглэ! Аавдаа манайхыг хайхрахгүй байгаа хүн шиг харагдаарай! Одоо чи эндээ аавыгаа ирэн иртэл цэцэг түүгээд явж бай! гэж хэлээд Базар уулын хяр өөд өгсөв.

Намсрай мод руу ороод чимээ анир гаргалгүй шиг ийш тийш эрэлхийлэн явтал охин нь юу ч тохиолоогүй юм шиг цэцэг түүж яваа харагдав. Эцэг нь түүний уйтгартай байсан харц сэргэж, царай нь улаа бутран ягаараад цаанаа л нэг жаргалтай хүний шинж бүрдмэл болсныг ажсан хэрнээ юу гэж хэлэх учраа олж ядан тээнэгэлзэв.

- Чи хонио юунд ингэж хол гаргав аа? ǻэсэнд,

- Энд гойд сайхан ногоотой болохоор нь... гэж охин хэнэггүй дуугарсан боловч хацар нь нэг л халуу оргиод байх шиг санагдахаар нь,

- Аав аа! Хөхөө донгодохыг сонсох мөн ч гоё байна шүү. Та чагнаач! гэж хэлжээ. Намсрай толгойгоо өлийлгэн хөхөөний уянгатай донгодохыг сонсоод охиноо сэжиглэсэн хар нь тэрхүү бяцхан шувууны содон дуу мод дэмжин цуурайтан замхрахын адил сарнив.

Базарын ирснээс хойш эцгийн сэтгэл сэргэж, царай зүс нь засраад бие нь дориун болíх янз орсонд гэрийнхэн нь одоо л илǻрших нь хэмээн машид баярлан байлаа. Гэтэл энэ нь өвчтэй хүний сэтгэл санааны түр зуурын тайвшрал байжээ. Хэд хоногийн дараа Сүхийн бие гэнэт муудаж толгойгоо ч өндийлгэх тэнхэлгүй болов. Бүхнийг бурхны далдын хүч гэж гүнээ сэжиглэдэг эмгэн Доржпалам нэгэн өдөр түлээ түүх нэрээр Агваанлуvsан дүвчингийнх рүү одов.

Сүхийн биеийг хариугүй, өдрөө хүлээж байна гэж сонссон ламтан эмгэний уйлсаар бөлцийсэн зовхийг хармагцаа л түүний учрыг андахгүй таамаглав.

- Багш минь! Өвгөний маань бие тун ч муу байна. Та төлөг судартаа үзэж хөөрхий өвгөнийг минь эдгээх арга засал хайрлаж үзээч! гэж эмгэн хүлцэнгүйгээр өчөөд гэрээсээ нууж авч гарсан бүсгүй хүний толгойн чимэг барив. Сүх хэзээнээс лам хуврагийг үл огоордог хүн учир дүвчин шоогоо дурамжхан шившиж хаяад

- Бурханд сүсэглэхгүй явсны гайгаар амь насыǻ нь аваачих барагдашгүй нүгэл халзалжээ гэж зоримог айлдав. Нэг насаар мэргэн сайн лам гэж итгэн шавь орж сүсэглэж явсан эмгэн дүвчингийн эл үгийг сонсмогц царай нь зэвхийрч íулимс нь асгарч гарлаа.

- Багш ламтан минь, та өвгөнийг минь өөрийн ариун сахиусандаа багтааж нүглээс нь гэтэлгэж нааш нь эргүүлэх арга чарга хийж өгөөч! гэж эмгэн ламтны өмнө наманчлан мөргөв.

- Тон хэцүү байна. Гэвч яах вэ, надад даатгаад буц даа. Үнэн итгэлт шавь чинийхээ сэтгэлийг бодож өвгөний чинь торгоохыг оролдъё гэж Агваанлуvsан эмгэнийг явуулахад дархан залуу цагтаа эхнэртээ хийсэн, ойр хавьдаа гайхагдаж байсан гоёмсог сайхан толгойн чимэг санаандгүй суутал гарт нь орж ирсэнд баярласандаа болоод дахин дахин үзсээр өвгөн Сүхэд ном айлдахаа умартсан байжээ.

Энэ үед Сүхийн амьсгаа дээрдэж хөл гараа ч хөдөлгөж чадахгүй болжээ. Тэгэвч түүний ухаан санаа эрүүл саруул, үг хэл хурц тод хэвээр байв. Амьсгалын тоо гүйцэх дөхсөнөө хашир өвгөн гадарлаж, ухаан саруул дээрээ хүүдээ үг захъя гэж бодоод Намбааг довтолгон Базарыг авчруулав. Базар эцгийнхээ толгойг түшиж, хавагнаж гөлийсэн цонхигор царай, хөдөлгөөнгүй шахам болсон нүиййǻ нь ширтэн сууна.

- Аавынх нь дэрэн дор нэг хормойн боолт бий. Ав даа, хүү минь гэж эцгийн хэлэхэд Базар дэрэн доогуур нь гараа шургуулж баруун талд нь бар арслан хоёрыг барьцалдуулж, зүүн талд

нь зүр гур хоёрыг зэрэгцүүлж мөнгөөр товойлгон сийлбэрлэсэн эр хүн шохоорхом сайхан хормойн боолт гаргаж ирэв.

- Аав нь хүүтэйгээ уулзахгүй юм шиг совин татаад байхаар нь наадхийн чинь биеийнхээ гайгүй шиг өдөр барин тавин хийсэн юм. Үхэх төрөх хоёроос бусад нь хуурамч энэ хорвоо аав нь удахгүй орхих болсон шиг байна. Миний хүү өрх гэрээ толгойлж үүлэн чөлөөний нар шиг үзэгдээд өнгөрөх өнгөт хорвоод хүний дайтай аж төрж яваарай! Дээдэст зусаргүй, доодост дээрэлхэлгүй байхыг эрхэм болгодог юм шүү. Лам, ноёдын өмнө хэзээ ч өвдөг сөхөрч болохгүй. Аав нь тэдний л гарт амь үрэгдсэнээс ялгаагүй боллоо гэж эцгийнхээ ярихад хүү нь,

- Би тэднээс таны өшөөг заавал авна гэж андгайлсанд Намбаа

- Би ч андын ёсоор туслахад бэлэн гэж үг нэмлээ.

- Хүү минь, эцгийнхээ өшөөг авна гэдэг ганц хар толгойн хэрэг. Цаана нь зовсон олны өшөө хорсол гэдэг тун ч их бий. Өшөө хорсол авахдаа түмэндээ тус хүргэхийг умартаж огт болохгүй. Ер нь тэгээд ухаан чадал, эр зоригоор өшөө авдаг юм шүү дээ. Ухаангүй дан муйхар зоригоор зүтгэвэл түүн шиг тэнэг юм байхгүй. Сүйрлээр л дуусна гэсэн үг. Аав чинь даанч хуурамч хорвоод энэ насаа элээлээ. Үнэн юм үнэнээ олохгүй нь бэрхтэй. Үнэнийг олох гээд үзвэл өөрөө зовно. Зүгээр номхон сууя гэхээр хүний идэш болно. Авьяас чадал байвал энэ хорвоогоос хожих юмаа хожих хэрэгтэй. Чадалгүй төрсөн бол хэрээ мэдэж номхон хүлцэнгүй явахаас аргагүй. Хэрээсээ хэтэрч сагсалзâал хуурамч хорвоог ганцхан шилгээхэд хумхийн тоос шиг хийсгэдэг юм шүү гээд Сүх мэдээ алдарсан том алгаараа хүүгийнхээ гарыг илэхчээн болж, амьсгал хураах дөхсөн хүнийх гэхийн аргагүй тод дуугаар,

- Чоно эрийнхээ сайнд хоолоо олж иддэг. Чононд хэн ч хоол бэлдэж өгдөггүй. Чоно сайн эрийн гарт үхдэг юм. Муу эр чонын ам руу орохоос хэтрэхгүй. Ёстой эр хүн бол чоно шиг уралцаж байгаад үхдэг юм. Чонын үхлээр үхэж байгаа эр хүн бол ёстой эр хүн юм шүү. Муу эр чоно шиг явж чадахгүй, чоно шиг үхэж ч чадахгүй. Үнэг шиг залиар хоол олж иддэг юм. Тийм дээ ч үнэг араг савар барьсан авгай хүүхдийн гарт амиа үрдэг ч удаа ч бий гэж ярив.

Дархан Сүх үдэш болтол дахиад юу ч ярьсангүй. Түүний амьсгал давхцуу болохоос биш харц нь дөлгөөн тайван байлаа.

- Өвгөөн, та цай оочно уу? гэж эмгэнийхээ асуухад өвгөн

- Үгүй шив дээ... Харин жаахан сүү хийгээд өгөөч! гэхэд нь эмгэн аяга сүү аваачиж аманд нь барихад ганцхан балгаад

- За боллоо гэж аяархан хэлсэнд “Өвгөн минь миний гараас амсах юмаа гүйцээ вэу дээ” гэж санахаас эмгэний нулимс асгарав. Эмгэн хүүгээ зовоохгүй гэхдээ тулганыхаа захад шалавхан суугаад гал засаж байгаа хүн болонгоо ханцуйгаараа нулимсаа арчсаар байлаа.

Өвгөн огцом огцом амьсгал авч цээж нь оволзож эхлэв.

- Хүү минь, аавыгаа өндийлгээд өгөөч! гэхэд Базар эцгээ өргөж цээжий нь тэврэв.

- Доржпалам аа! гэж өвгөн дуудав. Сүх Доржпаламыг үсээ хусуулж сахил хүртсэнээс нь хойш “Эмгэн” гэхээс биш, нэрээр нь хэлдэггүй болсон билээ. Эмгэн өвгөнийхээ дэргэд яаран хүрч хучилган доогуур нь гараа хийж хөлийн нь барьж үзэхэд цэв хүйтэн болчихсон байлаа.

- Өвгөн минь, чи биднийгээ... гээд эмгэн мэгшин уйлав. Сүх өвгөн нүдээ нээн ханийхаа үхлээс айж хэлмэгдсэн хөөрхийлэлтэй царайн хараад,

- Эмгэн минь, бүү уйл даа. Төрөх ёсон байхад үхэх ёсон буй нь хорвоогийн жам. Мөнхрөхийн тавилан үгүйгээс хойш уйлаад яах вэ. “Жаргалыг дага! Зовлонг сөр!” гэсэн үгийг санаж явдаа гэж тамирдангуй хэлэх үед Юмжирдулам өвгөнийг муудсанаас хойш байн байн орж ирдгээрээ л орж ирлээ. Гэрийн доторхи аймшигтай байдлыг бүсгүй ажуут дотор нь хачин хүйт даагаад явчихав. Өвгөн дархан түүнд цаанаа л аймаар ондоо болчихсон шиг харагдлаа. Юмжирдулам дуугарч ч чадахгүй, хөдөлж ч чадахгүй хөшчихсөн мэт зогслоо.

- Энэ хөнгөн хөлтэй... миний хайртай... охин уу? гэж өвгөнийг үгээ зөөн асуухад бүсгүй “Тиймээ, өвөө” гэж эхэр татан арайхийн дуугараад дэргэд нь очлоо. Өвгөн үг хэлэх гэж хүчээ шавхан байгаа бололтой Юмжирдуламыг удаан гөлийж харснаа

- Охин минь, чи... томоогүй байна даа... Эцэг чинь... чамайг чулуунаас... Уг нь та... хоёрыг гэж хагас дутуу хэлсэнээ үгээ гүйцээж чадалгүй нүдээ аньж чимээгүй болов. Юмжирдулам өвгөний юу хэлснийг ойлгохыг бодсон ч үгүй, зөвхөн балмаггаан уйлж байлаа. Базар эцгээ өнгөрчихлөө гэж санаад гарын нь хацартаа наан нулимс асгаруулж гарав.

- Хань минь, хүү минь... Та нар минь бүү... уйлдаа гэж эцгээ дуугарахад хүү нь цочин давхийж нүүр өөд нь харав.

Дархан Сүх хүүгээ чи ч болно доо гэсэн итгэлтэй харцаар, эмгэнээ чи минь намайг өнгөрөхөөр яана даа гэсэн өрөвдөнгүй харцаар нилээд удаан ширтэв. Юм хэлэх гээд байгаа бололтой уруул нь хэдэнтээ татавхийн хөдөлсөн боловч дуу гарсангүй. Тэгээд түүний нүднийх нь цог унтарч өөрийгөө тойрон байгаа хэдэн хүний хэнийг нь харж байгаа нь ч мэдэгдэхгүй гөлрөн байснаа хоолой нь хоррр гэж хоржигносон нь эцсийн амьсгалын дохио байжээ. Базар “Аав аа” гэж орь дуу тавиад эцгийнхээ толгойд нүд рээ нааж цорхирон уйлав.

Сүүлийн үес өвгөнийх рүү шагайхаа ч больсон Намсрай гадаа явж байснаа тэднийд хүн уйлалдахыг сонсжээ. Тэгээд өвгөний бие мууджээ гэж тааварлаад, хэрэв орохгүй бол энэ чавганц орсон гарсан хохимой толгойтой бүхэнд намайг нэг насаар гомдоллон ярьж, хүмүүс ч намайг хуншгүй амьтан гэж ад шоо үзэж магадгүй гэж нэр хичээсэндээ тэдний рүү оров.

Намсрай өвгөний амь нь гарах гэж зовсон хүний шинжгүй амгалан царайг хараад анхандаа таалал төгсчихсөн юм гэж санасангүй. Харин Базарыг хармагцаа үхсэн хүнийг харснаас илүү хөрдхийн цочив. “Энэ ороолон чинь газар дороос гараад ирсэн юм шиг хэзээ ирчихээ вэ? Манай энэ алмасын ойрноос царай зүс орчихсоны учир энэ болж таарлаа. Одоо яадаг билээ? Хошуу туслагч энэ ороолонг үхэхээс нааш гарахгүй саванд орсон гэж итгэж суудаг нь мөн таарав аа” гэж бодсон Намсрай буцаад гарчихаж ч чадахгүй зогссоор байлаа. Намбаа ухаан

элий балай болсон Базарыг ятгасаар эцгийн цогцсоос холтгоод өвгөний гарыг тэнийлгэн өвөр дээр нь тавилаа. Дарханы хуруу үл мэдэг чацав, чацав хөдлөв. Хотол хошуундаа гайхуулж явсан энэ хүний уран гар энэрэлгүй хорвоогийн гамшгаар ийнхүү цагаас өмнө хөдлөхгүй болжээ. Ил далдуур авьяас билгийг нь завшиж байсан тэр дээдсийнхээ гарт үрэгдсэн нь юутай гаслантай вэ! Тэд хичнээн ийм алтан зул цэцгийг мөхөөсөн бол доо?!

Арван тавдугаар бүлэг

Хэн ч хорьшгүй дур зориг

Хөөрхөн төрсөн хүүхэн заяа

Хорвоогийн зовлонгийн үүдэн буюу

Үүр дөнгөж хяраалах үес хот айлын баруун урд талын умгар бор гэрээс уур нүдүүрийн чимээ гармагц бусад хэдэн гэрийнхэн уралдсан мэт босох нь энэ өдөр эртлэн хөдлөх ажилтай бололтой. Охиноо цай чанасан хойно дээшилдэг Намсрайг өрхөө татаж явахыг харсан нэг нь охин нь яачихсан юм бол гэж гайхна.

- Арай хадамд гарах гэж байхад нь өмнөө хүн өрсөөд оргуулчихсан юм биш байгаа даа.

- Тэгвэл ч хошуунд багтахгүй шившиг болно шүү.

- Хэлээд яана! Тийм бол ч Намсрай гуай буух газраа мэдэлгүй нисээд дайралдсан юман дээрээ уначихдаг царцааны үлгэр болно шүү гэж зарим нь шивэр авир гэлцэнэ. Тэгэвч залаангийн д гүйж ороод үзчих хүн байсангүй.

Эмгэн Доржялам үүрийн шаргал туяанаар шанагатай цай барьсаар гарч ирлээ. Насны ханиасаа хагацсан хөөрхий эмгэний нүдэнд гаслан гунигийн ул мөр бат шингэж, царай нь барайгаад, тамир тэнхэл нь ч алдарсан бололтой.

- Баян хангай минь, аварч өршөө! гээд эмгэн цайныхаа дээжээй дөрвөн зүг найман зовхисо өргөж байхдаа “Миний үйлэйн үр яасан барагддаггүй вэ! Хүү минь гэр орондоо байж болдоггүй ийм ч хэцүү юм байх гэж. Хүү минь байгаа бол хичнээн сайхан байх билээ. Улиастай гэдэг чинь гурав дөрөвхөн өртөө газар гэсэн. Арваад хонож байхад ирмээр юм. Бас л өнөө хар гэрт нь орчихсон юм биш байгаа даа” гэж уймран бодов.

Базар гэмгүй ардыг зодож алсан тэргүүн туслагч Сэр-Одоос эцгийнхээ амийг нэхэж Улиастайн жанжин жасаанд зарга мэдүүлэхээр явах гэхэд эх нь буянт эцгээ бие барсан хойно хэл үг таталж, ясыя нь өндөлзүүлээд яах вэ гэж аргадаж ядав. Намбаа ч түүнийг дээдэстэй заалдаад хэзээ ч дийлэхгүй, харин ч Улиастайд баригдаж муугаа үзнэ гэж ятгаад ч дийлсэнгүй.

- Барин тавин үнэн юмыг яаж хаацайлах вэ. Түмний нүдүи дээр ил болсон хэргийг хэн ч нууж дөнгөхгүй. Энэ чинь алт мөнгөний зарга биш, амь насны зарга. Би явахдаа л явна гэж Базар анддаа хэлээд санаснаараа зүтгэсээр Улиастайг зориход хэрэг хэзээ ч бүтэлгүйтэнэ гэдгийг лавтайяа мэдэж байсан Намбаа түүнийг ганцаарангий нь явуулж түвдээгүй билээ.

Намсрай өвгөн дархныхаас салаад нүүчихье гэж санасан боёовч түүнийг амьд байхад арай ч зориглоогүй юмсанжээ. Сүхийг өнгөрч, Базарыг Улиастай руу явсны дараа эмгэнийг хар нутаг дээрээ орхиж нүүгээд нэгэн баян тайжийнтай зиндаархан айл буув. Эмгэн Намсрайд гомдсон авч олон жил айл аймаг явснаа бодоод хойноос нь нэхэж хаяагий нь дэрлэн буусан

билээ. Намсрай залан жинстэй малгайгаа ахин дахин засаж өмссөөр гарч ирээд хонь бэлчээж явахдаа “Залан хүн ингэж байна гэдэг ч олигтой юм биш. Бушуухан зарц барлагтай болохсон. Тэгвэл ёстой нэг залан шиг хоймроо заларч суух санж” гэж бодсоноо,

- Орших оо! гэж дуудахад баруун урдахь умгар гэрээс нэгэн залуу гарч ирсэн нь Пагмын сэтгэлтэй хархүү байлаа.

- Ээж чинь шөнө шүүс чанаж бэлдсэн биз? Гэж Намсрайг ихэмсэг дуугаар асуухад,

- Залантаан? бэлэн гэж Орших мэхэлзэв. Өөрийнхээ өмнө “Залантан” гээд бөхөлзөж нахилзаж байгаа хүнийг харахаараа Намсрай зэрэг жинсний ид хавыг улам ч биширдэг болжээ.

- Чи хө, манай морьдыг ойртуулаад өгөөрэй! Миний тун завгүй байгааг харж байгаа биз дээ гэж түрүүчийнхээсээ бардам дуугарахад Орших

- Жа гэж мэхийв. “Энүүн шиг зарцтай болбол мөн зүгээрээ дээ. Залангаараа түрээ бариад Оршихыг авахаар оролдоод үзвэл энэ баян тайж яадаг бол?” гэж бодсоноо Намсрай нөгөө талын дүнхийсэн цагаан гэрийг хяламхийн хараад “Энэ ч хошуу засагт нэртэй, баян тарган тайж даа. Нөгөө муу хохь тайж шиг бодож болохгүй шүү. Бас их шартай эр гэж байгаа” хэмээн эмээсхийв.

Намсрай залан болсноосоо хойш баахан албархуу, дээрэнгүй зантай болжээ. Данс хар гэж муутуу цаастай бичиг дэлгэн үзэж, сав л хийвэл хэрэг шийтгэнэ гэж тамгын газар руу шогшуулах дуртай болж хүн ам зөрвөл тайганд хүргүүлнэ, ял янганд унагана гэж сүр далайлгадаг болжээ. Намсрай өдрийн цагт жинстэй малгайгаа толгой дээрээсээ үл салгана. Шөнө орондоо орсон хойноо ч гэсэн малгайгаа эргүүлж тойруулан үзэж, жинсийн нь илж хадгаар арчаад дэрнийхээ дэргэд тавьж залаагий нь дэрэн доогуураа шургуулаад нойрсдог болжээ. Заримдаа жинстэй малгайгаа хулгайд алдав гэж зүүдлээд цочиж сэргэж тэмтэрч үздэг удаа ч байв. Тийм үед ямар нэг атгаг сэтгэл өвөрлөсөн хүн малгайгий ньавчих гээд байгаа юм шиг санагдаж нэг хэсэгтээ унтаж ч чадахгүй эргэж хөрвөдөг болжээ.

Намсрай гаднаас орж ирэхэд охин нь орныхоо урд буруу хараад уйлж суулаа.

- Чиний наад нулимс чинь яасан барагддаггүй нулимс вэ! Амьтан ах дүүс ирэх боллоо. Бос! Хувцас хунараа өмс, нүүр гараа угаа! гэж эцгээ зандрахад охин

- Үгүй ээ, үгүй! Би явахгүй! гээд гэнгэнэн уйлна.

- Хүн ирэхэд чи ингээд сууж байгаарай! Аргаар болохгүй бол хэмх нүдээд босгоё оо, чамайг би!

- Яасан ч босохгүй! гээд охин нь зөрүүдэлж түрүүлгээ харан унаж хөл гараа савчин орилсонд эцэг нь сүр үзүүлэн айлгах санаатай захнаас чөдөр авч

- Бос, чи! Эцэгтээ ихэрхсэн задарсан тархи вэ! гээд аяархан ороолгосон чинь охин нь улам ч

гаарч

- Ээж ээ! Яана аа! Ээж ээ, охиныг чинь аллаа! гэж тунхээгээрээ бахирсанд Намсрайн гайхаш барагдан чөдрөө хаяа руу шиджээ. “Базар минь байсан болоосой! Тэгвэл би юунд ингэж хүний эрхэнд хэвгэх билээ. Хоёулаа дуртай зүг рүүгээ оргоод явчихгүй юу. Ийм юм болохыг эртнээс мэдсэн болоосой! Миний заяа дутахад л энэ биз. Өвөө минь амьд сэрүүндээ надад юу ярих гэсэн бол? Эцэг чинь чамайг чулуунаас гээд юу хэлэх гэсэн бол! Өвөө л мэдэж байж дээ. Базарт ярьсан болов уу?” гэж Юмжирдулам өөрийн хувь заяанд гомдон ганихарна.

Намсрай Базар байвал охиноо туслагчийн хатан болгоход саад тотгор учруулж, аягүйдвэл охиноо заяа нь нийлсэн тэргүүн туслагчтай суулгаж чадалгүй өнгөрч юу магад гэж айсан учир хошуу туслагчтай ярилцаж хуримын болзоот өдрийг маш нууцаар нааш татаж, урилга заллагыг зөвхөн урьд өдөр нь хүргүүлэхээр товлосон билээ. Туслагч Сэр-Од хадам эцэг болох хүнээсээ Базарыг ирснийг сонсмогцоо түүнийг голомтон дээр нь барьж буцаан хүргүүлнэ гэж сайрбан хэд хэдэн хүнийг мордуулсан боловч өвгөн дархныг нэгэнтээ хөдөөлүүлсэн учир хоёр оргодол тэдний гарт орох нь өнгөрсөн байлаа. Базарыг гартаа оруулаагүйдээ бухимдсан тэргүүн туслагч Улиастайн жанжин жасаанд бичиг илгээн даатгаад сайхан хатан яаран таалахаар санаа шуударчээ.

Намсрай тэргүүн туслагчтай товлосон ёсоор охиндоо энэ тухай дөнгөж өнгөрсөн үдэш сонсожээ. Эцэг нь угийн дуу цөөтэйн улмаас юмны эв дүйг олж ярихдаа дульхан учир нэг юм хэлэх гэж ядаад байгаа бололтой хэсэг дүлгэнэж байснаа арайхийн ам нээж

- Охин минь, маргааш манайд хошуу туслагч Сэр-Од ах дүү нартайгаа ирнэ гэхэд нь аавыгаа залан боллоо гэж хошууны ихсүүд ирэх гэж байгаа юм байж гэж санасан Юмжирдулам,

- Тэгээд л та идээ будаа, архи дарс төхөөрөөд байгаа юм уу? гэж асуужээ.

- Тиймээ, охин минь. Ёс төртэй, хүнөөй мэндтэй угтаж авахгүй бол болохгүй шүү дээ.

- Тэгэлгүй яах вэ, аав минь. Охин нь учир бага мэдэх хэдий ч чадах ядахаараа мэрийе, да ч надад яахыг нь зааж зурж өгөөрэй!

- Тэгнэ, тэгнэ. Миний охин аавынхаа хэлснээр л байвал цалгардах юм ер байхгүй.

- Аав аа, хошуу туслагч гэдэг чинь танаар гоё бэлэг өгчилгөсөн хүн мөн биз дээ гэж охиноо санаандгүй асуусанд мулгуудуу эцэг нь түүнийг тэргүүн туслагчид талтай байна гэж ухаараад,

- Яг мөн дөө, охин минь. Тун сайн хүн дээ. Сэр-Од туслагч миний охиныг гуйсан юм. Бэлэг сүйгийг нь цагаан сараар тохирчихсон. Маргааш хурим хийж охиныг минь аваачих гэж байгаа юм гэж ярьж орхив. Эцгээ тоглоом хийж өөрийгөө цаашлуулж байна гэж байгаа Юмжирдулам

- Аав ёстой хамаагүй хадуурч байх шив. Үүрэглээгүй биз гээд тас тас инээлээ.

- Байтлаа эцгээрээ тоглох нь уу?! гэж зандраад Намсрайн царай хувьсхийжээ. Эцгийнх нь өтгөн хөмсөг атирч, харц нь ширүүн болохыг ажсан бүсгүй сая л тоглоом бус, шоглоом эхлэх гэж байгааг арайхан төсөөлжээ.

- Пөх, тэр хөгшин туслагчтай намайг суулгах гэж үү? Яршиг байгаа даа гэж Юмжирдулам ширэв татав. Өөрөө л дургүй бол эцэг нь түүний санаснаар болох юм шиг гэнэн бүсгүй боджээ.

- Охин минь, нэгэнт авчихсан сүй бэлгийг буцаах ёс байдаггүй юм...

- Хэн таныг дураараа сүй бэлэг ав гэсэн юм бэ. Надад хэлэх чинь яагаа вэ.

- Охин минь дээ, чи аавынхаа үгийг сонс! Ахар жолоот бүсгүй хүн өөрийнхөө толгойг мэддэггүй юм. Аав чинь, лам багш чинь зааж өгдөг юм. Аав нь багшо ламтнаас асуусан. Тэргүүн туслагч та хоёрын заяаг нийлнэ гэж айлдсан. Аав чинь залан боллоо. Энэ сайхан эрдэнийн жинсийг хар, чи! Тэгэхээр миний охин ноён язгуурт хүний хатан бололгүй яах вэ. Эрх ямба, эд хөрөнгөөр түүнтэй эгнэх хүн энэ хошуунд үгүй. Чамд хангай шиг түшиг болно. Миний охин маргаашнаас эхлээд лусын сан шиг баян түшмэлийн хатан болж дураараа жаргаж суух болно гэж Намсрай өөрийн чадах хэрээр сэнхрүүлэн ярилаа. Юмжирдулам цухалдан уйлж байж эцгийн үгийг хайхралгүй өнгөрсөн хэрнээ түүнээс ганцхан юм өлгөн авчээ. Аав нь залан болсноо ихэд гайхуулж жинстэй малгайгаа амь мэт хайрладгийг нь бодоход өвгөн дархны “Эцэг чинь чамайг чулуунаас...” гэж хэлсэн үгийн сэжүүр цухуйх шиг түүнд санагдав. Ийнхүү Юмжирдулам эцэгтээ бүр ч их гомдож

- Би тэр туслагчийнд чинь хэрхэвч очихгүй. Та намайг алт, чулуу хоёроос худалдаж идэхдээ хүрээгүй байх шүү гэж бачимдан хашгираад туслагчийн өгүүлсэн бэлзгийг өдий хүртэл томоогүйтэн зүүж явсандаа харуусаж, нүд ирмэх зуур мултлан авч гал руу шидчихээд гарч Базарынх уруу гүйв. Намсрай охиныхоо хойноос хоттой хонь үдäүүж пир пир хийн харайсан боловч гүйцсэнгүй. Юмжирдулам эмгэнээс зуурч,

- Аав намайг Сэр-Од туслагчтай суулгах гэнэ. Би яасан ч үгүй. Та намайг битгий өгөөрэй! гээд уйлж гарлаа. Намсрайг уухилсаар орж ирэхэд

- Чи ганц охиноо өдий хүргэчихээд өөр шигээ насны хөгшин түшмэлд өгч суухдаа сэтгэл зовохгүй байна уу? гэсэн үгээр эмгэн угтлаа.

- Та нар муусайн боолууд намайг сургах болоогүй. Тэр чинь дээд язгуурт хүн. Олон үг донгосвол тамганд хүргүүлнэ шүү. Зөнөг чавганц хэрээрээ бурвал барав гэж Намсрай загнаад охиноо гуд чирэн гарахад эмгэн

- Чи ч уг нь миний өөдөөс ийм үг хэлэхээргүй хүн сэн дээ. Гайтай жинснээс болоод омогшиж гүйцжээ гэж дэмий л үглэжээ. Намсрай охиноо гэртээ аваачаад

- Ганц биеийн жаргалыг умартаж чамайг өдий дайны болголоо. Гэтэл чи харанхуй шөнө харц боолын овоохой руу гүйж эцгийнхээ нэрийг түймэрдэж явна гэнэ ээ! Дураар нь байлгаж эрхлүүлэх тусам гаарах нь энэ үү?! Май, чи! Ингээд айл руу гүй! гээд охиноо хоёр сайн

алгадаж авлаа. Эцэг нь хоёрхон биеэр үлдсэнээс хойш анх удаа охиндоо ийнхүү гар хүрч байгаа нь энэ учраас Юмжирдулам хэмээлшгүй гомдон уйлсаар байлаа.

- Хайртай аав минь, та миний эрх охин гээд надад амин голоо тавьдаг биш үү? Гэтэл одоо яагаад намайг нэг насны тамд хийх болоо вэ? Ганц охин чинь хэзээ ч жаргал үзэхгүй шүү дээ гээд Юмжирдулам эцгийнхээ өвдгийг түшин өршөөл энэрэл гуйсан нүдээр царайчилж харав.

- Чамайг жаргаах, зовоох хоёроо би мэдэхтэйгээ байна... Би чамайг хэзээ ч хаяад өнхөрчих юм билээ. Амьд дээрээ хань ижилтэй болгож замыг чинь зүглүүлж байна. Олон үг гонгинолгүй унт! гээд охиноо орных нь урд руу түлхжээ. Юмжирдулам дахин хэнийг ч болов уяраасай үг хичнээн урсгавч эцэг нь шилэн гүнгэрваанд байгаа бурхан шигээ гөлийгөөд суучихав. Эцгийн сэтгэл үнэхээр чанд байгааг охин мэдэж цөхрөөд “Аав минь, яргачин хүн үхэр цохихоор далайсан сүхээ буцаадаггүйтай адил болжээ” гэж бодоод амаа хамхив. Юмжирдулам олон жил нандигнан хадгалсаар ирсэн эхийнхээ хоргой эмжээртэй дээлийг тэвэрч нулимсаараа шөнөжин шахам угаалаа. Үүрийн харанхуйгаар дугхийхдээ бүсгүй сэтгэлийн угт илхэн санагддаг хайрт эхтэйгээ учран зүүдэлж, тэр зүүдэндээ сэтгэл ханан баяссан билээ. Гэвч сэрмэгц бүх юм хуучнаараа байсанд бас л гомдон уйллаа. Эцгийнхээ сэтгэлийг уярах байх гэж горилсон бүсгүй өглөө нь зүүдээ ярив.

- Аав аа! Урьд шөнө би ээжтэйгээ уулзлаа. Ээжид би таныг хэлсэн. Ээж охиныг минь чи ингэж зовоож байдаг яасан эцэг хүний өрөвч сэтгэлгүй амьтан бэ гээд таныг загнаж байна. Тэгээд миний охиныг тэр хөгшин хүнд өгөх юм бол би охиноо аваад явлаа гээд ээж миний гараас хөтлөн явах гэхэд та, би охиноо тэр хүнд өгөхөө болилоо, битгий аваач гээд миний нөгөө гараас зуураад тавихгүй юм... Аав аа, ээжийн сүнс ирсэн юм биш байгаа даа. Тийм бол тантай лаа уулзсан даа гэж охиноо ярихад эцэг нь,

- Бүү донгос! Юун яасан сүнс? Солиороо юу чи!? Гэж ихэд зэвүүрхэн гарч оджээ.

Тэргүүн туслагч, залан хоёрын садангийнхан уван цуван ирсээр бага үдийн хирд найр эхэлж дуу хуур боллоо. Усан нүдэлсэн залуу хатагтайг харсан хоёр талын садангийн зарим ахмад настан

- Манай Сэр-Од өтөлсөн хойноо үр шигээ амьтныг зовоож яах нь вэ дээ.

- Өртлөөс нь дуусах болоогүй юм байлгүй.

- Намсрайд юу ч гэж хэлээд нэмэр алга. Энүүний данхар толгой буруу хараад зүтгэсэн бухын толгой дийлддэггүйтэй ижил болж.

- Ийм хүнийг яах вэ дээ.

- Буруу зөнөнө гэдэг энэ биш хэмээн өөр хоорондоо хэлэлцэх боловч дүвчин ламтан тэр хоёрын хувь заяа нийлнэ гэж айлдсаныг сонссон сүсэгтэн хүмүүс итгэн биширч, тэр хоёрыг төдий л зэмлэн гутаах сэтгэл өвөрлөсөнгүй.

Бэр буулгах тэр найр тэргүүн туслагчид нэг л уйтгартай баяр цэнгэлээр хомс санагдана.

Залан хүн хошууны тэргүүн туслагчид хүүхнээ өгч байгаа найр гэхэд хорь гучхан хүн ирсэн нь тун ч чамлалтай. Заллага тулгамдуу тарснаас зарим нь хэл хүрээгүй, нутаг холтой зарим нь сонсовч ирж заадаагүй биз хэмээн тэргүүн туслагч санавч Намсрайн талийгаач эхнэрийн садангаас нэг ч хүн ирээгүй нь цаанаа хорсголонтой санаа агуулсан байх гэж сэжиг төрнө. Сэр-Од таалах гэж байгаа залуу хатныхаа царайг харахад бүр ч дур гутах ажээ. Түүний нүүр бүлцийж цалцайн улайгаад, нүднийх нь зовхи хавдаж бараг нийлэх шахжээ. Өнгөрсөн зун хошуу цам дээр үзэж нүдээ унагах шахан сэтгэл алдаж байсан нөгөө үзэсгэлэнт бүсгүй гэж санахын аргагүй болжээ. Хүмүүс дуулж цэнгэж байхад гэнгэнэтэл орилж нударгаа нүднээсээ салгалгүй суугаа Юмжирдуламыг харахаас Сэр-Одын эгдүү хөдөлж, болдогсон бол нудраад авмаар санагдаж, аргаа барахдаа дэмий л ханцуйн дотроо гаргаа атгаж байлаа. Энэ хүүхний одооны олиггүй царайг харсан хүн намайг “Туслагчийн таалж байгаа хатан ч царай зүсээр даанч муу юм. Туслагч насыа нь хэрэглэх гэсэн юм байх даа” гэж цуу тараавал яана гэж бодохоос Сэр-Одын санаа зовно. Энэ нэрэлхүү зангаасаа болж түүний нүүр үе үе чинэрэн улайна. “Заяаны сайхан төрсөн бүсгүйд завсрын энэ зэргийн бүлцэн ч яамай. Ер нь богтуулсан хүүхнүүд дуртай ч дургүй ч ингэж л байдаг. Ингэлээ гээд тэд эрд гарахаас мултрах биш. Уйлж л байг, цаашаа. Над руу харах цаг ирнэ ээ, гайгүй” гэж Сэр-Од бухимдсан сэтгэлээ тайтгаруулахыг оролдоно.

Намсрай залан хадам эцгийн хувиар хоймор голлон айааиёоо сууж насны жаргалаа эдэлж байгаа янзтай ямбархаг харагдана. Залаа согтож хэл ам нь орооцолдон үг нь олшров.

- Ууцгаа! Идэцгээ! Дуулж хуурд! Ах дүү та нараа хонин өнжин найрлуулах бэл Намсрай заланд бий! гэж ахин дахин хэлж архины дугарааг яаруулна.

Жинсэнд хорхойтой Намсрай залан сархдад нэт халамцсаны учир хүргэнийхээ малгайг толгой дээрээс нь ичгүүргүй авч улаан жинсий нь шохоорхон үзүж “Сэр-Одын зоргоор авирлах нь ч хэр юм. Ийм жинс зүүсэн хүн тэгэхээс яах вэ. Тийм хүүтэйд нь болж би ганц охиноо өгч байгаа юм. Би ч гэсэн ийм жинстэй болчихвол яггүй түшмэл гарна даа. Бас л эдний адил өөртөө талтай, нахилзаж бөхөлзсөн хүнээ өөд нь татахыг бодох биз. Түшмэл бүхэн өөртөө шарвадаг сүүл, цорвойдог хушуутай байдаг бололтой. Тэгж байж ч түшмэлийн жинстэй малгай, түшлэгтэй суудал хоёрт эзэн болдог байх” гэж бодоод

- Манай хүргэний энэ ч мөн өнгөтэй чимэг юм даа гэж бахадсан янзтай хэлсэн авч өөрийнхөө хөх жинсийг голонгуй харахыг Сэр-Од туслагч ажаад зэвүү нь хүрч, миний оронд туслагч болъё гэж хэлэхээ шахаж байх шив гэж эгдүүцэв. Намсрай ч түүний дургүйцсэн хүйтэн царайг ажигламагц малгайгий нь толгой дээр нь дуугүйхэн тавилаа.

Сэр-Од энэ найрыг өөрийн дур зоргоор бушуухан цүглүүлээд буцахыг хүсэвч төрлийнхөө ах зах хүмүүсийн дэргэд ёс горимонд хүлэгдэн байн байн нар руу хялам хялам харж дэмий л цаг өнгөрөхийг хүлээн сууж байлаа. Хүргэнийхээ уйтгартай дүнсгэр байгааг мэдсэн Намсрай

- Туслагч та нанчид тогтоож хайрлаач! гэж тал засангуй дуугарав. Хадам нь хүргэнээ “Хүү минь, чи гэж ам бардаж хэлчихэж зүрхлэхгүй байгаа нь түүний өндөр хэргэм зэргээс сүрдсэн бололтой.

- За за гэж Сэр-Од хадмын өмнө уриалган дүр үзүүлэн толгой дохисон боловч “Засаг барьсан

хүний сүр хүч гэдэг мөн ч их юм даа. Хадам нь хүргэнийхээ өмнө ингэж гөлөгнөж байна гэдэг бэрх ээ. Намайг ийм залуу хөөрхөн хатан таалж байхад зэмлэх хүн нэг ч алга. Энэ чинь миний л сүр хүчний өмнө сөгдөж байгаа хэрэг. Ондоо нэг харц ард ингэсэн бол энэ хошуунд багтахгүй шуугиан болж байгаа даа. Өндөр дээд язгууртай хүн гэгч юу л хүснэ түүнээ өөрийн дураар болгож байдаг тун ч олодоггүй сайхан хувь тавилантай юм даа. Юу ч хийсэн буруудаж зэмлэл үзэх нь байдаггүй. Ихдээ л доохнуур жиг жуг хийгээд өнгөрнө. Дээдэст хошуу өргөдөг хүн байдаг болохоор баалуулахаас айж тэр бүр ч яриад байж чаддаггүй биз” гэж эрх мэдлээ бахдан байтал баруун талд нэгэн хүний дуу хадав. Сэр-Од ольсхийн харвал түүний садангийн залуу эр агсагнах бололтой олон үг хэлж гарсанд Намсрай

- Бага хүн байж яасан давьтаргүй юм бэ. Найр бүү үймүүл! Уух дуртай бол дуугайхан ходоодоо дүүргэж ав! гэж зандарсанд нөгөөх залуу бүр гаарч ханцуй шамлан ташаа тулж

- Бүсгүй хүний нус нулимсаар дүүрсэн гашуун ус уухгүй. Та нарын энэ чинь найр юм уу, юу юм, аа? Над хэлээд аль! Ангайдаг амтай хүн алга уу? Ичицгээв үү? та нар? гээд тал тал тийш ханхалзан гэр дэх хүмүүсийг тойруулан харснаа

- Өтөлсөн хойноо хүний өнчин хоцорсон бүсгүй үрийг зовоож байхдаа сэтгэл чинь ханаж байна уу!? Хүүхэд шигээ хүнийг эхнэр болгоё гэж яаж ухаанд чинь багтаа вэ! Түмэнд нүүрээ барж, түймэрт хормойгоо шатаасан ийм амьтнаар яах юм бэ! Үхсэн хойноо бас тэгээд тэргүүн туслагч гэж байгаа шүү! Төрөл саданд ноён ч бай, түшмэл ч бай хамаагүй. Би хэлдгээ хэлнэ. Хүний нялх үрийг тамлахаа боль! Орхиод эндээс тонилбол барав! гээд Сэр-Од руу агсарч гарлаа. Сэр-Од ч, бусад садангийн хүмүүс ч энгэр заамаа ярсан төрхгүй байрын тэр чийрэг залууг аргын үгээр номхруулах гээд чадсангүй. Залуу эр улам догширч өөртөө үг хэлсэн хүн бүрийн өөдөөс үсчиж байлаа.

Ганц охиныхоо найрыг найр биш болгох иү гэж айж уурласан Намсрай,

- Задарсан золигийг хүлчих! Хүний үг дуулдаггүй яасан эх захаа алдсан золиг вэ гэж загнасанд хэдэн хүн залууа ноцон авч чирч гаргав. Садангийн залуугийн ингэж агсагнасан нь явахын мөн болж суусан тэргүүн туслагчид аятайхан шалтаг болов.

Сэр-Одынхон нар баруунаа гудайхад Юмжирдуламыг авч буцах боллоо. Бүсгүй гартаа өртсөн юм бүхнээс зуурч,

- Би явахгүй ээ! Намайг орхиоч! Авраач, ах дүү нар минь! гэж түмний чихэнд хадтал чарлаж гарлаа. Намсрайн царай тугалга шиг цэлдэн хөх болжээ. Төрсөн гэртээ хоргодож, эцгээ гэж тэмүүлж байгаа өнчин охиныхоо өрөвдөлт дууг сонсч, хүний сэтгэл татам үзэмгэлэн гоо царай зүс нь мөндөрт цохиулсан наранцэцэг шиг тэр гэхийн аргагүй болсныг харахаас Намсрай халширч бушуухан салахуй хүслэн болжээ. Сэтгэл нь хичнээн шимшрэвч архины халуунд зориг нэмсэн эцэг,

- Ёстой юм ёсоороо болог! Бушуухан аваад яв! Тамд аваачих гээгүй диваажинд хүргэб гэж байна. Нар оройтох нь, түргэлцгээ! Түргэлцгээ! гэж хүмүүсийг яарууллаа. Эцгийнх нь үгэнд зориг орсон хүргэний талынхан бэрээ хүч түрэн гэрээс тэврэн гаргав.

- Та минь ээ! Би яадаг билээ. Ээж ээ, ээж ээ, ээж ээ! гэж Юмжирдулам орь дуу тавина. Түүний нүд нүүр нь булуу болтлоо хавдаж, хүн танихын аргагүй болоод ухаантай ухаангүй хоёрын хооронд үлгэн салган байлаа.

- Муу эх нь байсан бол нээрээ ч ингэхгүйдээ гэж гунганаад эмгэн Доржйалам нулимсаа арчиж,

- Намсрай, чи ганц охиныхоо нус нулимсыг барж суудаг яасан бөх зүрхтэй хүн бэ! Ийм ч эцэг байх гэж хэмээн гаслан өгүүлсэнд

- Чи намайг нөгөөх л Намсрай гэж санана уу? Олон үггүй тонил, цаашаа! Овоохойнхоо мухарт очиж гонгино! гэж согтуу Намсрай агсарчээ. “Бүсгүй хүн сайхан төрнө гэдэг мөн ч үйлтэй юм даа. Одооноос ингэж байгаа хөөрхий охин энэ хорвоог яаж шуу өнгөрөөнө дөө, Балданлхам минь” гэж залбирсаар эмгэн гэр рүүгээ алхав.

Намсрайн найрын бэлтгэлийг базаахад хуруу дүрэлцэн гэрт гадаа хоёрт гүйж байсан Орших олон хиа, бараа бологчдоо дагуулан ирж яваа тэргүүн туслагчийн бараанаар үнхэлцэг нь хагартал айж, түүний нүдэнд үзэгдчихгүй өнгөрөхийг хичээн найрын газар руу ганц ч алхсангүй гэртээ бүгжээ. Найрын буянгаар нэг сайн цадаж авья гэж санасан хүсэлдээ туулай зүрхтэйгээсээ болоод хүрч чадалгүй гомдолтой хоцорсон Орших буруу хатавчаараа шагайж Намсрайн гадаа болж байгаа явдлыг хараад улам ч айж “Яасан аймшигтай юм бэ! Үгүй тэгээд Базарыг чинь туслагчийн таалах гэсэн хүүхнийг булаалдсан гэж хэлэлцдэг биш үү. Намайг шивэгчинд нь очихоос эмээж байхад Базар хатан болох хүнийг нь авах гэж байдаг ямар зүрхтэй юм бэ! Бүр ийм мундаг түшмэлийнх шүү. Ий, яа! Санахаас айдас хүрч байна” гээд биеэ хураан арагш ухрав.

Ураг барилдсан хүмүүс мордож, нэгэн булиа эр тийчилж байгаа Юмжирдуламыг эмээл дээрээ дүүрч хөлийг нь хөлөөрөө хавчиж, хоёр гарыг нь хумхин тэврээд авч одоход хөөрхийлэлт бүсгүйн орилж бархирах зүрх шимшрүүлэм дуу холын холоос сонсдож, зовлонт хүний уяхан сэтгэлийг донсолгож байлаа.

Арван зургадугаар бүлэг

Зарга

Бурангуй засгаас үнэнийг эрснээс

Бударгана хөөсөн тэмээ хайвал төсөр

Зуны эхэн сард хааяахан тохиолддог цоном хурц нартай өдөр байлаа. Улиастай хотын хөл үймээн татарсан нь үд дундын халуунд залхууран нойрмоглосон мэт харагдана. Хотын байшин барилгыг халхлан өндөр өндөр ургасан аварга улиаснуудын навчис үл хөдлөх нь өчүүхэн ч салхигүй байгаагийнх аж. Хотын баруун талаас хоёр морьтой хүн сажлуулсаар ирж явах нь Базар Намбаа хоёр байлаа. Тэдний унасан хурдан шинжийн сайхан хүлэг морьд толгой хаялан зугуухан алхана. Тэр хоёрын хэн хэн нь бодлогоширсон янзтай мориныхоо толгойг ширтэн бие биеэ харалгүйгээр намуухан ярилцана.

- Учрыа нь олж хужрыа нь тунгаах гээд л ингэж хүлээлгэдэг юм байх даа гэж Базарыг гайхаш алдран өгүүлэхэд

- Ингэж удаг ч сайны ёр биш дэг ээ гэж Намбаа хотын зүг уйтгартай нүдээр харсан чигтээ хэлэв.

- Манай хошуу туслагч даанч дураараа аашилдаг хүн дээ. Одоо нэг юм дуулах болсон байх аа гэсэн Базарын итгэлтэй үгний хариуд Намбаа

- Ээ мэдэхгүй. Туслагчаас бид хоёр урьтах байх шүү. Хэнийх нь хацад, хонго илүү хорсож байгаа бол доо гэж ёжтой инээмсэглэсэнээ “Мөн ч гоомой байна даа. харц ардын зөв гэж хэлдэг түшмэл байдаг гэж дуулаагүй юм байна. Тэд бид хоёрыг хуурч байж урхинд хийх гэж байгаа бий дээ” гэж бодлоо.

- Намбаа гуай! Арай ч тийм муухай юм болохгүй биз? Отго жинстэй бүхэн хаанаас манай туслагч шиг байх вэ. Тэр түшмэд Сэр-Од туслагчид үнэхээр уурсаж байдаг шүү. Тэр хүн лав учрыг тунгаадаг цэцэн түшмэл байх гэж Базар хэлэв.

Базарыг жанжин жасаанд бараалхан зарга мэдүүлэхэд жирэвгэр хар сахалтай, цоргитол ширтсэн хурц харцтай түшмэл их л уриалган угтжээ.

- Танай хошууны тэргүүн туслагч чинь тийм хүн бий. Нэгд нэггүй яриарай! гээд бичих цаас дэлгэн бийр янтайгаа зэхэхэд Базар гомдож хорссон бүхнээ хөврүүлж гарав. Түшмэл хааяа хааяа хөмсөг атируулан сонсож байн байн лавлаж улам өдөөн яриулсаар байлаа. “Муусайн боолууд ингэж л ноёд түшмэддээ хар буруу санаж явдаг бий вий. Төрийн түшмэлийн нэрийг чам шиг боол гутаадаг юм биш. Нэг хотны ноход хоорондоо хэмлэлцдэг хэрнээ чоно ирэхэд нийлээд дайрдгийг чи мэдэхгүй гэж үү? Та нар гэнэн цагаан. Чамайг чөдөрлөчихөж дөнгөнө өө. Тэгээд хэн болохыг чинь яг таг мэдэж чамайг уу!” гэж занаж суусан түшмэл хуурмаг сайхан зангаар залуугийн нүдийг таглаад,

- За хө, мэдлээ. Хэдийбээр түшмэл хүн боловч энгүүн ардыг бас ч тэгж дарангуйлж болохгүй шүү. Танай туслагч хэтрүүлсэн байна... Би бусад түшмэл нартай ярилцана. Чи тав хоноод ирээрэй! гэж тэр түшмэлийг хэлэхэд Базар яасан сайхан зантай түшмэл вэ гэж санаад гарчээ. Түшмэлийн хэлсэн өдөр очвол нийлэх хэрэг бага бус, хараахан завдаагүй байгаа учир дахин гурав хоноод ир! гэжээ. Энэ зуур жанжин жасааныхан Сэр-Одын бичгийн хариуд Сэцэн Сарт-Уулын хошуунд бичиг довголгон Базарын хэргийн учрыг магадалж байсныг түшмэлийн өнгөний арганд автсан залуу эр хэрхэн мэдэх билээ.

Намбаа насаар ч ах, үзсэн дуулснаараа ч илүүгийн хувьд Базарын горьдлогыг нэг л ойшоохгүй байлаа. Тиймээс ч “Түшмэлийнхээ мууд дурладаг түшмэл байдгийг би ер мэдэхгүй юм. Цаадуул чинь башир аргатай шүү. Яах л гэж байгаа бол доо. Осолтой юм руу орчих гэж байгаа юм биш биз? Хүлээлгээд байдаг тун гэмтэй. Чи ямар ч гэсэн өнөөдөр очиж сориод үз! Тэгтэл яах нь мэдэгдэнэ” гэж Базарыгаа ятгасаар түшмэлийн хэлснээс нэг өдрийн өмнө, тэгэхдээ хамаг амьтан назгайрч залуу нь хүрсэн үдийн халуунаар жанжин жасаанд очуулахаар яваа нь энэ аж.

Хаяа хаяагаа дэрлэсэн олон пүүстэй худалдааны нарийхан гудамжаар тэр хоёр өгсөн явна.

- Би энд хүлээж байя. Чи шууд яваад орчих. Тун сэргэг байгаарай! Тэдний уурыг хүргэмээр өдсөн үг хэлээтэх. Тэгэхээр шинж нь мэдэгдэнэ гэж Намбаа хэлээд жанжин жасааны наахна морио бариад хоцров.

Базарт жанжин жасааны хашаа нэг л эл хуль юм шиг байлаа. Гавтай дөнгөтэй, үс сахал нь сэгсийсэн, эрүү шүүлтэнд зовж шаналсан хүмүүс ээлжээ хүлээн хэвтэж байдагсан бол өнөөдөр нэг нь ч байсангүй. Түүнийг нөгөөх учир мэдүүлсэн түшмэлийнхээ яамладаг өрөөнд ороход хоёр түшмэл, гурван бичээч байв.

- Чи юунд ирэв? Би чамайг маргааш ир гэсэн бус уу? Яв, яв! Бид тун завгүй байна гэж нөгөөх түшмэл Базарыг хармагцаа уцаарлангуй хэлэв.

- Өдий төдий хоног хүлээлээ. Унаа бие хоёр хэцүүдлээ. Миний хэргийг нэг тийш нь болгохгүй юм бол би одоо буцлаа гэж залуу эр шазруухан дуугарав.

- Хошуу засгийг давсан танхай боол энэ мөн үү? гэж хөгшин түшмэл шазуур зуун асуухад нөгөөх нь толгой дохив. Хөгшин түшмэл бичээч нар руу нүд ирмэхэд тэд босон үүд рүү дөхөв.

- Шүүх зарга байхгүй. Ноёны зарлигийг давсан балмад боолыг залхаасан тэргүүн туслагчийн түмэн зөв. Хошуу засагт тэрсэлсэн задарсан боолыг барь! Богдын хүрээний алтан бурхны хулгайчийг гавлаад ав! гэж хөгшин түшмэл шүдгүй амныхаа хэмжээгээр хашгирч нэгэн шүүгээнээс гарын гав, цоож хангинуулан гаргах зуур бичээч нарын хоёр нь Базарын хоёр гараас, нэг нь араас нь зуудаг нохой мэт давхийн зуурч авах нь сурмаг шинжтэй. Базарын уур шатаж хамаг эр чадал нь зангираад ирэх шиг болов.

- Да Хүрээнд ч, Улиастайд ч ингэж хэрэг барагдуулж гэмгүй ардын зовлого зулгаадаг болсон юм бий! Үхсэн хүний хохь болдог хаанахын ёс вэ! гэж хэлүүт Базар гараасаа зүүгдсэн бичээч

нарыг хоёр талын хана мөргөтөл түлхэж, араасаа тэвэрсний нь ганцхан шилбүүрдэж хаячихаад бүсэн дэх том хутгаа сугалан

- Зовсон олон ардын гомдлыг та нарын агьаа тайлаад өгье, би! гээд ухасхийхэд хоёр түшмэл хярсан туулай шиг суудалдаа нугдайн шигдэж, омогтой байсан бичээч нар нь хананд наалдан хөшөө мэт хөдлөхгүй зогсжээ. Тэд цөм ухаан алдталаа айж, нүд нь бүлтрэх шахан дагжин чичирч байлаа. Эцгийнхээ амины золиосонд хоёр түшмэлийг нухчихья гэж эрс зориглосон залуугийн санаанд “Ухаан самбаатай, тэвчээртэй яваарай. Тэгэхгүй бол дан ганц зориг тэнэг болдог юм шүү” гэсэн эцгийнх нь захиас гэнэт харван орж ирээд гарыа нь хүлчих шиг болов. Базар занал хорслын хилэнт харцаар тэдний нүдээр дальдартал ширвээд гарч гүйв.

Түүнийг гарсан хойно сая сэхээ орсон жирэвгэр сахалтай түшмэл

- Аагтай зөгийг вэ! гэж амандаа бувтнахад хөгшин түшмэл, -Юо цаадхиа бариач! гэж омгорхуу дуугарахад гурван бичээч давхийжээ.

- Танаас л болж байгаа юм. Би түүнийг чинь аргалаад хэд хонуулаад байна. Маргааш буу зэмсэгтэй хуяг цагдаа бэлдэж байгаад барих гэсэн юм. Өнөөдөр аятайхан хуураад гаргачих байсныг та үргээчихлээ гэж жирэвгэр сахалтыг ууртай дуугарахад

- Эд нараас л болж байгаа юм. Гурвуул байж ганц хүн дийлдэггүй яасан амьд сүгнүүд вэ. Жанжин жасаад ирээд та нар өвс идэж, ус ууж байсан уу? гэж хөгшин түшмэл бичээч нар руугаа уурсахад нөгөөх нь

- Ямар ч гэсэн хүнд ялтай хүнийг алдсаны гэм танд ногдох байх шүү. Би хуваалцаж чадахгүй. Одоо тэр хүн бидний гарт орохоосоо өнгөрсөн гэхэд

- Бэлэн морьтойсон бол одоо мордоод хөөхөд ч барьчихна л даа гэж хөгшин нь арга тасарсан янзтай гүнгэнэв.

Хоёр түшмэлийг ийнхүү бие бие рүүгээ түлхэлцэж суухад Базар Намбаа хоёр Улиастай хотын арын хадан хясааны эрүүгээр тойрч гараад Худагийн ам гэдэг хойноосоо орж ирсэн өргөн амны эхэнд хүрч явлаа.

- Мухар нүхэнд орсон тарвага шиг болох нь энэ дээ. Одоо хаа хүрч үнэнийг олъё гэж бодож байна? гэж Намбааг асуухад

- Хаа ч үнэн алга. Ноёд түшмэдүүд бие биесээ амь нэгтэй өмгөөлж хамгаалдаг юм байна. Ийм болохоор үнэнд хүрэх замгүй юм байна гэж Базар цөхрөнгүй дуугарав.

- Би ч залуудаа чамтай адилхан үнэнийг эрж явсан юм. Энэ цагт үнэнийг олно гэж найдах нь үхсэн эмгэнээс унгас гуйхтай адил. Тиймээс ч ах чинь сайн эрийн замаар ороод зуугийн тал хүрч явна.

- Үнэний замаар явсан хүн мухардаж төгсдөгийг одоо л мэдлээ.

- Эрийн сайнаар өшөө авахаас өөр зам байхгүй. Энэ чинь ухаан, заль, чадал, гурвыг хослуулна

гэсэн үг дээ, дүү минь! Чингэвэл өөрийн санасныг гүйцээж, түмэнд тус болж чадна.

- Тийм бол өнөөдрөөс эхэлье гэж Базарыг шийдмэг хэлэхэд Намбаа яах нь вэ гэж асуусан нүдээр өөдөөс нь харав.

- Улиастайн шоронд тарчилж байгаа улсыг гаргая. Тэд та бид хоёр шиг л үнэнд хүрэх гэж яваад мухарт орж түгжигдсэн улс магад мөн.

- Тэгж чадвал ч олон хүнд буян болно доо.

- Чадахаасаа чадахгүйгээ хүртэл үзээд алдья гэж Базар хэлээд эргэн харахад амны адагт “Хар гэр” гэж нэрийдэгч шоронгийн байшин торойн үзэгдэнэ. Тэр хоёр Улиастайн шоронг шөнө дайрахаар тогтож морьдын жолоог эргүүлэн зүүнтэйгүүр урсаж байгаа Чигэстэйн голыг гаталæ ногоорон дүнхийх их нурууны хөвчид гарч өнжив.

Бүгсэн хоёр харанхуй болмогц бэл рүү буулаа. Тэднийг шоронгийн байшинд хүрээгүй явтал сар мэлтийн гарсан учир Худагийн амны эхээр тойрч жалга уруудан дөхөж очив. Морьдоо бөхөлж орхиод Базар шоронгийн араас шууд мөлхөж Намбаа жалгаа даган баруун талд нь харалдаа очиж хүлээхээр болов.

Шоронгийн үүд сахисан буутай хуяг байшин даширлан мөлхөж ирсэн хүнийг огтхон ч анзаарсангүй. Цоїжтой хаалга руугаа хааяа харах нь байшингийн дөрвөн хананы бат бэхэд найдаж буй бололтой. Тэрүүхэндээ холхиж байгаа хуягийн хөлийн чимээг чагнан байшингийн сүүдэрт хэвтэж байгаа Базар хуягийн ямархуу байгааг харахыг тэсгэлгүй хүсэвч тэвчээр алдан сүү шиг гэрэлд өөрийгөө илчилж, хамаг хэргээ баллахаас болгоомжилно. Базар чилж оршголоо хэдэн мөч хүлээн хэвтгэл хөлийн чимээ намжсанд “Одоо лаа суусан байх. Чухам хаашаа харж байгаа бол? Байшингийн булангаар шагайвал үзчихгүй байгаа даа” гэж тээнэгэлзэн байтал хэт цахих чимээ сонсдов. “Тамхи татах гэж байна. Энэхэн үедээ ч ондоо юм ажихгүй байх” гэж бодоод Базар байшингийн баруун талаар тойрч шагайн харвал, хуяг хаалганы довжоон дээр урагш харан бөгцийн суугаад гаансаа амандаа зуучихсан хэтээ цахиж байлаа. Төдбөн ассан уулны үнэр салхин дагуу ханхийж, хуяг тамхиа асаахаар тонгойход нь Базар барс мэт дүүлэн хүрч очоод дарж авгал хуяг түүний хүчийа нь дагуулан толгой дээгүүрээ давуулж хаяв. Базар арай ч дор нь орчихолгүй босож барьцалдан авлаа. Тэр хоёрыг ноцолдож байтал Намбаа хүрч ирэв. Хоёр эр хуягийг дор нь хүлж хаяад байшингийн хаалгыг онгойлгож хоригдож байсан хэдэн хүнийг суллав.

- Ямар ачтан ирэх нь энэ вэ?

- Буян заяа нь дэлгэрч явтугай!

- Хаанахын хэн гэгч аавын хүүхдүүд вэ?

- Золбоотой эрс юм даа!

- Эндээс мултрах заяатай улс байжээ, бид гэж санамсаргүй суллагдсан тэд баярласандаа болоод ам амандаа шагшин, хэлэх үгээ олж ядан байлаа. Базар сайн хутга эр хүнд нөхөр

болдог юм гэж эцгийнхээ гараар хатааж хийсэн хутгаараа тэдний гав гинжний цүү цуургыг тас тас цохиж салгаад

- Суллаа бол гүйцээ биш үү? Олон үг шалгааж энд зогссоноос дуртай дуртай зүг рүүгээ бушуухан явцгаа! Хурдхан зайлахгүй бол дахиад цаадуулынхаа гарт орчихно шүү гэв. Суллагдсан улс ч чиг чигтээ алга болж өгөв.

- Наадхийг чинь шорон дотор нь хаячих уу? гэж Намбаа хүлэгтэй хуягийг заахад Базар

- Хүний маханд шунасан ноёд түшмэдтэйгээ нийлж олон аавын хүүхдийг зовоосон байлгүй. Манай хошууны тахар Пэрэнлэйн өрөөсөн гуя байхаас зайлахгүй. Цааш нь харуулчихвал буян болох биз гээд буугий нь шүүрэн авч гавал дундуур нь татахаар далайв. Энэ яриаг сонссон хуяг амандаа юм чихүүлсэн учир өршөөл гуйх үг хэлж ч чадахгүй арга барагдан тэрчилж байлаа.

- Дүү минь, өөрийн аминд л тулаагүй бол хүн алж хэрэггүй. Хүний аминд хүрэх шиг адгийн нүгэл байхгүй гэж Намбааг хэлэхэд Базар буугаа чулуудаад хуягийг байшингийн үүдээр дотогш нь шидчихээд морьд руугаа дуугүй алхав.

Тэр хоёр алтан гадасны чигт шөнөжин явж нар тусах үед Улиастай хотоос хоёр өртөө холдож Бумбат хайрхан гэдэг ой мод бүрхмэл, мөнх цастай нэгэн их сарьдаг уулын ард хүрчээ. Зусланд буусан олон айлаас зайдуу ганц гэрт бууж цай уугаад цааш мордлоо.

- За дүү минь! Чиний явдал хэрэг шувтарч шуудрах шиг боллоо. Ах чинь одоо нутгаа бараадъя. Танай тэр хүртэл явж Монголын их элсний араар тойрсноос эндээсээ шууд буцвал ойр гэж Намбаа гэнэт хэлэв. Ганцаар хоцорно гэдэг Базарт нэг л гунигтай санагдавч

- За за, тэгэхээс биш дээ. Алийн болгон миний аяыг дагах вэ гэж арайхийн дуугарлаа.

- Дүү минь, чи ноёд түшмэдээс гуйвраар юу ч олж долоохгүй гэдгийг бат санаарай! Тэд чинь өмнө нь сөхрөё бүр гаардаг юм. Чи хошуу туслагчаасаа өшөөгөө авах хүсэл чинь хэвээр бол адуу малаас нь шилж хөөхөөс өмнөө арга байхгүй.

- Түүний малыг би хаана шингээх вэ дээ.

- Тэр амархан. Надтай сумлахгүй юу.

- Сумлахы ий?

- Тиймээ. Чи сумлахыг мэдэхгүй байх нь хэр. Чи туслагчаас хөөсөн малаа болзоот өдөр товлосон газраа надад тосгуулж өгөөд миний хариас авчирсныг авч буцаад аймаг алсал, хошуу гулгуулж бай! Үүнийг хэлж байгаа юм...

- За тэгье. Эцгийнхээ амийг үрүүлчихээд би яаж хараад сууж байх вэ.

- Тийм бол сайн. Тэгвэл зуны эхэн сарын арван тавны сар мэлтийж байхад мухар Хүнгүйд уулзъя. Чадвал туслагчийнхаа адуун сүргийн манлайг элс давуулан хөөгөөд очоорой! Ширүүн

элдэхэд их Монголын элсийг огтлоод мухар Хүнгүйд хүрсэн морьдыг адууны хүү л гэхээс өөр үггүй. Боломжгүй бол хэрэггүй. Цадуулдаа баригдвал дахиад гараас нь гарна гэж горьдолтгүй шүү гэж хэлээд Намбаа сэгсийтлээ ургасан хууз сахалтай хацраа Базарын хацарт наалдуулан чанга гэгч нь тэвэрч “Салъя гэж салсангүй, салгуу замын эрхээр саллаа” гэдэг чинь энэ дээ гэж инээмсэглээд хангинатал исгэрүүлсээр давхин одлоо. Тэр гуниггүй сайхан эрийн хойноос эргэн эргэн харсаар хатируулж яваа Базар “Энэ хүний дэргэд би ч эр хүн болтол өдий байна. Намбаа гуайн сургамжийг сонсолгүйгээр хөдөлбөл осолдож мэдэх юм даа. Юутай ч гэсэн товлосон өдрөө хоосон уулзахгүйг хичээнэ дээ. Эр хүн мөн бишээ нэг үзье” гэж чанд боджээ.

Базар үдшийн бүрийгээр нутагтаа хүрэхэд гэр нь нүүчихсэн байлаа. Уулын модонд нуугдаж амьтан унтсан хойно айлд бууж сураглаад гэртээ харилаа. Бурхныхаа өмнө сунан мөргөж залбирал үйлдэж байсан эх нь нулимс унагасаар хүүгээ үнсэв. Хагацал үзсэн эх нь энэ хэдхэн хоногт хүүгээ тун их санажээ.

- Ээж минь та эртхэн унтахад яана вэ.

- Иш, хүү минь, ÷и ээжийнхээ зовлонг яаж мэдэх вэ. Шөнө нойр хүрэхгүй хэцүү юм байна шүү дээ. Хэвтэж холхисноос босоо холхисон нь арай дээр юм гэж эх нь өгүүлээд цай чанав.

- Чамайг чинь ирэхгүй болохоор баригдчихсан юм биш байгаа даа гэж хичнээн санаа зовов оо. Ээ, Балданлхам минь! гээд эх нь наманчлав.

- Баригдах ч шахсан шүү. Намбаа гуайн хашрын хүчинд л мэнд гарлаа.

- Тэр чинь хал дол үзсэн айхтар хүн билээ... Үгүй тэгээд очсон хэрэг чинь юу болов? гэснээ эх нь, “Асуугаад ч яах юм билээ. Ямар сайндаа барьж тавих гэж байв гэж дээ” хэмээн аман дотроо үглэв.

- Энэ засагт чинь хүний амиар тоглосон хүн ялгүй байдаг юм байна.

- Тэд чинь тэнгэр язгуурт улс шүү дээ, хүү минь! Тэдэнтэй зууралдвал биеэ зовоохоос өөр юу ч олж долоохгүй. Энэ бүх юм чинь бурхны тааллаар болж байгаа юм. Хүн мэдэхгүй болохоос биш эдлэх жаргал, амсах зовлонгийг маань бурхан л оноож байгаа юм. Дээдэйтэй тэйцэнэ гэдэг чинь бурхны зарлигийг давах гэж байгаагаас өөрцгүй. Бурхан хилэгнүүлсэн хүн ер өөдөлдөггүй юм гэнэ билээ гэж эх нь өөрийн ухаарснаар хүүгээ сэнхрүүлэхийг оролдов. Гэтэл хүү нь,

- Ээж ээ, тэгвэл Аваанлуvsан дүвчин намайг алтан бурхны гүжир хэрэгт түлхсэн чинь бас л бурхан л хийсэн болох уу? гэж сөргөн асуулаа.

- Миний хүүд нэг тийм юм тохиолдох тавилантай байж. Цаад лам нь үнэхээр алтан бурхнаа алдаж л дээ. Харин миний хүү түүнтэй нь орооцолдох учиртай байснаас л тэр. Түүнээс биш эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусыг бодож хорхой шавьжинд хүртэл буян санаж явдаг дүвчин ламтан хүний үрд яагаад ч хар буруу санах ёсгүй. Тэр чинь нэг үгээр хэлбэл бурхны бүрэлбаа байхгүй юу гэж эх нь лам багшаа өмгөөлөв.

Хүү нь эхийгээ өрөвдөөд үг зөрж маргахыг болив. Базар шөнийн хагас ч болов эхдээ хань болъё гэж бодоод биеийнхээ алжаалыг гаргахаар дээлээ тайлж тухлан суулаа. Ханхайж байсан гэрийн зай бөглөгдөж, үймэрч байсан эхийн сэтгэл амсхийв. Эх нь борц нүдэж хоол хийв. Эх нь хүүгээ харан харан баясаж, борцны шөл ууж хөлсөө арчин энэхэн мөчид сэтгэл тэнэгэр сууна.

- Намсрай гуайнх бас энд гэсэн байх аа? Сайн байгаа юу?

- Сайнаа ч алд даа, хүү минь! Манай хотоор чинь манан болж болж л өнгөрсөн.

- Юу болчихоо вэ! гэж Базар битүүхэндээ сэдгэл түгшин асуулаа.

- Намсрай залан гэж том амьтан болчихоод манайхыг бүр тоохоо байжээ. Хөөрхий охиноо Сэр-Од туслагчид өгчихсөн. Түүний хийж байгааг юу ч гэх билээ дээ, хүү минь гэж эхийгээ хэлэхэд Базарын царай барсхийж, түр намжсан сэтгэлийн тайвшрал нь алдагдав. Тэргүүн туслагчид алхам бүрдээ чадуулж байгаагаа санахаас түүний уур хилэн, өшөө хорсол нь цээжиндээ багтаж ядан оволзов.

- Юмжирдулам тэгээд тэр хөгшин туслагчтай суучихлаа гэж үү?

- Түүний дураар болох биш дээ, хүү минь. Орилуулж чарлуулж байгаад л аваад явсан. Балданлхам минь, одоо ч гэсэн түүний дуу чихэнд хадах шиг болох юм...

- Би хүний хүү юм бол түүнтэй эрэгчин эмэгчнээ үзэлцье ээ!... Юмжирдуламыг тэр хөгшин түшмэлд яасан ч зовоолгохгүй гэж Базар биеэ барьж чадалгүй санаснаа хэлчихэв.

- Яах юм бэ, хүү минь! Тэдэнтэй дахин бүү тамцагла! Түмний охиныг түймэр идчихсэн биш. Чамд хань олдоно. Хэл амтай юмаар хөөцөлдөх хэрэггүй. Хөөрхий охин минь тийм л төөрөгтэй юм байлгүй гэж хориглосонд хүү нь

- Цаадуул чинь энэ муу гүзээ намсрайтай нийлж юу юу хийж байгааг та бэлхнээ мэдэж байж юунд ингэдэг юм бэ гэж уцаарлав.

- Бурхан мэдэж байгаа шүү дээ, хүү минь! Ээжийнхээ үгэнд ор! гэж эх нь цөхрөнгүй дуугараад “Миний үйлийн үр яасан барагддаггүй юм бэ? Энэ хүүхдийг муу зүгийн юм хорлочихож. Ийм зантай хүүхэд байгаагүй юмсан. Одоо яана билээ. дүвчин ламтанд айлдвал аргалж өгөхсөн болов уу” гэж бодон нулимсаа арчлаа.

Айлынх нь баян тайж Намсрай хоёр Сэр-Одын хуриманд явчихсан учир Базар айхын аюулгүй амад жимэр нойрсоод өглөө яаралгүй босож Оршихтой уулзаж тэргүүн туслагчийнхны нутаг, байр байдлыг сураглав.

- Чамайг чинь Улиастайд баригдчихсан бололтой юм манай энд ярьсан. Гэтэл энд явж байдаг, мөн хачин аа! Чи яагаад баригдчихалгүй яваад байдаг хүн бэ? Би л бол аль хэдийн өнгөрсөн. Өдийд яс ч үгүй болсон байх гээд Орших түүнийг машид гайхан харж байлаа.

- Би хүнд үзэгдэхгүй болчихдог ид шидтэй шүү дээ. Далдын хар малгайтай... гээд Базарыг

инээмсэглэхэд

- Аягүй л бол тийм байх гээд Орших өөдөөс нь бүлтийтэл ширтсэнээ
- Чи туслагчийнхаар яах гээ вэ? Хатный нь булаалдах гээ юу! Туслагчид хүзүүгээ тас мушгиулах чинь дутаа юу гээд инээв.
- За за, чи намайг шалаад байхаар мэдэж байгаа юм байвал яриатах!
- Туслагчийн хурим дөнгөж өчигдөр эхэлсэн. Хөлгүй найр болж байна гэнэ билээ. Гурван өдөр хуримлах юм гэнэ шүү.
- Чи тэр хуриман дээр нь очив уу?
- Эсгий хийх газар хүүхэд нохой хоёр хэрэггүй гэгчээр туслагчийн хурим Оршихоор яах вэ.
- Чи чинь туслагчийн хүргэн болох гэж байгаа хүн шүү дээ гээд Базар доогтой инээхэд
- Ядарсан хүнээр бүү оролд! гээд Орших жуумганаж, харин тэр хуримын чинь буянгаар согтуу улсыг элэг барьж урьд шөнө Пагматайгаа ганц тавтай учирлаа шүү гэв.
- Чи тэр хүүхнээрээ дамæуулж Юмжирдуламд хэл хүргэ! Өнөө орой намайг очиж магадгүй, сэргэг бай гэж хэлүүлээрэй!
- Намайг туслагч харчихвал би сүйрнэ шүү дээ.
- Хөлчиж үймсэн хүмүүс хайхрахгүй. Туслагч өргөөнөөсөө гарч гүйгээд байхгүй нь мэдээж. Чи нэг сиймхийгээр нь тэр хүүхэнтэйгээ шурхийж уулзаад чихэнд нь шивхийчих гэж Базар үнэхээр арга мухардсан янзтай махруун гуйлаа. Оршиб туслагчийн нүдэнд өртөж дахин баалуулахаас айж байсан ч гэсэн өнгөрсөн өвөл өөрийн нь зээрэнд хэдэн удаа дагуулан явж ангийн олзоо хуваасны хүчинд гэдэс цатгалан онд орсноо бодохоор энэ сайхан сэтгэлтэй залууд тус болохоос аргагүй болжээ.
- Би ч өдөр очихоосоо айгаад байна. Гэсэн ч азаа үзье. Чамд яаж үгүй гэх вэ гэж Орших ам өгсөнд Базарын санаа амрав.

Арван долдугаар бүлэг

Үймээн наргиан

Ховсоргон нь шударгаа мэргэ

Худал нь үнэнээ залгимой

Оройн шар наран онгон тэнгэрийн баруунаа шургах дөхжээ. Уулын тунгалаг голын өнгийн цэцэг дэлгэрсэн сэрүүн сайхан зүлгэн дээр улаан халзтай том том цагаан гэр цайран харагдана. Энгийн цагт хөл хөдөлгөөн багатай дүнсгэрдүү байдгаар үл барам өмнүүр нь унаатай хүн өнгөрөх цээртэй, хэн нэг нь гэнэ алдан холуур ч гэсэн явж орхивол шаахай, ташуурын амт үзэж салдаг энэ хот өнөөдөр хүн, малын хөлд бүрнээ дарагдан хатуу дэг журмаа алдсан бололтой. Шинэ сайхан өргөө төхөөрч, үзэсгэлэн гоо залуу хатан таалж, хурим хийж байгаа тэргүүн туслагчийнд ирсэн гийчдийн морьд багширч, амьтан хүн үймэлдэнэ. Найр наадмын дуу шуугиан сонсдож, гуйвж дайвсан хүмүүс нааш цааш хөлхөлдөнө. Гаднаас хүн нэмж ирнэ үү гэхээс биш, хүн үл явах нь олны хүслийг булаасан элбэг дэлбэг найр болж буйнх аж.

Базар өргөөний дэргэдэх ойд бүгж эл бүхнийг ажиглан суухдаа “Агуйд нуугдан бэлчээрийн хонь харуулдан эзнийг нь холдмогц шогших гэж байгаа өлөн хөх чоно шиг хүний нүднээс дайжиж явах ч гэж дээ” хэмээн бодно. Туслагчийн өргөөнөөс хатад бололтой хэдэн авгай хэлхэлдэн гарч явахыг Базар дурандав. Юмжирдуламий хоёр талаас ахимагдуу насны хоёр хээнцэр авгай зүүгдэж, зарим нь урд хойно нь ихэмсэг алхах нь түүнийг оргон босохоос сэрэмжилсэн бололтой. Юмжирдулам толгой дээш татахгүй тонгойн явах нь уйлж унжиж гутруу байгаагийнх биз гэж залуу таамаглаад “Хичнээн хоног уйлсан бол доо. Хүний нулимс яасан ч дуусдаггүй юм бэ. Зовлонг хүртээмжтэй амсах гэж хүн, тэр дундаа бүсгүй хүн ийм арвин нулимстай төрдөг юм болов уу” гэж бодохоос ухасхийн мордож хар хурдаараа давхин хүрээд хайрт хүүхнээ бүргэд мэт шүүрэн авч давхин одмоор санагдана. Орж гарч байгаа хүмүүсийн дотор зуны халуунд бүдүүн өмднөөсөө салаагүй хоёр иргэн паацга паацга алхаж үзэгдэв. “Пүүснийхэнд долигнож данжааийг нь урьж дээ. Энэ хуримыг хийхдээ тэдэнд хичнээн лан мөнгөний өр тавьсан бол? Ичихгүй түүнийгээ айл өрхөд хувааж төлүүлнэ дээ. Ноёд түшмэд яахаараа эрээ цээргүй загнадаг юм бол” гэж Базар бодлоо. Сэтгэлтэй хүүхнээсээ дурангийн хараа салгалгүй баахан харж байснаа санаа алдаж дурангаа сая өвөртлөв.

Шөнө болоход найрчдын орилж бархирах нь улам ихэссэн нь сархдандаа дийлдсэнийх ажээ. Базар адуунаас өглөөхөн юүлсэн хоёр сайн морио бөхөлж орхиод айлын нутаг дээрээс түүж авчирсан хөсрийн сав суулга мэтийг барьсаар зөргөөний хот руу алхаж явахдаа “Бусдын зовлонгоор олсон жаргал жаргал болдог юм байх даа. Хэний ч бодоожоор Сэр-Од туслагч буруутан байтал зөв болгоод гэмгүй бид буруутан болдог ямар учир байна вэ” гэж бодно. Тэгээд сайхь эр морьдын дунд сэм гэтэн орж өөрийн таних хоёр омголон морины сүүлнээс өнөөх сав суулгаа уяад айлын түлээний ёроолд нуугдан хэвтэв. Тэгтэл ч төмөр хангир жингэр дуугарч морьдын хамар тачигнан хуурч байгаа тариа шиг зүг зүг тийшээ бут үсэрч пижиг пажигхийн давхилдав. Гөлөм дэр дэрхийн дэрвэж, дөрөө хавиралдаж эмээлийн мод тасхийн хугарах чимээ ч гарав.

Найрчид үүрээ эвдүүлсэн зөгийг шиг дуу тавин шуугилдаж гэрээс нэг нэгийгээ дайрч унаган сад тавин гарцгаалаа. Сандарч балмагдсан хүмүүсийн бүдүүн нарийн дуу хавь орчноор нэг хадаж

- Хүүе, хайя! Түргэлээрэй!

- Бурхан минь, юу болох нь энэ вэ?

- Миний морь хаа байна аа!

- Хар уснаас болж хайран эмээлээсээ саллаа! гэж хашгирч гуугалдан давхин одсон морьдынхоо хойноос гүйлдэнэ. Зарим нь унан тусан хэд харайснаа

- Яршиг цаашаа! Өглөө олдоно л биз!

- Үргэсэн адгуусыг харанхуй шөнө хаа гэж эрж явах юм бэ гэлцэнэ.

Хэн нэгэн хорон санаат хүн морьд үргээсэн гэж сэжиглээгүй учир бүх найрчид тэр шуугианаар унаагаа барьж авахаар санд мэнд гадаа гарцгаажээ. Нэгэнт хэл дуулсан Юмжирдулам юу болохыг мэдэж байсан учир энэ үймээнийг далимдуулан гарах гэтэл Сэр-Од ханцуйнаас нь зуураад босгосонгүй. Юмжирдулам гарч ирэхгүй байхад нь Базар хагалсан түеэ авч ардаа бариад туслагчийн өргөөнд харайж ороход Юмжирдулам давхийн босож гэнэгүй суусан туслагчийн гараас алдуулан гүйж ирэв. Сэр-Од ч Базарыг орж ирснийг мэдээд барьж авах гэж зүтгэлсээр тархин дундуураа татууллаа. Сэр-Од хашгирч ч чадсангүй нам унав. Базар бүсгүйн гараас шүүрэн авч бужигналдан байгаа олны чөлөөгөөр гүйв. Хоёр морь нь эзнийхээ дэгдээсэн үймээнээс болоод бас ч баахан холджээ.

- Хоёр сөдрөг чинь хаа÷чихав аа? Энд орхисон юмсан. Яасан үйлс нь хазайсан юм бэ гэж Базар зүхэж Юмжирдуламыг хөтөлж модон дундуур өөд сөөргөө гүйж явахдаа “Оршихыг гуйж морио бариулаад суулгах минь ч яалаа” гэж цухалдана.

- Базар минь, миний заяа дутахад л энэ биз. Надаас болж чи минь хэрэгт орох нь. Намайг орхиод эндээс зайлж үз! гэж бүсгүй уйлагнана.

Тэр хоёрыг унаагаа эрэн мунгинаж явтал тахар Пэрэнлэй улаан хөлз мөргөлдөв. “Чи ч ингэж л миний аманд унаж үхнэ дээ. Тэгэлцэг болтол чинь хүлээд туслагчид өгчихье өө” гэж тахар занаад

- Чи муу зулбасга ийм хэрэг тарьсан бий! гээд барьж авахаар ухасхийхэд нь Базар ганцхан цохичихоод зугатав. Хөсөр унан хоцорсон тахар төдөлгүй сэргэсэн авч Базараас эмээн ойр тойрноо хянамгай харснаа

- Таминь ээ! Наашаа яваарай! Хатныг оргууллаа! Бушуулаарай, бушуулаарай! гэж хар тэнхээгээрээ бахирчээ. Морьдоо олсон зарим нь энд тэндээс ирж

- Юу гэнэ ээ?

- Хатныг хулгайлсан гэж үү?

- Хэн тэр вэ? гэж агадаж гайхах зэрэгцэн асуув.

- Тийм тийм! Намайг ээрээд байхаар цаашаа түргэн яв! Цаана чинь өнөөх Базар гайхал! гэж Пэрэнлэй уцаарлан тэр хоёрын явсан зүг гар даялан зангав.

- Туслагчийн хатныг оргуулж гэнэ ээ.

- Тэрслүүг одоохой бариарай, даминь ээ! гэж согтуу хүмүүс ам амандаа бархиралдан модон дундуур учир начиргүй сүлжин давхилдана.

- Морь, морь! Чамайг би гартаа хийхгүй бол тамгын тахар биш, малгай өмссөн мануухай болох вий! гэж Пэрэнлэй ам алдаж, нэгэн хүний морийг булаан авч мордоод ухасхийв.

Базар Юмжирдулам хоёрыг морьдоо олж амжаагүй явтал нэгэн хүн давхин ирж таниад

- Хүүе, өнөөх хоёр чинь энд явна! Нааш яваарай! гэж хашгираад,

- Тархийа чинь хага цохичихье, чамайг! гээд ташуураа далайн буулгахад нь Базар бултан хий цохиулаад түүний гараас ташуурыа нь шүүрэн авч тархин дундуур нь татаад бүсгүйг хөтлөн цааш зугтав.

- Юмжирдулам минь! Бид хоёр одоо зууралдаад тусгүй. Хоёул баригдана. Чи минь модон дотуур нуугдаж яваад хөл дүүжлэх юм барьж унаад зугатах арга бод! Шар нуруунд л гараарай! Би эд нарыг хоргоож байя гэж Базар хэлээд юмжирдуламыг явуулав. Тэгтэл нэг хүн давхин ирээд Базарыг барьж авах гэхэд нь хулхи руу нь дэлсээд цааш харайв. Хоёр морьтой хүн давхин ирж мориноосоо буун гуйвалзан дайрахад нь Базар хоёулангийнх нь шилэн хүзүүнээс базаж духаар нь мөргөлдүүлсэнд хамар амнаас нь цус садарч хоёул зэрэг муухай орилон хоцорчээ. Базар нэг морийа нь арайхийн барьж автал мордохын завдалгүй хэдэн морьтон нөмрөн орж ирэв. “Хаашдаа ч өнгөрлөө шүү. Гэлээ ч шөнө байна. Эд согтуу, би эрүүл. Нэгийгээ үзэлцдэг хэрэг” гэж залуу эр бодоод модноос бүдүүн гишүүн хуга татан авч аль ойртсоныа нь цохиж унаган ухран явсаар байлаа. Тэгэвч “Хатан орголоо” гэдэг үгийн дуунаар сандарч тэвдсэн олны нэг хэсэг нь Базарыг бүсэлсэнд хаашаа ч гарахын аргагүй болов. Базар гишүүгээ толгой дээгүүрээ хий эргүүлэн хүн ойртуулахгүй байснаа цөөн хүнтэй газраар нь гэнэт нанчилдан дайрч гарах боловч дахин бүслэгдэнэ. Хүмүүс морьдоо орхин дор дороо гишүү авч нүдэлдсэнд мод тас нясхийж, пид пидхийн чимээ гарч хүн ёолж бахирна.

- Бариад ав! Бариацээ! гэж хашгичих авч хэн ч халдаж үл зүрхэлнэ. Тэгтэл тахар Пэрэнлэй давхин ирж морио хүнд өгөөд,

- Миний гарт үхэх үйл чинь ирж дээ. Эцгийн ÷инь хойноос сүнсийг чинь тонилгоод өгье! гээд учир начиргүй дайран орж Базарт нам цохиулан хөсөр ойчив. Түүнээс хойш хүмүүс айчихаад дэмий л алсуур тойрон нанчилдахаас үл хэтэрнэ. Базарын гар дээр хэн нэг нь цохичихсонд дуу алдан гишүүгээ алдав. Энэ хооронд гартаа бүлтэй нэгэн хүн түүний араас шурхийн тэвэрсэнд мултрах гээд чадсангүй. Базар “Ингээд л баригддаг байж дээ. Олон хүн

гэдэг айхаа ч мэдэхгүй ямар айхавгар юм бэ!” гэж бухимдаж тэр хүний бүснээс нь өрөөсөн гараараа бариад дүүгүүрдэж хөлөөр нь мод гууясанд нөгөө хүн амь тавин орилж гараа тавиад газар уналаа. Базар гишүү шүүрч авахаар тонгойтол бүдүүн шийдэм тархин дундуур нь бууж, дотор нь харанхуйлан хөл нь гуйвав. Нэг тийш бултахыг заагтал олон хүн тал талаас нь уулгалан дайраад зуурч авлаа. Морьдоо олсон хүмүүс ооцрог болон ноцолдож байгаа олны чимээнээр давхилдан ирж тойрон бүчээд хэрхэхийг саваагүйтэн сонирхоно.

- За чи хүний унаа явгалдаг хар санаатан бий!

- Энэ ёозоороо бол чи хэзээ ч өөдлөхгүй.

- Дээд язгууртны хатанд санаархдаг увайгүй золиг вэ! Заяа чинь дутна даа.

- Үхэх газрын чинь шороо энд пурхийж л дээ.

- Чи тийм дориу эр юм бол бидний гарын аргийг хэр даахыг чинь үзье.

- Чөтгөр шулмын санаатныг бүү хайрла! Тонилговол таарна!

- Санаа муутай нохойн гөлгийг яасан ч яадаг юм! гэсэн хараал зүхлийн үй дийлсэн олны амнаас сонсодно. Гэтэл тойрон зогссон морьтой, явган хүмүүсийн зарим нь,

- Зовлон үзсэн хүнээр яах гэсэн юм бэ, тавьчих!

- Эцгээ алдчихаад аргаа барж яваа амьтныг зодож юу хийх вэ?

- Туслагчийн хатныг аваагүйгээс л цааш наадахиа орхичих!

- Уг нь наадхийн чинь багын сүйтэй хүүхэн гэдэг шүү.

- Тэгвэл ч ингэх нь аргагүй юмсанж.

- Тэр хүүхэнд хөгшин түшмэлээс энэ залуу нь дээр байлгүй яах вэ гэцгээнэ.

Сэр-Од нилээд удаж байж ухаан оржээ. Толгой нь эргэн хөл нь туйваад тун ч амаргүй байлаа. Гэсэн ч сүр дуулиантай хуриман дээрээсээ хатнаа алдаж хошуунд багтахгүй шившиг болохоос айхын сацуу өөрийг нь алга байхаар архинд хөлчсөн найрчид хатнай нь эрж олохыг мэрийлгүй эргээд ирж мэднэ гэж хар санаад хатан Базар хоёрыг хоёулангий нь барихыг тэсгэлгүй хүсэх учир нэг хиа дагуулан морджээ. Морь давхихад толгой нь ангалзан өвдөвч чимээ шуугиан гарч байгаа зүг чигийг баримжаалан шүд зуун тэсэж явахдаа дайралдсан бүсгүй хүн бүрийг зуурч аван үзэх шахсаар овоорон ноцолдож байгаа хүмүүс дээр хүрч очив. Туслагч Сэр-Од Юмжирдуламын оргосонд уурсаж байсан хэдий ч үзэсгэлэнт хатнаа олны хөл дор үнгэгдэж байна гэж санаад хайрлан харамсах сэтгэл төрж,

- Та нар хүн аллаа! Хойшоо болцгоо! гэж хашгираад мориноосоо санд мэнд бууж тэдэн рүү дайран зүтгэлэв.

- Хатнаа хулгайлсан хүнийг мөн их хайрлав аа!

- Ингэхий нь мэдсэн бол дэмий цус нөжөө амсав байна.

- Манай туслагч ийм ч зөөлөн сэтгэлтэй хүн бишсэн гэж зарим нь харанхуйгаар далимдуулан тохуу хийжээ.

- Аа золиг, өнөөх гайхал уу? гээд Сэр-Од ухарч, хатан хаа байна? Хатан хаа байна, таминь? ǎэж уулга алдан асуусанд түүний арчаагүй байдлыг харсан хүмүүс нирхийтэл инээлдэв.

Олон хүний хөл дор орсон Базар газар бөмбөрдөн давхиж байгаа морин төвөргөөнийг сонсож, хайрт хүүхнээ давхин одлоо гэж санан өөрөө дийлдсэн ч сэтгэл нь онгойх шиг болов.

- Өнөөх чинь унаажаад зугаахлаа!

- Яваарай, давхиарай! гэж модон дотор эрэл хийгсэд хашгирч, хошууран давхилдлаа. Түрүүчийнхээ зодуулсанд хорсож занасан согтуу хүмүүс нэгэнт дийлснийх гэсэн шиг Базарыг дураараа балбаж байлаа. Тэргүүн туслагч түүнийг өөрийн гараар хатуу шүүж өшөө авахыг хүсэх учир

- Та нар больцгоо! Наад хүний чинь түйвээсэн хэрэг ганц энэ биш. Тусгайлан хүндээр цээрлүүлбэл зохих ялтай хүн. Бухын хүзүү бүдүүн ч буулганы дор байдаг, буруу хэрэгтэн хүчтэй ч хуулийн дор байдгийг сэнхрүүлээд өгнө. Одоохон хүлээд авч яв! гэж Базарыг тэдний хөл дороос салгажээ. Оргон зайдсан хатан ч хол явж чадсангүй тэр дороо баригджээ.

Өшгөнөө өвдөг дороо хийж санаа амарсан тэргүүн туслагч оргосон хатныǎ нь олох гэж хөөцөлдсөөр архи нь гарч алжааж сульдсан гийчдээ хөгөөхөөр найр цэнгэлээ үргэлжлүүлж байлаа. Туслагч Сэр-Од луун хээтэй даацай торгон дээл дээр уужим хэлдгэр ханцуйтай хилэн хүрэм өмсжээ. Юмжирдуламын үсийг хагалан самнаж хоёр том даргад үс болгон цавуудаж, сэргэр мөртэй эхнэр дээл өмсгөж элдэв гоёл зүүжээ. “Чи ч одоо миний гараас гарах өнгөрсөн. Харуул гаргаж найрчдын морийг харж байна. Хаашаа ч хөдөлнө чагаас салахгүй. Чи оргож алга болж нэрийǎ минь хөөдөх ганц шахлаа. Хатан минь бишсэн бол ч банз шаахай баримаар уур хүргэсэн шүү” гэж туслагч бодно.

Гэр дүүрэн хүн наргиж байхад Юмжирдулам л ганцаараа гэнгэнэтэл уйлж сууна. Түүнийг модны ёроол бараадан хүний хөлөөс бултан бултан явтал цулбуураа чиргүүлсэн морь ногоо идэж зогсоход нь барьж авчээ. Унаатай болсондоо учиргүй баярласан хүүхэн сэмхэн явж эрлийнхээс холдохоо ч бодсонгүй мордоод л ухасхийв. Морь нь хэдэн мод газар дориун давхиснаа сүүлдээ бандага бандага цогив. Нэхэгчид шуугилдан пижигнэтэл давхилдаж араас нь ойртох бүр Юмжирдулам улам бачимдан цулбуураараа ороолгон давдөвч морь нь цогихоо болиод пал палхийн хатирав. “Ядарч явахад ийм унаа таардаг яав даа. Одоо яадаг билээ” гэж Юмжирдулам уйлагнан дөрвөн мөчөө савчин урагш тэмүүлэн зүтгэж нэг нарийхан хөндийг огтолж цаад уулын модны хаяанд арайхийн хүрч газар хороохоо больсон морио орхиж цааш гүйтэл хүмүүс давхин ирж түүнийг ойн гүн рүү орохын тухандгүй барьж авчээ. Юмжирдулам аргаа барахдаа модноос зууран уйллаа. Түүнийг хэн ч өрөвдөж хайрласангүй, хамхуул шиг шүүрч аваад оджээ.

Сайхан учралаар оргож чадаагүйдээ өөртөө гомдож, бас баригдсан хайрт хүндээ санаа зовсон хүүхэн “Би ч яах вэ, дүүрсэн хүн. Надаас болж Базар минь хэрэгт орлоо. Эндээс зайлж гарах ч эрхгүй би түүндээ яаж тус болох вэ” гэж гансран сууна. Хоёр өдөр хэлэн дээрээ бараг юу ÷ тавилгүй уйлж гонгиносоор байгаа хүүхэн найрын шуугиан, архи дарсны үнэрээс залхаж гүйцжээ. Чих нь дөжирч, толгой нь өвдөж, тамир тэнхээ нь алдарчээ. “Базар минь, чи минь яана даа, яана” гэж хүүхэн зүрх шимшрэн гасална.

Амраг сэтгэлийнхээ алтан шижмийг хошууны тэргүүн туслагчид тас атгуулсан янаг хосын нэг нь айргийн гэрт хүлээтэй хэвтэж байлаа. Түүнийг Пэрэнлэй харгалзан сууна. Тахар, Базарт цохиулж булдруутан хавдсан толгойгоо барьж

- Чиний зооны чинь махыг зулгааж хариугаа авна даа гэж занахад Базар

- Чи самуун туслагчтайгаа нийлж эцгийг минь алснаа мартаж болоогүй шүү. Одоо миний махыг идэх чинь дутаа юу? Наашаа хүрээд ир! хүлэгтэй ч гэсэн чамдаа зөв гэж тэмүүлэхэд Пэрэнлэй “Энэ ер нь хүлгээ тас татаад ч босоод ирж чадах ороолон шүү. Мүдүүгүй байхгүй бол горьгүй” гэж цөсөө хальтал айж байв.

- Хүлэгтэй хүнээс айж байдаг ёстой амьд сүг юм даа, чи! Та нарын гараас амь голтой гардаг юм бол өшөөгөө авахдаа л авна гэж залуу сáíàлхийлнэ. “Эднийг би хичнээн занаад ч яах юм билээ. Тэртэй тэргүй гарт нь орчихсон хэвтэж байна. Ээжийнхээ үгэнд ордог байж үү дээ. Найран дээр олон хүн цугласан байхад ийм ул муутай юм хийсэн маань хамаг замаа хааснаас хэтэрсэнгүй. Уг нь хуримнаас хойш туслагчийн санаа сэтгэл тайвширсан үед гэнэгүй байтал нь Оршихын сэтгэлтэй шивэгчин хүүхнээр хэл дамжуулж оргуулсан бол түвэггүй байж. Ай, бас тоогүй юм боллоо. Ухаангүй хөдлөхийн гай л энэ. Эцгийнхээ үгийг эргэцүүлж нэг бодох минь яалаа” гэж Базар өөрийгээ зэмлэн халаглаж хэвтэнэ. Олон хүний гарын хор орсон хамаг бие нь хөндүүрлэж, аргамжны сур маханд нь шигдэж өвтгөнө.

Шивэгчин Пагмыг айраг авахаар орж ирэхэд туслагчийнхаа хуриман дээр шавайгаа ханатал архидах гэсэн хүсэл нь гэнэтийн энэ сааднаас болж бүтээгүйд бухимдаж суусан Пэрэнлэй,

- Найр ёстой сайхан дээрээ байгаа биз? Чимээ нь нэг л сэтгэл татам байна. Энэ босоо ороолонгоос ганц боллоо гэж үглэхэд шивэгчин

- Хэлээд яах вэ, буянтай хүний найр гэхээрээ өөр байна. Та орооч! Энэ хүлэгтэй хүн яав л гэж гэсэнд

- Туслагчтай толгой авна... Харин чи жаахан архи олж өгөөч! Би эндээ хувиа борлуулж сууя гэвэл

- Туслагч мэдвэл би толгойгүй шүү дээ гэхээр нь Пэрэнлэй

- Ах нь чамайг хөөдөхгүй. Би хэнд ч мэдэгдэлгүй уучихаж дөнгөнө. Ганц аягыг ч атугай өгчих гээд хэл амаа долоов.

- Та намайг өгсөн гэж хүнд хэлэхгүй биз. Архи ч ус цас шиг л байна гэж шивэгчин архинд

дуртай тахрынхаа овый нь хөдөлгөөд “Ам өчгийг нь авч байгаад ганц аягыг уугаад нам унах арз өгчихье. Тэгвэл Оршиход минь тус болдог энэ сайхан сэтгэлтэй залуу аргаа олоод сулрах байх” гэж бодов.

- Ах нь тэгж хилэнц хураах хүн биш гэж Пэрэнлэйг ам өгсөнд шивэгчин нэгэн лонх арз авчирч хоёр гардан барив. Пэрэнлэй архинаас нэг аяга хийж аваад ховдоглон балгаснаа

- Аах! Гал залгиж байгаа юм шиг гэж ярвайн толгой сэгсрэв.

- Пэрэнлэй гуай! Энэ хүн чинь яасан муухай харах юм бэ. Би айгаад байна гэж шивэгчинг айраг уудалж байхдаа хэлэхэд тахар

- Хавхайд орсон чоно ёггэж хардаг юм. Айлтгүй. Өөдөөс чинь хүйтэн харвал толгой дээр нь гишгэж орхиорой! Чамайг яаж ч чадахгүй... Арга ядахдаа л хараана биз. Ха ха ха. Хавхтай чоно хичнээн муухай харлаа ч ан-ны гарт амиа алддаг ёстой. Наадхийн чинь харцнаас айдаг цаг өнгөрсөн. Одоо сайран хамар дээр нь ганцхан цохих л үлдээд байгаа юм. Ха ха ха гэв.

- Хүлэг нь сайн юм биз. Босоод ирэхгүй байгаа даа гэхээр нь

- Санаа зоволтгүй. Өндийвэл тахар нь тоншчихно гэж Пэрэнлэй хэлэв. “Энэ муу хүүхэн чинь харц барлаг л байлтай юм. Хүний мууд яасан дуртай амьтан бэ! Энэ ёозоороо бол ч чи хушуугаараа хоол олж иддэг биз... Нөгөө Оршихын учирдаг шивэгчин ямар хүүхэн байгаа бол? Тэр л тус болж магадгүйсэн. Нэрийг нь асуудаг байж. Ядахдаа байр төрхий нь асуух минь ч яалаа. Ийм юм болно гэж огтхон ч зүүдэлсэнгүй. Бүх юм санаснаар болчих юм шиг бодож дээ” гэж Базар бодон дэргэдээ зогсож байгаа хүүхэнд уурсан хэвтгэл нэг юм подхийн унах шиг болсонд цочин харвал жижигхэн хутга байв. Тэр хутгыг хүүхний элэгдэж хуучирсан гутал тахрын нүднээс халхалж байлаа. Базар Шивэгчнийг санамсаргүй унагаачихав уу, яав гэж гайхан нүүр өөд нь харахдаа түүний айж эмээсэн харцтай тулгарав. Базар хутган дээр өнхрөхөд шивэгчин

- Хүүе, энэ хүн чинь! гэж хашгиран айсан хүн болж холдон явлаа.

- Мөрөөрөө шиг байж чадахгүй бол тархийг чинь хага цохино шүү гээд Пэрэнлэй ташуураа далайн сүрдүүлнэ. Тахар архиндаа шунан Базарыг төдий л анзаарахгүй, хааяа нүднийхээ булангаар хяламхийн харчихаад архиа тухтай болгож сууна.

Энэ үед туслагчийн өргөөний найр хавтгайрч эх адгаа алдаад байлаа. Энд тэндгүй хэсэг бусгаар дур дураараа дуулж орилолдоно. Хуримын хүндтэй зочны нэг Агваанлуvsан дүвчин ч согтож, жижигхэн толгой нь нарийхан хүзүүн дээрээ бөнжигнөх нь мэргэн гоодой шиг харагдана. Дүвчин өөрийн мэргэнийг гайхуулан ярихыг санаархаж шоогоо гаргаж орхиод,

- Сүсэгтэн олон шавь нар минь харцгаа! Ингээд л манай тэргүүн туслагч, хатан хоёрын заяа нь нийлсэн шоо бууж байгаа юм. Тиймээс ч өгөөмөр баян хурим болж байна гэж хүн хүнд сайрхан харуулахад Юмжирдулам түүнийг хөмсөг зангидан хялайн харсанд дэргэд нь сууж байсан настай авгай,

- Охин минь, лам багшаа тэгж харж болохгүй. Алдас болж буян заяанд чинь цөа орно гэхэд Юмжирдулам,

- Хүний сэтгэлийг зовоож нус нулимс барсан ийм хуриманд сайхан юм хаа байна? Та нарт л баяр юм уу гэхээс надад тамаас ялгаа алга гэж ууртай дуугарав.

- Хай! Ийм сайхан залуу амьтан хөгшин түшмэлтэй яаж нэг насыг барна гэж халаглах дуу хаяанаас гарав. Энэ үгийг сонссон дүвчингийн уур хүрч

- Бурханд харш үг хэн хэлэв? Хэн хэлэв? аэж баруун зүүн ханыг тойруулан харсан боловч эзнийа нь олсонгүй. Согтуу хүмүүс хэнийхээ тэгж хэлснийг ч оноож мэдэлгүй өнгөрчээ.

- Энэ орчлонгийн амьтны хувь тавиланг бурхан л соёрхон гийгүүлж байдаг юм. Бурхны номыг сэтгэлийн угаас хичээнгүйлэн шүтсэн хүнд дээд тэнгэрийн хишиг заяана. Сүжиггүй хүнийг бурхан мөн л үл өршөөнө. Сүх өвгөн шажин бурхныг харааж явсаар нүглийнх нь сав дүүрч усан тулам болтлоо хавдсаар талийсан. Надаар поогий нь түлхүүлсэн. Би түүнийг диваажинд төрүүлэе гэж хамаг чадлаа шавхан мэрийсэн боловч бурхан шажинд тэрсэлсэн барагдашгүй нүглээсээ болоод сүнс нь өөрийн эрхгүй тамын орон руу явчихсан. Энэ насанд нүгэл их үйлдвэл хойт насандаа их зовлон эдэлдэг юм шүү. Сүх бол нэг ёсондоо ландрамын төрөл байсан юм. Хүү нь ч одоо эцгийн мөрөөр оржээ. Бурхны сургаалыг огоорон тэрсэлбэл ийм болдог юм. Та нар ариун бурхан шажиндаа сүсэглэн залбирч, амь насаа даатгаж яв! Бурхны ном шиг гэгээн үнэнийг заагч хосгүй судар энэ ертөнцөд үгүй. Манай улсын бурхан номын эзэн Богд Жавзандамба хутагтын мэлмий түм буман шавь нараа гийгүүлэн харж байдаг юм. Би цагаан сараар оройн дээд Очирдарь багшдаа мөргөж, их сахиусанд нь өчүүхэн биеэ даатгаад ирсэн. Би бурхны тусын тулд энэ биеэрээ зулын гол болж буян хийхээс ч буцахгүй! гэж согтуу дүвчин ам мэдэн чалчихад хүмүүсийн зарим ньбишрэн залбирч, зарим нь тохуурхан инээж байв. Дүвчин чөргөр гараараа тагштай архиа хоёр гардан зулай дээрээ өргөж

- Шашин, төрийн эзэн Богд хааны ариун лагшин энх тунх орших болтугай! гээд уухад

- Богд гэгээнтэн манийгaa өршөөн хайрлах болтугай!

- Бурхан тэнгэр минь ивгээн тэтгэтүгэй! гэж хүн хүн нэг юм хэлж хувь хувиа ууцгаалаа. Агваанлуvsан толгойгоо түнжигнүүлж,

Зуун лангийн жороо луусыг

Жуузан дундаа хөлөглөнө

Зураг болсон Богд ламыгаа

Зулай дээрээ зална

гэж тийм хатмал давжаа хүнд баймааргүй паргиатсан сөөнгө хоолойгоороо эв хавгүй дуулахад найрчид даган орилолдов.

Дүвчингийн яриа Сүх дархны явдлаас үүдэн гарсан зарим нэг дургүйцлийг намжаахад тустай

санагдсан учир Сэр-Од түүнийг ухаантай сайн лам гэж улам ч бишрэн хүндэтгэх сэтгэл төржээ. Тэгээд дархан Сүхийн хийсэн гоёмсог мөнгөн гүцийг авдарнаасаа гаргуулан сайн сархдаар дүүргээд таны хувь гэж дүвчинд хоёр гардан барилаа. Дүвчин гүцийг авч хундага руугаа тонгойлгоход урт цоргоор нь архи годгодон гарахдаа “Боль боль” гэх дуу гарах шиг болжээ. Ойр байсан хүмүүс түүнийг анзаарч юу болов гэсэн шиг бие бие өөдөө гайхан харлаа. Дүвчин ч гар хүрэх хундаганууддаа хийсээр байв. Тэгтэл нэг түшмэл

- Ламтаан, наадхи чинь нэг юм хэлээд байх шиг. Алив, нааш нь нэг тонгойлгооч! гээд хундагаа барив. Гүцний цоргоноос “Боль, боль, боль” гэсэн дуу тодоос тод гарч байлаа.

- Таминь, энэ чинь нээрээ боль, боль гэж хэлээд байна биш үү? Яасан хачин юм бэ гэж дүвчин дуу алдаад

- Энэ муу ёрын юм чинь Сүхийн хийсэн гүц мөн үү? гэж туслагч руу харлаа. Сэр-Одын царай улайгаад явчихав. Найрчид гүцийг дамжуулан өөр өөрийн хундага руу тонгойлгон “Боль, боль, боль” гэж дуугарахад нь инээлдэж байлаа.

- Таныг энэ явдлаа боль гэж байгаа юм биш үү? гэж Юмжирдулам дооглонгуй хэлэхэд баруун хаяагаар суусан хэсэг залуус нирхийтэл инээв. Дархан Сүх туслагчийг дахин гэнэгүй ингэж чадсаныг үзээд зарим хүмүүс ихэд бахдан хоорондоо шивэр авир хийгээд авчээ. Ичих уурсах зэрэгцсэн Сэр-Од

- Нааш нь бушуу явуулаарай! гэж шалан байж гүцээ арайхийн эргүүлж аваад авдрын завсраар шидэж

- Хорон санаат хүн үхэвч балаг нь барагддаггүй байна шүү гэж бувтнаад хөмхий зууж “Бааврын нууцыг илэрсний дараа энэ гүцний хээг нүдээ чилтэл гөлөрч байхаар юм хийгээд үзэх ухаан орох минь яав аа!... Ингэж олны өмнө шившгээ тарих гэж байх уу даа” гэж гасалж суулаа. Туслагчийн ийнхүү бухимдаж дотроо шатаж суугааг ажиж мэдсэн дүвчин түүний гараар өстнөө тонилгохыг хүсжээ. Базарыг ирснээс хойш хэзээ нэг цагт өөрийг^{оо} сүйдэлнэ гэж дүвчин үргэлж айж явдаг болжээ. Тиймээс туслагчид ойртон,

- Сүх чаралба байхдаа шар харыг яаж зовоож байсныг бид мартаж болоогүй. Одоо хүү нь бидэнд өширхөн нэгээхэн ч амар заяа үзүүлэхгүй. Түрүүч нь эхэлж байна. Нэгэнт гартаа оруулж авсан дээрээ Базарыг Улиастайд чандлан хүргээд эргэж нүүр учрахгүй байх арга бодсон нь дээр шүү гэж аяархан хэлэхэд туслагч ихэд таашаан толгой дохиж байтал тахар Пэрэнлэй

- Би алуулах шахлаа. Болохоо байсан шүү! гэж дуу тавьсаар орж ирэхэд найрынхны тав дахин алдагдан үймж хатавч хавиар байгсад дэрхийн босож гарцгаалаа.

- Өнөөх босоо ороолон чинь намайг хурга шиг хүлж хаячихаад алга болсон гэж Пэрэнлэйг хэлэхэд

- Одоохон хөөгөөд бариад ав! гэж туслагч ууртай хашгирав.

- Яваад удаж байна шүү гэж айсан тахар ээрэн хэлбэл
- Хүн дуудахад яадаг мал вэ, чи! гэхэд нь
- Аманд даавуу чихчихсэн. Арай л үхчихсэнгүй гэж хэлэхдээ Пэрэнлэйн хоолой зангирав.
- Урагшгүй новш үхсэн ч гарз алга. Ядаж хүлэгтэйгээ бөмбөрөөд хүнд харагдах чинь яагаа вэ?
- Намайг хөхүүрийн араар чихчихсэн. Хөдлөх арга даанч байсангүй. Ашгүй Пагма сая үзэж хүлгийг минь тайлж өглөө.
- Түүнийг хүлгээ тайлж байхад чи юугаа харж суусан юм бэ? Согтуу байсан байлгүй. Эсвэл чи түүнтэй хуйвалдсан уу? гээд туслагч уурандаа босон харайж Пэрэнлэйг алгадаад авав.
- Туслагчтан минь! Би эрүүл байсан. Таны шивэгчин ч мэднэ. Тэр босоо ороолонтой би яалаа гэж нийлэх вэ. Үнэнч боол намайгаа өршөөж хайрла! гэж Пэрэнлэй уйлагнан туслагчийнхаа хөлд сөхрөн уналаа. Харц доодсын өмнө бялзуухайд эрэлхсэн харцага шиг омог бардам байдаг тахар ийнхүү нулимс унаган чичрэн дагжиж суугааг харахад үнэхээр инээд хүрэм аж.
- Базар нээрээ оргочихлоо гэж үү? гэж Юмжирдуламыг асуухад айж балмагдсан тахар
- Үнэн үнэн, хатантан минь! гэж хэлж орхив.
- Ээ, гялай! гэж хүүхэн баярлан дуу алдсанга туслагч түүнийг эгдүүцэн харжээ. Урьд шөнө нь ухаан алдталаа уучихсан Сэр-Од залуу хөөрхөн хатантайгаа дэр нэгтгэхийг тэсгэлгүй яад байсан учир эл шалтгийг далим болгож,
- Ах дүү нар минь! Хорон санаат муу хулгай дахин биднийг түйвээж болзошгүй. Найраа өндөрлөж тавтай нойрсоод өглөө дахин найрлая гэсэнд найрчид “Тэгье, тэгье” гэлцэн унаа морьдоо тавьж айл айлд тарж унтахаар явцгаав.
- Тэр балмад боол манайхны өдий төдий морьдын хөлийг гэмтээж, эмээл хазаар тоо томөгүйг эвдэн сүйтгэж чирэгдэл учруулсан төдийгүй Богдын шоронгоос оргосон билээ. Иймд түүнийг зүгээр орхих нь зүйд нийцэхгүй. Хэдэн хүнийг Пэрэнлэйгээр толгойлуулан нэхүүлэхээр явуулна гээд Сэр-Од бяр тэнхээтэй хэдэн эрсийг цохон заагаад гэрээс гарцгаав. Гэтэл туслагчийн унаган хээр гэж нутагтаа алдаршсан хурдан морь нь эмээл хазаартайгаа алга болсон байв. Сэр-Од амьн голоос хайртай хүлэг морио алдсандаа хилэгнэж морьдын харуулд гаргасан хоёр хүнийг хэд хэд ташуурджээ. Сэр-Од нэхүүлийнхнийг тэргүүлэн явж Базарыг өөрийн гараар барьж авчрахсан гэж санаархавч залуу хатан нь санагдаж сэтгэл хоёрдон авай. “Хээр морио тэр чигт нь Базарт өгчихвөл юу санасан хүслийг чинь хангана” гэж Юмжирдуламыг хэлдэгсэн бол тэргүүн туслагч “За” гэж амлахад бэлэн байв.

Хүүгээ нэг үзэгдээд гэнэт алга болсонд хаана юу хийж яваа болж гэж санаа зовсон эмгэн Доржпаламын нойр хүрэхгүй, чимээ чагнан орондоо эргэж хөрвөнө. Хоттой хонь малын буаар буаар хивэхээс өөр хол ойрд ямар ч чимээ үл гарна. Бурхны өмнөх том мөнгөн цөгцтэй зулын дөл сүүдэгнэж, түүний бүгтхэн шаргал гэрэлд эмгэний зовж шаналсан үрчлээт царай

барайн үзэгдэнэ.

“Нэг нь бурхны оронд эргэж ирэхгүйгээр явчихсан байхад үлдсэн нь надад хань болохгүй улам зовоож байх юм. Энэ ер нь ямар бодолтой үр юм бол доо. Хөөрхий талийгаач минь бурхны оронд очиж чадсан байгаа даа. Тамд унасан гэж дүвчин ламтан хүнд ярилаа гэдэг үнэн болов уу? Өвгөн минь хүний чинээ хүн явсан юм. Амьтанд тусархуу тийм сайхан сэтгэлтэй хүн юу боллоо гэж тамд очих вэ. Бурхан өршөөх болтугай” гэж эмгэн дэмий юм бодсондоо өөрөөсөө айж залбирахад өвгөнийх нь амгалан дүр нүдэнд нь харагдах шиг болов. Эмгэний бодлоор бол хүүгээ л гэрлүүлчихвэл хэнээс ч дутуугүй жаргалтай хүн байж болмоор санагдана. Ачаа тэвэрч зулайгий нь үнэрлэж суухсан гэж туйлаас хүснэ. Гэтэл юм бүхэн түүний санаснаас урвуугаар эргэж санаа сэтгэлийн зовлонд унагаж байгаагийн учрыг олох гэж эмгэн бурхан шажинд хүлэгдсэн богинохон ухааныхаа хэрээр бодовч дэмий мунгинаж сэтгэлээ зовоохоос хэтэрсэнгүй.

Морин туурай тачигнаж хонь мал үргэхэд эмгэн хэрдхийн цочиж өндийгээд үймэрсэн бодлоосоо салж “Юун хүн айлын хот руу галзуу юм шиг давхин орж ирдэг билээ” гэж гайхаж суутал гэрийнх нь гадаа хүн бууж хоолойгоо засах нь хүү нь мөн байлаа. Хүүгээ сүр пархийн харайн орж ирэхэд эмгэн түүний царайг харуугаа айж мэгдэн яваагийн нь мэдээд энэ маань бас ямар хэрэг тарьчихаад ирэв дээ гэж бодлоо.

- Ухаангүй юм шиг давхиад юу болоо вэ, хүү минь? гэж эх нь сэтгэл түгшин асуугаад ямар хариу сонсох бол гэхээс айж байв.

- Гай болсон хоёр муу адсаганаас болоод Юмжирдуламыг оргуулж чадсангүй. Өөрөө баригдаж сүйдэх шахлаа. Буянт хүний үр дайралдаж амьд ирлээ гээд Базар данхтай хүйтэн цай шүүрэн авч цоргоор нь хахаж цацан залгилав.

- Би чамд тэр охины хойноос явж хэрэггүй гэж эс хэллүү. Бурхан мэдэж байгаа шүү дээ, хүү минь!

- Бурхнаа ч алд! гэж санаагаа гүйцэлдүүлж чадаагүй Базарыг бухимдан хэлэхэд,

- Хүү минь, бурхнаа зүхэж болохгүй. Хилэгнэвэл сүйд хийнэ шүү. Харин ч миний хүүг бурхан өршөөсөн байна. Бурхны авралыг бодож яв хүү минь гэж эх нь хүүгээ ятгана. Энэ насандаа учирсан муу тохиол бүхнийг бурхны гэсгээл гэж санан сүжиг багатай байвал бурхан хэзээ ч таалахгүй гэж цусандаа шингэтэл итгэж, алхаж гишгэхээс эхлээд аливаа явдлаа гагцхүү бурхантай холбон бодсоор шашны харанхуй мананд мунгинаж төөрсөн хөөрхий эмгэн юутай гаслантай вэ! Үеийн үед шүтэн биширсэн түмэн зүйлийн бурхад хүний жаргалын гэгээн замыг бачууруулан хааж зовлонгийн үүдийг цэлийтэл нээсээр ирснийг сэнхэрдэг ч болоосой!

- Хүү минь, эцгийнхээ гал голомтод эзэн болж орон гэрээ толгойлж, намайгаа амраагаач дээ. Тэгвэл ээжийн чинь үр хүүхэдтэй явсны хэрэг бүтэхсэн гэж учирлахад хүү нь

- Цаад лам ноёд чинь намайг тэгж таны санааны зоргоор суулгах уу даа гээд эхийнхээ үгийг төдий л хайхарсан шинжгүй ханын толгойд өлгөөтэй цахиур буу, хавтагатай хорголжин сум,

дарь зэргээ авч, эцгийнхээ багажны хайрцгийг ухаж сумны хэв, тугалга гаргаж аваад явахаар зэхэж эхлэв.

- Хүү минь, чи одоо бас хаачих нь вэ? Буу саадгаар яах нь вэ? Хүн алах гээгүй бис? Чиний байр нэг л бишээ гээд эх нь буунаас нь зуурч уйлав.

- Ээж минь, бүү санаа зов! Би хэнийг ч алах гээгүй. Сая хүртэл тахар Пэрэнлэйг нухчих юм уу гэснээ, согтуу амтны цусаар гараа бузарлаад яах вэ гэж бодоод байчихсан. Хүү нь Шар нуруунд бүгж амь зулбахгүй бол яах ч аргагүй болоод байгааг та мэдэж байгаа шүү дээ гэж хүүгээ хэлэхэд эх нь

- Гэртээ байгаач дээ, хүү минь! Ээж нь гуйж байна. Чамайгаа явчихвал би энэ ханхай оронгийн мухрыг яаж сахиж суух вэ. Амьд явахын ч хэрэг алга гэв. “Муу ээж минь үнэнээ л хэлж байна. Хүү байлаа гээд ганц өдөр хань болж сэтгэлийн нь амар суулгасангүй. Намайг ингэж явахад хөөрхий эх минь яаж цагийг өнгөрөөх вэ” гэж Базар бодовч

- Ээж минь! Орон гэртээ амар жимэр суух хүсэл надад хичнээн байвч тэгэх арга алга. Хулгай хийв гэсэн гүжир хэрэг дээр Улиастайн шоронгоос хэдэн ялтан сулласан хэрэг нэмэгдэнэ. Бас өнөө шөнийн үймээг нэмэр болно. Ийм хүн чинь яаж энгийн хүнтэй адил санаа амар сууж болох вэ. Та хүүгээ гэртээ байлгана гэж зүтгэвэл өшөөтний гарт барьж өгөх нь тэр. Би аавынхаа өшөөг заавал ч үгүй авна. Хүү чинь амьд явж, хааяа танд бүлээг зүсээ үзүүлж явбал дээр шүү дээ. Ээж минь, та тэвчиж үз! гэж эхийгээ ятгалаа.

- Үртэй хүн жаргадаг байтал миний зовлон дуусдаггүй яасан үйлийн үртэй хүн бэ, би! гээд эх нь уйлав.

- Ээж минь, уйлаад яах вэ. Уйллаа гээд жаргахгүй. Туслагч дүвчин хоёрын гайгаар л бид ийм зовлон амсаж байна. Лам ноёдыг бурхнаар бамбай хийж нүгэл үйлддэг гэж аав маань хэлдэг байсан шүү дээ гэж Базар эхийгээ аргадсанд нь эх нь хүүгийнхээ толгойг тэврээд мэгшин уйлна.

- Ээжээ! Хүү нь түргэн явахгүй бол тун болохгүй. Тэд намайг барих гээд отожд магадгүй. Тэгэхээр би гэртээ мөд ирэхгүй шүү. Харин та сар бүрийн арван, хорин, битүүнд зүүн уулын модонд түлээ түүхээр очиж байгаарай! Хүү нь тосож уулзаж баймз! Тэдний гарт орчихгүй бол хүү нь эсэн мэнд явна аа гээд Базар хацраа өгөхөд эх нь “Хүүгийн минь хэлдэг ч үнэн үг. Нээрээ л тэд хүүгийн минь барьж авбал лав сайн юм болохгүй” гэж бодон хүүгийнхээ хоёр хацрыг үнсээд хамт гарлаа.

- Туслагчийн гайхуулдаг хурдан морийн нь авчихсан шүү гээд хүүгээ мордоход,

- Хүү минь, чи хүний аминд битгий хүрээрэй! Нүгэл хилэнц нь барагдахгүй шүү гэж захив. Базар эхийгээ бөртөйтөл ганцаарангий нь орхиод явахдаа “Эх үрийг амьдаар нь хагацаасан яасан гаслант хорвоо вэ!” гэж элэг эмтэрчээ.

Эмгэнийг арайхийн үүр хаяруулаад цайгаа чанаж суутал олон морьтон гэрийн нь дайрчих шахан давхилдан ирэхэд нь санд мэнд гарвал Базарыг нэхсэн хүмүүс байлаа.

- Хүү чинь хаа байна, зөнөг минь? Ёж Пэрэнлэй зандран асуугаад ташуураараа эсгий үүдийг нь гэр дээр эргүүлэн шидээд морин дээрээсээ үүдүэр нь шагайж харав. Эмгэн хулгасаар гарч ирээд, яахаас ч буцахгүй догшин шинжтэй тэр хүмүүсээс айсан хэдий ч биеэ барьж
- Мэдэхгүй л дээ. Хүүгийнхээ барааг харалгүй их удлаа. Харин та нар миний хүүг яасан бэ? гэж сөргүүлэн асуусанд
- Өө, бүр биднээс хүүгээ нэхэх санаатай юу? Цохиод авахсан, чамайг! гээд Пэрэнлэй ташуураа далайсанд нэг нь
- Гэртээ ирээгүй юм биш үү. Тэндээс зугадсан мөрийг нь хөөвөл дээр байх гэж хэлэхэд гэр тойрч мөр ажиж явсан хичээл эр
- Адууны шинэхэн баас байна. Гэртээ ирсэн байж таарна гэв.
- Энэ зөнөгийг ташуурд! Махаа хорсохоор хаана байгааг нь хэлнэ гэж Пэрэнлэй агсарч эмгэний нуруун дундуур ороолгоод авчээ.
- Үхэх дөхсөн надаар та нар яах нь вэ гэж эмгэн өвдсөндөө ярвайн хэлэв.
- Төрд тэрсэлбэл чавганц ч гэсэн өөрцгүй
- Энэ хөгшин шулмаар заавал хэлүүлж байж явна.
- Эрүү өвдөг нь нийлсэн чавганцтай орооцолдож цаг бараад юу хийнэ.
- Хэрэг хийсэн хүнээ л эртхэн олж авахыг бодъё гэж тэд өөр хоорондоо маргалдав. Эмгэн “Энэ тахар яахаасаа ч буцахгүй дэг. Талийгаачийг минь яалаа даа. Харин эдний дотор овоо өр зөөлөнтэй хүн яваа бололтой. Эндээс бушуухан зайлаасай” гэж горилон зогстол Пэрэнлэй
- Базар ирэх нь ирж. Тэр ороолон хаана очихоо эхдээ хэлээгүй дэг ээ гээд хүүгийнх нь явсан мөрийг олоод хөөж одов. Холдон холдон яваа тэр хүмүүсийн хойноос харж зогссон эмгэн “Хүү минь өдийд өнөөх газраа хүрээ биз. Эдэнд битгий олдоосой! Шар нурууг ганц хүн байтугай азаргаар адуу олдохгүй газар гэж улс ярилцдаг” гэж бодоод мандаж байгаа наран доогуур тэртээ алсад униартан дүнхийж байгаа их нурууг бишрэлтэйеэ саравчлан харж байснаа гэртээ орж цайныхаа дээжийг авчраад хүүгийнхээ хойноос ерөөл тавин өргөж байлаа.

Арван наймдугаар бүлэг

Хатан шивэгчин хоёр

Бүсгүй хүний гунигийн нулимсанд

Бүхий л зовлон живдэг ч болоосой

Хошууны тэргүүн туслагчийн улаан халзтай цагаан өргөөнөөс

“Нуур чи хөлдөх гээд байна уу даа, ай хө

Нугас гэдэг амьтан хөөрхий болно доо, ай хөөрхий минь дээ хө

Нууцгай чиг ханилсан бидэн хоёр, ай хө

Арга ч үгүй амраг мөнөөсөө мөн шүү дээ, ай хөөрхий минь дэу хө”

гэж бүсгүй хүний гунигтай дуулах сонсогдоно. Гадаа явсан хэдэн хатан эл дууг сонсоод зэвүүцэж чихээ таглах шахав. Жаргал цэнгэлд умбасан ямбатан дээдсийн чихнээ зовлонт хүний гунигийн дуу чийртэй байлгүй яах вэ.

- Цаана чинь хэн гэнгэнээд байна? Шивэгчин Пагма уу? гэж нэгэн ихэмсэг янзын сээргэр хатныг эгдүүцэн асуухад

- Биш ээ, туслагчийн хатан гэж саримгар шар хиаг хэлэхэд мөнөөх хатан

- Ам руу нь алгадаач! гэсэнд

- Бид байтугай туслагч алгадаад дийлээгүй байх гэж өндөр занги өгүүлээд гэртээ оров.

- Ямар зовлон амссан гэж энэ эм өргөөний хотод гэгэлзээд байгаа юм бэ?

- Хар нүд хуу татаад л гонгиночихыг яана!

- Нэг насаар энэ эм шиг уйлагнаж яваагүй болохоор цаанаа зэвүүнийг яана!

- Хатныхаа амыг хамхиж чадахгүй юм бол тэргүүн туслагч гэж байсны хэрэг юу билээ?

- Хатгаа ч алд даа. Жаргал үзэх заяагүй шулам биз. Гуйлгачны шар эсгий овоохойн ёроол сахиад хоосон хэвтэж байвал таарах амьтан.

- Тэргүүн туслагч тэгж л хатан таалах гэж ядсан юм бол манайханд ёс ёмбоо мэддэг гунхсан сайхан хүүхнүүд байж л байна даг.

- Ер нь дээд язгуурын их бага аль ч хүн ийм гуйлгачин заяатай амьтас руу хавьтамгүй юм.

- Эдний заяа биднийхээс тэс өмнөө юм байхгүй юу.

- Газар тэнгэр хоёр гэсэн үг. Газар тэнгэр хоёр хэзээ ч нэг болохгүйтэй адил бид ч харц дордистой хутгалдах ёсгүй гэж хийх юмаа олж ядсан хэдэн цадиггүй хатан хэл амаа урчих шахан бурцгааж байв.

Туслагчийн найман ханатай, хамбан хөшигтэй, алхан хээгээр захалсан тойруулан хивс дэвссэн их өргөөнөө тавьсан бурхан номын хэрэглэл, зүмбэрдэж алталсан хээтэй ор, шүүгээ, хүрэн зандан авдар, залуу хатандаа хэрэг болгож авсан танан шигтгээтэй жааз бүхий ханын эрстэй чацуу толь, хар тарлан гантиг өртэй аяганы ширээ, угалз цохисон зургаан бүслүүртэй ганган тулга, алтаар шарсан аяга таваг цөм шинэ төхөөрсөн аж. Баян тансаг өргөөний гял цялхийсэн эд агуурс Юмжирдуламын сэтгэлд од харвахын дайны ч гэгээтэй үзэгдсэнгүй, харин харанхуй хар нүх шиг санагдаж байлаа. Түмэн лангийн эд баялаг байлаа ч халуун янаг хүний ганцын төдий ч хайрлан үнсэхтэй үл тэнцэх учир богтлогдож ирсэн хөөрхий бүсгүй борхон зүрхээ шимшрүүлэнхэн гаслан суухаас өөр яах билээ дээ. Тэгэвч Юмжирдулам эчнээн цагдуул байгааг мэдэлгүй хоёр удаа оргохыг завдаад баригдсанаас орох гарах бүрийн нь отоож харуулддаг болжээ.

Намсрайн эрх охин тэргүүн туслагчийн хатан нэрийдээд хэд хонож байгаа авч сэтгэлийн зовлонд хатсанаас энэхэн зуур турж хацар нь үл мэдэг хонхойгоод хоёр нүд нь гархилж зүрх догдлуулам байдаг сайхан хадбуйн нь уйтгар гунигийн манан бүрхээд залуу насны цог золбоо туяарсан царай нь цонхийж цайсныг харахад уулын ганган цэцэг хурыг үгүйлж өнгө бууран хорчийсонтой адил болжээ. Тэр хүүхнийг ойн согоо адил танхил дураараа явахын нь мэдэх хэн боловч одоо үзмэгцээ л ангирын зулзага шиг энэ хөөрхөн амьтан хэдүйдээ ингэж нүднээс гарчихав гэж халаглан шогширч зүрх шимширдэг аж. Сэтгэлийн тамд унана гэгч өвчнөөс илүүтэй хүний шим шүүсийг сорж оддогийг тэр бүр хүн ухаардаггүй нь нэн бэрх.

Юмжирдулам туслагчийнд ирснээс эхнэр хүний ёсыг нэг ч удаа дагасангүй. Сэр-Одыг эзгүй хооронд үсээ задала сүлжээд эхнэр дээлийн нь тайлж өөрийн дассан хувцсаа өмсжээ. Туслагчид царайгаа ч харуулдаггүй үг асуухад нь дуугардаггүй байлаа. Тиймээс туслагчийн шадар хүмүүсийн зарим нь “Манай туслагч хэлгүй хатантай болсон” гэж хошигнодог болжээ. Туслагч үзэсгэлэн төгөлдөр залуу хатан таалсан нь ихэс дээдсийн дунд шагшигдаж, заримынх нь атгагч сэтгэлийг хөдөлгөх авч өөрөө хатантай хүн шиг байж эс чадав. Туслагч Сэр-Од ганц хүслээ гүйцээх гэж хичнээн оролдовч санасандаа хүрсэнгүй. Юмжирдуламыг түрүүчийнхээ хатад шиг өөрийн дураар эзэгнэх гэж аргадаж загнаад ч ядаж орхив. Яаж ч байсан шинэ хатан нь чулуун хөшөө шиг гөлийгээд л сууж байдаг болжээ.

Явал хатнаа хатан шиг байлгах агуу гэж бодон бодсоор эвтэй арга олж чадахгүй цөхрөнгөө барсан Сэр-Од “Хошууны туслагч байж харц боолын удамтай энэ муу эмд санаа хүслээ цагдуулж сууна гэдэг чинь дэндүү ичгэвтэр, дэндүү зөөлөн сэтгэл бус уу? Энэ зэргийн боолыг алчихсан ч надад амиар солих ял оноох биш. Малаар торгоод л өнгөрнө биз. Би л зөөлдөөд байх шиг байна. Ясыг нь янгинуулаад өгвөл энэ эм хур буулгахгүй хаашаа зайлах вэ” гэж ихэд уурсан нэгэн шөнө бяраа гаргалаа. Хатан түүний муйхар зодууранд орилж дуу тавьсан ч үгүй, харин голоо тасдуулж байгаа хонь шиг чимээгүйхэн тэлчилж байлаа. Шүдээ тас зууж царай нь хөхөрчихөөд байтал нүднээс нь нулимс тасралтгүй урсах нь хичнээн их тэвчээр гаргаж тэрхүү хүнд нударгыг дааж байгаа нь илхэн. Хатнаа “Ёо” гэж дуугарахгүй байх тусам Сэр-Одын хор шар дэвэрч хайр найргүй зодож байлаа. Юмжирдулам нэгэн хэсэг

муужирсан мэт хэвгэж байснаа “Ингэж амьд байснаас энэ түшмэлийг алчихаад үхсэн инь дээр” гэж бодмогц хорсол гомдол нь зангирч,

- Ээ, чааваас! Ээ, үйлийн үр! гэж гэнэт бачимдан хашгирч туслагчийн гараас мулт үсрэн зайлж ил байсан хутга шүүрэн авч,

-Чамд махаа зулгаалгахгүй. Нэртэйгээр нь таигандаа аваачиж тамлахгүй яагаа вэ? ! Чамайг ч өөрийгөө ч хорлоно. Яадаг юм бэ! гээд ухасхийсэнд Сэр-Од яахаасаа ч буцахгүй шийдмэг байгаа хатныхаа царайг хараад хутганы үзүүрт орчихолгүй холдье гэж санаад ухасхийн гарчээ. Хүний өөдөөс ширүүн үг хэлэх нь бүү хэл, эгцлэн харахаасаа эмээдэг бүрэг бүсгүйн амнаас ийм үг гарах болсон нь хорвоогийн эрээн барааны зах сэжүүрийг таньж, хатуу ширүүнийг амссаны улмаас зан ааш нь хувирч, үзэи ядах, өших хорсох гэгч юо болохыг ухаарч байгаагийнх ажээ. Сэр-Одыг гэртээ орох санаатай шагайхад л Юмжирдулам голомтны нь дэргэд хутгаа барьсан чигтээ өөдөөс нь заналтайяа харж суух учир дайраад барьж авья гэж санавч дүрүүлчихээс айж, айлд оръё гэвч өргөөнийхний шоолж шуугихаас ичиж гаднаа эргэлдсээр байтал үүр хаяарч эхлэв. Нүцгэн шахам зогсож байгаа туслагч дахиад гар хүрэхгүй, зодвол дураараа болоорой гэж хатандаа буулт хийж байж арайхийн гэртээ орж санаа амарсан болой.

Арга, хүч хоёрын алинаар нь ч оролдоод хатнаа номхруулж чадаагүй тэргүүн туслагч “Заяа төөрөг нь нийлнэ” гэж бат нот айлдсан Агваанлуvsан дүвчингээсээ асуужээ. Хуримын үеэр ч хатан нь туслагчид нүүр өгөхгүй зовоож байхыг дүвчин ажиглаад “Энэ хүүхэн төрсөн гаригаасаа болоод хуриман дээрээ ийм ааш муутай байгаа юм. Та битгий санаа зов! Огтхон ч хайхрахгүй юм шиг бай! Хатан чинь аяндаа танд наалдаад ирнэ” гэж Сэр-Одын сэтгэлийг сайхан үгээр зассан билээ. Гэтэл одоо хатныхаа аймаар ааш араншингийн тухай туслагчийн ярихыг сонсоод дүвчин лам хэрдхийн гайхаж “Тийм хачин бүсгүй төрөлтөн байдаг байжээ. Зарим эмсүүд эхэндээ хангал гүү шиг байвч эцэстээ хонь шиг болж дуусдагсан биш үү! Бага хүн мөртлөө тэр яадаг эм бэ! Туслагчийнд ямар нэг гай байгаагаас л хатан тогтдоггүй байх” гэж сэтгээд

-Танайд ялихгүй муу юм орогножээ. Түүний гайгаар хатны чинь ааш эвдэрчихэж гэхэд нь “Дүвчин гуай лав мэдэж байгаа. Тийм байж таарна. Миний таалсан хатад дотор энэ хүүхэн шиг ийм адсага шиг ааштай амьтан байгаагүй. Дүвчин гуайг өөрийн нь л зуураад суучихья” гэж Сэр-Од бодоод

-Та ааш зангий нь засах арга хийж өгөөч! гэж гуйж барьцанд нь таван эр төлөг амлав.

-Энэ хатныг маш их түвэг удаж байж авсан болохоор хар, цагаан хэл амнаас эхлээд барцад их байна. Би аргалахыг бодье. Сар болоход хатны чинь сэтгэл санаа зөөлрөх биз гэж дүвчин уриалган хэлжээ. Сэр-Од дүвчин ламтныг бурхны номын ид шидээр хатныхаа сэтгэлийг зассаны дараа учраа ололцье гэж тайвшдаад харин шөнө алчихаж магадгүй гэж айхдаа Юмжирдуламд тусад нь гэр бариулж, гагцхүү оргохоос сэрэмжлэн хиагаар харгалзуулжээ.

Юмжирдулам золгүй амрагийн тухай дуугаар ганёхарсан сэтгэлээ зогоож саатан суухад нь шивэгчин Пагма өргөөгий нь цэвэрлэхээр орж ирэв.

Нүгэл чиг нүглээс айсангүй дээ, ай хө

Нүдний чинь хөөрхөнд арга ч үгүй даслаа даа,

ай хөөрхий минь дээ хө.

Аюул чиг аюулаас айсангүй дээ, ай хө

Аашны чинь хөөрхөнд арга ч үгүй даслаа даа,

ай хөөрхий минь дээ хө

Мэлмэрүүлэн чиг уйлах гээд байна уу даа, ай хө

Мэнд амар суувал уулзана шүү дээ, үр минь дээ,

ай хөөрхий минь дээ хө

Асгаруулан чиг уйлах гээд байна уу даа, ай хө

Амар мэнд суувал уулзана шүү дээ, үр минь дээ,

ай хөөрхий минь дээ хө

гэж хатан хэмээх сайхан нэр зүүсэн Юмжирдуламыг гиншигнэн дуулахад тэрхүү гунигт дууны ая гэрийн тавилыг засаж цэвэрлэж байсан шивэгчин хүүхний зүрхэнд зүү шивэх мэт нэвчин хүрч өрийн нь өвтгөнө. Түүний зовлонг ирсэн цагаас нь сэтгэлийн гүнд хуваалцаж байгаа шивэгчин хүүхэн “Богино жолоот бүсгүй хүн л болохоор ялгаагүй ингэж зовж байх учиртай юм байж дээ. Энэ хатагтай ч надтай адил байхаар хүн биш санж. Аавтай, гэр оронтой, мал хөрөнгөтэй байтал яагаад ингэж байна вэ? Аав нь ийм сайхан охиноо хөгшин хүнд өгчихдөг нь яаж байгаа юм бол оо? Тийм золбоотой залууд сэтгэлтэй хүүхэн чинь яалаа гэж хөгшин хүнтэй суух вэ. Манай туслагчтан хүүхэд нь баймаар хүүхнийг хатан болгож суухдаа амьтнаас ичдэггүй юм байх даа. Энэ сайхан хүүхнийг ингэж зовоож байдаг даанч яав даа. Анх ирэхдээ ямар байлаа. Одоо нүднээс гарч гүйцлээ. Яана даа, хөөрхий минь” гэж элэг эмтрэн өрөвдөж нүднийхээ нулимсыг унагав.

- Чи юунд уйлав? гэж Юмжирдуламыг асуухад

- Ингэж суух ч гэж дээ, хатагтай минь! Таныг ирснээс хойш надад давхар зовлон нэмлээ гээд шивэгчин нулимсаа арчив.

-Яагаад тэр вэ? Эсвэл намайг харж бай гэж чамд тушаасан юм уу?

- Үгүй, үгүй, хатагтай минь!..

- Тэгвэл ямар учиртай билээ? гээд Юмжирдулам урт сормуусаа хөдөлгөн ялдамхан асуув.

- Би таны тухай бага сага юм дуулсан. Тэгээд л таны зовж байгааг харахаар миний дотор харанхуйлах юм.

- Чи намайг яаж мэддэг юм бэ?

- Орших гэж нэг залуу бий л дээ. Танайхан нутаг ойрхон болохоор таних байлгүй.

- Танилгүй яах вэ. Одоо ч манайтай айл байгаа.

- Тэр чинь Базартай их сайн шүү дээ. Тэгээд л би дуулсан юм... Эртүүд морьд чинь байсан бол та хоёр зугатаад гарчихсан даа. Тэгсэн бол одоо юунд ингэж суух вэ.

- Би энэ хөгшин түшмэлийн гараас салах хувьгүй хүн байх аа. Нэг л цагт энэ хүний гарт амь хохирсон байх вий гэүя Юмжирдулам асгаруулан уйлж,

- Базар минь өдийд багтах шингэх газаргүй яаж зүдэрч яваа бол? Хээрээр гэр хийж хэцээр дэр хийнэ гэдэг нь л болоо байх даа. Муу ээждээ хань болж гэр орондоо сууж байгаасан бол яая гэх вэ. Хөөрхий тэр минь энэ жил ямар ч их зовлон үзэв дээ. Эр хүн тулдаа л тэсэж явдаг байх. Би сэн бол ч өдийд амьд гозойж явахын эцэсгүй болсон гээд нулимсандаа хахаж цацан өгүүлэв.

- Та битгий уйл даа... Та бид хоёрт хэдэн үг солих ч сиймхий олдохгүй. Юм. Өнөөдөр ашгүй хүн цөөтэй байна. Надаас өөр хэн ч мэдээгүй нэг юмыг танд ярьж гээд Пагма хүн чагнуужин гэж болгоомжилсон бололтой үүдээр шагайж харлаа.

- За тэг тэг! гээд Юмжирдулам “Зовлон үзсэн ядуус л хүний зовлонг мэддэг юм байна. Өргөөний хотод Ёагмаас ондоо намайг өрөвдөж хайрлах өр нимгэн хүн бий гэж үү? Хэдэн сүрхий хатан нь нүд үзүүрлээд барьж идэх нь холгүй л байх юм. Эд хөрөнгө, эрх ямбандаа сагасан улс чинь ядарсан хүнийг яахаасаа ч буцахгүй байх шүү” гэж бодлоо.

- Дүвчин ламтан Да хүрээнээс эргэж ирээд туслагчтанд ингэж ярьж байхгүй юу... “Цаад тэнэг харыг чинь яг ярьснаараа ялд унагаад орхилоо. Тийм ялнаас мултарна гэдэг энэ насанд байхгүй. Сэтгэл зоволтгүй бэлдэж байгаад зуны эхэн сарын шинийн гурванд хуримаа хий! Харин тэр муу тархи чинь бас хар гэрт үхэхээ мэдэхгүй таны таалах хатанд жаахан мөсөн чихэр, хоёр хув явуулсан” гэж дүвчин ламтан яриад надаа чихрийя нь өгсөн. Хувья нь түл! гэхээр нь би нууж аваад хоцорсон. Тэр үедээ ч би учрыя нь мэдэхгүй болохоор алмайрч байгаад л өнгөрсөн... Тэгтэл ийм муухай юм хийж байж шүү. Ай хатан минь! Энэ хорвоод амьд явна гэхэд мөн хэцүүеэ! гээд Пагма залбирав.

- Ямар муухай амьтас вэ! Аав минь намайг ийм хөө шиг дотортой хүнд өгч байдаг яасан толгой нь эргэсэн хүн бэ! Багш багш гээд байсан хүнийх нь санааг! Ямар хүн үнэмших аргагүй, хүний санаанд оромгүй юм хийдэг улс вэ! гэж Юмжирдулам гаслан дуу алдаж, өвгөн дархны хэлж байсан уялдаа холбоогүй үгийг нэхэн санажээ. Пагма өврөөсөө нэг боодолтой юм гаргаж ирээд задалж хоёр том улаан хув авч өгсөнд Юмжирдулам түүнийг алгандаа өнхрүүлэн илж хацартаа наалдуулан байснаа,

- Чи Базарын тухай юм дуулаагүй биз гэв.

- Базарыг барьж шийтгэх санаатай эрээд байгаа бололтой. Олдохгүй байна гэж их л бухимдацгаах юм билээ. Тэр ч тийм амархан баригдчих эр биш дэг ээ... Би бас л танд хэлж амжаагүй. Найрын шөнө би түүнд нэг хутга дөхүүлж өгч амжсан шүү. Тэгээд л хүлэгнээсээ амархан салсан байх.

- Эш! Тэгсэн үү! Чи минь ямар бурхан шиг сайхан санаатай амьтан бэ! гээд Юмжирдулам Пагмыг тэвэрч авахад,

- Базар чинь хүнд тусархуу сайн залуу билээ. Тийм хүнийг бид хайрлалгүй яах вэ.

- Чи бид хоёр адилхан зүдэрсэн бүсгүй улс. Бие биедээ түшиг болж байя. Би эндээс тийм ч амархан салахгүй байх. Базартаа л горьдож байна. Тэр минь бас амь дүйж яваа хүн. Чи түүний тухай юм дуулбал надад хэлэхийг бодоорой! гээд Үмжирдулам хоёр хувныхаа нэгийг Пагмын алган дээр тавьж,

- Хоёулаа нэг нэгээр нь авья гэхэд нь

- Яах юм бэ! Угаасаа таны юм шүү дээ. Ижлээр нь танд байг гэвэл,

- Тэгэхгүй. Чи заавал ав! Хэн хэндээ сайн санаж явахын билэгдэл болгоё. Бас уулзаж учрахын улаан өнгө ч гэж ярьдаг шүү дээ гэсэнд Үагма хувыг авч баярлан инээмсэглэж,

- Хатан минь, би танд тус болохыг үнэн санаанаасаа хүсэж байна гээд намсхийн мэхийсэнд Юмжирдулам,

- Пагма минь, эд намайг хатан матан гэцгээж л байна биз. Хоёулхнаа байхдаа чи намайг үеийн бүсгүй шигээ л бодож байгаарай! Мэхэлзэж ёсорхоод хэрэггүй. Хатан ч гэж бүү дууд! Бусдын дэргэд бол айсан эмээсэн янзтай л бай! Би ч чамайг хяргачих гээд л байя. Тэгэхгүй бол цаадуул чинь сэжиглэнэ. Цаадуулдаа загналаа, зодлоо гээд хааяа худлаа хэлчихсэн ч гэмгүй. Тэгвэл бид хоёрт хар санахгүй. Тийм байж болох уу? гэж хэлээд инээмсэглэхэд Пагма толгой дохиод “Хөөрхий минь! Энд ирсээр ер инээсэн гэж үү. Байдгаараа баярлачихаж. Бас ч туслагчийн хатан болчихдоггүй өөрийнх^{оо} санаснаар зүтгэсээр дүүрдэг сүрхий хүүхэн юм даа. Ахар жолоот хүн гэхэд эргэшгүй хатуу боёолтой байна шүү. Санасан санаа нь бүтээсэй билээ, бурхан минь” гэж түүний өмнөөс сэтгэл догдлон бахархжээ.

Юмжирдуламыг шивэгчин хүүхэнтэй ийнхүү ярилцаж сэтгэл тэнийн баясаж суутал Намсрай залан ирж саад боллоо. Хошуу холбон зогсож байсан хоёр хүүхэн залангаас давхийн цочиж хурдхан холдов. Залан шивэгчинг ширвэж хараад охинтойгоо мэндлээд суулаа. Эцэгтээ туйлаас гомдсон Юмжирдулам мэндийн хариу ч өгөлгүй доош харан урвайн суучихав. Шивэгчин хүүхэн заланд идээ цай бариад “Муу нүдээр харахын аргагүй ийм сайхан охиноороо наадчихаад ямар нүүрээрээ ирж байгаа өгөр толгой вэ!” гэж зэвүүрхсээр гарав. Намсрай хуримнаас хойш туслагчийнд ирээгүй учир охиныхоо царай зүсийг үзээд өөрийн эрхгүй зүрх шимшрэн нүд дальдарчээ. Охиноо туслагчтай таарамжгүй байгаа тухай эцэг нь сонссон авч ингэж нүднээс гарчихсан гэж санаагүй явсан билээ.

- Охин минь, юунд ингэтлээ царай алдчихаа вэ? Бие чинь өвдөө юу? Алив аавдаа хүрээд ир! Охиноо үнсье. Аав нь ч саначихлаа.

- Яагаад ингэснийг та надаас асуугаад яах вэ. Өөрөөсөө асуувал дээр биш үү? гэж Юмжирдулам хүйтнээр хэлээд босож очсон ч үгүй, хэнэггүй сууж байлаа. Уулзалгүй удсан болохоор охин минь аягүй бол намайг үзээд уйлах байх гэж бодож ирсэн эцэг нь охиноо ийм хатуу үгээр угтсанд ихэд гайхжээ. Аавдаа уурлаж айлгасандаа л ингэж байна гэж санасан Намсрай

- Охин минь, надай эрхэлдэг шигээ урваганаж байж болохгүй. Төрийн түшмэл хүнийг шаналгахаа больж үз! Чи минь нэгэнт ёс төрөө хийсэн хатан хүн шүү дээ гэж ятгахад Юмжирдулам “Дүвчин, түшмэл хоёрын чинь заль мэхийг мэдсэн! Та ч тэдэнд бурантаглуулчихаад мунгинаж яваагаа ойлгооч!” гэж бачимдан хашгирах гэснээ Пагмыг зэмд унагахаа гэнэт санаж хэлээ хазаж болиод

- Та нарын ёс тэндээ л биз. Өөрийн ухаантай байсан цагтаа энэ хөгшин түшмэлийн чинь эхнэр болохгүй. Харж л байгаарай! гэж ууртай дуугарсанд эцэг нь

- Миний охин тэгж хэдэрлэж болохгүй. Харья очсон бэр, хаданд харвасан сум хоёр эргэж буцдаггүй юм шүү дээ гэв.

- Танайд л очихгүй байвал болоо биз гэж Юмжирдулам ширвэлзэв. Намсрай охиндоо юу ч хэлээд нэмэргүй болсноо ухаарч, хэрхэхээ бодон жинстэй малгайгаа нясалж тоосыг нь үлээнгээ охиныхоо царайг сэм сэм ажин суутал Юмжирдулам,

- Аав та наашаа яах гэж ирсэн юм бэ? Надаар сольж авсан наад муу чулуутайгаа л явбал болоо биш үү? гэж ёжтой өгүүлсэнд Намсрай хэлэх ч үггүй гөлөлзөж, охиныхоо нүүр рүү ч харж зүрхэлсэнгүй хоолойгоо засахчаан болж хэд хахираад гарч оджээ.

Тэргүүн туслагчийн хатан болсон охиноороо амтат идээ будаа, дотор газрын хатуу дарсаар дайлуулна гэж дээгүүр санаж ирсэн Намсрай өөрийнх нь хэтийн аз жаргалын төлөө ухаан заран зүтгэсэн эцгийнхээ санааг сэхээрэхгүй хүйтэн царай, гашуун үгээр угтсанд нь төрсөн охиндоо гомдосхийвч “Дэндүү эрх танхи өссөндөө л ингэж ярдаглаж суугаа байлгүй. Би жинсний учрыг ухаж мэдсэнтэй адил охин минь ямбатан дээдсийн халгим цэнгэлд хөл алдан хөвөхөөрөө л сая ухаан орж дээдсийн хүрээнээс хөөсөн ч тэндээ живэхийг хүсэн хэвтэх цаг ирэх биз” хэмээн сэтгэл уужран алсыг бодсоор бөг бөг шогшуулан буцжээ.

Арван есдүгээр бүлэг

Хээрийн хойморт

Орчлонд төрсөн эрийн заяа

Од харвах шиг таарах нь ч бий

Балар ой ширэнгийн бяцхан чөлөөнд цэнхэр утаа суунаглаж, түүдэг гал дүрэлзэн урт мөчирт шорлож өлгөсөн махнаас тос шүүс дуслахад шард шардхийсэн чимээ гараад галын дөл улам бадарна. Арьсан дээр нь эвдэж орхисон гөрөөсний махны дэргэд цахиур буу шийрлэн тавьжээ. Модноос уяатай хилэн хар морь амсхийх чөлөөгүй толгой хаялан байн байн тургиж, газар цавчлах нь үдшийн сэрүүнд бужигнах түг түмэн ялаанаас залхсан бололтой.

Базар гишүү мөчир тэвэрсээр түүдгийн дэргэд ирэн галаа засаж, мөнгөн тоногтой тохой хэурейн хутгаа сугалаэ өлгөөтэй махаа хэд сийчээд шүүрхий байхаар нь болохыа нь хүлээж гараа салаавчлан дэрлэж гэдрэг харан хэвлээ. Дээд тэнгэр өөд тэмүүлэн ургасан зэгзгэр гоолиг шинэсний үзүүр сэвшээ салхинаа үл мэдэгхэн найгаж сэрчигнэх авиа үүсгэнэ. Өнгийн шувууд шулганалдан жиргэж, бяцхан горхи нэгэн хэмээр хоржигнон урсах нь чихнээ чимэгтэй. Эзгүй хээрээр гэр хийж, эмээлтэй мориор нөхөр хийсэн залуу эрд зүдэрч залхаж, гандаж ганихарсан байдал ер үгүй. Нүүр нь тос дааж зүлгэсэн зандан мэт хүрэнтээд орь залуу насны золбоо хийморь бадарсан эрүүл царайн дундаас зоримог шинжийг илтгэх цогтой хар нүд гялалзана. “Орон гэртэй хүн ингэж явна гэж байх уу даа. Эсхүл эзгүй газар эрх дураараа явах чинь аятайхан ч юм уу? Тэгэвч гэмгүй мөртөө гэмтэн хүн шиг гэрээсээ дайжин явна гэдэг юутай гамшиг вэ. Хагацал үзсэн хөгшин эхээ ч асрах эрхгүй болгоно гэдэг чинь хэний гай вэ? Ноёд түшмэд, лам нарын л уршиг! Биднийг ингэж зовоосны хариуд өөрсдийг нь шар махтай нь хатааж явбал бах минь ханах нь тэр! Тэд надад хичнээн өширхөвч түмэн сайн эр үүрлэсэн ч далдалж чадах Шар нуруунаас яаж олох вэ... Би ч яах вэ, ингээд байж болох л юм. Хөөрхий ээж минь ядрах байх даа... За ээж ч яах вэ, бас ч гэртээ байгаа болохоор аргатай юм... харин хайрт минь л өшөөтний үүрэнд яаж зовж байгаа бол! Юуны азаар Орших, туслагчийн шивэгчинд сэтгэлтэй байв аа. Тиймгүй бол үхсэн амьдыа нь ч мэдэж чадахгүй, нүдэн балай, чихэн дүлий явна гэсэн үг Пагмын ачаар юу болж байгаагий нь биеэр уулзсанаас ялгаагүй дуулж байна. Пагма л нууцаа алдчихгүй бол сэтгэлтэй түүнийгээ орлуулах арга бодно. Ямар ч давуу хүчийг ухаанаар дийлж болно гэж аав минь хэлдэг байж билээ. Аавынхаа сургаснаас хазайхгүйг хичээе. Тэдний аймхай хулчгарыа нь далимдуулна. Чөтгөр шулам гэхээр л амь нь гарчих шахдаг улс. Түүгээр нь унатал тустал хуурч, үхэж хаттал нь айлгаж байгаад ганц сайхан дөнгөө өө. Тэгсэн цагт уу...” гэж Базар инээмсэглээд өндийж дэргэдээ байгаа жамъянмядаг цэцгийг таслан авч улаан шаргал шанамыа нь үнэртсэнээ “Хонгор минь, ийм л ариухан цэцэг шүү дээ. Хээрийн анхилуун цэцэг шиг чамайг хээгээ барсан туслагчийнд суулгаж байна гэдэг надад хичнээн бэрхтэйг хэлэх юун! Үзэсгэлэнт цэцгийг өргөст ортуузтай хамт байлгаснаас юуны ялгаа байх билээ” гэж бодон амраг хүүхнээ санагалзаж байтал хиншүү хярвас ханхалж шарсан мах түлэгдэж эхлэв.

Базар давхийн босч махаа авч нарийн горхины эрэг дээр очиж тухлан суугаад банздууны навч шиг нимгэн далбагар огтлон үмхэж хоёр гуравхан зажлах төдий болоод залгина. Гөрөөсний хааг ууцтай нь идчихээд гараа ногоонд арчиж хутгаа хуйлаад горхины хүйтэн уснаас залгилав.

Тэгээд эвдэж тавьсан махаа арьсанд нь боож ганзагалаад махирлаж тахирласан үл мэдэгхэн зөрөг даган уул өөд өгссөөр нэгэн агуйны үүдэнд бууж амны нь чулууг түлхэн зайлуулж мах буу хоёроо оруулж тавиад мордов.

Нар шингээд цагаан гэгээ хараахан тасраагүй байхад Базар Цэгээн нуурын хөндийд хүрлээ. Халуунд ялаархаж нууранд зогсч өнжсөн адуу үдшийн сэрүү ормогц бэлчээрт гаран идшилж байлаа. Шилийн сайн эрийн зам хөөж анхныхаа сорилтод орж яваа сайхь залуу “Аагтай түшмэл чамайг адууны чинь сорноос салгана даа. Хамгийн шилдэг морьд нь явдаг саарал азаргатай адуу нь энэ байна. Базар гэж нэг барагдахгүй хөнөөлтэй, дарагдахгүй дайсан гарч та нарыг зовоож дээ. Үнэнээрээ явахаар би дийлддэгээс хойш бяраараа үзэхээс биш яах вэ. Хошуу туслагчийн яахыг одоо л нэг харж дээ” гэж бодон мориныхоо дэлэнд наалдаж, адуу руу нь харцага шонхор мэт шумбан орж сайн морьдыг нь ялган захдуулж байгаад бугуйлаа толгой дээгүүрээ хий эргүүлэн ганцхан хашгираад элдэв. Гэнэт хөөгдсөн хур хүчтэй омголон морьд тургин унгалдаж цахиур мэт хагуу туурайгаар газрын хөрсийг эргүүлж хаялан тэнгэр тулам цагаан тоос босгон шашир дэлээ намируулан хуй салхин адил хурдлан давхина. Тайван бэлчээрлэсэн адуун сүрэг гэнэт хага үсрэн бужигналдаж хэн нэгэн хүн бөөн адуу таслан хөөхийг айлын сөхөтэй үүдээр харсан хоёр адуучин ухаан алдан айж аягатай цайгаа шидчихээд

- Та минь, сүүлгүй чоно! гэж уулгадан хашгираад мордон нэхлээ.

- Туслагчийн сүрэг рүү аймшиггүй ордог ямар амьтан бэ?

- Харийн хошууны л хулгайч байх. Өөрийн хошууных бол айгаад ойртох учиргүй.

- Үйл нь ирсэн хулгайч юм даа. Чамайг барьж авахгүй бол уу! гэж хоёр адуучин ярилцан унааныхаа хар хурдаар харайлгана. Тэд гүйцэх төлөвгүй боловч хоцрохгүй дагасаар байв. “Та хоёрыг гүйцээд ирдэг юм бол явгалж орхиод талийж өгнө дөө” гэж Базар ганцаараа яриад эргэн эргэн харж морьдоо исгэрэн хөөнө. Цагаан гэгээ тасарч харуй бүрий болов. Базар нэг содон сайхан цавьдар морь бугуйлдаж явуут дундаа ногтоор оосорлож аваад эмээллэв. Нэхсэн хоёрыг дөхөж ирэхээр нь хэдэн үг хэлэхээр хүлээзнэв.

- Наад морьдоо орхи! Манай тэргүүн туслагчийн адуу!

- Олз хайж яваа бол ондоо газраас ав! гэж адуучин эрс хашгиралдсаар ойртон ирлээ.

- Би Сүхийн Базар байна. Эцгийнхээ амины золиосонд авч байгаа юм гэдгийг цаад туслагчдаа хэлээрэй! Та хоёр энэ биенийхээ мэнд дээр буцсан чинь дээр. Бараадаад салахгүй бол манхан дотор хүлээд хаячихна шүү! гэж Базар хэлээд хилэн харыгаа морьдын дунд оруулж уухайлан элдсээр манхан дотор орж үзэгдэхгүй болжээ. Хоёр адуучны морь элсний зах руу ороод л эцэж сульдан урагш гишгэхээ болив.

- Ийм адгуус зайдалсан улс ч яаж хэргээ бүтээх вэ!

- Олигтойхон унаатай бол ч үзээд алдах санж гэж тэр хоёр Базараас айсан хэрнээ мориндоо муу нэр өгөөд манхан дунд нижигнэх морин түвэргээний битүү чимээг чагнасаар хоцорчээ.

- Одоо яана аа? Туслагчтанд юу гэж хэлнэ! гэж намхан хөх хүнээ гонгинон үглэхэд сартгар хамартай таргай эр нь,

- Адуучиндаа сайн морио унóблахгүй харамладгийн гай. Хөнгөн хөлтэй унаатайсан бол гүйцээд барьж авахгүй юу гэж эрдүү дуугарав.

- Гүйцсэн бол тэр яах байсан бол?

- Тэр муу яадаг юм. Адуугаа хаяад л зугатах байсан биз. Хоёрын хоёр эр хүнээс айхгүй яах вэ.

- Цаадхи чинь тийм эр биш. Чи бас түүнийг дийлнэ гэж горьдож байна уу? Санааны гарз. Гүйцээгүй нь дээр болсон. Туслагчийн хэдэн адсаганаас амиа алдаж юу хийнэ.

- Үхсэн хойноо, тэр муу хулгайчаас айхдаа яадаг юм бэ. Ганц би ч бариад авсан нилээд үзэлцэнэ.

- Тэгэж ярихгүй ээ. Базарыг ямар булиа гэж санана! Бид хоёрыг хүн гэж тоохгүй аман хүзүүгий маань мулт алгадчихаад явчихна гэж намхан хөхийгөө хэлэхэд сартгар хамарт нь “Ёстой үнэн үг, үхрийн тос. Найрын шөнө тэр олон хүнтэй ана мана нанчилдаж байхыа нь харахад зүрх алдмаар байсан шүү. Тийм хүн ч бид хоёрыг өвсөн түүдэг шиг аваад шидчихнэ дээ” гэж зүрх алдан бодоод

- Бид хоёр ч хонгогүй болсон байх аа гээд уйлахаар инээ гэгчээр инээх аядахад,

- Хонгоор зогсвол ч яамай гэхэд,

- Авсан эзнийа нь мэдсэн нь л их юм. Хулгайчийа нь хэлж өгөхөөс илүү яаж тус хүргэх вэ. Авсан хулгайчаа л шийтгэ. Бидэнд хамаагүй гэж хэлэхгүй юу гэж сартгар хамарт хургиатсанд,

- Чи минь энд ярьж байгаа үгээ л тэнд хэлж үзээрэй гэв.

Тэнгэрийн уудамд мэлтийн хөөрч байгаа тэргэл саран сүүн цагаан гэрлээрээ хавь орчныг гийгүүлнэ. Базар саран мандаж байхад уулзана гэсэн болзооноосоо хожимдсонд яарч амсхийх чөлөөгүй довтолгон бахардаж хөшсөн арваад морьдыг цувуулан орхисоор элсний сүвээр давж мухар Хүнгүйд орж ирлээ. Голын захад цооглон зогссон олон адуу сарны саруулд тов тодхон харагдана.

Намбаа Базартай мэндлээд их Монголын элсийг шөрмөснийхээ сайнд давж ирээд амьсгаадан зогсож буй морьдыг тойрон үзсэнээ

- Ёстой л аргамаг хүлгүүд байна гээч. Чи ч эр хүн юмаа. Чамайг ийм хүн гэж мэдээд хань болно гэж найдсан юм. Түүнээс биш муу эрийг чирч өөрөө ч, хүнд ч гай болоод яах вэ гэж бахдан өгүүлээд инээмсэглэжээ.

Тэр хоёр торгон элсэн дээр хэвтэж Халхын сайн эрсийн элдэв паянг дэлгэв. Тэгээд сүүлд нь Намбаа хошуу засагтаа баригдаж алуулах шахсанаа хуучлаад

- Манай хошуу тамгынхан надад хэрэг хүлээлгэж ядахдаа нэг удаа дөнгөж толгой цухуйсан нүхэнд хийж бүсэлхий хүртэл элсээр чигжчихээд мянга түмэн адуу хураадаг юм байна. Намайг адуугаар гишгүүлж алах гэж бодож л дээ. Би дэмий л хангинатал исгэрч байлаа. Тэгсэн чинь адуу тойрч хуйларч давхиад л байна уу гэхээс биш, хүний толгойд арай ч хүрдэггүй юм билээ. Мөн ч ухаантай мал шүү. Тэд ядаж орхиод намайг нүхнээс гаргаж санаснаа гүйцээж чадаагүйдээ нэрэлхэхдээ

- Чиний хэр зэрэг хийморьтой зоригтойг үзэх гэсэн юм гэж хэлээд тавьж билээ гэж ярилаа.

Хүнгүйн голын эхэн болсон асар том хөмөг манхнаас бургилан урсаж байгаа усны бидэртсэн мандалд сарны мөнгөн туяа тоглон наадна. Голын араар элсэн манхан цайран үзэгдэнэ. Өмнө этгээдэд мэлийсэн хөндий цайвалзаж холын уулсын толгой сүүдэр татан торойно. Хүний эрхээр замын ихийг туулсан адуу ширэг ч зулгаахгүй хааяа хөрвөж, хааяа ус ууж толгой унжуулсхийн зогсох нь хөлийхээ чилээг гаргах гэсэн мэт. Саран гиймэл салхи тогтуухан шөнийн нам гүмд өөрийн дураар тарайн хэвтээд гүнгэр гангар ярилцан байгаа энэ хоёр эр эмээж цочих хөндлөнгийн шалтгаангүй юутай амгалан, юутай жаргалтай вэ! Хүний нүднээс далд явж ганцаардлын зовлонг амсан уйдаж залхсан Базар идгэлт сайн андтайгаа санаа бодлоо уудлан ярьж сэтгэл баясна.

- За дүү минь, сар голлолоо. Зуны шөнө юухан байх вэ. Хөдлөх үү дээ. Миний авчирсныг чи туугаад буц! Өнөөх сумлана гээд байдаг чинь энэ шүү дээ гээд Намбаа өндийж дээлийнхээ шороог гүвэв.

- Намбаа гуай, та ямар амьтных нь голыг харлуулаад ирээ вэ дээ!

- Манай залгаа хошуунд маш баян, харамч хэрцгий отгын толгойлогч байдаг юм. Тэндээс хоёрхон азарга адуу авсан чинь явдлаа гүйцэлгүй тал нь хаягдах шив... Ах нь ч өөрийн хошууны өш хонзонтой баяд дээдсийг олон жил зовоож, өөдтэй малаас нь салгаж хорсол гомдлоо тайлсан хүн. Одоо ч голдуу Урианхай, Шинэ хязгаар руу явдаг болсон. Хариас хавирга хугална гэгч л болж байгаа ухаантай юм уу даа.

- Энэ олон ааббог чинь би яаж шингээх билээ.

- Эд нь байхад эдлэх эзэн нь байхгүй байна гэж үгүй. Баячуудын барж ядсаныг ядууст өгдөг байгаа даа гээд Намбааг морь руугаа алхахад Базар “Нээрээ тийм юм. Олсноо олонтойгоо хувааж түмэнд тус хүргэхгүй бол ингэж явахын хэрэггүй биш үү. Оршихдоо хоёр сайхан морь өгнө. Өвөл болохоор борчуулд хоол залгуулна. Ингээд бодохоор нэг байтугай нэг хүсүг адуу ч хэрэг болох нь гээч” гэж боджээ. Эрийн золбоогоор бие биедээ түшиг болж яваа хоёр сайн эр хорин таванд эндээ уулзаж, Хангайн сарьдаг уулсаар нутагтай Базар, хан буурал Алтайн нурууг давж хүний нутаг үзэхээр болзоод салж одлоо.

Мөнгөн сарны дор шилмэл сайхан адуун сүрэг туугаад хангинатал исгэрүүлэн жирэлзтэл хатируулж яваа Базар амссан хамаг зовлонгоо мухар Хүнгүйд орхичихсон юм шиг ухаан бодол саруул, сэтгэл санаа сэргэг нэг л хийморьлог явлаа. Үүрийн шаргал гэгээнээр адуугаа Шар нурууны нэгэн нугачаанд оруулаад агуйдаа очих үед сүргээ хулгайд хөөлгөсөн хоёр адуучин оногдох ялныхаа тухай бодож сэтгэлээр унаад хоорондоо ч үг солихгүй уруу

царайлж, цуцсан муусайн морьдоо унахдаа унаж, хөтлөхдөө хөтөлсөөр өргөөний хотод арай гэж хүрчээ.

Сэр-Од туслагч хараахан дээшлээгүй байсан боловч өөрт нь үүр цүүрээр бараалхаж зүрхлэх хүн үгүй болохоор адуучдын ирсэн нь ноцтой мэт санагдав. Туслагч яаравчлан хувцаслаад адуучдыг оруул! гэжээ. Сартгар хамарт нь намхан хөхийгээ урдаа түлхэн оруулаад өөрөө босго давмагц аалбагас хийгээд сөхрөн уначихав. Намхан хөх нь нөгөөхийгөө хээр явахдаа зоримог үг хэлээд байсан болохоор нь түрүүлж дуугарах байх гэж харсанд толгойгоо ч өндийлгөсөнгүй. Тэгэхээр нь “Бид дуртайдаа өгчихсөн биш. Яавал яатугай” гэж бодоод туслагчийнхаа өмнө сөгдөж адуугаа хэрхэн дээрэмдүүлснийг ярьж Базарын хэлснийг ч ёсоор нь айлтгав.

- Хайран морьд! Хайран морьд! Хайран морьд! гэж туслагч харуусан дуу алдаж босон харайгаад ташуур шүүрч

- Урагш нь хазайсан малнууд. Бариад авах чинь яагаа вэ гээд намхан хөхийг хэд ороолгоод сартгар хамарт руу очсонд цаадхи нь ташуурын сур хүрээгүй байхад

- Ёо, ёо! Эзэн тэнгэр минь өршөөж хайрла! гэж дуу тавин туслагчийн өлмийнөөс зуурч авсанд Сэр-Од улам хилэгнэж

- Хэдэн морьдыг минь алдчихаад бас өршөөл гуйна аа, чи! Чиний наад их зовлого чинь хэнд хэрэгтэй юм бэ. Зуураад авч болсонгүй юу. Идсэн нь идээн бэтэг, уусан нь усан бэтэг болсон хар мал! гэж хараан нөгөөхөөс нь илүү зоджээ.

- Энэ хоёрт эр гаргахаар тийм сайн юм бол авсан хулгайчийн нь авчраад залхаагаач! Гарын дор байгаа хоёр муу зарцыг махалж суухдаа ичихгүй байна уу? гэж Юмжирдулам басамжлан хөхөрсөнд Сэр-Од бусдаас ичиж гайхшаа барахдаа

- Энэ хоёрыг аваад яв. Тавь тавь шаахайд! гэж нэгэн хиад хэлж хатандаа гаргасан уураа адуучиндаа гаргажээ.

Тэргүүн туслагч хатан таалснаас хойш угийн догшин ширүүн дээрээ бүр ч хүн хайрлах сэтгэлгүй болсон билээ. Хорь банздах хүнийг дөч, тавь шаахайдах хүнийг зуу гэж хийсэн хэргээс нь хувь илүү хүнд ял оноох болсныг бусад түшмэд хиа нар нь гайхавч учрыг эс мэднэ. Тэгээд үйл нь ирсэн улс л туслагчийн ааш эвдэрсэн үед таарч дээ гэж ярилцдаг аж. “Би хууль барьсан түшмэл байтлаа тэр гуйлгачинд дөнгүүлж суух гэж үү? Чамайг барьж дөрвөн мөчийн чинь цовдолчихоод энэ эйд үзүүлэхсэн. Чамайг надад дайсагнахгүй болтол эхийг чинь тамлаад өгье. Тэгэхээр чи над руу дайрахаа болихгүй хаачих вэ” гэж Сэр-Од бодоод Пэрэнлэй нарын хэдэн хүнийг дагуулж давхив. Туслагч өөрийнх^{оо} дайсныг өөрөө бий болгож байгаагаар үл ухаарна. Малаа адуулаад амь зуулгаа хөөцөлдөж явсан Базарыг туслагч өөрөө аюултай дайсан болгож хувиргачихаад одоо дарж чадахгүй зовж байгаа нь энэ. Хүн гэгч ухаант амьтан болохоор санаанд оршгүй элдвийн аргыг сүвэгчлэн дайсагнах нь огтхон ч ганцаардахгүй ажээ.

Пагма морьтон хүмүүсийг дөрөлж даван далд ормогц гэрээс нэг баадантай юм аваад

туслагчийнд гүйж ороход Юмжирдулам

- Чи чинь юундаа ингэж үргэсэн ботго шиг сандраа вэ. Сууж цай уу л даа гэв.

- Үүнийг танд Базар өгүүлсэн байна гээд Пагмыг баадантайгаа өгөхөд

- Юу юм бол оо? гэж Юмжирдулам задлан үзэх гэв.

- Хүн ороод ирэх бий дээ. Хурдхан далд хийж үз! Туслагчид мэдэгдүүзэй гэсэн шүү... Танд ингэж хэлээрэй гэсэн гээд ярих гэтэл гадаа хүн ярилцах чимээ гарсанд Пагма айж мэгдэн, сүүлд хэлье гээд гарлаа. Юмжирдулам ч ямар учиртайг мэдээгүй хэрнээ бас л айчихаад өнөөх баадантай юмаа нуух газраа олж ядан байснаа эр хүн уудалж үздэггүйгээр нь гоёмсог эрээн нүүртэй том дэрэн дотроо хийгээд санаа амарч “Базар минь юу гэж хэлүүлсэн бол? Бушуухан дуулах юмсан” гэж сэтгэл догдолжээ.

Сэр-Од өртөө шахам газар морины эрчээр уурсан давхисаар хүүтэйгээ уулзаж байх гэж айлаас салж ганц гэр буусан Доржпалам эмгэний гадаа ирж

- Төрд тэрсэлсэн дайсныг өсгөсөн бузар эм чи гараад ир! гэж зандрахад хэд хоног сэтгэл амар байсан эмгэн бас юу болох нь энэ вэ гэж эмээн аягатай цайгаа тавиад бээцэгнэн гарч туслагчийн баргар царайг хараад бүр ч сүрдэв.

- Эрхэм дээдэс минь! Өчүүхэн би хорхойд ч гэмгүй ядарсан амьтан юмсан гэж өчөөд мөргөн сөгдөв.

- Чиний хүү ихэс дээдэстээ жөтөөрхөж туслагчийн адууг хөөж аваачаад байна. Чи л түүнийг мэдэхгүй байна уу? гэж Пэрэнлэй загнан ташуураа далайхад эмгэн

- Туслагчтан минь, би тэр хүүгийн биеийн нь төрүүлснээс биш, санаагий нь төрүүлээгүй... гэж хүлцэнгүй дуугарахад

- Дуугаа тат, зөнөг чинь! гэж Сэр-Од эмгэнийг зандраад

- Та нар үхэр малын нь туугаад яв! гэж тушаав. Дагуулууд нь хот руу чоно шиг дайран оров. Эмгэн малаа өгөхгүй гэж булаалдах санаатай оролдсонд Сэр-Од

- Харин хар толгойгий чинь хага цохилгүй үлдээж байгааг өршөөл гэж бод! гэж хилэгнэн хашгирч, эмгэний нүүрэн дундуур ташуурдаад авлаа. Дагуулууд үхэр хоний нь тоос татуулан хөөж одов.

- Балданлхам минь, өршөөж хайрлаач! Арван цагаан буянаасаа салсан би амьд явахын хэрэг байна уу? гэж эмгэн цорхирон уйлж хоосон хотон дотроо үлдэв.

Нохойноос өөр харах ч амьд юмгүй үлдсэн эмгэн гэрээс гарахдаа л харлан байгаа хотоо харж нүднийхээ нулимсыг унагана. Ийнхүү гутрал цөхрөлийн туйлыг үзсэн эмгэн тав хоногийг хуруу даран тоолж хүлээсээр зуны эхэн сарын хорин болоход түлээ баглах дээс барьж хүүтэйгээ уулзана хэмээн мод руу алхав. Хүүгээ хаанаас гараад ирэх бол гэж сэтгэл яаран

ийш тийш харуулдаж, чимээ чагнан нааш цааш холхисоор түлээгээ ч түүж чадсангүй. Хүү нь ирэхгүй тун удаж, өдөр өнгөрчих гээд байх шиг санагдахад гайхаш алдран зогсож байгаа эмгэн тун хөөрхийлөлтэй харагдана. Гэнэт мөчир гишүү чад пад хийх чимээ гарсанд эмгэн баярлан тэр чигт унан тусан зүтгэтэл хэдэн гөрөөс модны завсраар гүйж өнгөрөх нь үзэгдэв. Эмгэн урам хугарч амьсгаадан “Хүү минь өнөөдүүлийнхээ гарт ороогүй бол заавал ирэх учиртай. Тэдэнд арай баригдчихаагүй байгаа даа. Хүүгийн минь заяаг орон дэлхийн савдаг түших байлгүй” гэж мөн л хүүгээ бурхан тэнгэртээ даатган бодно. Бага үдийн алдад морь тургих чимээ гарч эмгэн босон харайв. Базар зэгзгэр өндөр алаг морь уначихсан хүрч ирлээ. Эмгэн хүүгээ тэврэн уйлж туслагчид зодуулж малаа булааёгасныг гомдоллон ярилаа. Базар эхийгээ хятад янжуур янз янзын амттан боовоор дайлж суутал эхийнх нь сэтгэл нь уужрав.

- Хүү нь туслагчийн хэсэг сайхан морьдыг Намбаа гуайд угтуулж өглөө. Намбаа гуай ч надад азарайа шахам адуу авчирсан. Заримый нь хятадын пүүсэнд худалдаж юм авсан. Үлдсэнийа нь нутгийнхаа ахар дугуу улсад өгч тус болох санаатай. Тэгвэл туслагчийн адуу үхрээс дахин хаана даа. Намайг гүжирт унагасан дүвчингийн малаас ч авна гэж Базарыг ярихад эх нь,

- Хүү мёнъ, дүвчин ламтан хараал хийнэ гэж хориглоход

- Гэм болохгүй ээ, ээж минь! Лам нар залиар хүнийг айлгадаг гэж аав минь хэлдэг байсан шүү дээ. Тэд танаас дахиад авах юм байхгүй. Хүү нь таныг юугаар ч дутаахгүй гээд Базар хоёр хуй торго, тамхи, чихэр эхдээ өгөв.

- Туслагчийнхан ирээд ижийгий нь зовоойд байхгүй байгаа даа. Түүнээс биш хүүгий минь үйлс бүтэж явбал яах вэ. Ээж нь өдөр шөнө өл хоолтой өнгөрч байвал болох нь тэр. Ухаан санаа гүйцсэн уул шиг том эрд ээж нь юугаа сургах вэ. Миний хүү яаж явахаа өөрөө мэдэхээс биш. Харин хашир сэрэмжтэй л байгаарай! Улсын яриад байгаагаар бол чамайг газар сайгүй отож эргүүлдээд байгаа даг шүү гэж эх нь өгүүлж хүүгийнхээ толгойг илж үнсээд “Хүү минь эцгийнхээ өшөөг авна гэж дандаа ярих юм. Арга ч үгүй юм биз. Өвгөн минь надаас тэнхлүүн, насны хэмжээ яагаа ч үгүй хүн байлаа. Сэр-Од туслагч Пэрэнлэй хоёрын зодуураас гэмтсэн нь ортой ч байх. Хүү минь дураараа л болог. Өөртөө болж байна гэж бодож явбал эцгээ үгүйлж гутрах нь хөнгөрөх байж магад” гэж бодон янжуурын зөөлөн утаа сорж суулаа.

- Ээж ээ, хүү чинь энэ хорин таванд Намбаа гуайтай Ховдын хязгаар орно.

- Хэр хол газар вэ?

- Ирэх очихын тавиад өртөө лав бий байх.

- Бурхан минь, ямар хол юм бэ! Өвлөөс нааш ирэх юм гэж үү? Ээж нь яана даа гэж эмгэн санаа алдав. Ээж минь, юу байх вэ. Зуны дунд сарын арван таван гэхэд хүрээд ирчихсэн байна. Хошуу засгийнхан намайг хаа ч үзээдэхгүй сураг тасарчихаар нэг тийшээ явчихсан гэж санаад отох нь ч гайгүй болох биз. Сайн сууж байгаарай, ээж минь гээд Базар явахаар босоход

- Сайн яваарай, хүү минь гээд эх нь хүүгийнхээ баруун хацар дээр үнсэж

- Ээж нь гэртээ хариад хүүгийнхээ алс замыг ерөөж тахил өргөнөө гэж хэлээд нүдэндээ

доглон нулимстай хоцорлоо.

Хорьдугаар бүлэг

Шулам

Мунаг харанхуйн эхэн

Мухар сүсгийн хүлээс

Тас харанхуй гэрт эрэгтэй хүн хяхтнасан с°өнгө хоолойгоор түвд ном уншиж, дамар тачигнаж хонх жингэнэж, арван наймтай эмийн чөмгөөр хийсэн ганлин, ясанд хадсан муухай дуугаар гийг гийг гэж орилно. Зодын сүрт зан үйлээс айж бурхны номын хүчинд итгэсэн хэдэн хүн мөргөн залбирч аман дотроо бишрэлийн үг шивнэнэ. Агваанлуvsан дүвчин тэргүүн туслагчийнд залран ирээд өргөөнд нь шүглэсэн ад зэтгэрийг хөөж хатан Юмжирдуламын ааш араншинг засах гэж зод тавьж суугаа нь энэ юмсанжээ. Сэр-Од дүвчингийн өөдөөс харан хоймор сууж “Бурхан минь! Ямар аймаар сүртэй юм болж байна даа. Ингэж байхад манайд муу юм яаж тогтох вэ. Үхсэнийг амь оруулахаас бусдыг чадах мөн ч ид шидтэй лам юм даа” гэж наманчлан залбирч, энд тэнд юм хөдлөх шиг санагдахад нь дав дувхийн цочин сууна.

Сэр-Од, дүвчингийн айлдсанд гүнээ итгэн цагаа болохоор хатан нь энгэрээ дэлгээд угтах юм шиг бодож ихээхэн тэвчээр гарган чимээгүйхэн явдаг байсан билээ. Дүвчингийн айлдсан хугацаат хоног дуусах дөхөхөд түшмэлийн сэтгэл догдолж залуу хатнаа харж мишилзэн инээхэд Юмжирдулам ярвайсхийн буруу хардаг учир Сэр-Одын гол нь гонсойдог байлаа. Туслагч зуны дунд сарын хуучаар Улиастай орж хэрэг нийлж хэд хонох зуур дүвчингийн хэлсэн хугацаа нэгэнт өнгөрсөн учир хатандаа үнэ цэнэтэй бэлэг авч их л баяртай эргэж иржээ. Сэр-Од хол газар явсных гэж хэдэн түшмэдээ дайлж өөрөө ч нилээд согтож, их л сайхан ааётай малилзаж суулаа. Тэднийгээ явсны дараа авчирсан үнэт эдээ гарган хатандаа өгч,

- Хэдийгээр муухай аашилж намайг зовоож байдаг ч гэсэн ханилсан хатан минь болохоор чамайгаа их л санаж хойшоо яарч явлаа шүү гээд маасайтал инээв. Согтуу туслагчийн сүүмгэр нүднээс тачаангуйн гал манасхийхэд Юмжирдуламын эгдүү хүрч нүүр буруулснаар үл барам

- Таныг эзгүйд сэтгэл амар байлаа. Тэр чигдээ алга болоосой гэж бурханд залбирч суулаа гэе зориуд хэлээд юмыа нь шүүрэн авч үүд рүү чулуудав. Түүний ёозгүй зан, билэг дэмбэрэлгүй үгэнд халамцуу туслагчийн уур дүрсхийн шатаж,

- Чи муу эм байтугай чамаас цаашиг нь миний өмнө сөгддөг юм. Чамд ингүүлж сууж чадахгүй гэсэнд

- Би танайд гуйж ирээгүй. Дургүй хүнийг эзэрхийлж авчирсан хүн ингэж зовно гэдгээ мэдэж байсан биз. Харин намайг охиноо болгосон бол дуртайуа өрхийг чинь татаж, уурыг чинь нүдэж, хөлийг чинь хучихсан гэж Юмжирдулам хэлэв.

- Өрөвдөөд байхаар өр рүү өшиглөнө гэнэ ээ, чи! Задарсан эмийг яаж номхруулдгийг үзүүлнэ дээ, чамд! гэж Сэр-Од шүд зуун дуугараад босон харайж хатнаа барьж авлаа.

Сархад их хүртсэн туслагч сөхөрч унаад хатнаа дийлэхгүй учир тэр хоёр зууралдан ноцолдож сав суулгаа унагааж, аяга шаазангаа хагалж, ширдэг дэвсгэрээ хуйлруулж тэмээ түйлсан юм шиг болгов. Бурхны ширээн дээр бариатай байсан зулнууд ойчиж дотор газрын эрээн хивсэн дээгүүр нэл шар тос болов. Үмжирдулам туслагчийн гараас арайхийн мултарч голомтоо тойрон зугадсанаа хаалга саван гарч гүйв.

- Таминь, хатан орголоо! гэж туслагчийг бачимдан муухай орилоход гадаа явсан хиа Юмжирдуламыг барьж авлаа. Энэ чимээнээр айл айлаас амьтан хүн гарч туслагчийнх руу хүрч ирлээ.

- Энэ эмийг өргөөнөөс зайлуулбал таарна.

- Дээдсийн буян эдлэх заяагүй өлөгчин!

- Ийм гуйлгачинд хүүдий бариулаад түмнийг хэсүүлбэл барав!

- Туслагчийн хатан болох сайхан дагинас энэ хошуунд мундахгүй! гэж тамгынхны хатад Юмжирдуламыг адгийн муу үгээр харааж, зарим нь нүүр өөд нь нулимав. Тэдний амны зугаа болсондоо Юмжирдулам харамсан өөрийн хувь тавиланд гомдон хоцорчээ.

Нэгэн орой туслагчийг хоолоо зооглож суотал нь хатны хоолыг өгөхөөр гарсан шивэгчин Пагма,

- Туслагчтан минь, яадаг билээ. Чоно, чоно! гэж муухай орилсоор эргэн орж ирэхдээ босгонд таварцаглан тавагтай махаа унаган данхтай цайгаа асгачихав.

- Яав чи! Өвчин тусав уу? гэж туслагч аман дахь махаа зажлуут зандарсанд Пагма

- Хатан алга!... Хатныг чоно идчихжээ. Гэрт нь чоно... гэж ээрэн хэлбэл

- Бүү худал хэл! Солиотой мал уу, чи! гээд туслагч огтхон ч тоосонгүй.

- Эрхэм дээдэс минь, үнэн байлгүй яах вэ. Та бушуухан очооч! гээд шивэгчин уйлагнав. Сэр-Од хутгаа дурамжхан тавиад аажуухан босч гарав. “Өөрийг нь оролддог болохоор энэ шивэгчин манай хатанд дургүй байдаг байх. Хатны минь нэрийг гутааж зайлуулчихаад өөрөө надтай хэвгэж байх санаатай даг шүү” гэж бодсоор хатныхаа гэрт орох гэснээ түрүүчийн нэг явдлыг санан тотгоор нь шагайвал орны нь урд саатайсан саарал ÷îно оцойн сууж байв. Сэр-Од ухаан алдталаа айн эргэж харайв. Буугаа цэнэглэж аваад хиа дагуулааь очтол чоно ч алга. Юмжирдулам сууж байснаа

- Та минь, яах нь энэ вэ, амь өршөө! гэж орилов. Сэр-Од хэсэг зуур алмайран харж зогссоноо мэл гайхаж буцав. Хүмүгс яах гэж тэгснийх нь учрыг олох гэж бие биесээс асуусан боловч мэдэх хүн гарсангүй. Гагцхүү Пагма үгэнд дуртай, хушуу урттай нэг хатагтайд энэ тухай аминчлан ярьчихжээ.

Туслагч өргөөнд орж хоолоо зооглох гэсэн боловч хамаг бие нь арзайж, духных нь хөлс чийхарч байлаа. “Ямар муу ёрын юм үзэх нь энэ вэ! Шивэгчингийн үгнээс болойд андуу харав

уу?... Үгүй ээ, осолгүй чоно байсан. Манай энэ өргөөнд муу юм шингэчихсэн байхаас зайлав гэж үү? Тэгээд энэ сайхан амьтанд хоргодож ааш зангий нь эвдээд байж мэдэх юм. Тэгээгүй бол усан нүдтэй цусан зүрхтэй бүсгүй хүн яагаад ч ийм алмас шиг ааштай байх ёсгүй. Заавал уярч зөөлрөх учиртай” гэсэн аймшигтай зэвүүн бодол Сэр-Одын ухаан санаанд ороход тайван сууж ч чадахгүй, чимээ гарвал давхийн цочиж байв. Тэгтэл Пагма орж ирлээ.

- Чи хө, эртүүд хатны өргөөнд үнэг байсан гэж үнэн хэлсэн үү? гэж туслагчийг зандрангуй асуухад

- Таны өмнө худал үг цухуйлгах зүрх надад яаж байх вэ гэж шивэгчин өчив. Пагмыг нэг өглөө хатгуй өргөөнд үнэг байна гэж айчихсан гүйж ирэхэд нь туслагчөөг үзээд алга байхаар нь уурлаж “Дээдсийн нэр сүрийг гутаах хорон санаагаар тохуурхан доромжлов” гэж Пагмыг ихэд зэмлэжээ.

- Би хатны өргөөнд орохоосоо айгаад байна. Намайг хорлочих байх. Та өөр хүнийг хатны шивэгчин болгож үзээч! гэж Пагма сөгдөн гуйсанд Сэр-Од эрхэм алдартаа халтай цуу яриа дэлгэрэхээс болгоомжилж,

- Эмээх хэрэггүй. Хувилгаан дүрийг олж төрсөн ид шидтэй хатан хүн тийм байдаг юм. Хэнд ч энэ тухай үг цухуйлгаж болохгүй. Тэгвэл чамайг хатуу цээрлүүлнэ гэж сүрдүүлэв. Гэтэл энэ хориг үнэндээ хожимдсон байлаа.

- Тэргүүн туслагчийн хатан чинь шулам юм гэнэ ээ.

- Үдэш үнсэн дээрээ гурав хөрвөөгөөд өлөн хөх чоно болоод явчихдаг юм байх.

- Туслагч хатнаа гаргахгүй гээд гэрийнх нь үүдийг цоожилчихсон чинь хон хэрээ болоод тооноороо нисээд явчихжээ.

- Тэр хатан чинь шөнө үнэг болчихоод өргөөний хотыг тойрч дуугараад байдаг гэнэ.

- Манай туслагч хатандаа хорлогдоод ялихгүй хэрэгтэй хүнийг ч хайрлалгүй хатуу шийтгэдэг болсон юм байх

- Тэргүүн туслагч даанч олон хатан сольсон доо. Шуламтай нөхцөхийн цондон байлаа.

- Сэр-Од туслагч өөрөө ч тэр шулмаасаа айгаад тусдаа суудаг болсон гэнэ.

- Сайн морь, сайхан хүүхэн хоёр чөтгөр болдог гэж ярилцдаг. Энүүгээр бодоход үнэн болж таарлаа шүү гэсэн хачин яриа айлаас айл дамжин хуурай өвсөнд ассан түймэр мэт хошуу нутгаар шахам тарсан байлаа. Туслагчийн шадар түшмэлүүд эл яриаг сонссон атлаа түүний догшин ширүүн зангаас болоод юу ч дуугаралгүй, таг дуугүй байжээ.

Түүнээс хойш Сэр-Од хатныхаа өргөө рүү шагайхаа больж, шөнө ч унтаж чадахгүй хар даран зүүдэлдэг болов. Хатнаа дахиад яахыа нь сэм ажиж хэд хоноод Агваанлуvsангийнд очлоо.

- Ламтан минь болгоож айлд! Хатны маань зан авир засарч наашлах нь байтугай бүр гаарч

гүйцлээ. Одоо миний аминд хүрэх нь шиг байна гэж Сэр-Од хэлээд, хатныхаа элдэвчлэн хувирдгийг ярихаас баахан нэрэлхэж түдгэлзэв.

- Би аргалаад аргалаад дийлэхгүй байна. Харин ч хүчтэй уншлага хийгээгүй бол таны амь насанд аюул учрах байсан гэж хатны нь хутга барьж Сэр-Од руу давшилсныг сонссон Агваанлуvsан айлдаж орхив.

Агваанлуvsан энэ насандаа олон эр эм хоёрын заяа замыг зааж ирсэн учир өөрийгөө хүний хувь тавиланг мэргэлээд мэддэг гэж санадаг аж. Тэгэвч Сэр-Од, Юмжирдулам хоёрын хувь тавилан түүний айлдсанаас тэс өмнөөгөөр эргэжээ. Туслагчид амалснаараа бурхны хоосон чанарын ном олныг уншсан боловч тэр хоёрыг эвлэрүүлж чадсангүй. Юмжирдуламын тухай элдэв яриаг сонссон Агваанлуvsан туслагчийг хатныхаа тухай юу ч ярихгүй болохоор нь гайхаж, дамын үг дамæёðàé гэгч болов уу гэж эргэлзсэн авч лавлах нь зүйтэй гэж бодов.

- Танай хатнаас ямар нэг муу шинж илрэв үү? гэхэд туслагч давхийж дүвчингийн өөдөөс харвал, түүний гөлийсөн царай “Би бүгдийг мэдэж байна, хэлбэл хэл, байвал бай” гэсэн янзтай тоомжиргүй байх шиг санагдав. Дүвчингээс нууж байж сэтгэлд нь юм хийчихвэл дэмий гэж бодоод болсон явдлаа нэгд нэггүй тоочив.

- Хар толгойд минь халзалсан ийм явдал боллоо. Би гэдэг хүн сэтгэл хоёрдоод тун ч хэцүү байна. Та манайд нэг очиж үзээч! гэв. Сэр-Одын яриаг сонсмогц дүвчингийн айдас хүрч тийм газар очно гэхээс зүрх алдав. Сэр-Одыг Галуутайн хүрээний лам нар руу түлхэн явуулж өөрийн биеэс зайлуулахсан гэж хүсэвч заяа нь нийлнэ гэж айлдсан хоёр хүнээ аргалж дийлэлгүй орхиж сүсэгтэн олны дунд нэрээ хугалахаас эмээхийн сацуу өөрийгөө ямагт хүндлэн шүтдэг дээд язгуурт хүнийг гомдоохгүйг хичээх учир Агваанлуvsан эцсийн удаа үзээд алдахаар санаа шулуудав.

- Танайд орогносон ад зэтгэр миний чадлаас давсан юм шиг байна. Аягүй л бол над дээр буучихаж ч магадгүй байна шүү... Гэлээ ч туслагч таныхаа сэтгэлийг бодож таны өргөөнд очъё доо гэж хаяагаа манасан үг хэлээд “Тэр хатны сэтгэлийг тогтоочихвол туслагч надад юугаа ч хайрлахгүй” гэж бодлоо. Сэр-Од “Үнэнээ хэлдэг минь онолоо. Дүвчин лам болгоомжтой байхыг бодоход би ÷ яггүй юмтай учирчээ. Дүвчингийн авралаар түүнээс салах байгаа даа. Сэтгэл хоёрдолгүй тандаа сүсэглэн явъя” гэж бодон гүн бишрэнгүй харцаар дүвчинг ширтэн хөлд нь сөхөрч өлмийнөөс нь адис авахад ч бэлэн сууж байж билээ.

Агваанлуvsан өөрийн бишрэнгүй сэтгэлээр зохимжтой гэж санасан өдрөө шилж ач ивээлээ хайрлахаар морилон очиход өргөөндөө орогносон чөтгөр шуламнаас сэжиглэж байна гэж санаж байсан Сэр-Од тун ч баяр хөөртэй угтаж тарган ирэг гаргаж дайлав. Дүвчин гурилаар элдвийн лүд барам хийж ном уншиж, тарган мах зооглож өнжив. Дүвчин лйтны айлдаж байгаа нîмыг хөндлөнгийн хүн ухаарах нь бүү хэл, өөрөө ч төсөөлөх барагтай.

Шөнө болоход өдөржин тухалсан дүвчин өрх, үүд хаалгыг битүүлээд зодоо тавьж эхлэв. Ганлин ойр ойрхон огцî огцом чарлаж, хонх дамрын дуу тасралтгүй нижигнэж, дүвчингийн уншлага агадаж тэвдсэн аялгатай болоход гэрт суугаа хэдэн хүн албин чөтгөр ар өврөөсөө гараад ирэх бий гэж айн сүрдэж харанхуй руу хулмалзан шивэр авир гэлцэнэ. Сэр-Од наминчлан залбирч “Ингэж байхад энэ оронд яаж муу юм тогтох вэ. Одоо л хөөгдөөд гарч

одоо шиг байна. Хатан минь ямар болж байгаа бол? Бушуухан очиж харах юмсан. Инээд алдаад л сууж байх болов уу?” гэж сэтгэл яарна. Дүвчин ямар нэгэн юмтай барьцалдан алдаж байгаа мэт байж ядан байснаа дуу нь зөөлөрч, хонх дамрын дуу нь цөөрсөөр зодоо тавьж гүйцээв.

- За лаагаа барь даа гэж дүвчин уншлагандаа тамирдсан бололтой амьсгаадангуй дуугарав. Дүвчин гэрэл гармагц хэдэн түвд үг амандаа гүнгэнэж, ядам хуруугаа бумбатай рашаанд хүргэж нанчид өргөөд,

- Хатгаа ариутгуул! гэв. Харанхуйд удаан суусан хүмүүс гэрэл гармагц нүд нь гялбаж энэ тэрийг анзаарч харсангүй, зөвхөн зод тавьсан ламынхаа ид шидэнд бишрэн түүн рүүгээ ангайтал ширтсэн байжээ. Хатандаа яах байсан Сэр-Од л орны өмнө оцойн сууж байсан том саарал чоныг хараад царай нь зэвхийрч,

- Ээ, лам гурван эрдэнэ минь! гэж хашгираад үүдээ дэлгэн гарч одлоо. Агваанлуvsанг хэрдхийн хартал чоно өөр рүү нь ухасхийхэд,

- Богдын минь сахиус! Амилсан шулам гэж муухай орилоод босон харайв. Чоно бумбатай рашааны нь шүүрэн авч ламын араас шидсэнд дагзан дээр нь онолоо.

- Бурхан минь! Хорлол боллоо гэж дүвчин амандаа бувтнаад баруун хатавчны хавьцаа тэрийн ойчив. Ухаан алдталаа айсан хүмүүс бахиралдан гарцгаав. Энэ самбаанд чоно ч бас гарч харанхуйд уусан алга болсныг мэдэх сөгөөтэй хүн байсангүй. Туслагчийнхан муурч унасан дүвчингээ сэргээх гэж бөөн манан болов. Агваанлуvsан сэргэмэгцээ юу болсноо эргэн бодоод өнөөх дүвчин чинь дарах гэсэн шулмандаа хорлогдсон гэнэ гэж амьтан хүний шуугиан тавихаас санаа зовсон учир үүнээс цэвэрхэн мултрах нэг арга олоод нүдээ ч нээсэнгүй, цээжилсэн номноосоо нэгийг уншин уруулаа хөдөлгөнө.

- Сэргэлээ, сэргэлээ.

- Бурхан хүн гэхээрээ мэнд үлдлээ шүү.

- Мөн ч аюултай юм болох шахлаа гэж хүмүүс шивнэлдэн залбирна. Дүвчин нилээд удсанаа өндийж

- Та нар их айгаа юу? гэж юу ч болоогүй юм шиг царай гарган асуулаа. Шивэгчин түүнд аагтай цай барив.

- Айхаар барах уу? Үнхэлцэг хагарах шахлаа. Таныг хорлочихлоо гэж саналаа шүү хэмээн Сэр-Одыг хэлэхэд

- Надад бүү санаа зовцгоо! Лам хүн, шулам хоёр учрахаараа заавал нэг нь дийлж салдаг жамтай. Над руу улаан дайрахаар нь би үхсэн мэт шидийг үзүүлээд хоцорлоо. Одоо шулам надаас ч, танай өргөөнөөс ч төөрсөн. Санаа зоволтгүй тайван сууж болно гэж дүвчин ажиггүй айлдахад сүсэгтнүүд сайн лам тулдаа л амь гарч гэгцгээн улам ч бишрэх сэтгэл төржээ. Тэр шөнө өргөөний хотын энд тэнд чоно ульж, заримдаа бүсгүй хүн уйлж,

тачигнатал хөхрөх зэрэг зүйл зүйлийн дуу чимээ сонсдож, амьтан хүн ч айж цочин унтаж чадалгүй хонолоо.

Өглөө Сэр-Одыг хатныхаа эрэлд мордьё гэхэд нь хүмүүс туслагчийгаа шуламтай нөхцсөөр түүндээ сэтгэл нь татагдаж байна гэж битүүхэн дургүйцээд явах хүн гарсангүй. Тэгэвч Агваанлуvsан мөн л шулмаас айдаггүй лам болохоо үзүүлэх далд санаа агуулж туслагч сүрээрэу хүч түрсний эрхэнд хэдэн хүн дагуулан ойр орчны газрыг самнаж үзэв. Эрэлчид нүдээ хөхөртөл газар шагайгаад, хүн чоно хоёрын алиных нь ч шинэ мөр олж харсангүй. Тэдний нэг нь

- Дөнгөж шөнө явсан өлөгчин чонын мөр яахаараа алга болчихдог юм бэ? гэж дүвчингээс асууснаа туслагчийн нүүр рүү гэмшингүй янзтай харав.

- Шулам чинь шувуу болоод нисчихийг хэн байг гэх вэ. Усан нүдтэй амьганд чоно мэт үзэгдэвч үүдээр гаруут үнсэн дээр хөрвөөгөөд юу ч болж хувирна... Хүнээ алдсан биш эрэл сурал болж юу хийх вэ. Буцацгаая! Сайхан бүсгүй хүн шулмын төрөлтэй байх ёсон буй. Хөөрхий хатан угаас шулам байж л дээ. Залуу бага болохоороо гай барцад бага өнгөрлөө. Хөгшин шулам бол ч амар дарагдахгүй гэж Агваанлуvsан айлдсан нь шулмын тухай эрэлчдийн бодлыг бүр ч лавшруулжээ. “Дүвчин гуай ч аргагүй сайн лам юм. Манайд юу байгааг мэдээд байж шүү. Өргөөнд минь олон жил орогносон аюулыг зайлуулж өглөө. Хатан тогтдоггүй чинь манайд шүглэсэн аймшигт юманд л байж. Харамсахад гол тасармаар сайхан хатныг минь шулам болгоод аваад явлаа шүү. Хэзээ нэг цагт ингэх учиртайгаас цааш яая гэх вэ. Миний толгойг цусдалгүй тонилсон нь яамай. Энэ ч дүвчингийн л ач” гэж туслагч буцах замдаа бодож явлаа.

Сэр-Од дүвчингээр сан тавиулж өргөөгөө ариуугуулаад түшмэд хатдыг цайлав. Тэд тэргүүн туслагчийнхаа ноёны зиндааны эрх мэдлээс нь айсандаа л өргөөнд нь морилцгоосон авч цаанаа ихэд жийрхэж, засдагаар инээж байгаад шалавхан гараад гараад явчихжээ. Сэр-Од ч тэднийгээ гадсан дээр суусан юм шиг өндөгнөж байгаад гарахад нь өөнтөгч санаа гаргасан ч үгүй, харин “Шүглэсэн бузар нь арилсан болохоор нэг аятайхан хатан таалж, өөрийн гэсэн нойтон сормуустай юмны бараа харж болох байгаа даа. Яараад ч яах вэ. Амьтны хэл ам намжихаар дүвчин гуайгаас асууя” гэж хэтээ бодож байв.

- Танд хоёр залуу морь барья. Манайд саатан хонож, хойчийн явдал суудалд минь харшлах юм байгаа эсэхийг бүр нэг сайн үзэж өршөөлөө хайрлана уу гэж хэний ч өмнө толгой гудайлгаж үзээгүй туслагч царайчлангүй гуйгаад дүвчинг давшгүй хүчтэй шулмыг зайлуулах гэсээр бие сэтгэл нь алжаан чилээрхэв гэж шинэ шөл уулгахаар дахин нэг хонь гаргалаа. Агваанлуvsан эндээс холдохын түүс болж байсан ч “Хоёр залуу морь” гэхийг чих дэлдийлгэн сонсмогцоо шуналын оч нь манасхийжээ.

- Эрхэм туслагч таныг аврал эрж байхад юунд цааргалах билээ. Өчүүхэн хувраг би таны таалалд нийцүүлье гэж дүвчин ёсорхуу өгүүлэн мэхэсхийв.

Хоёр хонохдоо хоёр хонины аминд хүрсэн дүвчин гэдэс цатгалан, сэтгэл тэнүүн, бардам сэхүүн яриа хөөрөөтэй үдшийг өнгөрөөлөө. Тэгээд хэвтэхийнхээ өмнөхөн гадаалж явтал хажууханд нь шулам болсон хатан эгдүүтэй муухай хөхөрсөнд сүнсээ зайлтал айж “Өнөөх

чинь!” гэж дуу алдаад туслагчийнд харайж орохдоо тотгонд нь толгойгоо цохичихов.

- Халаг минь! гээд дүвчинг духаа арчихад бүлээн цуй нэвчиж байлаа.

- Юу болов, ламтаан? аэж туслагч сандрангуй асуухад дүвчин айснаа тас нууж

- Өнөөх чинь танайхаас зайлахдаа дургүй байна. Эргээд ирж гээд хоймор завилан суугаад нэгэн судар дэлгэн үүд руу хялалзан хялалзан түргэн гэгч нь уншиж хааяа хааяа хуруугаа инчиднэ. Тэгтэл гэнэт морин туурай пижигнэн морьтой хүн бараг хаяанд ирэхэд Сэр-Од “Бурхан минь! Яадаг билээ! гээд босон харайж дүвчингийн дэргэд суучихав.

- Туслагч минь цаана чинь сүйд боллоо гэж дуу тавьсаар нэг хүн орж ирэхэд дүвчин туслагч хоёр тэр хүнийг нөгөө шуламд хөөгдөж явна гэж санан ухасхийн бослоо. Дүвчин сандрахдаа өвөр дээрээ дэлгэсэн номоо унагачихав. “Өнөөх шулам нь ороод ирчихээгүй байгаа даа. Тэгсэн бол яана аа? Дахиад зод тавихаас нааш гарахгүй байх даа. юуны азаар би энэ шөнө дүвчинг хонуулав аа” гэж туслагч айх алмайрах хослон суутал ирсэн хүн

- Нөгөө Базар чинь үхэрчнийг хүлж хаячихаад үхрийг чинь хөөгөөд явчихжээ гэв.

- Юу? Тэгээд яав? Тэр дор нь хөөгөөд барьж авахгүй яасан юм бэ?

- Аль өглөөгүүр тэгжээ. Дөнгөж сая мэдлээ...

- Эхийа нь хар гэрт хийхээс биш. Пэрэнлэйг дууд!

- Туслагчтан минь, тэр чавганцаар оролдоод горьгүй байх аа. Базар үхэрчнийг хүлж байхдаа аминдаа хайртай бол хөгшин хонины насгүй болсон эхэд минь бүү халд гэж танд хэлээрэй гэсэн байдаг шүү.

- Аа?... Тийм бий. Ямар ч гэсэн чи буц! гэж туслагчийг хэлэхэд түрүүчийн хоёр адуучин шиг болох байх гэж ухаангүй айж байсан тэр хүн өөрт нь гар хүрээгүйгээр барахгүй, загнасан ч үгүйд нь баярлахдаа өргөөнөөс нь ухарч гарахаа ч умартаад хаалга саван гүйж оджээ.

Сэтгэлийн аймшигт дарамтад хүлэгдсэн Сэр-Од мангуу дүйнгэ юм шиг гөлийчихөөд яах ч учраа олохгүй болжээ. Гэрлэх гэсэн биш байдаг хөрөнгөө барж гүйцэх нь. Базараас авч чаддаггүй юм гэхэд хошууны олноос нөхөх арга бий” гэж туслагч гол нь горойж сууна. Шулмын дуунаас айж хэлмэгдсэн Агваанлуvsангийн хамаг биеийнх нь хар хөлс чийхарч үе үе давхийн цочно. “Ариун сахиусанд минь бузар орчихоогүй байгаа даа. Надтай ийм муу ёрын юм дайралдаагүйсэн. Өдөр харид минь ч яалаа. Хоёр залуу морины сургаар хоночихсон юмсан. Үүр цайлгаад бушуухан мордьё. Аягүйдвэл шулмын хорлол болж магадгүй” гэж дүвчин бодоод шөнөжин уншлага үйлдэж, арц хүэ шатааж хонов. Өглөө нь Агваанлуvsан туслагчийнхныг өнөөдөртөө багтаж нутаг солихгүй бол горьгүй гэж айлдаад, шинэ газар буулгаж өгөөд яваач гэж гуйхад нь бараг зугатах шахам шилээ харуулжээ.

Хорин нэгдүгээр бүлэг

Аймшигт үзэгдэл

Сэтгэлийн зовлонг эс тэвчвээс

Итгэлийн хүлээс алдармой

Нар шингэж байлаа. 33үүн тийш харсан их замыг өгсөн нэгэн нүүдэл хөвөрнө. Ачаа хөтөлсөн ахимагдуу эхнэр, үргэсэн тэмээ шиг сэрбэлзэн харж амандаа нэг юм гүнгэнүүлэн үглэж, унасан тэмээгээ гуядан газрын өөд аахилуулан зүтгүүлэх нь нэгнээс айсан буюу нэгнээ яарсан буй заа гэлтэй. Тэмээд хүзүүгээ гүрдийлгэн амаа ангайж, хамраа шуухтнуулан суналзтал алхална. Ачааны хажуугаар халтар нохой газар шиншлэн шогшино. Эхнэр хөлс нь цувсан хэдэн тэмээгээ хааяа эргэн харж “Хайран мал, хэцүүдэв байна. Манай тэргүүн туслагч гэж балаг нь дуусдаггүй яасан гайтай амьтан бэ!” гэж гаслан шогширно.

Давааны нүцгэн тагийг чимэх гэсэн мэт их хөвчөөсөө тасран ургасан хэдэн том мод аварга мөчрүүдээ асар тэнгэрт цацан сарвайлгасан нь наран жаргасны дараахь мөнгөн туяанд сэрийж сарайн маш сүртэй харагдана. Эхнэр гэнэт зогтусан царай нь зэвхий дааж “Ингэнэ ээ, ингэнэ. Даанч оройтчихсон юм” гэж бодон ганц шад мэгзэи хурдан хурдан уншиж залбирна. Газрын өгсүүрт сунатлаа алхсан тэмээд яамай даа гэсэн мэт зогсож, зарим нь замын хажуугийн ногоо зулгааж, зарим нь хомоо шөргөөнө.

Ачааны сүүлээс бараадаж явсан Пэрэнлэй гөлмөө давьчсаар богиж очоод эхнэрээ хөмсөг атируулан харж

- Явахгүй яачихав аа? Гэгээтэйд даваа давах юмсан! Яв, яв! гэж зандрангуй хэлэхэд эхнэр нь

- Өнөөх чинь... гэж дөнгөж шивнээд айсан нүдээр өөдөөс нь харав.

- Аа гээд Пэрэнлэйн дуу суларч, уурламаар төлөвтэй байсан ширүүн харц нь зөөлрөөд явчихыг бодвол “Өнөөх” гэдэг нь хэнийг ч болов номхтгох далдын их хүчтэн бололтой.

Пэрэнлэй эхнэрийнхээ зэвхийж цайсан царайг ажиглаад толгой далжийлган чимээ чагнав. Их давааны ширэнгэ ойн гүнд бүсгүй хүний шингэн цээлдүү хоолойгоор дуулахыг сонсоод түүний дотор палхийж, хэнэггүй хүрэн царай нь эгшин төдийд хувирч, айж хэлмэгдсэн өнгөөр солигдов. “Надтай л зориуд учирч байна даа. Би гэдэг хүн бурхан болъоч дархан, тэр бүсгүй хоёрыг зовооход гар хуруу дүрэлцэж юунд нүгэл хураав даа. Туслагчийн амаар явсаар байгаад л энэ. Одоо ч зайлах замгүй боллоо. Амьд мэнд гарах хувь байдаг болов уу?” гэж Пэрэнлэй бодоод эхнэртээ айснаа мэдэгдэхгүйг хичээн хоолойгоо засаад түүний гараас бурантаг шүүрэн авч, амандаа маань дүнгэнүүлсээр ачаагаа хөтлөн ширүүхэн алхуулав.

- Туслагчийн хатан шулам болж гэнэ гэдэг яриа үүсээд хэдхэн хоног өнгөрсөн боловч нэмэр хачир нь ихсэн даамжирч амнаас аманд хүрэхдээ улам хүч орсоор байлаа.

- Туслагчийн амийг Агваанлуvsан дүвчин л аварсан гэнэ.

- Одоо ч гэсэн туслагчийг авч явах гээд эргүүлдээд байдаг гэнэ шүү.
- Тэр хүүхэн чинь хойт насандаа л туслагчтай ханилах тавилантай юм гэнэ.
- Дүвчин тэр шулмыг дарж дийлэхгүй, арайхийж л гэрээс нь хөөсөн юм байх.
- Сайхан орон дэлхийг бузарлаж гүйцлээ. Аль хүн их явдаг зам, даваагаар эргэлддэг гэнэ шүү.
- Галуутайн хүрээний лам нар тэр шулмыг дарах гэж сор залсан гэнэ. Тэгсэн ч хэвээрээ л байна.
- Есөн шид нь бүрдэж амилсан шулам гэдэг чинь хэрийн юманд дийлддэггүй юм гэнэ билээ гэж хүмүүс ам мэдэн ярьсаар хоёр өнжиж байгаа билээ.

Хүний сэтгэлийн уй гашууг илтгэсэн “Өнөөхийн” өрөвдөлт дуу улам ойртож уулын цуурайтай хослон хангинахад нүүдэлчин хоёр үнхэлцгээ хагартал айж, бие бие рүүгээ харан харан урагш зүтгүүлсээр явлаа. “Бид хоёрыг зүгээр орхихгүй байх. Мөрөөрөө үхэж болдоггүй, заавал шуламд хорлогддог хэзээ хийсэн үйлийн үр вэ?” гэж Пэрэнлэйн эхнэр бодон мааниа уншиж хар хүнээсээ нууж нулимсаа арчина.

- Маргааш нүүе ээ гэхэд л чи өнөөдөр гэсээр байгаад энэ.
- Амжина гэж бодлоо л доо гэж эхнэрээ нэг ч үг хэлүүлэхгүй зандарч сурсан Пэрэнлэй энэ удаа л гэмшингүй дуугарав.
- Яана даа, яана! Хаашдаа ч өнгөрлөө. Амьтны ярьдгаар бол чи бид хоёр ч мэнд өнгөрөхийн учир байхгүй байхаа гэж эхнэр хоолой зангируулан хэлэв.
- Айхгүй бол шулам хорлож чаддаггүй юм гэнэ билээ. Дайраад ирвэл тархин дундуур нь буулгаад үзнэ дээ гэж Пэрэнлэй огт айгаагүй, эр зоригтой хүн болж эхнэрээ тайвшруулахыг хичээв. Тэргүүн туслагч Сэр-Одынхныг нүүлгэж төвхнүүлэх гэсээр Пэрэнлэйнх ийнхүү оройтжээ.

Цагаан гэгээ тасарч үдшийн бүрий хавь орчныг нөмрөн харанхуйлав. Тэр хоёр улам ч айж, арай чарай урагш зүтгүүлсээр давааны оройд гарахын алдад “Өнөөдхийн” дуу чихэнд хадан цангинаж, дэргэд нь хүрээд ирэх шиг болжээ. Пэрэнлэй мориныхоо амыг татаж зогсов. Давааны тагийн хэдэн сэрэвгэр модон дундуур нэгэн хар дүрс торолзон өнгөрөх нь цайвартах тэнгэрийн наана тодхон харагдлаа. Эр эм хоёр юу болохыг ажих нь байтугай үхтхийн айж нүүрээ буруулав.

- Ээ, бүү үзэгд! Хорин нэгэн дарь эх минь аварч өршөө! Пэрэнлэй минь яадаг билээ! гэж эхнэр нь орь дуу тавьж эрээсээ зуурч авлаа. Пэрэнлэйн зүрх дэлсэж, хамаг биенийх нь хүйтэн хөлс асгарч “Дүвчин багш минь!” гэж бувтнав. Хоёул цагаан ногоон дарь эх, мэгзмээс эхлээд мэддэг хэдийгээ дахин дахин уншжээ. Өнөөх нь урд арын мод руу орох шиг болоод чимээ анир замхрав.

- Хөөрхий минь, өршөөлөө гэж эхнэр шивнэн өгүүлж алгаа хавсран тэмээнийхээ бөх рүү тонголзон залбирав. Тэд чимээгүйхэн алхуулсаар давааны бэлд буусан хойноо дотор нь онгойж, үг хэлэлцэх сэхээ орлоо.

- Чи айв уу? гэж Пэрэнлэй асуув.

- Бурхан минь, арай л сүнс зайлчихсангүй.

- Би ч айхгүй л байвал аргатай гэж бодоод яахыг нь хүлээгээд зогсож байлаа. Шулам чинь ер нь хэрийн хүний зүрх авчихмаар аймшигтай юм байна шүү. Чи харсан биш дээ?

- Юун харахтай манатай.

- Би ч дайралдсаныг сайн ажиглаж авлаа. Жигтэйхэн урт хошуутай, сэгсийсэн үстэй юм гээч. Хоёр том хөхөө мөрөн дээгүүрээ давуулаад хаячихсан байна билээ гэж Пэрэнлэйг ярихад эхнэр нь

- Бурхан гончигсүм минь, хэлэх ч юм биш гэж залбираад,

- Хүнд тусархаг, хөөрхөн ааштай охин байсан юм гэнэ билээ, ум ма ни бад ми хум. Түүгээрээ бол ч мань мэтэд гай болмооргүйсэн. Хайран залуу амьтан ингээд өөр төрлийн юм болчих гэж дээ хэмээн өгүүлэв.

“Намайг шулам үзсэнээ ярихаар хүмүүс Пэрэнлэй нөгөө шуламтай чинь харанхуй шөнө улаан нүүрээрээ тулгараад дажгүй гараад ирсэн гэнэ. Пэрэнлэй ч хэзээний зоригтой л доо.”

“Догшин тахар” гэдэг болохоор шулам хүртэл айгаад халддаггүй байна шүү гэж шагших байх даа” гэж Пэрэнлэй гайхуулахыг хүстэл “Чи тийм зоригтой хүн үү? гээд өнөөх чинь араас хүрээд ирвэл яана” гэсэн нэг бодол төрөхөд толгойтой үс нь өрвөсхийж, эргэн харах гэсэн боловч айдас нь хүрээд чадсангүй.

“Эхлээд туслагчдаа дуулгах юм байна. Миний зоригийг бахдаж шан хайрлах ч юу магад” гэж Пэрэнлэй бодож айл амьтанд бушуухан хүрч, энэ учралаа ярьж гайхуулахсан гэж санахаас хэл нь загатнах шиг болж морио давьчсаар ширүүхэн алхуулав.

Пэрэнлэйнх өглөө эртлэн гэрээ барьж, зарц барлагууд тусалж байлаа. Пэрэнлэйг шуламтай учирснаа эрээ цээргүй сүржигнэн ярихад эхнэр нь,

- Би ч айгаад ухаан тавих шахсан. Манай энэ л зүрхгэйгээрээ харсан байна билээ гэж хажуунаас нь үг нэмэхэд хүмүүс Пэрэнлэйн үгэнд итгэж түүний аймшиггүйг гайхан шагширч байлаа. Гэр бариад дуусаж байтал чанх өмнөөс нэг морьтой хүн давхин айсууг гадаа явсан Сэр-Од хараад омог нь хөөрч,

- Миний өргөө рүү халзлан давхиж байгаа цадигаа алдсан боолыг барьж арав ташуурд! гэж хиа нар руугаа зандраад өргөөндөө оров. Туслагч шулам болсон хатандаа хорлогдохоос айгаад хол юманд явахаа больсноор барахгүй, нар шингэснээс хойш гэрээс гарахаа байж хөхүүл хүүхэдтэй эхнэр шиг өргөөнийхөө мухарт шигдэн суудаг болжээ.

- Тэр хүн чинь Намсрай залантай байна гэсээр нэг хиа уухилан орж ирээд хэрхэхийг асуусан янзтай зогсоно.
- Тэгвэл ч яах вэ гэж Сэр-Од аман дотроо дуугараад хиаг гар гэж дохив. Хүний үрийг хатан болгон авч осолдуулсан болохоор туслагч хадмынхаа нэрийг сонсмогц айн бэмбэгнэж, юу хэлэхээ ч мэдэхгүй гайхаш алдран сууна. Намсрай орж ирэнгүүтээ,
- Чи миний охиныг яана гэнэ ээ! гэж хашгиран туслагчийг заамдан авлаа. Түүний нүүр уйлж гашуудсанаас болоод пэмбийн хавджээ.
- Миний хувь дутсанаас сайхан ханиасаа хагацлаа. Агваанлуvsан дүвчингээр олонтаа аргалуулсан боловч торгоож чадсангүй дээ. Би гэдэг ийм дүүрсэн хүн хоцорлоо шүү дээ гэж Сэр-Од учирлан хадмынхаа гарыг тавиулахаар оролдоно.
- Охиныг минь хатан болгож аваад адаг сүүлд нь толгойгий нь залгихаараа шулам боллоо гэж элдэв муугаар хэлнэ гэнэ ээ, чи! Биеийн нь муу байхад дуулгах чинь яагаа вэ! гэж Намсрай салахгүй зууралдсаар дээлийнх нь энгэрийг хүү татав. Залан гэнгэнэн орилж, цээж нь хэрчигнэх авч онийтлоо хавдсан хоёр нүднээс нь нулимс үл гарна.
- Та учир ойлгооч дээ. Хатанд минь өвчин эмгэг тусаагүй. Зүгээр байж байснаа шулам болоод явчихсан. Ийм л үйлийн үр дайрчихлаа. Одоо яана гэх вэ... Та суугаач дээ. Ярьж хөөрье.
- Тэгнэ байх, чи! Чамд би шулам өгөөгүй. Төрсөн ганц охиноо өгсөн. Чи ингэж хэлж суудаг яасан чулуун зүрхтэй амьтан бэ гээд туслагчийг нударгалж гарлаа. Гадна байгсад туслагчийн өргөөний үүдэнэ очоод тэдний маргаж, ноцолдож байгаа чимээг сонсовч айгаад орж зүрхлэхгүй байв. Тэргүүн туслагч хадамдаа хэд алгадуулмагц хацар нь учиргүй хавдах шиг санагдаж уур шар нь дэвэрч,
- Боль, чи! Тавь! Би чамаас хүн биш шулам авсан байна. Чиний тэжээсэн шулам миний голыг золтой л гогодчихсонгүй гэж хадмынхаа өөдөөс хайр найргүй хатуу үг хэлж барьцалдаж авлаа. Охиноосоо хагацаж яах ч учраа олохгүй балмагдаж яваа Намсрай туслагчийн хатуу үгэнд гомдох уурлах хосолж түүнийг дарж унаад
- Яана гэнэ ээ, чи. Чиний зодож алсан олон хүний сүнс чамд хоргодож байгаад харин чамайг биш, охиныг минь залгичихлаа. Эм сүвтэй амьтан тогтоодоггүй бузар шүглэсэн овоохойг чинь чамтай түймэрдвэл таарна. Чи яасан ичгүүргүй амьтан бэ! Охиныг минь шулам байсан гэнэ ээ, чи! Дахиад хэлээтэх! гэж Сэр-Одыг тархи толгойгүй балбав.
- Гадуур амьтай голтой юм байна уу? Ороод ирээч! гэж туслагчийг бархирахад Пэрэнлэй нэг хиатай орж ирээд заландаа салам зодуулсан туслагчаа салгаж авлаа.
- Намсрай гуай! Юу болж байна? Тайвширч үз! гэж Пэрэнлэйг хэлэхэд Намсрай ухаангүй юм шиг өөдөөс нь гөлрөн харж байлаа.
- Халуун цай ооч. Бий чинь тавирна гээд Пагмыг цай барихад Намсрай харж байгаа мөртөө авахгүй үхэр мөөрөх мэт гэнгэнэн орилно. Ухаанаа гартал архидчихаад ирээ юү гэтэл архины

үнэр үл ханхална. Ганц охиноосоо салж гашуун зовлонд учирсан Намсрайг хүмүүс өрөвдөж зөөлөн үгээр аргадан сэтгэлийг нь засахыг хичээвч түүнд хүний хэлснийг ойлгож байгаа янз огт үгүй, ухаангүй юм шиг толгойгоо барин мэлрэн сууна. Тэгж байснаа гэнэт ухаан орсон мэт босон харайж,

- Төрсөн үрийг минь эрлэгийн дэвсгэрт аваачих чулуу өгөө юу, чи надад гэж туслагчийнд байгсдыг цочтол муухай хашгирч нэгэн насны хүслэн болж байж олж аваад нандигнан хайрлаж явсан жинстэй малгайгаар тулганы тотго ороолгож, жинсийг нь хага цохиод согтуу юм шиг гойвганасаар гарлаа. Хүмүүс түүний яах гээд байгааг гайхан харж зогсол Намсрай морио авч дөрөөгөө олж ядан мулт мулт гишгэн байж мордоод мориндоо ташуур өгөн ум хумгүй давхилаа.

- Энэ хорвоо даанч яав даа. Миний ганц охиныг аваад явчихдаг нь юу вэ? Намайг яаж амьд явна гэж бодоо вэ! Энэ өгөр толгой амьд явахын хэрэг алга! Охиныг минь үлдээгээд намайг авах нь яагаа вэ! Ээ заяагүй хөгшин толгой! гэж Намсрай орь дуу тавьж, морио ч, өөрийгөө ч хайр найргүй ташуурдаж, хааяа тархи руугаа шааж “Даанч яав даа, даанч яав даа” гэж сэтээ сэлгээгүй гиншигнэв. Түүний толгой янгинаж байснаа гэнэт мэнэрээд явчихав. Тэгтэл хамаг бие нь сулраад агаарт хөвөөд ч байгаа юм шиг болоход диваажин руу явж байна уу даа гэсэн хачин элий балай бодол төржээ. Хайртай охиноосоо салж ертөнцөд орь ганцаар үлдсэн сайхь эр хэмжээлшгүй уй гашуудлын далайд умбан ухаан нь балартчихаад ингэж яваагаа хэргэм зэрэг, язгуур угсаагаар бүхнийг дэнсэлдэг энэ бурангуй хорвоогийн гамшиг гэдгийг сэхээрээгүй нь харамсалтай.

Намсрайн унасан цавьдар морин Цэгээн нуурыг чиглэн салхин мэт хурдална. Гэтэл өөрөө хаа хүрч, яах гэж яваагаа ч үл мэдэн морио л ороолгоно. Түүний хоёр нүд урдах замаа гөлрөвч хором өнгөрөх бүр ойртсоор байгаа гүн цэнхэр нуурыг оноож харахгүй байв. Цавьдар морь эзэн хүний алгасалгүй буулгах ташуурын эрхэнд хүчээ шавхан давхисаар нуурын эрэгт тулмагцаа адгуусныхаа зөнгөөр аюулыг мэдрэн урд хоёр хөлөө усны зах руу гадас мэт шаан зогтусахад Намсрай эмээл дээрээсээ хийсэн усан дотор цүлхийж ойчив. Эзнээ их ус цацруулан унахад морь үргэн гэдрэг ухасхийв. Намсрай гэнэт ухаан сэргэн хахаж цацан гараа сарвалзуулж зүтгэсэн авч нэгэн удаа толгой нь усны мандалд шовсхийн гарч ирээд буцаж живэхдээ “Намайг бас...” гэсэн саармаг бодол зурьхийгээд өнгөрчээ.

Нуурын энэхэн буланд үүссэн олон цагариг нэг нэгээ хөөцөлдөх мэт тэлэн жирвэлзсээр замхран алга боллоо. Юу ч болоогүй юм шиг мэлтийн ногоорох нуурын мандалд Намсрайн жинсийг нь хага цохисон шовгор малгай эзнээ үгүйлэх мэт нэгэн газраа үл мэдэг далбилзан хөдөлсөөр байв. Энэ хорвоод хичнээн хүн хэргэм зэрэг горилон аалзны шүлс мэт үл үзэгдэм ийм торонд ээрэгдсээр энэ хорвоог орхисон бол!

Хорин хоёрдугаар бүлэг

Агуйн мухарт

Үүлэн гарваас хур буумой

Үзэн ядахаас тэмцэл эхэлмүү

Бадамлан асаж байгаа лааны гэрэлд агуйн дотор тал бүдэг бадаг харлан үзэгдэнэ. Саяхан түлсэн галын утаа үнэртэж, унтарч байгаа цог үл мэдэгхэн улайна. Юмжирдулам шанаа тулж, лааны дөл ширтэн цомойн суужээ. Энд тэнд шар шур, шип шипхийх чимээ гарахад хүүхэн давхийн цочиж ийш тийш сэртэсхийн харж, айсандаа бие нь ширвээтнэ. Агуйн мухар пад харанхуйлах нь нэг л айдас хүрмээр. Юмжирдулам тэргүүн туслагчийн гараас мултарч сэтгэлийн гүнд наран ургасан авч агуйдаа дасахгүй, Базарын эзгүйд шөнө унтах нь байтугай гэрэл гэгээгүй байж ч үл чадна. Агуйг мэдэх өшөөтөн үгүй, түүний амыг Базар том чулуугаар дараад явдаг боловч хүүхэн өдөр ч гэмээ нь тайван сууж чадахгүй, үргэлжид элдвийг бодон уймарч аюулын дунд яваа хайрт хүнийхээ хойноос сэтгэл зовнино.

Юмжирдуламыг туслагчийнхаас оргож гараад баяр хөөр болж байтал эцэг нь усанд үйж хилэнцэт хорвоог орхисноос дахин уй гашууд дарагдаж хэдэн өдөр толгой өөд таталгүй уйлж хайлаад тун ч гутруу байж билээ. Базар эцгийнх нь насан эцэслэснийг хэлж чадахгүй зүрхшээсээр хоёр гурав ч хонож, сүүлдээ аргагүйн эрхэнд дуулгажээ.

- Амьд мэнд байгааг минь тэр дор нь аавд дуулгасансан бол хаанаас ийм юм болох вэ гэж Юмжирдуламыг гомдоллон уйлахад Базарт хэлэх үг олдсонгүй. Хэрэв Юмжирдуламын “шулам” болсныг Намсрай мэдвэл туслагчид хэлж эцэс төгсгөлгүй эрэл болно гэж Базар хаширлаад алгуурлан явтал санаанд оромгүй хагацалтай учирчээ. Базар өөрийнхөө л гэнэн гоомойгоос болоод Намсрайн амийг бүрэлгэчихлээ гэж бодох тусам сэтгэл нь улам ч зовж, тийнхүү гэнэдсэнээ гэмшивч баршгүй байлаа. Гэнэдсэн учраа хэлбэл хайрт хүүхэн нь

- Нээрээ ч чиний тэр болгоомжилдог зөв. Тиймгүйсэн бол тэд намайг эрж олох гээд сүйд болох байсан байх гэж хэлсэнд залуугийн сэтгэл тэнийсхийж билээ. Юмжирдулам эцгийнхээ хийсэн хамаг гэмийг аль хэдийн умартаж “Аав минь юутай гэнэн бэ! Намайг шулам болж гэлээ гэхэд сэтгэл хатуужин амьд явахаа бодох нь яав даа. Аав минь одоо байгаасан бол би урьдын адил юутай сайхан жаргаж байх билээ” гэж бодон сэтгэл гутруу байдаг ажээ. Хүүхэн өөрийн азгүй хувь заяаг эцгийн мунхаг сэтгэлээс боллоо гэж бодохоос биш, Намсрайг хөтлөн аваачиж хөлгүй усанд үйсэн хорвоогийн үр урхаг гэдгийг үл мэднэ.

Базараас өөр учран ярилцах хүн нэг ч үгүй, өдөр шөнийн ихэнхийг агуйн мухарт ганцаар гиюүрэн өнгөрөөх нь хүүхэнд тэсэшгүй уйтгартай санагдаж амьтныг мөрөөднө. Тэгэвч амгалан нуурандаа хөвсөн ангирын зулзага адил эрх дураар явах аргагүйгээ ухааран дэмий л бухимдана. Юмжирдулам ингэж суухдаа зовлонгийн хүндийг үүрсэн ч зориг самбаатай байдаг шивэгчин Пагмыг санагалзана. Түүнтэй хоёул байвал юунаас ч айж эмээхгүй, уйдаж шаналахгүй баймаар санагдана. Гагцхүү өдрийн цагаар агуйгаас гарч ойр зуур ой шугуйгаар хэсэж шувуудын жиргэх, горхины хоржигнохыг чагнан аглаг дайдын ан амьтдын гүйлдэхийг харан сэтгэлээ зугаацуулдаг ажээ.

Базарыгаа л цаг ямагт агуйдаа байж байвал санаа зовох юмгүй баймаар санагдах учир нэг удаа

- Базар минь! Идэж уух маань л болж байвал олз хайж өдөр шөнөгүй хэсэж яваад яах вэ. Тэгж яваад хорон санаатны гарт орвол яана. Агуйдаа л байж байгаач гэж гуйхад

- Олзонд шунасандаа биш. Ноёд түшмэд биднийг ингэж зовоож байхад бид яаж тэвчин суух вэ. Чадах ядахынхаа хэрээр л хариугаа авах гэж оролдож байгаа минь энэ шүү дээ гэж Базар учирлажээ.

- Тийм бол тэр ноёд түшмэдээ л чадаж байхгүй, хаа хамаагүй аянчин жинчин иргэдийг тонож адуу малыа нь хөөж авчрахын хэрэг юу байна? гэж Юмжирдулам асуув.

- Юмжир минь! Чи даанч гэнэн байна. Аль ч газрын ноёд, баяйа амин судасны сүлбээтэй, нэг нэгийгээ өмгөөлж хамгаалдаг юм байна. Пүүсний данжаад нар чинь бас л тэдэнтэй ах дүү шиг ойр дотно юм. Тэгэхээр алиных нь ч юмыг авсан адилхан Би ямар ч гэсэн өөрийнхөө санасныг л хийж байгаад дуусах хүн гэж Базар эрс шийдмэг хэлсэнд хүүхэн түүнийг хоргоосон ч үгүй.

Ямар нэгэн амьтны муухай дуугарах сонсогдоход Юмжирдулам агуйн үүд рүү хяламхийн харснаа лаагаа үлээв. Харанхуй болоход бүр ч аймаар. Агуйнх нь ойролцоо ямар нэг амьтан үргүлдүүд байх шиг санагджээ. “Ийм юманд сууж байж юунаас ч айх юм билээ. Өдөр хүн олохгүй агуйд шөнө хэн ирэв гэж. Ойр амьтан яваа бол амыа нь тагласан агуйг яах ч үгүй. Би ер нь өөрөө л өөрийгөө айлгаад байх шиг байна. Унтаж байвал болоо биш үү” гэж хүүхэн сэтгэлээ чангалаад лаагаа дахин асааж нүдээ анин хажуулсан боловч нойр нь хүрсэнгүй.

Тэгээд Юмжирдулам чинээлэг биелэгжүү айлын охин болж танхил дураараа өсөөд жаргалыг хүсэн тэмүүлэх залуу насны зах сэжүүрээс дөнгөж шүүрч хорвоод хүний сэтгэл гутаах муу муухай юм байдгийг огтхон ч гадарлалгүй инээж наадаж явгал хувь тавилан нь гэнэт урваж хориод насандаа үзээгүй их зовлонг хоёр гуравхан сар үзсэнээ эргэи санаж, чухам юунаас болсны учрыг олох гэж ядан хэвтэнэ. Базарын тийнхүү бүх ноёд түшмэд, данжаад, худалдаачин нарт өширхөх нь түүнд хачин санагдана. Түүний бодлоор бол дархан Сүхийг зодож, өөрийг нь хатан болгох гэсэн тэргүүн туслагч л гэмтэй мэт.

Их зургаан ханатад эзэн болж эцэгтээ тунирхан эгээ л хүүхэд мэт эрх дураараа аашлан байсан цэнгэлтэй сайхан үеэ дурсан одоо хөх чоно мэт хүнээс буруулан хөндий хоосон агуйн мухар сахин айж зовон хэвтэж байгаагаа санахаас нүднийх нь нулимс өөрийн эрхгүй мэлмэрч лааны гэрэлд олон өнгөөр солонгорно. “Ай хөөрхий, миний жаргал тийм богинохон байсан гэж үү? Би яасан хувьгүй хүн бэ? Нэг насаар тэгж явах юм шиг бодож байсан минь юутай гэнэн бэ. “Өглөөний дулааныг дулаанд бүү мод, өсөхийн жаргалыг жаргалд бүү мод” гэдэг ямар их үнэн үг вэ! гэж бодоод гацуунаар шүүрс алдлаа.

Юмжирдуламыг айх, ганихрах хослон ганц хором ч нүд анихгүй сууж байхад Базар агуйгаас өртөө илүү газар Улаагчины голын хөвөөнд их зам отон нэгнийг хүлээнэ. Алсад жингийн хонхны дуу бүдэг бадаг сонсогдоход түүний сэтгэл догдлон нэг босож, нэг сууж байснаа хазаарынхаа сүүж, чөмгийг даавуугаар ороож чимээ гаргахгүй болгов. Хонхны дүн дан

цохилох чимээ тодрон тодорсоор жингийн урт цуваа бараалан дөтөлсөөр дэргэдүүр өнгөрөхийг нь үзвэл гучаад тэмээн ачаа байв. Жин хөтөлсөн хоёр иргэн зэрэгцэн алхай хааяа хонхныхоо дууг лавлан чагнаж явах нь хонхны дуу л тасраагүй бол хөсөг бүрэн гэж найддагийн шинж ажээ. Базар мориндоо мордож сүүлчийн хонхтой думээний бурантгийг тайлан цувааны дэргэдүүр явж сүүлээсээ долоо дахь тэмээний хомноос уяд таван тэмээ ачаа таслан авч өөр замаар орлоо.

Зуны шөнө богино, очих газар хол учир ширүүхэн алхуулж зарим газар бараг зогдор хөдөлгөх шахам явлаа. Жин хөсөг улаан цайм дээрэмдэж базаахгүй юм хийж байгаа мэт санагдавч амь зуух гэсэн хүний аяга хоолыг салгаагүй, ашиг хонжоо харсан харийн наймаачдаас хариугаа авч байна гэж Базар биеэ цагаатгах сацуу “Дотор газрын данжаад нар эрээн мяраан элдэв чамин юмсаар манайхны нүдийг хуурч үнэтэй цэнэтэй юмыг нь сул авдаг. Ганц тэмээ бараагаа арван тэмээ ноос болгоод буцдаг. Бас манай ноёд түшмэдэд аятайхан аргаар нүүр тал олдог. Ингээд түшмэд данжаад хоёрын завсарт хөөрхий ардууд хохирдог” гэж Намбаагийнхаа хэлдгийг эдгэн санаж, арга самбаа л байвал аль болохуйц юм авахыг зөв гэж бодно.

Түүнийг Шар нурууны дунд хүрэхийн алдад тэнгэрийн зүүн хаяа манхайн цайж үүрийн болжмор босон суун жиргэж эхлэв. Тэмээ ч газрын өгсүүрт сульдаж ширэнгүй ойн давчуу зөргийн мод харгиас нь боочихоод ачаатай тэмээ явахын аргагүй боллоо. Базар тэмээнийхээ тэнг мулталж орхиод мориндоо нэг нэгээр нь дүүрч агуйнхаа хаяанд хүргэв. Тэгээд тэмээгээ хол аваачин бөхөлж орхиод агуйдаа очиж үүднийхээ чулууг авлаа.

Хараа суугаа хоносондоо үүрэглэхийн байсан Юмжирдулам агуйн замаар гэрэл мэлсхийн тусахад цочиж сэрээд лаагаа унтрааж амин зүрхний хайрт эрээ харж, сэтгэл сэргэн ишилзэн инээмсэглэсээр тосон очлоо. Хүүхний нойр алдсанаас улайсан нүдийг Базар ажаад,

- Бас л нойргүй хоноо юу? гэхэд,

- Чамайг байхгүйд ерөөсөө айгаад болохгүй юм гэж Юмжирдулам тунирхангуй дуугарав.

- Эзгүй буйд газар ийм юманд орогнож үзсэн биш, хирээ хир. Гайгүй ээ, яваандаа дасна...

- Өөрийн эрхээрээ байх нь сайхан юм.

- Үс гэзгээ түргэн янзалж үз! Нарнаар Намбаа гуай ирнэ гэсэн. Цайгаа шалавхан чанаарай гээд Базар хүүхний толгойг тэврэн хэдэнтээ илбэж үнэртээд авчирсан юмаа оруулахаар гарлаа.

Улаан наран уулсын сэрвэнд тусахуйяа аглаг ойн дээгүүр цэнхэр манан дэгдэж, буйд ширэнгийн эзэн болсон түмэн өнгийн шувуухай дорь дуугаа авалцах мэт жиргэлдэнэ. Юмжирдуламыг гоёж гоодоод агуйгаас гарах үед нарны алтан саан цацрал моддын завсраар ташуу тусаж гүн ногоон ой үлэмжийн сонин өнгөөр туяарав. Хул морьтой гандмал хүрэн царайтай эр агуйд ирдэг нууц зөргөөр хүрч ирүүтээ цэнхэр торгон дээлтэй цэврүү шиг сайхан бүсгүй зогсож байхыг хараад мориныхоо амыг татаж “Үгүй энэ чинь юу вэ? Энэ Базар чинь газар дэлхийн савдагтайгаа нөхөцнө гэдэг нь болсон юм биш байгаа даа” гэж гайхашран

бодлоо. Базар түүнийг угтан очиж мэндлээд морийа нь авлаа. Намбаа агуйн үүдэнд ирэхдээ л өвгөн дархныд үзсэн бүсгүй мөнийг сая таньжээ. Тэгээд агуйд орж суухад бүсгүй цай идээ барилаа. Намбаа “Энэ ч овоо зайтай сав юм. Авсаар хүн олохооргүй газар юмсанж. Хангай дэлхий дайжиж боссон амьтныг халхлах энэ мэт оромжоор элбэг юм даа. Ганцхан бид л үүнийа нь тэр бүр олж үздэггүй бололтой” гэж бодон агуйн доторхийг ажин суутал Базар орж ирэв.

- Би чинь энэ охиныг харуутаа нутаг усных нү савдаг биш байгаа даа гэж тэнэг юм шиг мангуурч орхисныг яана! гээд хүд хүд инээв.

- Би таныг нэгэнт ирэх болохоор нарийн учраа яриагүй юм л даа гээд Базар хонины мах эвдэж тогоонд үйгээд лүүтэй архи ханзалж,

- Бид хоёрыг чинь одоо айл гэж болно биз дээ. Тэгэхээр энэ айлын эхний гийчин та боллоо. Бас бид хоёрт их тус болсон нэг залуу эр ирнэ. Өөр зочин гийчин одоо ч, хойшдоо ч ирэхгүй биз. Хэдүүлээ айл гэр болсноо ёсолж өнөөдөр аятайхан наргичихья гэхэд,

- Чи ч шинэ айл болоод одтой байгаа юм байна... Олз омгоор ч их шив гэж Намбаа яриад тэнгийн баглаа руу толгой дохилоо,

- Савдагтаа нэг мөргөж азынхаа тэнгэрийг даатгачихаад явдаг юмаа гэж Базарыг тоглон өгүүлэхэд тэр гурав инээлдэв.

- Урьд шөнө пүүсний жингээс таван тэмээ ачаа авсан чинь нэг нь дан нанжин чавга, бусад нь торго дурдан таарчихсан байх юм гээд Базар баглаатай бараага задалж хэдүүл үзэцгээх зуур Юмжирдуламыг оргуулсан тухайгаа ярив.

- Шулам гэдгээ улам лавтай болгохоор эртүүд тахар Пэрэнлэйнхнийг оройтож нүүхээр нь даваан дээр тосож сайхан дамшигласан даа гээд агуйн мухраас чоно, үнэгний арьсан баг гаргаж Намбаад сонирхуулав. Намбаа толгой сэгсрэн гайхан шогширч,

- Чи ч мөн сэргэлэн эр юмаа. Дээдэс хар авахааргүй иём нарийн арга яаж хүний ой тойнд орно вэ! гэж өгүүлэхэд нь,

- Миний ухаансах юу байх вэ. Эцгийн минь л ухаан шүү дээ. Ер нь тэгээд мөрөөрөө номхон байсан хүнийг ноолж зовоогоод байхаар санаанд оромгүй арга сүйхээлж амиа бөөцийлдэг юм байна шүү дээ. Чин үнэнээ хэлэхэд аавынхаа л арга ухаанаар Юмжирдуламыгаа туслагчийн гараас салгалаа шүү дээ гэж Базарыг ярихад,

- Ноёд түшмэдтэй хонь чоно болоод ирэхийн цагт тэднийг давах арĀа ухаан олохоос л аргагүй болдог нь ч үнэн шүү гэж Намбаа хэллээ. Тэр гурвыг ярилцан бүсгүйг үе үе цовоо цолгим инээж хөхрөн байтал Орших хүрч ирэв. Тэр залуу хоосон хөндий агуй гэнэт нарийн тажаг эд агуурсаар дүүрчихсэнийг үзээд нүдээ бүлтэртэл ширтэн харна.

- Орших оо, сууж цай уугаач! гэж Юмжирдуламыг хэлэхэд залуу сая мэнд усаа мэдэлцэн суув.

- Энэ залуу туслагчийн зарц бүсгүйтэй сайн байдаг юм. Тэр бүсгүй энэ хоёргүй бол ч Юмжирдуламыг тэндээс оргуулна гэдэг тийм амар биш.. Оршихынхоо ачийг заавал хариулнаа гэж яриад Базар
- Хэзээ нэг цагт туслагчийнхаас гэрлүүлбэл болно биз дээ гэж тоглоом хийсэнд Оршихын шар царай ув улаан болчихов.
- Цаагуур чинь сонин юу байна даа гэж Базар залуугаас асуув.
- Та хоёрын тухай бөөн яриа
- Одоо намжаагүй л байна уу?
- Үгүй чиш. Харин ч хуй салхи шиг улам эрчээ авч байх шиг.
- Тийм бол тун сайн. “Даарин дээр нь давс үрнэ” гэгчээр чи ташуурдаад л байгаарай!
- Би чиний ярьсныг ч хачирлаж байгаад л уулзсан амьтанд яриад л байгаа шүү гэж Оршихыг хэлэхэд Юмжирдулам
- Орон нутгийн ах дүүс чөтгөр шуламтай боллоо гээд идээшиж дассан зуслангаасаа дайжиж нүүгээд байдаг ч тусгүй байна санж гэв.
- Одоохондоо тэгэхээс аргагүй. Тэгэхгүй бол бид сэжиглэгдэнэ. Тэртээ тэргүй намайг барих гэж отуул туршуул тавьж байгаа нь магад гээд Базар нэг хуй элгэн торго авч
- Май, Орших оо! Сайхан дээл хийж өмс! Илүүгий нь арилж гээд барихад
- Үгүй, үгүй, Базар минь! Торго өмссөнөөсөө долоон дор юм болно. Торго өмсөх нь байтугай бор гэдсээ тэжээж чадахгүй шахам байгаа намайг торго авсан гэж хулгайн хэрэгт барьж авна гээд Орших халгаасангүй. Тэгэвч хуй торго шингэүж чадахгүй байгаа эр маань “Сайн эр болчихвол амархан баяжих юм байна даа. Базар шиг ингэж явбал газар хагартал баяжих амархан байх шүү. Ганц шөнө ингэж байгаа юм чинь юухан байх вэ. Намайг дагуулж яваач гэж дараа нэг гуйя байз” гэж бодлоо.
- Оршихын хэлдэг үнэн шүү. Харин нанжин чавганаас ээжид нь нилээдийг өгчилгө! гэж Юмжирдулам хэлэв.
- Өвөл болтол шулам хэвээрээ байя. Гэхдээ нутгийн савдаг гэж яриад байгаагийн нь бас жаахан дэвэргэж байгаад аажимдаа туслагчийн хатан шулам биш, манай эндхийн савдаг байсан болгоод хувиргая. Нутгийн маань савдаг ядуу зүдүү хүмүүст удахгүй хишиг хүртээнэ гэж Галуутайн хүрээний мэргэн лам айлдсан гэнэ гээд цуурхуулья. Зул сарын хорин тавны шөнө Оршихынхоос эхлээд хэдэн ядуу айлын босгон дээр торго тавьж гэрийнх нь бүснээс цоо шинэ ногттой адуу уялна. Тэгэхээр л хүмүүс нутгийн савдгийн хишиг гээд сүйд болцгооно. Намайг ч савдагтай нийлсэн азтай хүн гэх биз гэж Базарыг өгүүлэхэд Намбаа
- Ганц зөв санаа. Олсноо олонтойгоо хуваах шиг сайхан юм үгүй гэж ихэд таашаан хэлэв.

- Эртүүдийн таны хөөж авчирсан адууг эндээ ядууст өгөх гэсэн чинь гар хоосон амьтас мэдэгдэж ялā уначих гээд болдоггүй. Тэгэхээр нь Далай Чойнход вангийн хүрээ оруулж авдранд хийх юмаар арилжаад авчирч өгсөн шүү. Бодвол өдийд гурил будаа болгочихсон байлгүй гэж Базар яриад,

- Таныг буцахад Агваанлуvsан дүвчингийн хэсэг сайхан морьдыг ялгаж туулгана аа гэхэд Орших

- Чи Юмжирдуламтайгаа хоёул боллоо. Одоо тэгэхээр хулгай хийж байхын хэрэг юу байна? Хэрэг нэмэгдэж хойноос чинь нэхэл болохын нэмэр биш үү? гэв.

- Орших минь, тийм биш. Энэ Намбаа гуай, аав, Юмжирдулам би ямар гэм хийсэн юм бэ? Мөрөөрөө л явсан шүү дээ. Биднийг ноёд түшмэд, лам нар л зовоож байна. Эднийгээ мэддэг захирдаг, үнэн мөнийг тунгаан шүүдэг газар байх гэж санаад Улиастайн жасаанд очсон чинь хүний амь хохироосон түшмэлээ ялгүй, амь нэхсэн ардыг ялтай гэж байгааг бод л доо. Тэгэхээр ийм улстай чинь нэгийгээ үзэж нэхий дээлээ уралцана шүү дээ. Чадах бүхнээ л, бодсон санасан бүхнээ л хийж байгаад учраа олно. Эднийг хараад санаа амар сууж яагаад ч тэвчихгүй гэж Базарыг шүд зуун хэлэхэд нүдэнд нь өшөө хорслын гал гялалзаж байлаа.

- Би л энэ толгой мөрөн дээр байгаа цагт ноёд, баядад амар заяа үзүүлэхгүй дэг гэж Намбааг эрсхэн дуугарахад хэнийг ч өмнөө сөгтгөдөг ихэс дээдэстэй үзэлцэнэ гэж аймшиггүй ярьдаг эрчүүд вэ гэж санахаас Оршихын айдас хүрч, биднийг бүсэлчихсэн юм биш байгаа даа гэж гэнэт бодогдон сэтгэл нь түгшээд сууж чадалгүй морь харья гэж шалтагцан гарч чимээ чагнан нэлээд холхиж байгаад орж ирлээ.

Юмжирдулам том хавтгай чулуун дээр мах гаргалаа.

- Умгар хадан агуйгаа улаан халзтай өргөө гэж саная. Ачийā нь мартамгүй итгэлт хоёр андаа гэр дүүрэн гийчин гэж бодъё. Тэгээд дөрвүүлээ гэрийн найр, гэрлэсэн хоёрын хуримаа хийе дээ гэж Базар инээд алдан өгүүлээд эцгийнхээ урласан мөнгөн хундаганд архи бялхуулан дүүргээд Намбаад барилаа. Их нурууны хэн ч үл мэдэх эл агуй амь санаа нэгтэй дотно нөхдийн элэгсэг халуун яриа, инээд наргианаар амьсгалæ, Базар Юмжирдулам хоёр ч гэр дүүрэн гийчин залж, дуу хуур, ёс ёмботой хурим хийж байгаагаас ялгаагүй сэтгэл нэн хөгжүүн байлаа.

Хорин гуравдугаар бүлэг

Эрлэгийн элч

Хоосон чанарын номлолд автвас

Хожмын өдөр аминд халтай

Шар нурууны баруун жигүүрийн ойд Сэр-Од туслагч бараа бологчдынхоо хамт авд гарчээ. Туслагч айх эмээхийн харгайгаар гэрээс гаралгүй сар гаруй болсноор үл барам эцэстээ хар даран зүүдэлж цочин сэрээд шөнө ч унтаж чадахгүй болсон учир хүн явуулж дүвчинг залсан билээ. Агваанлуvsан туслагчийнд очихоосоо эмээж байсан хэдий ч сайн лам гэж итгэл хүлээсэн нэрээ бодохын эрхэнд гэгээн цагаан өдрөөр ирээд оройтолгүй буцахдаа, туслагчийг гэрийн мухар сахисаар хийморь лүндаа чинь доройтож байна гэж айлдаад хийморийн дарцаг шинээр үйлдэн сан тавьж буугий нь ариулаад ан авд мордож уул хадаар явбал засал олно гэсэн ажээ. Тэгээд туслагч, дүвчингийн товлож өгсөн эл өдөр ийнхүү алслан гарчээ. Өдрийн хагас морьтой, явган хэсүүчлээд амьтны хамраас цус гаргаагүйдээ урамгүй байсан ч хөвч ойн байгалийн үзэсгэлэнг урьд үзээгүй юм шиг шохоорхсоор элдвийн муу бодол шүглэж гүйцсэн сэтгэл нь овоо сэргэв.

Үдийн алдад бороо шаагихад ядарсан туслагч ойн цоорхойд шаасан майханд тавлан зоог бариад бороо өнгөртөл амрахаар хажуулав. Тэгтэл хань болж чадалгүй алдсан залуу хүүхний тухай бодол зурсхийн орж ирэхэд туслагч санаа алдлаа. Залуу зандан бүсгүйг шулам болгосондоо бус, харин тийм царайлаг хатантай болж чадаагүйдээ харуусжээ. Утсан чинээ улаан голоосоо ч илүү хайртай гэж бодож явсан ганц охиныхоо хувь заяагаар тоглосондоо ухаан балмагдан уймарч яваад тоост хорвоогоос хагацсан Намсрайн тухай бодох зай туслагчийн сэтгэлд нэгэнт үгүй болсон нь бодгаль хүний зовлонгоор жаргал хийж амташсаных буюу.

“Өнгөрсөн юмыг өлөг болтол бодвол сэтгэлийн хэг өвчтэй болно шүү гэж дүвчингийн айлддаг үнэн болж таарна. Намайг тэгээд байгааг ламтан андахгүй байна. “лзийтэй сайн юм бодож бай! гэж дүвчин хэлсэн шүү. Ер нь ч сэтгэлээ тэвчье байз. Өвчтэй болчихвол туслагч байдаг минь өнгөрнө гэсэн үг... Ганцын хойноос гасалж гангинаад ч яах вэ. Хошууны залуу сайхан бүсгүйчүүд мундах биш. Дүвчингийн айлдсанаар найр наадам хийж сэтгэл санаагаа засья. Тэгээд намар тийшээ Бээжин юм уу, Утай явдаг хэрэг. Цэцэн Сарт ”Уулын хошууг эзэгнэж байгаа болохоор надаас сохор зоосны гарз гарах юм биш... Түрүүчийн будлианыг жаахан мартагнуулж байгаад ирэх жил хатан таалахаа бодно байгаа. Харин хэнийхээс... Үгнээс гардаггүй үнэнчээр нь Пэрэнлэйгээ хошууныхаа сум отгоор явуулъя. Хошуу туслагчийн хатан чинь хошуоны сор нь л байх учиртай даа” гэж Сэр-Од бодон, таатайхан бодолдоо сэтгэл ханан зүүрмэглэж байснаа,

- Туслагчтан! Бороо арилчихлаа! гэх дуунаар цочин өндийлөө.

- Туслагчтан! Бороо арилж нар гараад мөн ч сайхан байна даа. Одоо л гөрөөс ёдүүшлүнэ дээ гэж тахар Пэрэнлэй майхны үүдээр шагайн, хоёр гараа элгэндээ аван нахилзан хэллээ. Туслагч босож малгайгаа өмсөөд гадаалахад ой нэлэнхүйдээ сэргэн өнгөжиж улам ч сэтгэл

булаам харагдана. Усан дусал бөнжигнөсөн цэцэг навчис нарнаа гялалзаж үнэгэн шогшоо салхинаа үл мэдэгхэн дохилзох нь баясан бүжихийг завдан буй мэт. Сэр-Од борооны дараахь гойд сайхан үнэртэй агаарыг ховдоглон амьсгалж “Ай хөөрхий, бурхан тэнгэр намайг харж л байна даа. Шулмын хорлолоос шингэсэн бузар байдаг юм бол ариусаж арилахаар л сайхан байна” гэж сэтгэл тэнийн бодоод,

- За түргэхэн хөдөлцгөөе! гэв. Тэд үдээс өмнө явснаасаа өөр тийш зүглэв. Ой самнан нилээд явсан боловч хоёрхон гөрөөсний бараа харлаа. Ан элбэгтэй газар атал нэг л тааралдах шинжгүй байхаар нь энэ саагалдсан олон хүний чимээнээс дайжаад байна гэж санасан Сэр-Од ийм сайхан цагаар буугаа мялаалгүй буцвал азанд муу болно гэж боджээ. Тэгээд энд дориун нэг хүнээрээ гөрөөсний гүйдэл, хэвтэгшгүй газар заалгаад тэднийгээ тээршаан орхиж ганцаар салж явлаа. Ямар ч гэсэн хоосон буцахгүй гэж бодон модны зай чөлөөгөөр гэлдрүүлэн ийш тийш сүрхий ажиж явав. Нарийхан шилбэтэй өндөр хүрэн морь унаж, хар ногоон дээл өмссөн Базар, түүнийг өглөөнөөс хойш алсуур харуулдан, олуулаа яваа болохоор нь яаж ч чадахгүй байснаа нөгөөдүүлээсээ салмагц нь араас нь сэм дагасаар явахад туслагч өчүүхэн ч сэжиг авсангүй. Анд Сэр-Одын ийнхүү явахаар товлосныг Орших, Пагмаас сонсоод Базарò ирж хэлсэн байжээ. Туслагч нар баруунаа таштал нилээд газар тэнэлээ. Нэг халзан хамар өөд өнгийтөл гурван гөрөөс идшилж байснаа түүнийг харчихаад мод руу давхилдан орчихов.

- Ээ харла, хайран хишиг гээд туслагч амаа барин шогшров.

“Ер нь ямар хүн, унаатай сэндийж явж ан хийж байлаа даа. Морины хөлийн чимээ дуулдаггүй хээрийн соргог ан гэж хаа байх вэ. Энэ чинь уг нь тун гоочтой газар байна” гэж туслагч бодоод морио модноос уяад ой руу орлоо. “Ай даа, мөн сайхан байна! Ийм газар явахад эр хүний хийморь сэргэлгүй ч яах вэ” гэж туслагч баясан сэв сэв алхаж явтал нь ойн чөлөөнд цааш харан идшилж байгаа бор гөрөөсний цагаан өгзөг модны завсраар гялалзан харагдахад “За тэр шүү” гээд зогтусав. Нүд нь илт сэргэж, нүүрэнд нь баярын совин татаад ирлээ. Туслагч түр азнан газрын байдлыг ажаад алсуур тойрч салхиных нь доод талд гараад мод таширлаж нарийн өвс нахийлгалгүй, бүдүүн өвс бөхийлгөлгүй гөрөөс рүүгээ гэтлээ. “Ямар барьж авах гэж байгаа биш дээ. Дэндүү шунаж байж үргээчихвэл гарзтай юм болно. Эндээсээ л...” гэж хаширлаад мөлхөхөө больж, буугаа шийрлэн овоо хараагий нь онилон шагайв. Бүдүүн гурын хүрэн бор нүд бүлтэлзээд, ногоо таслах нь хүртэл сонсодно. “Ямар сайхан амьтан бэ! Тархинд нь... Ээ. Больё. Би энэ жил аз муутай яваа хүн шүү. Алдчихвал түвэг. Баараггүйгээр нь дал хавсарья” гээд овоогоо далан дээр нь тааруулаад амьсгалаа хураав. Буун дуу тасхийв. Туслагчийн чих дөжрөн уул хад нүргэлэн цуурайтлаа. Бууны ам хавьцаа хөх суунаг татаад дарь хүхрийн үнэр ханхийлээ.

Гур нэг ухасхийснээ тонгорцоглон үсрэв. Туслагч буугаа барин баярланихсан харайж хүрлээ. Ганцхан хормын өмнө хоол хөөцөлдөн явсан хөвчийн сайхан амьтны нүд нь цэхийгээд амь тавьж байлаа. Туслагч “Азтай л байна. Юу ч гэсэн хангай дэлхий надаас хишгээ харамласангүй. Хойшид үйлс минь бүтэх цагаан зам, буяны минь шам нээгдэв бололтой. Хатан таалсан ч харшлахын шалтгаангүй болох байгаа. Дүвчин ламтан ч аргагүй л сайн засал хийж дээ” гэж бодон баясаж бууныхаа амыг гурын цээжнээс урссан хөөсөрхөг ягаан цусанд хүргэн мялаагаад газар тавьж, сөхрөн сууж хоёр гараа хавсран

- Баян хангай минь өршөөж өлзий хишгээ хайрлаж байгаарай! гэж үглэн үглэн залбирлаа. Буун дуу ер сонсдоогүй болохоор бусдыгаа хоосон явна гэж туслагч санажээ. Гэтэл бараа бологчид нь гөрөөс үзлээ ч гэсэн туслагчийгаа нэг юм анаж явахад нь саад болохгүйг бодоод буудаж зүрхэлсэнгүй. Хэрэв туслагч олзгүй болох болбол тийм шалтгаанаар өөрсдийг нь залхаана гэдгийг цөм мэдэж байжээ.

- За байц, үүнийг яаж шүү аваачдаг юм билээ. Дагуулуудаа дууддаг юм уу?.. Тэд маань даанч хол хоцорч дээ. Аягүй бол эргээд олохгүй болчиж мэднэ. Ан хийх гэж номхон унаатай гарсны хэрэг юу билээ, өөрөө ганзагалаад очвол бас сүртэй ч хийморьтой ч байхсан гэж ганцаараа ярьснаа алсан гураа урд хөлнөөс нь барьж өвсөн дээгүүр чирлээ. Энэ бүхнийг ажин зогссон Базар модонд уяатай мориных нь наахна очоод хүлээв. Аягатай хоолоо барьж зооглохоос өөр юухан ч хийдэггүй туслагч саахалт хэртэй газар гур чирэх гэж үйлээ үзэж яваа бололтой. Цээж нь дэлбэрэх гэж байгаа юм шиг амьсгаадан шанаа хацрыг нь даган хөлс урсана. Гураа ойр ойрхон тавьж сарвуугаа атгаж тэнийлгэхийг нь бодвол хоёр гар нь чилж гүйцсэн бололтой. “Ийм байж морио аваачаад ганзагалах ухаан төрдөггүй байна шүү” гэж Базар унтууцав. Түүний жаахан амсхийгээд гураа чирсээр хажуугаар нь өнгөрөхөд Базар бүсгүй хүний хяхтнасан нарийхан дуугаар инээв. Туслагч гураа тавин юу болов гэсэн янзтай ийш тийш харахад нь Базар

- Хэ хэ хэ! Чи энд яваа бий! Одоохон чамайг! гэж бас л өнөөх хачин дуугаараа орилов. “Өнөөх чинь” гэсэн бодол түүний тархинд харваж толгойных нь хуйх хуураад явчих шиг болжээ. Айсан туслагч Базарыг мордох хооронд хэдхэн харайгаад мориндоо хүр÷ мордуугаа цулбуураа модноос тайлаад “Таминь ээ, үхлээ!” гэж нэг муухай орилчихоод газрын уруу ухасхийв. Базар ч дамшиглах гэж байж гай болов уу гэж бодон бугуйлаа яаран авч араас нь хөөв. Морьдын туурай тачигнаж унанги мөчир гишүү тас нясхийнэ. Тэр хоёрыг модон дундуур сүлжилдэн хөөцөлдөхөд Сэр-Од эмээлээсээ салчихгүйг хичээн жолоогоо мориныхоо шанхтай давхад атган тас зуураад “Ямар гай нь намайг нааш нь чангаав аа? Дагуулынхаа нэгийг нь ч болтугай авч байдаг байж. Одоо яана?” гэж бүүр түүрхэн бодож морио сэлгэлгүй ороолгоно. Ард нь пижигнэсэн их чимээ гарч нэг юм уухилж аахилан улам ойртоод байх шиг санагдахад туслагч хашгирах гэж амаа ангайсан боловч айсандаа болоод дуу нь ч гарсангүй. Базар түүний араас гэзэг даран яваа ч модон дунд бугуйл шидэж болохгүй аргаа барж явлаа. Тэгтэл ч модноос мултран нилээд өргөн чөлөө рүү орлоо. Туслагчийн толгой дээгүүр нэг юм исгэрэн бүсэлхийгээр нь шавхуурдаад авах шиг болтол мориноосоо ховх татагдан чанх ар тийшээ дагзаараа шааж унаад ухаан алджээ. Тэр үес туслагчийн бараа бологсод буун дуу гарсан чигийг баримжаалан дөхөх гэсэн боловч бас л туслагчаа хилэгнүүлэхээс айгаад түдгэлзэн байлаа. Гэсэн ч дахин буун дуу гарсангүй, туслагч нь ирсэнгүй учир тэд яаран туслагчийнхаа хойноос явцгаалаа. Хичнүүн эрж, дуу чимээ хичнээн өгөвч цуурайнаас өөр хариу үл сонсодно. Нар шингэхийн өмнөхөн жолоондоо хөлөө хийчихээд холдож завдаагүй байсан морийг нь оллоо.

- Туслагчийг ангаа ганзагалж явтал морь нь булгиж явгарсан байх.

- Тийм бол ганзагандаа чиргүүлж явах юм уу, үгүй бол ганзага нь тасарсан байх ёстой. Хэрвээ гөрөөс ганзагалсан бол цус, үс нь ч үзэгдмээр юм.

- Тэгвэл ганзагалах гэж байхад нь морь нь үргэж цулбуураа шувт татуулсан байх.

- Хашид хүн чинь чөдөрлөж байгаад ганзагалахаа мэддэг л баймаар даа
- Буудахад нь зулраа биз дээ.
- Ха ха ха. Морио барьж байж буудахдаа яах вэ дээ.
- Тэгээд яасан байх вэ?
- Яах юу байх вэ, уяд орхичихсон нь л алдуураа биз.
- Маргаад байх юу байх вэ. Туслагчтан ямар ч гэсэн явгарсан л байна.
- Явган хүн чинь биднээс салсан газар руугаа дөхөхийг боддог байгаа даа.
- Майхнаа ч баримжаалмаар юмаа.
- Тэгвэл туслагчтан үзэх бараагүй, сонсох дуугүй хаачаа вэ?
- Та минь ээ, мориноосоо ойчоод гэмтчихсэн юм биш биз? Үэж ам амандаа баахан шуугив.
- За за, битгий дур дураараа мэргэ төлөг тавиад бай гэж Пэрэнлэйг зандрахад тэд дуугуй болцгоов.
- Харанхуй болохоос өмнө сайн эрцгээе! Тэгээд олдохгүй бол нэг нь майхан дээрээ, бусад нь ойгоор хэсүүчлэн шөнөжин түүдэг асааж чимээ дохио өгнө шүү гэж Пэрэнлэйг хэлэхэд тэд түүний үгийг даган тал тал тийшээ эрэлд гарцгаалаа.

Сэр-Од туслагч ухаангүй хэвтэж арайхийн сэргэтэл хамаг бие нь янгинаж, хөдлөх гэтэл нь хүлэгтэй байлаа. Мориноосоо салсныг санахаас биш хэн, хэзээ хүлснийг ч мэдсэнгүй. Нүдээ нээж хаана ирснээ мэдэх гэж ажвал тэнд гэж төсөөлөхийн аргагүй, өдөр шөнө нь ч мэдэгдэхгүй нэг л нүхэрхүү харанхуй юм байсанд тун ч их гайхжээ. Галын дөл сүүмэлзэж байгаа мухар руу ахиулан харвал нэг сүүдийсэн хар юм сууж байв. Туслагчийн хөдлөхийг мэдсэн бололтой тэр хар юм өөр рүү иү эргэж харлаа. Сэгсийсэн үс толгойтой хүн төрхтэй юм байхыг туслагч үзмэгцээ айсандаа дахин ухаан нь балартаж “Би чинь шулмын гарт орчихсон юм биш үү! Одоо ч хаашдаа өнгөрчээ” гэж бүүр түүрхэн бодоод харахаас ч зүрхшээн нүдээ анилаа. Нөгөөх нь босож дэргэд нь ирэх чимээ гарснаа,

- Чи намайг таньж байна уу? гэж хүний хэлээр асуув. Дуу нь танимаар ч юм шиг санагдсанд туслагч нүдээ дутуу нээн аньсганыхаа завсраар ажвал, нүүрээ бүрхсэн үстэй, бүсэлхийгээ өнгөрсөн том хар дэлэнтэй, ёрдойсон урт хошуутай амьтан зогсож байсанд тэнхээгээрээ бахираад хөрвөлөө. “Шулам” түүнийг дээш нь харуулаад,
- Би чиний шулам болсон хатан чинь байна. Одоо хоёулаа сууна даа. Чи надтай суух гэдэг хэвээрээ биш дээ? Үэж тачигнатал инээгээд тонгойход үс нь туслагчийн нүүрэнд хүрсэнд бас л муухай орилоод доош харлаа. “Зэс хошуу... Хорлох гэсэн хүнээ түүгээрээ хатгаж алдаг юм гэсэн. Би ямар үйлийн үрээр шуламтай нөхцөв өө? Миний хань болох заяа сүүдэр нь таарсан бүсгүй гээд л дүвчингийн айлдаад байсан чинь эцэст хар толгой залгих аюул нүүрлэлээ.

Өнөөдөр ч намайг авд мордвол хийморь сэргэнэ гэсэн чинь яалаа? Дүвчингийн айлдсан бүхэн ингэж урвуугаар эргэхийн учир юу вэ? Ийм юу ч мэддэггүй ламыг би нэгэн насаар шүтэж байсан гэж үү?.. Хошууны тэргүүн туслагч байтал сайхан хатантай ханилах заяа золгүй явсан минь эцэстээ ингэж дуусах зураг тавилантай байснаас л тэгж дээ... Дүүрчээ, дүүрч. Ийм л заяатай төрснөөс цааш хойт төрөлдөө ноён болох болтугай гэж бурханд залбирч байгаад л дуусахаас” гэж туслагч бодон маанийг хэдэн шад шивнэн духаараа газар мөргөн залбирав.

- Чи юу гээд аман дотроо үглээд байгаа юм бэ? Намайг зуурч аваад элдэвлэж зовоодог байсан хүн чинь арайхийж бараа бараагаа харахтай зэрэг юу гэж нүүрээ буруулаад байгаа юм бэ? гээд “Шулам” тас тас хөхөрч түүнийг хүлэгнээс нь угз татан эргүүлж,

- Чамайг би хорлож өөртэйгөө адилхан шулам болгоно. Энэ зэс хошуугаараа ганцхан хатгахад л сүнс чинь зайлаад надтай адилхан шулам болно гээд улайдмал зэс хошуугаа түүний шанаанд хүргэтэл үс нь шажигнан хиншүү ханхалсанд туслагч

- Аа, яадаг билээ! гэж орилон бөмбөрөхдөө “Намайг шулам болгочихвол хурааж хуримтлуулсан хайран сайхан хөрөнгөөр минь ямар амьтас гараа угаах бол?” гэж хармын сэтгэл төрөв.

- Эрлэг хаан чиний нүглийг шүүлгэхээр намайг явуулсан. Ямар ямар нүгэл хийж явснаа тоочиж миний өмнө наманчил!

- Надад хийсэн нүгэл гээд байх юм байхгүй. Бурхан, ном, лам гурван эрдүнэдээ үнэнээр сүсэглэж явна. Өршөөж хайрла!

- Аа чи бас худал хэлэх үү? Чиний нүгэл эрлэг хааны толинд илхэн. Базар гэдэг залууг хилс хэрэгт унагаж эцгийг нь зодож алснаа худал гэх үү? гээд “Шулам” зэс хошууныхаа үзүүрийг хацарт нь хүргэтэл часхийтэл түлэв.

- Миний нүгэл үнээн! гэж туслагч бархираад

- Өчүүхэн намайг өршөөж хайрла! гээд дахин давтан үглэж гарлаа.

- Чи ядарсан эмгэний амин тэжээлийг яах гэж дээрэмдсэн бэ?

- Хүү нь миний юмыг дээрэмдэхээр нь оронд нь...

- Чи нүглээ наманчлахын оронд өөрийгөө өмгөөлөх гэнэ ээ! Чамайг одоохон тоилголоо! гээд “Шулам” туслагчийн хоёр нүдний хооронд хошуугаа чиглүүлэн зугуухан ойртуулав.

- Нүглээ түмэнтээ наманчилъя аа! Амийг минь өршөөгөөч! гээд туслагч нүдээ тас анин орилохдоо “Эрлэг хаан нэгэнт л миний энэ яваа насны нүглийг толүдож байгаагаас хойш би мэлзэхээ больё, тэгвэл амь гарч магадгүй” гэж бодов.

- Чи тэр хөөрхий эмгэний юмыг буцааж өгөх үү?

- Өгье өө, өгье... Хэлсэн бүгдийг чинь ёсоор болгоё. Амийа минь өршөөсний ачийг санаж эцгээс өвлөж үлдсэн алтан шагай, алтан ембүүгээ өргөө гэж туслагч гонгиносонд

- Чи эрлэгийн нүдийг алтаар хуурна гэж санаж байна уу? гээд үсийа нь хуйхлаад орхитол туслагч

- Алт мөнгө гэж дуугарахаа больё оо! Би үхлээ! гэж амь тавин ориллоо.

- Чи үүнээс хойш амьтан зовоохоо болих уу? Эсвэл над шиг “Шулам” болох уу?

- Эрлэгийн элч минь өршөө! Хэлсэн бүгдийа чинь ёсоор болгоё! гэж туслагч голынхоо дууг гарган уйлагнаж, духаа халцартал газар мөргөж, одоо бас ямар нүглийа минь хэлдэг бол гэж айж бэмбэгнэж хэвтгэл нэг хүчтэй гар цээжийа нь өргөн амыа нь бөглөж нүдийа нь боогоод чирч явлаа. Тэгснээ нэг юман дээр бөгтрөн ёвроод орхив. Дөрөөний чимээ гараад хүн морин дээр мордох шиг болж, яваад өгөхөд нь ашгүй амь гарах нь юм болов уу гэх бодол туслагчид төрж “Шулам гэдэг чинь ямар тэнхээтэй юм бэ. Бас морь унадаг байх нь ээ” гэж гайхах аядав. Өгөршсөн мод морины хөлөөр хугарч хааяа мөчир биеийа нь шүргэн өнгөрөхөд модон дундуур явж байгааг туслагч таамаглав. Энд тэндгүй хашгирч гуугалах чимээ сонсодно. Энэ чимээг туслагчийн бөглөөгүй чих сонсовч бөглөөтэй ам нь би энд байна гэж хэлж чадахгүй нь гачлантай.

Туслагчийг удтал ингэж тэгнэж явсаар бараа бологчдынх нь дуу тасарсан хойно, амны нь бөглөөг аваад пидхийтэл нь газар унагав. “Манайхны ойролцоо орхих нь ч яав аа... Хүлгийа минь тайлдаггүй байна шүү. Хүлэг байтугай нүдний боолтыг ч авсангүй. Намайг баригдах үед орой болж байсан. Өдийд лав харанхуй болсон байх. Ингэж байтал чоно ирээд идчихвэл яана” гэж туслагч бодсоноо өөрийн эрхгүй орь дуу тавилаа. Чимээ чагнан чагнан орилов. Базар туслагчаас холдоод нилээд хүлээж байснаа эргэж ирэхдээ,

- Хүн байна уу? гэж үл мэдэгч болон асуусанд

- Байна аа, байна, энд хүн байна гэхэд нь

- Юун хүн бэ! гэвэл бараа бологчдынхоо нэгийг тааралдлаа гэж баярласан Сэр-Од,

- Туслагч нь байнаа. Наашаа ирээрэй! гээд тэдэндээ юу гэж хэлэхээ бодлоо. Базар түүний дэргэд ирээд нүднийх нь боолтыг авахад туслагч дэргэдээ өнөөх өстөн болсон Базар нь зогсож байгааг хараад “Өстөн хүнтэй өл хөтөл дээр гэгч яасан үнэн бэ? Шулын гараас мултарч ядаж явахад энэ тэнүүлчин заавал тааралддаг байна шүү. Хэрэггүй ч хашгирав байна. Энэ ч намайг хонзонгоороо заавал цааш нь харуулахаас зайлахгүй” гэж айж балмагдахдаа

- Базар минь, намайгаа өршөө! Ачийа чинь хариулна гэж царайчлав.

- Туслагчтан минь, та яахаараа энд хүлэгтэй хэвтэж байдаг билээ?

- Хулгайчид баригдаад аа...

- Над шиг олон хүнийг зовоосны чинь гор нь гарч байгаа нь тэр дээ.

- Хэлээд яах вэ? дүү минь! Цаст уулын цагаан арслан цагаа болохоор бэлд бууж шоргоолжинд баригдана гэгчийн үлгэр болоод үхлээ хүлээж байгаа намайг мөрөөр минь орхи доо. Та нарыг зовоосон арван хар нүглээ наманчилж, гэмгүй явсан чамд сайныг ерөөж байгаад л үхье, би чинь гэж туслагчийг айсандаа ээрэн гоншигоноход яахаараа ийм нэрэлхүү, аймхай, зусарч болдог байна вэ гэж зэвүүрхсэн Базар юу ч хэлэлгүй эргэж алхлаа. “Туслагч “Ашгүй мэнд өнгөрөх нь. Сэр-Од амьд үлдсэн хойно хэзээ нэг цагт чамайг даа...” гэж шазуур зуув. Тэгтэл Базар нойтон гишүү огтолж ирээд түүнийг түрүүлэг нь харуулж өмдийн нь шувт татлаа.

- Дүү минь, чи намайг яах нь вэ? гэж яах ч учраа олохгүй арга тасарсан туслагч дуу алдан хашгирав.

- Ингэх гэсэн юм гэж Базар хилэнтэйгээр хэлээд туслагчийн эцэг эхийнх нь гараас өөр юу ч хүрээгүй тантгар цагаан хонгон дээр тас буулгав.

- Ёо ёо!... Дөнгөө ядаж байгаа намайг ингэж яах нь вэ... Ёо ёо ёо!

- Эцгийнхээ өшөөг, сүйтэй хүүхнийг минь шулам болгосны өшөөг авч байна аа гээд Базар хэд цохиод авлаа. Нойтон гишүү гулбилзаад махтайхан хонгон дээр яг л буулгаж байгууштай санагдав. Түшмэлийн, сарны гэрэлд цайрч байсан хонго харлаад ирсэн нь хэдхэн цохихын аяыг даахгүй хэгзрэн цус шүүрч байгаа бололтой.

- Таминь, авраач! Ёо ёо, ёо ёо! Өрөвдөж хайрлаач дээ гэж туслагч тэнхээгээрээ бахирсан нь ойр хавьд хүн явбал ирэг гэж бас боджээ.

- Хүнийг зодох гэдэг ийм л байдаг юм. Та нар хүн хайрлахыг мэддэг үү? Миний эцгийг зодож байхдаа өрөвдөж байсан уу?! гээд эцгийгээ дурсмагц Базарын уур нь шатаж улам ч чанга цохилоо.

- Би аавыг чинь зодоогүй. Зод гэж хэлэх нь хэлсэн. Пэрэнлэй тахар л хэтрүүлчихсэн байх, гээд хэлчихсэн биш эцгээсээ бүх үнэнийг сонссон Базарын уурыг бүр ч шатаачив.

- Тарган түшмэл зодуур даах л байлгүй гээд Базар гүвшиж гарсанд туслагч,

- Ээ ёо ёо, ий ий, ёо ёо! Яаа даа, даанчиг! гээд уйлан гиншиж байснаа чимээгүй болсон нь ухаан тавьжүэ. Хонгоных нь мах салбараад цус гоожиж байлаа.

- Муу махчин! Чамайг алсан ч миний эцгийн амийг төлөх юм биш гэж Базар заналтай хэлээд хальс нь салбарч цус бялтсан гишүүгээ дэргэд нь хаяад мордов. Нилээд явгал уур нь гарч, өшөө хорсолдоо багтарсан дотор нь уужирч энэ тэрийг уудам ухаанаар эргэцүүлэн бодохтойгоо боллоо. “Энд чинь чоно элбэгтэй газар. Гай болж чоно идчих юм биш байгаа даа. Тэгвэл Цэцэн Сарт-Уулын хошуу тэргүүн туслагчаа чонын хоол болгочихсон гэнэ ээ гэж гаднын хошууныхан шуугивал хошуу нутгийн нэрд муухай юмаа даа. Түүнийг алахгүйгээс цааш хүн амьтны үзэхийн аргагүй газар хаяад ч яах вэ. Миний өстөн ч гэсэн бусдадаа ноён ухаантай юм даа. Өөрийнхөө ижил эр сүвтэй, тэгээд ч тэнхэлгүй муу амьтныг хүлээтэй

шалдан хаяж түмний доог тохуу болгох нь ч сайн эрийн зан биш юмуу даа” гэж Базар бодоод буцлаа. Дөнгөж ухаан ороод байсан туслагч ямар нэг юм ирж яваа чимээ чагнан, цусны үнэрээр чоно ирж яваа байх гэж айхдаа муухай ориллоо. Базарыг дэргэдээ ирэхэд туслагч намайг зодоод сэтгэл ханахгүй амёiа минь ъ᠘ᠳᠦᠳᠦᠳᠦᠳᠦ ирлээ гэж бодоод,

- Дүү минь, чи намайг битгий алаач дээ! гэж доожоо муутай дуугарав.

- Амь хэрэгтэй болсон цагт өстөнөө ах дүү гэхээс ч буцахгүй болж эрээ цээрээ алддаг юм шив дээ гэж Базар ууртай хэлээд морин дээрээсээ тонгойн туслагчийн бүснээс шүүрч эмээл дээрээ бөгтрөөд явлаа.

- Амийа минь өршөө! Амийа минь өршөө! гэж туслагч үглэн Базарын гутлын хошууг үнсэн уйлахаар нь залуу “Харц ардад эр бар байдаг өнөөх ширүүн дориун авир нь хаачлаа! Амьдаараа сүр сүлд нь үхчихээд байгаагий нь! Нүдний булай болмоор ийм амьтас хошуу толгойлж байхаар зовсон олин яаж ч жаргал үзэх билээ” гэж бодоод ой гутсандаа толгой руу нь ёворч явлаа.

Галын бараа үзэгдэж, үе үе хашгирч гуугалах сонсдож, явах тусам тод болсоор байсанд туслагч өөрийгөө арай ч нухчихгүй нь гэж ухааран зодуурандаа үхэн хатан шаналж байгаа ч гэсэн харанхуйлсан дотор нь үл мэдэг гэгээ оров. Базар түүнийг буулгаад,

- Чамайг алчихмаар байвч эх минь хүний аминд битгий хүрээрэй гэж захисан болохоор болилоо гээд хүлгийа нь тайлахад амь гарсандаа хэмжээлшгүй их баярласан туслагч,

- Ямар буянтай хүний үр вэ! гэж дуу алдаад залуугийн өлмийд сөгдөн мөргөв. Базарыг модон дунд ороод харагдахгүй болсонд Сэр-Од туслагч “Шөнө байсан нь яамай. Тэгээгүй бол нэг насаар түмний шившиг болох байлаа” гэж бодоод залбирчээ. Чимээ гарч байгаа зүг явах гэтэл хонго нь таталдаж хоёр хөл нь янгинаад газар хороодог юм биш. Дөрвөн хөллөн мөлхөөд үзэхэд ч ялгаагүй. Олон хүний хонгоны мах барсан сайхь туслагч бөгсөө чирэн ганц нэг сажилж, дараа дараалан хашгирч чимээ өгч явахдаа хонгоных нь мах сэг болчихсон хүмүүсийн шархан дээр нь хайрга үрүүлж байгаад босож чадахгүй болтол нь зодуулдаг байснаа нэхэн бодоход өөрөө бас ч аргатай хоцорсон санагдана. Туслагч арайхийж нэг галын бараа олж хараад тэр рүү дөхөхчөөн болж явав. Хичнээн хашгирлаа ч тамир тэнхлээ барсан учир дуу нь хүрсэнгүй. Сүүлдээ явж ч чадахаа болиод түрүүлгээ харан унав.

Нойргүй хоносон бараа болоочид үүр цаймагч дахин эрэлд мордлоо. Туслагчийг хоолойгоо сөөтөл гууглаж, тэсэхүйеэ бэрх болон өвдөж байгаа бөгсөө дааж ядан нэг модноос нөгөө модонд хөлөө чирсээр хүрч амсхийн газар хороосон ч юмгүй, дэмий л тамираа шавхан дөнгөн данган сажилж явахад түүний дуугаар бараа болоочдын нэг нь ашгүй давхин ирж санд мэнд сөгдөн эмээлтэй морио өгөхөд,

- Наадхи дээр чинь мордох тэнхэл алга. Цаадуулаа цөмийа нь майхантайгаа аваад ир! гэж иш мухаргүй зандрахад тэр хүн давхин одлоо. Цөмөөрөө ялд унана гэж айж байсан бараа болоочид туслагчийнхаа амь мэнд байгааг сонсуут баяр хөөр болон цуглаж хоромхон зуур майхнаа босгож хоол унд зэхэж байхдаа туслагчийнхаа янгуучилж шаналсан царай, уур хилэнтэй харцнаас айгаад юу болсныа нь асууж зүрхэлсэнгүй. Түрүүлгээ харан хэвтэж

байсан туслагч зоог барьсны дараа бие нь жаахан тавирч, зангирч байсан хөмсөг нь тавигдаад ирэхэд түүнтэй илүү дотно байдаг Пэрэнлэй хэрхсэнийг нь зориглон асуув. Туслагчийн хаа юу болсныг мэдэхсэн гэж тэсэн ядан байгаа бараа бологчдынх нь мятрамхай харц түүн дээр сэм сэм тусаж байлаа. Туслагч бас шууд хэлчихгүй тээнэгэлзэв. Шулмын гарт ороод гэх нь эрхэм дээд язгууртан хүний нэрд даанч тусгүй. Хулгайчаа барьж шийтгэх хэргэмтэн нь байж өөрөө Базарт зодууллаа гэж хэлбэл захын хүний доог тохуу болох байлаа. Тэгээд туслагч нэр цэвэр үлдэхийн эрхэнд худал хэлэхээр шуударч,

- Шилийн дээрэмчин дайралдаад... Амьд гарсан минь л зол боллоо гэж дурамжхан дуугараад таг болов. Бараа бологчид нь нарийн шургааг огтолж майхнаараа дамнуурга хийгээд унаан дээр гарах аргагүй болсон туслагчаа морин дээрээ дамнан буцлаа.

Сэр-Од туслагч замын туршид Базараас өшөө авах тухайгаа бодож ухааныхаа савны ёроолыг сэгсэрч үзлээ. “Шуламд амласнаа ч ёсоор болгохгүй бол аминд халтай. Ерөөсөө шуламтай тэрцэж болохгүй. Түүний есөн шидийг давж дийлэх хүн яаж байх вэ. Одоо ч миний яахыг үзэхээр шувуу болоод даган нисэж яваа ч юм билүү. Харин Базар бол өөр хэрэг. Хулгайчаа дийлэхгүй толгой дээрээ гаргачихаад өөрийгөө доромжлуулж байна гэдэг миний муугийнх яах аргагүй мөн. Базарыг байгаа цагт би ч, манай хошуу ч амар заяа үзэхгүй. Энэ хошууны эзэн юм бол чамайг би заавал гартаа хийнэ. Түүнийг манай хошууны дархалсан хулгайч, хаа ч явсан хэн ч халдаж барьж болохгүй гэж сум, отгуудад бичгээр зарлана. Ингэснийг дуулахтайгаа зэрэг тэр хулгайч намайг өөрөөсөө айгаад дураар минь тавилаа гэж бодоод цалгардах нь мэдээж. Одоо ч гэсэн тэр хулгайч эхтэйгээ ямар нэг аргаар заавал уулзаж байгаа. Пэрэнлэй, бас нэг итгэлтэй хүн хоёрт дориун шан хүртээж байгаад өдөр нь алсаас дурангаар, шөнө нь ойроос гэрийн ээлжлүүлэн харуулдуулъя. Өөрийн талын ам бөхтэй нэг эмэгтэйг гуйлгачин болгоод эхийнд нь хааяа очуулж туршуулах юм байна. Түүнийг гэртээ хэд хэдэн удаа очиход нь хоёрын хооронд оролдож өчүүхэн ч сэдэв авахуулахгүй байхаар улам ч тайвширна. Тэгсэн цагт уу, миний гарт орохгүй хаачих вэ, чи! Барих барихдаа бүр гөрөөсний гүрээнд ассан шилүүс шиг нэгмөсөн базна шүү” гэж туслагч эргэцүүлэн тунгааж, хорсолдоо автан хумсаа алгандаа шигдтэл атгаж, шүдээ тас зуун хавирахад бараа бологчид нь зодуурандаа шаналахдаа тэгж байна гэж санажээ.

Тэр шөнө Сэр-Од шархны халуунд шаналан унтаж чадахгүй тарчилж Базарыг занан харааж, ингэж тамлуулсныхаа хариуг хэзээ нэг цагт яаж авахаа төсөөлөн бодож, хорсол дүүрсэн хар санааныхаа хоосон мөрөөдлөөр сэтгэлээ зогоож, өвчиндөө янгуучилсан хариг аашаар хажуудах хүмүүсээ зовоон хэвтэж байв.

Тэр үес Агваанлуvsан дүвчингий хотод бас нэгэн хэрэг дэгдлээ. Дүвчин хулгайд алдсан адууныхаа хойноос гонсойн санааширч, амьтнаас асуугаад ч сураг сонсолгүй, өөрөө шоо хаян мэргэлээд ч учрыг нь олохгүй мунгинаж гүйцээд хэд хоножээ. Адууныхаа хойноос санаагаар унаснаас бүтэн нойртой хоносон нь бараг үгүй.

Агваанлуvsан шөнө дундын хэрд адуугаа нутагтаа байж байна гэж сайхан зүүд зүүдлэн нойрсож байтал гэгэж гэнгэнэсэн царгиа дуунаас цочин сэрлээ. Дүвчин нүүрнийхээ арьсыг татвалзуулж нүдээ хэд анивчаад бурхан өөдөө өндийж харав. Түүний амилах дөхсөн шүтээн гэж биширдэг гуулин бурхад нь хөл гараа сэрийлгэж сарайлгаад зулын сүүмгэр гэрэлд бүр ч сүртэй мэт үзэгдэнэ. Нойрон дунд юу дуугарав гэж гайхсан дүвчин чих тавин чагнатал нэг

юм гэрийй нь тойроод л үглэж дуулаад байх нь тэр. Өнөөх шулам болсон хатны дуу яах аргаүй мөн бололтой. Дүвчин ухасхийн босон бурхныхаа өмнө зогсоод

- Эзэн Богд минь. Надад ирж хоргоддог байна шүү гэж шивнэж, хүчтэй уншлага уншихгүй бол салахгүй гэж сэтгээд өөрийнхөө ачтай тустай гэж цээжилсэн тангад номноосоо хурдан хурдан уншиж хорхой түүж байгаа тогоруу шиг тонголзон бурхандаа мөргөлөө. Гуулин бурхад нь эзнийгээ духаа хорсож улайтал мөргөж байгааг огтхон ч ажрахгүй мэт хүйтэн цэвдэг өнгөөр гөлийж байв.

Хоосон буян амлаачин

Хотол олныг мэхлээчин

Ханан гэрээ орхигтун.

Хадан гэртээ очигтун!

гэж шулам занан дуулж гэрийй нь шажигнатал шөргөөв.

- Бурхан минь! Ээ, бурхан минь! гэж дүвчин муухай орилоод

- Ачит бурхан таныгаа би ухаан мэдээ орсон цагаасаа шүтсэн шүү дээ... Бурхан минь намайгаа энэ нүүрлэсэн аюулаас аварч хайрла! гээд түрүүчийнхээсээ өөр нэг тарнийн ном эхэлж чанга чанга уншина. “Туслагчтанд ачийг санасаар ийм их гайтай учирдаг байна шүү. Дийлэхгүй нүгэл хураасан бүсгүй байсан юм. Одоо миний толгой дээр буулаа гээч! Богд минь, би чинь яадаг билээ? Арай ороод ирэхгүй байгаа даа. Энэ ч хэр баргийн аюулыг хаах л судар юмсан” гэж дүвчин уншлагынхаа хажуугаар бодоод хаалга руугаа хяламхийн эргэж хартал барвайсан хар гар тотгоор нь орж ирээд оньсый нь мултлав. Дүвчин бурхныхаа өмнө сөхрөн унаж “Юутай ч гэсэн айгаагүй юм шиг байх юм шүү. Айвал тэр дор нь хорлодог юм гэдэг. Намайг хармагцаа сүрдэн цаашилж ч магадгүй” гэж санав.

- Амилсан сахиус минь! Догшин шүтээн минь! Би хар бага наснаасаа бурхан багшид сүслэн дандаа буян үйлдэж явлаа. Эрлэг номун хаанд намайгаа битгий явуулаач! Нас минь дөнгөж тавьж шүүрч байна. Дахиад бурхан сахиусаа баярлуулах буян хийе. Үгүй ядахдаа таван жилийн нас сүүдэр хайрлаач! гэж цөхрөн гуйж мөргөж байхдаа “Барагдашгүй их хөрөнгө хошуу хүрээнийхээ балданлхам бурханд өргөө гэж амлавал дойшин шүтээн минь аминд орох юм биш байгаа даа. Нэгэнт мэнд үлдвэл хувраг хүн бурхандаа амласан амнаасаа буцаж алдаа хийж болохгүй. Амласнаараа өгчихнө гэхээр хожмын өдөр өөрөө модоо барьж үлдэх хэрэг болох юмаа даа” гэж бодон тээнэгэлзэж байтал үүд тархийн онгойж нэг юм сүр сархийн ороод ирлээ. Араас нь дараад авах гэж байх шиг санагдан ухаан алдталаа айсан дүвчин босон харайж эргэн харвал өөрийнх нь төсөөлөн мэддэг шулам гэгч нь яг дүрээрээ зогсож байв.

- Оройн дээд Очирдар минь ээ! Олон түмээн! Авраач, намайгаа! гэж дүвчин чарлав. Түүний царай хөсрийн яс шиг болжээ.

Энэ бие минь шулам сан.

Эрлэг нааш нь илгээсэн

Очир там зэхээстэй

Орох үүд нь дэлгээстэй

гэж “шулам” хахир дуугаар хэлж, үсээ сэгсэлзүүлэн урт дэлэнгээ савчуулан дэвхцэж цовхчисоор дүвчин руу зугуухан дөхлөө.

- Аа, аа! Би дүүрлээ шүү! гэж дүвчин бахирч тулга тойрон зугаадаа “шулам” хөөв. “Шулмын” нөмөрсөн дээлийн хормой бурхан тахилыа нь татаж унагасанд дүвчин түүнийг хамгийн муу ёрын юм болов гэж сэтгээд, дэн дун ухаантай үүд рүү ухасхийсэн боловч “шуламд” баригдан нэг муухай орилоод босго дамнан үхүдхийн унав. “Шулам” ч дээгүүр нь харайн гарч одлоо.

Айлын нь хүмүүс эл бүхнийг сонссон боловч тахар Пэрэнлэйтэй учирсан явдалын дуулианаар нутаг усандаа амилсан шулам бий болсон гэж нэгэнт мэдсэн учир багшид халдсан шулам өөрсдийг ий дор нь хорлоно гэж айгаад нэг ч хүн гэрээсээ гарахыг зүрхлээгүй билээ. Цөм л гэр гэртээ маани мэгзэм уншиж мөргөл эргэл хийж байжээ. Дүвчингээ амь тавих мэт муухай орилоход багшийа минь яачихав гэж бодсон хэрнээ яаж ч чадахгүй дэмий л балданлхам бурхандаа залбирчээ. Чимээ намжаад удсан авч айлынхан нь шуламд хорлогдохоос айгаад гарч ч чадахгүй байсаар үүр хаяарахад үүдээрээ шагайж, эхлээд толгойгоо, дараа нь цээжээ цухуйлгасаар их л болгоомжлон гарч дүвчингийн рүү хойно урдаа оролцон чимээгүйхэн очицгоов. Тэд босго тээн ухаангүй хэвгэж байгаа дүвчинг үзээд хэрдхийн цочиж “Хөөрхий багш минь” гэж дуу алдацгаан, нэгэнт таалал төгссөн байх гэж санасан учир хүн хүн дор бүрнээ нэг юм амандаа шивнэж, бие бие рүүгээ харан “Чи, би” гэж харцаараа дохилцсоор сая дүвчинд гар хүрлээ. Гэтэл дүвчинг амьсгаатай байсанд,

- Сайн лам тулдаа л шулмаа хөөж явоблаад өөрөө амьд үлдэж шүү гэцгээн улам ч сүслэн залбирсаар дүвчинг өргөн гэрт нь оруулж хэвтүүлэв.

Уулын ороёа нар тусах үед хөглөгөр ногоон ой бүрхсэн Шар нуруу өөд хоёр морьтой хүн өгсөж явсан нь Базар Юмжирдулам хоёр байлаа. Тэр хоёр юм ч ярихгүй бодолд дарагдан алхуулж байснаа Базар ам нээж

- Бид хоёрын ингэж явахыг хүн харвал юу гэх бол? гэсэнд хүүхэн

- Чамайг л шуламтай нөхцчихөж гэнэ биз гэв.

- Нээрээ л тэгэх байх. Харин тэгвэл “шуламнаас” нь айгаад надад хүн ойртохгүй амар биш үү? гээд Базар инээв. Хоёул дахин үг хэлэлцсэнгүй явсаар нэгэн горхины захад хүрч очоод мөн л дуугүйхэн буулаа.

- Юмжирдулам аа! Наад ёргоо тайлаад өгчих! Одоо үүний хэрэг гарахгүй биз. Замдаа хойшоо харсан хонгил руу чихчихнэ гэж Базарыг хэлэхэд хүүхэн шулмынхаа хувцсыг тайлав.

- Нүүр гараа угаа даа. Чамайгаа гутааж орхив уу даа гээд залууг гэмшингүй мэт мөртөө ялдам

зөөлнөөр өгүүлэхэд хүүхэн инээмсэглэв. Хөөн хар царайн дундаас түүний баясгалантай хоёр нүд тормолзон хасын цагаан шүд нь ярсхийлээ. Хүүхэн уулын горхины цэнгэг хүйтэн усаар нүүр гараа угааж суухдаа

- Би ч хүн айлгах гэсэн биш, гэрт орсон хойноо өөрөө айчихсан шүү гэж хөгжилтэй инээгээд

- Дүвчингийн царай ёстой аймаар муухай байсан шүү. Намайг бариад авбал яана даа л гэж бодож байлаа. Чамайг гадаа зогсож байгаа болохоор л зүрх орж хэлснийг чинь хийж байлаа гэв.

- Хэрэв чамтай зууралдаад авдаг юм бол ч би харайж ороод ганцхан цохиод унагачихъя гээд хатавчинд отоод байсан юм байхгүй юу.

- Би жаргалаараа байсан бол яагаад ч ийм юм хийж чадахгүй байсан. Зовлон үзэж өширхөөд ирэхээрээ хүн чинь зүрх зоригтой болдог юм байхдаа гээд хүүхэн хормын төдийд бодлогошрон гүн санаа алдах нь энэхэн насандаа үзсэн хал зовлонгоо дахин санав бололтой.

- Охаантайдаа ад үзэгдсэн, унхиагүйдээ төөрөлдсөн хоёр эцгийнхээ өшөөг авч л байна даа, Юмжирдулам минь! Аав минь чөтгөр шулам гэдгийг мухар толгойтнууд л гаргасан юм гэж хэлдэг сэн. Өөрсдийнхөө бий болгосон юмандаа өөрсдөө хорлогдоод дуусаж дээ гэж Базар санасандаа хүрсэн хүний бардам дуугаар өгүүлэхэд хүүхэн

- Амьтны ч бараа харж чадахгүй ийм хоёр хүн чинь цаашдаа яаж шүү амь зууна даа. Байхаас харанхуй хадан агуй, үзэхээс хоёр биенээсээ өөр юу ч алга даа гэж гунигтай дуугарав.

- Хоёулаа байхаараа л хорвоогийн жаргал биш үү? Хэрэв би өдийд Да хүрээний шоронд ялзраад хэвтэж байгаа бол ямар байх вэ? гэж залуу хэнэггүй царайлан хэлээд инээмсэглэхэд

- Нээрээ ч тийм дээ. Чи минь ирээгүй бол би өдийд амьдаараа хатаж байгаа байх шүү. Бүсгүй хүн юмыг наагуур боддог гэдэг нь ортой байх аа даа. Чи надад битгий юм санаарай гээд хүүхэн гэмшингүй харцаар Базар руу харлаа. Залуу, Юмжирдуламын улаа бутарсан сайхан царай, гоолиг тэгшхэн хурууг харанхуй агуйд харж чадахгүй байснаа одоо л сэтгэлээ ханатал харж авъя гэсэн юм шиг аз жаргал, хязгааргүй хайр гэрэлтсэн зоримог шинжийн харцаар хүүхнийг тогтуухан ажиж мишээн зогссоноо дэргэд нь очоод ус нь хатаж гүйцээгүй нойтон булбарай хацрыг нь бадриун гараараа энхрийлэн илбэв.

- Чи минь элдвийг бодон сэтгэлээ бүү зовоо доо! Одоо бид хоёрыг хэн ч салгаж чадахгүй. Хоёулаа хүний дайтай явахыг бодно шүү. Орон дэлхий арвин болохоор бид хоёрыг хортны гараас хаацайлж дөнгөх байлгүй дээ гэж хэлээд сэтгэл догдолсондоо хөнгөн санааширч, хүүхний толгойг элгэндээ тэврээд ургах нарны туяанд ширхэг ширхгээрээ гялалзан байгаа мяндсан хар үсэн дээр нь үнэрлэн, бас дахин үнэртэхэд түүний эрийн заяа түшсэн алаг зүрхэнд нь аз жаргалын дуу бялхана. Хүүхэн өөрийн сэрэхүйгээр тэрхүү баясгалант дууллыг угтан аваад эргэн тойрноо шулганан дэрвэлзэж байгаа эртэч боламорын жиргээ шиг түмэн өнгийн хөгөөр сэтгэл зүрхээрээ уянгалаг дуулж байнам.

Ай, хорвоо чи хүнийг хүлцэшгүй бэрх зовоох атлаа хүслэнгийн дээд цэнгэл жаргалыг юутай

өгөөмөр хайрланам бэ!

Хорин дөрөвдүгээр бүлэг

Мэхт мэхэндээ

Тум тунгаасан хор бэлдвээс

Бум нэрснийг хариуд нь хүртмүү

Өглөөний сэрүүнд тогоо нэрж тулганы халуун галд цонотлоо шарагдаж суугаа Доржпалам эмгэний царай улайж дух, хамар дээгүүр нь хөлй бурзайжээ. Цоргоор гоожиж байгаа архины аагтай хурц үнэр гэр дүүрэн ханхийнэ. Эмгэн эхний усны охийг тасалж аваад галд өргөхөд хөх гал манасхийв. Тэгээд өөрөө амсан ярвайснаа,

- Ай даа, мөн ч бэрх гарчээ! гэж бувтнаад босож мөнгөн тахилд мэлтэлзтэл хийж бурхандаа өргөөд уруулаа умалзуулан нэг юм хэлж хүрд эргүүлэв. Эмгэн, дэрийн авдарнаас хар халтар галуун хүзүүтэй архи гаргаж ирээд авсан охио дээр нь нэмлээ. Хүү нь архи уудаггүй боловч идээ бүхнийхээ дээдийг амсуулах гэхдээ ийнхүү хураадаг ажээ.

Хэдэн малнаасаа салсан эмгэн сэтгэлээр унаж, өдөр хоногийг арайхийн өнгөрөөсөөр зуны дунд сарыг ардаа хийжээ. Хүү нь эсэн мэнд явж, хааяа нэг бараагаа харуулдаг нь л эмгэний сэтгэлээ зогоох юм нь болжээ. Тиймээс ч хүүгийнхээ үгэнд орж, хоосон бууцан дээр ганц гэрээрээ байсаар байлаа. Айлтай буувал хүүтэйгээ уулзаж чадахгүй, харин хүүгээ хэрэгт хийчихнэ гэж боджээ. Гэтэл нэгэн шөнө гадаа нь хонь мал майлалдан шуугихад нь эмгэн сэрж, “Энэ чинь юу болов? Би зүүдлэв үү. Эсвэл хий юм дуугарч байна уу?” учрыг олж ядан чагнахад үнэхээр бог мал тожир тожир явж, үхэр биеэ шир шир хийтэл долоож, тугал эхийгээ ховдоглон хөхөх сонсдов.

- Үгүй энэ чинь юу вэ, таминь! Айл нүүж ирж байна уу? Харанхуй шөнө нүүх айл гэж байдаг л юм байх даа. Хүн хар дуугардаггүй бас хачин юмаа гэж бодсоор эмгэн гарлаа. Олон жил үр төлөө өгсөн юм гэж ихэд хайрладаг хөгшин харагч үнээ нь үүдэндээ хивэн зогсохыг таниад бүр ч алмайрч хоцорлоо. Эмгэн бөгцөгнөн явж үзэхэд үхэр, хонь нь зүсээрээ ирчихсэн байхаар нь баярлах гайхах хосолж бурхны ивгээлээр л ингэлээ гэж санаад

- Авралт бурхан минь! гээд сөхрөн сууж дөрвөн зүг найман зовхист наманчлан залбирлаа. Гэтэл айж хэлмэгдсэн Сэр-Од мултарч харьсан шөнөө л эмгэнээс урьд булааж авсан малаа тахар Пэрэнлэйгээр хүргүүлсэн ажээ. Хэрэв өдөр явуулбал өргөөнийхний нүдэнд өртөж өөрийнх нь тухай элдвээр шагшин шуугихаас айсан ажээ.

Өөрийн зовлон зүдгүүрийг урьд насанд хийсэн үйлийн үр хэмээн итгэж шар өдөр, бор хоногийг тун ч шаналгаатай өнгөрөөж байсан эмгэн малынхаа барааг хармагцаа бурхан намайг нигүүлсэв гэж баярлан сэтгэл нь тэнийж элдвийг бодон зовниж суух ч зав олдохгүй баянт малаа эргүүлж тойруулан, идээ цагаагаа базаан борви бохисхийлгүй хөдөлсөөр байтал нар шингэнэ.

Урьд нь сардаа гуравхан удаа эзгүй хээр бараагаа харуулдаг байсан хүү нь орон гэрээрээ ойрхон ойрхон орж гардаг болсноор барахгүй хоёр ч удаа ирж хоносон учир эхийн гялайсныг

хэлэх юун. Шөнө байн байн өндийж, унтаж баёгаа хүүгийхээ царайг зульи гэрэлд харан, сэрээчих вий гэхдээ толгойгий нь аяархан илж, духан дээр нь хошуу хүргэх төдий үнэрлэж, эх хүний үрээ гэсэн далай шиг сэтгэл нь хэмжээлшгүй хайраар бялхан долгиж, баярын нулимсаа унаган унаган байж билээ. Эхийн гялайсныг хэлэх юун! Цаг зуурын зовлон үзсэн ч гэсэн лам бурхандаа алгуурлалгүй сүслэн биширч байсны ачаар заяа буян инь дахиад тэгширч байна гэж орж гарсан нутгийн ах дүүст ярих болжээ.

Өнөөдөр хүү нь ирнэ гэсэн болохоор байн байн гарч харан тэсэж ядан хүлээнэ. Эмгэн бүрхээр тогоогоо авч халаасан усаа асгах гэж гартал хүү нь гадаа ирээд бууж байв. Эх нь хүү рүүгээ майжигнан очиж тэврэн үнсээд оруулав. Базар ааруулын тавиур дээр уруу нь харуулан тавьсан бүрхээрийн халуун ээрэмнээс хуруугаараа этэн долоож

- Ээж ээ, та тогоогоо нэрээд ёстой нэг гялалзаж байх шив дээ гээд эх рүүгээ харан инээмсэглэв.

- Халдах аюулгүй, харшлах зовлонгүй сэтгэл амар сууж байхад тэгэлгүй яах вэ гэж эх нь хэллээ. Базар ирэх бүрийдээ эхийнхээ царай засарчихсан, сэтгэлийн зовлон нь хагасарч байгааг ажиг баясаж, хөгшин эх минь л жаргалтай байвал би ч яах вэ, эр хүн болохоор аргаа олоод л байна гэж боддог ажээ.

- Ээж нь тогоогоо нэрээд цайгүй л сууж байна шүү... Миний хүү идээ амс! гээд эх нь хүүгийнхээ өмнө ширээ тавьж тавагтай идээ бариад, авдарнаас эцгийнх нь хүүдээ хийж өгсөн гоёмсог хийцтэй мөнгөн аяга гаргаж өнөөх галуун хүзүүтэй охиноосоо дүүргээд хоёр гардан өглөө. Хүү архийг ёсорхуу авч нанчид өргөөд нэг балгаж өмнөө тавилаа.

- Ээж ээ, гэртээ ороод ирэх мөн сайхан юмаа. Утааных нь үнэр хүртэл цаанаа л нэг өөр гээч!

- Төрсөн өссөн орон гэр шиг сайхан юм хаа байх вэ, хүү минь! Хүний үр байтугай шувууны дэгдээхэй ч өсөн торнисон нуурандаа хоргоддог юм газар даа, хөөрхий... Хүү минь ирж байх хичнээн сайхан ч тамганыхны гарт орчих вий дээ гэж санаа зовох юм.

- Түүнд сэтгэл зовох хэрэггүй ээ, ээж минь! Намайг бүр дархалсан хулгайч болгосон шүү дээ. Одоо надаар оролдохоо больсон байх гэж Базар эхийнхээ сэтгэлийн зовиурыг засах үг хэлэв.

- Ээ мэдэхгүй дээ, хүү минь! Чам шиг хүнийг цаадуул чинь үнүхээр зүгээр орхино гэж үү гээд эх нь хүү рүүгээ эргэлзэж эмээсэн харцаар харлаа.

- Намайг дархалсан тухай хошуу даяар зар бичиг тараачихсан шүү дээ гэж хүү итгэлтэй өгүүлэв. Түүнийг гэртээ олон удаа ирэхэд нь хэн ч нэхэл дагал болоогүй, тэр ч байтугай хоёр хоноход нь ямар ч сэжиг сэдэв мэдээгүй учир түүний итгэл хоног өнгөрөх тусам лавширч байжээ. Базарыг гэртээ ирсэн байхад нь Пэрэнлэйг заавал очоод туршаатах гэж туслагч Сэр-Од их л холын бодолтой зарлиг болжээ. Пэрэнлэй, Базартай учирна гэдгийг үхлийнхээ зам руугаа явна гэсэн үг гэж айгаад дургүйцсэн боловч эзний зарлигийг нугалж болохгүйн эрхэнд нэг өдөр эмээсээр очжээ. Морьтой хүний бараа харсан Базар дурандаж таахрыг таниад мордож ухасхийх гэснээ, энэ муу намайг дийлэх юм биш, санаагий нь мэдье гэж бодоод морио цулбуурынхаа үзүүрээр гүйдэг уяагаар тушиж орхиод, айрийн сүүдэрт гудас дэвсэн,

эхийнхээ хамт цай ууж, өөр хамсаатан гарч ирэх магадгүй гэж орчин тойрноо нягтлан ажиж суув. Пэрэнлэй бууж морио бөхлөөд энэ гайхал цохиж алчихаад зугадах магадгүй гэж хулгасан хэрнээ биеэ барьж, инээмсэглэх гэсэн боловч айсандаа нүүрээ үрчийлгэн шазайсаар тэдний дэргэд ирж эмгэнтэй энгүүн мэндлэв.

- Бид хоёр үүнээс өмнө нэг нь тамгын тахар, нөгөөх нь гэмтний ёсоор уулзаж явсан болохоор золгосон биш дээ. Одоо чи нэгэнт манай хошууны дархалсан сайн эр болсон болохоор золгоё хө! гээд Базартай гар зөрүүлэн золгоод суухад нь эмгэн цай аягалан барив. Пэрэнлэй цай ууж, тамхи татах зуураа илүү дутуу юм чалчиж сэжиг авахуулав гэж туслагчийнхаа хэлснийг санан үгээ ихэд цэнэж хэдэн отогт тамгын бичиг хүргээд яаруу буцаж явна гэх төдийхэн юм дурсаад

- Манай ноён, тэргүүн туслагч хоёр чамайг дархалсан болохоор өөрийн хошууг хөнөөхгүй, харин харь аймаг хошуунаас “хавирга хугалж” ирэх байх гэж бодож байгаа бололтойдог гэж туслагчийнхаа зааж өгсөн үгийг хэлээд мордов. “Сайндаа ч биш, надаас залхаж аргаа барахдаа өөрсдийнхөө юмыг айтгий аваасай гэж л дархалсан юм байж” гэж Базар ухаараад хоцорчээ.

- Эртгүүд тахар Пэрэнлэй юу гэж хэлснийг та дуулсан шүү дээ.

- Пэрэнлэй ч ёозгүй хүйтэн царайтай хүн дээ. Инээж байгаа нь хүртэл цаанаа л нэг өнгөц шүү гэж эх нь яснаасаа сэвүүцсэн янзтай дуугарав. – Тэр яах вэ, ээж минь! Дахиад ямар та бид хоёрт гай болох юм биш гэж Базар тоомжиргүй хэлэв. Эмгэний эгдүүцээд байгаа тэр тахар одоо ч гэсэн тэртээх уулын модонд морио уячихаад хадны завсар дуран бариад нуугдан хэвтэж байгааг эх үрийн элбэрэл хайранд жарган суугаа энэ хоёр яахин мэдэх вэ.

- Ээж нь хүүгээ яачих бол доо гэж дандаа л санаа зовох юм. Заримдаа муу ёрын юм зүүдэнд орохыг яана! гээд эхийн нь хоолой зангирч, нүднээсээ өөрийн эрхгүй бөмбөрсөн нулимсыг арчаад санаа алдав.

- Ээж минь хэрэггүй юү бодоод уймарч суухаа болиоч дээ. Өөрт чинь зовлон болохын нэмэр гэж хүү нь хайхрамжгүй хэлээд гарч алсын бараа харлаа.

Үдийн хонь хотлоход эх нь хүүдээ хонь зааж өгч гаргуулав. Хонины гэдэс чанаж суухдаа

- Тамгынхан миний хүүг ял янганд хийхээ больсон юм бол гэртээ хүрээд ирвэл болох юм биш үү? гэж эх нь горилсон харцаар хүүгээ харав. Юмжирдуламыг оргуулаад ууланд бүгж байгаагаа эхдээ хэлбэл шуламтай нөхцлөө гээд сүйд болох нь гарцаагүй. Хэрэв бүсгүйг гэртээ авчраад эхдээ учрыа нь ярьж үнэмшүүлбэл дээдсийг мэхэлсэн хамаг нууц нь задарч дахин хэрэг ундраад яахын ч аргагүй занганд орчих байлаа. Өөрийа нь дархаллаа гэснээс хойш дөнгөж ганц сарын нүүр үзэж байгаа болохоор туслагч Сэр-Одын амнаасаа буцахыг байг гэж газаргүй. Базар энэ бүхнийг бодоод хаширлаж байгаа бололтой.

- Өнөө хэр нь ууландаа л байсан нь дээр дээ, ээж минь. Эх нь хайчаа авч гэдэс эргүүлэнгээ

- Хүү минь, манай энд чинь шуламтай болсон ч гэх шиг элдвийн л юм дуулдах юм. Хүүгээ зэлүүд газар ганцаараа хонож өнжиж яваад шулмын хорлол болчих бий дээ гэж ээж нь санаа

зовох л юм. Балданлхам минь! Хэлэх ч юм биш, гэж өгүүлээд баруун гараа магнайдаа өргөн залбирав.

- Агваанлуvsан дүвчин гуай шуламд хорлогдсон гэж үнэн үү?

- Ээ базарваань, сүйд болсон. Би л лам хүнийг чөтгөр шуламд хорлогдлоо гэж ер дуулаагүй. Хөөрхий минь. Тиймдээ л жанч халалгүй тэсэх шиг боллоо. Сар шахам ухаангүй байсаар ойрноос сэрвийж боссон гэнэ билээ. гэхдээ гэртээ хүн орж ирэхэд цочиж ухасхийдэг, заримдаа дэмий донгосдог юм байх. Баян хүн хоёр амьтай гэдэг үнэн юм даа гэж эх нь хүүрнэхдээ завсар нь хэдэн удаа маани уншиж залбирав.

Дүвчинг сэхээх гэж ах дүү нар нь хүрээ хөдөөгүй баахан гүрэм хийлгэжээ. Түүнийг ойр тойрныхоо амьтны хамгийн хайртай морь мал, үнэтэй цайтай эд агуурсыг хураасан дундаршгүй баян лам гэдгийг хавийнхан нь андахгүй мэднэ. Тиймээс ч Галуутайн хүрээний нэртэй цуутай лам нараас эхлэн мурий захтай дээл өмссөн бүхэн нь дүвчинг юу ч мэдэхгүй байж өөрөөсөө давсан аймшигт шулмыг дарах гэж онгирч байж харин өөрөө хорлогджээ гэлцэн би ч босгоно, би ч аргална гэж өөрсдийгөө ид шидтэй, арга чаргатай гэж гайхуулцгаан тэдний рүү цувах болжээ. Тэгээд дүвчингийн хотод өдөр шөнөгүй хэнгэрэг цан нижигнэж, ном гүрэм уншсан лам нарын бүдүүн нарийн дуу тасрахгүй болж, сүсэгтэн олны юмыг хайр найргүй салгаж байсан дүвчингийнхээ юмнаас ахиухныг олж авах гэж сахил хүртэж санваар зүүсэн бүхэн л өрсөлдөж гарчээ. Хэцүү санаатай хашир зарим нь хэнгэрэг цангийн нижигнээн дунд би тэрийн нь авна, чи энийн нь ав гэлцэж байхад болчимгүй зарим нь гүрмийн дараа гүнцгээ зооглож байхдаа өглөг барьцаа булаалдан маргаж шившгээ дэлгэв. Хориод хоноход дүвчингийн хагаг юм лам нарын гар дамжин ус мэт урссаар юу ч үгүй хоосорч өөрөө хуучин муу бүрээстэй дөрвөн ханатай илүү гэрийнхээ хаяанд ухаангүй хэвээрээ үлджээ. Юмаа барснаас нь хойш тэднийхээр дархан Сүхийн хэлдгээр нэг ч мухар толгойтон үзэгдсэнгүй. Дүвчин хагас дутуу ухаантай сэрвийн боссонд олон хоногийн гүрмийн ач тус одоо л ирлээ гэж ах дүү нар нь баярлаж биширцгээсэн билээ.

Амандаа нэг юм уншиж эрхээ гүйлгэж суусан эх нь босож уур савссан халуун гэдэс гаргаж хүүгийнхээ өмнө тавиад шөл аягалж өгөхдөө

- Хүү минь, бурхан манайхыг мөн л их гамшгаас завсарласан шүү... Талийгаачийн тэр охин даанч цэвэрхэн төрсөн гойдын хөөрхөн ааштай байсан нь тийм л учиртай юм байж л дүү. Ум ма ни бадь ми хуи, хэлэх ч юм биш... Дээдэст тэгж харшилж байгаа юм чинь биднийг бол бүр ч сүйдлэхгүй яах вэ гэж өгүүлэхэд өөхтэй гэдэс ам руугаа хийж байсан Базар эхийгээ цаашлуулмаар санагдаж

- Харин доодост таарах байсан юм биш биз гэсэнд

- Донгос, чи! Тархи чинь яах нь вэ хөөе. Бурхандаа залбирахгүй юу гэж хайчаа барин зангахад хүү нь дуугүйхэн инээмсэглээд доош харлаа.

Тэр хоёрыг гэдэс идэн, яриа хөөрөөтэй тэн ч хөгжүүн байтал ноорхой хувцастай нэгэн ядуу эмгэн саваа тулсаар орж ирэн мэнд мэдээд тулганы баруун өмнө түлээний хөвх тохойлдон суув.

- Та ч морь сайтай явна шүү. Халуун гэдсэн дээр орж ирлээ гээд эмгэн цай хийж, тавагтай гэдэс авч өгөв.

- Ачит вангийн хошууны хүн гэнэ билээ, хүү минь. Яагаа вэ, илжгэн хошуу... Аль эртэд манайд нэг ирсэн юм. Өргөж тэтгэж байсан сайхан охиныг нь өвчин ээрэхээр арга засал хийлгэж амин тэжээлийнхээ хэдийг барьцаанд өгсөн юм байх. Охин нь сэхсэнгүй өнгөрчихсөн гэнэ. Тэгээд хөөрхий амьтан амь зуухын эрхэнд хар хүүдий бариад хошуу дамжин гуйлга гуйж яваа юм гэнэ гэж гуйлгачнаас сонссоноо хүүдээ яриад

- Хаа газрын амьтны зовлон барагддаггүй мөн ч бэрх юм даа гэж дуу алдан шогшров. Гуйлгачин эмгэн Базарыг хайхарсан янзгүй гэдэс идэн суухдаа “Хүү нь их тухлуу байх чинь мөд явахгүй нь дээ. Ингээд өнжих юм болов уу? Яая даа байз. Жаахан харзнах арга бодсон нь дээр байх аа даа” гэж бодов.

- Яасан ч халуун өдөр вэ дээ гээд толгойгоо боосон хиртэй хар алчуураа авч хөлсөө арчив.

- Танайд жаахан байж байгаад оройн сэрүү орохоор явбал яана? Үэж хэлээд эмгэн рүү харлаа.

- Тэгээ тэг. Энэ халуунд яаж явах вэ. Тэр баруун талаар хажуулахгүй юу гэж эмгэнийг хэлэхэд

- Яах вэ, яах вэ гэсээр гуйлгачин эмгэн гарч гэрийн сүүдэрт суугаад чихээ туурганд наан эх хүү хоёрын үгийг чагнах гэж оролдов. Базар удсангүй явахаар болж мах эвдэн өөрийн авахыг богцонд хийж байхдаа

- Ээж ээ! Цаад хөгшиндөө шинэ магнаасаа ахиухан юм өгчихөөрэй! Амьтан тэр болгон л хаанаас олигтой юм өгдөг байв гэж гэх нь сонсдов.

- Миний хүү ингээд гэртээ байж байвал ээжид нь мөн сайхан байх санж... Цаадуул чинь нэгэнт чамайг хөөцөлдөхөө больсон юм бол өнөөдөртөө гэртээ бөмбөрч хоноод өглөө явбал яасан юм бэ? гэж хүүтэйгээ ганц өдөр ч болтугай хамт байхыг хүсэж, одоо яваад өгөхөөр нь яана даа гэж зүрх шимшрэн суусан эхийгээ хэлэхэд

- Ээж минь! Хашир нь дээр шүү дээ. Ямар ч гэсэн би одоо явсандаа явъя! Шөнө харанхуй болохоор ирье дээ гэж Базар эхийнхээ сэтгэлийг зассан намуун дуугаар хэлээд богцоо авч гарлаа. Түүнийг явснаас хойш төдий л удалгүй гуйлгачин орж ирээд

- Овоо амраад авлаа. Мөд сэрүү орохгүй нь шиг байна. Явахаас биш дээ гээд аяга цай хийж уухад нь эмгэн Доржпалам хувь өглөө. Туслагчийн бодон бодон байж таних хүмүүсээсээ шилж авсан тахар Пэрэнлэйн эг÷, гуйлгачны дүрээр хувилсан энэ чавганц уутаа үүрээд саваагаа доёлзуулан явахдаа “Энэ хулгайч нь туслагчийн гарт бушуу ороодохоосой. Туслагч тэгвэл амласан алтан бэлзгээ өгөх байгаа. Энийг өгнө гэж алган дээр тавьж үзүүлсэн юм чинь хаанаас буцна гэж. Дор хаяхад гурван цэн бий дэг. Охиноо өнчин ишигний гарзгүй алтан бэлзэгтэй болгож дээ” гэж бодоход нүдэнд нь хүний цусаар олох гэж байгаа алтан бэлзэг нь гялалзан үзэгдэх шиг болж, алт хэмээх өнгө нь шижир боловч хар замтай эдийн шуналд хөтлөгдөн халууцахыг үл тоон улам улам хурдан алхаж явлаа.

Тэр шөнө Базар эхдээ хэлснээрээ гэртээ ирж хоножээ. Туслагч Сэр-Од буу шийдэмтэй, бяртэнхээтэй арав гаруй эрсийг дагуулан мордов. Морьтой очвол чимээнээр сэрээд зугадчихна гэж муу санаалан хол орхиж, гэтэж мяраасаар Базарын гадаа хүрэв. Сэр-Од буугаар эсгий үүдийг нь гэнэт сөхөн хаяж, хий буу тавин сүр үзүүлж, нөгөө эрчүүдээ оруулахад унтаж байсан эх хүү хоёр цочиж босон харайлаа. Нүцгэн Базарыг зулын гэрэлд харсан Сэр-Одын хөх инээд нь хүрч, санасандаа ганц хүрлээ гэж бодон үүдэнд нь дэвхцэн алдаж байлаа. Тэд Базарыг дор нь барьж хүлэв. Сэр-Одыг таньсан Базар байж ядахдаа

- Чамайг би ойд алчих минь яав даа! Ээ чаваас, ямар холын муу санаатай амьтан бэ, чи! гэж хэлээд уурандаа шүдээ хавирав.

- Ноён хүний холч ухаан гэж энийг л хэлдэг юм. Харцаар захирч, хулгайчаа барьж чадахгүй бол хошууны эзэн болж суугаад яах вэ гэж Сэр-Од бардаж хэлэхэд Базар

- Ноёноо алд! Нохойноос дор амьтан шүү дээ, чи! гэж хашгирсанд Сэр-Од

- Наадахиа аваад яв! гэж зандрав. Эрчүүд хүлэгтэй Базарыг дамжлан үүд рүү явахад эмгэн туслагчийн хөлд сөхөрч хормойноос нь зууран

- Хүүгий минь, өршөөгөөч! Эцгийг нь та яалаа даа. Ядарсан намайг бодож хүүгий минь тавиач! гэж орилоход

- Дүү, зөнөг чи! гээд Сэр-Од эмгэнийг өшиглөж унагаагаад гарлаа.

- Малыг нь хөөгөөд явна биз дээ гэж Пэрэнлэйг хэлэхэд өнөөх шулам нь Сэр-Одын санаанд орж бүх бие нь зарсхийгээд явчихав. Малыг нь аабал нөгөөх шулам надаас салахаа болих байх гэж айсан туслагч нэрэлхэхдээ

- Үхэх дөхсөн амьтны малаар ч яах вэ. Гай болж мэднэ гэжээ. Тэд Базарыг авч давхилдан одоход ухаан нь элий балай болсон эмгэн

- Бурхан минь, би яана аа!... Эс хэллүү, даанч муу ёр зөгнөөд байсан юм. Хайран үр минь, хайран үр минь! гэж орь дуу тавьсаар хоцорлоо.

Сэр-Од туслагч ирмэгцээ л Базарыг дархалсан бичиг шийтгэн тарааж, эмгэний малыг нууцлан хүргүүлж авах юмгүй болсон, хоёр гуяа сувилуулж байгааг өргөөнийхөн мэдчихээд хэл амаа билүүдэж дээрэмчин, хүний юмыг булааж аваад л алга болохоос биш, тэгж өмдийг нь тайчиж тухтай тохитой зодох учиргүй, харин өнөөх Базар нь модон дотор санаандгүй тааралдаж өш хонзонгоо тайлах гэж зодоход нь туслагч андгай өргөж амь хэлтэрснээс чингэж байна хэмээн Сэр-Одын аймхай хулчгарыг гайхан харааж зүхэж байсан бол одоо гартаа гавтай, хөлдөө дөнгөтэй мүглэнд сууж байгаа Базарыг хармагцаа туслагчийнхаа арга ухаантайг бие биенээс уралдан шогширч тэнгэр тултал магтах боллоо. Сэр-Од ч Базарыг хэдийд ирээд яаж сүйдлэх бол гэж ямагт бэмбэгнэж байдгаа больж, өшөөтнөө өвдөг дороо сөгтгөсөн баатар эр шиг толгой гэдгэр, ихэмсэг бардам явна.

Гав гинжгүй байлаа ч дотроос нь хүн гарахын аргагүй дөрвөн хуруу зузаан банзаар хийсэн

мүглэнд байгаа Базар руу өргөөний зарим саваагүй хатан, аальгүй шивэгчин, хэрэгт дурласан хиа нар гүйлдэн элдэв хорон үгээр тавлана. Заримдаа язгууртны дүрсгүй хүүхдүүд ирээд

- Манай адууг чи яасан бэ?

- Миний хайртай цоохор морийг авчирч аль!

- Адууныхаа оронд тархийа чинь цоо цохино! гэж хашгичин чулуу нүүлгээд харгалзагчид хөөгдөн зугатна. Мүглэнгийн хажуугийн нүхээр ил гарган өйæëüí Базарын толгойтой үс нь сэгсийж, хоёр өдрийн халуун наранд цоносон нүүр нь харлаж айдас хүрэм харагдана.

- Пээ, таминь! Ямар аймаар амьтан бэ? гэж бүсгүй хүн дуу алдахад Базар тэр зүг харвал хоёр хатан зогсож байсны нэг нь

- Ямар хүйтэн харцтай гуйлгачин бэ! гээд хойш ухрав.

- Туслагчийн хуриман дээрээс хатныа нь оргуулах гэсэн их санаат чинь энэ шүү дээ. Хөөрхөн хатанд санаархмаар ч царайтай амьтан бол доо.

- Одоо тэр шуламтайгаа нөхцвөл таарна даа гээд тэр хоёр бие биеэ нудран доогтой инээлдсээр явжээ. “Очиж очиж энэ эмсүүдэд муугаа үзүүлж байдаг даанч яав даа. Хийморь лундаа минь үхэж гүйцэх байх даа” гэж Базар дэмий л гаслав. Тэгтэл нэг өдөр туслагчийн адууг алдсан хоёр адуучин, хээр хүлүүлсэн үхэрчин гурав түүний баригдсаныг дуулсан бололтой цугтаа хүрч ирлээ. Тэд мүглэнгийн дэргэд сууцгаан

- Намайг адуугаа авсан гэж туслагчдаа хэлээрэй гэж хашгираад байсан сүрхий эр чинь чи мөн үү?

- Биш байх аа. Тийм сайн эр хаанаас баригдах вэ.

- Манай хошуу Базар гэдэг дориун сайн эртэй боллоо гэсэн. Чи арай тэр нь биш биз?

- Мүглэнд хэвтэж байхыг бодоход муу эр юм шив дээ.

- Манай туслагчийн цаана гарах ухаан чам шиг өөдгүй амьтанд яаж байх вэ.

- Чамайг мүглэнд хатаж байхад бид чинь эр улс шиг давхилдаж явна даа.

- Муу хулгайч л ичээд хүний нүүр рүү харж чаддаггүй юм гэнэ билээ. Тэгээд л чи бидэн рүү харахгүй байх шив.

- Өрвийсөн толгой руу нь яргай ташуур буулгаатахвал яах бол?

- Одоо хүзүүгий нь тас цавчихад мөн амархан байна аа. Ингээд л... гээд ташуураар хүзүүгий нь хэрчигч болон хөрөөдөж, хамрыа нь сөргөөж толгой руу нь дэлсэх дүр үзүүлж элдвээр гоочлоход Базар арга барахдаа өөдөөс нь ганц ч удаа хараагүй боловч сүүлдээ тэсвэр алдаж тэднийа хорсолтой хараад,

- Ёстой муу эрс л ингэж хөдлөх аргагүй болсон эр хүнээр оролддог юм. Та нарт сүвнээсээ бусдаар өргөөний эмсүүдээс ялгарах юм ердөө алга гэж хэлсэнд тэд ичсэн ч юмбó яваад өгчээ. Базар гурав хоног өргөөнийхний болоод туслагчийн зарц нарын доог тохуу болж байхдаа намайг ингэж амьдаар минь тарчлааж байхаар бушуухан алаад өгдөг ч болоосой гэж бухимдана. Гэтэл Сэр-Од туслагч яах гээд байгаа нь ч мэдэгдэхгүй таг чиг гурав хоносон нь түүнийг барьсантайгаа адил яаж залхаахаа бодсон байжээ. Улиастайн жанжин жасаанд хүргүүлбэл Да хүрээний шоронгоос оргосон аюултай хулгайчийг уран аргаар барьсан ухаантай мэргэн түшмэл гэгдэн шан хишиг хүртэж, эв нь таарвал хэргэм цол ч ахиж болмоор байлаа. Гэтэл жанжин жасааныхан гартаа хийж авсан хүнд хэрэгтнүүдийг алдчихаад Монголын нийт хошуудад баривчлах зар тарааж байсан болохоор Базарыг алдахгүй хадгалж чадна гэж тэдэнд бүрэн итгэж боломгүй санагдана. Хэрэв тэднээс мултарчихвал өөрөө дарж дийлэхгүй дайсантай болж хэзээ нэг цагт амь хохирно гэж айж байв. Тиймээс Базарыг барьснаа Да хүрээ, Улиастай хоёрын алинд нь ч мэдэгдэлгүй, гартаа орсон дээр нь цааш нь харуулаад нуун дарж өнгөрөөх нь хэтдээ аминд өлзийтэй гэж туслагч шийджээ.

Тэгээд нэг өдөр Базарыг тамгын өргөөнд аваачин, хошууны ихэс дээдсээс булаасан малыг хаанахын хэн гэгчид дам өгснөө хэлбэл өршөөнө гэж амлан байцааж, нэг ч үг сонсож чадаагүйдээ тэчъяадан хорсож, хэлүүлчих санаатай зуу хүртэл шаахайдуулав. Гэтэл Базар шүдээ тас зуун туслагчийг үзэн ядсан харцаар ширтэхээс биш, ганц ч үг хэлсэн. “Ёо” ч гэж дуугарсангүйгээр үл барам өвдөж ярвайсан ч үгүй. Түүнийг ёолох ч үгүй болохоор нь хор шар нь хөдлөн Пэрэнлэй байдаг тэнхээгээрээ цохиод ч нэмэр болсонгүй харин өөрөө тамирдаж орхив. Гэлээ ч түүнийг мянга шаахайдахад ч бэлэн байлаа. “Чи ч ёстой эрийн хуйх юм даа” гэж бодсон туслагч

- Одоо боль! Наадхи чинь хэлийн нь сугална гэсэн ч хэлэхгүй гэхэд Пэрэнлэй шаахайгаа газар шидээд амьсгаадан суулаа. Өргөөнийхний магтаалд хөөрсөн туслагч ухаантай мэргэн түшмэл гэдгээ энэ далимд үзүүлээд авах гэж мэрийжээ.

- Чи өөрийгөө дархалчихлаа гэж горьдсон биз... Засаг барьсан түшмэл хүний ухааны цаана гарч байж сайн эр болдог юм. Есөн эрүү давж баймаае нь дархан хулгайч болдог юм. Чамайг яс маханд чинь хүртэл зодож зовоохгүй. Улаан гараараа ч алчихгүй. Гэхдээ чи үхэхдээ л нэг үхнэ... Эр хүний үхлээр биш шүү. Усны амьтанд ч ховор тохиолдох адгийн муу үхлээр л дуусна даа. Тэр ямар үхэл болохыг түшмэл хүний ухаан л мэднэ. Өөр хэний ч санаанд орохгүй гэж туслагч үгээ тун ч нухацтай хэлж, үл мэдэг бодлогоширсон мөртөө басамжилсан харцаар ханын толгой ширтэн суух нь цаанаа л бардам сүрлэг.

Туслагч Базарыг мүглэнд нь хийлгээд чимээ аниргүй дахин гурав хонов. Харин энэ үеэр адуу хөөж ирсэн Намбаа бат журмын анд нөхрөө болзоот газартаа алга байхаар нь ямар нэг гай тохиолдсон байж магадгүй гэж ихэд сэжиглэн агуйд нь очоод уйлж унжиж яахаа ч мэдэхгүй болсон хөөрхий бүсгүйгээс учрыг нь мэджээ. Тэгээд Оршихтэй уулзаж, Пагмаар дамжуулан холбоо тогтоож Базарыг суллахаар хонон өнжин харуулдаж, шөнөд мөлхөн ойртож ирэвч гурван хуягийг ер салахгүй болохоор нь яах ч арга олсонгүй. Хошууны ардууд өвгөн дархан, түүний хүү хоёрын тухай ямагт сайнаар ярилцах учир Сэр-Од хэн нэг нь суллаж магадгүй гэж Базарыг тун ч хатуу чандлан харгалзаж байлаа. Бүстэй хүнээр хоол унд өгүүлбэл ямар нэг холбоо сүлбээ тогтоож мэднэ гэж Сэр-Од харлахаад өөрийн шивэгчин Пагмаар өдөрт ганцхан

удаа хоол өгүүлж байсан нь харин завшаан болжээ. Гэлээ ч яах гэж байгаа нь мэдэгдэхгүй, тэгэх нь гэж таамаглах шижим ч гарахгүй болохоор Базар, Намбаа Орших хоёрт оновчтой юм хэлж чадахгүй дэмий л хүлээлгэнэ. Пагма нэг хоол авчирч өгөхдөө,

- Базарыг оодроод байхаар нь миний зэвүү хүр÷ ухаан сийлж баривчлаад дээдэстэй тэрсэлбэл тэдний гараас гарахгүй гэдгийг үзүүлж байгаа юм. Гэсэн ч овоо шөрмөстэй эр болохыа нь танилаа. Өөрийнхөө хошууны ноёд баядын юманд гар хүрэхгүй гэдэг амыа нь аваад ёстой дархлаад тавьчихна гэж ярьж байна гэж баярлан хэлэхэд нь Базар ихэд гайхан,

- Үнэхээр тэгж байна гэж үү? гэсэнд

- Бүр олон хүн гэрт нь байхад ярьсан гээч. Би яг сонссон... За удвал цаадуул чинь хар авна шүү гээд Пагма шурдхийн босож явахыг завдахад Базар

- За чи Намбааг шөнө тун ойрхон бай! Ямар нэг хий гарч магадгүй гэдгийг хэлээрэй гээд Базар Пагмын хэлснийг эргэцүүлэн бодсоор хоцорлоо. “Намайг яагаад ч суллах ёсгүй дээ. Огт худал. Бас л нэг ов мэх зохиож байгаа хэрэг... Намайг хүн оргуулж магадгүй гэж муу санаалахдаа суллана гэж олонд цуурхуулаад сэмхэн Улиастайд хүргүүлэх гэж байгаа юм. Нэг нь нөгөөгөө нухаж байж л үлдсэн нь амар заяа үзэхээс биш, хоёулаа зэрэгцээд явах зам ч бид хоёрт байхгүй. Байцаахдаа юу гэж занаж байлаа? Усны амьтны адгийн үхлээр үхнэ гэсэн шүү дээ. Тэр юу гэсэн үг вэ? Усны амьтны адгийн үхэл гэж юу байдаг бол? Тэгж хэлсэн хүн намайг яалаа гэж тавих вэ. Нэг л юм бодож олсон доо. Яаж тарчлаах гээ бол? Энэ хар дотортой туслагч хүний санаанд оромгүй юм бодож байгаа. Яах л гээд байгаа бол доо?” гэж Базар туслагчийн санааг таах гэж ядна. Базарыг суллана гэсэн цуу тарааж байгаад элсэн манханд ширлэн хаяж хатааж алахаар нас гүйцсэн шарын шир дэвтгээж байгааг туслагч, Пэрэнлэй хоёроос өөр хэн ч эс мэднэ. Нэг орой туслагч, Пэрэнлэйтэй хоёулхнаа дотор газрын зунгааралдсан өтгөн хар архи ууж нууцгайхан ярилцжээ.

- Пэрэнлэй минь! Чи миний хамгийн итгэлтэй тахар. Занги, мээрэндээ ч хэлэхгүй ганцхан чамд ярьж байна гэдгийг сайн бодоорой! Энэ хошуу засгийг бат байлгахад чиний хүчин зүтгэл багагүй тус болсон нь лавтай. Одоо бид хоёр энэ хошууныхаа ихэс дээдэст тэрсэлсэн хамгийн аюултай дайсныг дарах гэж байна. Энэ нууцыг бид хоёроос өөр хэн нэг хүн мэдвэл эцсийн ял хүнд гэдгийг санаарай! Бас санасан хэрэг маань ёсоор болбол хайр хишгийг нь багадуулахгүй гэж туслагчийг өгүүлэхэд Пэрэнлэй алга хавсран бөхөлзөж

- Таны тааллаар больё! Дорд миний бие таныхаа хишгийг олонтаа хүртсэн билээ гэв. Жинс зэрэг, эрх ямбанд дургүй хүн байх биш дээ гэж бодож түүгээр хөхүүлэн өөрийн хэргийг хялбараар бүтээж заншсан туслагч

- Чи олон жил тахар хийж үүд өрхтэй бүхнээр орж саеí муу үйлд хошуу дүрж явсан даа. Алийн болгон нэр нүүрээ барж явах вэ. Тэгэхээр чамайг хошууны залан болгоно гэж бодож байгаа даа гэж туслагчийг хэлэхэд өөрөө огтхон ч бодож байгаагүй, санаанд оромгүй сонин үг дуулсан Пэрэнлэйн нүд очтон гялалзаж, хөлчүүрхсэн хөргөр царайд нь баярын мишээл зурсхийгээд явчихав. Гэсэн ч тахар цээжиндээ багтаж ядсан баярын давалгааг дарж

- Өчүүхэн надад ахдах байх даа гээд духаа ширдгэнд хүргэн алдан мэхэлзэхэд туслагч

- Энэ хэргийг нууцлан сайн бүтээвэл санаа зоволтгүй болно гэж хэлсэнд

- Намайг батад санаж болно. Энэ хошуу тамгын алив нууц миний амнаас гарч байсан удаа үгүй билээ гээд Пэрэнлэй их л хүлцэнгүй номхон царай гарган туслагчийгаа халамцуу хүний сүүмийсэн нүдээр гөлрөн “Манай туслагч хэлсэн үгэндээ эсэí болох хүн. Эгчид маань амласан алтан бэлзгээ яг л өгсөн. Тэр гайхлыа нь ширлээд хаячихвал намайг залан болгоно гэдэг ч үнэн. Туслагчийнхаа далласан газар нь ил гарч, далайсан газар нь далд орж явсан муу Пэрэнлэй залан болчихвол ч тэнгэрийн өнөөдөхийг атгаснаас ялгаа юун” гэж бодон хөхөн баясаж сууна.

- Шир чий дэвтэж гүйцсэн үү?

- Одоо ч хэрэглэсэн бэлэн.

- Маргааш орой уснаас гаргаад загсаагаарай!

- Жа, туслагч аа! Чармай нүцгэн ширлэвэл мөн ч сайхан юм болно доо. Хатахаараа хамаг биеий нь умартал бариад л... гэж Пэрэнлэй шүлсээ савируулан хэлэх нь хүний зовлонд үнэхээр шунаж байгаа мэт.

- Пэрэнлэй минь, гэнэн хөдөлж болохгүй. Бид хоёр хоёулхнаа ширлэнэ. Өөр хэнд ч мэдэгдэхгүй. Гав гинжнээс нь салгавал бид хоёр дийлэхгүй алдаж хөгөө тарина шүү. Хашир байхгүй бол горьгүй. Цаадхи чинь тийм амар амьтан биш гэж туслагч айснаа хаширлаж байгаагаар халхлав. Пэрэнлэй согтоод туслагчийнхаа ухаантай мэргэнийг эрээ цээргүй магтаж, “Ийм хүний төлөө морь нохой мэт зүтгэнэ. Мөнхөрдөг толгой биш өнхөрдөг толгойг өнхөрч унатал нь туслагчаа дагана” гэж андгайлж сүүлдээ бүр давраад туслагчаа хүзүүдэн үнсэж нэг юмаа долоо дахин яриад саламгүй болохоор нь Сэр-Од зэвүүцэж бушуухан явуулжээ.

Базарыг мүглэнд суусны арав дахь хоногийнх нь шөнө улс амьтан унтсаны дараахан Сэр-Од Пэрэнлэй хоёр түүн дээр хүрч очив.

- Чиний мүглэнд суух хоногийн чинь тоо гүйцэж дээ гээд туслагч хачин хүйтэн инээж

- Энэ сайн эрийг суллаж дархална. Одоо та нарын хэрэггүй гэж харгалзагч нарт хэлэхэд Пэрэнлэй

- Сайн санаат туслагчийн ачаар амь мултарч байгаадаа бoян санаж яваарай гэж үг нэмэрлэв. Базарыг олон хоног сахиж, нойр хоолоо алдан залхаж гүйцсэн харгалзагч нар тавих л байсан юм бол биднийг завсар нь юунд зовоов доо гэж бодсон хэрнээ туслагчаасаа айгаад нэг ч үг дуугарсангүй гэр гэрийн зүг одлоо.

- Пэрэнлэй! Ширээ дэлгээрэй гэж туслагчийг хэлэхэд Базар усны амьтны адгийн үхлээр үхнэ гэдэг үгийг сая ухаарсан ч түүний хар санааг дэмий л зүхэхээс биш, өөрөөр яах ч аргагүйдээ харамсавч баршгүй. Гагцхүү Намбаа Орших хоёр мэдэж байгаа болов уу гэж горилон чимээ чагнана. Пэрэнлэй мүглэнгийн цоожийг түлхэн Базарыг гаргахдаа

- Туслагчтан, мэдээтэй бариарай! Наадхи чинь та бид хоёрыг гавтай гараараа цохиод унагачихаа сийхгүй шүү гэв. Тэр хоёр Базарыг нойтон ширэн дээр унагах үеэр шар шувуу “Хүүг, хүүг” гэж хэдэнтээ дуугарав. Эсгүй хээр шөнө явахдаа шар шувуу дуурайсаар адилхан дуугарч сурсан Намбаагийн хэлцэж тохирсноороо гурван шөнө өгч байгаа энэ дохиог Базар сонсмогц сэтгэл нь тэнийгээд явчихлаа. Урьд нь хоолойгоо чангахан засах буюу худал ханиалган амьд байгаагаа мэдэгддэг байв. Тэгвэл энэ удаа ч юу болж байгааг тодорхой ойлгуулахгүй бол анд нь өөрийн нь аваад явчихыг харанхуйд харалгүй хоцроод амь хохироход хүрэх нь гарцаагүй боллоо. Иймээс Базар

- Таминь ээ! Намайг ширлэж аллаа гэж хоёр дахин байдгаараа хашгирахад туслагч, өргөөний хэн нэг нь сэрүүн байгаад сонсчихоогүй байгаа даа гэж сандарч уурсахдаа

- Алчихна шүү! гэж зангаад толгой руу нь өшигчиж, аманд нь даавуу чихэж

- За одоо чи орилоотох! Дэлхий доргитол орил! гэж тавлав. Оршиход морио бариулж орхиод ойрхон мөлхөж ирсэн Намбаа Базарыг хэлснийг сонсоод суллах боломж гарсанд баярлан зүрх нь лүг лүгхийн цохилон. Тэгээд улам ойртож харанхуйд сүүтэгнэн байгаа хоёр хүний барааг харахтайгаа болов. Тэр хоёр эхлээд Базарын цээжийг битүүлсний дараа гарынх нь гавыг авч доош ахиулан үдэж байлаа. Пэрэнлэй, чамайг хувцастай ч гэсэн ясыг нь янгинуулахаар ширлэх юм шүү гэж занан, нойтон бүдүүн үдээрийг шүдээ зууж байгаад гараа өвдтөл ягштал чанга татан ширлэв.

- Арван хар нүглийн чинь замаар оруулах гэснээс чамайг арав дахь хоног дээр чинь ширлэж байгаа юм. Нүглээ сайн наманчилбал хойт төрөлдөө бурхан болж ч магадгүй. Чиний ёр ч чөтгөр л болно доо гээд туслагчийг даажинтай инээхэд Базар уурлаж хараал зүхэл ч болсонгүй юм ч хэлсэнгүй зөвхөн “Чи тэгж л бай! Аавын хүүгийн аз, алтан шооны нүх гэж үг бий дээ” гэж бодон тайван хэвтэнэ. Ширлүүлсэн Базарыг араг тэгнэсэн тэмээн дээр хөдлөн тавьж даруулав. Пэрэнлэйг мориндоо мордоход туслагч бурантгийг өгөөд

- Шар нохойн хэвтэш шүү. Чи шөнө мунгинаж байгаад хүний зам дээр хаячихуузай гэж захиад

- Туслагчтан, санаа зоволтгүй гээд тахар хөдөллөө. Базарыг орой дээр тодоос тод гялалзаж байгаа зуны шөнийн оддыг ширтэж тэмээний алхаанд зайлагдан явахад нь өөрөө бус, тэнгэр дайвалзан, одод хөдлөөд байх мэт түүнд санагдана. Бут сөөгөнд унтаж байсан болжмор морины хөл дороос хааяа нэгхэн дэрхийн босож шулганахаас өөр чимээ анир үгүй. “Сэр-Од туслагч гэдэг худал инээж байгаад хүн алдаг байна шүү. Муу санаа шүглэсэн хүн гэж ийм л амьтныг хэлдэг байх. Сэр-Од, Агваанлуvsан, энэ тахар Пэрэнлэй мэтийг хорвоогоос тонилгож байвал таарах хүний хог шавхруу чинь л жинхэнэ шулмууд мөн. Би гэнэнээсээ болж ийм шулмуудын гарт орлоо. Түрүүчийнхээсээ хашир суух минь ч яалаа... За дүүрч, ус уухын хувь л мэдэж дээ. Өнөөх хоёр маань дагаж чадсан болов уу? Алдчихсан бол ч би өнгөрчээ. Би ч яах вэ, Юмжирдулам минь яана даа. даанч нас бага, надаас дор гэнэн амьтан. Энэ хорвоог мөн ч зовж гэтэлнэ дээ” гэсэн шаналгаатай хүнд бодолд залуу эрийн сэтгэл шимширнэ.

Намбаа, Орших хоёр тахрын араас бараа алдалгүй дагаж явааг Базар яахин мэдэх билээ.

- Намбаа гуай! Яасан ойрхон явах юм бэ? Тахар та бид хоёрыг харчихгүй байгаа даа гэж айсхийн явсан Оршихыг хэлэхэд Намбаа

- Тэнтэй тэмээ хөтөлсөн хүн барагтай бол арынхаа юмыг үздэггүй юм. Тэгээд ч их харанхуй байна. Харин чи миний араас чимээ гаргалгүй л дагаад яв гэжээ. Тахар их Монголын элсний эх рүү орж ирээд манх сүлжин төөрч будлихгүй явах нь газраа тун сайн мэддэг бололтой. Тахрыг харанхуй татсан нэгэн их хүнхэр манх руу элс нураан гулссаар ороход Намбаа яаравчлан зэрэгцэн очив. Нэг юм нүднийх нь буланд сүүдэсхийх шиг болоход тахар гайхан хажуу тийш хартал Намбаа цулбуураас нь шүүрч авлаа. Тахар эргэн тойрон элсэн манхнаас өөр юу ч үгүй байгааг мэдэх хэрнээ айсандаа хашгирч цулбуураасаа чангаацалдахаар нь

- Галзууралгүй байгаарай! Нударчихна шүү! гэж Намбаа зандрав. Тахар дуугүйхэн аяяа нь дагавал амь гарч магадгүй гэж бодоод номхон хонь мэт хөтлүүлэн явлаа.

Намбаа манхны хонхорт хүрүүт тахрыг мориноос нь хуу татан унагаад бүсээр нь хүлж байхад Орших “Манай хошууныхны зүрхэнд орчихсон догшин тахрыг бариад авдаг яасан зоригтой эр вэ! Эцэстээ юу болдог бол” гэж бодоод баахан айчихсан зогсож байв. Түүний айсныг мэдээгүй Намбаа

- Хүүе, чи наад тэмээгээ бушуу хэвтүүлээч! гэхэд Орших сая ухаан орсон мэт мориноосоо санд мэнд буулаа. Тэр хоёр Базарыг ширнээс салгав. Үхлээс өөр юм бодохгүй болсон залуу эр чийрэг гараараа ачтай хоёр андаа бат чанга тэвэрлээ. Тэд тахар Пэрэнлэйг нүцгэлэн ширлэхэд

- Базар минь, амь авар! Би туслагчийн эрхээр яваа өөрийн мэдэлгүй ядарсан амьтан шүү дээ. Гэдэс тэжээхийн эрхээр хий гэснийа нь хийдэг. Намайгаа өршөөө үзээч! Би туслагчийг орхиж чиний номхон морины чинь ногт, догшин морины чинь чөдөр болж явья! гэж тахар хоолой чичрүүлэн хэлээд энэ насандаа зовлонт хүнийг өрөвдөн нэг ч дусал нулимс унагаагүй атлаа өөрийн амь хутганы ирэн дээр ирэхэд нүглийн хар нулимсаа бороо мэт асгаруулав.

- Аа тийм үү! Ингэж хэлбэл тавьчихна гэж чи горьдов уу? Энэ чинь чиний туслагчдаа хэлдэг үг! Одоо чи зусар зуйрган үгээ түүндээ ч хэлж чадахгүй гэрэлт хорвоогоос салах чинь энэ! Эцгийа минь алсан нүглээ эрлэгийнд очиж шүүлгээрэй! гэж өш хонзонгийн далайд живэх шахсан Базар амьсгал нь цухалдсан мэт бачим харгиа дуугаар заналтай хэллээ. Тэд тахрын эмээл хазаар, хувцас хунарыг араг дотор нь хийж, морь тэмээ хоёрыг нь тавьж хөөв.

Аюулаа ардаа хийж санаа амарсан Сэр-Од туслагч манаагаа тараачихаад, шүлэг нойрон дунд умбан сайхан хатантай хуримлаж байна гэж зүүдэлж байлаа. Гэнэт хаалга дуугарч хүн орж ирэхэд бөх унтсан туслагч арайхийн сэрж, тахрыг гэж санан шүдэнз зурж лаагаа асаах гэж ядаж байтал өнөөх хүн шууд дэргэд нь очиж яах ийхийн зуургүе амыа нь бариад дарж уналаа. Гэрэл гаргахад туслагч, ширлүүлсэн Базарыг өмнөө зогсож байгааг хармагцаа бие нь чичирч, нүд нь гөлийчихөв. Базар

- Авдрынхаа түлхүүрийг өг гэсэнд

- Мэдэхгүй. Зарц шивэгчингүүдэд бий гэв.

- Чи үнэт эдлэл хураасан авдарныхаа түлхүүрийг тэдэнд өгдөг вий! Бушуул! Би яарч байна. Харц олноос чиний луйвардсан юмыг эргүүлж авна гээд дэрийн авдран дээр байсан туслагчийн хутгыг суга татаж
- Түлхүүрээ өгөхгүй бол дарлаа шүү гээд хутганы хүйтэн ирийг төвөнхөн дээр нь тавилаа. Хар хөлс нь чийхарсан туслагч амь гарахын эрхээр түлхүүр хадгалдаг жижигхэн хайрцгаа заав. Базар туслагчийн нүдийг боож үүдэнд хүлээж байсан Намбааг оруулж ирээд авдруудыг захаас нь эхлэн тухтай уудлав. Алт мөнгөн эдлэл, гулууз мөнгө, бөгтөр ембүү, хоргой торго мэт үнэт зүйлийг цөмийн нь ялгав. “Шулманд” амлаж байсан алтан шагай, ембүү хоёр нь ч гарч ирлээ. Туслагчийн ямбаны хувцас, Юмжирдуламд хийлгэсэн бүсгүй хүний гоёл, авгай хувцсыг авч бооход Намбаа
- Наадахиараа яах нь вэ. Новшны нэмэр гэсэнд Базар
- Хамгийн хэрэгтэй юмны нэг энэ. Ид шидийн нь сүүлд үзүүлэмц гээд инээмсэглэснээ дуугүй бай гэж дохио өгөв. Тэгээд бас өмнө хуучрыг авсанд Намбаа их гайхжээ. Базар авсан юмаа гурван том бааданд боож Намбаад өгч гаргаад туслагчийн нүдний боодлыг авлаа.
- Одоо өөрийн чинь амийг л авах үлдлээ гээд Базар хутгаа дахин хоолой дээр нь тавихад туслагчийн царай цусын нь юулчихсэн мэт цонхийж цайгаад хөлс нь цувлаа.
- Утсан чинээ улаан голын минь үлдээ. Юу дуртайгаа ав! гэж туслагч дуудах төдий хэлсэн нь айсандаа дуу нь гарахгүй болсных ажээ.
- Олон жил зарцалж байгаа Пагмыгаа явуулна даа.
- Хэрэгтэй бол ав ав! гээд туслагч “Энэ чинь хатан, шивэгчин хоёулантай минь учир холбоотой байсан байх нь ээ” гэж үнхэлцэг нь хагарч үхэх гэж байсан хэр нь бас хэрэггүй юм бодож хэлэв.
- Одоо би явууллаа шүү.
- Тэгээ тэг!
- Ядуу доордсыг тарчлаан зовоож байдгаа болих уу?
- Хүнийг зовоовол өөрөө зовдгийг мэдэж нэгмөсөн хаширлаа.
- Хөгшин эх, Пагма хоёроор оролдоод, бас Улиастай руу бичиг явуулж намайг бариулах гэж хөөцөлдөөд байвал чинь хичнээн давхар манаатай байсан ч нэг л сүвээр нь орж ирж бодийг чинь хөтөлчихөөд учраа олно шүү.
- Тэгээрэй, тэгээрэй! Би яасан ч тийм юм хийхгүй.
- Худал хэлж хүний гараас мултрахтайгаа зэрэг л муу арга заль зохиож эхэлдэг биш билүү?
- Одоо л амь өршөөдөг юм бол бүр ч тэгэхгүй. Хэн хэндээ хал балгүй алтан дэлхий дээр амьд

явахаа л бодож байна.

- Хоёр дахь удаагаа амийн чинь үлдээе. Гурав дахь удаад цусаар уйлсан ч нэмэргүй гэдгийг мартавзай гээд Базар

- Танай өргөө тамгынхан дотор миний дотнын хүн бий шүү. Ямар нэг хорон санаа цухалзуулбал надад дорхиноо дуулдана. Тэгээд л чамайг санасандаа хүрэхээс чинь өмнө цааш нь харуулчихна гэж хэлээд гарч одлоо.

Орон дээрээ хүлээтэй хэвтэж байсан Сэр-Одын овозож байсан зүрхнийх нь цохилт намсаж, овоо тайвширсан хойноо маш нууцаар ширлэж, өөрийн нүдээр харж байгаад явуулсан хүн нь яагаад орон гэрийн нь талж, амь насын нь бүрэлгэх шахан ам өчгийг нь авсны учрыг олох гэж сэтгэлээ зовоож эхлэв. Эцэг нь уран дархан хүн байсан болохоор хүү нь илбэтэй, ид шидтэй болсон юм биш байгаа даа ч гэж бодож үзлээ. Гэтэл хутагт хувилгаад биш, харц барлаг хүн ид шидтэй байна гэдэг санаанд нь багтамгүй бодогдов. “Тамгынхан дотор миний хамсаатан бий гэдэг нь ортой боллоо. Хэн нь оргодол босуултай үгсэн нийлсэн юм бол? Миний нүдийг боогоод нэг хүн оруулж ирсэн. Тэр л байсан байх. Нэг удаа юм хэлэх нь танил биш дуу байсан. Айсандаа болоод би сайн таниагүй ч байж магад... Базарыг муглэнд хийснээс хойш л хамсаатан нь миний юу хийхийг ажиж эргүүлдээд байж л дээ. Тэгж мэдчихээд л хойноос нь очоод суллагчид байж таарлаа. Тэгвэл түүнийг тахар танина шүү дээ. Үгүй үгүй... Пэрэнлэйг Шар нохойн хэвтшинд Базарыг хаяад буцахад нь хударгаар нь очоод тавьчихсан хэрэг байх нь. Яах аргагүй тэгж таарлаа. Тэр золигийг ирүүлээд амьдаар нь арьс махыг нь зулгаагаад өгөхсөн. Гэтэл хэнийг нь гэж тэгэх вэ? Өргөө тамгынхан цөмөөрөө л муу санахын аргагүй хүмүүс... Гэлээ ч итгэсэн нөхөр дайсан гэдэг тун учиртай үг” гэж туслагч бодоод хүн бүрийн тухай эрт эдүгээгийн явдлыг нэхэн санах гэж оролдов. Туслагч, Базарын хамсаатан гэж оноох хүнгүй болж уймарч хоцроод байтал бүүдгэр гэгээ тооноор тусах нь үүр тэмдгэрч байгаа бололтой.

- За одоо яана! Өргөөнийхөн намайг харагдахгүй болохоор бужигналдаад л ороод ирдэг! Би хүлээтэй хэвтэж байдаг! Эртдийн ойд зодуулсны хов живийг арайхийж дарсан чинь ингэж бас түүнээсээ долоон дор шившиг болоо гэж дээ. Юу гэж хэлнэ ээ... Базарыг дархална гэж худал зарласан минь одоо хэрэг боллоо. Эзэн ноён нигүүлсэнгүй сэтгэлээр өршөөсөн чинь шөнө ирээд манайхыг дээрэмдлээ гэж хэлье. Энүүн шиг сайхан үг байхгүй. Тэгэхээр л өргөөнийхөн Базарын хуншгүйг мэднэ гэж туслагч амандаа үглэж, нэр бүтэн гарах арга олсондоо ихэд олзуурхав. “Базарыг барьснаа Улиастайд мэдэгдээгүй байсан минь ганц онолоо. Хэрэв жанжин жасааныхан мэдсэн бол өөрсдөө шоронгийнхоо ялтнуудыг алддаггүй юм шиг намайг баалах байсан юм” гэж туслагч бодоод Базараас болж юмаа алдсанаас өөр хал балгүй хоцорсондоо бага зэрэг тайтгарч хүн орж ирэхийг хүлээн хэвтэнэ.

Нар ургахаас өмнөхөн Базар, Намбаа Пагма хоёрыг дагуулсаар гэртээ ирэв. Цайгаа самарч байсан эх нь шанагаа тогоон дотроо шидчихээд хүүгээ тэвэрч аван үнсэхэд баярын нулимс хоёр хацрыг нь даган урсана.

- Ямар аргаар хүү минь амьд гараад ирэв дээ. Би гэдэг хүн хүүгээ өөрөө л бариад өгчихсөн юм шиг санаж дандаа л өөртөө гомдон уйлж, тэр шөнө ирж хоно гэж яах гэж хоргоов доо гэж боддог байлаа гэж эмгэн дахин дахин үглэнэ.

- Намбаа гуай Орших хоёр л намайг хэд хоног өдөр шөнөгүй сахиж дагаж явж аминд минь орлоо. Энэ бүсгүйг Пагма гэдэг юм. Туслагчийн өргөөнд шивэгчин байсан юм. Хоёр удаа надад их тус болсон хүн дээ гэж Базарыг ярихад сэтгэл нь догдолсон эмгэн

- Ямар их буянтай амьтны үрс вэ гээд ирсэн гуравтаа цай барьж, идээ тавилаа.

- Ээж ээ! Энэ бүсгүй манаёа байх юм шүү. Танд ханьтай зүгээр шүү дээ гэж Базарыг хэлэхэд эмгэн “Миний хүүгийн л хань болох охин юм байх даа” гэж санаад

- Эш хүү минь! Тийм ачтай тустай охиныг үр шигээ саналгүй яах вэ гэж ихэд олзуурхсан байртай дуугарав. Базар явахынхаа өмнөхөн Пагмад ганцааранд нь

- Чи манай ээжтэй ганц хоёр сар бай! Тэгэхгүй бол Орших та хоёрыг нийлчих юм бол туслагч зовооно. Харин Юмжирдуламыг оргуулсан тухай ээжид нэг ч үг дурсаж болохгүй. Цаад хөгшин чинь гэнэ алдаад нэгэнд нь ярьчихвал бөөн гай чирнэ шүү гэж аминчлан захилаа. Тэднийг мордоход эмгэн

- Хүү минь, ээж нь нэгмөсөн хаширлаа. Одоо гэр рүүгээ давхиж хэрэггүй. Хааяа нэг ээждээ бүлээн зүсээ үзүүлж байна биз. Чамгүй бол хөгшин толгой амьд явахын ч хэрэг алга гэж учирлан гурвуулангийнх нь дөрөөнд сүү дусааж, ерөөл хэлсээр цацал өргөн үйлдлээ.

Базарынхаа хойноос сэтгэл шаналан нулимс цувуулахаас өөрөөр яах ч аргагүй болон мухардсан Юмжирдуламыг хэзээ, ямар сураг дуулдах бол гэж гайхаш баран зүрх шимшрэн сууж байтал гэнэт агуйн амаар гэрэл харван хэдэн хүн орж ирэх шиг болсонд өөрийгөө барихаар ирэв хэмээн санаж агуйн мухрын нэгэн хонгилд ярган нуугдаж хярсан туулай мэт нам боллоо. Тэгтэл Базарынх нь хоолойгоо засах содон дуу гарав.

- Юмжирдулам аа! гэж дуудахад Юмжирдулам хоолой нь тагжирсан мэт хариу дуугарч чадалгүй өөдөөс нь очих тэнхлээ барсан юм шиг тэндээ суусан чигээр гэнэт часхийтэл цурхиран уйллаа. Базар түүнийг энхрийлэн, хэлмэгдэж зовсон сэтгэлийнх нь тайтгаруулах гэж оролдов. Базарынхаа барааг харахаасаа нэгэнт өнгөрч, амьдралынхаа алтан жолоог алдлаа гэж гутран, сэтгэлээр уначихаад байсан Юмжирдулам аз жаргалтай дахин учирсандаа баярлан бас л баахан уйлав.

- Нөхрийгөө амьд эргээд ирж байхад чи чинь улам уйлж дуулаад байдаг яасан хачин хүн бэ! гэж Намбааг гайхан шогшоход Базар

- Яах вэ, уйлаг! Амссан зовлон нь нулимсаараа урсан гарч байгаа юм. Дотроо цүлмэтэл уйлаг! гээд бүсгүйн уйлж байгааг юман чинээ бодсонгүй сууна. Юмжирдулам ханатлаа уйлж аваад нулимс мэлтэгнэсэн нүдээр Базарыгаа харж инээмсэглэх нь сэтгэлийнх нь хүлээс одоо л нэг тавигдав бололтой. Тэдний хүрч ирсэн нь агуйн дотор нарны гэрэл цацрах шиг бүсгүйд санагджээ. Юмжирдулам инээн баясан босож гал түлэн цай, хоол зэхэж, тэд хоорондоо ярилцаж, арваад хоног эл хуль байсан харанхуй хүйтэн агуй нь амь орсон мэт бүлээн дулаан амьсгалаар дүүрч, гэрэл гэгээтэй боллоо. Базар баригдаж, Намбаа ирлээ ч гэсэн шинэ махтай залгах завдал гараагүй болохоор тэд борцтой хоол идлээ. Арваад хоног хэлэн дээрээ бараг юу ч тавиагүй, хааяа нэг унд буцалган ууж байсан Юмжирдулам ч сэргэн, хоол унданд орж, олон

хоног уйлсаар, харсан хүний сэтгэл эмтэрмээр болсон царай зүс нь ч туяараад ирлээ.

Базар авчирсан юмаа задлан хуучир шанз хоёрыг Юмжирдулам өгөв.

- Намайг эзгүй хойгуур ганцаараа уйдаж суухаар хөгжим оролдож сур! Хоёулаа агуйнхаа мухарт сайхан дуу сонсож суувал хэн хэний маань сэтгэл сэргэнэ шүү дээ гэж өгүүлэхэд нь

- Нэг насаар агуйн мухар сахина гэж бодоод нөхөр хийх гэж авчирсан юм биз дээ гэж Юмжирдулам инээвхийлэв.

- Орон гэр төхөөрөөд эцгийн голомтыг бадраа хүн шиг аж төрж суух ёстой улс ингэж чоно шиг хонгил сахиж сууна гэдэг мөн бэрх ээ! Хэрэв үр хүүхэд гарвал хүний бараа харахгүй чоно шиг л амьтан болох байх даа гэж Базар хэлээд санаа алдахад Намбаа

- Заяа тавилан иймээс хойш дагахаас өөр яах вэ. Тэгэхгүй гэхээр дээдсийн зоог болчих гээд байх юм чинь гэж арга тасарсан байртай дуугарав. Ганцхан шөнийн дотор болсон явдал Оршихын сэтгэлд багтах нь байтугай зүүдэнд нь ч оромгүй санагдаж, яагаад чингэж амжсаныг эргэцүүлэн бодох тусам хүнд хичнээн арга ухаан байдгийг сэхээрэн урам нь сэргэлээ. Түүний жил тойрон эргүүлээд туслагчийн гараас салгаж авч бараагүй байсан хүүхнийг нь Базар хоромхон зуур салгаж өгсөнд баярлан хөөрсөн Орших

- Аз дайрч Намбаа гуай ирж, Пагма хэл болоогүй бол би гэж нэг урагшгүй амьтан мэдлээ ч Базарыг суллаж дөнгөх байсан гэж үү? Туслагч, тахар гээд л тэр тамгынхныг чинь хүн ойртох аргагүй эртэй чадалтай, идтэй шидтэй улс гэж боддог болохоор айгаад ойртож ч чадахгүй байсан байх. Тэгсэн чинь гурвуулхнаа хэрнээ тэднийг чинь мөн ч амархан дөнгөлөө шүү. Гурван хүн ингэж байгаа юм чинь олуулаа бол ёстой баллаж тавих юм байна гэсэнд Базар

- Оршихын хэлдэг ортой шүү. Гэтэл хоёул гурвуулхнаа чинь бас л нэг дэмий бололтой. Улиастайн шоронгоос сулласан хүмүүсээ гаргаад орхичихоор, ярьж хөөрч эвсэж нэгддэг л байж. Тэд одоо бидний л адил ганц хоёроороо болдогсон бол огтнын нүхэнд ч гэсэн орохсон л гэж яваа. Хэрэв олноороо нийлээд буу шийдэмтэй болчихвол юунд ч дийлдэхгүй шүү. Намбаа гуай! Ер нь хань ижилтэй болцгоох нь зөв юм биш үү? гээд Намбаа руу харлаа. Намбаа сэгсийтэл ургасан өтгөн хууз сахлаа шувтран илж, дурамжхан янзтай доош харан сууснаа

- Тэр хар заарцаг болсон олон хүнээр юу хийнэ. Өөрийгөө л барьж өгөхийн цондон. Олон дотор ганц ташуурын пян даахгүй олиг муутай эр явж л таарна. Баригдахаараа байдгаа хөвнө. Зарим нь чи, би гэлцэн дур дураараа зүтгэнэ. Тэгж хөгөө хөлдөө чирснээс ганц хоёроороо байсан нь хавьгүй дээр. Арга ухаан зарж ноёд дээдсээс өшөөгөө аваад л... олсон жаахнаа ядуу доодчуудтайгаа хуваалцаад л явбал барав. Тэгвэл тэр яах бол, энэ яах бол гэж дотор санаагий нь мэдэхгүй хүний төлөө сэтгэл зовох юмгүй амар шүү дээ... гэж шуудхан хэлэхэд “Ханьтай бүлтэй байхаас дургүйцдэг хачин хүн байх гэж. Олуулаа байвал би л айхгүй дэг. Дэндүү цөөхүүлээ байна гэдэг ч аймшигтай юм. Тамгынхан энэ агуйг мэдчихээд бид хэдийг ингэж суутал ороод ирвэл дүүрлээ шүү” гэж бодсон Орших “Бурхан минь” гэж амандаа шивнээд үүд рүү айсан харцаар хяламхийснээ

- Олуулаа болдогсон бол ч сайхан л байна гээд Базарыг санаа нийлэх байх гэж горилсон бололтой харлаа. Базар Намбаагийн хэлснийг эргэцүүлэн бодож хэдэн хором дуугүй байснаа

- Намбаа гуай манийг бодвол олон оймс илүү элээсэн болохоор эрхбиш учир мэдэж байгаа биз. Нээрээ ч олон хүн сайнтай муутай болохоор гай болж занганд орж мэдэх л юм гэж хэлэхэд Орших баахан гонсгор хоцорчээ.

* * *

Хүний амийг золбин нохойноос доорд бодож хийсэн нүгэлт хар хэргээ туслагч бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй гэж түүний нууцад сэтгэл ханаж, харин ч хишиг шан авахаа бодож уужуу тайван явсан тахар Пэрэнлэй өштөнийхөө гарт өөрөө орчихоод манхны ёроолд ширлүүлэн хаягдахдаа үе үе чимээ чагнан тэр шөнөжингөө орилсоор хоолой нь сөөнгөтжээ. Хааяа нэг тэмээ малын эрэлчин явахаас бусдаар хэн ч зүглэхгүй элсэн анхан дунд түүний дууг хэн сонсон ирж аврах билээ дээ. Маргааш нь нар мандахдаа зовлонг нь улам ч нэмлээ. Нар шарсаар байтал шир нь хатаж хамаг биеийг нь баглаж, халсан шир биеийг нь тэсэхүйеэ бэрх болтол жигнэнэ. Хөдлөх аргагүй болохоор нүүр нь түлэгдэн хорсож байснаа сүүлдээ мэдээ алдав. Ам нь ангаж дотор нь халуу шатах шиг санагдана. Дэмий л шүлсээрээ эвэрсэн уруулаа шилэмдэж байв. Амьтан хүн тааралдаж магадгүй гэж бодон хааяа хааяа орилоход эхэндээ манхны цуурайнд дуу нь сонсдоод байх шиг болсноо үдээс хойш цуурай ч гарахгүй элсэн манхан дүлий юм шиг цайран харагдахад сэтгэлээр бүр ч уналаа. Тамир тэнхэл нь барагдаж, дуу нь гарахгүй болсноо өөрөө мэдсэнгүй. Ихэс дээдэйтээ үнэнч явсаар байтал ингэдэг байжээ гэж гайхан лам, бурхнаа дуудан сэтгэлийн гүнд хичнээн сүсэглэвч тусыг эс олов. Тэгээд бүр цөхрөхдөө туслагчийн балгаар л сүйрч гүйцлээ гэж санан Сэр-Одыг харааж зүхлээ. Тэгтэл өвгөн дархны үзэн ядсан зэвүүн харц өөдөөс нь ширтэж, банздуулж салмарсан цус нөж болсон чөргөр гуя нь үзэгдэж “Пэрэнлэй, чи нэг насаар хүний махаар хооллохгүй шүү. Нэг л цагт чи хүний маханд хахаж үхнэ дээ. Би үздэггүй юм гэхэд бусад нь үзнэ дээ” гэж заналтайяа хэлж байсан нь сонсдох шиг болоход мухар сүсгийн мананд төөрсөн тахар нүдээ аньж, бурхан миний хийсэн нүглийг үзүүлэн намайг гэсгээж байна гэж бодон “Балданлхам минь! Туслагч тэгснээс би тэгээгүй шүү” гэж залбирав. Амь нь тэмцэж, болдогсон бол тийчилмээр байвч гарынхаа хурууг ч хөдөлгөх аргагүй яг л бариад гагначихсан юм шиг болжээ. Нар баруунаа гудаэхад цоинотол шарах нь багассаар шөнө болоход амь тэмцэх нь намжлаа. Гэвч өдөржин нэвт халсан шир тийм ч амархан хөрсөнгүй. Хоёр дахь шөнөө арай л амьсгал хураачихсангүй өглөөтэй золгов. Нар шарж эхэлмэгц уруул нь хатаж омголтон эвлэхээ болиод хамаг биенийх нь мэдээ алдарч, нүдээ нээхэд юм бүрэлзээд байдаг боллоо. Нүүр нь түлэгдэж харлаад хамар нь хавчийж, хоёр навч нь бараг нийлж, амаараа дөнгөж амьсгалсан болж байлаа. Ухаан нь нэг орж, нэг гар÷ элий балай болов. Гэтэл нүүрэн дээр нь нэг юм сүрхийгээд хүрэх шиг болохыг дөнгөж мэдрээд, хүн ирэв үү дээ гэсэн бодол бүүр түүрхэн орж, нүдээ нээн харсанд нүүрийг нь нэг хар юм бүрхээд шувууны толгой шиг юм бүрэлзэн үзэгдэхэд манарсан сэтгэлд айх санаа тэрхэн зуур төрж тэнхээгээрээ орилохыг оролдов. Хараахан амь тавьчихаагүй болохоор түүний цээжнээс хэрчигнэж хоржигносон бөглүү дуу гарсанд толгой дээр нь суусан хон хэрээ соргог амьтан болохоороо цочин нисэж дээш хөөрөөд агаарт эргэлдэж, тахарт нэг ойртон, нэг холдоно.

Туслагч Сэр-Од, хэн ч мэдэхгүй гэж бодсон нууцаа задруулсан Базарын хамсаатныг олчих

санаатай өргөө, тамгынхны хүн толгойтой бүхнийг хянуур гэгч нь ажиж шинжин, битүү далдуур юм асууж сонжсоор өнжлөө. Пэрэнлэйг ирэхгүй байгааг гайхаж гэр рүү нь хэдэн удаа хүн явуулсан боловч хариугүй байв. Тэгээд ямар ч сураг гарсангүй. Тахрын морь үүрээр сүрэгтээ ирж нийлсэн боловч уг хэргийг нууцлан хийснээ улмаас түүнийг ямар морь унаж явсныг адуучид мэдээгүй учир санаанд орсонгүй. Тэмээ нь элсний бүүрэг дайжин ногоо хөөн алга болжээ. Тэгэхээр Пэрэнлэйн тухай сураг таамаг гарах аргагүй болжээ. Тахрыг алаад хээр хаячихсан буюу эсвэл хүлээд тавьчихсаны алин болохыг мэдэхээр маргааш нь Сэр-Од итгэлтэй хоёр хиа дагуулан мордлоо. Төөнөм халуун наранд элсэн манхан дамжин өөд сөөргөө хэйг тэнэж байгаа туслагчаасаа хаа хүрч, яах гэж яваагаа асуух зүрх хоёр хиад байсангүй болохоор хааяа нэг бие бие өөдөө гайхсан нүдээр харж туслагчийг хаашаа л зүглэнэ, тэр рүү нь морины жолоо залж явлаа. Туслагч Шар нохойн хэвтшийг олохгүй ихэд мунгинаж байж үдийн алдад энэ л байх гэж санасан манх руу өнгийтөл хоёр араг нүдэнд нь туслаа. Түүнээс холхон нэгэн гулдгар юм байхыг туслагч хармагцаа айж зүрх алдан давхийв. Тэднийг манхны хонхор руу буутал гулдгар хар юман дээрээс хон хэрээ сүрхийн босож, горр-н, горр-н гэж дуугарсаар нисэж одлоо. Хоёр хиа бас л айж гайхсан харц солилцов.

Тахар Пэрэнлэй ширэнд боолттой амьсгал хураачихсан хэвтэнэ. Хоёр ухархай нь хүнхийж улайгаад тун ч аймаар ёозгүйг хэеэ юун. Тэд айн ширвээдэж маань уншин залбирцгаав. Хоёр хиа юу болох нь энэ вэ гээд туслагч руугаа харлаа. Туслагч тэдний өөдөөс эгцлэн харж чадсангүй, харин энэ хэргийг юу гэж булзааруулж өөрөө гэм зэмгүй мултрах вэ гэж бодож байв. Буцах замдаа туслагч арга заль зохиож амжжээ.

- Би задарсан боолууд мэдвэл замаас нь суллачихаж магадгүй гэж хаширлахдаа Базарыг дархалж тавина гэж зар тараагаад өөрийг нь ширлэж Улиастай руу хүргүүлэхээр тахар Пэрэнлэйг явуулсан юм. Хэн ч мэдэмгүй юм ийм болчихдог тун хачин... Манай тамгынханд элэг буруутай хүн байдаг юм биш байгаа даа гээд харсанд хоёр хиа нь бид хоёрыг сэрдээгүй байгаа даа гэж эмээн гөлөлзөв.

Энэ явдлын тухай санаанд оромгүй сонин яриа хуурай өвсөнд ассан түймрийн дөл мэт хошуу нутгаар тарлаа.

- Дархны хүү Базарыг ширлээд Улиастайд хүргүүлэхээр явуулсан чинь Базар биш тахар Пэрэнлэй болчихсон байна гэнэ.

- Туслагч тахар хоёр хоёулхнаа харанхуй шөнө ширлэсэн гэдэг шүү.

- Өнөөх Намсрайн охин чинь шулам биш, манай нутгийн савдаг байсан гэнэ хөөе.

- Ширлүүлсэн хүн чинь тахрыг яаж ч чадахгүй шүү дээ.

- Тэгсэн чинь манай нутгийн савдаг буянтай Базарыг нь нүгэлтэй тахраар солиод, Пэрэнлэйг Базарт нь хөтлүүлээд явуулчихсан юм гэнэ шүү дээ.

- Тэр Базар чинь Шар нуруу хавиар бэжээ гэнэ ээ!

- Тэгвэл нутгийн савдагтайгаа нийлчихсэн юм биш үү, таминь!

- Тэгж таарлаа. Хөхөө Намжил гэдэг сайхан эрийг Алтайн савдагтай нийлсэн гээд л ярьдаг шүү дээ...

- Савдагтай нийлсэн бол Базар яаж дийлдэх вэ. Түүгээр оролдвол эргээд өөрийн нь толгойд буух юм байна гэж сүсэгтэн олон ярьцгаан Шар нуруу хэмээх олон ам судагтай, хүглийсэн ой хөвчтэй уулын зүг гүн бишрэлтэйгээр ширтэн, цайныхаа дээжийг өргөдөг болжээ.

Хорин тавдугаар бүлэг

Мухардал

Үйлийн үртэй энэ л хорвоод

Үнэнийг эрсэн нь хохидох амуй

Улиастай хотын хоёр талын байшингийнх нь дээвэр золгох шахсан гудамжаар өөд сөөргөө хөлхөх олны хөлөөр боссон бор тоос намрын цэлмэг тэнгэрт бур бурхийн дэгдэж агаар улам ч бүгчимдэнэ. Урд урдаасаа харсан пүүс, мухлаг, гуанзны хатавч хатавчаа түшсэн хаалга бүхнээр суман нүхтэй огтно мэт орон гаран, энэ тэрийг шохоорхон яваа түмний дунд ганган хээнцрээрээ хүн хүний хараа булаасан цэл залуу ноён хатан хоёр нэгэн ахимаг хиагийн хамт харц дээгүүр ихэмсэг бардам алхана. Зөрөн өнгөрөх дэгжин шаавай хүүхнүүд идэр ноёны ид хавыг эчнээ бахдан, бас ч нууцгай хүсэмжлэн, сэм сэмхэн харц чулуудаж, харчууд нь хөөрхөн хатны царай дээр нүд унагана. Тэр гурав өөрсдийн санаа бодолд нийцэхүйц баян пүүс эрэн явсаар нэгэн элбэг дэлбэг юмтай пүүсэнд ороод явчив. Залуу ноён доторхи юмыг тоомжиргүй гүйлгэн харснаа санаанд чинь таарч байна уу гэсэн бодолтой хиа руугаа харлаа. Дотор хаалганыхаа дэргэд зогсож байсан данжаад, царайлаг хатан ороод ирэхийг үзүүт сүйжин шилнийхээ цаанаас бүлтэртэл гөлийн ширтэж байхыг ажиж амжсан хиа ноёныхоо чихэнд гараа барин шивнэж байгаа дүр үзүүлж

- Ноёнтоон! Энэ тийм ч баян пүүс биш бололтой. Арай дөнгүү юм олж наймаа хэлэлцэнэ байгаа гэж данжаадад дуулдахуйцаар чанга хэллээ. Тэгтэл ч данжаад хүрч ирээд

- Эрхэм ноён та амархан сайн морилж явна уу гээд нахилзлаа. Залуу ноён хариу мэндлээд түүнийг данжаад нь мөн гэж таамагласан хэрнээ

- Та энэ пүүсний юу нь вэ? гэж асуув.

- Ай би их данжаад нь байхгүй яах вэ!.. Эрхэм ноён өчүүхэн манайд морилон орваа. Тэнд зогсож юу хийнэ. Манайд сайхан сайхаан юм их бий шүү. Таатай сууж байгаад үзэхийг би гуйж байна. Ноён таны санаанд нийлбэл дуртай юмаа авбаа гээд засдаг инээдээр хачирлаж, лангууныхаа дотогш орох хаалгыг нээв. Ноён хиа хоёр бие бие рүүгээ харснаа орлоо. Данжаад тэднийг нэгэн тохитой өрөөнд дагуулан ороод суусны дараа

- Энэ таны хатан баа? Үгж асуугаад ноёныг толгой дохиод

- Ийм залуу ноён ийм сайхан хатантай байхгүй яах аа гээд шав шар савар шүд гарган илбэдэх мэт инээхдээ ус гүйлгэсэн цийлэн нүдээ хатнаас салгаж чадсангүй. Нэгэн залуувтар иргэнийг орж ирэхэд данжаад нанхиадаар хэдэн юм хэлсэнд цаадхи нь бөхөлзөн бөхөлзсөөр гарлаа.

- Манайд наймаа хийхээр яваа бололтой маш баян ноён ирээд байна. Энэ залуу ноёны сэтгэлийг булааж чадах хамгийн нарийн зоог, дээд сайн сархад тавьсан будаалга төхөөр! гэж хэлжээ.

- Эрхэм ноён таныг манай пүүсээр морилон ирсэнд өчүүхэн би маш баяртай байна. Одоо тантай сайхан танилцах их дуртай байна. Таныг хэн гэдэг ваа? Гэж Данжаад асуугаад ноён хатан хоёрын өмссөн зүүснийг нэгд нэгэнгүй ажин шинжиж, цаанаа яасан их баян бол гэж дотроо гайхан шагширч суув. Гэнэт нэр усыа нь асуусанд залуу ноён түгдэрсхийсэн авч хошуу нутгаа хэлбэл хожим өөрийгөө занганд хийнэ гэж санаад

- Манайх Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу л даа гэж буруулан хэлсэнд данжаад

- Над шиг далай нэртэй лаа гэж үг хавчуулав.

- Би тэр хошууны ноёны тэргүүн туслагч. Миний нэр Гүрдорж гэж ноёныг хэлэхэд

- Данжаад их сайн, их сайн гэж амандаа давтан маасалзан инээж толгойгоо дохиж байлаа. Залуу ноёны тамхины уутны тээглүүрийн алтан ембүү, хэт хутганы бэлд зүүлттэй алтан шагайг харсан Далай данжаад “Энэ ноён алтан дотор бөмбөрдөг байхаас зайлахгүй. Хай яа, яасан баян байна! Ийм ноёнтон их гарын наймаа хийхгүй яах аа! Би яасан азтай данжаад вэ! Өөр пүүсэнд алдсан бол ёстой тусгүй юм болох байсан шүү” гэж бодон түүнээс хэрэгтэй юм салгаж авахаа л бодож байлаа. Тэгтэл түрүүчийн иргэн орж ирээд нэг юм шулганасан нь зоог бэлэн болсныг айлтгажээ.

Тэд өөр нэг чамин засалтай өрөөнд орж дотор газрын амттан бүхнийг алаглуулан өрсөн зоогийн ширээнд сууцгаалаа.

- Манай ёсонд хиа хүн ихэс дээдэстэйгээ эн чацуу суудал эзэлдэггүй учир бийг данжаад та болгооно уу. Манай хиа, танай бичээч даамал мэт хүмүүстэй хамт хооллог гэж залуу ноёныг хэлсэнд

- Хай, би ёс алдсан байна шүү. Эрхэм ноён та өршөө ваа! гээд нанхиадаар нэг юм хэлсэнд тэр нь хиаг дагуулж гарлаа. Данжаад ноён хатан хоёрт тал засан ид, уу гэж сайхан сайхан хоолоор дайлж, гайхуулах бодолтой тавьсан зүйл зүйлийн архиар шахаж хоёр гараа дэлгэн нахилзан долдогонож байлаа. Данжаад наймаа хийхийг хорхойтон юм юм асуухад залуу ноён үгээ цэнэж хааяа нэгхэн дуугарна. Тэгтэл нэг бичээч орж ирээд баахан юм ярьж, данжаад нь нүд бүлтийлгэн, гайхан толгой сэгсрээд байхаар нь залуу ноён өөрийнхөө тухай юм яриагүй байгаа даа гэж бодон баахан сэжиглэнгүй ажна. Гэтэл бичээч

- Энэ ноён тийм гэж баримжаалах аргагүй баян гэнэ. Хөндий дүүрэн адуутай гэнэ. Хонь нь хорь гучаад айл дээр байдаг юм байна. Өөрөө хичнээн малтайгаа ч сайн мэддэггүй гэнэ. Хиа нь хоол идэж байхдаа сая ярилаа. Би таныг ноос сураад байсан болохоор ноёных ноостой юо гэж асуулаа. Тэгсэн чинь хэдэн байшин дүүрэн ноос бий гэж байна. Одоо ингээд өвөл болохоор олон анчин булганы анд явуулах гэнэ дээ. Танд яаран дуулгавал хэрэг болох юун гэж саналаа гэж бичээч эзэндээ тал олох гэж гүйн ирж дуулгаад гарчээ. Хиа нь ноёныхоо хэлснээр түүний хязгааргүй баян хүн болох тухай хоол идэж суухдаа ярьсныг бичээч нь ийнхүү данжааддаа уламжилжээ. Далайн царайд сэтгэл хангалуун хүний мишээл тодрохыг ноён ажаад муу юм болохгүйг таамаглав. Далайн долдой зан гаарч, ам ангайх бүртээ ноёныг магтан сайшаасан үг урсгаж, сархдаар шахах нь түүнийг согтоож орхивол наймаа унацтай

болно гэж санасных байжээ.

- Би нас залуу болохоор сархдад төдий л дуртай биш... Таны хүндэтгэн дайлсанд гялайлаа гээд залуу ноёныг өндийхөд хатан ч шурхийн бослоо.

- Ай, их ноён та жаахан суухгүй яасаан? Манай идээ будаа таны таалалд нийцсэнгүй юу? Би дахиад сайхан зоог хийлгэе гэж данжаад мэхэлзэв.

- Гялайлаа, данжаад гуай гэж ноёныг хэлэхэд данжаад

- За тийг бол яах аа гэж дурамжхан мэт дуугараад

- Та манай барааны агуулахаар одоо сонирхоно уу. Их ноён таны таалалд нийцвэл жаахан наймаа хийваа гэж алга хавсран тонголзов. Данжаадын ингэж хэлсэн нь залуу ноёны санаснаа гүйцэлдүүлэхэд тун ч таатай шалтаг боллоо. Тэгээд хиагаа дагуулж нүд хужирлам нарийн бараа хураасан агуулахад орлоо.

- Их ноёнтон, та энэ сайхан эрээн алаг хивс аваад ноос өгвөл их сайн байна гээд данжаад зарц нараараа том жижиг хивс задлуулж харуулна. Булгаар, торго дурдан, бал бурам юу байдгаа данжаад үзүүлэн магтаж

- Ай, их ноёнтон, та манай пүүснээс юу дуртайгаа ав аа гээд түүний амнаас нааштай үг гарах болов уу гэж горилсон бололтой нүүр өөд нь харав.

- Би Эндхийн хэд хэдэн пүүсээр орлоо. Танай пүүс хамгийн баян нь бололтой. Ийм пүүсний данжаадтай наймаа хэлэлцэж болох л юм гэж ноён худал магтсанд данжаад хөөрч

- Ёстой үнэн шүү. Энэ Улиастайд манай пүүс шиг том пүүс байхгүй лаа. Манайд юм юм байна. Та юу авнаа? гээд хоргоож гарлаа.

- Авмаар юм ч байна. Гэхдээ би тэмээн хөсөггүй ирсэн болохоор тиймхэн байна санж гэж ноён хэлбэл данжаад

- Тэр яах аа. Манайх хүн гаргаад тэмээгээр хүргүүлээд өгч бололгүй яах аа. Наймаа таарвал Далай данжаад маапаангүй шүү гэхээр нь

- Би эндээс буцаж очуугаа Да хүрээ орж Богд эзэндээ өргөл өргөх гэж байгаа юм. Тийм болохоор эндээс тавин лангийн ембүү хоёр зууг олж авахаар ирлээ л дээ. Далай гуай та энэ хэргийг бүтээвэл бусад талын наймаа хэлцэж болох л юм гэхэд нь

- Хоёр зуун ембүү юу ч биш ээ... Харин их ноён та булганы арьс олж өгч болохсон болов уу? гэж данжаад бичээчээсээ дуулснаа бодон асуулаа.

- Манайх өвөлд наад зах нь мянга гаргаж булга агнадаг гэж ноёныг хэнэггүй хэлсэнд данжаад толгой сэжин шогширч

- Ай! Ноён та надад мянган булга агнуулж өгваа. Бас надад хонины ноос, эр хонь хэрэгтэй

шүү гэхэд

- Тэр зэргийн юм бололгүй дээ гэж ноён ам бардан хэлсэнд данжаад ихэд олзуурхав.

- Ийм их ноёнттой наймаа хийхэд ёстой сайхан шүү. Ямар ч маапаан байхгүй гэж данжаад хөл алдан “Мянган булгыг дотор газар аваачиж сайн сойвонгоор малгай оёулаад эргүүлж зарахад энэ үхэр монголууд ухаан алдан үнэ хайрлахгүй авна” гэж хожоо бодож амжлаа. Хиагийн ярьсан хуурмаг үгэнд Далай данжаад бүрэн итгээд өөрөөс нь их юм салгаж авахаар санаархаж байгааг ноён гадарлаж дурамжхан байдал үзүүлбэл илүү үнэмшиж шуналынх нь ов хөдлөх биш гэж бодоод

- Танайхаас бага сага юм авч болох л юм. Гэхдээ би бас өөр пүүсээр орно. Манайд хэрэгтэй юм байж юу эс вэ? Та юмаа их магтаад байгааг харахад цагтаа тулахаар үнэрхэж мэдэх хүн шиг байна гэхэд наймааны аяс хожоогүй тал руугаа эргэх нь гэж мэгдсэн байдал данжаадын царайд илрэв.

- Ай, их ноён та олон пүүс хэсвэл алжаана шүү. Улиастайн аль ч пүүсэнд байгаа юу манайд цөм байна. Би лоосуутай юм ярих тун дургүй. Юу хэрэгтэйгээ манайхаас авбаа. Манай юм бас тийм ч үнэтэй бишээ гэж Далай хэлээд энэ ноён юу гэх бол гэсэн бололтой нүүр өөд нь горьдож царайчилсан харцаар харна.

- За тийм бол тантай ярилцахаас даа гэж ноён хэсэгхэн дуугүй байснаа ам нээсэнд Далай

- Тэгэхгүй яах аа. Та бид хоёр хамгийн түрүүн танилцсан баа. Одоо их сайн түнш болноо шүү гээд маасалзан инээлээ. Ноён жаахан юм салгаж аваад эртхэн хөдлөх нь өлзийтэй байх гэж санаад

- Та давын өмнө надад Богд эзэнд өргөх таван лангийн ембүү хоёр зууг өг дөө. Танаас хэдэн хуй торго, дурдан, чисчүү, жангийн хивс, цааһан жин чихэр боов авъя. Энэ удаад гурван тэмээ ачаанаас илүү юм хэрэггүй. Ембүүнээс бусад юмандаа дандаа сайхан морьд өгье. Би хэсэг сайн морь авчруулсан. Манай зарц Чигэстэйн голд хариулж байгаа. Харин ембүүндээ та булга авна биз. Танайд тийм их хэрэгтэй юм бол мянгаас илүү ч булга өгч болно. Ноос авах бол зуугаас доошгүй аттай очоорой! Одоо надад гурван хомтой тэмээ өгвөл болно биз. Манай хиа юмаа аваад яваг гэж хэлээд Намбаагийн Ховдын хязгаараас хөөж авчирсан морьдоос хэдий нь өгч энэ данжаадыг хар санах юмгүй болгоод үлдсэнийг нь хурдхан мөнгөөр зарчиод юм байна гэж бодлоо. Энэ ноён надтай наймаа хийхгүй бол санаандгүй суутал өөрөө ороод ирсэн бөөн олзыг ондоо пүүсэнд алдах хэрэг болох нь дээ гэж санаа зовж, дайлж байхдаа л ноён хатан хоёрт бэлэг барьж сэтгэлийг нь засаагүй минь гай боллоо гэж хар толгойдоо хар буун дотор хүний нарийн ов заль зохиохсон гэж ядан байсан данжаадын сэтгэлийн түгшээ арилжээ. Далай амандаа орсон олзоо алдаагүйдээ баярлаж, хэлсэндээ хүрдэг хүн болох гэж нэрэлхсэндээ

- Ийм их ноёны хүссэнийг өгч чадахгүй бол энэ пүүсний данжаад болж юу хийнэ ваа гэж бардуу дуугараад, зарц нартаа баахан шулганасанд тэд энд тэндээс өнгө өнгийн торго, амтат боов, алаг эрээн хивсийг гарган үзүүлж, алий нь авах вэ гэж дур сонгуулж эхлэхэд ноён, хиа хоёр өөд өдөөсөө харан нүд ирмэлцэн инээмсэглэжээ.

Тэр өдрийн оройн нар шингэж байхад гурван тэмээ ачаа хөтөлсөн гурван морьтой хүн Улиастай хотоос хойш өртөө илүү газар байдаг Хатавчийн даваа хэмээх үргэлжилсэн том уулын арéí ой руу орж явчихав. Тэд ойн цоорхойд бууцгаан, бие биеийг харан инээд хөхрөлдөөн болж, энд иртэл сольж амжаагүй ямбатан дээдсийнхээ хувцсыг тайчлаа.

- Отго жинстэй, өнгөтэй хувцастай хүн үзэхээрээ үхнийã нь ч мэдээгүй байж долоочих шахан бөмбөлзөхийг яана! Улиастайд ч, хаана ч ноён баяд гэдэг цөм ижил долдой зантай юм шив. Ийм ч хуурамч хорвоо байх гэж! хэмээн Базарыг тохуурхсан жигшсэн өнгөөр хэлэхэд Наíбаа

- Тэр данжаад одоо нэг мундаг баян ноёнттой түнш болсон гэж бодон мөн ч маадгар байгаа даа. Тэнэгтэйгээ адил нэрэлхүү гэдэг нь! гээд уул цуурайттал хөхрөв.

- Ингэх л санаатай туслагчийнхаас энэ хувцсыг авсан юм. Юутай ч гэсэн санасан хэрэг бүтлээ гээд Базар дараа хэрэг болж магад гэж санаад ямбатны хувцсаа нямбайлан эвхээд далд хийж байхад Намбаа “Эр хүн ийм ханьтай хаа ч явсан яах вү. Зоримог сэргэлэн хоёр нь дэндэж гал руу үсрээд орчихгүй бол юмны аргыг олох л залуу” гэж андаа бахдан бодно.

Базар Намбаа хоёрыг ачаагаа буулгах зуур Юмжирдулам хуурай гишүү цуглуулан гал түлэхэд хөнгөн цэнхэр угаа хөвч ойн дунд хөшиглөн тархаж, төдөлгүй хээрийн аагтай цайны үнэр ханхийв. Тэр гурав галын захад сууцгаан цайллаа. Базар аягатай цайндаа хэдэн танзуур хөвүүлэн оочилж

- Дассан газраа өөрийн дураар суух ч Далай данжаадын дайлуулж байснаас хавьгүй сайхан байна шүү гэхэд

- Би тэгэхэд юу болдог бол гэж мөн ч их айж байсан шүү. Бас тэр гоё боов, чихрийã нь харахаар хорхой хүрч идээд л баймаар санагдсаныг яах вэ. Хэлнийхээ үзүүрийг зуучихаад л тэсэж суулаа гэж Юмжирдуламыг өгүүлэхэд

- Юмжирдулам ч ёстой их юм үзэж өнгөрөөсөн ноёны хатан шиг тоомжиргүй царайлж дөмбийж суусан шүү гээд Базар инээв.

- Би ч хамт хоол идсэн хэддээ ноёныгоо баян гээд л бурж гарсан чинь сониучилж шохоорхож байна гэдэг нь туйлгүй. Тэр дороо л нэг нь гүйгээд гарсан гэж Намбааг хэлэхэд

- Нэг нь орж ирээд баахан юм ярихад нь сэжиг төрж данжаадын царайг ажаад байсан чинь нэг л өөр болоод явчихсан шүү. Тэгээд л таныг өнөөхийгөө ярьж дээ гэж санаад дотор уужирсан гээд Базар урт гишүү өвдгөндөө даран хугачаад галд хийлээ.

- Та хоёр ийм их юм авч яах гэж байгаа юм бэ? гэж Юмжирдуламыг асуухад

- Бид үүгээр яах вэ дээ. Нутаг орныхоо зовж зүдэрсэн ах дүүст өгөх гэсэн юм. Эхлээд зул сарын хорин тавны шөнө өгөх айлынхаа үүдэн нэг нэг дээлийн торго, нэг нэг ембүү тавьж, гэрийнх нь бүснээс нэг нэг идэшний адуу уяж орхино. Тэгээд Оршихоороо дамжуулан Юмжирдулам чинь шулам биш, манай нутгийí савдаг байгаад ядуу дордсыг тэтгэн хишиг хайрлаж байгаа юм гэнэ гэж цуурхал тараана. Базар чинь нутгийн савдагтай нөхөцсөн юм

гэнэ гэсэн ч яах вэ. Тэгвэл Сэр-Од туслагч намайг тийм ийм рí хийж байна гэж хардаж сэжиглэн амьтан ах дүүсээр оролдохгүй байх биз. Цагаан сараар бас дахин хишиг тараана. Зовж зүдэрсэн ард олондоо бага ч гэсэн тус болох юмсан гэж бодсон юм шүү дээ гэж Базарыг учирлахад Намбаа чийглэг өтгөн өвсөн дээр гэдрэг харан хэвтээд

- Юмжёрдулам минь, бид хоёр чинь ийм л бодолтой улс шүү дээ. Түүнээс биш ганц хоёр хар толгой хогшил хөрөнгөөр яах вэ дээ. Яаж ийгээд гол зогоох арга олдохгүй яах вэ. Эрхтэн дархтанд дандаа дийлдэж ад үзэгдэж орох оронгүй оочих аягагүй болж, өшөө хорслоо тайлах аргаа олж ядахдаа л эцэг эхээс заяасан биендээ найдаж ингэж амь дүйсэн үйл бүтээх гэж яваа ухаантай юм уу даа гэхэд нь Базар

- Ёстой л тийм дээ гэв.

- Намбаа гуай! Та намрын адаг сарын дундуур баахан адуутай ирэхгүй юу. Тааруухныа нь хишигт тараахаар үлдээж шилдгийа нь тууж Хөвсгөл далайн хавь дархдын нутаг орьё. Пүүсний данжаад нарт булга үнэтэй байдаг бололтой. Тэр нутгийн анчдаас булга худалдаж авчраад цагаан мөнгөнөөс наймаалж өрөнд баригдсан амьтаст өгч зовлонгоос гэтэлгэх санаа төрлөө. Би ч өөрөө буцах замдаа Дүүрэгч вангийн хошууны ноён сүргийн дэргэдүүр зүгээр өнгөрөхгүй л дээ гэсэнд

- Болох л юм... Аль газрын түмний зовлон барагддаггүй хэцүү ч үйлийн үр байх гэж дээ, хөөрхий гээд Намбаа гүнээ санаашрав. Гуниггүй эрийн гэнэтхэн ийн санааширсан нь дэргэдэх хоёрынхоо сэтгэлийн хөвч-ийг хөндсөн бололтой. Тэр хоёр ч бодол тавин чив чимээгүй боллоо. Шатаж байгаа гишүү тас няххийн оч үсэрч модноос уясан морьд хааяа амгай хэмлэж хэвтээ тэмээ шир ширхийтэл хивж хоолойгоо хоржигнотол сэвсээ залгихаас өөр өчүүхэн ч аниргүй. Шөнийн харанхуй нөмрөн, моддын оройн сиймхийгээр ганц нэгэн одод гялалзан, жихүүн салхин хүйс хүйсхэн хөдлөхөд мөчир гишүү үл мэдэг сүрчигнэн, түүдгийн дөл өрвөс өрвөсхийнэ.

* * *

Лааны гэрэл агуйн доторхийг гийгүүлнэ. Эрүүэн хивсээр агуйг өвч доторлож, хивс давхарлан дэвссэн нь хадан агуй гэхээргүй нүдэнд дулаахан, сэтгэлд өег баймаар атал тэнд байгаа хоёр хүний царай гүн бодолд дарагдан цаана л уйтае харагдана. Юмжирдулам баруун өвдгөө нугалан сууж, өвөр дээрээ шанз тавиад сэтгэлийн энэлэл гунигийг хүүрнэсэн дуу хөгжимдөнө. Энэ хөгжим дүлий дүмбэ оргисон агуйг эрхбиш амь орсонтой адил болгодог юм уу даа гэж санасан Намбаа

- Чи яаж хөгжимдөж сураа вэ? гэж асуув.

- Базарыг юманд явчихсан хойгуур өдөржин шөнөжин уйдаж хийх юмаа олж ядаж байхдаа оролдон оролдсоор энэ зэрэгтэй боллоо. Туслагчийн өргөөнд гуньж уйдаж суухдаа нэг дууч эмээр бага сага юм хэлүүлж оролдон сатаарч байсан минь ч хэрэг болсон шүү... Цор ганцаарангаас арай дээр санагддаг юм.

- Аргаа барсан хүн сэтгэлээ хуурах л юм биз дээ гээд Намбаа наранд нүд гялбам гялалцах

өндөр Алтайн цаст уулс, хаана нь ч яваад орчихсон хүн морийг далдлах бэрх хүцүү хад асга, адуун сүрэг элдэн нижигнэтэл давхиж явахад эр хүний хийморь цог сэргэдэг ээрэм цагаан тал хөндийгөө мөрөөдөн хүснэ. Тэндээ байхад өөрийн эрх дураар жаргах болжмор лугаа адил сэтгэл тавиун хичнээн жаргалтай байдагсан билээ. Гэтэл ганц бие бүсгүйд бараа болж Базарыг явж ирэхийг хүлээн энэ агуйд арав гаруй хоноход толгой нь дүнсийж, шар усандаа баригдсан мэт хамаг бие нь шархирч, уужим амьсгалад аргагүй санагдан дотор нь бачуурах мэт болж өдөр хоногийг арай ядан элээж байгаа аж.

Хөгжмийн хоёр чавхдас хүний хэлээд уянгалаг дуурсаж сэтгэл дэнсэлгэсэн аялгуу нь агуйн хана мөргөн замхарна.

“Хорвоо ертөнц дээр

Хоёулхнаа төрлөө дөө хө хө

Хорвоогийн жаргал зовлонгоос

Хоройлцож явна даа хө хө”

Энэ гунигт дуу Намбаагийн зүрхэнд нэвчин хүрч байлаа. “Нээрээ л үнэндээ, хөөрхий минь. Хар нялхаасаа зовлон туулж яваа хүний үр шүү дээ. Ямар ч гэмгүй ийм улсыг зовоож байдаг энэ ихэс дээдсийг яая даа байз! Энэ хоёрын амсах зовлон дөнгөж эхэлж байгаа биш үү? Олноос онцгой, түмнээс тасархай нэгэн насыг яаж барна даа. Амаргүй даваа. Над шиг үеэ өнгөрөөж яваа бол хамаатай юу. Гэтэл эд маань насныхаа өглөөтэй нь л дөнгөж золгож байна шүү дээ. Үд гэж бий үдэш гэж бий. Өдий өдий, хаа ч байсан юм. Нарт хорвоод жаргал айсана гэх найдлага тун ч бага байна даа. Явал зохилтой юм бэ” гэж Намбаа бодолхийлнэ.

Агуйн аманд түр тар хийсэн чимээ гарч гэрэл харвахад хөгжмийн чавхдас тасарсан мэт уянгат аялгуу таг болов. Намбаа ч давхийн өндийв. Тэгтэл Базар орж ирсэнд эмээж цочсон хоёрын нүдэнд хүлээн ядсан хүнтэйгээ учирсны баярын оч гялалзаж урьхнаар инээцсэглэн угтлаа. Юмжирдулам хоол унд зэхэж, Базар явсан сониноо ярьж хөөр хөгжөөн өрнөлөө.

- За тэгээд олз омог юутай ирэв дээ? Яагаад болзсон хугацаанаас өмнө хүрээд ирэв? Үэж Намбааг сонирхсонд Базар

- Нэгэнт явсных хоёр зуугаад булганы арьстай ирэх нь ирлээ. Сүүлдээ наймаа арилжаа хийх ч бодол төрөхөө болилоо. Морьдоо ядарсан зүдэрсэн амьтаст тэгж ингэж тарааж өгчихөөд нутаг руугаа л амь тэмцлээ гэсэнд

- За яагаад тэр билээ? Наймааны од муутай байгаа юу? Зайдаа Дүүрэгч вангийн хошуу ноёны сүргээс авчирч надаар Ховд туулгана гэсэн чинь яалаа? Үээд Намбаа түүний нүүр өөд гайхсан, шинжсэн нүдээр ажлаа.

- Та бид хоёрын адуу хөөж наймаа арилжаа хийдгээс чинь илүү нарийн юм мэдэж ирлээ. Ёстой л суусан цэцнээс явсан тэнэг дээр гэгч болсон доо гээд Базарыг ярьж эхэлтэл Намбаа суугаагаараа дөхлөө.

- Манай улс гэдэг чинь устаж үгүй болж гэнэ дээ.

- Ухай хэн тэгж байна? Энд л мэдэгдэх юм алга байна биш үү?

- Та бид хоёр хүнгүй газраар явж, агуйн мухар сахисаар хорвоогийн явдлын хажуугаар нүдэн балай, чихэн дүлий морины хурдаар өнгөрчихдөг юм байна шүү. Би тэр нутгийн айл хунараар бууж мордож олон аавын хүүтэй нүүр учирлаа. Дундад иргэн улсын цэргийн том эрүдүй хүн Да хүрээнд шороон түмэн цэрэгтэйгээ ирж Монгол улсыг маань устгаж эр цэргийн нь тараасан гэнэ ээ! Тэгээд тэр гамин чандруу гэгч цэрэг нь газар сайгүй тарж тонуул дээрэм, аллага таллага гаарч түмний зовлон давагдашгүй болж байгаа юм байна. Монгол нутагт хуучин байсан дотор наймаа нар ч оодорч гүйцсэн юм байх. Амьтны санаа сэтгэл унанги гутруу гэж даанч хэрэг алга. Газар сайгүй л гасалж гангинасан улс тааралдах юм даа гэж Базар ярив.

- Чи минь Монгол улс устаж гэнэ гэж ярих. Гэтэл Монгол улс чинь байдгаараа байж байгаа юм биш үү? Энд ноёд түшмэд чинь биднийхээ хүзүүн дээр зайдагнасан хэвээрээ л байна шүү дээ. Чиний ярианы учир нэг л олдхоггүй байна гэж Намбаа ухаж ядсан байртай дуугарав.

- Манай улсыг Богд эзэн хаан захирч байдаг бол одоо хаан нь хаан биш болж оронд нь дотор хүн манай улсыг захирах болж байгаа юм байна. Ухаандаа, Далай данжаад л та бидний эзэн боллоо гэсүй үг юм даа.

- Эй чааваас, савны ам руугаа харсантай адил болоо шив дээ гэж сая ухаарсан Намбаа дуу алдан нударга зангидлаа.

- Тэгэхээр Намбаа гуай! Улс орон маань харийн дайсны хөлд гишгэгдэж байхад та бид хоёр ноёд дээдэйтэйгээ тэрсэлдэж байдаг маань нэг бодоход зөв гэлээ ч, нөгөө бодоход эндүүтэй байна. Хотны ноход хоорондоо хэмлэлдвэл чонын идэш болохтой адил юм даа. Ноёд баяд хэзээ ч хань болохгүй. Гэлээ ч харийн дайсны аюулаас хамгийн урьдаар сэрэмжлэх нь зайлбаргүй болсон цаг юм байна. Очиж очиж Далай данжаад мэтийн тэнэг мулгуу юмнуудыг толгой дээрээ гаргачихаад боол нь болж босгоных нь шороог зөөж сууна гэдэг даанч дүү? гэж Базар шүд зуун хэллээ.

- Тэгээд бид чинь яах болж байна?

- Нутаг хошуундаа хүнтэй уулзъя гэхээр нөгөөдүүлийнхээ гарт орчихно. Тэгэхээр хоёулаа алсхан гарч улс амьтны ам ямархан байгааг тагнаж мэдье. Тэгээд эрэг хаашаа бол ус тийшээ байдаг шиг та бид хоёр олон түмнээ л дагадаг байх даа гэж Базар шийдмэг хэлсэн нь эх оронд нь аюул учирсан тухай хүн хүнээс үг дуулан тэд ямар санаатай байгааг мэдэж авснаар барахгүй түүнээ зам зуураа тунгаан цэгнэж өөрийн гэсэн бодолтой болох гэж яваагийнх ажээ.

- Мөн ч хэцүү цаг ирж байгаа юм байна даа... Олноо өргөгдсөний хоёр онд Хатанбаатар Магсаржав гэдэг баатар эр Ховд хотод үүрлэж байсан манжийн хар цэргийг үлдэн хөөснийг би мэдэх хүн дээ. Гэтэл зургаа долоохон жилийн дараа эргээд ирдэг хачин юмаа. Тэгэхэд сайхан л нүдүүлсэн юмсан. Хаширдаггүй юм байж дээ гээд Намбаа сахлаа илбэн бодлогоширно.

- Базар минь, та хоёр залуу улс. Энэ харанхуй агуйн мухарт яаж нэгэн насыг барах вэ. Би чиний ирэхийг хүлээх гэж бус залхаж гүйцлээ. Алт мөнгө амласан ч, лусын дагиныг хань болгоод өгсөн ч энэ агуйд чинь байж ердөө чадахгүй юм байна. Ерөөсөө энд удвал эцэстээ базаахгүй юм болно шүү. Чамайг ингээд зөнд нь орхичоогүй. Битүүдээ эрж л байгаа. Хэзээ нэг цагт энэ нууц агуй илэрч та хоёр баригдаж муугаа үзнэ шүү. Тэгэхээр алс холын харь хошуунд зугадаж очоод хүний чинээ амь зуухаа бодсон нь дээр. Яах вэ, очсон нутгийн ах дүүст гамингийн хөлд нэрвэгдээд амь дүйж явна гэж хэлнэ биз. Давын өмнө эндээс холдохоо бодсон чинь дээр дээ гэж энэ хоёр залуугийн хувь заяаны төлөө санаа зовниж, яавал зохимжтой бол гэж үргэлж бодож явдаг Намбаа өөрийн санааг хэлэхэд Базар Юмжирдулам хоёр өөд өөдөөсөө яах вэ гэсэн харцаар харсан хэрнээ дуугарсангүй.

- Тэд хоол идэх зуураа ойр зуурын юм хүүрнэлдэв. Намбаа нас ахиж яваа ч гэсэн нэг ч унаагүй яралзсан цагаан шүдээрээ мөч махыг хоёр гуравхан шувт татаад барахыг Базар хараад

- Та ч хоолонд үнэнхүү сайн юмаа гэхэд

- Одоо юу базаах вэ. Залуу байхад нэг хонины мах идчихээд долоо хоног эмээлээс буухгүй явахад хааяа ам цангана уу гэхээс биш, өлсдөггүй байлаа. Хаа ч хүрээд юу ч бүтээчихдэг мөн ч урамтай шүү гэж Намбаа өгүүлэв.

- Би уйдахаараа хааяа Оршихынхоор ордог юм. Ор танихгүй нэг хар юм үзэгдээд байхаар нутгийн улй харалхаж магадгүй гэж бодоод бүрэнхий болсноос хойш очдог юм. Тэд Пагма чинь ажилд бузгай дориун бүсгүй байна шүү. Оршихын муу хөгшин эх амарчээ, хөөрхий. Тэр бүсгүйд хүний зарц барлаг баэснаас ядуу ч гэсэн өөрийн дураар байна гэдэг насны нь жаргал шүү дээ гэж Намбааг шөл оочингоо ярихад

- Би Оршихыг туслагчийнхаас гэрлэсэн гэхээр их ичдэг юм гээд Базар инээснээ

- Чи саядаа цаадагдаа мөнгө санга өгсөн биз гэж Юмжирдуламаас асуув.

- Айл гэр болсон хүн байна, ганц хивй аваад яв гэсэн чинь хэрэгт орно гээд халгаадаг юм биш. Тэгэхээр нь Пагмад хоёр дээлийн торго, чихэр боовхон өгсөн гэв.

- Орших их тусархуу сайн залуу байгаа юм. Аймхай, ичимхий хоёр нь горьгүй дээ гээд Базар инээж гарынхаа тосыг арчлаа.

Намбаа тавтайхан хажуулдаж хэвтээд

- Галуутайн хүрээний Цагаан наймааны пүүс олон жилийн өрийн данс шүүж хүүгийн хүү, түүний хүүг хүртэл хөөн бодож заавал цагаан мөнгөөр авна гэж нэхэж байгаа гэнэ. Зарим нь ч ор үндэсгүй юм байх. Ардууд давхар давхар хүү төлөхгүй гэж бөөн зарга заальхай гаргаж байгаа гэнэ. Цагааны пүүс хошуу тамганд гомдол гаргажээ. Хошууны ихэс дээдэс данжаадын өмнө бөхөлзөж өрийй нь төлөхгүй гэсэн ардын махыг зулгааж байгаа гэнэ дээ. Заавал зул сарын хорин тавны наана төлж дуусгахгүй бол Да хүрээнд мэдэгдэнэ гэж данжаад сүрдүүлж баэгаа гэнэ. Оршихоос л ийм юм сонслоо гэж өгүүлэхэд

- Пүүсний данжаад тэгж оодордог чинь Дундад иргэн улсын цэрэг ирсэнтэй яах аргагүй холбоотой байна. Хэцүү ч юм болох нь дээ гээд Базар гайхаш алдран санааширснаа

- Мөнгө их цуглаж байгаа гэнэ үү? гэж асуулаа. Юмжирдулам тэр хоёрын яриаг чих тавин сонсож, тэд яаж үймж байх нь бидэнд ямар хамаатай юм бол гэж бодно.

- Хошуу нутаг уудам, түмний буян арвин болохоор хаанаас бага юу байв гэж дээ.

- Намбаа гуай! Тэр мөнгийг авах арга бодвол яасан юм бэ?

- Түүнийг тийм амархан авчих газар хадгалахгүй л дээ. Тэгээд ч дотор хүний санаа бэрх.

- Тийм ч байх аа даа. Гэхдээ хаана яаж агуулж байгаагий нь мэдэх арга бодъё. Зул сарын хорин тавныг хүлээгээд яах вэ. Ядууст өгөх хишгээ өнөө маргаашгүй тараая. Заримд нь мөнгөн эмбүү маань өрөө төлөхөд нь нэмэр болох биз.

- Энэ ч харин болох юм шүү. Би ч тэгээд орон нутагтаа түргэн буцахыг бодъё.

- Цагаан наймааны мөнгийг авалцсаны дараа та буцах тухай яриуа шүү... Тэр мөнгө бидний юм. Биднээс дээрэмдэж авсан болохоор ямар нэгэн аргаар буцааж авахыг бодно. Таны, бид хоёрыг эндээс яв гэдэг ч зүйтэй үг. Мөнгөө авч эздэд нь тараагаад эндээс холдож харийн дайсны хөл гишгэсэн нутаг оронд очъё. Тэгсэн цагт та бид хоёрын зам эрхбиш тоймтой болох биз гэж Базарыг хэлэхэд Намбаа өөрийн нь явуулах дургүй байгааг түүний үгнээс таамаглавч санасандаа хүрэх гэдэг энэ зоримог залуугийн бодлыг няцаахыг түвдсэнгүй.

* * *

Нэгэн шөнө Галуутайн голын өмнөд арын модон дундуур гурван морьтой хүн баруун зүгийг барин яаралгүйхэн алхуулна. Тэд эзгүй хээр яваа хэрнээ намуухан ярилцах нь нэг л нууцлаг байдалтай. Тэнгэр бүрхэг болохоор таг харахуй. Базар урьд нь Урианхайгаас ирсэн булганы наймаачин гэдэг дүрээр Цагааны пүүсэнд очиж данжаадтай нь их хөлийн наймаа хийнэ гэсээр суудаг байранд нь орж амжаад мөнгөний авдрынх нь цүү цуурга, хаалганы түгжээг ажиж, тэндээ данжаад нь ганцаараа хонодгийг ч мэдэж авчээ. Бас хэдэн шөнө хашаагийн нь өнгийн тагнаж, нэг иргэн шөнө дунд өнгөртөл хашаа манаж байгаад угаас хулгай дээрэм гардаггүй бөглүү газар болохоор төмөр хэцнээс гүйдэг уяагаар уусан нохойндоо ааатгаад байшиндаа орж унтаад өгдгийг ч мэдэж авчээ. Одоо тэр л пүүсийг дээрэмдэх санаатай Галуутайн хүрээ рүү дөхөж яваа ажээ.

- Орших оо! Чи яагаад дуугарахгүй байна? Айгаад байна уу? гэж Базар түүн рүү бөхийсхийн асуухад тэднийг дагуулаа явах гэхэд нь үгүй гэж хэлж чадалгүй гарсан Орших юу болдог бол гэж эмээж, хүн тааралдах бий дээ гэж хол ойрын чимээ чагнаархан сэтгэл түгшиж байсан боловч нэрэлхэхдээ

- Айгаад ч байх ч юу байх вэ... Гэхдээ л зэвүүн байна шүү гэхэд нь Базар

- Манай Орших ч тэгж байгаад зүрхтэй шүү. Хэдэн айлын гадаа хишиг хүргэж дөнгөсөн дөө

гэж түүнийг зоригжуулах санаатай хэлээд

- Хишигний талаар улсууд юу ярьж байна? гэхэд

- Орон дэлхийн савдаг хишиг тарааж ядуусыг харж үзлээ гээд бие биедээ шагшин яриад жигтэйхэн. Би ч өөрийн чинь хэлснээр цуурхуулаад орхисон. Амьтан хүн үнэхээр үнэмшсэн байдаг шүү гэж Оршихыг ярихад

- Өнөөх Далай данжаад юу болсон бол? Тэр хэргийн тухай эрэл сурал болмоорсон. Сураг чимээ байна уу? гэж Намбаа асуулаа.

- Би сая Далай Чойнход вангийн хошуугаар дайрч гарахдаа амьтан хүнтэй энэ тэрийг ярьж л явлаа. Далай данжаад ноос авахаар баахан хомтой тэмээ явуулсан гэнэ. Хошууных нь тэргүүн туслагч өвгөн хүн байдаг юм байна. Данжаадын бие хүн, бичээч сэлт нь тэр өвгөнтэй уулзаж ярилцаар арайхийж учрыг тунгаан хэн нэг зальт хүнд мэхлэгдсэнээ мэджээ. Тэгээд Улиастайн жанжин жасаанаас бүх хошуудад бичиг илгээж тэр зальт хүнийг илрүүлж олох зарлиг болсон гэнэ. Манай хошуу тамгынхан намайг тэгсэн байх гэж сэжиглэж байсан боловч хошуундаа төлбөр гарч чирэгдэл болохоос гадна өөрсдөө юманд орооцолдохоос түвэгшээгээд үл мэдэгч болж өнгөрөөсөөн гэнэ билээ гэж Базар яриад шиг шигхийн инээв.

- Бид тэднийг чадах л юм. Гэтэл тэд тэглээ гээд зөөлөрч номхорсон юм байхгүй, харин ч бидэнд улам өширхөн мөшгөж байна. Өнөөдөр Цагааны пүүсний лөнгийг авлаа гэхэд тэд маргааш ардуудаас дахиад л татвар татах нь мэдээж. Тэгэхээр л бид чинь тэдний ганцхан үлээхэд хомхийн тоос шиг хийсэх өчүүхөн амьтад байна шүү дээ. Тэгээд бодохоор тэдэнтэй яаж ч тэйцээд нэмэргүй, бид л айсан, зугадсан, нуугдсан, дийлдсэн хэвээрээ байх юм даа гэж Намбааг өгүүлэхэд түүний дуунд цөхрөнгөө барсан өнгө илхэн.

- Та тэгээд Цагааны пүүсний биднээс дээрэмдсэн мөнгийг авахаа больё гээд байгаа юм уу? гэж Базар огцом асуусанд

- Тэгсэн ч юмгүй. Гэхдээ л тийм ч түвэггүй юм биш шүү гэв.

- Тэднийг бээцэгнэж ядаж байхад нь нэг нэг нудраад л унагачихна бис гэж Базарыг тоомжиргүй хэлсэнд Намбаа

- Цаад дотор улс гэдэг чинь хүн санахгүй юм бодож олдог улс. Хар санаагаараа бидний хударганд үлдэж байгаад л араар минь тавина шүү гэв.

Үүрийн үнэгэн харанхуй нөмөрч амьтан хүн сэршгүй нойронд дарагддаг үеэр Цагааны пүүсний хашаанд сэм дөхөж очлоо. Базарыг өндөр шургааган хашааны орой дээр дүүжингээр гармагц нохой нь архиран хүрч ирлээ. Базар шогшроод, авч явсан махнаасаа хаяхад нохой газар уно́о́о нь авч залгив. Савааны үзүүрт мах өлгөн дахин дахин өгч нохойн хорхойг хөдөлгөж байгаад нэг удаа өгөхдөө мах шорлосон саваагаа дагуулан бүдүүн яргай ташуураар ганцхан хусаж нохойн сарьсан хамар дээр хүчтэй цохилоо. Нохой ганц ч дуугүй газар саван уналаа. Базар Намбаа хоёр данжаадын байшингийн үүдэнд хүрч хаалгыг нь төмрөөр хөшин орлоо. Данжаад сэрж,

- Хай юу байна аа? гэнгүүт нь Базар үсрэн очиж дарж аваад

- Дуугарвал ална шүү! гэж занаад аманд нь даавуу чихэж хүлэв. Энэ үед ханзан дор нуугдан хэвтэж байсан түүний амь хамгаалагч нь энэ чимээнээр сэрсэн боловч хөдөлбөл амь хохирч мэдэх нь гэж бодоод таг чиг байв. Базар лаа барив. Гаднаас хүн сэжиг аваад орж ирж магадгүй гэж бодоод Намбаа үүдэнд чимээ чагнан хөдлөлгүй зогсов. Базад мөнгөний авдрын цүү цуургыг тас цохиж тагийа нь авч тавчихаад мөнгөнөөс уутанд хийж гарлаа. Ханзан дор хэвтэж байгаа хүн лааны гэрэлд Базарыг ажаад өнөөх Урианхайгаас ирсэн булганы наймаачин мөн байна гэж таньжээ. Тэгээд ч түүнийг ганцаархнаа явна гэж санасан учир ханзан дороосоо сүх барин гэнэт үсрэн гарч цаашаа хараад мөнгө ууталж байсан Базарын дагзан дунд нь яах ийхийг завдалгүй буулгав. Намбаа түүнтэй зэрэг шахам ухасхийсэн боловч нөдрөө амжин хамгаалж завдсангүй. Гэсэн ч иргэн хүнийг эргэж харахаас нь өмнө хүнд ташуураар нугасыа нь тас цохилоо.

Базарын толгойноос асгарсан цус шалан дээгүүр урсаж, үхсэн амьд нь ч үл мэдэгдэнэ. Намбаа айх балмагдах зэрэгцэн түүнийг тэврэн хашааны явган хаалгыг онгойёгон Оршиход хүргэж өгөөд явах гэснээ “Сайн нөхөр маань сэргэсэн хойноо мөнгийг нь авсангүй гэж зэмлэх байх” гэж бодоод санд мэнд эргэн орж уутандаа мөнгө дүүргэж аваад бас данжаадын байшинд гал оруулж амжаад гарч одов.

Намбаа, Базарын моринд мөнгөө ганзагалаад өөрөө нөхрийгөө дүүрэн авч явлаа. Үүр цайж байхад тэд Галуутайн хүрээнээс нилээд холджээ. Цагааны пүүс тэнгэр тултал олгойдсон хар утаанд умбасан харагдана.

- Пүүсийа нь шатаачихаа юу гэж Орших асуухдаа айсандаа болоод хоёр нүд нь орой дээрээ гарчих шахжээ.

- Базарыгаа ийм болгосны хариуг өгч ул мөрөө ааллаж байгаа нь энэ гэж Намбаа хэнэггүй дуугарав. “Ямар аймаар юм хийдэг улс вэ! Араас хөөгөөд ирэх бий дээ. Баригдвал яана” гэж бодохоос Оршихын айдас хүрч эргэн эргэн бараа харуулдана. Тэр хоёр ойн гүн дэх нэгэн горхины захад бууж Базарын цусыг цэвэрлэн толгойгий нь бүсээ цуулан боолоо. Орших элдвийг бодон уймарч самгардаж байхдаа

- Намбаа гуай! Олуулаа бол ийм юм болохгүй дээ. Цөмөөрөө тэр муу пүүсийг дайрч ороод л баллачихна шүү дээ гэж хэлэхүд нь Намбаа, нилээд эрт хань ижил олонтой болох тухай гурвуул маргаж байснаа санаж “Иймэрхүү юм хийх чинь хээрээс адуу хөөхтэй адилгүй юм байна. Нөхөд элсүүлье гэхэд нь дэмий гэж хорьсноос сайн андынхаа аминд хүрч байгаа юм биш үү? гэж бодсон билээ. Базар ухаан орсонгүй. Намбаа Орших хоёр гэмтсэн хүний аяс, тааруулан гэлдэрсээр үдийн үед агуйдаа арайхийн хүрчээ. Тэр хоёрыг ухаангүй нөхрөө дамжлан орж ирэхэд нь Юмжирдулам орь дуу тавин тэвэрч уналаа. Базар орой тийш бүүр түүр ухаан ороход сахин суугаа гурван хүний сэтгэлийн гүнд наран ургах шиг болжээ. Базар “Үнэн... үнэн... хаа байна?” гэж амандаа дахин давтан үглэнэ. Тэгэхээр нь тэд ингэж байгаад арай жаахан дээрдэх болбуу гэж горилон аманд нь бүлээн цай бага багаар хийж өгөн нүүрнийх нь арьсны хөдлөх төдийг ч алдалгүй ажин сууна. Гэтэл Базар хүндээр зовуурлан байсаар шөнө дундын алдад насан эцэслэхэд хадан агуй нурж тэр хэдийг бяц дарах шиг болжээ. Түүний нэг нүд араасаа сүхээр цохиулах үедээ мөнгөний авдрын булан мөргөсөн

болов уу гэмээр хөх няц болí хавджээ. Нөгөө эрүүл нүд нь хялайн харсан нь үиэнийг эрээд ололгүй амь эрсэдсэн энэрэлгүй хорвоог үзэн яджээ гэмээр.

Юмжирдулам дэргэд нь хүн тогтохын аргагүй орь дуу тавин уйлахдаа,

- Бид хоёр жаргал үзэх хувьгүй яасан улс вэ гэж гашуудалтайяа чарлана. Оршихын өрөвчхөн сэтгэл уярч өөрийн эрхгүй бөмбөрөн байгаа нулимсаа арчиж байхдаа “Ноёд, лам, данжаад нарын балгаас энэ сайхан залуу эндлээ. Чадал байдагсан бол бүгдийа нь тонилгоод өгөхсөн” гэж хорсон заных нь Базарын цогтой харц үүрд аньж, хэтийн хүсэл нь унтарсан ч гэсэн энэрэлгүй хорвоог түймэрдэн булшлах сэтгэлийнх нь гал түүний зүрхнээ хэзээ нэгэн цагт асан дүрэлзэх оч болон үлдэж буйнх ажээ.

- Би одоо хорвоог яаж өнгөрөөх юм бэ, таминь! гээд Юмжирдуламыг арга тасран уйлахад Намбаа хүрлэгэр бараан царайлчихаад таг дуугүй хөмсөг зангидан суух нь түүний сэтгэлд шуурга дэгдэж байгаа бололтой. Дотныхоо андыг өөрийн буруугаас алдсан мэт санагдана. “Тэр мөнгийг авах гэдэг анхнаасаа буруу байсан гэж үү? Би Базарыг хориглох ёстой байсан уу? Үгүй ээ. Мөнгийг авдаг ч зөв. Аргаа ч зөв сонгосон. Тэр ханзан дороос гарч ирдэг босоо ороолонгоос л боллоо. Миний л анзаарагагүй байсных. Араас нь харайхын оронд хашгирах минь яалаа. Тэгсэн бол тэр ороолон ч сандарч, Базар ч босон зайлж амжих байсан. Тэгээд л бидний хэрэг санаснаараа бүтэх байсан шүү дээ. Ганцхан миний муугаас боллоо” гэж Намбаа °өрийгөө зүхэн зүрх шимшрэн шаналж, андынхаа энэ хорвоог үзэн ядсан зоримог мөртөө гэнэн царайнаас нүд үл салгана.

Маргааш өглөөний мандах улаан нарнаар Намбаа тэд талийгаачаа уулын оройн нэгэн их байц хадны өврийн багахан хавтгайд нутаглууллаа. Намбаа цаашид хэрхэхээ бодоход өөрөө хэдий амьд сэрүүи ч явах зам нь тэрхүү байц хадыг мөргөн мухардсан мэт санагджээ. Насны нар хэвийх тийшээ хандсан өөрийгөө хэзээ нэг цагт эмээл дээрээ эцэслэх хүн гэж гаргуунд нь орхилоо ч зовлонд нэрвэгдсэн залуу бүсгүйн замы нь олж өгнө гэдэг түүнд сэтгэлийн тээг болов. Тэгээд Оршихтойгоо ярилцаж түүнийг Базарын эхэд хүргэж өгөхөөс дээр юм байхгүй гэж тогтлоо. Юмжирдулам ч хадан агуйд ганцаар сууж чадахгүйгээс хойш хар нялхаасаа хайр ивээлд нь өссөн эмгэнийхээ гар дээр очихгүй бол хаана очих билээ. Тэр гурав хожим унаа хөсөг авчирч юмаа авахаар болж дан биеэрээ шар нуруунаас буулаа. Намбаа түрүүлэн явж хүүгийнх нь үрэгдсэн тухайг ээжид нь аргагүйн эрхэнд дуулгаж уйлаан унжаан болж байтал Оршид, Юмжирдулам хоёр ч хүрч очжээ. Намбаа үнэн учрыг өгүүлэн ятгавч эмгэн огтхон ч итгэхгүй

- Шулам чи тонил цаашаа! Лам багшийг минь хорлож хүүгийн минь толгойг залгичихаад одоо над руу халдаж байна уу? Түй, базарваань хум пад! Долоон уулын цаагуур далд ор! гэж хашгиран хоёр гараараа шороо самран Юмжирдуламын өөдөөс цацаж хөөлөө.

- Доржпалам гуай! Энэ чинь Юмжирдулам шүү дээ. Хүүгээс чинь ялгаагүй байтал та ингэж муухай аашилж яаж болох вэ гэж Орших зүрх гарган хэлтэл ухаан балардсан эмгэн

- Юун яасан Юмжирдулам! Амилсан шулам! Шуламтай нийлж муу юм шүглэсэн та нар ч зайлцгаа! гээд бүгдий нь шороо цацан хөөлөө. Тэд яах ч аргагүй болж буцахад Юмжирдулам өөрийн нь шулам гэж бодсонд бүр ч сэтгэл ганһран цурхиран уйлсаар явлаа.

Эмгэн уйлж унжиж бурхандаа мөргөж, хүрд эргүүлэн баахан маани уншиж байгаад дотроо жаахан онгойход сая энэ тэрийг эргэцүүлэн бодтол дэмий ингэж нулимсаа барж сууснаас хүүдээ дэрбйхан буян хийлгэхээс дээр юм үгүй санагджээ. Эмгэн үдийн алдад арваад хонь нэг сайхан тугалтай үнээгээ тууж Галуутайн хүрээ рүү явсан нь тосон ангайж буй том ам руу өөрөө орчих нь тэр. Сүсэгтэн хүн гэгч өөрийнхөө зовлонгийн тамыг өөрөө ийнхүү малтдаг ажээ.

Хорин зургадугаар бүлэг

Эргүүлэг

Алтан дэлхий уужим гэлээ ч

Ариун үнэнд давчуухан буюу

Цас бударсан нэгэн зэвүүн хүйтэн орой амьтны хөл үймээн татарсан хойно ганц тэмээн ачаа хөтөлсөн гурван морьтой хүн Улиастай хотын нэгэн явцуу гудамжаар гулсах мэт чимээгүйхэн алхуулсаар дотроо жижигхэн байшинтай багахан хашааны хаалганд хүрээд гинжээр даруулан цоожилсон цоожийа нь онгойлгон орж явчихлаа. Тэмээний ачаа эмээл юмаа байшинд оруулж, морьдоо хашаанаас уяв. Намбааг лаа барихад нэг буландаа пийшинтэй бяцхан өрөөнд хоёр цооход авдар, ор тавиастай байхыг үзээд яагаад ийм бэлэн зэлэн юм байдаг билээ гэж Юмжирдулам гайхахдаа,

- Энэ ямар айл вэ, Намбаа гуай? гээд асуучихав.

- Танайх шүү дээ. Би та хоёрыг ууланд орхиод хоёр гурав хоног явахдаа эрэл сурал болж байж ухаандаа чамайг бэлэн юман дээр оруулах санаатай ийм нэгэн хашаа олж авсан юм. Ингээд л чи минь амь зуух аргаа хайхаас аргагүй боллоо доо гэж Намбаа түүний нүүр өөд нь харж чадалгүй гунигтайхан өгүүлэв. Юмжирдуламыг хадан агуйд ганцаар сууж чадахгүй, нутаг хошуундаа багтах шингэх аргагүй болсон болохоор олон хөлийн газар сэм бараадуулбал эрхбиш дээр биз гэж Намбаа бодсон учир түүнийг Улиастайд төвхнүүлж өгөхөор ирсэн нь энэ билээ. Намбаа, Орших хоёр түлээ хөрөөдөн оруулж Юмжирдулам цай буцалгаж хоол хийлээ. Намбаа ямар ч айлд давын өмнө хэрэг болдог үнсний хутгуур, хогийн шүүрнээс эхлэн хөрөө сүхий нь хүртэл бэлдэж өгсөн нь орох оронгий нь бүсгүйн сэтгэлд аль болох аятай нийцтэй байлгах гэж мэрийснийх ажээ.

Юмжирдулам энэ хоёр хүний нөмөр нөөлгөнд зовлонгоо нимгэлж байгаа боловч маргаашаас эхлээд хүний газар эзгүй хашаа, хөндий байшин сахиж орь ганцаар үлдэнэ гэхээс элдвийг бодон шаналсаар тэр шөнө бараг унтсангүй. Дөнгөж үүр тэмдгэрэх төдийд босож цай чанав. Намбаа Орших хоёр ч морио эмэуллэн унд уугаад явахыг завдлаа. Гурвуулаа уйтгартай царайлан хэн нь ч дуугарахгүй дүнсийн сууцгаах нь сална гэдэг тэдэнд тун ч амаргүй байгаа бололтой. Энэ чимээгүй байдлыг Намбаагийн намуухан гунигтай дуу эвдэхэд нөгөө хоёр нь түүний өөдөөс харахаасаа зовсон юм шиг шал ширтэн чагнана. Намбаа үгээ цээжнийхээ гүнээс ихэд хүчлэн гаргаж байгаа юм шиг зугуухан ярьж эхэллээ.

- За Юмжирдулам минь! Одоо бид хоёр мордохоос аргагүй боллоо шүү дээ. Өнчин янзага шиг болсон чамайг тормойтол нь орхиод явна гэхэд үнэхээр өр минь өвдөж байна. Гэхдээ бид боёр яаж энд сууж байх вэ. Бидэнд бас нэг бодол байна. Сайн нөхөр маань үнэнийг эрсээр яваад эрсэдлээ. Тэгэхээр түүнийхээ эцсийн удаа хэлсэн хорвоогийн үнэний эрэлд бид хоёр мордох гэж байна. Харийн дайсан үүрлэсэн газар очиж талийгаач шигээ зоригтой золбоотой сайн эрсийг олж нөхөрлөө. Хээрийн амьтан шиг ингэж ганц нэгээрээ явдаг туйлын буруу байжээ. Тэглээ гээд олсон хожсон юм юу ч алга. Бүх юм бахь байдгаараа л байна... За тэгээд хүч мөхсөөсөө болж сайн нөхрөө алдсан минь бидэнд гашуун ч гэсэн сургамж болох ёстой.

Биднийг харсаар байтал бүхэл бүтэн айл орон сүйрч байна. Ганц энэ биш, газар сайгүй ингэж байна. Тэгэхээр хар амиа бодоод шогшиж явахын аргагүй боллоо. Энэ Орших хүү ч намайг дагаад явах боллоо. Би дотроо их баяртай байна... За ингээд мордох уу даа гэж санаа алдаад Намбаа бослоо. Одоо би яана даа гэхээс Юмжирдуламын дотор багтрах мэт болж эхэр татан уйлав. Намбаа түүнийг тэврэн сэтгэл уяраасай сайхан үнэртэй үсэнд нь хошуугаа хүргэн үнэрлэж эвэршсэн ширүүн алгаараа нулимсыг нь арчи аргадав.

- Охин минь, уйлаад яах вэ. Уйллаа гээд учирсан зовлон хийсээд явчихгүй. Харин сэтгэлээ чанга баривал зовлон чинь хагасарна. Зовлонг сөр, жаргалыг дага гэсэн үгтэй шүү. Хорвоогийн зовлонг хүн ганц өөрөө биш, үүнийг ямагт санаж яваарай! Цагааны пүүснээс авсан мөнгийг амьтан ах дүүст тараах байсан боловч бидний бодсон хэрэг санасанчлан бүтээгүй болохоор чамайг гар хоосон орхихгүйн эрхэнд үлдээлээ. Түүгээрээ улжаад амь зуух аргаа бод доо. Есөн шидийн амьтан цугласан энэ газар хүний сайныг олж ханилаад дотроо бодолтойхон явахад гэмгүй шүү. Хөндийвгэр байж юмны аяыг сайн ажиглахад зүгээр. Цаашдаа ямаа болох нь чамд аяндаа мэдэгдээд ирнэ. Бид хоёр ч чамайг энд хаяад тэр чигтээ алга болчихгүй. Амар мэнд явбал эргээд уулзана шүү дээ, охин минь! гэж сургамжлаад гарлаа. Тэр хоёрыг мордон явахад Юмжирдуламын нулимс бөмбөрч юм бүхэн бүрэлзэн үзэгдэнэ. Тэгтэл гудамжны булангаас нэг хүн гараад ирэх шиг болоход нь Юмжирдулам хашаандаа бушуухан орж хаалгаа янгинатал түгжээд байшиндаа орж орон дээрээ ойчин гаслантайяа уйлав.

Юмжирдулам байшиндаа хэд хоног таг чиг бүгж, хориодхон насандаа амссан зовлонгоо эргэн эргэн бодож үе үе уйлан хайлсаар сүүлдээ бодох ч юмгүй, уйлах ч нулимсгүй шахам болж цөхрөнгөө баржээ. Намбаагийн бэлдсэн хоол хүнс нэгэнд барагдсан учир арга буюу гэрээс гарч Улиастайн зээлээр айсан туулай мэт хүн хараас нүүр буруулан явсаар ганц хоёр мухлагаар орж жаал зугаахан юм цуглуулж ирлээ. Хэд хоног гиюүрэн суухдаа бас шанзаараа зугаацан цаг нөхцөөлөө. “Ичээний амьтан шиг алийн болгон ингэж суух вэ. Зээлээр явж юм сонирхье байс. Гэгээн цагаан өдөр намайг яав л гэж. Гадаа гарч энэ тэрийг үзэж сатаарвал байшингийн оёорт гэгэлзэж байснаас арай дээр байх” гэж Юмжирдулам бодоод насан бага бүсгүй хүний сониуч зандаа хөтлөгдөн гэрээс гарчээ. Дэлгүүр мухлагаар хэсэж, эрээн мярааныг харан нүд хужирлалаа. Нэгэн гуанзанд орж өөртөө сайхан санагдсан лю за хуа хэмээх хоолыг ч идэж үзлээ. Тэгээд маргааш нь хятад ший янгууны газар юм үзнэ гэж хоёр бүсгүйн ярилцахыг сонсоод хаана байдгийг нь зүрхлэн асууж заалгаад харьжээ. Тэр өдөр нь урьдын арваад хоногийг бодвол арай л хөнгөн өнгөрөв.

Маргааш нь ший янгууны газар очиж өнгө хослон хийсэн гоё гоё хувцастай, нүүр амаа будсан иргэн хүмүүсийн ший тоглож, дуу дуулахыг ихэд сонирхов. Тэндээсээ хэдэн пүүсээр орж элдэв чамин эд юм үзэж сэтгэл овоо хөгжүүн явлаа. Орж ирсэн хүүхнүүдийг нууцгай нүхээр харуулдаж, царайлаг нэгийг нь гоочилж байдаг Далайн пүүсэнд Юмжирдулам ороод очсон нь данжаадынх нь нүдэн дээр унаад явчихав. Урьд удаа нэг л үзсэн юм шиг Далайд санагдсан учир түүнийг юм үзүүлэн саатуулж бай гэж нэг бичээчдээ хэлээд өөрөө нууцгайгаар ажиж суув. Хүүхний ярих, инээх, хөхрөх нь өнгөрөгч зуны залуу ноёнтон ирсэн хатан яах аргагүй мөн болохыг танив. Далай бичээчээ дуудаж пүүсэндээ хүн оруулалгүй байж байгаад энэ хүүхнийг айлгаж сүрдүүлэн байцаа! гэж тушаав. Юмжирдуламыг санаандгүй байтал хэдэн иргэн хүн гэнэт дайран орилуулж чарлуулсаар дотогш нь авч оров. Харанхуй зооринд цаг

гаруй суулгасны дараа нэгэн өрөөнд оруулаад залуу ноёны хамт бараа луйвардсан хэргийг хүлээлгэх гэж оролдов. Хэрэв үнэнээ хэлж хамсаатнаа зааж өгөхгүй бол дөрвөн аймгийн жанжин жасаанд шилжүүлэн тамлан зовооно гэж сүрдүүлэв. Юмжирдулам хэдий айж ширвээтсэн ч эдэнд юу ч хэлэхгүй гэж шүд зуун бодов.

- Би тэр хаган чинь биш, та нар эндүүрч байна. Одоохон намайг тавиатах! гэж мэлзэн уйлж цовхчиж гарав. Наймаанууд яаж ч чадахгүй гайхашран дэмий л сүр бадруулан загнана. Тэгж байтал Далай данжаад орж ирэв. Юмжирдулам ч данжаадыг танимагцаа гарцаагүй урхинд оров гэж бодоод санаа шулбодан таг дуугүй болов.

- Хай, та нар энэ хүүхнийг загнаж юу хийнэ ээ гэж Далай бичээч нараа ширвээд

- Ай хүүхэн, чи надтай яв баа гэхэд нь Юмжирдулам юу руу аваачих гэж байгаа бол гэж харалхан хөдлөхгүй суусаар байв.

- Хай, чи яасаан? Монгол хэлээ мэднээ? Надтай явбаа. Би чамайг яах ч үгүй лаа гэж данжаадыг дахин шалахад Юмжирдулам яах гэж байгаа юм бол доо гэж бодоод түүнийг дагаж гарав. Гэтэл данжаад түүнийг Базарынх нь хамт дайлж байсан өнөөх тансаг өрөөндөө аваачив.

- Сууваа, сууваа! гээд Далай данжаад түүнийг намхан суман ширээний хажуугийн түөлэгтэй зөөлөн сандалд суулгаж, өөрөө нөгөө талд нь тухлаад нэг юм хашгирав. Тэгтэл зарц иргэн гоёмсог шаазан авчран цай аягалж чихэр боовтой таваг тавиад гарлаа.

- Цай ууваа... Айх юм байхгүй лаа. Манай зарц нар чамайг таниад дор нь барьж авсан байна шүү. Би байгаагүй бол чи өнгөрсөн баа. Одоо хоёулаа сайхан яриваа гээд данжаад маасалзан инээнэ. Удсан ч үгүй хоол, архи, шанцай авчирлаа. Юмжирдуламын сэтгэл бага зэрэг тайвширсан боловч эндээс бушуухан явах юмсан гэж яарч савх барьж сураагүй учир тавагтай хоолноос нь бага зэргийг идэхчээн болж байлаа.

- Хүүхэн чи надаас юу ч нууж болохгүй лаа. Би муу хүн биш шүү... Танай нөхөр одоо байхгүй болсон үнэн баа? Үгээд данжаад хоол савхдан орстой шар шүдтэй ам руугаа хийв. Юмжирдулам дуугарсангүй.

- Хай, чи хэлэхгүй их тусгүй. Би бүгдийг мэдэж байна шүү. Зун намайг залилсан тэр хүн танай нөхөр байсан баа. Сая Галуутайн хүрээнд байдаг Цагаан наймааны мөнгийг дээрэмдэх гээд үхсэн баа. Пүүс их шатсан шүү. Харин сайн зарц нар байснаас данжаадыг шатаж байсан байшингаас авч чадсан. Данжаад үхсэн бол хэн юу хийснийг мэдэхгүй байсан өүү. Би цөмөө дуулсаан. За энэ ч яах вэ, өнгөрсөн баа гэж данжаад хэлээд алтан хүрээтэй сүйжин шилээ гялалзуулан зовхи нь унжсан бүлцэн нүдээр Юмжирдуламын өөдөөс нүрхий ажингүй харлаа. Өөрийнх нь нууж байсан үнэнийг яг хэлсэнд бүсгүйн царай улайж харц буруулан “Би ч эдний гараас мултрах нь өнгөрчээ. Хамаг юмыа минь булааж аваад намайг гудамжинд хөөж гаргах байх даа” гэж бодоход аманд хийсэн юм хоолой дээр нь тээглэчих шиг болжээ. Түүний айсан царайг данжаад ажаад

- Тэр тусгүй хэргийг их муу хүн хийсэн баа. Чи зүгээр дагаж явсан хөөрхий хүүхэн. Чамд

ямар хамаатай лаа... Чи надаас бүү ай! Би чамд жаахан ч муу юм хийхгүй лаа. Чи харваас их сайн хүүхэн байна. Чамд их зовёон учирсан байна шүү. Зовсон хүнд тусалбаа гэж бурхан багш хэлсэн шүү. Би чамд тус болохгүй яах аа гээд архиар шахахад Юмжирдулам дөнгөж амсаад тавив.

- Архи жаахан жаахан уухад гэмгүй шүү. Зовлон мартана шүү гэж данжаад ятгаад

- Чи одоо энд ямар газар ирсэн бэ? гэж асуув. Данжаад сайхан үгээр хуурч гэрийн минь мэдүүт баллах гэж байгаа байх гэж Юмжирдулам бодоод баахан түгдэрч байснаа

- Айлд ирсэн. Маргааш явна гэхэд түүний худал хэлснийг данжаад харцнаас нь мэдсэн хэрнээ хаа байгааг нь олох аргаа тэрхэн зуур санасан учир дахин шалгаасангүй.

- Би чамайг сүйхээрээ хүргэнэ гэж данжаадыг хэлэхэд

- Үгүй үгүй. Би гүйгээд харьчихна гээд Юмжирдуламыг явах гэсэнд данжаад түүнд боов чихэр нилээдийг өгч

- Манайд ирж байгаарай! гээд явуулахдаа түүний хаа байгааг сэм тагнуулахаар нэг зарцаа өөр хаалгаар гаргажээ.

Юмжирдулам айгаад гурав хоног гэрээс гарсангүй. Түүний хойноос нэхэл дагал бололгүй орхисонд сэтгэл нь тэнийж Улиастайн гудамжаар хааяа нэг явах боловч Далайи пүүс рүү шагайсан ч үгүй. Юмжирдулам нэгэн аюул өөрийн биеэс зааглалаа гэж санан сэтгэл амгалан явсан нь эндүүрэл болжээ. Нэгэн өдөр гадуур явж байгаад өөрийнхөө гудамжаар ороод иртэл хашааных нь үүдэн дээр сайн үүлдрийн өндөр зээрд морь хөллөсөн, шил толь болсон ганган сүйх тэрэг зогсож байв. Айл андуураа юм уу гэж санасан боловч зовлон үзсэн бүсгүйн сэтгэлд болгоомжлох санаа төрөв. Тэгээд түүний явсан хойно нь хашаандаа орё гэж бодоод дэргэдүүр нь өнгөрөх гэтэл сүэхний хаалга сэвхийн нээгдэж

- Ай хүүхээн! гэж Далай данжаад дуудах нь тэр. Юмжирдулам хэрдхийн цочиж зогтусав.

- Хай! За сайн байна уу? гээд данжаад шар шүдээ гарган инээмсэглэв. Юмжирдулам яахаа ч мэдэхгүй хөшсөн мэт зогссоор байв.

- Хүн тус больё гэж сайн санаж байхад чи худлаа хэлээд яасан муухай лаа. Чи манай пүүсээр орохгүй яасаан? гэж хэлэхдээ данжаад инээмсэглэсээр байв. Юмжирдулам дуугарсангүй, гутлынхаа хошуугаар шороо хөдөлгөн газар ширтсээр байв. Юмжирдуламын цор ганцаар байгааг мэдэж авсан данжаад энэ залуу сайхан хүүхнийг гартаа оруулаад авахсан гэж яаран тэмүүлж байлаа.

- Чамайг надад итгэсэнгүй гэж би муу юм өчүүхэн ч санахгүй лаа. Чи зовлон үзсэн хүүхэн хүн надаас зугатах нь зөв байхгүй яах аа. Ердөө ч буруу бишээ. Би чамд дандаа сайн юм хийнэ. Одоо чи надад битгий муу юм санаваа гэж данжаад толгойгоо хоёр тийш үл мэдэг дальжис хийлгэн инээмсэглэн байж өгүүлэн түүний сэтгэлийг засаад:

- За одоо манайд очваа. Би чамайг сайхан дайлбаа. Удаахгүй гэрт чинь хүргэж ирнэ шүү гэхэд нь бантаж хоцорсон гэнэн бүсгүй сүйх тэргэнд орохоос аргагүй болов. Далай данжаадын далдуур тавьсан аалзны торонд Юмжирдулам ийнхүү орооцолдов.

Далайг цэвэрхэн залуу хүүхэн дэргэдээ суулгаад түшлэгээ налан тун ч ихэмсэг байдлаар явж байтал сүйх нь зогсож данжаад уцаарлан хараал тавив. Тэгтэл сүйхний хаалга онгойж гялалзсан сортой үсээр хийсэн малгайтай, дунд зэргийн нуруутай, тогтож ядсан харц бүхий жижигхэн хар нүдтэй, жавхалзсан шар эр сүйхэнд нь шууд орж ирээд Далайтай мэндлэхдээ бүсгүйг нэвт шувт хараатахав. Далай данжаад түүнийг баахан тээршаасан бололтой дурамжхан дуугарав. Улиастайн хүүхнүүдийн аль олигтойг андахгүй болсон энэ эр, ийм сайхан амьтныг данжаад хаанаас олоод авчихав гэж атаархан бас хүүхний хаанаас ирснийг мэдэхээр сүйхэнд орж иржээ.

- За манай түнш! Сонин юутай байна даа? гэж дотносон асуухад данжаад түүнээс салахын хүслэн болж байсан учир

- Юу ч байхгүй... Ай Должоо \Дорж\! Чи яриа байвал маргааш болваа. Надад өнөөдөр жаахан жаахан ажил байна гэсэнд

- Манай түнш ч одтой байх шив дээ гээд тэр эр гялалзсан хурц нүдээр данжаад Юмжирдулам хоёрыг гүйлгэн харж хэлээд цаанаа ёжтой инээмсэглэхэд Юмжирдулам намайг энэ хөгшин данжаадтай холбож байгаа юм биш байгаа даа гэж санахаас нүүрнээс нь гал бутраад явчих шиг болов. Тэр эрийг удвал өөртөө балаг тарьж магадгүй гэж санасан данжаад

- Хай, явбаа! гэж хөтөчдөө захирангуй хэлсэнд залуу эр сүйхнээс үсрэн буув. Далай данжаад нилээд зузаан түншилдэг сайхь эртэй Улиастайн зах дээр наймаа арилжаа хоршин хийдэг боловч эмс хүүхнүүдээс эхлээд аливаа юман дээр гэнэ гэнэ шаггүй мөргөлдөж өгч авалцаж явсан болохоор түүнд Юмжирдуламыг алдуужин гэж хар санасан байжээ.

- Саяны хүнийг Долж баян гэдэг. Бас ч их зальтай. Яаж ч магадгүй лаа гэж хэллээ. Юмжирдулам Улиастайд ирсээр монгол хүнтэй танилцаж завдаагүй болоод ч тэр үү нүдэнд нь нэг л дулаахан харагдах шиг болж, түүнийг сэргэлэн эр юм даа гэж боджээ. Дорж баян, гудамжны өлөн тоос бургиулан хурдалж байгаа данжаадын сүйхний араас харж нуруу үүрэн алцайн зогсохдоо “Чи муу луухаан ямар амьтны үрийн тархийг эргүүлж яваа бол? Яасан цэвэрхэн амьтан бэ! Нас нь ч бага юм. Царай нь улайчихаад хүний өөдөөс харж чадахгүй байгааг бодоход ч тэр, юм үзэж нүд тайлсан шинжгүй байгаа нь ч тэр, хөдөөний л хүүхэн баймаар. Хурга авсан чоно шиг энэ муу луухааны надаас зугадаж байгааг хөөе! Халхын хүү юм бол чиний урдуур орохгүй юу болох бол доо! гэж дотроо андгайлжээ.

Юмжирдулам Далай данжаадаас айж эмээхээ болиод харин ч харийн хар элэгтэн гэхэд тус÷ сайн хүн юм уу гээ бодон хааяа заллаганд нь очиж амттай сайхан хоолоор дайлуулдаг болжээ. Очих бүрт нь данжаад ховор нандин бэлэг өгдөгт нь бас ч амтшив. Тийн байсаар нэгэн сарыг ардаа орхин хот орны байдалд бага сага дадан байтал нэг өдөр нөгөөх баян Дорж хэмээх жавхалзсан эртэй гудамжинд тааралдчихав. Юмжирдуламыг хажуугаар нь өнгөрөх гэтэл нүүрэмгий байрын тэр эр, яг л танил хүн мэт шууд мэндлэн энд ирсээр ямархуу янзтай сууж байгаагийг нь лавлаж, гудамжаар дагуулан явж хаана юу нь байдаг, тэр нь ямар учир

ухаантай болохыг дэлгэрэнгүй ярьж өгчээ. Тэгж явахдаа Дорж

- Би ч та нарын явдлыг мэднэ шүү. Танай талийгаач үнэхээр аавын хүү дуулддаг байсан юм. Муусайн ноёд лам нарт дургүй болохоор би зүс үзээгүй ч гэсэн тэр залуутай танилцахсан гэж боддог байсан юм. Тэгсэн чинь хөөрхий, их тоогүй юм болсон сонсогдсон. Хайран хүн гэж халаглажээ. Додæ бүсгүйн сэтгэлд өөртөө байр олох үг хэлж үнэхээр чадав. Юмжирдулам түүний ярианд уярч, миний талийгаачид хайртай хүн бас байдаг л юм байна гэж бодон Доржоос жийрхэн дөлөх бус, харин ч дотночлох сэтгэл төржээ.

- Чиний ирснийг ч гэсэн гадарлаж л байлаа. Гэхдээ чамайг танихгүй болохоор шууд яваад очихоор ганц бие бүсгүй хүн айж сандрах биз гэж бодоод очдоггүй байсан юм. Тэгээд Далай данжаадтай явахыг чинь үзээд уулзаж ярихаас аргагүй боллоо. Чиний явдал надад хамаагүй л дээ. Гэхдээ адилхан монгол хүний үр хүүхэд байж нэгийгээ осолдож эндэх зам руу орох гэж байхад татаж авалгүй яах вэ гэж Доржийг битүү хатуу юм хэлэхэд нь Юмжирдулам бүр ч гайхаж Далай данжаад намайг яах гээ юм бол оо гэж сэжиглэх, шохоорхох зэрэгцэв.

- Хоёулаа танайд очих уу даа. Гудамжаар дэн их явбал олны хараанд өртөж мэднэ. Манай энэ хот хүн цөөтэй болохоор хов жив ихтэй шүү. Бодолтой байсан нь дээр. Чамайг элдэвлэж зовоох хүн мундахгүй гэж Дорж хэлээд бэлэн сайхан амаар бүсгүйг хуурч гэрт нь дагаж очлоо. Сар болоход өөрөөс нь ондоо нэг ч хүн хөл тавиагүй хашаанд ухаалаг зальжин Дорж бүхнээс түрүүлэн орж чадлаа. Дорж, Далай данжаадыг газар доогуур ортол муулан бүсгүйгээс холтгож дөнгөд байвч хэзээ нэг цагт өөрийнх нь тэр залигч мэдвэл хонзогнож, Далайгаар дамжуулан хождог олзных нь сав хаагдахаас айгаад бас ч тэгж зүрхэлсэнгүй.

- Далай данжаад тийм ч муу хүн биш. Далайтай сайн байлаа гээд чамаас холцрох юм байхгүй. Гэхдээ харийн хар санаатай хүн өнгөн дээрээ буянтай бурхан хүний дүртэй байвч цаанаа шулмын санаа шүглэсэн амьтан байхыг хэн байг гэх вэ. Цаадхи чинь яах л гээд чамд хөл алдаад байгаа бол доо? Дотор хүний санааны цаад талд амар гарахгүй шүү. Чи давхар бодолтой байгаарай. Хагуу ч гэсэн халхаа түшиж явбал хэт нь өлзийтэй байх нь мэдэх л юм гэж Дорж яриад “Данжаад та хоёрын дунд Дорж орсон байхад зоонд нь юм хавчуулчихаар хөдөлж болдоггүйтэй адил шаналгаж байгаад нэг л өдөр өөрийнхөө санасныг хийнэ дээ” гэж бодон дотроо инээж бүсгүйн хөдлөх бүрийг хорхойсон ажиж суулаа.

- Чи энэ хашаанд ганцаараа байдаг тун тусгүй. Өөдгүй амьтан элэг баривал яах ч арга алга. Тэгэхээр саяхан хөдөөнөөс амь зуух гэж нүүж ирсэн, хоёр өнчин хүүхэдтэй нэг хар хүнийг энд буулгая. Айлын бараатай байвал сэтгэл амар шүү дээ гэж Доржийг хэлэхэд Юмжирдулам шөнө бүхэн айж хагас дутуу нойртой хонодог болохоор айлын ханьтай болоход дуртай байв. Дорж гарахдаа түлээгий нь үзээд

- Ойрноос сүрхий хүйтрэх янзтай байна. Хүн танихгүй болохоор энэнээс өөдтэй юм яаж олдох вэ. Маргааш би сайхан хуурай түлээ өгөмз! Нөгөө айлаа ч даруйхан буулгая. Түмэндээ тустай сайн эртэй ханилж явсан чамайг ягтаа тулаад байхад монгол ах дүүс нь харж үзэхгүй бол өөр хэн харж үзэх вэ гэж найр тавин хэлээд гялалзсан үстэй нударгаа бардам байдалтай сэгсрээд явахад нь Юмжирдулам “Өөрийн ах дүүгээс ялгаагүй яасан сайхан сэтгэлгүй хүн бэ! Ядарсан намайг зөв харах хүн байдаг л юм байна. Далай данжаадаас өмнө энэ хүнтэй тааралдсан болоосой. Далай гуай энэ хүнийг зальтай гээд л байсан. Панз наймааны улс

болохоор хоорондоо түнжин муутай ч байдаг юм билүү, би яаж мэдэх вэ” гэж бодон Доржийн сэтгэлийн сайхныг шагшин хоцорчээ. Маргааш өглөө нь Юмжирдуламыг дөнгөж босоод байтал үхэр тэрэгний дугуйн хяхтнах, түг тагхийн эргэх чимээ сонсогдоор гадна нь хүрч ирлээ. Хаалгыг нь гинжин оосроор балбахад Юмжирдулам гарч очив. Нэгэнт үүр цайсан учир төдий л айсангүй, хашааны завсраар шагайвал түлээ ачсан хэдэн сайхан хайнагийн шар онгоронз хамраа шуухэтнуулан уур манан савсуулан зогсож байв.

- Юун хүн бэ? гэж асуухад

- Баянтны түлээ буулга гэсэн айл танайх юн үү? гэв эрэгтэй хүний дуу хаалганы цаанаас гарлаа.

- Баянтай гэж хэн бэ?

- Дорж баян.

- Мөөн мөн гээд Юмжирдулам даамангаа онгойлгохдоо “Жинхэнэ эр хүн бол хэлсэн амандаа заавал хүрдэг юм. Хэлсэндээ хүрдэггүй хүн бол эр хүн биш, ердөө л засаатай чавганц” гэж Базар Намбаа хоёрын ярьж байсныг санах. Уранхай дээлтэй булиа залуу түлээгий нь цэгцтэйхэн хурааж өгөөд татлага сэлтээ эвхэж байв. Түүний байдал урьд шөнийг хэдэн хайнагийн шартай замд өнгөрөөсөн нь илт учир Юмжирдулам залууг гэртээ оруулж цайлав. Юмжирдулам түлээний үнэ цэнийг асууж төлөх гэтэл баянтантай өөртэй нь ярь гээд халгаасангүй. Залуу эр бүсгүйг хулгай нүдээр ажиж сайхан төрсөн хүн юм гэж бодон түүний үзэсгэлэнтэй царайнаас сүрдэж биеэ барин унд таатай уусангүй тэгж ингэсхийж байгаад босоход нь Юмжирдулам Далай данжаадын өгсөн бэлэгнээс баахан боов чихэр өгөхөд залуу хоёр гараа тосон авч, гартаа багтахгүй болохоор одоо боллоо гэв.

- Өвөртөө хийчихээд дахиад тосооч гэж Юмжирдуламыг хэлээд инээмсэглэхэд залуу түрүүчийнхийгээ өвөртлөөд дахин алга тосох доо ичиж царай нь улайв.

- Хатагтай, гялайлаа! гэж залуу баярласан сэтгэлийн угаас хэлээд нахилзсаар гарахдаа “Сайхан зүстэйгээ адилхан сайхан зантай, өгөөмөр өглөгч хүн юмаа. Баянтан надаар энэ хатагтайнд дахин дахин түлээ буулгуулаасай” гэж боджээ. Мөн тэр өдрөө Дорж баян нөгөө айлаа нүүлгэж ирэв. Нилээд оворжуу, ядарч зүдэрсэн харшинг царайтай хижээл хар хүн, хүүхэд атлаа их л томоотой байрын хөдөлгөөн удаантай, арван хэдэн настай хөвгүүн, тормолзсон хар нүдтэй, долоо найман насны нүдэнд дулаахан охин гурав байлаа. Юмжирдулам айлын ханьдээ болж байгаадаа баярлан тэднийг гэртээ оруулж цай уулган хоёр хүүхдэд нь чихэр өгч энхрийлэн үнсэхэд эхээсээ хойш бүсгүй хүний хайраар хомс байсан хоёр хүүхэд түүний намуухан хонгор дуу, зөөлөн дөлгөөн аалинд автан нүд нь гэрэлтээд явчихав. Юмжирдуламыг тэр айлын гэрээс барилцаж байтал Дорж

- Чи гэртээ сууж байхгүй эдний шар эсгийтэй ноцолдож яах нь энэ вэ гэж зэмлэнгүй аястай хэлсэн түүнд тун ч эвгүй санагдаж “Гаднаа айл бууж байхад цонхоороо хараад сууж байх хэрэг үү” гэж хэлмээр байвч угийн бүрэг учир дуугүй өнгөрөв. Харин түлээний үнийг өгөх гэсэнд Дорж

“Би хүний сэтгэлийг мөнгөөр үнэлэх гээд байдаг хүнд дургүй шүү гэж зэвүүрхсэн дүр үзүүлжээ.

* * *

Арц хүжидеэ анхилуун үнэр, янз янзын зуушны гойд сайхан амт, тагнайд хүрэхдээ бал бурам мэт боловч толгойд гарахдаа амархан дарсны ааг энэ бүхэнд Юмжирдулам баахан мансуурч, нүд нь үл ялий сүүмийж улам ч хөөрхөн болчихоод шанзныхаа чихийг гөлрөн сууна. Нэг л адтай орчлонд очсон юм шиг хачин байдал бие сэтгэлийн нь эзэмджээ. Тусгай суурин дээр тавьсан зантгар толгойтой урт гуулин гансаар хар тамхи сийгүүлэн сорж байсан данжаад гүн санаа алдаад

- Ай хүүхэн, чи яасан гоё дуулнаа. Залуу цагийн сайхан сайхан явдал аргагүй санагдсан шүү. Дахиад дуулбаа гэж шавдуулав. Юмжирдулам шанзныхаа утсыг хэд имрээд амраг сэтгэлийн тухай дуу хөгжимдөн аялахад Далай ноёрмоглосон мэт нүдээ аньсхийж бүсгүйн хөдлөхийг дагаж ганхана. Түүнийг дуулж гүйцэхэд данжаад

- Хай яа! Амраг сэтгэл ёстой сайхаан! гэж дуу алдаад жоотойсон хачин нүдээр Юмжирдуламыг харснаа архи хундагалж

- Уу ваа, уу ваа! Хорвоо ертөнцийг мартваа гээд барив. Юмжирдулам дөнгөж уруул хүргээд

- Би аль хэдийнэ гурван хундага уучихсан. Одоо болохгүй гэхэд

- Гурав уусан юм дөрөв болохгүй яах аа гээд данжаад худал инээв.

Данжаад Юмжирдуламыг сүйхээрээ авчруулан өргөөндөө дайлдаг нь олширчээ. Тэдний хашаанд айл буусныг хөтчөөсөө дуулсан данжаад юун айл болохыг мэдэхээр өөрөө нэг удаа хэрэг болгон очжээ. Юмжирдулам ч баян Доржийн тухай ярилаа. Данжаад түүнийн өмнүүрээ хөндөлдөж байгааг мэдэж Юмжирдулам ч түүнд муугүй байгааг гадарласан учир холын санаа муу аргаараа давахыг бодоод Доржийг гоочилсонгүй. Харин тэднийхээс гарахдаа Доржийн буулгасан түлээг хараад

- Хай, хүнд юм өгч үзээгүй хорголоо тоолсон үхэр монголын өгсөн түлээ энэ үү? Ийм бүдүүн модыг ганц хүүхэн яаж хөрөөдөж түлэх вэ. Чи түлээ хэрэгтэй байсан бол надад хэлэхгүй яасаан? Ийм жаахан байж бас муу санаатай лаа гээд яваад өгсөн билээ. Данжаад хэдэн даачаа тэргээр өөр шигээ өгөрч гүйцсэн, галд хийхэд бэлэн хагалсан түлээ буулгажээ. Тэгээд Юмжирдуламыг муу юманд аажмаар дасган өөрийн болгох санаа өвөрлөж ойр ойрхон дайлахдаа эхлээд ганц жүнз уулгаж сурган, дараа нь бага багаар ахиулж байлаа. Юмжирдулам ганц жүнзэнд дотор нь халуу шатан толгой эргэдэг байсан бол одоо гурван жүнзэндээ эзэн болдог болжээ.

Данжаад Юмжирдуламыг оройтуулж, архиар шахаж унагаад дураараа эдлэхийг хүсэж хэдэн удаа оролдсон боловч муу юманд дадаагүй бүсгүй түүний арганд автсангүй. Данжаад бүсгүйн нэрийг ирэх болгонд нь шахам асуувч тогтоодоггүй болохоор ярих юмгүй гацахаараа нэрийн нь асуудаг байв.

- Ай хүүхэн, чиний нэр миний толгой дотор бас байхгүй болсон шүү. Хэн байна аа?

- Яагаа вэ дээ. Юмжирдулам л байхгүй юу.

- Юмжаа, ай бишээ. Юмжий, ээ золиг оо, бас буруу

- Юмжир... дулам

- Аа тийм ээ, мэднаа, мэднаа. Юмжил-дулам. Дулмаа ч яах аа, мартахгүй лаа. Тэр Юмжир ердөө ч болдоггүй. Ийм маапаантай нэрээр юу хийнэ ваа.

- Аав ээж өгсөн юм чинь яах вэ дээ.

- Хэенхуал, Үйтэнхуал, Жинхуал гээд сайхан сайхан нэр хаа мундана. Чамд тийм нэр байвал бүр ч гоё болно шүү гэж данжаадыг хэлэхэд тэс өмнөө юм бодож суусан Юмжирдулам

- Далай гуай! Дандаа гэрээс гарахгүй байх уйтгартай юмаа. Би бас сүүлийн үед ажил амь зуулгаа бодох боллоо. Та цөөн ч гэсэн мөнгө олох арга хэлж өгөөч! гэв.

- Чи мөнгөөр юу хийнэ ээ?

- Амь зуухад мөнгө хэрэгтэй биз дээ. Хот орон газар чинь мөнгөгүй бол турж үхэж ч мэдэх юм байна.

- Хай, чи юу ярина аа? Чи өөрөө мөнгөтэйгээ төрсөн байна шүү гэж данжаадыг хэлэхэд Юмжирдулам ойлгосонгүй гайхан харав.

- Чи мөнгө эрж юу хийнэ ваа. Мөнгө чамд өөрөө ирнэ шүү гэж данжаад хэлээд “Энэ хүүхэн өөрийнхөө үнийг мэддэггүй байна шүү. Хямдхан дээр нь чамайг заавал ч үгүй нэг дөнгөв аа” гэж бодлоо.

- Далай гуай, би явья даа гээд Юмжирдуламыг босоход данжаад давхийн бослоо.

- Цаг эрт байна. Чи жаахан суухгүй яасаан?

- Таныг гурав уусан, дөрөв дэх нь яах вэ гэхээр нь уучихсан чинь толгой манараад хачин болоод байна. Бушуухан харъя.

- Би зөндөө уусан байхад яаа ч үгүй сайхан байна шүү. Чи миний энэ тамхинаас татваа. Танай монголын татдаг тамхитай ямар ч төсгүй лаа. Биенд сайн, их үнэтэй ховор тамхи шүү. Жаахан татнаа, дорхиноо бие сайхан болно. Тэгээд сүйхээр хариваа гэж данжаадыг ятгахад Юмжирдулам хар тамхинаас нь хэд сороод хэсэгхэн суутал бие нь нэг л аятайхан болчих шиг санагдсанд дахин бага зэрэг татлаа. Чингэхэд нь данжаад тун ч тааламжтай инээмсэглэн харна.

Сүйх тэрэгний хонхны дуугаар жижигхэн охин гүйн гарч

- Юмжаа эгч ирлээ! гэж хашгиран дэвхцэж хаалга нээж өглөө. Юмжирдулам нэг гартаа шанзаа, нөгөө гартаа Далайн бэлэг том баадантай юм барьжээ. Охин түүнийг дагаж ороход Юмжирдулам нэлээд боов боож ахтайгаа хувааж ид гээд духан дээр нь үнсээд гаргав. Охин Юмжирдуламд дасаад хажууд нь байж эрхлэх дуртай. Хөвгүүн өдөр үзэгддэггүй нь эцэгтэйгээ хар бор ажилд зүтгэж хэдэн зоос олоход нэмэр болдог бололтой. Харин орой өглөөд дандаа түлээ хагалан оруулж өгнө. Эцэг нь Юмжирдуламыг хэлэхэд ганц удаа орж ирэхдээ амин тэжээлийн хэдэн малтай байснаа ханиа өвчлөхөд лам нарт бариад үлдсэн хэдээ ноёны алба гувчуурт хураалгаад хоосорч хоёр хүүхдээ тэжээхийн эрхэнд суурин газар бараадсан тухайгаа ярьжээ. Юмжирдулам орон дээрээ хажуулдаад, нэгэн хашаанд аайгаа хоёр айлын аж төрлийг эргэцүүлэн бодно. Гадаахь айлын том бага хоёр хүн өдөржин хоол эрж шогших атал цатгалан байх нь ер үгүй. Хоол унд, түлээ түлшээр дандаа гачигдана. Гэтэл өрөө гэрээс гарахгүй боловч юу л хэрэглэе гэвэл бэлэн. Далай данжаад гурил будаа зөөж, Дорж баян ширэнд нь боосон шарын мах өгсөн болохоор хоол хүнсэнд сохор зоос ч зарсангүй. Өвөлжин өрдөөд барахгүй хуурай түлээтэй байхад айлын охин голцуу гар нь хүйтэн, хошуу нь улайчихсан орж ирдэг болохоор ховорхон гал түлдэг нь илэрхий. Юмжирдулам тэднийхийг өрөвдөхдөө Доржийн буулгасан түлээг өгч, бас жаахан гурил илүүчилжээ. Айлын хар хүн Юмжирдуламыг хар нялхаараа завхарсан хот газрын биеэ худалддаг бузар эм гэж цээрлэн хүүхдээ оруулахаас дургүйцэн цагддаг байснаа түүний өглөгч сэтгэлд нь бишрэн муу юм бодож байсандаа гэмшин өгсөн хишгийг нь залбиран хүртдэг болжээ.

- Энэ айл манай хоёр яахаараа ийм өөр өөр байна вэ? Хорвоо гэдэг ийм алаг цоохор байдгийн учир юу вэ? Манай хошуунд надад орогнох нүх ч олдохгүй зовж байсан бол энд юугаа ч хайрлахгүй сул хаяж тус дэм болох гэж хөл алдаад байх юм. Энэ Улиастайнхан ийм сайн санаатай хүмүүс байдаг юм болов уу? гэж Юмжирдулам учрыг тайлахыг хичээн хуурамч хорвоогийн мананд төөрөн эргэлдэж байтал Дорж орж ирлээ. Дорж цай ууж, Юмжирдуламаар ганц нэг дуу хөгжимдүүлэн нилээд суув. Хананд зүүсэн хөхөөтэй цаг дуугарахад Дорж ольсхийн харснаа

- Далай өгөө юу? гэхэд нь Юмжирдулам толгой дохиод түүнийг орж ирэхийн өмнөхөн бодож байснаа асуумаар санагдав.

- Далай гуай та хоёр яахаараа надай ийм их юм өгөх мөртөө үнийг нь авдаггүй юм бэ? Би гайхаад гайхаад учры нь мэдэхгүй юм. Заримдаа хүний юм зүгээр авсандаа санаа зовоод та хоёрын нүүрийг харахаас ичих шиг болох юм.

- Хэн нь ямар бодолтой өгч байгааг чи сэтгэлдээ тунгаах ёстой байх. Далайн хувьд гэвэл, бүсгүй хүн үзэхээрээ нүдээ ухаж өгөхөөс буцахгүй хүн дээ. Цаадхи чинь бээх шахсан баян амьтан. Юу л өгнө аваад бай! Хэрэг болмоор юм байвал нэхсэн ч цаадхи чинь нэрэлхэхдээ тавиад туучихна. Гэхдээ бид нэг их нүүр өгөх хэрэггүй. Ер нь мэдээтэйхэн байхаа мартавзай гэж хэлээд Дорж “Чи муу луухаан юмаараа торгоож бай, би санаагаараа, торгоож байя. Дотор хүнтэй өөрийнх нь аргаар үзэх хэрэгтэй. Чамаар баахан юмыг чинь цацуулж энэ хүүхнийг хэдэн жилийн хоолтой болгосны дараа баян Дорж өөрийнхөө шавхрууг ам руу чинь хийхээ л хийнэ” гэж бодлоо. Юмжирдулам гэнэн цайлган болохоор Доржийн залирхаг инээмсэглэсэн нүдэнд би чамайг нэг л өдөр тэнгэр харуулна гэсэн хорон санаа ив илхэн байгааг олж

харсангүй.

- Юмжирдулам минь! Чи хэзээ нэг хотын хүүхэн болно доо гэж Дорж зориуд санаа алдаад түүний өөдөөс харахдаа нойрмоглосон юм шиг дуниартсан харцтай нь тулгараад ихэв гайхав.

- Чи чинь үүрэглэж байна уу даа?

- Үгүй... Далай гуайнд сая нэг сонин тамхи татсан юм. Түүнээс хойш бие нозоороод нэг л хачин.

- За тэр, хар тамхи байхгүй юу гээд Дорж хөмсгөө зангидан “Одоо чамайг Далайгаас нэг хэсэгтээ хөндийрүүлээтэхье. Тэгэхээр эргүүлж татахын төлөө юугаа ч хайрлахгүй болно доо” гэж бодлоо. Гэрт нь ирэхдээ дандаа зугаатай юм ярьж инээж хөгжөөж байдаг хүнээ гэнэт уурлах шиг болоход Юмжирдулам би нэг л буруутай юм хийж дээ гэж санан гэмшингүй янзтай сууна.

- Чамд хар тамхи татуулсан байна. Тэр чинь хамгийн цээртэй, хамгийн хортой эд. Хар тамхины дайн хүртэл гарч байсныг би сонссон юм байна. Идгэн хүний санаагаар болдогсон бол монгол хүн бүрийг хар тамхинд оруулж мансууруулчихаад эх нутагт нь эзэн болох санаатай байгаа юм. Хар тамхинд орвол наад бие чинь хатсан навч шиг болоод Улиастайн хог дээр хэвтэж байгаад л үхнэ шүү. Эндхийн олон сайхан хүүхнүүд хөгшин луухаануудын хар тамхинд хазаарлуулж тэдний дураар эвчүүлж байгаад л өнгөрсөн юм даа. Хэрэв чи хар тамхинд орчихвол Далай данжаадад шигдсээр байгаад л дуусна.

- Пээ! Тийм муухай юм надаа өгсөн бий! Тэр данжаадын чинь барааг дахиад харахгүй байж чадна аа!

- Чиний яаж явах нь надад хамаагүй, дураараа л бол. Гагцхүү тэр хорноос хол яв! Би чамд сайн санаснаараа тус болж явбал барав. Чи намайг тус боллоо гэж санааа уу, ус боллоо гэж санана уу, ердөө ч падгүй гэж Дорж шуудхан хэлээд цагаан гансаа гаргаж тамхи нэрлээ. Юмжирдуламыг аргамжиж авснаасаа хойш түүний хэлсэн ганц үнэн үг энэ байлаа. Баян Дорж арга заль, муу санаагаараа Далай данжаадаас ялгарах юмгүй боловч монголоо гэсэн сэтгэлээсээ ингэж ярьсан ажээ. Дорж тамхиа хурдан татаж гансаа түрийлээд чамайг яая даа гэсэн юм шиг хардаг өнөөх дөлгөөхөн харцаараа Юмжирдуламыг хараад аяархан санаа алдан гарлаа. Ингэдэг нь өөрийнх нь бодлоор бүсгүйн зүрхийг ягуухан доргиож, түүний сэтгэлд өөрийн эзлэх зайг ямх ямхаар ахиулах гэсэн санаа байлаа.

“Нээрээ л энэ хүн монгол ах дүү гэхээрээ элэг зөвтэй байна шүү. Харин хүн, учир мэдэхгүй надад яаж ч үнэн санаагаа цухуйлгах вэ. Далай гуай инээж байгаад л хүнд хор өгч байдаг яасан муухай хүн бэ! Хэлсээр сануулсаар байхад нь би ийм болчимгүй юм хийдэг даанч тусгүй яа! Намайг данжаадтай нийллээ гэж арай бодоогүй байгаа даа” гэж Юмжирдуламыг сэтгэл зовнин бодож байхад хаалганы хонх жингэнэн Дорж гарч одов.

Түүнээс хойш арваад хоноход Далай данжаад гурван удаа сүйхээ явуулж залахад нь Юмжирдулам очоогүйгээр барахгүй хүргүүлсэн боодолтой бэлгийг нь ч авалгүй буцааж байсныг дандаа отоож битүү тандаж байсан Дорж мэдээд “Би ч балчирхан хүүхний толгойг

ганц сайн эргүүлээ. Далай ч одоо боож үхэх бор шидмэс эрэхдээ хүрч байгаа биз” гэж бах нь ханажээ. Тэгээд Юмжирдуламыг нэг удаа гэртээ очихыг гуйсанд Доржийг өөртөө чинхүү санаа тавьдаг цайлган сайхан сэтгэлтэй хүн гэж бодоод бүсгүй цааргалсангүй хамт явжээ. Баян Доржийнх хотын урт нүүрний дээд эхэнд урагшаа харсан том хүрэн дааман хаалгатай, дотроо зуны сууцнаас гадна урт төмрөөр хөндлөн дарж том цоож зүүсэн, хоёр заамал дүнзэн байшинтай цэлгэр хашаанд байлаа. Дорж ханцуйгаа шамлаад тогоо шанагаа хангинуулан цай үйж байхдаа

- Ганц бие эр хүн гэдэг ийм л байх юм даа гэж гутарсан янзтай хэлээд буруу харан инээд алдах шахан хэлээ хазаж “Энэ ямар манайхаар дахин ирэх юм биш. Би л санасандаа хүрч байвал юу ч гэж айлдсан ямар пад байна. Санаа бодлыа нь дэнсний годил шиг дэндэлзүүлж байвал болох нь тэр” гэж бодоод хэнэггүй царайлж

- Муусайн бүсгүй дүү нарын хүчинд болоод л байх юм гэв. Эхнэрээ хадмынх руугаа хоногоор явуулчихаад ингэж байгааг Юмжирдулам мэдэхгүй болохоор “Ийм залуухан, тэгээд ийм баян хүнд эхнэр олдохгүй яах вэ. Харин эхнэргүй мөртөө намайг оролдоод байдаггүйг бодоход угийн төлөв сайн хүн юм. Ингэж өөрийнхөө байдлыг үзүүлж байгаад намайг ханилъя, сууя гэх юм биш байгаа даа” гэж бодон жаахан эмээсхийж суутал Дорж

- Би л дандаа танай руу харайж байдаг, чи манайхаар орж үзээгүй байна гэдэг гэмгүй танил улсад тусгүй юм уу даа гэж бодоод чамайг авчирлаа л даа. Манайх гэж нэг иймэрхүү айл байдаг юм. Миний бодлоор бол чамайг хааяа ирүүлж наадаж бужигнаж баймаар санагдах юм. Гэхдээ тэгж байх нь чамд дэмий байх гэж боддог. Аягүй бол чамайг эхнэргүй баян хүн рүү шогшоод байна гэж амьтан муу хэлбэл яах вэ, та минь. Зүгээр байж цагаан хэл аманд орооцолдоод хэрэггүй гэж тун ч тоомжиргүй хэлсэнд Юмжирдуламын дотор цэлмээд явчихжээ. Дорж, Далай данжаад шиг түүнд хөл алдсангүй, зөвхөн банш чанаж, ёс гэж ганц хундага архи амсуулах төдий дайлсан болоод өнгөрсөн нь чи миний жирийн л нэг дотно хүн шүү дээ гэдэг бодол төрүүлэх гэсэн юмсанжээ. Түүнийг явахад Дорж өөрөө түлхүүрийа нь авч явдаг авдраа уудлан жижигхэн хээтэй тунарсан хар ногоон торго гаргаж

- Орж ирсэн хүний гар цайлгадаг нь монголын ёс юм болохоор яаж зүгээр гаргах вэ гээд хоёр гардан барив. Өөрийнх нь ирснээс хойш Доржийн хөдлөх, харах, ярих нь тун ч энгийн, ямар нэг далд санаа агуулсан байдал огт үгүй юм шиг санагдсан учир Юмжирдулам илүү дутуу зангүй, хүний мөсөөр сайн, ойр дотно байж болох ёстой нэг гүндүүгүй эр юм гэж бодсоор их л баяртай харьжээ.

Сүйхээ явуулахад л шөнийн сар гийгүүлэх шиг ялдамхан мишээсээр орж ирдэг Юмжирдулам нь хэдэн удаа залахад нь бараагаа ч харуулахаа больсонд Далай данжаад юунаас тэгснийг цөхрөнгөө бартал, бодож ядаад нэг өдөр чансаатайхан бэлэг төхөөрөөд өөрөө гэрт нь очлоо. Халиу захтай бошинз өмссөн пөөнөгөр данжаадыг орж ирэхэд Юмжирдулам нүд буландан харж дурамжхан угтав. Далай юу хэлэхээ мэдэхгүй нэгэн хэсэг дөмбийн сууснаа

- Ай Юмж... Хүүхэн, чи яагаад манайхаас зугадсаан? Би чамайг гомдоогоогүй байх аа гэхэд Юмжирдулам

- Та их тусгүй хүн. Би таныг тийм хүн гэж санаагүй гэвэл

- Хай, би яасаан? Яасан ч юм байхгүй лаа. Муу юм хийсэн бол хамаагүй хэл ваа гээд данжаад өөдөөс нь гайхан харахад

- Та хар тамхи гэж муухай юманд намайг сургах гэсэн байна шүү. Тэр чинь хүнийг үхүүлдэг гэнэ. Би танайд дахиад очихгүй гэж Юмжирдулам хэлэв. Өөрийн хэлээгүй байтал бүсгүй яагаад хар тамхи гэж мэдэх болов хэмээн данжаад гайхан бодов. “Аа тиймаа тиймаа. Манайд очсоноо Доржид ярьсан байх нь. Тэр нохой толгойт хар тамхинд хэзээний дургүй, харааж зүхдэг. Тэгээд энэ залуу хүүхнийг надаас салгах гэж муучилсан байж таарёаа шүү” гэж данжаад бодоод төнхмөл муу санаагаараа хэргийн эзнийг зөв таав.

- Аа золиг оо! Тэр яах аа. Чамайг бие муу байна гэхээр чинь бё жаахан тат гэсэн шүү. Би бүх насаараа татаад яагаа ч үгүй байна. Би чамайг татаж сур гэж ердөө хэлээгүй. Чиний дурны хэрэг ваа. Ийм сайхан хүүхнийг хорлоё гэх санаа надад байхгүй. Ай, би чамд дандаа сайныг бодно. Гэтэл чи яадаг аа! Чи яасан муухай юм бодно оо! Чамайг би ийм хүн гэж зүүдлээгүй шүү. Хайяа, яасан тусгүй лаа. Одоо би яана ваа! гэж данжаад гаслантай үглэв. Данжаадын “Хай яа” гэж дахин дахин дуу алдан толгой сэгсэрч, байж сууж чадахгүй байгааг Юмжирдулам үзээд “Нээрээ ч би хэтрүүлчихэв үү дээ. Санаандгүй хэлсэнд нь Дорж гуай бид хоёр дэндүү муу санасан байж болох юм” гэж бодтол сэтгэл нь дорхиноо зөөлрөөд явчихав. Гэнэн туйлбаргүй бүсгүйн сэтгэл салхин хаанаас бол тийшээ хийсдэг хамхуул шиг бөмбөрч эхлэхийг дол цохисон данжаад сүржин авирлах завсраа сүйжин шилнийхээ цаанаас ажаад бас дахин нэг түншиж үзэхээр аяндаа мэдэгдэнэ гэж бодов.

- Чи нэгэнт зан хувирсан бол би яадаг ч аргагүй шүү. Гэсэн ч чамд дандаа сайн санаж явсных гэж сүүлчийн бэлэг өг ваа гээд босон нэг баадан задалж галын дөл мэт улаан шаргал өнгө нь туяа татаж гялалзсан хоргой гаргаж ирээд

- Цагаан сар ойртсон. Дээл хийж өмсваа. Энэ галд шатахгүй гайхалтай сайн ястай хоргой шүү. Би худал хэлдэггүй гэж чамд хэлсэн шүү гээд шүдэнз зурж барихад хоргой шатсангүй. Хоёр гар дээрээ хоргой тавчихаад өгөх санаатай сарвайж бөөвийн зогсож байгаа данжаадын гэмшсэн, гуньж гутарсан өрөвдөлтэй царайг харсан Юмжирдулам тэр бэлгийг нь авахаас аргагүй болов. Данжаад санаа амарсан бололтой санаа алдаж

- Ай Юмжаа, чи их сайн! гээд инээмсэглэн хоёр гуяа зэрэг алгадаад сандал дээрээ лүгхийн суучихав. Тэр хоёр нэгэн хэсэг таг дуугүй байлаа.

- Юмжаа, чи миний сайн санааг бодвол манайд ганц удаа морилж очваа. Дахиад очихгүй байсан ч би гомдохгүй лаа гээд данжаадыг босоход түүнд царай өгөхгүй байсан Юмжирдулам сэтгэлийн бөглөө арилж харин хүнийг хилсээр гомдоосон гэмээ цагаатгах нь зүйтэй юм шиг санагджэу.

Далай Юмжирдуламыг эргүүлж чадсандаа инээд алдасхийн их л маадгар сууж, түрүүчийнхээсээ өөр сайхан хоол архиар далайв.

- Би Монгу /монгол/ газар олон жил суусан болохоор монгу хүнд дуртай лаа. Монгу хүн цагаан сэтгэлтэй болохоор би ч бас санаснаа хамаагүй ярьж сурсаан гэж данжаад Юмжирдуламд улам тал олох гэж хайрцагтай юм авчрахад нь бас нэг гайтай юм гаргах гээгүй

байгаа даа гэж бүсгүй хардасхийн хэрхэгийг хүлээж суув.

- Чи надад муу санаж яасан ч болохгүй шүү. Би чамд дотор газрын бас нэг сонин юм үзүүлвээ гээд данжаад тамхиа нэрэ мөнгөлөг хайрстай жижигхэн буурцгийг гаансны толгойн тамхинд далд ортол шигтгээд асаан татахад утааны хамт зөөлөн анхилуун үнэр түгэв.

- За ямар байна гэж данжаадыг асуухад

- Зүгээр аятайхан үнэртэй юм байна. Бас өнөөх хар тамхи шиг чинь мансууруулчих юм биш биз? Үгээд Юмжирдулам үл итгэсэн харцаар нүд цавчихгүй ширтэв.

-Хай, яалаа гэж! Энэ янлиу гэдэг байна шүү. Тамхинд хийж татахад их гоё ваа. Чамайг манайд орж ирэхэд чамаас ийм сайхан үнэр гардаг шүү гэж данжаадыг хэлэхэд Юмжирдулам

- Надаас уу... Арай үгүй байлгүй гэж хэлэхдээ царай нь улсхийжээ. Түүний зааны ясан савх шиг нарийхан хуруутай цагаан гарт ганц удаа ч атугай хүрэхсэн гэж ямагт хүсэвч өөрөө ч зүрхлэхгүй, шалтаг ч гарахгүй дэмий л хорхойтохоос хэтрэхгүй байсан данжаад

- Үнэн байхгүй яах аа! Чи өөрөө мэддэггүй лаа? Үгээ хэлүүт бүсгүйн гарыг шүүрэн авч үнэрлэж байгаа болон хошуундаа хүргээд

- Хай, ийм сайхан үнэр байна шүү гээд хоол авчирсан тогоочид

- Чи бас үз ваа гэв. Тогооч бүсгүйн гарыг үнэрлэхчээн болоод

- Их сайхан юм гэж тал засан инээж мэхэлзсээр гарчээ. Далай Юмжирдуламын гарыг атгасан чигтээ “Энэ гарыг атгаж байгаа шигээ энэ турьхан биеийг хэзээ нэг тэврэх бол? Тэгвэл ёстой хорвоогийн жаргал мөн баа!” гэж бодтол хамаг бие нь сулраад явчих шиг болжээ. Далай Юмжирдулам руу яаран довтолж үргээлгүй алхам алхмаар ойртсоор нэг л цагт санасандаа хүрэх бодлыг хар санааныхаа мухарт хийчихээд ягуухан мярааж байгааг санаж сэрэх ухаан гэнэн бүсгүйд яахин байх билээ.

* * *

Цагаар сар болох ойртжээ. Хоёр хүн Юмжирдуламын байшинг ногоовтор өнгийн торгоор доторлоод дуусаж байлаа. Юмжирдулам хүүхдийн торгон дээл хийж дуусаад товч шилбий нь хадаж байв. Өөртөө данжаадын өгсөн шатдаггүй хоргойгоор дээл, булгаар малгай хийлгэхээр иргэн сойвонд өгчээ. Баян Дорж нэг өдөр тэднийд ирэхдээ,

- Ийм утаа тортог болсон байшинд яаж цагаалах вэ. Амьтны нүдэи дээр нэрээ бод гэхээр нь байшинг яаж засдагийг огтхон ч мэдэхгүй бүсгүй

- Тэгвэл яах вэ? гэж асуужээ. Гурван сар шахам болоход Юмжирдуламтай илэн далангүй ярилцаар тэднийд юу байгааг гадарлах болсон Дорж

- Торгоор доторлочих гэжээ

- Болдог юм уу?
- Болохоор барах уу дээд зиндааны баячууд л байшингаа торгоор доторлодог юм.
- Пэй, тэгвэл над шиг ядарсан амьтан торгон дотортой байшинд суувал амьтан муу хэлэх байх даа. Больё, чи минь
- Харин ч чамайг яахаа алдсан амьтан гэж дээрэлхэхгүй сайн байхгүй юу.
- Байшингаа торгоор доторлолоо гэж үү?
- Хөрөнгөтэй хүнд хэрийн хүн халдахгүй шүү.
- Би эндхийн явдлыг яаа мэдэх вэ... Тэгээд би өөрөө урьд нь байшинд сууж үзсэн биш, тэгж чадахгүй шүү дээ.
- Өө, тэгвэл би чамд хоёр хүн олоод өгье гэж Дорж хэлжээ. Ингээд Базарын жинчнээс авчирсан торгоны үлдэгдлийг үзэж байгаад өөр юм хийхэд өнгө муотай юм гэж энэ торгыг сонгож авсан билээ. Айлын охин гаднаас гүйн ирээд
- Эгчээ миний дээл дуусаж байна уу? гэж хөөрөн асуухад Юмжирдулам
- Одоохоо!... Чи хүлээж бай! гээд суганы нь товчийг хадаж дуусаад охинд өмсгөж хаваасыа нь сугалж авлаа. Тэгээд дээлий нь мялаан боов чихэр өгч байтал баян Дорж нэг ууттай юм барьсаар орж ирээд хонины чанасан том ууц гаргаж ширэун дээр нь тавиад байшингийн ханыг тойруулан харж
- Танайх ч шинэ байшинд орсон юм шиг болжээ гэв. Доржийг дандаа ирж байдаг болохоор ижил дасал болсон охин түүний өмнө ирж дээлээ үзүүлэхэд
- Эднийх чинь гэдсэндээ хийх хоолгүй байж мөрөндөө торго угладаг байх нь ээ гэж Дорж тэднийхийг басамжлангуй хэллээ.
- Эш хөөрхий, эднүүст юу байх вэ. Ганц би энэ их торгыг хэзээ эдэлж барах вэ гэж бодоод гурвууланд нь нэг нэг дээлийн өнгө өгсөн юм гэж Юмжирдуламыг өгүүлэхэд Дорж зэвүүцсэн бололтой “Хн” гэж хамраараа дуугараад
- Энэ муусайн гуйлгачингуудад сүйд болж юм үрээд юу хийнэ гэхэд Юмжирдуламын царай хувьсхийж
- Өө, та чинь ийм хүн байсан юм уу?.. Эд чинь над шиг л ядарсан улс. Та надад бишгүй юм өгдөг хэрнээ эднийд ганц цайны сүү хаячихдаггүй чинь ямар учир байна? Таныг ийм хүн юм бол би танаас юу ч горьдохгүй. Наад ууцаа ч аваад яв! гэж хэлчихсэнд ийм үг сонсоно гэж санаагүй байсан Дорж давхийн цочиж өөдөөс нь харвал, түүний хорсон зэвүүцсэн харцтай тулгарав. “Ямар түргэн зантай эм бэ! Үхрийн сүүлэн дээр хутга хугална гэгчээр авирсаар байж энд ирчихээд хулжаагаад алдах хэрэг болох нь уу? Одоо яах билээ” гэж Дорж бодтол түүний сэргэлэн ухаанд нэгэн сайхан санаа гялсхийн орж ирлээ. Дорж гэнэт уурласан янзтай

ухасхийн босож, шүд зуусхийн сүр үзүүлж

- Би хүнд тусгүй хүн биш, тустай хүн. Яах аргагүй гурван амьтан Улиастайд орж ирэхэд нь хар бор ажил олж өгсөн. Түүний хүчээр голоо зогоож байгаа биш үү? Эднийг хашаатай болгож, чамайг ханьтай болгож энд буулгалаа. Энэ чинь эр хүн, гурван амиа тэжээж чадна. Чи чинь арчаагүй бүсгүй хүн. Бас талийгаач чинь олонд тус болж явсан болохоор би ачийа нь санасан хэрэг. Харин тэгтэл чам руу гүйж байгаа хүн болох нь ээ. Ингэж адгийн муугаар дуудуулчихаад зуйрган хүн зулгаа барна гэгчээр шогшиж байгаа болъё чи минь. Хүн, хүн шиг байвал би хүн шиг л байна, чоно шиг байвал чоно шиг л байна гэж хэлээд шурхийн гарлаа. Хаалга тасхийхэд Юмжирдулам давхийв. Би буруу юм хийчихэв үү гэж бодоод үүд рүү алмайран харав.

- Би гэдэг дандаа тэнэглэж наашаа гэсэн хүнийг дандаа цааш нь түлхэж байдаг яасан үйлс нь хазайсан амьтан бэ! гэж Юмжирдулам амандаа үглэж, ухасхийн хаалгаар цээжээ гаргаж

- Дорж гуай! гэж дуудсан боловч Дорж эргэж харсангүй. Бүсгүйн бачимдсан дууг Дорж сонсмогцоо алхаагаа хурдасгаж “Миний бодол ганц зөвдлөө. Хурц үг маань сайн анчны сүт шиг зүрхийа нь яг онолоо. Араас дууддаг чинь өөрийгөө гэмтэй гэж санасных. Тэгэхээр Дорж цагаан сар болтол эднийхээр үзэгдэлгүй сэтгэлий нь тамладаг хэрэг” гэж бодоод ганцаараа инээмсэглэлээ.

Дорж өөрийнхөө бодсоноор сураг тасарсан мэт байсаар битүүний орой харанхуй болсон хойно эмээл хазаартай жороо морь хөтлөн Юмжирдуламынд иржээ. Болчимгүй үг хэлж нэг сайн хүнээсээ холдлоо гэж санаж байсан бүсгүй түүнийг баяр хөөрөө нууц чадалгүй угтлаа. Гэмээ наманчилсан байдал бүсгүйн нүүрэнд илхэн байгааг ажсан Доржийн сэтгэл амарч, тэгэхээс тэгэх гэж юу ч болоогүй юм шиг царай гарган “Ингээд л өөрөө бөмбөрөөд хүрээд ирдэгсэн дээ” гэж бодон дотроо инээд алджээ.

- Жил сар гарах гэж байна. Битүүний хуралд очиж хийморио сэргээвэл зүгээр биш үү? Чамайг явах болов уу гэж бодоод дайраад ирлээ.

- Сүм дугаг гэж энд чинь байдаг юм уу? Хотын эхэнд нэг сүм байсан тэр юм уу?

- Бишээ. Тэр чинь дотор улсын мөргөл хийдэг Гэсэд сүм. Манай монголчуудынх энүүхэн зүүн хойно улаан сүм нэртэй хурлын дуган бий.

- Хол юм бол явган хүнд явж барагдахгүй байх даа.

- Би морь аваад ирсээн гэж Доржийг хэлэхэд гурван сар унаан дээр гараагүй хөдөө нутгийн бүсгүй морь гэдэг үгийг сонсоод нүднийх нь гал цог гялалзаад явчихав. Юмжирдулам Доржийг гомдоохгүй гэсэндээ бус, морь унах хүсэлдээ хөтлөгдөөд хамт мордлоо. Бөмбөлзтөл тэшүүлсэн жороо морь унаж, шөнийн жаварт явахад бүсгүйн сэтгэл сэргэж, танхил бага насаа өнгөрөөсөн аглаг сайхан хөдөө нутгаа мөрөөдөж, зүрх нь булгилан цохилж байлаа.

Битүүний үдэш монгол иргэн хэдэн баячууд Далай данжаадынд цуглаж найрлав. Далай Юмжирдуламын нүүрэн дээр тэдэнд бэл бэнчингээ гайхуулах гэж хичээх учир тун ч нижгэр

бэлджээ. Хундаганы завсар бүрт нэг янзын хоол ирнэ. Тэд дуулж хуурдан сархад, наргиа хоёртоо сүрхий халамцаж байлаа. Далай данжаад, баян Дорж хоёроос бусдыа нь Юмжирдулам ер зүс үзээгүй билээ. Гурван данжаад ирсний нэг нь бордмол гахай шиг бүдүүн улаан, нөгөө нь өндөр ёохгор туранхай хөх, гурав дахь нь нас сүүдэр дал шахсан болов уу гэмээр бээцгэр өвгөн данжаад байлаа. Ширүүн харцтай монхор хамартай хөнгөн шингэн байрын насжуу хар хүн, архинд маш дуртай бололтой ид дунд насны тэвхийсэн чийрэг эр ийм хоёр монгол баян иржээ. Эл монгол баячууд данжаад нартай сүлбэлдэн наймаа хөдөлгөж хонжоо олж хөлжсөн хүмүүс байлаа. Улиастайн хоёр “байцаа” гэж тэдний өхөөрдөн нэрлэсэн нас дөнгөж гуч хэвийж байгаа болов уу гэмээр, нүд шүд сайхантай, хоорондоо төстэй ч юм шиг, хоёр бумбагар цагаан хүүхэн үе үе нүд солбиулан ирмэлцэж, Юмжирдуламд баахан атаархангуй янзтай цаанаа нилээд давлиун байдалтай сууна. Тэр хоёрын нэг нь монгол хувцастай нөгөөх нь дотор маягаар хувцаслаж, хоёул оо энгэсэг тавьжээ. Тэд Улиастайнхаа гудамжинд ургуулсан, ухаан алдан дурладаг хоёр “байцаагаа” өнөөдөр хүртэх хүслээр дурамжхан, харин эв нь таарвал уулын зэрлэг сонгиноос үмхээд авах санаатай байгаа нь хэний ч нүднээ илхэн. Юмжирдулам аваад үмхчимээр бяцхан сонгино шиг харагдавч чухам идэхийн цагт чинжүү гэсэн үг. Гэвч дотор хүн халуун ногооноос буцдаггүй болохоор аргалаад шингээчихийг хүсэж байлаа. Тэд үүнээс амс, түүнээс ид гэж бие биенээс өрсөлдөн нэг нэг савхдаж Юмжирдуламын ам руу барина. Тэгээд өөрийн гараар юу амсуулчихвал сэтгэл нь амарсан бололтой гэдийн сууж тааламжтай инээмсэглэнэ. Харин хоёр монгол баян, ширвэгдэж хоцроод хор шар нь буцалж байгаа хоёр “байцаатай” сээтэгнэлдэн аманд нь зууш савхдан хийж данжаад нарын ар хударгаар амиа борлуулж байв. Гэтэл баян Дорж урьд нь ихээхэн маасганадаг хоёр “байцаанд” ч сүйд болохгүй, Юмжирдулам руу ч тэдэнтэй зэрэгцэн тэмүүлэхгүй, бүсгүй хүнд сэртэнддэггүй юм шиг ирсэн хуидагыг тогтоочихоод төв байдалтай харагдана.

- Дорж өнөөдөр бид хоёр руу ч харахгүй юу болчихоо вэ?

- Хуучин ч үгүй, шинэ ч үгүй хоцров бололтой.

- Нүд нь ч тэр муу дээр байна л даа.

- Сайн лам олдохгүй бол буцахдаа бид хоёрыг залж нэрээ хөөдөх юм биш байгаа даа гэж хоёр “байцаа” шивнэлдэн тэрүүхэндээ дооайтой нь аргагүй час час инээлдэв. Юмжирдуламын хацар нь ягаарч зүс царай нь гэрэлтээд сэтгэл булаам үзэсгэлэнтэй харагдана. Талимаарсан сүүмгэр нүдээр тэр хүмүүсийн элдэвлэж байгааг шохорхон харахын сацуу, яагаад над руу тэмүүлээд байгаа юм бол доо гэж гайхширна. Түүний ялимгүй жимийсэн нимгэн улаан уруул дээр доогтой инээмсэглэл зурс зурсхан бүжнэ. Юмжирдулам, та нар ч хачин инээдэмтэй улс юм даа гэж бодохоос тэднийг шоолон элэг мэдгүй тас тас хөхөрмөөр санагдана. Тэдний дуулж хөгжимдөж инээж алиалах нь тун дадмаг. Юмжирдулам хааяа мэддэг дуу гарвал дагаж аялж, ихэнхдээ тэднийг харж сууна. Гэтэл тэд түүнийг тал талаас нь албадсаар дуулуулав. Юмжирдулам ичингүйрэх боловч их л хичээн дуулсанд

- Ай яасан сайхан дуулнаа!

- Ёстой дуучин байна?

- Ийм гоё дуулахыг ердөө ч үзээгүй шүү гэж данжаад нар хөөргөн магтсанд Юмжирдулам ичиж, нөгөө хоёр хүүхэн жөтөөрхөхдөө нүд нь сэлэм зөрүүлэх мэт солбиж алджээ.

- Далай энэ муу годгор амьтныг хаанаас олж ирэв ээ?

- Шар шүдэлсэн новшийг энэ нь тоох л юм байх даа.

- Бид хоёрт царай алдаж байгаагүй юм шиг эдний байж байгааг.

- Дахиад бид хоёрыг гуйх цаг бий.

- Тэр үед нь хөлнийхөө улнаас адис авахуулах юм шүү.

- Энэ хөөрхий амьтан юм үзсэн ёоз бий гэж үү? Нүдээ ч аятайхан ирмэчихэж чадахгүй байж байгаа ёрыа нь хөөе!

- Чи бид хоёр ийм л байсан шүү дээ. Энэ муусайн новшнууд л бид хоёрыг ийм юм руу түлхэж оруулсан даг. Одоо энийг ч удахгүй бидний өрөөсөн болгоно, харж л байгаарай!

- Ирэх жилийн цагаан сараар л ямар болсон байхыа нь харъя.

- Гангараад өгсөн байх биз. Тэр цагт эд нар энэнийхээ хөлд муужирч унах шахаае биц гэж хоёр халамцуу хүүхэн хоорондоо ууртайхан ярилцаж, тэднийг эгдүүтэй харцгаан, дотроо шатаж байгаа хор шараа дарахаар нэг нэг хундага архи хөнтөрч урт амьсгаа аваад, та нарт мөчөөгөө өгөхгүйдээ гэсэн шиг

- Улиастайнхаа голыг яасхийгээд туулья даа хөө... гээд тасхийтэл дуулж гарлаа. Юмжирдулам нилээд халж, данжаад нарын шахаад байгаа архийг амсах төдий буцааж биеэ барих гэж ядан суугааг Дорж ажиглаад, архи нь хэтэрвэл энд унаж Далайн зууш болно гэж сэтгэв.

- Та нар наад хүүхнээ битгий шах! гэж хэлсэнд нөгөө хоёр “байцааны” нэг нь хөндлөнгөөс дайрч

- Бид хоёр уугаад байхад энэ адилхан наргиж байж ууж согтож яагаад болдоггүй юм бэ! гэсэнд Доржийн уур хүрч

- Та нар шиг болчихсон хүн биш гэж хэлчихсэнд хоёр хүүхэн

- Бид хоёрыг ийм болгоход чиний хувь нэмэр багадаагүй дээ хө!

- Чи хэнийа нь өмгөөлж, хэнийа нь гаргуунд нь гаргадаг хүн бэ?! гээд агсарч гарсанд хоёр монгол баян хорьж аргадаж байж намжаалаа.

- Должоо! Чи бид нэг санаатай шүү. Ингэж болохгүй лаа. Энэ хүүхэн увал ууж л байг. Чамд ли ч үгүй лаа! гэж өндөр ёохгор данжаадыг хэлэхэд Дорж

- Би хэзээ ч та нартай нэг санаатай биш гэвэл бүдүүн улаан данжаад

- Санаа нэг байтугай төр нэг болчихоод байна шүү. Манай цэрэг Да хүрээнд байгааг мартаагүй лаа гэж басамжлав. Эд нар цэргээрээ түрээ барьж бидний амыг үдэж, гарыг хүлэх санаатай вий гэж санахаас Дорж омог шар хөөрч
- Та нар Шанхайгаас шаахайгаа, Гуандунгаас гутлаа чирч ирчихээд Монголын хоолонд сагаж даврах болоогүй шүү гэж шазруун хэлсэнд
- Бид тэндээ ч юмтай байсан шүү. Баян хүний сэтгэл ханахгүй улам баяжих гэдгийг чи мэдэхгүй яах аа. Тэгээд л Монгу газар ирсэн баа гэж угийн ягир ядуугаа дуудуулсанд нэрэлхсэн өвгөн данжаад өгүүлэхэд Дорж
- Та нарыг монголын шороо долоож баяжсаныг би мэддэггүй гэхэд миний эцэг мэддэг байсан шүү гэв. Гамин цэргийн хөлд гишгүүлж байгаа цагт данжаад нартай эвдрэлцвэл хожим өөдтэй юм болохгүй гэж хаширласан монхор хамарт монгол
- Дорж минь согтуудаа илүү дутуу юм ярьж байж сайн түншүүдээ гомдоож юу хийх вэ гэж аргадангуй дуугарав. Тэгэхэд нөгөө эр нь
- Ёстой тийм. Сайхан найрлая, сайхан найрлая гэж давтаад хундагатай архиныхаа хагасыг нь балгаж үлдсэнийг нь бага “байцааны” аманд барихдаа нөгөө гараараа гуяыг нь илээд авлаа. Доржийг омогтой залуу хүн болохоор надгианыг маань юу ч биш болтол самарч мэднэ гэж болгоомжлон түрүүний дуугарахгүй байсан Далай данжаад энэ эгзгийг шүүрч
- Манай Долж их сайн түнш шүү... Шинэ баян цээж өвчтэй, хуучин баян хулуу өвчтэй гэж танай мэргэн үг байдаг. Бид хэд одоо хулуу өвчтэй болж, Дорж түнш цээж өвчтэй дээрээ байгаа хүн гээд албаар инээж өөрөө хундагаа өргөн цөмийг нь ав гэж дохиод
- Энэ Доржийн шүд нь ургаж гүйцээгүй байна. Шүд нь гүйцэхээрээ ч бэрх чоно гарна даа. Над шиг Бээжин ордог бол хөлгүй баяжих хүн. Даанч малынхаа бэлчээрээс гарахгүй болохоор явдал нь богинодсондоо миний гарт баригдаад толгой дээгүүр гүйж чадахгүй байгаа юм. Надад ч их юм залгуулж өгсөн дөө. Хэн хэнээ л тоншсон байх” гэж Далай бодолхийлэн Доржийг ажин наймааны одтой арга зальтайгийг нь гайхахын сацуу алсдаа өөрсдийнхөө хосыг сугалуулах бий дээ гэж эмээсхийнэ. Дорж ч гэсэн Далайтай тэрцэхийг хүссэнгүй, дотор хүнтэй өөрийнх нь аргаар үзнэ гэдэг зангаа умартаж тэдэнтэй дэмий шөргөөлцсөндөө өөрийгөө зэмлэв.
- Далай гуай, Юмжирдулам бидний аяыг даахгүй ядарч байх шиг байна. Хүргэж өгнө байгаа гэж хэлээд бүсгүй рүү Дорж сэм нүд ирмэжээ. Толгой нь хааяа эргэх шиг болж, нүд нь маналзаж арайхийн суусан Юмжирдулам
- Одоо би харихаас болохгүй. Дэндүү оройтчихлоо гээд өндийхөд Далай данжаад хориглож зүрхэлсэнгүй.
- Би хүргэж өгөөд ирье гээд Дорж босож Юмжирдуламыг түшиж авлаа. Далай бичээчээ дуудаж, Доржийг тэнд орхилгүй сахиж байгаад хамт гараадаг гэж чихэнд нь шивнэжээ.

Монгол иргэн хэдэн хөлчүү хүний дуулж орилолдох, чанга чанга ярих нь Юмжирдуламд зөгий дүнгэнэлдэх мэт тээртэй санагдана. Бүсгүй хоёр өдрийн найрнаас залхаж гүйцжээ. Зул сарын ноход шиг Үмжирдуламыг даган эргүүлдсэн тэд хэд шинийн нэгний орой гэрт нь ирээд найрлаж байгаа нь энэ. Архи хоолыг Далай даажээ. Иргэн тогооч пийшин дээр хоол хийж бөндөгнөн гал тасрахгүй учир халуун бүгчим гэдэг жигтэйхэн Тамхины угаа адар тулан хөшиглөж, архины эхүүн үнэр өрөө дүүрэн ханхлах нь тэднийг архины торхон дотор сууж байна уу гэлтэй.

- Би монгу газар олон жил суусаан. Одоо монгу дуу дуулваа гэж Далайг хэлэхэд бусад нь тэг тэг гэж инээлдэв. Далай толгойгоо далжийлган намжиртай хөдөлгөж

- Цонхон дээгүүр... цонхон дээгүүр... цонхон дээгүүр... гэж гурав дахин эхлэх гэж оролдоод давалгүй

- Хай, Юмжаа! Цонхон дээгүүр юу байна аа?.. Жоомоо биш ваа гэхэд бүгд нирхийтэл инээлдэв.

- Та “Цонхон дээр суусан ялаа” гэж дуулах гэсэн юм уу? гэж Юмжирдуламыг асуухад данжаад

- Тиймаа, тиймаа. Ялаа байна шүү. Арай жоомоо бишээ байх аа гэснээ

- Ай хүүхэн, чи нэг гоё дуу дуулваа гэхэд нөгөөдүүл нь бас л шалж боорлов. Юмжирдулам шанзаа авч хөгжимдөн

Замбуулингийн нарыг үүл нь яагаад хаана вэ,

Залуу зандан насыг минь зовлон юунд дайрна вэ.

Хорвоогийн жаргалыг амсаагүй хонгор нас минь хөөрхий еэ

Хотол түмнээс ангид хоёрхон бие минь хэцүүеэ

᠗эж агуйд байхдаа дуулдаг байсан дуугаа гэгэлзүүлсхийн дууллаа. Тэгээд амсаж өнгөрүүлсэн зовлонгоо өөрийн эрхгүй дурсаж “Хайртай хүнээсээ хагацаад гуравхан сар болж байхад би ийм амьтастай ингэж суудаг даанч яав даа” гэж санахаас дотор нь багтарч хөгжмөө орхиод асгаруулан уйллаа.

- Цагаан сар гарч байхад уйлж яана. Муу ёр байгаа даа гэж нэгнийх нь унтууцахад Далай

- Хай, зовлонтой хүн уйлахгүй яах аа, юун дэмий яринаа гэж бүсгүйг өмөөрсөн нь цаанаа бас л нэг бодолтой мэт.

- Толгой эргээд байна. Ёо ёо, дотор дотор. Та намайг салхинд гаргаад өгөөч! гэж Далай Дорж хоёрын дунд сууж байсан Үмжирдулам элгэн дээрээ дарж зовиуртай, ярвайж Дорж руу налав. “Эдэн дотроос над л элэгтэй байна шүү. Миний бодсоноор бол ингэх л ёстой” гэж Дорж бодоод тэдэнд эрдэж бардсан дуугаар

- Энэ чинь та нар шиг архины хөнгөө биш шүү. Юунд тэгтэл архи шахдаг юм бэ гэж хэлээд Юмжирдуламыг сугадан гарлаа. Дорж бүсгүйн цээжин дээр дарж, хоёр гарынх нь булчинг зөөлөн атгаснаа
- Элгэн дээр чинь цанхайгаад байгаа биз? гэж асуухад нь бүсгүй огиулангаа толгой дохилоо.
- Би жаахан илээтэхье. Тэгэхээр зүгээр болно гээд Дорж элгэн дээгүүр илж байснаа сурсан юмыг сураар боож болдоггүй гэгчээр гар нь өөрийн эрхгүй хоёр хөх рүү нь хүрч байхдаа дургүйцэхгүй байна шүү гэж боджээ.
- Овоо боллоо. Өнөөх цанхайдаг чинь намдлаа гээд Юмжирдулам босов.
- Нэмж битгий уу! Дахин эвгүйрхэж зовооно шүү.
- За... Архи чинь аймаар юмаа.
- Цаадуулаа одоо тараа! Далай л хоргодоод цаг нөхцөөж мэднэ шүү. Бас согтсон болохоор чамайг амрахгүй. Дотор хүн горьгүй шүү. Чи Далайг яв гээд шавдуулчих. Цаадхи чинь нэрэлхүү юм болохоороо бусадтайгаа хамт яваад өгнө.
- Тэгье тэгье. Ерөөсөө хэвтэхгүй бол над шиг хүн эдний аяыг даахгүй юм байна.
- Хэрээ хэр. Харин ч чи хоёр өдөр тэслээ. Овоо шүү гээд Дорж бүсгүйн толгойг илээд орлоо. Дорж жаахан сууж байснаа
- Орой болж байх шив. Одоо амрахаа бодъё. Олон хоног ингэж салбайна шүү дээ гээд нэг хундага уухад Алай,
- Азнаж байгаад хамтдаа явахгүй дээ гэж хэлж байвч харц нь бушуухан гарахыг нь хүлээж ядан догдолж байгаа сэтгэлийн нь нууж чадсангүй. Дорж түүний харцыг ажаад “Чи мөнгөөрөө дандаа намайг цохидог бол би санаагаара ганц удаа ч болтугай чамайг давна даа” гэж бодон араандаа зуувч нүүрэндээ хуурамч инээмсэглэл тодруулан байж,
- За хүндэт та бүхэн маргааш өглөө манайхаар морилж очоорой! гээд мэхэлзэн гарчээ. Дорж Далайг чимээ чагнаж байж магадгүй гэж бодон хаалганы хонх дуугаргачихаад байшин түлээ хоёрын завсарт орж нуугдав. Түүнийг гарснаас хойш удалгүй бусад хүмүүс аргагүйн эрхэнд явлаа. Юмжирдулам хашааныхаа хаалгыг түгжээд ирэхэд Дорж үүдэн дээр нь зогсож байсан учир гайхахдаа
- Хүүе, та чинь яваагүй байсан юм уу? гэж дуу алдав.
- Далайг явахгүй чамайг зовоож магадгүй гэж санаад эргэж ирлээ.
- Далай гуай тун дурамжхан гарсан. Харин бүр манайд очъё гэж байхгүй юу.
- Тэгнээ тэр. Би эс хэллүү гээд Дорж тэдний орлоо. Юмжирдулам түүний гарахыг хүлээн суув.

- Чи хэвт хэвт. Би ингэсхийгээд явна. Бие чинь эвгүйрхвэл хэнийгээ гэх вэ гэж Дорж хэлсэн нь хүний хайр халамжаар гачигдаж яваа бүсгүйд их л аятайхан санагджээ. Юмжирдулам орондоо ороод нилээд болсон боловч Дорж суусаар л байлаа.

- Та явахгүй юу. Би унтмаар байна.

- Нэг л гарамгүй санагдаад байх юм даа. Чамайг өрөвдөөд ч гэх юм уу, хоргодоод ч гэх юм уу... гээд Дорж хүнгүнүтүл санаа алдав. Бас нилээд удлаа. Бүсгүй хааяа хөдөлнө. Амьсгал нь унтаагүй хүнийх мөн гэдгийг Дорж андахгүй байлаа. “За байз яадаг юм билээ? Аль аль ч үгүй жигшээчих бий дээ. Юм ганзагалаад нэг жигшсэн морь дахиад хавьтуулахгүй хялайн харж хамраа тачигнуулан цовхочдог шүү. Надаас жийрхэж туйлсан чигтээ Далай данжаадын өвөр рүү давхиад орчихвол мөн алав аа... ! Юутай ч гэсэн нэг ахидаг хэрэг” гэж Дорж эргэлзэн байснаа зориг орж лаа унтраасанд бүсгүй

- Та яаж байгаа юм бэ? гэхэд нь дуугарсангүй зөвхөн санаа алдаж хариулаад “Ингэхэд ч бүсгүй хүн хэртэй бол хатуурхдаггүй сэн” гэж бодоод орон дээр нь сандайлав.

- Та болиоч дээ. Яах гээд байгаа юм бэ?

- Ийм бодол миний зүүдэнд ч ороогүй юмсан. Гэтэл өнөөдөр, бүр сая гэр өөдөө явж байтал ийм нүгэлтэй юм санаанд орчихлоо. Чамайг гомдоох байх гэж бодоод толгой минь гэр өөдөө зүтгэж байхад хоёр хөл минь энд аваад ирэх юм даа. Яахыг чиний сэтгэл мэдэж дээ. Намайг туужуугаар нүдээд хөөж гаргасан ч чамд гомдохгүй гэж хэлээд Дорж яах ч аргагүй болсон хүний дүр үзүүлэж “Ай хөөрхий” гээд гүн санаа алдав. Тэгтэл бүсгүй “Нээрээ урьд өмнө нь яадаг ч үгүй байсан биш үү? Сая бодсон гэдэг нь ортой байх... Эс вэл намайг хүсээд байсан мөртөө сэтгэлд нь юм хийчихнэ гээд оролддоггүй байв уу” гэж бодоод хөнгөн санаашрав. “За тэр шүү. Дохио нь мөн дөө. Сэтгэл нь уярч байна. Ингэхлээр л...” гэж бодоод Дорж хажуугаар нь оров. Юмжирдулам “Хичнээн сар би ингэж ганцаар хэвтэх билээ дээ. Хэн нэг хүнтэй энгэр зөрүүлэх нь магад. Үйлийн үрээр учрах тэр хүн нь энэ юм болов уу? Эхнэргүй гэж байсан. Ханилья гэвэл би яах вэ? Гэм нь арав гаруй ах юм даа. Гэхдээ л залуу хүн шүү дээ. Хамраараа газар хатгаж яваа надад ийм хүн түшиг болохгүй гэж үү... Хагацал зовлон үзээгүй бол би юунд ингэж сэтгэлийн тамд унах билээ” гэж бодтол хоёр хацрыа нь даган нулимс бөмбөрлөө. Халуун нулимс хацартаа хүрэхэд Дорж

- Би гэж нэг газрын гай шиг амьтан чамайг гомдоочихов оо доо гэж өөрийгөө зэмлэгч болон нулимсыа нь арчингаа үнсээд авахад бүсгүй дуугараагүй учир өөрөөс нь болж уйлаагүйг зөнгөөрөө мэдээтэхэв. Тэгээд гарыа нь атган хацрыа нь илж таалахад бүсгүй хөдөлсөнгүй. Сэтгэл нь холбилзож байгаа ийм үед зөв ярихгүй бол толгойдоо ороолгон морь шиг гэнэт эргээд тангарчихвал яана гэж Дорж сэрэмжилж, зүрхэнд нь хүд- байвал юу ч ярьсан яах вэ гэж бодоод,

- Би одоо л баян тарган жаргалтай яваа болохоос биш, үхэхээс бусдыг үзэж, үйл тамаа цайж явсан хүний нэг дээ. Амьтан хүнд ад шоо үзэгдэхээс эхлээд аль зовлон зүдгүүрийг тоочиж барах вэ! гээд өөрийн нэгэн танил хүнийхээ багын явдлыг өөрийнх болгож баахан нэмэр хачиртай ярив.

- Ухаан заль хоёрыг уралдуулж явахгүй бол энэ хорвоо дээр бидэн шиг улс амь зуухад хэцүү дээ хэцүү гэв. Түүний ярианд бүсгүйн сэтгэл уярлынхаа туйлд хүрч, тэгж зовж байсан хүн ийм болчихоод явж байхад надад ч бас замаа зөв олбол жаргах зай байгаа юм байна гэж боджээ.

- Гарч байгаа жилдээ ямар явах шинж нь эхний өдрөөсөө мэдэгддэг гэж хөгшчүүд ярьдаг. Уйлаад яах вэ. Зовлонтой гэж орондоо бүү уйл, жаргалтай гэж орондоо бүү дуул гэж бага байхад ээж минь хэлдэг байж билээ гээд Дорж бүсгүйг үнсэхэд

- Тийм дээ гээд өрөвч хүний зүрх шимшрэм санаа алджээ. Сэтгэл нь дэнсэлж уяран хайлсан бүсгүй биеэ эзэмдэх сөгөөгүй болсныг мэдсэн баян Дорж дураараа дургив. Есөн шид нь бүрдсэн албин чөтгөр шиг энэ хүн гэнэн хонгор бүсгүйг яагаад ч мултрах аргагүй торон дотор гурван сарын турш хоргоон зовоочихоод эцэст нь илбэ үзүүлэн наадаж, хэргүй сайхан сэтгэл ариун бие цогцсыг нь буртаглаж байхдаа бахаа ханан инээмсэглэж байсныг нь хөөрхий бүсгүй түнэр харанхуйн хөшгийг нэвг хардаг нүдтэй байгаад үзсэн ч болоосой!

- Тэр хоёр нам унтаад үүр цайх үеэр сэрсэнгүй. Өглөө болчихсон хойно Дорж босож биеэ займчин ууцаа хөдөлгөж суниагаад хувцаслав. Юмжирдуламын толгой нь дүнсийж, бие нь буларчихсан юм шиг янгинаж байлаа. Аргагүйн эрхэнд босохоор өндийхөд царай нь их л шаналгаатай байгааг ажсан Дорж,

- Чи жаахан хэвтэж биеэ амраасан нь дээр байх аа. юундаа яарах вэ гэж хэлэхэд нь Юмжирдулам түүнийг цай чанах гэж байгаа юм байж дээ гэж дотроо баяртай байв. Гэтэл Дорж гудиггүй царайлан нааш цааш таахалзан алхаж данх сэгсрэн хүйтэн цайны шавхруу залгилаад

- Дотор жаахан тиймхэн байх чинь. Чи яаж байна гэж буруу харсан чигтээ хайнгадуу асуув. Тун ч хүе́дуй хөндий дуу сонсоглоо. Өнөөх санаа алдаж, салж хагацашгүй мэт энхрийлэн наалдаж байсан Дорж бус, тэс өмнөө хүн шиг харагдлаа. Түүнийг хамгийн сайн хүн гэж санадаг болохоор ганц шөнийг өнгөрөөхдөө сэтгэл тавин ээнэгшиж байсан бүсгүйн дотор ширхийж, зүрх нь эмзэглэн өвдөх шиг болжээ. Дорж лонхтой архианаас шаазанд хийж уугаад нударгаараа хошуугаа арчиж, Юмжирдуламын дэргэд ирж тонгойн үнсэх гэхэд нь дотор муухай оргиулсан архины үнэрээс жигшиж Доржийн хайхрамжгүй байдлыг ажсан бүсгүй нүүрээ бултуулав. Тэгэхүд нь Дорж үнсэх гэж ч улайсан ч үгүй. Энэ чинь наалинхай ялдам зантай, халуун янаг үг чихнээ шивнэж хоносон өнөөх Дорж маань биш гэж үү хэмээн бүсгүй сэтгэл шимшрэн бодлоо.

- Чи аажуухан босож замдаа Далайнхаар дайрч хамтдаа манайд очоорой! Далай чамайг оролдох л байх. Биеэ яаран битгий өгөөрэй! Юмыг нь салгаад байдаг юм шүү. Өөрийгөө үнэд хүргэнэ ээ, хө гэж Дорж хэлээд инээхэд түүнийг өөртэйгээ хамт тавтай цайлаад цугтаа явах юм байх гэж горилон хэвтэж байсан Юмжирдулам хүний сэтгэлд багтамгүй ийм үг сонсоод ичсэндээ хөнжлөөрөө нүүрээ битүүлж гомдсондоо мэгшин уyllлаа. Яах вэ, ингэж байгаад л цагааширна биш гэж бодсон Дорж түүнийг аргадаж нялганасан ч үгүй, хэрэггүй юмаа хог руу шидчихээд явж байгаа хүн шиг хоолойгоо зассаар гарлаа.

Шинэ цас орчихжээ. Нарны хурц гэрэлд бүх юм шив шинэхэн юм шиг нүд гялбам харагдана.

Дорж цэнгүүн сайхан агаар шунаглан амьсгалæ “Ялзарч гүйцсүн шавар тагзанд толгой өвдчихөж” гэж амандаа бувтнаад, нуруугаа үүрч, ууц нь чилж шархирах учир оёнготсон бух шиг хөлөө чирсхийн, Юмжирдуламын сэтгэл шиг цавцайсан цагаан цасан дээр палигар гутлаараа гишгэн том хар мөр үлдээж буртагласаар алхахдаа цэцэгт сайхан нугаар цэнгэн зугаацаж байсан ариун шүтээн мэт бүсгүйг үмхий балчигт шидсэнээ юман чинээ бодохгүй, Дорж гэдэг хүн гарч байгаа цагаан бичин жилд азүйб нь тэнгэр гийж, олз омог арвинтай мөн ч одтой байх нь дээ гэж баясан инээвхийлж хамраараа гиншигнэн дуу аялж явлаа.

“Ээ, бурхан минь! Би чинь юу хийчихэв ээ? Хэзээ ингэж амьтан дагаж архидаж найрлаж явлаа даа. Ямар шившигтэй юм болох нь энэ вэ! Энүүн шиг бузар булай юм гэж байна уу? Миний энэ толгой юугаа бодож ангайж алгуурлаж явсан юм бэ!” гэж бодох тусам гутрал цөхрөлдөө давчдан уйлж байсан Үмжирдулам дотроо бага зэрэг уужрахад сая сэхээ орж нэвширтэл санаа алдан, өндийж суугаад, цахилдгийг дов шиг сэгсийсэн толгойгоо илэн зовхи нь бүлцийж улайссан уйтгартай цийлгэр нүдээр өрөөн доторхийг гүйлгэн харлаа. Хагас дутуу идсэн хоолны шавхруутай аяга таваг, халбага сэрээ, янз бүрийн лонх, архины жүнз хөглөрч, сандал ширээ ундуй сундуй байх нь дур гутмаар. Муутуу цаасан цонхны онигор сараалжин нүхнүүдэд шөнийн орсон цас шавж гэрэл нэвтрэхгүй шахам болжээ. Бөглөрөх шахсан цонхоор тусаж байгаа бүүдгэр гэгээнд өрөө доторлосон ногоовтор торгоны өнгө хувирч үхмэл зэвхий саарал даагаад сэтгэл хэрдхийн зэвүүн байлаа. Ертөнцийн нар сэтгэлийнх нь нар хоёр хоёулаа алга болж, санаа бодол нь эзгүйрч хоосорсон юм шиг бүсгүйд санагдана. Хуншгүй зан гарган аль хэдийнэ нүднээ далд орсон Доржийг санахаас түүний сэтгэлд хорсол заналын бараан үүл зангираад ирэв. Юмжирдулам “Яагаад” гэж өөрөөсөө асуун өнгөрсөн явдлыг эхнээс нь дэс дэсээр бодон бядуухан ухаанаар шүүж үзтэл, амаа ангайсан олон цөөвөр чоно бие биеэсээ өрсөн үмхэхээр өөрий нь тойрон отож байсныг гэнэт ухаарав.

- Та нар нэг нэгийгээ барьж хэмээх шахан над руу дайрч юугаа ч хайрлахгүй шидэлж байдгийн чинь учрыг одоо мэдлээ! гэж хөмхий зуун заналаа. “Хайрт хань минь үнэн, үнэн гэсээр амьсгал хураасан биш үү? Тэр үнэн надад ч бас олдохгүй, би эдний худал хуурмаг бүхэнтэй хутгалдах хэрэг үү” гэж бодоод Юмжирдулам орноосоо үсрэн бууж

- Та нар тэгж хүнийг гаргуунд нь хаядаг бол би өөрсдийн чинь дурыг нь дагуулж нэг нэгээр нь энд авчраад тонилгож хайрт хүнийхээ өшөөг аваатахъя гэж үглэн уурласан охин бар шиг өрөөн дотроо нааш цааш тогтож ядан холхиж уйтгар гуниг бүрхсэн нүүрэнд нь хорсол хилэнгийн оч гялалзана.

- Болохгүй, болохгүй. Би чинь бүсгүй хүн. Яаж хүний аминд хүрч зүрхлэх юм бэ! Нүгэл болно шүү дээ гээд бачимдаж багтарсандаа уйлав.

- Дорж сая юу гэлээ? Тийм, тийм. Намайг үнэя хүрнэ гэсэн. Миний бие тийм их үнэтэй юм бол та нараас талийгаачийнхаа өшөөг энэ биеэрээ насан туршдаа авья. Хүч чадалгүй өчүүхэн бүсгүй амьтан болохоор надад энэнээс дээр арга олдохгүй гэж Юмжирдулам бодоод санаа алдахад сэтгэл нь хөнгөрөх шиг болжээ. Ханын цагны хөхөө тонгос тонгосхийн арван удаа донгодлоо. Хүний оюун санааг хумхин базсан, бүүдийсэн гэгээтэй умгар тасалгаанд түмэн хөхөө нэгэн зэрэг донгодовч хөөрхий бүсгүйн гансарсан сэтгэлийг сэргээж яахин чадах билээ!

Үржил шимтэй сайхан хөрсөнд үндсээрээ бат сууж наран өөд тэмүүлэн ургаж байсан, тгүний нүд булаасан үзэсгэлэнт цэцгийг энэрэлгүй хорвоо ийнхүү хайр найргүй булга татан хүчит эргүүлгэндээ хумин авч, шавар балчигтай хутгалдуулан урсгаж одлоо. Тэр ариун цэцэг урсгал даган хэзээ, хаа хүрч, ямархан хувь тавилантай төгсөхийг мөхөс бичээч миний ухаан мөрдөж үл гүйцмүү.

Тэрэлж Улаанбаатар

рашаан сувилал

ÝÍÝÐÝËÃ´É

ÕîÐÁîî

DDC

894,23’3

Á-983

Æ.Áÿíáà

Ðåååèðîð: ×íéáàèñàíàèéí Íàðàíîÿóÿã

Äèçàéíàð: Õç÷èòáàààðàððíí Àíàððçàøèí

Ïÿæýèèéí ÿðèèã: Áÿíáííí Æààðèè

Õààðàñííú çóðãèèã: Ä.Áàðñóóððü

Õààðàñííú ÿðèèã: Áàÿíí°íðèèí Îðñííáààðàðð

Ïÿæýèèã øèèæñýí: 2007.03.01

Õààñííú ðÿíæÿý: 60ð90/16

Ïÿæýèèéí ðóóáàñ: 12.75

Á°íèé áíèíí æèæèãèÿíàèèí ðóáàèèàà:

Óðàñ: 459790, 55150744, 55155154

Ôàèñ: (976-11)-462616

E-mail: selengepress@magicnet.mn

“Ñÿéÿíáÿíðàññ” ÕÕË-íú ðÿæÿýð çèèãàÿðð ðÿæÿÿá.



“Ñýéýíāýíðāññ” ÕÕÊ-ā çîðèîā÷èéí ýðð àèāáí ññîð ðāāāāèāāñāí áíèíí.

Ýððèýí āāðāāā÷èéí ç°āø°ð°ēā¿éāýýð āāðèí ðýāèýðèéā ðîðèāèííí.

ÝÍÝÐÝËÄ-É ÕÎÐÂÎÏ

Óóò íü ðîîððîé ÷

·ðñè íü °ā°ðð°°

1971 íā íî ðýāèýāāýí āāðñíü āāðāā “Óóò íü ðîîððîé ÷ ðñè íü °ā°ðð°°” ø¿¿¿æèéā àè÷èí āāðāñāí áíèíā÷ āāðāāāāā 1991 íā “Çîðèñð àýèāóó” ñííèí (5.24 110)-ā ðýāèýñíèéā ýíā ýíðýóāýí ðāðóóèèā.

Ýíý ø¿¿¿æèéā àè÷ñýíýýð ìèíèé àèā òóðāéí ¿āāýý ìèèýýā ø¿¿¿æèýè ð¿ððýýā āāñāí.

Óíøìāāø çîðèîā÷ íü ðýçýý ÷ ñ¿¿è āāðññāíā¿é āýý āýæ ðýèíýýð, àèü ÷ ¿āā òíøèā÷èéí á¿òýýè÷ èāýāðèéā ñýðāýýæ ÷āāāð “ðóó÷èí íî” òāāðāèāāāā. Õèéí íî íýā òāèúí °ð°ñā°è ¿íýèāýýíā °ð°æ “øóóāèāíāāð” āāðāāāāā áíèíā÷ ¿çýè áíāèúí ðóāüā “ðāðø” āýāāýð ðí÷ òāèāñ íü ýðāýí ýðèèòāð áíèíāè āāéð þì.

“Õ¿íèé íýāýí íāñāíā ðíðāíñāèéí á¿ð ýāāāè ðóāüñāí °ð÷è°āā°ðèéā ¿çèýý” āýæ àíüāðāè ðýíýýí “èð ñāāíü” āíòîð þó ýñ āāāðòāðüā ðýèýð çîðèîā āāāððóóā āāð÷ èðñýí ðñāíü íýā áíè Æ. Áýìāúí “Ýíýðýèā¿è ðíðāíñ”, “Õîðāíñāèéí °íā°”, “-íýíèé ðíðāíñ” ðýíýýð āóðāè þì. Ýíý ðñāí āó÷ āāðóé (1971) æèèèéí °í°ñ íýā áóñ óāāā ðýāèýāāýæ, òíøèā÷èā āāð āāìæóóèāí ¿çāýā çîðèíèúí ðñíā ðýāýýðýý ýāíā. Çîðèíèā °ðí°ñ°í àíüāðāè ðýíýýð “èð ñāāíāāñ” °ð °ðèéí óóóíü ðýíæýýāýýð òóāðāè ðñāíü āāāððóóā āā÷ āāéíā.

Àíüāðāèúí °ð÷è°āā°í ðóāèðāð æāíüā ýíýāðýé ð¿íèé ðóāüā °ððèéí āýð íóððóóàé, ÷èā çîðèèāíòíé çàèæ, àæ ò°ðè° āýð çóóðúí ìð÷íñ ðñèðñíèā¿éāýýð ðèéāýā ó÷èððāèā ¿ç¿¿èæ ÷āññāí íü ýð ð¿íèé í°íð í°èā°íā èè òāýýāāýð āð÷āāāā àèāñāí “æāðāèèā” ðóóðòāāāā÷āāā ñóðāñāè °ā÷ āāéíā.

Íèèāíèéí íèíí āāāðāðāüā ò°è°èñ°í ā¿ð¿¿æèéí ðóāüā íèíí òðāāèü÷ òðāāðāè āíòîð “... ¿íýí āíòíññāíð āāèāí āýýð íü àèāāāā÷”-āāðāā ýèāāð÷ áóé āāāððóóā ¿çñýí āóóèññāāðāā ñýðýýð÷, ðýðā¿¿èæ èāýýèāýñíýýðýý āāýæāāā áíè “Åāð áāíāāðüā” àèāñ÷ íýāýð ðíøèí āýñ āāāðāð áéé.

Àèā, ðýè, ñýðāýèèéí °íā°íā ðñāðññā òðāí ¿ñèéí òóāāāíā óýāíü ìðüā øèā ìðñèññíí āāāððóóāúí àíüāðāè íü “èāýð çàèóó íāñòāé, èñāýèýí ðāèóóí àèāðýèāýý °ðèèā° ñāéí ç¿āð āāé÷èèæ àìæāèè íóó þì ìðñāíñð ðñññí çàé ¿èāýðā¿é”-ā °ā¿¿èñýí ç°í ññāèíāèéí íýāðýíæðýé āāèāā íü “Õèñ ò°ðèéí òāāüòāð” āāāññāí ðýðýā àèø āāéíā.

Õ¿íèé ¿è òāíèāāāð ÷āíāðüā āóóèèāí øóóāèāíü ¿ç¿¿èāýýð áíèññāè °íā°è°ð àè÷èýāýýñ ýèāāðññíüā “... Õðāíñññ á¿ññā¿éí āóíèāðāè ýðèā”-íā ¿è ñýæèèèýð Àèèā¿¿í è¿āýý íèèñññññ òóñ ìðññíí ñýðāýè ç¿éí ø¿¿¿æèè òāíüā òðèèāā.

IÇY-èéí ãèøìí, óðãà çîðêîîî ñóãèàà÷

Ä. Õìì

Зохиогчийн сургаал үгс

Үзүсгэлэн гоо төрнө гэдэг

Үзсэн бүхний нүдний чимэг

Эрх ямбандаа омойтох аваас

Энэ биенд халтай буюу

Ухваргүй нэгэн хэргээс

Удаах мянга нь үүсмой

Амьдралыг тунгаан бясалгаваас

Аминдаа зөв ухаан суумой

Хэргэм зэргийн хүслэн

Хэтийн явдалд халтай

Харц ядуус хоосон ч

Халуун сэтгэлээр баян

Шооны нүх, хаашаа бол

Хүний заяа тийшээ

Үнэн цагаан сэтгэлийн толь

Гэнэн хонгор нас хөөрхий

Төрийн нэр барьж зоргоор загнаваас

Түмэн олонд зовлон хураамой

Авилгач санаатны башир заль

Алт мөнгөтэй цусан төрөл

Хүнлэг сэтгэлийн нарыг хааваас

Хүлцэшгүй хилэнгийн дөл бадармой

Зол баяргүй уйтан тамд ч

Зул мэт ухааны оч гялбана

Ховорхон тохиох авьяасыг үл энэрэгч

Хотол түмний аранга нь болой

Төрсөн эцгийн нас элж өнчрөн хоцрох нь

Тэнгэр ниргэж газар еврэх лүгээ адил буюу

Хөөрхөн төрсөн хүүхэн заяа

Хорвоогийн зовлонгийн үүдэн буюу

Бурангуй засгаас үнэнийг эрснээс

Бударгана хөөсөн тэмээ хайвал төсөр

Ховсоргон нь шударгаа мэрж

Худал нь үнэнээ залгимой

Бүсгүй хүний гунигийн нулимсанд

Бүхий л зовлон живдэг ч болоосой

Орчлонд төрсөн эрийн заяа

Од харвах шиг таарах нь ч бий

Мунаг харанхуйн эхэн

Мухар сүсгийн хүлээс

Сэтгэлийн зовлонг эс тэвчвээс

Итгэлийн хүлээс алдармой

Үүлэн гарваас хур буумой

Үзэн ядахаас тэмцэл эхэлмүү

Хоосон чанарын номлолд автгаас

Хожмын өдөр аминд халтай

Түм тунгаасан хор бэлдвээс

Бум нэрснийг хариуд нь хүртмүү

Үйлийн үртэй энэ л хорвоод

Үнэнийг эрсэн нь хохидох амуй

Алтан дэлхий уужим гэлээ ч

Ариун үнэнд давчуухан буюу